Улсын бүртгэлийн
дугаар:

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШуГх(ОХУ)-2019/18

# НИЙГМИЙН УХААН: ОРЧИН ҮЕИЙН ТЕХНОУГШИЛТ ИРГЭНШЛИЙН СОРИЛТУУД

**Гадаадтай хамтарсан судалгааны төслийн тайлан**

**2019-2022**


**Төслийн удирдагч:** **Б.Дагзмаа Доктор (PhD), профессор**
МУИС-ийн ШУС-ийн Философи, шашин судлалын тэнхим


**Захиалагч:** **Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам**

**Санхүүжүүлэгч:** **Шинжлэх ухаан технологийн сан**


**Улаанбаатар хот**
**2023**

# НИЙГМИЙН УХААН:
# ОРЧИН ҮЕИЙН ТЕХНОУГШИЛТ
# ИРГЭНШЛИЙН СОРИЛТУУД

**Гадаадтай хамтарсан судалгааны төслийн тайлан**

**2019-2022**


| | |
|---|---|
| **Төслийн удирдагч:** | **Б.Дагзмаа Доктор (PhD), профессор**<br>МУИС-ийн ШУС-ийн Философи, шашин судлалын тэнхим |
| **Захиалагч:** | **Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам** |
| **Санхүүжүүлэгч:** | **Шинжлэх ухаан технологийн сан** |



**Улаанбаатар хот**
**2023**

# АГУУЛГА


**1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА** 4

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА 4

1.2. ТӨСЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН 4

**2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ** 6

2.1. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ 6

2.2. СУДАЛГААНЫ ТОЙМ 7

2.3. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД 12

2.4. СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ 13

2.5. СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ 14

2.6. СУДАЛГААНЫ ДИЗАЙН 14

2.7. СУДАЛГААНЫ БААЗ, ЛАБОРАТОРИ 15

**3. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН** 16

3.1. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 16

3.2. СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭЛТ 19

3.3. ЭКСПЕРТИЙН СУДАЛГАА 19

3.4. ФИЛОСОФИ, ШАШИН СУДЛАЛ СЭТГҮҮЛ 21

3.5. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЛҮҮД 25

3.6. НЭГЭН СЭДЭВТ БҮТЭЭЛ 28

**ДҮГНЭЛТ** 29

**ХАВСРАЛТ 1.**

СУДАЛГААНЫ СЭДЭВТ ХАМААРАХ СУДАЛГААНЫ АЖЛУУД БОЛОН НЭГЭН СЭДЭВТ БҮТЭЭЛҮҮДИЙН ЖАГСААЛТ 32

**ХАВСРАЛТ 2.**

СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН СЭДЭВТ ХАМААРАХ БҮТЭЭЛҮҮДИЙГ СОФТ ХУВИЛБАРТ ХӨРВҮҮЛЖ, КОДЛОСОН ЖИШЭЭ 36

**ХАВСРАЛТ 3.**

ЭКСПЕРТИЙН ЯРИЛЦЛАГЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ 48

**ХАВСРАЛТ 4.**

ФИЛОСОФИ, ШАШИН СУДЛАЛ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ISSN 2220-959X

СЭТГҮҮЛИЙН ДУГААР 23 (551) 56

**ХАВСРАЛТ 5.**

“ЭКОЛОГИЯ ЧЕЛОВЕКА И ПРИРОДЫ ИНФОРМАЦИОННО ТЕХНИЧЕСКОЙ СРЕДЕ” (ЭКОМИР-10) ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ 10 ДАХЬ ХУРЛЫН ИЛТГЭЛИЙН ЭМХТГЭЛ 188

**ХАВСРАЛТ 6.**

“МОНГОЛЫН НИЙГЭМ ДЭХ ЦАХИМ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ: ФИЛОСОФИ АСУУДЛУУД” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛД ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ИЛТГЭЛҮҮД 194

**ХАВСРАЛТ 7.**

БҮХ ОРОСЫН АРД ТҮМНИЙ НАЙРАМДЛЫН ИХ СУРГУУЛИАС ЭРХЛЭН ГАРГАДАГ ШИНЖЛЭХ УХААНЫ СЭТГҮҮЛИЙН 2020 ОНЫ ФИЛОСОФИЙН ЦУВРАЛЫН 24-Р БОТИЙН 4 ДҮГЭЭР ДУГААРТ ХЭВЛЭГДСЭН ӨГҮҮЛЭЛ 227

**ХАВСРАЛТ 8.**

БҮХ ОРОСЫН АРД ТҮМНИЙ НАЙРАМДЛЫН ИХ СУРГУУЛИАС ЭРХЛЭН ГАРГАДАГ, СКОПУСЫН САНД БҮРТГЭЛТЭЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СЭТГҮҮЛИЙН 2020 ОНЫ СОЦИОЛОГИЙН ЦУВРАЛЫН 21-Р БОТИЙН 2 ДУГААРТ ХЭВЛЭГДСЭН ӨГҮҮЛЭЛ 236

**ХАВСРАЛТ 9.**

ФИЛОСОФИ, ШАШИН СУДЛАЛ СЭТГҮҮЛИЙН 25 (580) ДУГААРЫН ӨГҮҮЛЭЛ 251

**ХАВСРАЛТ 10.**

“АЙСУЙ ХҮН: ДАЯН ДЭЛХИЙН ШИЛЖИЛТ ДЭХ ЁС ЗҮЙН СОРИЛТУУД” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ 271

# 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

***Төслийн нэр:***

“Нийгмийн ухаан: орчин үеийн техноугшилт иргэншлийн сорилтууд /Социальное знание: вызовы современной техногенной цивилизации

***Төслийн англи нэр:***

Social knowledge: the challenges of modern technogenic civilization

***Төсөл хэрэгжих хугацаа:***

2019-2022

***Захиалагч:***

БСШУСЯ

***Гүйцэтгэгч:***

МУИС, Философи, шашин судлалын тэнхим

***Санхүүжүүлэгч:***

ШУТСан

## 1.2. ТӨСЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

***Төслийн удирдагч:***

МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Философи, шашин судлалын тэнхимийн эрхлэгч, философийн ухааны доктор (PhD), профессор Балдоогийн Дагзмаа (Регистрийн дугаар: ХА72120665), Утас: +(976)88112737, E-mail: dagzmaa@gmail.com

***Төсөлд оролцогчид:***

***Судалгааны ажлын удирдагч*** МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Философи, шашин судлалын тэнхимийн профессор, философийн ухааны доктор (PhD) Момолын Отгонбаяр (Регистрийн дугаар: ШЕ65011909) Утас: +(976)99193603, E-mail: motgnbr@gmail.com

***Үндсэн гүйцэтгэгч*** МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Философи, шашин судлалын тэнхимийн цагийн багш, зөвлөх профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D) Цэдэндагвын Гомбосүрэн (Регистрийн дугаар–ХЖ47070571) Утас: +(976)99147036, E-mail: gombosuren_num@yahoo.com

***Үндсэн гүйцэтгэгч*** АШУҮИС-ийн Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч, философийн ухааны доктор (PhD) Цэрэннадмидын Нямсүрэн (Регистрийн дугаар: НЭ78090316) Утас: +(976)91199633, E-mail: nyamsuren976@gmail.com

***Үндсэн гүйцэтгэгч*** "Максима консалтинг ХХК" судалгаа, консалтингийн компанийн судалгаа, дата менежментийн газрын захирал Ядамсүрэнгийн Хишигсүрэн (Регистрийн дугаар: ОБ74012005) Утас:+(976)98118887, E-mail: khishigsuren.ya@gmail.com

# 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

## 2.1. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Дэлхий дахинд мэдээлэл-компьютерийн хувьсгалын нөлөөгөөр бүрэлдсэн мэдээлэлжсэн нийгэмд философи зэрэг хүмүүнлэгийн ухааны өмнө шийдвэрлэвэл зохих асуудал нэлээд байгаа билээ. Өнөөдөр Монголд улс орныхоо түүхэн болон өнөөгийн байдлыг шинжилсэн бүтээл цөөнгүй гарч байгаа боловч манай төсөлд санал болгож байгаа сэдвээр судалгаа үгүйлэгдэж байна.

Энэхүү төслийн хүрээнд орчин үеийн техноугшилт нийгэмд мэдлэгийг хуримтлуулах, хадгалах гол хэрэгсэл бөгөөд хөгжлийн стратегийн үндсэн нөөц болж буй мэдээлэл, Монголд энэ үйл явц хэрэгжиж буй төвшин, цаашдын хүлээгдэж байгаа чиглэлүүд юу юу болохыг философийн үүднээс авч үзэх нь бидний судалгааны гол зорилго байв. Мөн бид судалгаандаа бас орчин үеийн нийгмийн тухай онолуудад гарч буй дараах шинэ өөрчлөлт болон хүчин зүйлсийг харгалзан үзсэн болно. Үүнд:

- “Мэдлэгт суурилсан нийгэм”, “мэдлэгийн нийгэм” зэрэг шинэ ойлголтууд бий болсон;
- Мэдлэгт суурилсан нийгэмд чухамхүү мэдээллийн хүрээнд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гарч байна;
- Үүний үр дагавар болж аливаа мэргэжлийн үйл ажиллагаанд интеллектуальчлал, харилцаа холбооны виртуальчлал, мэдээллийн орон зайн медиачлалын үйл явц өрнөж байна;
- Мэдээлэлжсэн, өндөр хөгжсөн эдийн засаг бүхий улс орнууд дэлхийн санхүүгийн хямралаас гарах, дэлхийн тавцанд өрсөлдөх чадвар нь дээшлэх зэрэг бололцоо илүү байна.

Энэ төслийн судалгааны үр дүнд бид дараах онол, үзэл баримтлал, тэдгээрийн цөм ойлголтуудыг Монголын нийгмийн өнөөдрийн нөхцөл байдалтай холбон авч үзсэн болно. Үүнд:

- “Техноугшилт иргэншил” гэдэг онолын баримтлалын агуулгыг оновчтой илэрхийлэх;
- Энэ философи баримтлал өнөөгийн Монголын нийгэмд хэрхэн холбогдохыг шинжлэх;
- 1990-ээд оноос хойш Монголд хэрэгжүүлсэн нийгмийн философийн асуудлаарх судалгааны үр дүнд төслийн сэдэвтэй холбон үнэлгээ өгөх;
- Мөн 90-ээд оноос хойшхи манай философи сэтгэлгээн дэх арга зүйн шинэчлэлд төслийн сэдэвтэй холбон үнэлгээ, дүгнэлт өгөх;

XX зууны 2-р хагаст нийгэм, хүмүүнлэгийн ухааны үндсэн чиг хандлагыг нөхцөлдүүлж буй эпистемологи эргэлт гарсан ба энд юуны өмнө дараах өөрчлөлтийг онцолж байна. Үүнд:

- рациональ чанарын хэв маягуудын өөрчлөлт, түүний дотор түүхийн хөгжлийн шугаман загвар, нийгмийн үйл явцыг оюун ухаан захирах тухай асуудал, ертөнцийг хүний хэмжээсээр ойлгох зэргээс татгалзах болсон.

- шинжлэх ухаанч чанарын универсаль стандартын оронд мэдлэгийн нийгэм-соёлын шалтгаацлын зарчим гарч ирж, шинжлэх ухааны үндэслэгээний тухай үзэл өөрчлөгдөн, улмаар мета-онолын өөрчлөлт явагдаж байна.
- шинжлэх ухааны онолыг байгуулах зарчмууд өөрчлөгдөж, байгалийн шинжлэх ухааны мэдлэгийг олж авах зарчмаас татгалзсан, "нийгмийн зүйл" бол "объектив өгөгдөл" төдийгүй хүмүүсийн бүтээсэн утгын талбар болжээ.

Ертөнцийг үзэхүйн болон арга зүйн эдгээр өөрчлөлт нь нийгмийн ухааныг экспликаци хийх, шинэ шинэ аргуудыг эрж хайх, сонгодог биш арга зүйн баримтлалуудыг судалгааны зорилт болгон тавих зэрэг зорилтыг буй болгож байна.

Сүүлийн жилүүдэд нийгэм, хүмүүнлэгийн ухааны онолууд мэдлэгийг илэрхийлэх арга зүйн олон янз байдал, олон парадигмт байдал, арга, тайлбарлалын плюрализмыг төрүүлж байна.

Орчин үеийн техноугшилт нийгэмд өрнөж буй глобаль өөрчлөлтүүд ба мэдээллийн коммуникатив шинжийг философи онолын хүрээнд авч үзэх, үүнээс үүдэн нийгмийн ухаанд тулгарч буй сорилтууд, Монголын нийгмийн өвөрмөц онцлогийн талаархи нийгмийн судалгаа, зайлшгүй тулгамдаж байна.

## 2.2. СУДАЛГААНЫ ТОЙМ

***Энэ төсөл бол Оросын эрдэмтэдтэй хамтарсан судалгааны төсөл учраас бид Оросын болон сэдэвт холбогдох гадаадын судлаачдын бүтээлийг тоймлон авч үзсэн. Эдгээр судалгааг дараах байдлаар бүлэглэж байна. Үүнд:***

**Нэг. Танин мэдэхүйн онол, шинжлэх ухааны философи, арга зүй, нийгмийн эпистемологи, нийгэм, хүмүүнлэгийн салбарын парадигмт чанарын талаарх бүтээлүүд.**

Шинжлэх ухааны мэдлэгийн философи үндэслэл, шинжлэх ухааны бүтэц, тогтолцооны талаар С.А.Лебедев, С.Т.Мелюхин, А.Л.Никифоров, Ю.А.Петров, В.С.Степин (Лебедев С.А. Структура научного знания //Философские науки. 2005. №10. С.83-100; Никифоров А.Л. Философия науки: история и теория. М. Идея-Пресс, 2006 ба бусад) нар задлан шинжилжээ. Мөн В.С.Степиний бүтээлүүд, тухайлбал «пост сонгодог бус рациональ шинжийн» тухай түүний үзэл баримтлал нэн сонирхолтой.

Шинжлэх ухааны танин мэдэхүй, мэдлэгийн янз бүрийн тал хандлагын асуудлыг П.П.Гайденко, В.В.Ильин, А.В.Кезин, В.А.Лекторский, Е.А.Мамчур, И.П.Меркулов, А.П.Огурцов, В.Н.Порус, Г.И.Рузавин, В.С.Швырев, В.А.Штофф (Гайденко П.П. Научная рациональность и философский разум. М.: Прогресс-Традиция, 2003; Ильин В.В. Критерии научности знания. М.: Высшая школа, 1989; Ильин В.В. Теория познания. Социальная эпистемология. Социология знания. М.: Академический проект; Гаудеамус, 2014; Кезин А.В. Научность: эталоны, идеалы, критерии. М.: МГУ, 1985; Лекторский В.А. Эпистемология классическая и неклассическая. М.: Эдиториал УРСС, 2009; Мамчур Е.А. Объективность науки и релятивизм. М.: ИФ РАН, 2004; Меркулов И.П. Эпистемология (когнитивно-эволюционный подход): В 2-х т. СПб.: РХГА, 2006; Огурцов А.П.

Дисциплинарная структура науки. М.: Наука, 1988; Порус В.Н. Рациональность. Наука. Культура. М.,2002; Рузавин Г.И. Методы научного исследования. М.: Мысль, 1974; Швырев В.С. Анализ научного познания: основные направления, формы, проблемы. М.: Наука, 1998; Штофф В.А. Проблемы методологии научного познания. М.: Высшая школа, 1978) нарын бүтээлд авч үзжээ.

Орчин үед танин мэдэхүйн социал онол нь танин мэдэхүйн нийгмийн мөн чанар, нийгмийн нөхцөлийг судалдаг нийгмийн эпистемологи болж тодорхой хэмжээнд өөрчлөгдсөн билээ. Мэдлэгийн нийгэм, соёлын нөхцлийг судалдаг судлаачдаас С.Фуллер, А.Голдман, Д.Блур, Б.Барнес (Barnes B. Scientific Knowledge: A Sociological Analysis. University of Chicago Press, 1996; Bloor D. Knowledge and Social Imagery. Chicago Press, 1991; Goldman A. Knowledge in a Social world. Oxford. N.Y.: Clarendon Press, 2003; Фуллер С. Социальная эпистемология университета: Как сохранить целостность знания в так называемом обществе знания //Эпистемология & философия науки. 2008. Т. XV. № 1. С.158 - 186) ба бусад эрдэмтдийг онцолж болно.

**Хоёр. Орчин үеийн социал онол, нийгэм, хүмүүнлэгийн танин мэдэхүйн өвөрмөц онцлогийн асуудлын талаар дараах судалгаанууд байна.**

Социологийн онол, түүхийн бүтээлээр Л.Г.Ионин, Ю.Н. Давыдов, В.И. Добреньков, В.А.Ядов нарыг нэрлэх хэрэгтэй. Нийгмийн онолын орчин үеийн сонгодог бус хувилбарын асуудлыг авч үзэхэд чиглэсэн К.Х.Момджян, Ю.М.Резник, И.Ф.Девятко, А.Ю.Ашкеров, Л.А.Савченко, Ю.А.Кимелев, В.Е.Кемеров, Ю.Л.Качанов нарын бүтээлийг мөн дурдаж болно. Өрнийн социологичдоос П.А.Сорокин, Р.Арон, Э.Гидденс, П.Бурдье, Н.Элиас, Ю.Хабермас, Ф.Коркюф, П.Штомпки, Р.Коллинз нарын зохиол, бүтээлийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Нийгмийн танин мэдэхүй дэх «чанарын аргын» парадигмыг онцлох нь зүйтэй. Үүнд Б.Глезер, А.Страусс, А.Корбин, Н.Дензин, И.Линкольн зэрэг судлаач хамаарна.

**Гурав. Дараагийн бүлэг эх сурвалж бол нийгмийн үндсэн парадигмыг судалсан бүтээлүүд болно.** Энд парадигм хэмээх ойлголт, түүний бүрэлдэхүүн орцыг авч үзэн, нийгмийн үндсэн парадигмыг ялгасан нийгмийн онол Ж.Ритцерийн судалгаа онцгой ач холбогдолтой (Ritzer G. Sociology: A Multiple Paradigm Science. Boston: Allyn and Bacon, 1975; Ritzer G. Toward an Integrated Sociological Paradigm. Boston: Allyn and Bacon, 1981; Ритцер Дж. Современные социологические теории. СПб.: Питер, 2002. С.574-576). Нийгмийн мэдлэгийн сонгодог, сонгодог бус, пост сонгодог бус парадигмд тохируулан социологийг сонгодог, сонгодог бус, пост сонгодог бус гэж ангилж судалсан В.Д.Плаховын судалгаа бас сонирхолтой. (Плахов В.Д. Социология: эпистемы и эпистемология //Социологические исследования. 2007).

Нийгмийн мэдлэгийн үндсэн парадигмыг В.А.Бачинин, Б.П.Гоголев, Ю.Н.Давыдов, Г.Е.Зборовский, Ю.А.Кимелев, С.А.Кравченко, Г.В.Осипов, Н.Л.Полякова, Ж.Т.Тощенко (Бачинин В.А. О двух парадигмах социологического мышления //Социологические

исследования. 2004. № 8. С.123-131; Гоголев Б.П. От плюрализма и релятивизма к интегральной социологической парадигме //Вестник Самарской гуманитарной академии. Серия «Философия. Филология». 2011. № 2 (10). С.113-127; Давыдов Ю.Н. Эволюция теоретической социологии ХХ века //Социологические исследования. 1995. №8. С.53-60; Зборовский Г.Е. Метапарадигмальная модель теоретической социологии //Социологические исследования. 2008. №4. С.3-16; Кимелев Ю.А. Социологические теории модерна, радикализированного модерна и постмодерна. М.: ИНИОН, 1996; Кравченко С.А. Социология: парадигмы через призму социологического воображения. М.: Экзамен, 2004; Осипов Г.В. Социология и социальное мифотворчество. М.: Изд-во НОРМА, 2002; Полякова Н.Л. ХХ век в социологических теориях общества. М.: Логос, 2004; Тощенко Ж.Т. Парадигмы, структура и уровни социологического анализа //Социологические исследования. 2007. № 9. С.5-17) нар задлан шинжилсэн байна.

Нийгэм, хүмүүнлэгийн мэдлэгийн онцлогийг О.Д.Агапов, М.М.Бахтин, В.В.Василькова, П.К.Гречко, Н.Н.Козлова, А.М.Орехов, Ю.М.Резник, М.А.Розов (Агапов О.Д. Очерки синергийной социальной философии. Казань, 2008; Бахтин М.М. Автор и герой. К философским основам гуманитарных наук. СПб.: Азбука, 2000; Василькова В.В. Порядок и хаос в развитии социальных систем. СПб.: «Лань», 1999; Гречко П.К. Концептуальные модели истории. М.: Логос, 1995; Козлова Н.Н. Опыт социологического чтения «человеческих документов», или размышления о значимости методологической рефлексии //Социологические исследования. 2000. №9. С.22-32; Орехов А.М. Социальная философия: Предмет, структурные профили и вызовы на рубеже XXI века. М.: Книжный дом «ЛИБРОКОМ», 2011; Резник Ю.М. Введение в социальную теорию. Социальная онтология. М.: Институт востоковедения РАН, 1999; Резник Ю.М. Введение в социальную теорию. Социальная эпистемология: учеб. пособие. М.: Институт востоковедения РАН, 1999; Розов М.А. Теория социальных эстафет и проблемы эпистемологии. М.: Новый хронограф, 2008) нар судалжээ.

Нийгмийн мэдлэгийн янз бүрийн талыг авч үзсэн судлаачдаас П.Бурдье, Э.Гидденс, А.Гоулднер, П.Монсон, Ж.Ритцер, Ж.Тернера, Л.Флека, М.Фуко, П.Штомпки (Бурдье П. Начала. М.: Socio-Logos, 1994; Гоулднер А. Наступающий кризис западной социологии. СПб.: Наука, 2003; Монсон П. Современная западная социология: теории, традиции, перспективы. СПб.: «Нотабене», 1992; Ритцер Дж. Современные социологические теории. СПб.: Питер, 2002; Тернер Дж. Структура социологической теории. М.: Прогресс, 1985; Фуко М. Археология знания. К.: Ника-Центр, 1996; Штомпка П. Формирование социологического воображения. Значение теории //Социологические исследования. 2005. №10. С.64-72) нарын нэрийг онцолж дурдаж болно.

**Дөрөв. Орчин үеийн өрнөдийн нийгмийн онолчдын мэдээллийн нийгэм, орчин үеийн техник угшилт иргэншлийг судалсан бүтээлүүд бас бий.** Тухайлбал З.Бауман, У.Бек, Ж.Бодрийяр, Ф.Жеймисон, Ж.Ф.Лиотар, Н.Луман, М.Маклюэн, Э.Тоффлер, Ю.Хабермас (Бауман З. Индивидуализированное общество. М.: Логос, 2002; Бауман З.

Свобода. М.: Новое издательство, 2006; Bauman Z. Postmodernism as social theory: some challenges and problems //Theory, culture, and society. Cleveland, 1988. Vol.5. № 2-3. P.217-238; Beck U. World at Risk. Cambridge: Polity Press, 2009; Бодрийяр Ж. К критике политической экономии знака. М.: Академиеский проект, 2007; Джеймисон Ф. Постмодернизм и общество потребления //Логос. 2000. № 4. С.63-77; Лиотар Ж.-Ф. Состояние постмодерна. М., СПб.: Алетейя, 1998; Луман Н. Социальные системы. Очерк общей теории. СПб.: Наука, 2007; Маклюэн М. Война и мир в глобальной деревне. М.: АСТ: Астрель, 2012; Тоффлер Э. Третья волна. М.: АСТ, 2010; Хабермас Ю. Отношения между системой и жизненным миром в условиях позднего капитализма //THESIS. Весна 1993. Т. 1. Вып. 2. С.123-136) нарыг дурдаж болно.

Орчин үеийн нийгмийн асуудлыг В.Л.Иноземцев, В.А.Кутырев, И.А.Мальковский, М.О.Мнацаканян (Иноземцев В.Л. Современное постиндустриальное общество: природа, противоречия, перспективы. М.: Логос, 2000; Кутырев В.Л. Философия постмодернизма. Нижний Новгород: Изд-во Волго-Вятской академии государственной службы, 2006; Мальковская И.А. Метаморфозы субъектности в современном мире //Социологические исследования. 2008. №5. С.16-26; Мнацаканян М.О. Модерн и постмодерн в современной социологии //Социологические исследования. 2008. №12. С.46-54) зэрэг судлаач бас судалжээ.

Постмодерн философи, шүүмжлэлт арга зүйг И.Ф.Девятко, Ю.А.Кимелев, В.П.Култыгин, В.П.Ратников (Девятко И.Ф. Состояние и перспективы социологической теории в мире и России //Социологические исследования. 2007. №9. С.35-39; Кимелев Ю.А. Методология социальных наук (Современные дискуссии): Аналитический обзор. М.: РАН ИНИОН, 2011; Култыгин В.П. Облик социального мира в современной социологической мысли //Социологические исследования. 2003. №2. С.8-17; Ратников В.П. Постмодернизм: истоки, становление, сущность //Философия и общество. 2002. №4. С.120-133) нар үнэлж үзсэн байна.

Эцэст нь, сэдэвт холбогдох «салбар хоорондын», «салбар дундын» асуудлаарх дараах бүтээлүүдийг нэрлэж болно: Междисциплинарность в науках и философии, М., ИФРАН. 2010; Трансдисциплинарность в философии и науке. Подходы. Проблемы. Перспективы. М.: «Навигатор». 2015. Салбар хоорондын асуудлыг В.С.Степин, В.М.Розин, Ю.М.Резник, Р.Г.Браславский, Л.П.Киященко, И.Т.Касавин зэрэг эрдэмтний бүтээлд авч хэлэлцжээ. Жишээлбэл, В.М.Розин системт-синергетик, феноменологи, постструктуралист, мэдээлэл харилцааны, аргазүйн гэсэн салбар хоорондын таван үндсэн стратегийн асуудлыг дэвшүүлсэн (Розин В.М. Обсуждение феномена трансдисциплинарности событие новой научной революции //Вопросы философии, 2016, №5) бол В.Бажанов «салбар хоорондын хувьсгалд» хүргэдэг үзэгдлүүдийг судалжээ (О феномене трансдисциплинарной революции //Трансдисциплинарность в философии и науке, с.138). А.Маркович и Т.Шинн нарын өгүүллийг энд мөн онцлох хэрэгтэй

(Markovich A., Shinn T. Where is Disciplinary Going? Meeting on Borderland. Studies of Science and Technology //Social Science Information. 2011, vol.50, № 3-4. P.582-606).

***<u>Төслийн судалгааны сэдэвт холбогдох монгол судлаачдын бүтээлийн тойм</u>***

**Нэг. Техноугшилт иргэншил, түүний өнөөгийн Монголын нийгэмд холбогдох нь**

Ц.Батбаяр. Аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай үзэл баримтлалд хийсэн философи шинжилгээ. Докторын диссертацийн ажил. УБ., 2013; Г.Сайнхишиг, Ц.Батбаяр. Аж үйлдвэржсний дараах нийгэм ба үйлчилгээний технологийн асуудалд. Философи, шашин судлал. XIII. УБ., 2012, №371 (65);

Жич: тухайн сэдвээр бичсэн өгүүллүүдийн товч мэдээ “1990-ээд оноос хойших Монголын философийн амьдрал. Сэдэвчилсэн тоочилт, зэрэгцүүлэл ба харьцуулал. УБ., 2019” хамтын бүтээлийн X, XI бүлэгт буй.

**Хоёр. Дэлхийн хөгжлийн орчин үеийн нөхцөл дэх Монголын нийгэм**

Ч.Ган-Өлзий. Хүмүүнлэгийн гурван ертөнцийн гоц чанарын судлахуйн чандмань эрдэнэ. УБ., 2011; Бунийхны Ц.Гомбосүрэн. Нийгмийн тухай философийн интеграль (нэгтгэгч) хувилбарыг боловсруулах эхлэл (онол арга зүйн асуудал). УБ., 1999; Б.Даш-Ёндон. Нийгмийг танин мэдэхүй; түүх хөгжлийн философи. УБ., 2014; Б.Даш-Ёндон. Цаг үе: Сэтгэл, бодрол, философи. УБ., 2012; Д.Дашпүрэв. Монгол нийгэм (философийн анализ). УБ., 2017; Н.Лүндэндорж. Төрийн онол. УБ., 2005; И.Лхам. К.Попперийн “Нээлттэй нийгэм”-ийн үзэл санаа ба нийгмийн ардчилах үйл явц: философийн шинжилгээ. УБ., 2001; Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. ШУА-ийн ФСЭЗХ. УБ., 2013; Постмодернист философийн үзэл санаа. УБ., 2011; Н.Хавх. Соёл иргэншлийн онол. Боть 2. УБ., 2004; Н.Хавх. Монголчуудын нүүдлийн соёл иргэншлийн гүн ухаан. УБ., 2005; Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. УБ., 2008; Д.Чулуунжав. Монголын эртний түүхийн философи (нэмж засварласан хоёр дахь хэвлэл). УБ., 2013; Д.Чулуунжав. Нийгмийн философи: онол, туршилт, сургамж, шүүмж (нэмж засварласан гурав дахь хэвлэл). УБ., 2014; Г.Эрдэнэбаяр. Нийгэм ба соёл, иргэншил. УБ., 2004;

Жич: энэ сэдвээр бичсэн өгүүллүүдийн товч мэдээ “1990-ээд оноос хойших Монголын философийн амьдрал. Сэдэвчилсэн тоочилт, зэрэгцүүлэл ба харьцуулал. УБ., 2019” хамтын бүтээлийн X, XI бүлэгт буй.

**Гурав. XX зууны философийн сургаалууд дахь арга зүйн баримтлалууд манай өнөөгийн философийн сургалт, судалгаанд хэрхэн холбогдож байгаа нь**

Ц.Баатартогтох. Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй. УБ., 2010; Д.Баттөмөр. Математикийн баталгааны логик-эпистемологийн судалгаа. Докторын диссертацийн ажил. УБ., 1988; Д.Баттөмөр. Логик, эпистемологи, шинжлэх ухааны филсофийн асуудлууд. УБ., 2005; Т.Булган. Буддын филсоофийн дэвтэр. УБ., 2008; Д.Ганболд. Техникийн философи. УБ., 2008; Ч.Ган-Өлзий. Шинжлэх ухааны философийн зарим асуудал. УБ., 2016; Бунийхны Ц.Гомбосүрэн. Шинжлэх ухааны тухай филсоофийн позитивист ба постпозитивист чиглэлүүд. УБ., 1998; Бунийхны Ц.Гомбосүрэн. Нийгмийн тухай философийн интеграль (нэгтгэгч) хувилбарыг боловсруулах эхлэл. УБ., 1999; Б.Даш-Ёндон. Нийгмийг танихуй: түүх-хөгжлийн философи. УБ., 2014; Г.Лодой.

Реконструкция философской мысли прошлого как методологическая проблема историко-философского исследования. Докторская диссертация. УБ., 1990; Г.Лодой. Шинжлэх ухааны судалгааны логик-аргазүйн асуудлууд. УБ., 2012; М.Отгонбаяр. Шинжлэх ухаан дахь уламжлалт ба шинэ мэдлэгийн харилцааны философийн асуудал. Докторын диссертацийн ажил. УБ., 1995; Оюунлаг танин мэдэхүй. Хамтын бүтээл. ШУА-ийн Философийн Хүрээлэн. УБ., 2010; Т.Содномдаргиа. Буддийская тибетоязычная логика. Тэнгэр институт. УБ., 1999; Г.Цэрэн. Философи сэтгэлгээний үндэсний уламжлалын судалгааны онол, арга зүйн зарим асуудал. Доторын диссертацийн ажил. УБ., 2000; Г.Чулуунбаатар. Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик, судалгааны ажлын арга зүй. УБ., 2001; Шинжлэх ухааны арга зүй. Зохиомжилсон хамтын бүтээл. УБ., 2008.

Жич: энэ сэдэвт холбогдох өгүүллүүдийн товч мэдээ “1990-ээд оноос хойших Монголын философийн амьдрал. Сэдэвчилсэн тоочилт, зэрэгцүүлэл ба харьцуулал. УБ., 2019” хамтын бүтээлийн V, VI, VII бүлэгт буй.

## 2.3. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

**Зорилго 1 /2020 он/.** 1990 оноос хойш Монголын академик хүрээлэлд нийгэм, улс төрийн философи, нийгмийн онолын чиглэлээр хийгдсэн судалгааны ажилд анализ хийж, түүхэн үнэлэлт өгөх.

***Зорилтууд:***

1. 1990 оноос хойш их сургууль, ШУА-д гарсан дараах төрлийн бүтээлүүдийн талаар нэгдсэн мэдээлэл цуглуулна. Үүнд:
    - диссертацийн ажил
    - нэгэн сэдэвт бүтээл
    - эрдэм шинжилгээний өгүүлэл
    - эрдэм шинжилгээний хурал, илтгэл
    - сурах бичиг
2. Цуглуулсан мэдээлэлд анализ хийж, үнэлэлт өгнө.

**Зорилго 2 /2021 он/.** Нийгмийн философи, нийгмийн судалгааны орчин үеийн онол, арга зүйн бүтээлүүдийн агуулгыг тайлбарласан нэгэн сэдэвт бүтээл гаргах

***Зорилтууд:***

1. Монгол улстай адил түүхэн нөхцөл байдалд байсан постсоциалист орнуудын нийгмийн философи, онолын судалгааны туршлага судлах
2. Өрнөдийн нийгэм судлаачдын бүтээлүүдээс түүвэрлэн, агуулгыг тайлбарласан нэгэн сэдэвт ном хэвлүүлэх /монгол хэл дээр/

**Зорилго 3 /2022 он/.** Нийгмийн философийн онолуудын үндсэн ойлголтуудын агуулгыг Монголын нийгмийн бодит байдалд буулган тайлбарлах, нутагшуулах боломжийг эрж хайх.

***Зорилтууд:***

1. 90 оноос хойш монголын нийгэмд өрнөсөн түүхэн өөрчлөлтүүдийг судлах

2. Өнөөдрийн Монголын нийгмийн бодит байдлыг тодорхойлох, Монголын нийгмийн өнөөгийн байдлыг орчин үеийн онолуудаар тайлбарлах боломжийг харуулах

***Төслийг хэрэгжүүлэх явц дахь гадаад, дотоодын хамтын ажиллагаа***

Төслийн үе шат бүрт нягт хамтран ажиллаж, харилцан мэдээлэл солилцож ирсэн боловч, ковидын жилүүдийн хөл хорионы үед бид олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг гадаад хамтын ажиллагааны талаар дэвшүүлсэн зорилтуудаа хэрэгжүүлэх боломжгүй болсон. Мөн дээрх шалтгааны улмаас улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах боломжгүй болж, төслийн үр дүнгийн даалгаварт тусгагдсан зарим ажлыг гүйцэтгээгүйг энд дурдах шаардлагатай байна.

***Үр дүнг ашиглах боломж:***

Нийгэм-хүмүүнлэгийн ухааны энэхүү төслийн судалгааны үр дүнд “Нийгэм, улс төрийн философийн орчин үеийн зарим чиглэлүүд” сэдэвт нэгэн сэдэвт хамтын бүтээл бичиж хэвлүүлэв. Төслийн хүрээнд хийсэн судалгааны ажлын үр дүнг МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн тусгай дугаарт нийтлүүлэн гаргав (МУИС. Философи, шашин судлал. ЭШБ. Дугаар 23(551)). Мөн 2023 онд хэвлэгдэн гарах тус сэтгүүлийн 25(580) дугаарт хоёр өгүүлэл хэвлүүлэхэд бэлэн болгосон байгаа. Түүнээс гадна ШУА-ийн Философийн хүрээлэнгээс 2020 оны 12 дугаар сард зохион байгуулсан “Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл, философи асуудлууд” сэдэвт ЭШХ, Философи, шашин судлалын тэнхимээс 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд” сэдэвт ЭШХуралд илтгэлүүд тавьж, эмхэтгэлд хэвлэгдсэн болно. Тэрчлэн цаашдын олон мэргэжлийн судалгаа шинжилгээнд эх хэрэглэгдэхүүн болж, судалгаа, сургалтын хэрэгцээнд ашиглах боломжтой болно.

## 2.4. СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ

1990 оноос хойш Монголын академик хүрээлэлд нийгэм, улс төрийн философи, нийгмийн онолын чиглэлээр хийгдсэн судалгааны ажилд онолын анализ хийж интерпретаци өгөхийн тулд холбогдох тохирох аргуудаас сонгон хэрэглэсэн.

Нийгмийн философи, нийгмийн судалгааны орчин үеийн онол, арга зүйн сурвалжийг нэгтгэн, нийгмийн онолуудын үндсэн агуулгыг тайлбарласан нэгэн сэдэвт бүтээл гаргах гэсэн 2-р зорилтын хүрээнд нийгмийн бодит байдлыг тайлбарлах олон янз байдал, салбар дундын судалгааны аргуудыг ашиглахаас гадна арга зүйн плюрализмыг удирдлага болгосон.

Нийгмийн философийн онолуудын үндсэн ойлголтуудыг Монголын нийгмийн бодит байдалд буулган тайлбарлах, нутагшуулах боломжийг эрж хайх зорилтын хүрээнд монголын нийгмийн бодит байдлын бүтэц, үзэгдэл, тогтолцооны түүхийн логикийг судлахад эвристик ач холбогдол бүхий структурализм, феноменологи, постмодернизмын философи арга зүйг ашиглахаас гадна компаратив судалгааны аргууд, тухайлбал, арга зүйн инкоменшур баримтлалыг гол үндэслэл болгосон.

## 2.5. СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ

1. Нийгэм-хүмүүнлэгийн ухаан дахь мета-онолын анализын хэрэгсэл болох онолын нэр томъёонуудын /нийгмийн мэдлэг, парадигм, мэдээлэлжсэн нийгэм, нийгмийн онол, техноугшилт нийгэм гэх мэт/ утгын тайлбарлал өгөх, мэдээлэлжсэн нийгэм, мэдлэгийн нийгмийн үзэл баримтлалыг нийгмийн ухааны онол болгон дэвшүүлэх.
2. Мэдээлэл, коммуникацийн болон орчин үеийн бусад технологиудын нийгмийн мэдлэгт нөлөөлөх нөлөөллийг судлах, мэдээлэлжсэн нийгэм дэх мэдлэгээр удирдахуйн арга зүйн асуудлыг судлах.
3. Нийгмийн мэдлэгийн парадигмч шинж, олон парадигмуудын харилцаа, нийгмийн ухааны салбаруудын холбоог харуулах зэрэг болно.

## 2.6. СУДАЛГААНЫ ДИЗАЙН

"Нийгмийн ухаан: орчин үеийн техноугшилт иргэншлийн сорилтууд" судалгааны төслийн эхний жил буюу 2019 онд 1990 оноос хойш Монголын нийгмийн ухааны салбарт [философи, социологи, улс төр судлал, нийгэм соёлын антропологи, соёл судлал] Ph.D. болон ШУ-ны докторын зэрэг хамгаалсан судалгааны ажлууд, нэг сэдэвт бүтээлүүдийг судалгааны хоёрдогч эх сурвалж болгон сонгож тэдгээр судалгааны сэдэв, дэвшүүлсэн асуудал, судалсан үр дүнг үнэлэх баримт бичгийн судалгаа хийх эхний шатны буюу баримтын судалгааны дизайн боловсруулж багийн судлаачид хэлэлцэж батлав. Улмаар судалгааны сэдэв, агуулга, үр дүнг үнэлж, тухайн салбарын "онол арга зүйн" сэдэвт хамаарах эсэхээр нь ялгалт хийх арга зүйн удирдамж боловсруулж төслийн багийн судлаачид болон туслах судлаачдад танилцуулсан. Иймэрхүү баримт бичгийн судалгааны материал цуглуулах, үр дүнг нэгтгэх нэгдсэн аргачлалтай болсоноор дараагийн шатны судалгааны бэлтгэл хангагдсан юм.

Судалгааны ажил, бүтээлүүдтэй танилцаж, улмаар дижитал эх бэлдэж, баримт бичгийн судалгааны материал бүрдүүлэх нь энэ шатны гол ажил байв. Иймд тухайн бүтээлээс хэрэгтэй эх сонгон авах, түүнийг дижитал хэлбэрээр хадгалах ажлыг 2019 оны 12 сараас 2020 оны 1 сар хүртэл хийсэн.

Судалгааны баг судалгаанд хамруулсан салбар тус бүрээр бүтээлүүдийг ангилж танилцахаар хуваарилагдсан ба дараах 3 чиглэл тус бүр 2-5 туслах судлаачдын баг бүрдүүлсэн.

Философийн салбар: М.Отгонбаяр [туслах судлаачийн нэр: Э.Эрхэс философийн хөтөлбөрийн оюутан]

Улс төр судлал, Социологи, Нийгмийн антропологийн салбар: Я.Хишигсүрэн, Б.Дагзмаа нар [туслах судлаачийн нэр: Э.Баасандорж философийн хөтөлбөрийн магистрант]

Дижитал хэлбэрээр олдож байгаа бүх бүтээлүүдийг Ц.Нямсүрэн хариуцаж ажилласан. [туслах судлаачийн нэр: Г.Уянга, Б.Анар философийн хөтөлбөрийн магистрант, З.Баярцэнгэл]



**Зураг 1. Багийн гишүүд судалгааны дизайн боловсруулах үеэр**

## 2.7. СУДАЛГААНЫ БААЗ, ЛАБОРАТОРИ

Онол, аргазүй, судалгааны үндсэн материал, эх хэрэглэгдэхүүнийг Улсын төв номын сан, Улаанбаатар хотын болон МУИС-ийн, бусад их сургуулийн номын сан, мөн нээлттэй эх сурвалжаас холбогдох ном, сэтгүүл, өгүүлэл олж ашигласан. Судлагааны ажилдаа МУИС-ийн болон, Философи, шашин судлалын тэнхимийн сургалт, судалгааны техник хэрэгсэл болон бусад мэдээллийн эх сурвалж, техник хэрэгслийг ашигласан болно.

## 3. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН

### 3.1. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн зорилго, зорилтын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг төслийн багийн гишүүд хэлэлцэн, баталж, төлөвлөгөөний дагуу ажлыг гүйцэтгэв.

| **Ажлын төлөвлөгөө** | | | | |
|---|---|---|---|---|
| **Зорилтууд буюу нийлүүлэх бүтээгдэхүүн** | | **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа** | **Хугацаа** | **Гүйцэтгэл** |
| **Зорилго 1: 1990 оноос хойш Монголын академик хүрээлэлд нийгэм, улс төрийн философи, нийгмийн онолын чиглэлээр хийгдсэн судалгааны ажилд анализ хийж, түүхэн үнэлэлт өгөх.** | | | | |
| **1** | Судалгааны ажлын дизайн, төлөвлөгөө боловсруулах | Судалгааны ажлын материал цуглуулах, анализ хийх, боловсруулах арга зүйн нэгдсэн удирдамж гаргах | 2020 оны 1-3 дугаар сар | Удирдамж боловсруулан, төслийн багийн гишүүд болон туслах ажилтан нарт танилцуулах сургалт зохион байгуулав. |
| | | Судлаачдад зориулсан ажлын удирдамж боловсруулах | 2020 оны 3 дугаар сар | |
| | | Судалгааны ажлын арга зүйн удирдамжийн талаар сургалт явуулах | 2020 оны 3-4 дугаар сар | |
| **2** | 1990 оноос хойш их сургууль, ШУА-д гарсан дараах төрлийн бүтээлүүдийн талаар нэгдсэн мэдээлэл цуглуулах | Судалгааны ажлуудын нэгдсэн сан бүрдүүлэх /диссертаци, нэгэн сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, сурах бичиг/ | 2020 оны 3-5 дугаар сар | Улсын төв номын сан, МУИС-ийн номын сан, ШУА-ийн ФХ-ийн номын сан зэрэг байгууллагад ажиллан, холбогдох материал цуглуулав. |
| | | Бүтээлүүдтэй ажиллах | 2020 оны 5-8 сар | Багийн гишүүдэд хуваарилан өгөв. |
| | | Их сургууль, ШУА зэрэг байгууллагын экспертийн түвшний эрдэмтэдтэй ярилцлага хийх | 2020 оны 4-6 дугаар сард | Экспертийн ярилцлагын аргаар судалгаа явуулав. |
| **3** | Төслийн судалгааны эхний жилийн ажлын тайлан гаргах | Ажлын эхний шатны үр дүнг танилцуулах үндэсний хэмжээний симпозиум зохион байгуулах /2 илтгэл хэлэлцүүлэх/ | 2020 оны 10 дугаар сар | Ковидын хөл хорионы улмаас симпозиум зохион байгуулж чадаагүй, багийн гишүүд |
| | | Зорилго 1-ийн тайлан гаргах | 2020 оны 11 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | /симпозиумын үр дүнг тусгасан/ | дугаар сар | өргөтгөсөн байдлаар цахим хуралдав. |
| | | Эрдэм шинжилгээний өгүүлэл /2/-ыг бичиж үндэсний болон олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх | 2020 оны 12 дугаар сард | Философи, шашин судлал мэргэжлийн сэтгүүлд 2 өгүүлэл нийтлүүлсэн. |
| **Зорилго 2: Нийгмийн философи, нийгмийн судалгааны орчин үеийн онол, арга зүйн бүтээлүүдийн агуулгыг тайлбарласан нэгэн сэдэвт бүтээл гаргах** | | | | |
| **1** | Судалгааны ажлын дизайн, төлөвлөгөө боловсруулах | Ажлын хуваарилалт, төлөвлөгөө гаргах | 2021 оны 1 дүгээр сар | Нэгэн сэдэвт номын агуулга, бүтэц, арга зүйн нэгдсэн төлөвлөгөө гарган ажиллав. |
| | | Номын агуулгад орох онолуудын сонголт хийх, нээлттэй уулзалт семинарууд зохион байгуулах | 2021 оны 1-2 дугаар сар | |
| **2** | Монгол улстай адил түүхэн нөхцөл байдалд байсан постсоциалист орнуудын нийгмийн философи, онолын судалгааны туршлага судлах | Нээлттэй эх сурвалжаас холбогдох бүтээлүүдийг олох, ялгах, судлах | 2021 оны эхний хагас жил | Нээлттэй эх сурвалж болон номын сангуудаас холбогдох ном, өгүүлэл, бүтээлүүдийг цуглуулав. |
| | | Орос, Беларус зэрэг орны судлаачидтай уулзах, туршлага солилцох | 2021 оны 6 дугаар сар | Ковидын хөл хорионы улмаас биелээгүй. |
| | | Ажлын үр дүнг танилцуулах эрдэм шинжилгээний их семинар зохион байгуулах | 2021 оны 9 дүгээр сар | Оросын талын судлаачидтай хамтарсан хуралд онлайн оролцож 1 илтгэл хэлэлцүүлэв. |
| | | Ажлын үр дүнг нэгттэж, тайлан, эмхэтгэл гаргах | 2021 оны 12 дугаар сар | ЭШ-ий өгүүллүүдээс бүрдсэн мэргэжлийн сэтгүүлийн бүтэн дугаар хэвлүүлэв. Мөн Оросын эрдэмтэдтэй хамтран Скопусын санд бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд 1 |
| | | Эрдэм шинжилгээний өгүүлэл /2/-ыг бичиж үндэсний болон олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | өгүүлэл, хянан магадлагаа хийдэг гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд 1 өгүүлэл тус тус хэвлүүлсэн. |
| **3** | Өрнөдийн нийгэм судлаачдын бүтээлүүдээс түүвэрлэн, агуулгыг тайлбарласан нэгэн сэдэвт бүтээл хэвлүүлэх /монгол хэл дээр/ | Номын агуулга дээр ажиллах ажлын хуваарилалт, төлөвлөгөө гаргах | 2021 оны 6 дугаар сар | Номын агуулга, бүтцийн дагуу төлөвлөгөө, ажлын хуваарь гаргав. |
| | | Ажлын явцын уулзалт, семинарууд зохион байгуулах | 2021 оны 9-10 дугаар сар | Нэгэн сэдэвт номын явцын талаар тогтмол хэлэлцүүлэг, уулзалт хийж ирэв. Нэгэн сэдэвт бүтээлийн хэвлэлийн эх бэлэн болов. |
| | | Нэгэн сэдэвт бүтээл хэвлүүлэх, нийтэд танилцуулах | 2022 оны эхний улиралд | |
| **Зорилго 3: Нийгмийн философийн онолуудын үндсэн ойлголтуудын агуулгыг Монголын нийгмийн бодит байдалд буулган тайлбарлах, нутагшуулах боломжийг эрж хайх** | | | | |
| **1** | Судалгааны ажлын дизайн, төлөвлөгөө боловсруулах | Ажлын хуваарилалт, төлөвлөгөө гаргах | 2022 оны 1 дүгээр сар | Ажлын төлөвлөгөө гарган хэлэлцүүлсэн. |
| | | Сэдвүүд сонгох, боловсруулах: хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулах | 2022 оны 2-4 дүгээр сар | |
| **2** | 90 оноос хойш монголын нийгэмд өрнөсөн түүхэн өөрчлөлтүүдийг судлах | Дэд төслүүд боловсруулах, бусад эх сурвалжаас бүх төрлийн нөөцийн дэмжлэг авах | 2022 оны 1-9 дүгээр сар | Төслийн хүрээнд ЭШ-ий хурал зохион байгуулав. Хурлын илтгэлийн эмхэтгэл хэвлүүлэв. |
| | | Дэд төслүүдийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх | | |
| | | Дэд төслүүдийн ажлын үр дүнгийн танилцуулга: симпозиум, хурал зохион байгуулах /илтгэл 2/, төслийн тайлан хэвлүүлэх | 2022 оны 9-10 дугаар сар | |
| **3** | Өнөөдрийн Монголын нийгмийн бодит байдлыг | Цаашдын судалгааны зорилтууд дэвшүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл /2/ нийтлүүлэх | 2022 оны 11-12 дугаар сар | ЭШ-ий 2 өгүүлэл Философи, шашин судлал эрдэм |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тодорхойлох, өнөөгийн байдлыг орчин үеийн онолуудаар тайлбарлах боломжийг харуулах | Монголын нийгмийн хөгжлийн стратегид онолын баримжаа болох санал, зөвлөмж боловсруулах зорилго бүхий гадаад, дотоодын бусад судлаачдын оролцоог хангасан ахисан шатны судалгааны төслүүд боловруулах, нөөцийн дэмжлэг олох | 2022 оны 9-12 дугаар сар | шинжилгээний сэтгүүлд бичиж хэвлүүлэхэд бэлэн болов. |

## 3.2. СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭЛТ

Судалгааны өгөгдөл буюу эрдмийн зэрэг горилсон бүтээлүүд, нэг сэдэвт бүтээлүүд ямар цаг хугацаанд бүтээгдсэнээсээ хамаарч хэвлэмэл болон дижитал 2 төрлөөр олдсоны дотор нийт бүтээлийн 90 хувь нь хэвлэмэл хэлбэрээр олдлоо *(Хавсралт 1)*.

ШУА-ийн хүрээлэнгүүд, МУИС-ийн эрдэм шинжилгээний номын сан, Улсын төв номын сан, ШУТС-ын эрдэм шинжилгээний бүтээлийн фондоос тус тус судалгааны материал олж танилцав. Цуглуулсан судалгааны ажил, бүтээл тус бүрийн агуулгатай танилцаж, судалгааны сэдэв, агуулга, үр дүнг үнэлж, тухайн салбарын “онол арга зүйн” сэдэвт хамаарах эсэхээр нь ялгалт хийв.

Дараагийн шатанд онол арга зүйн сэдэвт хамаарах бүтээл бүртэй дэлгэрэнгүй танилцаж, улмаар хэвлэмэл бүтээлүүдийн судалгааны сэдэв, агуулга, дэвшүүлсэн асуудал, үр дүнг багтаасан дижитал эхийг бүрдүүлж, фремвок анализ хийхэд бэлтгэн кодлосон болно *(Хавсралт 2)*. Тус санд үндэслэн багийн судлаачид эрдэм шинжилгээний нэг өгүүлэл бичиж хэвлүүлэв.

Цугларсан судалгааны ажил, бүтээлүүдтэй танилцах явцад баримт бичгийн судалгааны материал дангаар хангалтгүй байна хэмээн багийн судлаачид санал нэгтэй үнэлж нэмэлтээр экспертийн судалгаа хийх шийдвэрт хүрсэн.

## 3.3. ЭКСПЕРТИЙН СУДАЛГАА

1990 оноос хойш Монгол улсын нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбарт хийсэн онолын судалгааны талаар салбарын экспертүүд ямар үнэлгээ өгч буй талаар мэдээлэл авах зорилгоор улс төр судлал, социологи, соёл судлал, нийгэм соёлын антропологи, философийн салбар тус бүрээс мэргэжлийн тэнхим, судалгааны хүрээлэнгийн нэгж удирдаж байсан, удирдаж байгаа, өөрийн салбарын сүүлийн 30 жилийн судалгааны талаар мэдээлэл өгөх боломжтой субъектүүдтэй экспертийн ярилцлага хийсэн. Ярилцлага тус бүрийн аудио бичлэг хийж, товч тэмдэглэл хөтөлсөн.

Тус ярилцлагын мэдээлэлд суурилан салбар тус бүрийн онолын судалгааны асуудлууд, судлагдсан сэдвүүд, тэдгээрийн талаарх мэргэжлийн салбарынханы өгч буй үнэлгээ ач холбогдлыг тодруулахыг зорьсон. Ингэснээр орчин үеийн Монголын нийгмийн тулгамдсан асуудлууд, сорилтууд хэмээн манай оронд ямар сэдвүүд онолын судалгааны

эргэлтэд орж байгааг илүү нарийвчлан тодруулах бидний зорилтыг хангах нэг гол эх сурвалж болох байв.

Дээрх 2 төрлийн судалгааны үр дүнд нэгд, сүүлийн 30 жилийн Монголын нийгмийн шилжилтийн үед ямар сэдвүүд сорилт болон тулгарсан болох, хоёрт, эдгээр сэдэв тус бүрийн хүрээнд хийсэн судалгааны агуулга, арга зүйн байдлыг тодорхойлох боломж бүрдсэн.

Үүний үр дүнд Монголын нийгэм, улс төрийн салбарын хүрээнд тулгамдсан онолын асуудлууд, тэдгээрээс манай эрдэмтдийн авч үзсэн судалгааны үр дүн, тэдгээрийн нийгэм практикийн ач холбогдлыг тодорхойлсон нь энэ шатны ажлын гол үр дүн юм.

Ярилцлагад дараах чиглүүлэх үндсэн асуултуудын хүрээнд социологи, улс төр судлал, философи, нийгмийн антропологийн салбарын тус бүр нэг судлаач-эксперттэй ярилцлага хийлээ. Үүнд:

1. 1990-ээд оноос хойших нийгмийн ухааны салбарт доктор хамгаалсан, нэгэн сэдэвт бүтээл бичсэн эрдэмтдийн бүтээлүүдээс нийгмийн философи, тухайн салбарын онол арга зүй гэсэн ангилалд хамааруулж болох судалгааны ажлуудын талаарх судлаачийн үнэлгээ, байр суурь;
1. 1990-ээд оноос хойш үед Монголын нийгмийн ямар асуудлуудыг энэ тэргүүнд судлах ёстой тулгамдсан сэдэв болсон, нийгмийн ухааны салбар бүрт тэдгээр сэдэв, асуудлыг авч үзэх;
2. Хийгдсэн судалгаанууд ямар асуудал, сэдэв дээр түлхүү төвлөрч байгаа, энэ нь ямар шалтгаантай болох;
3. Нийгмийн ухааны салбар бүрт судлах шаардлагатай тулгамдсан асуудлуудаас аль сэдэв, асуудалд илүү төвлөрч судалсан болох, мөн орхигдсон сэдэв, түүний шалтгаан;
4. Онцгой ач холбогдолтой гэж хувь судлаачийн хувьд үнэлж байгаа судалгааны ажил, шалтгаан;

Экспертүүдтэй хийсэн ярилцлагаар дэвшүүлэн тавьсан асуудлын хүрээнд бүрэн хариулт олж авч чадаагүй болохыг тэмдэглэе. Учир нь манай нийгмийн ухааны аль ч салбарт дээрх асуултад хариулах түвшинд онол, арга зүйн судалгаа хийгдээгүй байна. Энэ нь бас түүхэн, зайлшгүй шалтгаантай байна гэж үзлээ.

1990-ээд оноос хойш нийгмийн ухааны зарим салбар цоо шинээр үүссэн буюу бие даасан салбар болон хөгжих эхлэл тавигдсан. Ингээд мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай хэдий ч сургалтын хөтөлбөр боловсруулах, сурах бичиг гаргах, багшлах боловсон хүчин бэлтгэх ажилд үндсэн хүч нөөц нь зарцуулагдсан учраас онол арга зүйн судалгаа хөгжих бодит хөрс болон нөөц бүрдээгүй байсан гэж дүгнэж байна.

Манай нийгмийн ухааны салбар тус бүрийн тухайд мэргэжлийн номын сан, судалгааны ажлын туршлага, судалгааны арга зүй, судлаачдын манлайлал, эх хэл дээрх эх

сурвалжууд байхгүй. Монгол хэлээр онолын судалгааны нэр томъёо цэгцэрч, жигдрээгүй, ямар нэгэн судалгаа хийсэн л бол салбартаа анхдагч нь болдог, хувь судлаачийн сонирхол, хичээл зүтгэл дээр суурилсан судалгаа л хөгжиж байна гэж үзэж байна. Нөгөө талаас нийгмийн шилжилтийн үед хувь хүний болон улс төр, нийгэм, сэтгэл зүйн шинжтэй хүчин зүйлүүдийн нөлөөгөөр онол, арга зүйн шилжилт харьцангуй урт хугацаанд явагдсан байна гэж үзэв.

Судлаачдыг мэргэжлийн хүрээлэн, тэнхимээс тодорхой судалгааны чиглэл, сэдэв дээр төвлөрүүлж удирдлагаар хангаагүй, хүний нөөцийн талаар бодлого хэрэгжүүлээгүй, бүх салбарт улсын хэмжээний бодлого, менежмент байгаагүй. Энэ нь нийгмийн шинжлэх ухааны онолын судалгаанд бүрэн тусгалаа олсон байна. Иймд нийгмийн ухааны бүх салбар судалгааны суурь сэдэв, тэргүүлэх чиглэлээ ч тодорхойлоогүй байна.

Товчхондоо хоёр өөр системийн зааг дээр нийгмийн ухааны салбарын судалгааны эрэлт их, судлах сэдэв асуудал арвин байсан боловч энэ орон зай дээр гадаадад сурч мэргэшсэн, тэнд судалгааны ажил хийж байгаа дотоодын судлаачид, шилжилтийн нийгмийн зарим асуудлаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн захиалгат судалгаа гүйцэтгэгчид, ганц нэг “сонирхолтой” гэж сонгосон сэдвээр судалгаа хийсэн гадаадын судлаачдын ажлын хүрээгээр хязгаарлагдаж байна.

Тус экспертийн судалгааг багийн удирдагч, судлаач Б.Дагзмаа, судлаач Я.Хишигсүрэн нар хийж гүйцэтгэв. Экспертийн ярилцлага дараах судлаачдаас авсан. Ярилцлагын товч тэмдэглэлийг *(Хавсралт 3)* тусгав.

1. Улс төр судлал: Э001
2. Нийгмийн антропологи: Э002
3. Философи: Э003
4. Социологи: Э004

## 3.4. ФИЛОСОФИ, ШАШИН СУДЛАЛ СЭТГҮҮЛ

Баримт бичгийн судалгаа экспертийн ярилцлагын үр дүнд суурилж судалгааны баг 2020 оны ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан.

1990-2020 он буюу нийгмийн шилжилтийн үед Монгол улсын нийгмийн ухааны салбарт (судалгаанд хамруулсан салбарын хүрээнд) хийгдсэн онол, арга зүйн шинжтэй судалгаанууд, тэдгээрийн үр дүн зэрэг асуудлаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахаар төлөвлөсөн. Тус эрдэм шинжилгээний хуралд дурьдсан салбар тус бүрээс төлөөлөл сонгож илтгэл хэлэлцүүлэх урилга өгсөн боловч “Ковид-19” цар тахалын нөхцлөөс хамаарч эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах боломжгүй болсон учир дараах судлаачдын судалгааны материалыг МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг Философи, шашин судлал эрдэм шинжилгээний сэтгүүлийн шаардлагын дагуу өөрчилж, 2021 онд хэвлүүлсэн.

**Д.Ганболд** – Доктор (Ph.D). ШУТИС. Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн Хүмүүнлэгийн салбар.

## НИЙГМИЙН ДЕФОРМАЦЫН МЕХАНИЗМ

***Товч утга:*** *Дэлхийн улс орнуудын нийгэм судлаачдын хэлэлцэж буй асуудлын төвд нийгмийн дегуманизаци голлох байр суурь эзлэж байна. Үүний учир нь орчин үеийн нийгэмд амьдарч буй хүний үйлдлийн мотив янз бүрээр илэрч байгаатай холбоотойгоос гадна хүн өөрөө дотооддоо зөрчилт чанарыг агуулж явдагтай холбож үзэх ёстой. Орчин үеийн хүн дотооддоо зөрчилтэй, дотоод атгаг санаа ихтэй (амбици) тул энэ асуудлыг зүгээр л хараад суугаад байж болохгүй. Үүнд нь тайлбар хийх заавал шаардлага амьдралаас нэхэгдэж байна. Дегуманизацийн хандлагын ямар ч хэлбэрийн олон үр дагавар эцсийн нийлбэр дүнгээрээ нийгмийн деформацийг бий болгож байгааг хүн төрөлхтөн XX зуунаас эхлэн яс махаараа мэдэрч байна.*

**О.Хатанболд**, доктор (Ph.D), **А.Хишигдаваа**, докторант**:** ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбар

## УЛС ТӨР СУДЛАЛЫН САЛБАРТ 1990-ЭЭД ОНООС ХОЙШ ХЭРЭГЖСЭН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, АРГА ЗҮЙ БА ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

***Товч утга:*** *Манайд харьцангуй хожуу үед үүссэн шинжлэх ухааны нэг бол улс төрийн шинжлэх ухаан юм. Бид энэхүү өгүүлэлдээ 1990-ээд оноос хойш хэрэгжсэн улс төр судлалын судалгаа, шинжилгээний онол арга, зүй, шинж байдлын өнөөгийн төлвийг судалгааны бүтээлүүдийн онол арга зүй, үзэл баримтлал, шийдвэрлэх арга замыг нэгтгэн дүгнэж тоймлох байдлаар бэлтгэв. Чингэхдээ туулж өнгөрүүлсэн замаа эргэн харж, түүнээс сургамж авч, судалгаа шинжилгээний ажлаа улам чамбайруулах нь бидний өмнөө тавьсан гол зорилтуудын нэг тул өнгөрсөн үеийг эргэн дурсахуй нь түүний мөн чанар болоод дараа дараагийн үедээ уламжлагдан үлддэг сонголт байдаг. Тэрхүү агуулгын хүрээнд бид оршил хэсэгтээ монголчуудын улс төрийн мэдлэг, сэтгэлгээний уламжлалын талаарх тоймыг цухас тэмдэглэв. Тиймээс эл тойм өгүүлэлд Монгол Улс дахь улс төрийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний онол, арга зүйн төлөв байдлыг 1990 оноос өмнөх ба хойш хэмээн* ***хоёр үндсэн хэсэгт*** *хуваан дараах байдлаар үечлэн авч үзэхийг оролдов. Үүнд, (i) Монголчуудын улс төрийн сэтгэлгээ, түүний мөн чанарын талаарх тойм; (ii) Шинжлэх ухааны коммунизмын онол болон марксист-ленинист сургаалын үе (1972-1990); (iii) Шинэ онол, арга зүйг эрэлхийлэхүй буюу шилжилтийн үе (1990-2000); (iv) Улс төрийн шинжлэх ухааны шинэ төлөвшилтийн үе (2000-2010); (v) Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны судалгааны өнөөгийн байдал, цаашдын хандлага (2010 оноос- өнөөг хүртэл)*

**Г.Мөнх-Эрдэнэ,** ШУТИС-ийн Хүмүүнлэгийн тэнхимийн багш, Нийгэм-соёлын антропологийн магистр

## 1990-ЭЭД ОНООС ХОЙШИХ МОНГОЛ УЛС ДАХЬ НИЙГМИЙН АНТРОПОЛОГИЙН СУДАЛГАА

***Товч утга:*** *This article reviews studies of Mongolian anthropologists on different social issues in Mongolia which took place since 1990s. Following the collapse of the socialist system and the rise of the democratic regime in the country in 1990, pluralism, openness, and productive criticism were introduced to different branches of social sciences in the country. Among these branches, social anthropology which was previously known as ethnology or ethnography due to the Soviet legacy is developed in two different ways since that time. The first way is more based on the former methodological practice that was heavily influenced by Soviet social sciences. Drawing on the descriptive writing method, this approach focuses on a regional and local level and attempts to study 'traditional research topics' – Mongolian ritual, custom, history, and cultural heritage. The second way engages more the Western especially English-speaking academic world's research activities and tries to encourage constructive critical research views. This way also makes more effort to study 'non-traditional issues' – capitalism, development, and international projects among locals, mining, and development problems in the country.*

**М.Отгонбаяр, Ц.Нямсүрэн, Б.Дагзмаа** доктор (Ph.D), МУИС-ын Философи шашин судлалын тэнхмийн профессор

## 1990 ОНООС ХОЙШИХ ҮЕИЙН МОНГОЛЫН ФИЛОСОФИЙН СУРГАЛТ, СУДАЛГААН ДАХЬ ОНОЛ, АРГА ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ, ТУРШЛАГА, СУРГАМЖ

***Товч утга:*** *Энэхүү өгүүлэл бол 1990 оноос хойш үе дэх манай философийн мэргэжлийн сургалт, судалгааны онол, арга зүйн өөрчлөлтийн үйл явцын дүр зургийг гаргах, үнэлгээ өгөх зорилготой юм.*

*Бид манай улсад философийн сургалт, судалгааг дагнан эрхэлж ирсэн мэргэжлийн, ууган, том институц болох МУИС-ийн философийн тэнхмийн бакалаврын болон ахисан түвшний сургалтын баримт бичгүүд, тус тэнхимд гүйцэтгэсэн магистрын болон докторын зэргийн судалгааны ажлуудыг судалгааныхаа үндсэн объектоор сонгон авсан болно. Мөн институцийн түүхэнд холбогдох зарим баримт бичгүүдийг авч үзсэн болно.*

*Сургалтын бичиг баримтуудад документын анализ хийх, харьцуулах, судалгааны ажлуудыг чиглэл, салбараар бүлэглэн ангилах зэрэг аргаар ажиллав.*

**Д.Дашпүрэв**, доктор (Sc.D.) профессор, *Олон улс судлалын дээд сургууль*

## МОНГОЛЫН НИЙГМИЙН МОДЕРНИЗАЦИЙН ҮЕ ШАТНЫ АСУУДЛААР МАНАЙ ОРОНД ХЭРЭГЖИЖ ИРСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

***Товч утга:*** *Монгол үндэстэн ардчилсан өөрчлөлтийг амжилттай хийсэн нь модернизацийн тухай судлахад чухал суурийг гарган өгч байна. Энэ явцад урган гарч, өөрчлөгдөж буй Монголын модернизацийн талаарх үзэл баримтлалууд ба өөрчлөгдөж буй нөхцөл байдлын тухай уг өгүүлэлд авч үзнэ. Зөвлөлт Холбоот Улс ба Дэлхийн Социалист Тогтолцоо унаснаас хойш Монголын тухай судалгаа өрнөд эрчимтэй хийгдэх болов. Гэвч*

*орчин үеийн Монгол дахь ардчиллын үйл явцад залгамж, тогтвортой чанар дутагдаж байна. Хэдий тийм ч модернизаци явагдсан хэвээр байгаа юм.*

**О.Мөнхбат**, доктор (Ph.D), профессор, МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэн

## МОНГОЛЫН НИЙГМИЙН ДАВХРААЖЛЫН СУДАЛГААН ДАХЬ ПАРАДИГМЫН ӨӨРЧЛӨЛТ

***Товч утга:*** *Энэхүү өгүүлэл нь Монголын нийгмийн давхраажлын судалгааны онол арга зүйн хувьсал өөрчлөлтийг авч үзэж, парадигмын халаа сэлгээ, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс зэргийг шинжилсэн байна. Монголын нийгмийн давхраажлын онол арга зүйн үндэс голлон позитивист чиглэлийн Нийгмийн баримт сэлтийн парадигм дээр тулгуурлаж ирсэн агаад тоон байдлаар хэмжигдэхүйц орлого хөрөнгө чинээ, боловсрол зэрэг шалгуурууд зонхилсоор ирсэн болохыг зохиогч тэмдэглээд орчин цагийн судалгаанд ажиглагдаж буй олон хэмжээст, чанарын хандлагыг онцолсон байна. Зохиогч энэ чиглэлийн судалгааны парадигмын өөрчлөлтийг судлагдсан байдлыг шинжлэн, улмаар позитив тоон үзүүлэлтийг интерпретив чанарын парадигмын үзүүлэлттэй хослох зүй тогтол илэрч байгааг онцолжээ. Тэрээр өөрийн судалгааны хүрээнд чанарын шинжилгээний аргыг ашиглах замаар холбогдох ном зохиол, хэрэгжсэн судалгааны тайланг тоймлон судалж, дүгнэлт хийжээ.*

**Ц.Нямсүрэн, М.Отгонбаяр, Б.Дагзмаа** доктор (Ph.D), *МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим*

## МОНГОЛЫН НИЙГМИЙН ФИЛОСОФИЙН ЕРӨНХИЙ ЗУРАГ: 1990 ОНООС ХОЙШИХ НИЙГМИЙН ФИЛОСОФИЙН СУДАЛГААНД ХИЙСЭН ТОЙМ

***Товч утга:*** *Энэхүү судалгаагаар 1990 оноос хойш Монголд хөгжсөн нийгмийн философийн онол, арга зүйн хандлага, судалгааны ерөнхий агуулгыг нэгтгэн харуулахыг зорилоо. Ингэхдээ Монгол дахь нийгмийн философийн онцлог шинжийг тодорхойлох, онол арга зүйн хандлагыг багцлан тоймлох, үндсэн сэдэв, агуулгыг ангилан харуулах зорилт дэвшүүлэв. Судалгааны хүрээг философийн салбарт хийгдсэн, нийгмийн философитой холбоотой, 1990 оноос хойших докторын ажил болон тус талбарт шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан судлаачдын нэгэн сэдэвт бүтээлээр хязгаарлав. Загвар, аргын тухайд харьцуулсан судалгааны загвараар баримтын шинжилгээний фремвок анализын аргыг ашиглан гүйцэтгэлээ. Судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг нийгмийн философи, нийгмийн тухай философи, нийгмийн гүн ухаан, монголын нийгэм, монголын нийгмийн хөгжил гэсэн түлхүүр үгсээр шүүж, 1997-2018 оны хооронд бичиж хамгаалсан 9 докторын дипломын ажил, 1997-2017 оны хооронд хэвлүүлсэн нэгэн сэдэвт 13 зохиолд боловсруулалт хийв.*

**Ивлева М.Л.** Российский университет дружбы народов, Москва, Россия, **Иноземцев В.А.** МГТУ имени Н.Э. Баумана, Москва, Россия, **Баграмянц Н.Л.** Департамент человеческих ресурсов.

## КОНЦЕПЦИИ ИНФОРМАЦИОННОГО ОБЩЕСТВА КАК ТЕОРИИ СОЦИАЛЬНОГО ЗНАНИЯ

***Аннотация.*** *В статье выделяются и исследуются два основных подхода к изучению современного общества: концепции постиндустриального общества и концепции информационного общества. Устанавливается, что в концепциях информационного общества главное внимание обращается на понимание информации и знания как главного стратегического ресурса общества. В работе концепции информационного общества рассматриваются как теории социального знания*

*(Хавсралт 4)* Философи, шашин судлал эрдэм шинжилгээний ISSN 2220-959X сэтгүүлийн дугаар 23 (551).

## 3.5. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЛҮҮД

Судалгааны багийн судлаачид тус төслийн сэдэвт хамаарах олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх, мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх ажлуудыг мөн хийлээ.

1. Төслийн удирдагч, судлаач Б.Дагзмаа Н.Э Баумана нэрэмжит Москвагийн Техникийн Их сургуулийн зохион байгуулсан “Экология человека и природы информационно технической среде” (Эко Мир-10) олон улсын эрдэм шинжилгээний 10 дахь хуралд Ивлев И.Ю, Ивлева М.Л нартай хамтарсан “Экологические сознание и трансформация общественного сознания техногенного общества” илтгэл хэлцүүлж улмаар тус хурлын илтгэлийн эмхтгэлд хэвлэгдлээ *(Хавсралт 5)*.

2. Төслийн судлаач Ц.Нямсүрэн, А.Ган-Эрдэнэ, Т.Жаргалсайхан, М.Л.Ивлева нарын хамтарсан “КОВИД-19 цар тахлын үеийн нийгмийн сэтгэлзүй цахим орчинд”, М.Отгонбаяр, Б.Дагзмаа, В.А.Иноземцев нарын хамтарсан “Орчин үеийн нийгмийн өөрчлөлтийн тухай онолууд дахь шинжлэх ухаан, технологийн нөлөөллийн асуудал” сэдэвт илтгэлүүдийг Монгол Улсын ШУА-ийн Философийн Хүрээлэнгээс Дэлхийн Философичидын өдөрт зориулан зохион байгуулсан “Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл: философи асуудлууд” эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн *(Хавсралт 6)*.

3. Төслийн удирдагч, судлаач Б.Дагзмаа, Архириев Н.Л., Ивлева М.Л. нарын хамтарсан “Когнитивные исследования в кантианской перспективе: на пути к новому дискурсу” сэдэв өгүүлэл Бүх Оросын Ард Түмний Найрамдлын Их Сургуулиас эрхлэн гаргадаг шинжлэх ухааны сэтгүүлийн 2020 оны философийн цувралын 24-р ботийн 14-т хэвлэгдлээ *(Хавсралт 7)*.

4. Төслийн удирдагч, судлаач Б.Дагзмаа, М.Л.Ивлева, С.Н.Курилов нарын хамтарсан “Высшее образование глазами студентов (на примере мониторингового исследования выпускников МЭИ) сэдэв өгүүлэл Бүх Оросын Ард Түмний Найрамдлын Их Сургуулиас эрхлэн гаргадаг шинжлэх ухааны сэтгүүлийн 2020 оны

Социологийн цувралын 21-р ботийн 2-т хэвлэгдлээ (Скопусын санд бүртгэлтэй сэтгүүл *Хавсралт 8*).

5. Төслийн судлаач Ц.Нямсүрэн "Эрх мэдлийн зарим илрэл", төслийн судлаач Ц.Гомбосүрэн "Монголын хөгжлийн философийг боловсруулж буй үр дүнг шинжлэх нь" сэдэвт өгүүллүүдийг Философи, шашин судлал сэтгүүлийн 25(580) дугаарт хэвлүүлэхэд бэлэн болгосон *(Хавсралт 9)*.
6. "Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, тус хуралд төслийн судлаач М.Отгонбаяр, төслийн удирдагч Б.Дагзмаа нар "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөр, агуулгад хийсэн шүүмжлэлт зарим эргэцүүлэл", төслийн удирдагч Б.Дагзмаа, Философи, шашин судлалын тэнхимийн багш доктор Б.Мөнхжавхлан нар "Эрүү шүүлт ба түүний ёс зүйн асуудал" илтгэлийг тус тус хэлэлцүүлсэн болно. *(Хавсралт 10)*




**Зураг 2. Төслийн удирдагч Б.Дагзмаа тус хурлын хэлэлцүүлгийг удирдаж буй нь**




**Зураг 3. Төслийн багийн гишүүн М.Отгонбаяр илтгэл хэлэлцүүлэв**




**Зураг 4. Төслийн багийн гишүүн Ц.Нямсүрэн хурал хөтлөх үеэр**

## 3.6. НЭГЭН СЭДЭВТ БҮТЭЭЛ

Орчин үеийн нийгэм, улс төрийн чиглэлийн үзэл, онолуудын талаар нэгэн сэдэвт бүтээл бичих, хэвлүүлэх ажлыг гүйцэтгэв. 2 хэсэг, 8 бүлэг, 32 зүйл бүхий нэгэн сэдэвт хамтарсан бүтээлийг хэвлэлд бэлтгэж бэлэн болгов.

## ДҮГНЭЛТ

Бид “Нийгмийн ухаан: Орчин үеийн техноугшилт иргэншлийн сорилтууд” хамтарсан төслийн хүрээнд төлөвлөсөн ажлуудыг бүрэн гүйцэтгэж, төлөвлөгөөний дагуу ажиллаж дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

Төслийн зорилго, зорилтуудын хүрээнд хийх судалгааны ажлын арга зүй буюу төлөвлөгөө, дизайн боловсруулах, өгөгдөл, мэдээллийн сан бүрдүүлэх, тэдгээрт анализ хийх зэрэг ажлыг багийн гишүүд хамтран гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын хүрээнд дэвшүүлсэн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. 1990 оноос хойш Монголын академик хүрээлэлд нийгэм, улс төрийн философи, нийгмийн онолын чиглэлээр хийгдсэн судалгааны ажилд анализ хийж, түүхэн үнэлэлт өгөх гэсэн зорилгын хүрээнд нэгэн сэдэвт бүтээл, диссертацийн ажлуудыг олж цуглуулах, документын анализ болон харьцуулсан судалгааны загвараар баримтын шинжилгээний фремвок анализын аргыг ашиглан судалгаа хийлээ. Судалгааны үр дүнд эрдэм шинжилгээний өгүүлэл 2-ыг багийн гишүүд бичиж хэвлүүлэв. Мөн төслийн судлаачдын 2 өгүүлэл хэвлэлд шилжсэн байна.
2. Манай нийгэм, улс төрийн ухааны салбарт ажиллаж буй эрдэмтэн судлаачдын 6 өгүүлэл хэвлүүлэв.
3. МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн ахисан түвшний оюутнууд Б.Анар, Г.Уянга, Э.Баасандорж, Э.Эрхэс, Э.Янжинлхам нар төслийн судалгааны туслах ажилтнаар ажилласан:
4. 90 оноос хойшхи үеийн Монголын нийгмийн ухааны салбарын экспертийн түвшний судлаач нартай ярилцлагын аргаар судалгаа хийсэн.
5. Нийгмийн философи, нийгмийн судалгааны орчин үеийн онол, арга зүйн бүтээлүүдийн агуулгыг тайлбарласан нэгэн сэдэвт бүтээл гаргах гэсэн хоёрдугаар зорилгын хүрээнд номын агуулга, бүтцийн загвар болон ажлын төлөвлөгөө гарган ажиллаж, хоёр хэсэг, 8 бүлэг, 32 зүйл бүхий нэгэн сэдэвт бүтээлийн эхийг бэлтгэн хэвлэлд шилжүүлсэн болно.
6. Төслийн ажлын хүрээнд олон улсын болон үндэсний хэмжээнд зохион байгуулсан эрдэм шинжилгээний 3 хуралд оролцон, 5 илтгэл хэлэлцүүлэв. Мөн төслийн хүрээнд нэг эрдэм шинжилгээний хурал зохион байгуулав.
7. Оросын эрдэмтэдтэй хамтран гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд 2 өгүүлэл хэвлүүлсэн. Нэг нь Скопусын санд бүртгэлтэй сэтгүүл.

Төслийг хэрэгжүүлэх явцад давагдашгүй хүчин зүйл Ковидын халдвар гарч дэлхий даяар хөл хорио тогтоосны улмаас гадаад хамтын ажиллагааны талаар бидний төлөвлөсөн зарим ажил хэрэгжээгүй боловч бид онлайн хэлбэрээр Оросын талын хамтрагч нартайгаа

харилцан, хуралд онлайнаар оролцон илтгэлээ хэлэлцүүлэх, харилцан өгүүллээ нийтлүүлэх зэрэг аргаар ажилласан болно.

Эцэст дүгнэхэд бидний ажил тавьсан зорилгоо бүрэн биелүүлсэн, бидний хэвлүүлсэн мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллүүд, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, мөн нэгэн сэдэвт бүтээл манай их, дээд сургуулийн оюутан суралцагч нар болон судлаач нарт чухал судалгааны хэрэглэгдэхүүн болно гэж үзэж байна.

## ХАВСРАЛТ 1. СУДАЛГААНЫ СЭДЭВТ ХАМААРАХ СУДАЛГААНЫ АЖЛУУД БОЛОН НЭГЭН СЭДЭВТ БҮТЭЭЛҮҮДИЙН ЖАГСААЛТ

СЭДЭВТ ХАМААРАХ ДОКТОРЫН (PhD) ДИССЕРТАЦИ ХАМГААЛСАН СУДАЛГААНЫ АЖЛУУД

**Философи**

1. Б.Гантөмөр. Нүүдэлчдийн нийгмийн байгууллагын хөгжлийн онцлог, 1997
2. Ш.Ганхуяг. Нүүдлийн ба соёл иргэншлийн харилцаа нөлөөллийн гүн ухааны судалгаа 1998
3. Н.Эрдэнэтунгалаг. Монголын нийгмийн оюун санааны модернизацийн шинж төлөв хандлага, 1999
4. И.Лхам. Попперийн нээлттэй нийгмийн үзэл санаа ба ардчилсан үйл явц, философийн шинжилгээ, 2000
5. Г.Эрдэнэбаяр. Нийгмийн хөгжлийн талаархи философийн зарим сургааль, тэдгээрийн арга зүйн ач холбогдол, 2000
6. Б.Галиндэв. Монголын нийгмийн өөрчлөлтийн үе дэх ёс суртахууны асуудлууд, 2001
7. С.Давуудулам Монголын боловсролын тогтолцооны философи шинжилгээ 2007
8. Ц.Батбаяр Аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай үзэл баримтлалд хийсэн философи шинжилгээ УБ.,2013
9. Д.Ганболд. XX зууны эцэс XXI зууны эхэн үеийн нийгмийн гуманитар хөгжил ба деформацийн асуудал, 2013
10. М.Мөнхзул. Даяаршлын нөхцөл дэх үндэсний ухамсарын асуудал, 2016
11. Г.Уянга Боловсролын тухай Жон Дьюигийн философи үзэлд хийсэн шинжилгээ 2018

**Улс төр судлал**

1. Д.Мандах. Монголын өнөөгийн улс төрийн өөрчлөлт, иргэншлийн төлөвшлийн харилцан хамаарлын асуудал, 1998
2. Д.Ганбат. Монгол улс дахь ардчиллын хөгжлийн онол арга зүйн зарим асуудал, 2002
3. Г.Цэнд-Аюуш. Монголын нийгмийн улс төрийн ухамсар хувьслын зарим асуудал, 2011
4. Д.Отгончимэг. Монголын ардчилалд улс төрийн боловсролын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, 2017

**Социологи**

1. О.Мөнхбат. Нийгмийн социал бүтцийн онол арга зүйн асуудал. Монголын жишээн дээр, 1999
2. С.Түмэндэлгэр. Өнөөгийн монголын хөдөлмөр эрхлэлт дэх тусгаарлалтын асуудал, 2007
3. М.Батбаатар Монголчуудын амьдралын чанарт хийсэн социологийн дүн шинжилгээ (1990 оноос хойшхи үе), 2016
4. Г.Түмэннаст. Монголын нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцоонд хийсэн социологийн шинжилгээ, 2017
5. Ч.Тамир Ерээд оны Монголын олон нийтийн эсэргүүцлийн социологийн шинжилгээ 2018

**Нийгэм соёлын антропологи**

1. И. Бямбабаатар. Монгол дахь хөгжлийн байгууллагын интервенци мал аж ахуй байгаль хамгааллын жишээн дээр, 2019

СЭДЭВТ ХОЛБОГДОХ НЭГЭН СЭДЭВТ БҮТЭЭЛҮҮД

2. Н.Хавх Монголын нийгмийн гүн ухаан, УБ.,1997
3. Ц.Гомбосүрэн Нийгмийн тухай философийн интеграль /нэгтгэгч/ хувилбарыг боловсруулах эхлэл, УБ.,1999
4. Г.Чулуунбаатар XX, XXI зууны зааг үеийн монгол дахь иргэний нийгмийн төлөвшил хөгжил, УБ., 1999
5. Д.Болд-Эрдэнэ. Монголын улс төрийн нам, намын систем, УБ., 2000
6. Г. Гүндсамбуу. Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, УБ., 2002
7. Б.Батчулуун.Орчин үеийн зүй ёсны онолууд хийгээд монголын бодит байдал, УБ., 2002
8. Б.Батчулуун. Пост-коммунист нийгэм дэх төр иргэний харилцаа, УБ., 2003
9. Ш.Ганхуяг. Соёл иргэншил дэх байгалийн ба соёлын хүчин зүйлийн хамаарал, УБ., 2003
10. Б.Даш-Ёндон. Нийгмийг танихуй: түүх, хөгжлийн философи, УБ.,
11. Д.Дашпүрэв. Монголын нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн үе шатууд, УБ., 2005
12. Ж.Ядамсүрэн, Д.Даш-Ёндон. Эдийн засги йн онолын шим шүүсийн тойм, УБ., 2014
13. Д.Чулуунжав. Нийгмийн философи. Онол, туршилт, сургамж, шүүмж, УБ., 2014

14. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн хүндрэл: шалтгаан, шийдвэрлэх арга зам, ЭШХурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2014
15. ФСЭХ.  Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал, УБ., 2014
16. Ж.Ядамсүрэн. Капиталист биш хөгжлийн замын тухай онол, Монголд судлагдсан байдал, УБ.,
17. Р.Батмэнд. Монголын хөгжлийн бодлогын философи: Улс төрийн эдийн засгийн ухаан холбогдох нь, УБ.,2016
18. Д.Дашпүрэв. Монгол нийгэм (Философийн анализ), УБ., 2017
19. Б.Даш-Ёндон, Монголын хөгжлийн философи, УБ., 2017
20. О.Хатанболд  Ардчиллыг ойлгохуй ба судлахуй  УБ., 2017
21. Ц. Уртнасан Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ

# ХАВСРАЛТ 2. СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН СЭДЭВТ ХАМААРАХ БҮТЭЭЛҮҮДИЙГ СОФТ ХУВИЛБАРТ ХӨРВҮҮЛЖ, КОДЛОСОН ЖИШЭЭ




Зураг 5. Нэгэн сэдэв зохиолууд




Зураг 6. Нэгэн сэдэвт зохиолыг кодлосон жишээ




Зураг 7. Диссертациуд




Зураг 8. Диссертацийг кодлосон жишээ

**Хүснэгт 1. Софт хувилбарын жишээ**



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|

## Nodes\\Практик философийн асуудал\Философийн түүхэн судалгаа

| | No | 0.0577 | 1 | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | TS | 1/3/2021 11:53 AM |

Сэтгэгчдээс нийгэм-түүхийн философи сургаалыг боловсруулахдаа ямар ямар арга зарчмыг дэвшүүлж ирсэн тоймыг гаргаж, энэ хүрээнд формацын ба соёл иргэншлийн онолын байр суурийг тодорхойлох

## Internals\\A022

### Node

## Nodes\\Арга зүй

| | No | 0.0044 | 1 | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | TS | 11/10/2020 4:17 PM |

Орчин үеийн иргэншлийн хөгжлийн чиг хандлага, тухайлбал, нийгмийн гуманитар хөгжлийн бодит байдлын хэрэгжилт, деформаци үүсдэг шалтгаануудад түүх, одоо, ирээдүйн байр сууринаас түүхэн зарчим, нийгмийн үйл явцыг үндэслэхүйн (интерпретаци) парадигмыг механизмёлах хандлагатай хослуулан судалгаандаа хэрэглэсэн.

## Nodes\\Гарчиг

| | No | 0.0179 | 1 | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | TS | 11/10/2020 4:15 PM |

Гарчиг

Оршил..........................................................................................................................3

Нэгдүгээр бүлэг. Нийгмийи гуманитар хөгжил ба XX зууны нийгмийн деформаци

Нийгмийн гумаиитар хөгжлийн үзэл баримтлал, түүний философи арга зүйн үндэслэл ..........................................10

XX зууны нийгмийн хөгжил дэх дегуманизаци хандлага ба деформаци...................49





| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|

## Nodes\\Гол дүгнэлт

| | No | 0.0944 | 1 | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | TS | 11/10/2020 4:21 PM |

Дүгнэлт

Хүн төрөлхтөн эрт үеэс иргэншлээ цогцлон бүтээхийн тулд байгалийн ширүүн сорилтыг давж амьдралын шинэ орон зайг байлдан дагуулахын хамт байгалийг сүйтгэсээр ирсэн. Товчоор хэлбэл иргэншлийн дэвшил байгалийг доройтуулсантай шууд пропорциональ хамааралтай энэүү үйл явц нь үр дүнгээрээ иргэншил хөгжихийн тулд өөрийгөө мөхөөж ирсэн түүх, өөрийнх нь төрөлх мөн чанар гэлтэй хачирхалтай парадокс хүн төрөлхтөнийг сүүдэр мэт дагасаар байх нь нэгэнт тодорхой.

Нийгэм мөн чанартаа байгалийн жам ёсны бодит байдлын физиологи, биологийн хуулиуд нийгмийн түвшинд үйлчилж ирсний шууд үр даавар тул байгаль болон нийгэмд явагддаг үйл явцууд жам ёсны хөгжлийн дагуу төдийгүй, орчлон хорвоод үйлчилдэг байгалийн хуулиудын нэг адил тодорхой нийтлэг шинжтэй хэмээн ойлгож болно. Орчлонд хүмүүний төрлийн амьдарч, бүтээж, байгалийг доройтуулж ирсэн түүх өнгөрсөн болон одоод өөрт нь нэгэнт тодорхой, ойлгомжтой. Гэвч системийн анализын үүднээс авч үзвэл ирээдүйд хүмүүний тавилан хэрхэх нь тодорхойгүй. Учир нь хүмүүний төрөл ирээдүйд өмнө нь байж үзээгүй-. Биднээс өмнө орчлонгийн энэ хэсэгт урьд өмнө хөл тавьж байсан хүмүүн төрөл огт байхгүй. Үүний зэрэгцээ ирээдүй хүмүүст тодорхой бус олон хатуу ширүүн сорилтыг тулгасаар ирсэн бөгөөд цаашдаа ч мөн иймэрхүү хувь тавиланг хүмүүст "бэлэглэсээр" байх жамтай. Хүн өөрийн атгаг, сонирхол, санаархал, үйлдлийнхээ шалтгааныг (мотив) байгалийг доройтуулахгүй байж, ирээдүйгээс тодорхойгүй байдлаар тулгасан сорилтыг тодорхой болгоход нэгэн сэтгэлээр иулуудаж хөгжил дэвшил, хүмүүнлэгийн эрхэм зорилгын төлөө тэмцэх ганц зорилго үлдэж байгаа нь нийгмийн гуманитар хөгжил юм. Нийгмийн гуманитар хөгжлийг утга төгөлдөр байлгахын тулд хүн юу хийх ёстой вэ? гэсэн асуудал аяндаа зүй ёсоор дэвшигдэн гарч ирнэ.

Үүний тулд нийгмийн гүнд явагддаг, нийгмийн деформацийн үйлчлэлийн механизмуудын үйлчлэлийг танин мэдэх явдал хамгиин чухал юм. Эдгээр механизмуудын үйлчлэлийг урьдын адил цэвэр онолын хийсвэр хийц загвар (конструкфи)-аар бус, харин практик амьдралд тулгарч буй гол бэрхшээлүүд дээр шууд тулгуурлан зах зээлийн гэх өнөөгийн хэрэглээний нийгмийн бэрхшээлтэй асуудлуудыг прагматик аргаар шийдвэрлэх нь нэгэн хэсэгтээ гарцаагүй болж байгааг ухаарах нь чухал. Гэхдээ энэ нь сонгодог прадигмын чиглэлийн төлөөлөгчдийн онолын өвөөс татгалзахыг хэлж буй хэрэг бус. Энэхүү онолын өвийг өнөөгийн иийгэмд нэгэнт бүрэлдсэн ээдрээтэй бодит байдлын нехцөлд чадварлагаар, прагматик менталитетийг ашиглан хэрэглэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл. аливаа асуудлыг зөв шийдвэрлэхийн гол шалгуур нь үнэт зүйлс шинжгэй байх. Тухайлбал, үнэт зҮйлсийн шалгуур бүхий шинжлэх ухааны санаануудын шууд практик ашиг тусыг юуны өмнө

эрхэмлэх явдал юм.

Дээр хэлснээр хүн Өөрийн атгаг сонирхол, санаархал, үйлдлийнхээ Шалтгааныг (мотив) байгалийг доройтуулахгүй байх, еерийгөө хязгаарлаж чадахгүй бол оршин ахуйн үндсээ устгах буюу олон зууны турш шашин, философийн сэтгэлгээнд нөлөөлж, орчин үеийн философи, социологи, соёл судлалын үзэл баримтлалуудад хүртэл тусгалаа олж, ирээдүйн ертөнцийг байгуулах, түүний талаар эргэцүүлэхийн өвөрмөц эхлэл байхаас цааш хэтрээгүй эсхатологийн домог үлгэрүүд нь үнэн хэрэгтээ тодорхой хэмжээгээр үнэний хувьтай болохыг өнөөгийн иргэншлийн хямралт сэрэхүй, хүртэхүй, хямралт ухамсар (апокалипсис), деформацчлагдсан төлөв байдал батлах мэт болж байна.

Хүн төрөлхтөн өнөөгийн шиг хүнд нөхцөлд урьд өмнө хэзээ ч оршин байсангүй. Амернкнйн эрдэмтэн, Гарвардын их сургуулийн профессор С.Хантингтон "Иргэншлүүдийн мөргөлдөөн ба дэлхийн дэг журмыг дахин өөрчлөн зохион байгуулах нь" (1996) нэртэй бүтээлдээ хүн төрөлхтний иргэншлүүд сергөлдөөний (конфронтаци) байдалд орж, хятад, энэтхэг, исламын. христийн гэсэн 4 хэсэгг хуваагдсаныг онцлон тэмдэглээд, эдүгээ иргэншлүүд хамтран ажиллах бус, харин сөргөлдөн тэмцэлдэх нь гарцаагүй болоод байна хэмээн сэрэмжлүүлснээС ХОЙШ 5 жилийн дараа исламын террористуудын зүгээс АНУ-д 2001 оны 9 дүгээр САРЫН 11-ний өдөр АНУ дахь Дэлхийн худалдааны төвд зэрлэгээр халдсан явдал анөөгийн иргэншлийн хямралт сэрэхүй, хүртэхүй, хямралт ухамсарын (анокалипсис) нөлөөгөөр деформаци улам илүү глобаль шинжтэй болж байгаагийн нотолгоо юм. Өнөө үед хүн төрөлхтөн өмнө нь бодит байдалд, байгальд хандаж байсан нийгмийн буруу практикт эргэж шүүмжлэлгэй хандах, улмаар деформациин тодорхой бус зүсэн бүрийн хэлбэрийн илрэлээс өөртөө хал балгүйг нь сонгон тодорхой болгон, туулж ирсэн амьдралынхаа алдааг засахын (коэволюциин үзэл баримтлал) тулд деформацийг аль болохоор хамгийн бага хэмжээнд байлгах, тэр дундаа нийгмийн гүнд явагдаж буй үйл явцуудын деформацийн механизмын нууцыг үндэслэхүйн парадигмын тусламжтайгаар нээн илрүүлж амьдралаа зөв залж сурах явдал хүн төрөлхтний шийдвэрлэх асуудлуудын дундаас хамгийн чухлаар тавигдаж байна.

Энэхүү асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хөгжил хэмээх үйл явцыг шинээр авч үзэх явдал эхний ээлжинд тавигдаж байна. Дэлхийн II дайны дараахи жилүүдэд эдийн засгийн өсөлт олон улс орны уруудалтын асуудлыг шийдэж чадахгүй гэдэг нь илэрхий болсон зэрэг нь хөгжлийн тухай шинэ ойлголтыг боловсруулахад тус дөхөм болсон билээ. Эдүгээ нийгмийн хөгжил бол хүний хөгжил мөн хэмээх үзэл шинэ гуманитар парадигм төлөвшиж эхлэж байна. Энэ парадигм ёсоор хүн урт удаан эрүүл энх амьдрах, эрдэм мэдлэг олж авах. боломжийн амьдралын түвшинд хүрэхэд шаардагдах баялгийг хүртэх гэсэн гурван чухал сонголтыг тулгуур болгои авч үздэг. Хэрэв эдгээр сонголтыг хийх боломж нөхцөл хомс болоход бусад олон



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|

үлдэж байна.

## Nodes\\Зорилго

| | Yes | 0.0211 | 2 | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | TS | 11/10/2020 4:15 PM |

Орчин үеийн глобаль асуудлуудыг гуманизмын байр сууринаас шийдвэрлэхэд нийгмийн хөгжлийн эрч хүчийг алдагдуулж буй деформацийн механизмын үйлчлэлийг тодорхойлох.

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2 | TS | 11/10/2020 4:16 PM |

Орчин үеийн глобаль асуудалд гуманизмын байр суурьнаас хандаж, тулгарн буй бэрхшээл зөрчлийг шийдвэрлэхэд нийгмийн философийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох;

Нийгмийн гуманитар хөгжилд нийгмийн оюунлаг болон зан суртахууны үнэт зүйлсийн утга алдагдал (дегуманизаци). ёс суртахууны хөсөрдөлт (деморализаци), зан суртахууны доройтол (деградаци) зэрэг чиг хандлагуудыг деформацитай

харьцуулан тогтоох;

Нийгмийн гуманитар хөгжлийг хүн төрөлхтний гуманизмын үзэл санааны баялаг өв санд өнөөгийн нийгмийн зэдрээтэй

## Nodes\\Зорилго\Зорилт

| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|
| | No | 0.0188 | 1 | | | |
| | | | | 1 | TS | 11/10/2020 4:16 PM |

Орчин үеийн глобаль асуудалд гуманизмын байр сууринаас хандаж, тулгарн буй бэрхшээл зөрчлийг шийдвэрлэхэд нийгмийн философийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох;

Нийгмийн гуманитар хөгжилд нийгмийн оюунлаг болон зан сургахууны үнэт зүйлсийн утга алдагдал (дегуманизаци). ёс сургахууны хөсөрдөлт (деморализаци), зан суртахууны доройтол (деградаци) зэрэг чиг хандлагуудыгдеформацитай харьцуулан тогтоох;

Нийгмийн гуманитар хөгжлийг хүн төрөлхтний гуманизмын үзэл санааны баялаг өв санд өнөөгийн нийгмийн зэдрээтэй нөхцлийн хүрээнд дахин шинээр хандаж нийгмийн философийн үүднээс үнэлгээ өгөх;



## Nodes\\Нийгмийн эмгэг зүй

| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|
| | No | 0.1675 | 2 | | | |
| | | | | 1 | TS | 12/26/2020 8:59 AM |

Хариуцлагагүй засаглалын нийгмийн хор уршгийг өнөөгийн монголын нийгмийн жишээн дээр тодорхойлсон.



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2 | TS | 12/27/2020 12:44 PM |

Эднйн засгийн амьдралмн хүрээний деформаци:

Сүүдэр эдийн засгийг зузаатгаж, улсын төсөвт орох орлогыг багасгахаас гадна төрийг удирдлагыг хөшүүрэггүй болгодог.

Шударга өрсөлдөөнийг үгүй хийж, өрсөлдөх чадвар муутай этгээдүүдэд давуу байдал олгодог. Ингэснээр зах зээлийн харилцааг нурааж оронд нь авлилгын монполиуд гарч ирнэ.  Эдгээр нь ихэвчлэн гэмт хэргийн ертөнцтэй холбоотой ажилладаг. Эцсийн дүнд улс орны эдийн засгийн үр ашиг буурдаг.

Төрийн зүгээс зах зээлийн харилцааны дүрмийг сахин хамгаалах үүргийг алдагдуулж, зах зээлийн үзэл санааг гутааж, тор нь нийгмийн ерөнхий арбитр, шүүгч байх ёстойг нэр хүндгүй болгодог. Соёлтой зах зээлийн харилцаанд саад чөдөр болдог.

Өмч хувьчлалд сөргөөр нөлөөлж, ядуурлыг ихэсгэж, нийгэмд үр өгөөжтэй өмчтөнгүүдийг гарч ирэх замыг хаадаг.

Дээрх бүх сөрөг нөлөөллөөс болж төсвийн зарцуулалт зохисгүй явагдаж, төсвийн

хямрал гүнзгийрдэг.

Эдийн засгийн субъектүүдийн зардлыг эрс нэмэгдүүлснээр энэ нь цаашдаа жирийн хэрэглэгчдийн хэрэглээний сагсны үнэ, тариф ихсэхэд зайлшгүй хүргэдэг.

Төрийн удирдлагын байгууллага болон томоохон корпорациудын удирдлагын аппаратыг ч задлана. Төрийн болон арилжааны үйл ажиллагааны удирдлагын үр ашиг буурна.

Нийгмийн удирдлагьш потенциал нийт улс орны хөгжлийн ашиг сонирхолоос эх орны баялагийг хулгайлагчдьш сонирхолыг хэрэгжүүлэхэд шилжин хөтлөгддөг.

Өргөн хэмжээтэй авилга шудрага бус өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжиж, гадаадын

болон дотоодын хөрөнгө оруулагчдыг татах боломжгүй болгодог.

Авилга бол ялзарсан, эсхүл нийгэмд ач тусаа үзүүлээгүй хөрөнгө оруулалтаас өөр юу ч биш.

Хөрөнгөгүй хүмүүс хөгжлийн ямарваа дэмжлэг төрөөс авах боломжгүй болдог. Авсан ч маргааш нь төр эргээд уг хүмүүсийг хоосруулна. Үүний хариуцлагыг хэн ч хүлээхгүй өнгөрнө. Засаглалтай ойр шадарласан хэн нэгний хөрөнгө оруулалт нийгэмд үр ашиггүй, зөвхөн богино хугацааны санхүүгийн луйвар, өмч шудрага бусаар олж авах, засаглалыг авилгаар цаашид зэврээхэд л хэрэгтэй.



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|

сонгуульд ялсан нам өөрийн "диктатурыг" тогтоож мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ тулаад ирэхээр намын ашиг сонирхолыг төрөөс дээгүүр тавьж, нам төрийн хэрэгт хөндлөнгөөс оролцдог муу практик хэвийн үзэгдэл хэвийн болдог.

"Нийгмийг шинэчлэгчид" "улс төрөөр халхавчлагдсан бизнесийн төрлүүдийг" бий болгоход үнэхээр их санаа тавьдаг. Бизнесийн эдгээр төрөл нь засгийн эрх авсан бүлгүүдэд баяжих зорилгыг нь хангах боломж олгохоос гадна тэдний хувьд нийгмийн ажил хэрэгч үйл ажиллагаа явагдаж буй мэт дүрээр нийгэм санхүүтийн найдвартай бааз нь болж байдаг. Шинэчлэгчид ийм замаар "сүүдэр хангамжтай" болсноор авилгыг өөгшүүлж. улам лавшруулдаг. "Улс төрөөр халхавчлагдсан бизнесийн төрлүүд"-д дараах өргөн цар хүрээтэй үйл явцууд хамрагдана. Үүнд:

"Нийгмийг шинэчлэгчид" эхлээд өмч хувьчлалыг явуулахад хуулиар баталгаажуулахын зайлшгүйг сурталчилна. Энэ нь ч нэг талаар зөв гэдэг нь эргэлзээгүй;

Төсвийн хэрэгслийг янз бүрийн аян шалтагаар "сүүдрийн дахин хуваарилалт" хийнэ. Жишээ нь, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах нэрийн дор арилжааны зуучлагчдаар дамжуулан гадаадын санхүүгийн луйварчдыг дэмжиж дундаас нь мөнгө зувчуулдаг;

Төрийн хяналтгүйн улмаас үгүйрэл хоосрол газар авч, эрүүгийн нөхцөл байдал хүндэрч, өмчийг хуваах явдал улам замбараагүй эрээ цээргүй болдог;

Төрийн удирдлагын талаас ямар ч хяналтгүйгээр олон улсын санхүүгийн байгууллагын хэрэгслийг ашиглаж эхлэдэг;

Төрийн захиргааны, хяналтын, санхүүгийн болон шүүхийн хүч суларна. Төр хүчгүйднэ. Улс орны иргэд, үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн өмнө хүлээсэн үүргээ түүлж чадахгүйд хүрдэг. Төрийн үйлчилгээний хомсдол үүснэ. Хомсдол буй газар оочер дараалал бий болно. Үүн дээр авилга дөрөөлж нийтийг хамарсан шинжтэй болдог. Төр үүргээ биелүүлж чадахгүй болсноор үйл ажиллагаа нь илүү хаалттай болно. Төрийн тунгалаг байдал үгүй болоход ард олны зүгээс элдэв шаардлагатай тулгардаг. Төрийн нийгмийн удирдлага хаалттай болсноор нийгэмд тавих хяналт нь суларч энэ нь авилгачдад хамгийн таатай нөхцөл

болно. Чухамдаа төрийн санхүүгийн шийдвэр гаргах механизм тунгалаг бус болсноор хөрөнгө чинээтэй түшмэдүүдийн анги буюу каст үүсдэг.

Нийгэмд өөрсдийн эрх болон ашиг сонирхолыг хамгаалахад нэгдэх тухай индивидуализмын орчин үеийн ойлголтын үзэл санааг бус, харин нийгмийг жижиглэн тархай бутархай болгон хуваах дээр үндэслэсэн бүдүүлэг индивидуализмыг системтэйгээр сурталчилж эхлэнэ. Авилгыг хөгжлийн нэг механизм хэмээн өмгөөлж хаацайлах явдал түйлширч, "авилга ардчилалыг хамгаалж байна", "авилга коммунизмаас илүү дээр" гэх мэтийн лоозунгийн хэлбэрээр ч илэрч болно;



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|

## Nodes\\Практик философийн асуудал

| | Yes | 0.2076 | 1 | | | |
|---|---|---|---|---|---|---|



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | TS | 1/3/2021 11:56 AM |

Нэгдүгээр бүлэг

Нийгмийн гумаиитар хөгжил ба XX зууны нийгмийн деформаци

1.1. Нийгмийн гуманитар хөгжлийн үзэл баримтлал, түүний философи арга зүйн үндэслэл

Орчин үеийн глобаль асуудлыг гуманизмын байр суурьнаас шийдвэрлэхэд нийгмийн философийн үүрэг нь онцгой чухал. Нийгмийн философийн үүрэг нь амьдралын тодорхой чанар. хүнлэг утгыг онолын ухамсрын байрнаас тоггоож өгөх явдал юм. Ялангуяа "Хөгжлийн нь хэтийн төлөв тодорхой биш болчихвол, нийгэмшилтийн хэлхээ холбооны системийг шинэчлэх хэрэшээ гарвал, соёлын нөөц боломжийг ашиглах, хүний хүчин зүйлийг идэвхижүүлэх шинэ хэрэгсэл хэрэггэй болвол нийгмийн философийг судлах шаардлагатай болдог". Өөрөөр хэлбэл, эдүгээгийн нийгмийн өмнө тулгарч буй адармаатай олон асуудлыг шийдвэрлэхэд эдгээрийн хэрхэн үүссэн гол шалтгаан нь нийгмийн гуманитар хөгжлийн оронд деградаци, дегуманизаци чиг хандлагууд давамгайлж ирсний улмаас бэрхшээл учирч, нийгмийн гуманизаци дутагдаж, нийгэм деформацичлагдаж. улмаар иргэншил мөхлийн аюулд өртөх магадлал нэмэгдсэн хэмээн үзэж болно.

Нийгмийн хөгжил иргэншлийн төдийгүй тив, бүс нутгийн түвшинд гуманитар шинжтэй байж чадахгүй байсаар хүн төрөлхтөн XXI зуунтай золгов. Үүний шалтгаан юунаас болоод байгааг нийгмийн шинжлэх ухааны уламжлалт арга зүйн парадигмаар дүрслэх явдал хангалтгүй болов. Учир нь нэгэнт бий болж бүрэлдэн тогтсон нийгмийн хөгжлийн бодит байдал улам ээдрээтэй (сакраль шинжтэй) болсон тул үүнийг танин мэдэхэд нийгмийн гүнд болж буй нарийн үйл явцууд ямар механизмуудын үйлчилгээгээр (механизмчлах хандлагын үүднээс) хоорондоо зохицон явагдаж эхлэснийг илрүүлэн гаргах хүнд бөгөөд хэцүү үүрэг нийгмийн шинжлэх ухаануудын өмнө цаг үеийн шаардлага (императив) болон

танин мэдэхэд шаардагдах зорилго, суурь (базис) зарчмаар нь зааглан авч үзэхийг үгүйсгэхгүй байж болно. Байгаль шинжлэлийн ухаан үүссэн үеэсээ эхлэн байгалийн үзэгдэл юмсыг тайлбарлах буюу үндэслэх (судлагдаж буй зүйлийг

тодорхой хуулиудтай жиших замаар үндэслэх сэтгэлгээний арга барил). шалтгаан болон хөдөлгөгч зүй тогтлыг нь илрүүлэх. өөрөөр хэлбэл, үндэслэхүйн парадигмын хүрээнд хөгжсөөр ирсэн. Нийгэм түүхийн мэдлэг нь өнгөрсөн болон одоогийн нийгэм-түүхийн үйл явдлыг дэлгэрэнгүй, гоёмсогоор, заримдаа бүр ашигтайгаар (нийгэм улс төрийн конъюнктурын үүднээс) дүрслэх парадигмын хүрээнд хөгжиж байсныг олон баримт өгүүлдэг.

Өрнөдийн шинжлэх ухааны уламжлалд шинжлэх ухаануудыг science (шинжлэх ухаан) and art (дүрслэх урлаг) хэмээн ангилаад тухайн үеийн нийгмийн шинжлэх ухаануудыг аг1й гэсэн ангилалд хамааруулан үздэг байв. Учир нь нийгмийн тухай хүн төрөлхтний анхны мэдлэг нь ертөнцийг хүртэхүйн дүрслэх хэлбэр болсон домог үлгэр, шашны төсөөллөөс эх авсан байдгийг олон эх сурвалжууд нотлодог. Тухайлбал, О.Конт социологийг физик, хими, биологийн нэгэн адил фундаменталь шинжлэх ухаан хэмээн үзээд өндөр нарийвчлал, логик зүй тоггол, туршлагаар шалгагдах үндэслэл бүхий позитив байгаль шинжлэлтэй дүйцэх ёстой гэж үзэж байжээ.  Үүний зэрэгцээ нийгмийн хөгжлийн асуудал сонгодог парадигмын олон чиглэлийн төлөөлөгчдийн бүтээлүүдэд тусгалаа олсон байдаг. Тухайлбал, эволюционизм (О.Конт. Г.Спенсер, Э.Дюркгейм), түүхэн үе шатны онолууд (В.Парето, Н. Данилевский. О.Шпенглер, П.Сорокин) болон түүхийн материализм(К.Маркс, Ф.Энгельс, Д.Лукач. Г.Осипов, и др.) гэх мэт. Эдгээр төлөөлөгчид тухайн үедээ нийгмийн хөгжлийн асуудалд социологийн философийн анализ хийхийг зорьсон нь тодорхой.



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|

бүлэг, бодьгалууд гэх мэт) зохицуулагддаг. Эдийн засаг, улс төр болон бусад үйл явцуудын нийгмийн механизмын тухай санаа нь эдгээр үйл явц, хүчин зүйлүүд, хамаарал зэрэг нь хамтдаа нийлээд нь бүхэл бүтэн цогц үзэгдэл (феномен) бий болгодог. Энэхүү цогц үзэгдлийг судласнаар нийгмийн далд зүй тогтлын гүнд нэвтрэн орох боломж бүрдэнэ хэмээдэг. Нийгмийн механизм хэмээх категорийг эдүгээ нийгэм судлаачид төдийгүй, тухайлбал, ОХУ-д социологийн нилээд хэдэн сургуулиуд (Т.И. Заславская. Р.В. Рывкина, М.А. Шабанова. Л.Я. Косалс. Е.А. Якуба) арга зүйн суурь элементээ болгон

ашиглаж байна.

Нийгмийн механизм хэмээх категорийг пракгикг хэрэглэснээр нийгмийн үйл явцууд, системийг үүсгэдэг нийтийн холбоосыг үндэслэхүйн парадигмаар тайлбарлан улмаар нийгмийг удирдах боломжийг бүрдүүлдэг ач холбогдолгой. Нийгмийн үйл явцын механизмд өнгөрсөн, одоогийн элементүүд агуулагдаж буй тул эдгээр нь ихэнхдээ идэвхигүй шинжтэй байдаг учраас хэсэгчилсэн байдлаар байнга шинэчилж байх шаардлага гардаг. Үүнээс гадна дээрх элементүүдэд тодорхой зорилгод хүрэхийн тулд бүтээгдсэн, мөн түүхэн жам ёсоор хөгжиж ирсэн үзэгдлүүд (феномен) нэгэн зэрэг оршиж байдаг. Эхнийх нь нийгмийн өөрчлөн байгуулалтын замаар, дараах нь нийгмийн хувьслын замаар аажимдаа өөрчлөгдсөөр байдаг.

Янз бүрийн нийгэмд үйлчилдэг нийгмийн механизмын шинж төлөв нь байгууламжлагдсан (институцижсэн) бүтцийн онцлог, тухайн нийгэмд тогтворжсон харилцааны нөхөн үйлдвэрлэл, мөн түүнчлэн нийгмийн тодорхой өөрчлөлтөөр тодорхойлогддог. Нийгмийн үйл явц хичнээн их хэмжээгээр нийтийг хамарсан байхаас шалтгаалж энэхүү үйл явцыг зохицуулдаг механизм нарийн бөгөөд олон талтай байдаг учраас уг үйл явцын тодорхой болгох нь нилээд бэрхшээлтэй болдог.

Нийгмийн механизм хэмээх категорийн үйлчлэх цар хүрээ өргөн. Нийгмийн удирдлага, хүн ам зүйн хөгжил, нийгмээс авч явуулж буй хөдөлмөрийн урамшуулалт, миграцийн чиг баримжаа, бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжил, хууль эрх зүйн бус практикийн болон эдийн засгийн хөгжлийн нийгмийн механизмын трансформаци гэх мэт.

Ийнхүү нийгмийн хөгжил хэрхэн явагддаг талаар онол арга зүйн шинжтэй судалгаанууд олон хийгдэж ирсэн ч өнөөгийн нийгмийн шинжлэх ухаанд нийгмийн харилцан үйлчлэлийн механизм хэрхэн явагддаг тухай судалгааны тулгуур асуудлын нууц одоо хүртэл ойлгомжгүй тодорхой бус байна. Нийгмийн шинжлэх ухаанууд жинхэнээрээ шинжлэх ухааны статусын төлөө өрсөлдөх ёстой хэмээн үзэх юм бол нийгэм гээчийн үүсэл, хөгжил, үйл ажиллагааных нь дотоод фундаменталь

механизмуудыг илрүүлсэн цагт мөн чанарыг нь үндэслэхүйн парадигмын тусламжтайгаар танин мэдэх үүргээ биелүүлнэ хэмээн үзэж болно.

Энэхүү шинэ парадигмын ерөнхий чиг хандлага нь өмнөх парадигмыг бодвол илүү практик шинжтэйн (илүү прагматик - хэмээн ойлговол зохистой. Д.Г) зэрэгцээ эдүгээгийн болж буй нийгмийн бүх үзэгдэл, үйл явцын шалтгааныг илрүүлэх чадвартайгаас гадна, эдгээрийн хөгжлийг урьдчилан харах, удирдах, мөн түүнчлэн нийгмийн шинжлэх ухаануудын өмнө тулгарч буй шаардлагыг байгаль шинжлэлтэй уялдуулах хандлага руу эрдэмтдийн санаа бодол чиглэх болов. Энэ талаар Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс 2008 онд туурвисан "Монголын нийгмийн өөрчлөлтүүд" хамтын бүтээлд 1990 оноос хойшхи шилжилтийн үеийн монгольш нийгмийн амьдралд гарсан язгуур өөрчлөлтүүдийг олон талаас нь судласан дорвитой сайн бүтээл болсныг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ "философийн аливаа үзэл сургаалд улс төрийн үзэл суртлын хэмжүүрээр хандах хандлагыг халлаа. Үндэсний өвөрмөц онцлог, уламжлалт сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлд нааштай өөрчлөлтийг эхлүүллээ. Философийн судалгаа, сургалтын ажилд бүтээлч, шүүмжлэлт хандлага идэвхжлээ. Философид прагматик хандлага бий болж эхэллээ"гэжээ. Товчоор хэлбэл, "нийгмийн инженерчлэл"-ийн хэрэгцээ байгааг судлаачид янз бүрээр илэрхийлэх болов.



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|

байгалийн хүчин зүйлийн оролцоог нээх зорилго бүхий онолууд юм. Эдгээрийн тоонд газар зүйн детерминизм, геополитнкнйн онолууд орно. Жишээ нь, угсаатны гарвалжын талаарх Л.Н.Гумилевын онол, В.И.Вернадскийн оюун мандал (ноосфер)-ын үзэл баримтлал гэх мэт. Өнөө үед нийгмийн харилцан үйлчлэлийн хүрээнд микро- түвшний нийгмийн онолууд ч (М.Веберийн ойлгохуйн социологи, нийгмийн солилцооны онол, бэлэгдлийн интеракционизм) аль хэдийн боловсрогджээ



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|

## Nodes\\Практик философийн асуудал\Философийн түүхэн судалгаа

| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|
| | No | 0.2076 | 1 | | | |
| | | | | 1 | TS | 1/3/2021 11:56 AM |

Нэгдүгээр бүлэг

Нийгмийн гумаиитар хөгжил ба XX зууны нийгмийн деформаци

1.1. Нийгмийн гуманитар хөгжлийн үзэл баримтлал, түүний философи арга зүйн үндэслэл

Орчин үеийн глобаль асуудлыг гуманизмын байр суурииаас шийдвэрлэхэд нийгмийн философийн үүрэг нь онцгой чухал. Нийгмийн философийн үүрэг нь амьдралын тодорхой чанар. хүнлэг утгыг онолын ухамсрын байрнаас тоггоож өгөх явдал юм. Ялангуяа "Хөгжлийн нь хэтийн төлөв тодорхой биш болчихвол, нийгэмшилтийн хэлхээ холбооны системийг шинэчлэх хэрэшээ гарвал, соёлын нөөц боломжийг ашиглах, хүний хүчин зүйлийг идэвхижүүлэх шинэ хэрэгсэл хэрэггэй болвол нийгмийн философийг судлах шаардлагатай болдог". Өөрөөр хэлбэл, эдүгээгийн нийгмийн өмнө тулгарч буй адармаатай олон асуудлыг шийдвэрлэхэд эдгээрийн хэрхэн үүссэн гол шалтгаан нь нийгмийн гуманитар хөгжлийн оронд деградаци, дегуманизаци чиг хандлагууд давамгайлж ирсний улмаас бэрхшээл учирч, нийгмийн гуманизаци дутагдаж, нийгэм деформацичлагдаж. улмаар иргэншил мөхлийн аюулд өртөх магадлал нэмэгдсэн хэмээн үзэж болно.

Нийгмийн хөгжил иргэншлийн төдийгүй тив, бүс нутгийн түвшинд гуманитар шинжтэй байж чадахгүй байсаар хүн төрөлхтөн

XXI зуунтай золгов. Үүний шалтгаан юунаас болоод байгааг нийгмийн шинжлэх ухааны уламжлалт арга зүйн парадигмаар дүрслэх явдал хангалтгүй болов. Учир нь нэгэнт бий болж бүрэлдэн тогтсон нийгмийн хөгжлийн бодит байдал улам ээдрээтэй (сакраль шинжтэй) болсон тул үүнийг танин мэдэхэд нийгмийн гүнд болж буй нарийн үйл явцууд ямар механизмуудын үйлчилгээгээр (механизмчлах хандлагын үүднээс) хоорондоо зохицон явагдаж эхлэснийг илрүүлэн гаргах хүнд бөгөөд хэцүү үүрэг нийгмийн шинжлэх ухаануудын өмнө цаг үеийн шаардлага (императив) болон

танин мэдэхэд шаардагдах зорилго, суурь (базис) зарчмаар нь зааглан авч үзэхийг үгүйсгэхгүй байж болно. Байгаль шинжлэлийн ухаан үүссэн үеэсээ эхлэн байгалийн үзэгдэл юмсыг тайлбарлах буюу үндэслэх (судлагдаж буй зүйлийг тодорхой хуулиудтай жиших замаар үндэслэх сэтгэлгээний арга барил). шалтгаан болон хөдөлгөгч зүй тогтлыг нь илрүүлэх. өөрөөр хэлбэл, үндэслэхүйн парадигмын хүрээнд хөгжсөөр ирсэн. Нийгэм түүхийн мэдлэг нь өнгөрсөн болон одоогийн нийгэм-түүхийн үйл явдлыг дэлгэрэнгүй, гоёмсогоор, заримдаа бүр ашигтайгаар (нийгэм улс төрийн конъюнктурын үүднээс) дүрслэх парадигмын хүрээнд хөгжиж байсныг олон баримт өгүүлдэг.

Өрнөдийн шинжлэх ухааны уламжлалд шинжлэх ухаануудыг science (шинжлэх ухаан) and art (дүрслэх урлаг) хэмээн ангилаад тухайн үеийн нийгмийн шинжлэх ухаануудыг аг1й гэсэн ангилалд хамааруулан үздэг байв. Учир нь нийгмийн тухай хүн төрөлхтний анхны мэдлэг нь ертөнцийг хүртэхүйн дүрслэх хэлбэр болсон домог үлгэр, шашны төсөөллөөс эх авсан байдгийг олон эх сурвалжууд нотлодог. Тухайлбал, О.Конт социологийг физик, хими, биологийн нэгэн адил фундаменталь шинжлэх ухаан хэмээн үзээд өндөр нарийвчлал, логик зүй тоггол, туршлагаар шалгагдах үндэслэл бүхий позитив байгаль шинжлэлтэй дүйцэх ёстой гэж үзэж байжээ. Үүний зэрэгцээ нийгмийн хөгжлийн асуудал сонгодог парадигмын олон чиглэлийн төлөөлөгчдийн бүтээлүүдэд тусгалаа олсон байдаг. Тухайлбал, эволюционизм (О.Конт. Г.Спенсер, Э.Дюркгейм),түүхэн үе шатны онолууд (В.Парето, Н. Данилевский. О.Шпенглер, П.Сорокин) болон түүхийн материализм( К.Маркс, Ф.Энгельс, Д.Лукач. Г.Осипов, и др.) гэх мэт. Эдгээр төлөөлөгчид тухайн үедээ нийгмийн хөгжлийн асуудалд социологийн философийн анализ хийхийг зорьсон нь тодорхой.



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|

болж байна Энэхүү ойлгошыг анх О.Конт нийгэм нь «нийгэмжсэн биет», бүхэллэг, амьдрах чадвар бүхий шинжийг агуулсан гэдгийг харуулахьш тулд хэрэглэсэн. Түүний үзсэнээр нийгэм бүр аливаа сорилтыг тэсэн амьд гарах, хөгжих өөрийн гэсэн нийгмийн механизмтай. Нийгмийн механизм нь нэг талаас нийгмийн институтүүдээр (тоглоомын формаль болон формаль бус дүрмүүд), нөгөө талаас, акторуудын нийгмийн статус болон соёлын онцлогоор (удирдлагын байгууллагууд, бусад байгууллагууд, бүлэг, бодьгалууд гэх мэт) зохицуулагддаг. Эдийн засаг, улс төр болон бусад үйл явцуудын нийгмийн механизмын тухай санаа нь эдгээр үйл явц, хүчин зүйлүүд, хамаарал зэрэг нь хамтдаа нийлээд нь бүхэл бүтэн цогц үзэгдэл (феномен) бий болгодог. Энэхүү цогц үзэгдлийг судласнаар нийгмийн далд зүй тогтлын гүнд нэвтрэн орох боломж бүрдэнэ хэмээдэг. Нийгмийн механизм хэмээх категорийг эдүгээ нийгэм судлаачид төдийгүй, тухайлбал, ОХУ-д социологийн нилээд хэдэн сургуулиуд (Т.И. Заславская. Р.В. Рывкина, М.А. Шабанова. Л.Я. Косалс. Е.А. Якуба) арга зүйн суурь элементээ болгон

ашиглаж байна.

Нийгмийн механизм хэмээх категорийг пракгикг хэрэглэснээр нийгмийн үйл явцууд, системийг үүсгэдэг нийтийн холбоосыг үндэслэхүйн парадигмаар тайлбарлан улмаар нийгмийг удирдах боломжийг бүрдүүлдэг ач холбогдолгой. Нийгмийн үйл явцын механизмд өнгөрсөн, одоогийн элементүүд агуулагдаж буй тул эдгээр нь ихэнхдээ идэвхигүй шинжтэй байдаг учраас хэсэгчилсэн байдлаар байнга шинэчилж байх шаардлага гардаг. Үүнээс гадна дээрх элементүүдэд тодорхой зорилгод хүрэхийн тулд бүтээгдсэн, мөн түүхэн жам ёсоор хөгжиж ирсэн үзэгдлүүд (феномен) нэгэн зэрэг оршиж байдаг. Эхнийх нь нийгмийн өөрчлөн байгуулалтын замаар, дараах нь нийгмийн хувьслын замаар аажимдаа өөрчлөгдсөөр байдаг.

Янз бүрийн нийгэмд үйлчилдэг нийгмийн механизмын шинж төлөв нь байгууламжлагдсан (институцижсэн) бүтцийн онцлог, тухайн нийгэмд тогтворжсон харилцааны нөхөн үйлдвэрлэл, мөн түүнчлэн нийгмийн тодорхой өөрчлөлтөөр

тодорхойлогддог. Нийгмийн үйл явц хичнээн их хэмжээгээр нийтийг хамарсан байхаас шалтгаалж энэхүү үйл явцыг зохицуулдаг механизм нарийн бөгөөд олон талтай байдаг учраас уг үйл явцын тодорхой болгох нь нилээд бэрхшээлтэй болдог.

Нийгмийн механизм хэмээх категорийн үйлчлэх цар хүрээ өргөн. Нийгмийн удирдлага, хүн ам зүйн хөгжил, нийгмээс авч явуулж буй хөдөлмөрийн урамшуулалт, миграцийн чиг баримжаа, бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжил, хууль эрх зүйн бус практикийн болон эдийн засгийн хөгжлийн нийгмийн механизмын трансформаци гэх мэт.

Ийнхүү нийгмийн хөгжил хэрхэн явагддаг талаар онол арга зүйн шинжтэй судалгаанууд олон хийгдэж ирсэн ч өнөөгийн нийгмийн шинжлэх ухаанд нийгмийн харилцан үйлчлэлийн механизм хэрхэн явагддаг тухай судалгааны тулгуур асуудлын нууц одоо хүртэл ойлгомжгүй тодорхой бус байна. Нийгмийн шинжлэх ухаанууд жинхэнээрээ шинжлэх ухааны статусын төлөө өрсөлдөх ёстой хэмээн үзэх юм бол нийгэм гээчийн үүсэл, хөгжил, үйл ажиллагааных нь дотоод фундаменталь механизмуудыг илрүүлсэн цагт мөн чанарыг нь үндэслэхүйн парадигмын тусламжтайгаар танин мэдэх үүргээ биелүүлнэ хэмээн үзэж болно.



| Classification | Aggregate | Coverage | Number Of Coding | Reference Number | Coded By Initials | Modified On |
|---|---|---|---|---|---|---|

компьютерын технологиуд дээр суурилсан нийгмийн үйл явцуудын математик анализ болон загварчлальш тусгай аргуудыг боловсруулан одоо хэрэглэж байна. Социологи. нийгмийн сэтгэл зүй болон зарим нийгмийн шинжлэх ухаануудад объектив танин мэдэхүйн үндэс болгон сорилын судалгааны арга зүйг ашигласнаар ирснийг анхаарах нь чухал.

Нийгмийн сэтгэлгээний хөгжлийг авч үзвэл үндэслэхүйн парадигмд хамгийн тохирох чиглэл бол нийгэм-түүхийн үйл явцад байгалийн хүчин зүйлийн оролцоог нээх зорилго бүхий онолууд юм. Эдгээрийн тоонд газар зүйн детерминизм, геополитнкнйн онолууд орно. Жишээ нь, угсаатны гарвалжын талаарх Л.Н.Гумилевын онол, В.И.Вернадскийн оюун мандал (ноосфер)-ын үзэл баримтлал гэх мэт. Өнөө үед нийгмийн харилцан үйлчлэлийн хүрээнд микро- түвшний нийгмийн онолууд ч (М.Веберийн ойлгохуйн социологи, нийгмийн солилцооны онол, бэлэгдлийн интеракционизм) аль хэдийн боловсрогджээ

## ХАВСРАЛТ 3. ЭКСПЕРТИЙН ЯРИЛЦЛАГЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

***Улс төр судлал: Э001***

Улс төр судлалын ангиллаар улс төрийн онол, Орос школоор улс төрийн философи нөгөө талаар улс төрийн сэтгэлгээний түүх гэсэн ангилалд хамааруулах судалгааны ажил ховор байна.

Бат-Эрдэнэ судлаачийн “Шүүмжлэлт рационал сэтгэлгээний тухай асуудал”-аар доктор хамгаалсан сэдэв мөн “Улс төрийн сэтгэл судлал ба хүчирхийллийн сэтгэл зүй” гэсэн нэртэй жижиг номыг нэрлэсэн.

Улс төрийн сэтгэлгээний сэдвээр дорвитой “монографи” байхгүй.

- Батболд докторын бюрократитай холбоотой ном бий. Мөн “Социологийн онолын асуудлууд” гэдэг ном байна.
- Ц.Ганболдын “Mongolian Politics” гэдэг зохиол, англи хэл дээр 5 цуврал болж гарсан.
- Монголын улс төр судлаачдийн нэгдсэн холбооноос эрхлэн гаргадаг ЭШБХ-ын цуврал материалууд байна. Тухайлбал, “Монголын улс төр асуудал, эрэл, шийдэл”, “Ардчилал асуудал, эрэл, шийдэл”, “Праламентын институтийн улс төр, эрх зүйн шинжилгээ” зэрэг гарчигтай хэдэн цуврал гарсан байна.
- Конрад Аденауэрын сантай хамтраад хамтарсан төслийн хүрээнд “Монгол Улсын төрийн байгуулал дахь засаглалын институтийн талаархи судалгаа” гэсэн цуврал материалыг одоо гаргаж байгаа.
- 1990-д оноос улс төрийн онолын суурийг судалж байсан, үргэлжлүүлээд 2005 оноос улс төрийн онолд хамаарагдах салбаруудыг судалж эхэлсэн байна.

*Улс төрийн салбарт зайлшгүй судлах ёстой сэдвүүд:*

Монголд улс төр судлал дэлхийн жишигийн дагуу хөгжиж байгаа. Тэр чиглэл болгоноор манай судлаачид ном зохиол бичиж байгаа. Улс төрийн онол, институтууд, төрийн удирдлага, харьцуулсан улс төр судлал, улс төрийн сэтгэл судлал, улс төрийн үзэл суртал, олон улсын харилцаа гээд олон асуудал бас судлах шаардлагатай.

*Онолын чиглэлээр гарсан судалгаа:*

Ганбаатар багшийн “Улс төр сэтгэлгээний түүх”, Базарпүрэвийн “Дундад зууны үеийн улс төрийн сэтгэлгээ”, мөн “Монголын улс төрийн сэтгэлгээний сургааль”, “Дорнын улс төрийн сэтгэлгээний түүх” зэрэг бүтээл энд орж ирнэ. Энэ бол онолын салбарт хамаарагдах сэдвүүд.

*Цаашид судлах хэрэгтэй сэдвүүд*

Онцолж дурьдаагүй. Харин манай улс төрийн амьдрал гадны судлаачид их сонирхдог, монголын улс төрийг судалдаг Стивен Фиш, 1990-д оны эхээр Civil education project-ын хүрээнд хийсэн хэдэн ажил, Радченко, Малколм, Паппазако зэрэг хүн Монголын талаар судалгаа хийсэн байна.

Түүнээс гадна монголын үе үеийн удирдагч нар Японы нэрт эдийн засагчийг Монголд урин авчирж Монголын монголын эдийн засгийн талаар судалгаа хийлгэсэн байдаг. Одоо Нобелийн шагналтан Штиглиц монголд ирээд судлагаа хийгээд явсан. Ларри Даймонд, Сато, Фрийдман, зэрэг судлаачид мөн ирж Монголын талаарх судалгаа хийж байсан.

***Нийгмийн антропологи: Э002***

*1990-д оноос хойш нийгмийн ухааны салбарт доктор хамгаалсан, нэгэн сэдэвт бүтээл бичсэн судлаачдын бүтээлүүдээс нийгмийн философи (онолын судалгаа) гэсэн ангилалд хамааруулж болох судлагааны ажлуудын талаарх санал бодол*

Хамгийн их өөрчлөлт авчирсан судалгаа бол МУИС-ийн Археологи Антропологийн тэнхмийн багш Мөнх-Эрдэнийн судалгааны ажлууд юм. Нэгэн сэдэвт зохиол хараахан гараагүй ч гэсэн, 6-7 цуврал өгүүлэл хэвлэгдсэн байгаа, Монголын түүх, соёл, угсаатны асуудал, марксист түүхийн материализмаар тайлбарлаж байсан онолыг сөрж нийгмийн онолын асуудлыг нухацтай авч үзсэн юм. Гол санаа нь түүхэн сурвалжуудыг задлан шинжлээд, Монголчууд өөрсдийгөө юу гэж ойлгож, тайлбарлаж байсныг гаргаж өгсөн явдал.

Мөн "Эзэнт гүрний түүх" гэсэн нэртэй 5 боть ном бий. Сүүлийн үеийн барууны онолоор нийгмийн өөрчлөтийн асуудлыг тайлбарлахыг зорьсон нь бас их шинэлэг санагдсан. Энэ эомоос сүүлийн үеийн парадигмуудыг тэндээс харж болно.

*1990 Оноос хойших нийгмийн ухааны салбарын нэн тэргүүнд судлах ёстой сэдэв*

Нийгмийг тайлбарлаж байгаа хандлагаа салбар салбарынхаа үүднээс тайлбарлахыг оролдох хэрэгтэй. Бид капитализмын эхэн шатанд явж байгаа. Энэ нийгэм үе шатаар хөгждөг гэдэг хандлагаар авч үзэх явдал урьд нь өргөн дэлгэрсэн байсан. Тэр хандлага нь зүгээр нэрээ л өөрчилсөн юм. Тэгээд либерализм, либертарианизм зэрэг онолууд үүсч буй болжээ. Бид хөгжлийн аль шатанд явж байгаа вэ гээд л асуугаад байдаг. Манайхан тэр үеийн маягаар л сэтгэж байна. Бид сүүлийн үеийн гол гол ном зохиол орчуулаагүй, судлаагүй байна. Бид хуучин хэвээрээ л байгаад байна. Нэр л өөрчлөгдсөн байна. Хурал дээр баахан нэр томъёо л шидэлцдэг, баахан хэлбэр төдий зүйл л ярих юм. Сүүлийн үед гарсан онолыг л авч үзэх хэрэгтэй гэж бодож байна.

*Нийгмийн ухааны салбарын хувьд онцгой ач холбогдолтой сэдэв асуудал, нмйгмийн үзэгдлийн талаар*

Монголын нийгэм гэхээс илүү монгол хүн гэдэг нэг сэдэв байна. Жинхэнэ монгол хүнийг монгол хүний үнэлэмжийг тодорхойлохыг оролдож байгаа судлагаа их сонирхолтой гэж үзэж байна.

Хоёр дахь нь мал аж ахуй гэж юуг хэлэх вэ? Бэлчээрийн асуудал, нүүдлийн аж ахуй гэдэг бол их ховор үзэгдэл шүү. 1993-1998 оны хооронд хийсэн судалгаа байгаа. Уул уурхайн асуудлууд яах аргагүй бас нэгэн судалгааны том талбар. ***"Монголын эдийн засагт шинээр бий болж байгаа субъектууд"*** гэдэг том төсөл байсан. Үр дүн нь болж 4 том ном гарах

юм. Нийгмийн антропологи бол заавал манайх шиг сонин нийгэмд очиж судалгаа хийх шаардлагатай байдаг. Тийм болохоор антропологийн судалгаанд өөрийн онцлог ба давуу талууд байна. Хуучин буюу 19990-ээд оноос өмнө Монгол бол хаалттай нийгэм байсан. Тэр утгаар барууны судлаачдад их сонирхолтой.

Бусад салбар, философийн нэгэн сэдэвт бүтээлийг мэдэхгүй юм байна. Би яг л өөрийн сонирхож байгаа сэдвээ л мэдэж байна. Соёл судлал дээр 3 талбарыг багтаан ойлгож болно: 1. Оросоос орж ирсэн культурология гэдэг ойлголт, 2. Лесли Уайлдын 60-аад оны үед culturology гэдэг ойлголт. Энэ монголд байхгүй, судлагдаагүй гэж зүйл үзэж болно, 3: Cultural science. Энэ гурвыг хольж хутгаад бантан хутгасан байна.

Антропологийн хувьд арга зүйн чиглэл заавал өгнө. Антропологи шинэ зүйл биш, 50-60-аад угсаатны зүйг хөгжүүлж байсан. Шүүмжлэлт сэтгэлгээ нь бага байсан, дүрслэл бичлэг л хийж байсан. Дадлага хийлгэнэ, бага сага практиктай болно.

Ч.Тамир багшийн докторын ажлыг хэлэх хэрэгтэй. Монголын нийгмийн асуудлыг хөндсөн гадаадын судлаачид байна. Лорен Боннилагийн ажлууд. Нийгмийн газар зүйн чиглэлээр хийсэн ажил бий. Манай нийгмийн газар зүй шиг тийм нэр томъёо байна. Уул уурхай, нутгийн ардын харилцаа. Их өргөн хүрээтэй сэдэв.

Нийгмийн трансформацийн тухай Б.Мандухайгийн судалгаа байна. Ажлыг нь бөөгийн онгодын дуудлагын судалгаа гэж бодоод байдаг угтаа тийм биш.

Нийгмийн ухааны салбарын менежмэнттэй холбоотойгоор судалгаа сул байна. Уг нь тодорхой бодлого бариад зүтгэх хэрэгтэй, тэрийгээ хөгжүүлэхгүй байна. Социализм болон коммунизмын судлагаа ялангуяа посткоммунизм сонин байх боломжтой, монголын мал аж ахуй, гэх мэт асуудал бас байж болох юм. Мөн монголын төрийн кейс бол бас судалгааны сэдэв байж болно.

***Философи: Э003***

*Нийгмийн философийн салбарт хийсэн онцлох судалгааны ажил*

Философид судалгаа хийсэн хүмүүс ихэвчлэн энэ чиглэлээр хамгаалсан хүмүүс байгаа. Н.Хавх багш болон түүний удирдсан 3-4 хүн бий. Орост хамгаалсан хүн гэвэл Д.Дашпүрэв багшийн докторын буюу шинжлэх ухааны докторын ажил байна, мөн түүний сүүлд гаргасан бүтээлүүд энд зүй ёсоор орно гэж бодож байна. Учир нь 1992-95 оны хооронд Энэтхэгт судалгаа сайн хийсэн. Мөн түүний докторантаар тэр үед ажиллаж байсан Шарад Сони, одоогоор Ж.Неругийн Их Сургуулийн Монгол судлалын тэнхмийн эрхлэгчээр ажиллаж байгаа. Дашпүрэв гуай тэнд байхдаа нэлээд шүүмжлэлийн шинжтэй зохиол “Хар ном” гаргасан. Шүүмжлэл дагуулсан. Одоо “Монгол ухаан” гэдэг ном хэвлүүлсэн байна лээ АНУ-д.

Шинжлэх ухааны Академид тогтсон ёсоор бол Шинжлэх ухааны доктор хамгаалсан хүмүүст тавих гол шаардлага нь өөрийн гэсэн дэг сургууль байгуулсан байх явдал. Тийм болохоор энэ шаадлагын дагуу дараагийн хүн бол Хавх багш, шавь нар нь

байна, энд өөрийн дэг сургууль бий гэж үзэж болно. Мөн ШУТИС-ийн Ганболд багшийг хэлэх ёстой. Философиор хамгаалсан хүмүүс бол гарын таван хуруу шиг. Но, Жү, Лууяа, Чука, Дашпүрэв, Даш-Ёндон, Ган-Өлзий, Гооёо байна. Мөн Ариунаа багшийн хамгаалсан шинжлэх ухааны докторын ажилтай танилцах хэрэгтэй байх.

Доктор PhD дээр Эрдэнэтунгалагийг хэлэх ёстой байна.

Бусад салбарын хувьд социологид шинжлэх ухааны доктор алга. Гэхдээ Гүндсамбуу багшийг энд заавал хэлэх хэрэгтэй. Үнэхээр хамгийн том судлаач мөн. Гүндсамбуу багш маань өөрөө хэн байсан бэ гэдэг нь маш чухал. Багшийн талаар муу яриа их бага сонсогддог. Өөр хүн алга. Саяхныг хүртэл докторын зэрэг хамгаалсан хүн маш бага Мөнхбат, Оюунханд 2-оос өөр хүн бараг байхгүй шахуу байлаа. ШУА дээр ганц Цэцэнбилэгээс өөр хүн алга. Сүүлд л тэр МУИС-ийн социологийн салбарын залуучууд захаасаа хамгаалж эхэлж байна. Энд Тамир, Түмэннаст, Батбаатар зэрэг залуучуудыг хэлмээр байна. Социологоор бие дассан Хамгаалуулах зөвлөл бий болсонтой холбоотой, гэхдээ хамгаалсан сэдвүүдийг үзвээс тэдний дийлэнхи нь нийгмийн ажил талдаа байна. Сүүлд хамгаалсан залуучуудаас Тамир маш сайн. Сэдэв нь ч гэсэн Улс төрийн социологоор юм энэ их сайшаалтай, тэрээр олон орноор явж хангалттай их судлагаа хийсэн. Бусдаас хамаагүй илүү, ганц гийх ажил нь. МУИС-ийн социологийн тэнхимд бие даан бичсэн онолын ном, сурах бичиг бараг байхгүй. Харьцуулвал ШУАкадеми сайн ч муу ч басхүү Смелзерийг орчуулсан байдаг. Түүнээс гадна ШУАкадеми “Судалганы арга зүй” гэсэн сайн ном орчуулж, одоогоор хэвлүүлэхэд бэлэн болгоод байна.

Мөн социологийн тэнхмийнхэн онолын семинар ЭШХурал бараг хийгээгүй ирж, салбар социологид хамаатай нэг ч ном орчуулж, бичээгүй. Дашрамд хэлэхэд Хууль сахиулах Их сургуульд “Эрүүгийн эрх зүйн фф” гэдэг хичээл ахисан түвшиндээ ордог юм байна. МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим анхаарах хэрэгтэй юм шүү. Ядаж л онолын чиг хандлага дээр нь анхаарч, шаардлагатай бол зөвөлгөө өгөх хэрэгтэй байх шүү.

Улс төр судлалын хувьд академич алга. Лидершипийн утгаар тэр чухал. Салбараа чирдэг юм шүү. Шинжлэх ухааны доктор хамгаалсан хүн бол Цанжид гуай. Монголын төрт ёсны сэдвээр хамгаалсан юм. Цанжид гуайн өмнө Атар хамгаалсан гэхдээ одоо юу болж байгаа хэн ч мэдэхгүй. Аав нь анхны Шинжлэх ухааны доктор байсан, мундаг хүн байсан байх. МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн эрхлэгч Довчин багш болсноор тэр салбарын залуучууд хамгаалж эхэлсэн. Гэхдээ тэнд Улс төрийн философиор хамгаалсан хүн байхгүй ганц л хүн байлаа. Манай ШУА-д байсан Болд-Эрдэнэ гуай. Тийм болохоор энэ салбарт ч гэсэн Шинжлэх ухааны доктор хэрэгтэй байна. Ер нь Шинжлэх ухааны доктор бол хэрэгтэй гэж би үздэг, зарим хүмүүс шүүмжлэхдээ үүнийг зохицуулсан хууль дүрэм байхгүй гэж үздэг. Гэхдээ тухайлбал манай ШУА-д цалин мөнгө, зэрэг дэвийн ялгаа бий. Энэ институцийг дэмжих хэрэгтэй, ядаж л стратификацийн хувьд хэрэгтэй шүү. Үй олон PhD ээс ялгарахад хэрэгтэй байна.

Соёл судлалын хувьд бол урьд нь хамгаалсан хүмүүс философийн доктор гэдэг байсан бол одоо СУИС дээр бие даасан Соёл судлалын хамгаалуулах зөвлөл байгуулагдсан. Нийт Соёл судлалаар хамгаалсан 26 доктор бий, Дулам, Баянсан, Чулуунбаатар зэрэг эрдэмтийг нэрлэх хэрэгтэй байна.

*Иргэншил судлал гэдгээр хамгаалсан, судлалгаа хийсэн байдал.*

Бараг байхгүй. Чулуунгэрэл "Когнитив соёл судлал"-аар хамгаалсан. ХИС дээр хамгаалсан байгаа. 2013 онд З.Батжаргал багш "Соёлын идентификаци"-иар хамгаалсан. Миний сэдэв бол "Хэлний онтологи агуулгын философийн харьцуулсан судалгаа". Жанцанноров гуай бодлогын шинжтэй зүйл их үзсэн байдаг. Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаална гэж байсан. Мөнхбадрал "Соёлын дархлаа"-гаар хамгаалсан. Ганжаргал хамгаалсан, Мяндас "Музей судлал"-аар хамгаалсан.

*Нийгмийн философийн ямар асуудлыг судлан авч үзэх ёстой вэ? Судалбал зохистой ямар сэдэв байна вэ?*

- Үндэсний ижилсэл, жишээлбэл, Тувад Хүмүүндэгийн ухааны хүрээлэн гэж бий. Тэнд Сибирь, Тува орчим соёлын ижилсэлийг сайн судалсан. Манайд бол ММСЖ группынхэн 2.000.000 сая төгрөгний төсөл авсан. Бум-Очир, Дулам нар 2 төслөөрөө 4.000.000 сая төгрөгний төсөл авсан байгаа. Ямар үр дүн гарахыг мэдэхгүй байна.
- Нийгмийн эрүүл мэндийн судлагаа чухал байна. Ялангуяа, Нийгмийн сэтгэцийн судалгаа чухал. Илүү гүнзгийн судалгаа хэрэгтэй. Clinical social work маш чухал байна. Нэг мэдэхэд УБ галзуучуудын хот болно. Хар тамхины асуудал хурц байна. Цагаан хадаар нүүрс тээвэрлэж байгаа хүмүүс зөөж байна. Үүнийг дагаад тэр урт замыг дагасан явуулын бие үнэлэлт газар авлаа. Маш түвэгтэй байна.
- Нийгмийн тэгш бус байдал, бүх төрлийн тэгш бус байдалыг судлах нь чухал байна. Тогтвортой хөгжлийн конвенцид энэ талаар сайн бичсэн байна.
- Шинжлэх ухааны философи чухал. Барууны зарим оронд нийгмийн шинжлэх ухаан, байгалийн шинжлэх ухаан гээд тусдаа ордог юм байна. "Монголын нийгмийн шинжлэх ухааны философи" гэж бичих хэрэгтэй байх. Миний мөрөдөл бол Монголын соёлын онол философиор судалгаа хийж, ном бичих явдал.

*Нийгэм, хүмүүнлэгийн салбарын судалгаа шилжилийн үед хэрхэн хөгжив?*

- Нийгэм хүмүүнлэгийн салбар бүхэлдээ сул хаягдсан нь үнэн. Хамгийн хөгжөөгүй салбар. Учир нь тухайн үед гадна дотны тэтгэлэг олдоогүй. Монголын төр өөрөө сонгодог салбаруудаа хаясан. Тэтгэлэг бол бараг дан ганц байгаль шинжлэлийн салбарт олддог байлаа.

- Угаасаа дэлхий даяр нийгэм-хүмүүнлэгт тэтгэлэг бага байна. Дэлхийн өрсөлдөх чадвартай листтэй бас холбоотой. Монгол 99 байранд байгаа. Улс орны ВВП-ийн хэдэн хувийг шу зарцуулж байгаатай холбоотой. Монгол бол 0,12 хувь гэсэн тоо бий. Гэхдээ тэр бас тийм ч зөв тоо бий. Хувийн хэвшлийн зүгээс оруулж байгаа хөрөнгө оруулалтыг тооцоогүй байна. Тооцвол бараг 1 хувь хүрнэ шүү. Манайд

оюунлаг түвшин байгаа “Spirit level” бас доор биш. Гэхдээ тэр хүмүүс өөр газар ажиллаад байна.

- 1990-ээд оноос хойш энэ асуудалд мэргэжлийн тэнхим, судалгааны байгууллагуд ажлын приоритет өгч ажиллаагүй байна. Шинжлэх ухааны менежмент байгаагүй.
- Төр итгэж өөрөө дээд сургуульд захиалга өгөөгүй. Японд техникийн салбарт хамтын бүтээл болгох замаар дипломын ажлаа хийж гүйцэтгэдэг. Энэ их чухал.
- Төр өөрөө мэргэжилтнээ бэлддэг байсан тэр тогтолцоогоо 100 хувь нураасан. Энп зүгээр нэг жишээ болгоод олны дунд жижиг Мөнх-Эрдэнэ гэдэг судлаачийн саналыг хэлэхэд: Монголын судлаачид монголоос өөр хэл дээр юм уншдаггүй….. Том Мөнх-Эрдэнийн саналаар: 1990 оноос өмнө хамгаалсан бүх диссертацийг хүчингүй болгох хэрэгтэй байсан юм.

***Социологи: Э004***

*Сүүлийн үед хийсэн томоохон судалгааны ажил, нэг сэдэвт бүтээл*

1. Социологийн чиглэлийн том судалгааны ажил гэвэл Гүнд-Самбуу багшийн 20-р зууны үеийн Монголын нийгмийн давхраажилт хөгжил хандлага гээд бүтээл байна. Энэ судалгааны ажил маань 100 жилийн хугацаанд хувирал өөрчлөлтийг харуулсан судалгааны ажил. П. Сорокины арга зүйг баримталсан. 2000-аад оны зааг дээр гаргасан.
2. Философийн салбараас Ц.Гомбосүрэн багшийн судалгааны ажлууд байна. Тэдгээр бүтээлүүд нь социализмын үеийг шүүмжилж гарч ирсэн боловч 1990 оны асуудлыг тавьсан бүтээл юм. Багшийн 2 бүтээлийг онцолж хэлмээр байна. 1. *Нийгмийн тухай философийн интеграль (нэгтгэгч) хувилбарыг боловсруулах эхлэх Онол, арга зүйн асуудал 2. Монголд өрнөдийн философиор явуулсан судалгаа, сурталчилгааны товч тойм /1990-2003/.*
3. Д. Мөнх-Эрдэнэ багшийн бүтээлийг хэлнэ. Угсаатанчлах маягаар ЗХУ Монголчуудыг ингэж харж байна. Монгол гэдэг дэвсгэр дээрээ байх ёстой гэсэн санааг хэлсэн. Монголчуудыг Чингисийн үеийн удам судартай хэрхэн холбогдохыг хэлсэн гэж би хувьдаа бодож байна.
4. Улс төрийн хүрээнд Д.Болд-Эрдэнэ багшийн бүтээлийг онцолж хэлмээр байна. Яагаад 1990 онд бидний сонгож авсан ардчилал маань 20 хэдэн жил болж байна. Ардчилалыг шүүмжилсэн асуудал болгонд онолын түвшинд тайлбар өгч байсан.

*Социологийн салбарт хийсэн судалгааны ажлын сэдэв болон онолын судалгаа*

Социологи харьцангуй цөөхөн эрдэмтэнтэй.

- Оюунхандын судалгааны ажил байна. 2000 Нийгмийн девант/ архидалт, амиа хорлолт/ үзэгдлийн социологи.
- Ч.Тамирын судалгааны бүтээл 1990оны үйл явдал олон нийтийн эсэргүүцэл нийгэмд хэрхэн өөрчилөгдөх талаар
- Цэцэнбилэг хүмүүсийн үнэт зүйлийн асуудал гэдэг судалгааг эхлүүлсэн хүмүүсийн нэг. Үргэлжлүүлээд бүтээл хийсэнгүй гэж дүгнэх гэж байна.

- Хүрээлэн бол хэд хэдэн чиглэлээр */хөдөлмөр эрхлэлт, давхраажилт, шашин/* судалгаа хийх төсөвтэй байдаг юм шиг байна.

*Зайлшгүй судлах ёстой судалгааны ажлын асуудлаа тодорхойлсон эсэх*

- Захиалагчдын өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн судалгааг бол хийж байна.
- Сүүлийн үед судалгааны байгууллага ихээхэн гарч ирсэн. Эдгээр байгууллагууд маань эмпирик судалгаа хийж байна .
- Хувийн байгууллагууд маань нэг удаагийн судалгаа л хийж байгаа.
- Нийгмийн бүтцийн судалгаа бол хаягдсан гэж хэлж болно. Нийгмийн бүтцийн судалгаа хийх хэрэгтэй гэж бодож байна.

*Социологийн онолын парадигмаар Монголын нийгмийг тайлбарладаг уу? Энэ чиглэлд судалгаа хийсэн эсэх*

- Барууны ямарч онолоор тайлбарлаж болж байна. Түмэннастын судалгааны ажил байна. Барууны аргачлалыг судлаад нийгмийн халамж дээр тайлбарлаад явсан. Монголд нийгэмшилийн систем байхгүй болсон.
- Хотжилттой холбоотой асуудал байна.
- Шинжлэх ухаан болгон өөрийнхөө бие даасан байдлыг олох гэж явсаар салбар дундын судалгаа байхгүй болсон.

## ХАВСРАЛТ 4. ФИЛОСОФИ, ШАШИН СУДЛАЛ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ISSN 2220-959X СЭТГҮҮЛИЙН ДУГААР 23 (551)

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

# ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

*ISSN 2220-959X*

## ФИЛОСОФИ, ШАШИН СУДЛАЛ

**№ 23 (551)**

**XXIII**

Улаанбаатар хот
2021 он

**PHILOSOPHY, RELIGIOUS STUDIES**
**SCIENTIFIC JOURNAL**

**№ 23 (551)**

ISSN 2220-959X

**Key title: Filosofi, šašin sudlal**

# XXIII

**EDITORIAL BOARD**

**Editor in chief:** **B. Dagzmaa Ph.D**
**Secretary:** **S. Yanjinsuren Ph.D**
**Board members:** **G. Chuluunbaatar Acad**
**R. Darikhuu Ph.D**
**M. Gantuya Ph.D**
**S. Lalla Sc.D**
**T. Matsukava Ph.D**
**M. Otgonbayar Ph.D**
**K. Teleki Ph.D**

**ADDRESS:**
Department of Philosophy and Religious Studies
Division of Humanities, School of Arts and Sciences
National University of Mongolia
Room number 206, 237. NUM bldg. 2
14201, Baga toiruu 47,
Sukhbaatar duureg, Ulaanbaatar-46a, MONGOLIA
Phone: 976-75754400-/extension no 2220/
E-mail: PRS.journal@num.edu.mn, yanjin555@yahoo.com
Web: www. dep.num.edu.mn/pshs/, www.sas.num.edu.mn

Ulaanbaatar, 2021

**ФИЛОСОФИ, ШАШИН СУДЛАЛ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

**№ 23 (551)**

ISSN 2220-959X

# XXIII

**РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ**

| | |
|---|---|
| **Ерөнхий эрхлэгч:** | **Б. Дагзмаа (Ph.D)** |
| **Нарийн бичгийн дарга:** | **С. Янжинсүрэн (Ph.D)** |
| **Гишүүд:** | **М. Гантуяа (Ph.D)** |
| | **Р. Дарьхүү (Ph.D)** |
| | **С. Лалла (Sc.D)** |
| | **Т. Мацукава (Ph.D)** |
| | **К. Телеки (Ph.D)** |
| | **М. Отгонбаяр (Ph.D)** |
| | **Г. Чулуунбаатар (Acad)** |

**Сэтгүүлийн хаяг:**
Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбар,
14201 Улаанбаатар хот-46а ш/х-330, Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 47, Утас: 976-75754400-/2220/

E-mail: PRS.journal@num.edu.mn, yanjin555@yahoo.com
Web: www. dep.num.edu.mn/pshs/, www.sas.num.edu.mn
“Тотопресс” Хэвлэлийн Газарт эхийг бэлтгэж хэвлэв.

Улаанбаатар, 2021

# АГУУЛГА


| | | |
|---|---|---|
| 1 | О.Хатанболд,<br>А.Хишигдаваа | УЛС ТӨР СУДЛАЛЫН САЛБАРТ 1990-ЭЭД ОНООС ӨМНӨ ХЭРЭГЖСЭН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, АРГА ЗҮЙН БАЙДЛЫН ТОЙМ (ТЭРГҮҮН ХЭСЭГ) |
| 2 | О.Хатанболд,<br>А.Хишигдаваа | УЛС ТӨР СУДЛАЛЫН САЛБАРТ 1990-ЭЭД ОНООС ХОЙШ ХЭРЭГЖСЭН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, АРГА ЗҮЙ БА ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ (ТӨГСГӨЛ ХЭСЭГ) |
| 3 | Ивлева М.Л.<br>Иноземцев В.А.<br>Баграмянц Н.Л. | КОНЦЕПЦИИ ИНФОРМАЦИОННОГО ОБЩЕСТВА КАК ТЕОРИИ СОЦИАЛЬНОГО ЗНАНИЯ |
| 4 | Д.Ганболд | НИЙГМИЙН ДЕФОРМАЦИЙН МЕХАНИЗМ |
| 5 | Д.Дашпүрэв | МОНГОЛЫН НИЙГМИЙН МОДЕРНИЗАЦИЙН ҮЕ ШАТНЫ АСУУДЛААР МАНАЙ ОРОНД ХЭРЭГЖИЖ ИРСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН |
| 6 | М.Отгонбаяр,<br>Б.Дагзмаа,<br>Ц.Нямсүрэн | 1990 ОНООС ХОЙШ ҮЕ ДЭХ МОНГОЛЫН ФИЛОСОФИЙН СУРГАЛТ, СУДАЛГААН ДАХЬ ОНОЛ, АРГА ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ, СУРГАМЖ |
| 7 | Г.Мөнх-Эрдэнэ | 1990-ЭЭД ОНООС ХОЙШИХ МОНГОЛ УЛС ДАХЬ НИЙГМИЙН АНТРОПОЛОГИЙН СУДАЛГАА |
| 8 | О.Мөнхбат | МОНГОЛЫН НИЙГМИЙН ДАВХРААЖЛЫН СУДАЛГААН ДАХЬ ПАРАДИГМЫН ӨӨРЧЛӨЛТ |
| 9 | Ц.Нямсүрэн,<br>М.Отгонбаяр,<br>Б.Дагзмаа | МОНГОЛЫН НИЙГМИЙН ФИЛОСОФИЙН СУДАЛГААГ ТОЙМЛОСОН НЬ |

# ӨМНӨХ ҮГ

***"Философи, шашин судлал" сэтгүүл*** 2021 оны тусгай дугаараа уншигч, бичигч Танаа өргөн барьж байна.

Бид ШУТС-ийн санхүүжилттэй гадаадтай хамтарсан "Нийгмийн ухаан: орчин үеийн техноугшилт иргэншлийн сорилтууд /Социальное знание: вызовы современной техногенной цивилизации" төслийн хүрээнд хийгдсэн 90-ээд оноос хойш Монголын нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарууд дахь онолын судалгааны үр дүнгийн тухай өгүүллүүдийг эмхэтгэн сэтгүүлийнхээ энэ дугаарт нийтлүүлж байна.

МУИС-ийн холбогдох журмын дагуу ФШС сэтгүүлд ирүүлсэн бүтээлүүдийг хянан тохиолдуулсны үндсэн дээр хэвлүүлдэг. Сэтгүүлийн энэ дугаарт орсон 12 бичигчийн 9 өгүүллийн нэрийг үсгийн дараалаар жагсаан гарчиглаж, хэвлэсэн болно.

***"Философи, шашин судлал сэтгүүлийн бичлэгт тавигдах шаардлага"***-ыг сэтгүүлийн дугаар бүрт хэвлэдэг уламжлалтай тул Та дараагийн дугаарт бүтээлээ ирүүлэхдээ зохих журмын дагуу боловсруулж ирүүлнэ гэж найдаж байна.

*Уншигчийн мэлмий хурц, бичигчийн бийр уян байх болтугай.*

**РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ**

# “ФИЛОСОФИ, ШАШИН СУДЛАЛ” СЭТГҮҮЛИЙН БИЧЛЭГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. ЭШӨ нь шинэ судалгааны үр дүн байх,
2. Өгүүллийн эхэнд ***өгүүллийн нэр; зохиогчийн овог, нэр; эрдмийн зэрэг цол; харьяа эрдэм шинжилгээний байгууллагын нэр; эрхэлж буй ажил, мэргэжлийг*** бичих***;***
3. Өгүүлэл нь ***түлхүүр үгс, товч утгатай*** байх бөгөөд өгүүллэгийн эхэнд бичсэн байх;
4. Өгүүллэгийг ***монгол, англи*** хэлний аль нэгээр бичих;
5. Монгол хэлээр бичсэн өгүүллэг англи, англи хэлээр бичсэн өгүүллэг монгол ***товчлолтой байх*** ба өгүүллийн ард хавсаргах;
6. Товчлолыг /Abstract/ ***8-12 өгүүлбэрт*** багтаан бичих;
7. Өгүүллэгийн төгсгөлд ***Ном зүйг*** журмын дагуу хийж хавсаргах, (зохиогчийн нэрийн үсгийн дараалаар, ижил зохиогчтой бол нэрийн эхний үгийн эхний үсгээр жагсаах, зохиогчийн овгийн товчилсон үсгийг зохиогчийн нэрийн өмнө бичих);
8. Өгүүлэлд ***төвд, хятад, араб, япон, солонгос зэрэг үсгээр бичсэн нэр томьёо байгаа тохиолдолд тухайн нэр томъёог латин галигийн хамт хаалтанд дагалдуулах ба өгүүлэл дэх гадаад нэр томъёог болж өгвөл монгол хэлэнд орчуулж хэрэглэсэн байх;***
9. Үсгийн фонт: ***Microsoft Word*** программ дээр **Times New Roman** байх;
10. Үсгийн хэмжээ: **12**
11. Мөр авалт: ***Single***
12. Догол мөр: **5 нэгж /tab/**
13. Өгүүллийн хэмжээ: ***А4 форматаар 2000-5000 хүртэл үгтэй***
14. Зургийг ***JPG ба TIFF*** форматаар, ***диаграммыг Microsoft Excel*** дээр үйлдэх;
15. Зураг хавсаргасан бол зураг нь тайлбартай байхаас гадна зургийн эх сурвалжийг заасан байх;
16. Эшлэл зүүлтийг ***“зохиогчийн нэр” ба “кодын” /footnote/*** аргаар авсан байх;
17. Үсэг, үг болон найруулга зүйн хувьд алдаагүй, агуулгын хувьд логик зөрчилгүй байх.

Жич: Дээрх шаардлагуудын аль нэгийг дутуу гүйцэтгэх нь тус өгүүллийг хэвлэхгүй байх шалтгаан болно.

Сэтгүүлд бүтээлээ ирүүлж буй бичигч *харилцах утас, E-mail хаягийг* редакцийн зөвлөлд ирүүлнэ.

**Өгүүлэл хүлээн авах цахим хаяг:** PRS.journal@num.edu.mn; yanjinsuren@num.edu.mn

**Сэтгүүлийн редакцийн зөвлөл**

# УЛС ТӨР СУДЛАЛЫН САЛБАРТ 1990-ЭЭД ОНООС ӨМНӨ ХЭРЭГЖСЭН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, АРГА ЗҮЙН БАЙДЛЫН ТОЙМ *

*(тэргүүн хэсэг)*

О.Хатанболд, *доктор (PhD)*
А.Хишигдаваа*, докторант*
*ШУА-ийн Философийн хүрээлэнгийн*
*Улс төр, эрх зүйн салбар*

***Товч утга:*** *Манайд харьцангуй хожуу үед үүссэн шинжлэх ухааны нэг бол улс төрийн шинжлэх ухаан юм. Бид энэхүү өгүүлэлдээ 1990-ээд оноос хойш хэрэгжсэн улс төр судлалын судалгаа, шинжилгээний онол арга, зүй, шинж байдлын өнөөгийн төлөвийг судалгааны бүтээлүүдийн онол арга зүй, үзэл баримтлал, шийдвэрлэх арга замыг нэгтгэн дүгнэж тоймлох байдлаар бэлтгэв. Чингэхдээ туулж өнгөрүүлсэн замаа эргэн харж, түүнээс сургамж авч, судалгаа шинжилгээний ажлаа улам чамбайруулах нь бидний өмнөө тавьсан гол зорилтуудын нэг тул өнгөрсөн үеийг эргэн дурсахуй нь түүний мөн чанар болоод дараа дараагийн үедээ уламжлагдан үлддэг сонголт байдаг. Тэрхүү агуулгын хүрээнд бид оршил хэсэгтээ монголчуудын улс төрийн мэдлэг, сэтгэлгээний уламжлалын талаарх тоймыг цухас тэмдэглэв. Тиймээс эл тойм өгүүлэлд Монгол Улс дахь улс төрийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний онол, арга зүйн төлөв байдлыг 1990 оноос өмнөх ба хойш хэмээн* ***хоёр үндсэн хэсэгт*** *хуваан дараах байдлаар үечлэн авч үзэхийг оролдов. Үүнд, (i) Монголчуудын улс төрийн сэтгэлгээ, түүний мөн чанарын талаарх тойм; (ii) Шинжлэх ухааны коммунизмын онол болон марксист-ленинист сургаалын үе (1972-1990); (iii) Шинэ онол, арга зүйг эрэлхийлэхүй буюу шилжилтийн үе (1990-2000); (iv) Улс төрийн шинжлэх ухааны шинэ төлөвшилтийн үе (2000-2010); (v) Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны судалгааны өнөөгийн байдал, цаашдын хандлага (2010 оноос- өнөөг хүртэл)*

***Түлхүүр үг:*** *улс төрийн шинжлэх ухаан, судалгааны тойм, онол, арга зүй, монголчуудын улс төрийн сэтгэлгээ, түүхэн уламжлал, шилжилт, төлөвшилтийн үе, өнөөгийн төлөв, хандлага*

***Abstract:*** *One of the relatively recent sciences in our country is political science. In this article, we have summarized the current state of political science research theory, methodology, and characteristics since the 1990s by summarizing the theories, concepts, and solutions of the research papers. One of our main goals is to look back to our history, learn from it, and refine our research, so recalling the past is its nature and a choice that will be passed on to future generations. In that context, we have outlined in our introductions an overview of Mongolian political knowledge and thought traditions. Therefore, in this review article, we have tried to divide the political science research, analysis theory*

* *Эл эрдэм шинжилгээний өгүүллийг ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөний 2.2-т тусгагдсан "1990-ээд оноос хойш Монголын нийгэмд гарсан хувиралт өөрчлөлтийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, тохиолдож буй бэрхшээл сорил, тулгамдаж буй асуудлуудын гарц шийдлийн зохист хувилбарыг санал болгох" ажлын хүрээнд бэлтгэн боловсруулав.*

*and methodological situation in Mongolia before and after 1990 into two main parts and periodically as follows. These include (i) an overview of Mongolian political thinking and its nature; (ii) The Theory of Scientific Communism and the Marxist-Leninist Doctrine (1972-1990); (iii) The search for new theories and methodologies or the transition period (1990-2000); (iv) the new development of political science (2000-2010); (v) Current status and future trends of political science research in Mongolia (2010-present)*

***Keywords:*** *Political science, research overview, theory, methodology, political thinking of Mongolians, historical traditions, transition, development period, current state and trends*

**Оршил**

Улс төрийн сэтгэлгээ бол монголын ард түмний нийгмийн сэтгэлгээний түүхэнд голлох байр суурь эзэлж, түүний тэргүүлэх чиглэлийн нэг болсоор ирсэн баялаг агуулгатай, үндэсний онцлог шинжтэй, оюун санааны түүхийн үнэт өв сан болох нь эдүгээ шинжлэх ухаанд нэгэнт тодорхой болсон зүйл билээ. Монголчуудын улс төрийн сэтгэлгээний түүхэн уламжлал ба өнөөдөр манай оронд орчин цагийн улс төрийн шинжлэх ухаан дэлхийн хөгжилтэй орнуудын жишиг, туршлагыг чиг баримжаа, үлгэр загвар болгож бүрэлдэн хөгжсөөр ирсэн нь уламжлал, шинэчлэлийн хэлхээ холбоотой гэж болно. Тиймээс манай оронд улс төрийн шинжлэх ухаан бүрэлдэн хөгжиж буй өнөөгийн үйл явцыг авч үзэхдээ монголын улс төрийн сэтгэлгээ, монголчуудын улс төрийн мэдлэг ухааны түүх, уламжлал зэргийг товч боловч хөндөж тоймлон өгүүлэх хэрэгтэй болно. Монголчууд төр ёсны эртний түүх, уламжлалтай ард түмэн бөгөөд түүний тусгал, илэрхийлэл болж улс төрийн мэдлэг ухаан бүрэлдэн хөгжиж ирсэн билээ. Тэр нь төр, нийгмийн-улс төрийн амьдрал, харилцааны олон янзын үзэгдэл, үйл явцыг ердийн ухамсрын түвшнээс илүү гүнзгий тусгаж, нэгтэн дүгнэсэн ойлголт үзэл санааны цогц хэлбэр, илэрхийлэл болох улс төрийн сэтгэлгээгээр илэрч хөгжиж ирсэн явдал мөн. Чингэвэл монголчуудад улс төрийн мэдлэг, сэтгэлгээ түүхийн чухам аль үед, хэдийд үүсэн бүрэлдсэн болох, түүнийг түүхийн баримтаар судлан тогтоох боломж, үндэс суурь бий эсэхийг тодруулах нь зүйтэй. Энэ талаар цухас тэмдэглэвэл дараах дүр зураг бидний өмнө илрэх буюу.

Дэлхийд улс төрийн сэтгэлгээ анх үүсэн хөгжсөн голомт, төв бүхий улс орнуудын түүхэн жишээ баримтаас үзвэл улс төрийн сэтгэлгээ үүсэн хөгжихийн тулд *нэн тэргүүнд,* иргэншил бий болсон явдал, хүмүүсийн хамтын амьдрал, нийгэм нь улс төрийн зохион байгуулалттай болж, улмаар төр ямар нэг хэлбэр, түвшинд үүсэж бий болсон байх шаардлагатай аж. Энэ нь улс төрийн сэтгэлгээнд тусч, түүний агуулгыг нөхцөлдүүлэгч улс төрийн ахуй бүрэлдэн төлөвшсөн байна гэсэн үг. *Хоёрдугаарт,* тухайн нийгмийн соёл, ухамсар, оюуны хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн оюун ухааны түвшин, сэтгэн бодох чадвар нь улс төрийн ахуйг хийсвэрлэн сэтгэж тусгах, төсөөлөн ойлгох хэмжээнд хүрсэн байх шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн сэтгэлгээний субъект бий болж төлөвшсөн байх явдал мөн. *Гуравдугаарт,* улс төрийн сэтгэлгээний үүсэл хөгжилд танин мэдэхүйн хэрэгцээ шаардлагаас илүүгээр нийгмийн анги бүлгүүдийн эрх ашиг, түүнийг илэрхийлж хамгаалсан үзэл суртлын хүчин зүйлийн үүрэг, ач холбогдол илүү давамгайлах байдлаар нөлөөлдөг. Тийм учраас, улс төрийн сэтгэлгээ үүсэн хөгжихөд улс төрийн ахуйг үзэл суртлын хэлбэрээр тусган илэрхийлэх хэрэгцээ, шаардлага, тухайлбал нийгмийн анги бүлгүүдийн эрх ашиг, байр суурийн ялгаа бий болсноор түүнийг ухамсарлаж ойлгох улс төрийн өөрийн ухамсар ямар нэг байдлаар бүрэлдсэн байхыг шаарддаг. Түүхээс үзвэл чухам ийм нөхцөл байдал, бусад холбогдох хүчин зүйлс бүрэлдсэн МЭӨ IV-III

мянган жилийн үед хүн төрөлхтний соёл, иргэншил, төр, нийгмийн сэтгэлгээний анхны голомт төвүүд бий болсон эртний дорно дахин Египет, Энэтхэг, Хятад зэрэг оронд улс төрийн сэтгэлгээ анх үүсэж, улмаар цааш хөгжих болсон байна. Ийм аналоги жишээг монголын түүхээс эрж хайвал тэр нь манай түүхч эрдэмтдийн судалгаа ёсоор МЭӨ III зуунд тохиосон ажээ. Чухам энэ үед монголын газар нутаг төдийгүй Төв Азид анхны томоохон төр улс болох Хүннү гүрэн байгуулагдан, улс төрийн ахуй, түүний үндсэн шинж тэмдэг, үзэгдэл, үйл явдлууд тэр үеийн боломжит хэлбэр хэмжээгээр бүрэлдэн явагдаж байжээ.[1] Энэ нь монголын улс төрийн сэтгэлгээний анхны, эртний үеийн үүсэл, эхлэлийг Хүннү гүрний үеэс эрж хайн судлах нэгэн чухал үндэслэл, шалтгаан болж байгаа юм. Үүний дагуу манай эрдэмтэд эртний үеийн монголын нийгэм-улс төр, хууль цаазын сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл, шашин шүтлэгийн үүсэл, эхлэлийг голцуу энэ үетэй холбон судалсаар иржээ. Түүний үр дүнд нийгэм, улс төрийн амьдралын тухай тэр үеийн хүмүүсийн (хүннүчүүдийн) ойлголт, үзэл санааны агуулга, тойм, зураглал ерөнхий байдлаар гарсан байна. [2] Тухайлбал эзэн хаан, түүний засаглалын гарал үүсэл (эзэн хаан бол тэнгэрийн хөвгүүн бөгөөд түүний эрх мэдэл, засаглал тэнгэр гаралтай гэх мэт үзэл), захирах захирагдах харилцаа, хүчирхийлэл, албадлагыг үзэх үзэл зарим талаар тодорхой болсоор[3] байгааг энд цухас тэмдэглэн үзэв. Тийм учраас эртний үеийн монголын улс төрийн сэтгэлгээний түүхэн тоймыг зураглан гаргахыг оролдохдоо түүх бичлэгт одоогоор тодорхой болж ашиглагдан буй сурвалж бичиг, улс төрийн сэтгэлгээний түүхэнд шууд ба дам байдлаар холбоо хамааралтай, гэхдээ хэсэг бусаг байгаа янз бүрийн мэдээ, баримтыг анхааралтай судлах замаар тэдгээрийн утга санааны логик холбоо, нэгдлийг гаргах ерөнхий агуулга, утга санааг нь реконструкцийн аргаар бүхэлд нь сэргээн гаргаж тавихыг хичээх, цаашлаад шинэ сурвалж бичгүүд, бусад баримт сэлтийг эрж хайх нь судалгааны шинжлэх ухаанч зарчимд нийцэх одоогийн хамгийн боломжит хийгээд бодит зорилт мөн. Ер нь улс төрийн сэтгэлгээний үүсэл, хөгжил, тэр нь түүхэнд ямар нэг байдлаар тэмдэглэгдэн үлдэхэд олон янзын хүчин зүйл, нөхцөл байдал нөлөөлдөг болох нь эртний үеийн дорно дахины орнуудын улс төрийн сэтгэлгээний түүхээс ажиглагдаж байгааг судлаачид заажээ. Аль нэг улс оронд философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээ анх үүсэхийн хамт тэр нь тэмдэглэгдэж хадгалагдан үлдэхэд биеийн ба оюуны хөдөлмөрийн хуваарь ялгарч гарсан, тухайн ард түмэн суурин амьдралтай, бичиг үсэгтэй, түүх соёл, сэтгэлгээгээ бичиж тэмдэглэдэг туршлагатай байх явдал нэн чухал ажээ.

Монголын улс төрийн сэтгэлгээний түүхийг холбогдох сурвалж бичиг, баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлаж, судлан гаргах боломжтой билээ. Учир нь тийм сурвалж бичиг, шууд ба дам холбогдолтой баримт материал арвин бий. Тэдгээр сурвалж бичгүүдийг манай эрдэмтэд түүх, философи, уран зохиол, хэл шинжлэл, угсаатан судлал зэрэг ухаануудын судлагдахуун, аспектын үүднээс судлан боловсруулсаар иржээ.[4] Одоо тэдгээр эх сурвалж, бичгүүдийг монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн үүднээс шинжлэн судлах зорилт эл чиглэлийн мэргэжилтэн судлаачдын өмнө тулгамдаж буй асуудал хэвээр байсаар буй. Энд тэдгээр сурвалж бичгүүдийг

---

[1] *ФСЭХ., ШУА. XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред. Жамбал А. Уб., 2006, 10 дахь тал*

[2] *Жүгдэр Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ (Эртнээс XIY зуун хүртэл). Уб., 1987, 240 дэх тал*

[3] *Жүгдэр Ч. XV-XVIII зууны монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. Уб., 1984, 108-110 дахь тал*

[4] *ФСЭХ., ШУА. XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред. Жамбал А. Уб., 2006, 11 дэх тал*

тоочих, агуулгыг нь дэлгэрэнгүй авч үзэх шаардлагагүй. Бид тэдгээрийг дараах хэсгээр ангилахыг оролдов.




Бид дээрх ангиллыг хийхдээ тэдгээр сурвалж бичгүүдийн зохиогдсон цаг хугацаа, төрөл зүйл, хоорондын ялгаа, онцлог, улс төрийн сэтгэлгээ болон үзэл санаа тусаж илэрхийлэгдсэн байдал, сурвалж бичгүүдийн зохиогчид нь хэн байна вэ гэдгийг харгалзан үзэв. Тухайлбал монголын төр, нийгмийн зүтгэлтэн, түүхэн бие хүмүүс, баатар, сайн эрс, нийгэм-түүхийн томоохон үйл явдлын тухай домог, хууч ярианд ард олон, энгийн хүн ардын эрх, эрх чөлөө, шударга ёс, тэгш байдлыг үзэх үзэл санаа, эрхэмлэл, чин хүслэн, мөрөөдөл нь тусгагдсан байдаг. Үнэндээ монголчуудын улс төрийн үзэл санаа, улс төрийн эрхэмлэл нь ардын зүйр цэцэн үгэнд ч тусгагдан онч мэргэн, уран цэцнээр нэгтгэн дүгнэсэн товч хураангуй байдлаар илэрхийлэгдсэн байдаг. Энэ бол өвөрмөц, хосгүй үзэгдэл бөгөөд учир нь нийгэм, төр, улс төр, эх орон, эрх чөлөө, шударга ёс, тэгш байдал, дарлал мөлжлөг, бурангуй ёсыг үзэх үзлээ тийнхүү зүйр цэцэн үгэндээ тусган илэрхийлдэг нь монголчуудын эртнээс наашш шударга ёс, тэгш байдал, ёс суртахууныг эрхэмлэн дээдэлж ирсний нэг гол илрэл гэж үзэхэд буруудахгүй болов уу. Учир нь, монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн агуулга, дэвшүүлэн тавьж, эргэцүүлэн бясалгаж, хариу тайлбар өгч ирсэн зангилаа чухал асуудлуудыг илрүүлэн гаргаж тавих ахул дараах шалтгааныг дурдах нь зүйтэй.

*Нэгдүгээрт*

Эртнээс эдүгээ хүртэлх үеийн монголын улс төрийн сэтгэлгээний түүх нь агуулгаараа өргөн хүрээ багтаамжтай ба улс төрийн философи, улс төрийн сургаал, онол, номлол, үзэл суртал, улс төрийн үзэл санааны хэлбэр, түвшинд илрэн гарч, оршин хөгжиж ирсэн болох нь тодорхой болж байна.

*Хоёрдугаарт*

Монголын улс төрийн сэтгэлгээний түүхэнд төрийн тухай асуудал хэдийгээр гол болж тавигдсаар ирсэн ч гэсэн нийгмийн амьдралын улс төрийн хүрээний бусад олон чухал үзэгдлүүд, тухайлбал, улс төрийн бодлого, засаглал, төр улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, төр улсын задрал бутрал, түүнийг даван туулах асуудал, дарангуйлал, боолчлол, дайн ба энх, хууль цааз, шударга ёс, тэгш байдлын тухай асуудлууд ч түүхэн тодорхой байдлаар тавигдаж байжээ.

Түүхийн явцад монголын улс төрийн сэтгэлгээний агуулга, түүнд хамрагдсан асуудлын цар хүрээнд ялангуяа XX зуунд өргөжин баяжиж, дээр дурдсан уламжлалт

асуудлын зэрэгцээ нийгэм, төрийн харилцаа холбоо, төр, засаглалын хэлбэр, зохион байгуулалт, үндсэн хуульт ёс, ард олны эрх, эрх чөлөө, ардчилал, шударга ёс, сайн сайхан нийгэм байгуулах, хувьсгал, улс төрийн нам, олон нийтийн байгууллагын тухай шинэ асуудлууд чухлаар тавигдсан байдаг. Энэ нь угтаа монголын нийгмийн улс төрийн амьдралын түүхийн явцад хөгжиж, улс төрийн шинэ үзэгдлүүд гарч ирсний сацуу улс төрийн сэтгэлгээ өөрөө бие даан, өөрийн дотоод логик, хэрэгцээ шаардлагаар хөгжих болсонтой шууд холбоотой. Тиймээс бид энэхүү өгүүлэлдээ 1990-ээд оноос өмнө болон хойш хэрэгжсэн улс төрийн судалгаа, шинжилгээний шинж байдлын өнөөгийн төлөвийг онол, арга зүй, үзэл баримтлал, шийдвэрлэх арга зам зэргээр нэгтгэн тоймлож дүгнэхийг зорив. Чингэхдээ Монгол Улс дахь улс төрийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний онол, арга зүйн төлөв байдлыг 1990 оноос өмнөх ба хойш хэмээн дараах хэсэгт үечлэн авч үзэв.




### *Нэг. Монголчуудын улс төрийн сэтгэлгээ, түүний мөн чанарын тухайд*

Монголын улс төрийн сэтгэлгээ нь анх үүсэн бий болсон үеэс эдүгээ хүртэлх урт хугацаанд тасралтгүй, бүхэл чиг шугамтай, уламжлалын хэлхээ холбоотой байсны зэрэгцээ нэг нь нөгөөгөөсөө ялгаа онцлогтой тодорхой үе шатуудыг дамжин өнгөрүүлж иржээ. Тиймээс монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн үе шатуудыг үечлэх, тэдгээрийн агуулга, хоорондын ялгаа онцлогийг нь гарган тавьж тодорхойлох явдал энэхүү өгүүллийн нэг аспект, зорилт мөн билээ. Монголын улс төрийн сэтгэлгээний үүсэл хөгжлийн түүхийн томоохон үе шатуудыг тодорхойлон гаргаж үечлэх нь асуудлыг загварчилж, хэлбэр хөөж байгаа хэрэг биш, харин ч судалгааны нэг арга мөн бөгөөд тэр нь арга зүйн болон сургалт, заах аргын чухал ач холбогдолтой зүйл.

Үүнийг нэрт эрдэмтэн, академич Ч.Жүгдэр Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ бол (i) эртнээс XIV зууны үе (ii) XV-XVIII зуун, (iii) XIX-XX зууны зааг үе хэмээн хуваан[5] судалсан байдаг. Бид үүнд XIX-XX зууны үеийг тус бүрд нь монголын улс төрийн сэтгэлгээний хөгжил, түүхийн бие даасан үе шат болгон авч үзэх саналыг нэмэрлэж байна. Энд монголын улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжлийн бие даасан тодорхой үе шатуудыг үечилж гаргах, хуваах хийгээд энэхүү сэтгэлгээний түүхийг цуврал бүтээлүүдэд техникийн үүднээс хуваан авч үзэх хоёр нь хоорондоо холбоотойн зэрэгцээ бас багагүй ялгаатай болохыг тэмдэглэх нь

[5] *Жүгдэр Ч. Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. ФСЭХ, ШУА. Уб., 2008. "Бэмби сан" ХХК.*

зүйтэй. Тухайлбал дурдсан үе шат тус бүрийн аль нэгийг түүний агуулга, багтаамж, сэтгэгч төлөөлөгчдийн тоо, сурвалж бичгүүдийн болон үргэлжилсэн цаг хугацааных нь хэмжээ, байдлаас шалтгаалж нэг бүтээлд багтаан авч үзэх боломжгүй хэд хэдэн цуврал бүтээлээр судлах шаардлага гарах болно. Монголын улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжлийн дээрх үе шатууд хоорондоо уламжлал, үзэл санааны нягт хэлхээ холбоотойн хамт бас үүсэл хөгжил, сэтгэлгээний хэв маяг, түүхэн нөхцөл, авч үзсэн асуудал, агуулгад, сэтгэгч төлөөлөгч, бичиж тэмдэглэсэн сурвалж бичиг, түүний төрөл зүйлээрээ багагүй ялгаа онцлогтой байна. Эдгээр зүйл дээрх үечлэлийг гаргаж тавих үндэслэл болж байгаа юм. Тухайлбал эртнээс буюу МЭӨ III зуунаас XIV зууны үе бол монголын улс төрийн сэтгэлгээ анх үүсэн бүрэлдэж төлөвшсөн, холбогдох сурвалж бичгүүдэд анх бичигдэн тэмдэглэгдсэн, сэтгэлгээний уламжлал бий болж дараагийн үеийн үзэл санаа, сэтгэлгээний хөрс суурь болсон зэрэг онцлогтой. *Хоёр дахь үе* буюу XV-XVIII зуунд монголын улс төрийн сэтгэлгээ, өмнөх үеийн улс төрийн үзэл санаа, сэтгэлгээний уламжлал, нөлөөгөөр цааш хөгжиж, нийгмийн улс төрийн амьдрал, түүний түүхэн томоохон үйл явдал, үзэгдлүүдийг тусган илэрхийлж байсан[6] бөгөөд бичигдэж тэмдэглэгдсэн сурвалж бичгийн хувьд хөгжин гүнзгийрсэн, түүхийн бичиг, намтрын зохиол, товчис, тууж, хууль цаазын бичиг зэрэг төрөл зүйлээр баяжсан, өргөн хүрээ, агуулгатай болсон байна.

Монголчууд XVII зууны эхэн үеэс эх түүхээ ихээхэн сонирхож, эргэн санах болсны дагуу XVII-XVIII зуунд монголын түүхийн ойллого судар, түүхэн сурвалж бичиг, зохиол бүтээл олноор гарч, энэ үеийн эрдэмтэн мэргэд тэдгээр бүтээлдээ өмнөх үеийн монголын нийгэм, улс төрийн түүхийн талаарх сурвалж бичиг, аман болон бусад мэдээ материалыг эргэн харж авч үзэх, тэдгээрийн агуулга, үзэл санааг шууд болон дам байдлаар дахин өгүүлэх, сэргээн тавих, зааж дурдах, тайлбарлах болсноор нэг ёсондоо монголын түүхийн түүх бичлэг XVII-XVIII зуунд бий болсныг академич Ш.Бира ба бусад эрдэмтэд судалж, нотлон[7] тогтоожээ. Энэ нь монголын улс төрийн сэтгэлгээний түүх бичлэгийн асуудалд ч холбоо хамааралтай гэж үзэж болох юм. Чухамдаа XVII-XVIII зууны үед зохиогдсон “Хаадын үндсэн хураангуй Алтан товч”, “Эртний монголын хаадын их Шар тууж”, “Хаадын үндэсний эрдэнийн товч”, “Дай Юань улсын болор эрхи”, “Эрдэнийн эрхи” гэх мэт түүхийн зохиол, сурвалж бичгүүдэд өмнөх үеийн монголын улс төрийн сэтгэлгээний ерөнхий агуулга, голлох үзэл санааг ямар нэг хэмжээгээр сэргээж зураглан гаргажээ. Үүнийг эш үндэс болгон эдгээр товчис зохиолууд нь монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн чухал сурвалж бичгүүд мөн хэмээн үзэж болох юм.

Тэгвэл, XIX зууныг монголын улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжлийн бие даасан шинэ үе шат болгон авч үзэх үндэслэл бий. Энэ үед гадаад дотоодын нөхцөл, хүчин зүйлийн нөлөөгөөр монголын нийгмийн амьдрал, түүхэн нөхцөл байдал өмнөх үеүдээс өөрчлөгдөж, тэр нь улс төрийн сэтгэлгээнд тусгалаа олсон, энэ үед гарч ирсэн нэг шинэ чухал зүйл бол улс төрийн сэтгэлгээ нь нийгэм-улс төрийн зүтгэлтэн, томоохон яруу найрагч, зохиолч, соён гэгээрүүлэгч зэрэг түүхэн тодорхой сэтгэгч бие хүмүүсийн[8] улс төрийн үзэл санаа, сургаал, зохиол бүтээлүүдээр[9]

---

[6] *Жүгдэр Ч. XV-XVIII зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. ШУАХ. Уб., 1984; Жүгдэр Ч. Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. ФСЭХ, ШУА. Уб., 2008. “Бэмби сан” ХХК. 235 дахь тал*

[7] *ФСЭХ., ШУА. XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред. Жамбал А. Уб., 2006, 10-11 дэх тал*

[8] *Нацагдорж Ш. То ван ба түүний сургаал. ШУА-ийн мэдээ сэтгүүл. ШУАХ. Уб., 1966.*

[9] *Жүгдэр Ч. XIX-XX зууны заагдахь Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. ШУАХ. Уб., 1972; Дашжамц Д. Монгол дахь дэвшил ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд (XIX-XX зууны заагдахь). ШУАХ.*

баяжсан явдал юм. XIX зууны сүүлчээр нийгэм-улс төрийн сэтгэлгээний хэв маяг өөрчлөгдөн шинэчлэгдэх хандлагатай болж, шүүмжлэлт, шинэтгэлийн үзэл санаа товойн гарч иржээ. Энэ хугацаанд улс төрийн амьдрал ба улс төрийн сэтгэлгээний холбоо, харилцан нөлөөлөл өмнөх үеүдийнхээс илүү нягт, идэвхтэй болжээ. XIX зууны монголын их зохиолч, түүхч, сэтгэгч Инжиннаши "Их Юань улсын мандсан төрийн хөх судар" хэмээх гурамсан зохиолдоо XII зууны сүүлч, XIII зууны эхэн үеийн монголын нийгэм, улс төрийн түүхийн 70 гаруй жилийн үйл явдлыг түүхэн романы хэлбэрээр гарган тавих явцад тэр үеийн монголчуудын улс төрийн сэтгэлгээний үзэл санааг[10] дам байдлаар ерөнхийд нь зураглан гаргажээ. Холбогдох зарим ном бүтээлээс тоймлон үзэхэд монголын улс төрийн сэтгэлгээнд шууд ба дам холбогдолтой түүх, хууль цааз, уран зохиолын дурсгалт бичиг, сурвалж ба бусад баримт сэлтийг гадаадын судлаачид XIX зууны эхэн биеэс сонирхон судлах болжээ. Тухайлбал XIX зуунд Н.Я.Бичурин, Г.Гомбоев, Кафаров Палладий, П.С.Паллас, К.Ф.Голстунский, А.М.Позднеев, Г.Н.Потанин, В.П.Васильев нар, XX зууны эхээр Б.Я.Владимирцов, В.А.Рязановский, хожим нь Н.П.Шастина, түүнчлэн Европ, Хятад, Японы зарим эрдэмтэн тэдгээр сурвалж бичгүүдийг сурвалжлан тогтоох, нягтлан үзэж тайлбар хийж нийтлүүлэх, гадаад хэлэнд хөрвүүлэх зэрэг байдлаар судалгааны ажлын эргэлтэд оруулах[11] болсон байна. Энэ нь монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг холбогдох сурвалж бичгүүдээр баримтжуулж үндэслэхэд чухал ач холбогдолтой болсон бөгөөд тэгэхдээ яг сэтгэлгээний түүхийн аспеттэй зориудын судалгаа хараахан биш байсныг хэлэх хэрэгтэй болов уу.

XX зуун бол монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний өөрчлөлт, хөгжлийн цоо шинэ, сонирхолтой, баялаг агуулгатай үе шат болсныг энд тайлбарлах нь илүүц зүйл. Тухайн ард түмэн, түүнийг төлөөлсөн сэтгэгч мэргэдийн улс төрийн үзэл санаа, сургаал, сэтгэлгээ нь нэг талаас ямар нэг хэлбэр, төрөл зүйлээр бичигдэж тэмдэглэгдэн үлддэг, тэгснээрээ улс төрийн сэтгэлгээний түүхийн эх сурвалж, дурсгалт бичиг, бусад баримт сэлт бүрэлдэж хуримтлагддаг байна. Өөрөөр хэлбэл, XX зууны эхээр тухайн үеийн эрх баригчдаас явуулсан шинэ засгийн бодлого нь феодалын үндсэрхэх үзлийн өрнөлтөд хүчтэй түлхэц үзүүлсэн байдаг. Энэ бол үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэлд хүчин зүтгэх, улмаар үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд уриалан дуудсан монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөх чухал түлхэц болжээ. Угтаа эл хөдөлгөөний үр дүнд тогтсон засаг төр нь феодал ангийн эрх ашгийг хамгаалах зэвсэг болж байсан нь угтаа шашныг улс, үндэсний тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг хэмээн ард нийтээр үзэж, шашны далбаан дор нэгдэн нягтарсан феодалын эх оронч үзлийн бодитой хэрэгжилт байв. Үүнээс улбаалан монголын ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх тэмцлийг эхнээсээ тууштай дэмжиж "онолын" үүднээс зөвтгөн үндэслэж ирсэн үзэл санааны өөр нэгэн чиглэл бол соён гэгээрүүлэгч дэвшилтэт-ардчилсан үзэл билээ. Дэвшилтэт-ардчилсан үзэл нь манж-хятадын колоничлогчид, тэднийг аялдан дагагч феодал ноёдын байр суурийг илчлэн харуулаад зогсохгүй, ерөөс феодализмыг нийгмийн байгууллынх нь хувьд эсэргүүцэн үгүйсгэж, феодалын төрийг илүү дэвшилттэй, ардчилсан буюу хөрөнгөтний, бүгд найрамдах төрөөр халах үзэл санааг дэлгэрүүлэн сурталчилж байжээ. Үүгээрээ дэвшилт-ардчилсан үзэл нь монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн үзэл санааны чухал ололт байж, уг тэмцлийн үндэсний хийгээд нийгмийн агуулга, хүрэх үр дүн, эцсийн

*Уб., 1970.*

[10] *ФСЭХ., ШУА. XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред. Жамбал А. Уб., 2006, 11 дэх тал*

[11]

зорилтыг тухайн үедээ бололцоотой хэмжээгээр илэрхийлэх[12] явдал байжээ.

Нөгөөтээгүүр дээр дурдсан бүхэн нь улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгааны гол хэрэглэгдэхүүн, судлагдахуун болдог. Тэдгээр нь эх сурвалж ба бусад баримт сэлтээр дамжуулж улс төрийн сэтгэлгээний түүхийг тусгайлан судлах, түүний үр дүнг системтэй бичиж тэмдэглэснээр улс төрийн сэтгэлгээний түүх бичлэг бүрэлдэн бий болдог байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн сэтгэлгээний бодит түүх, түүний эх сурвалж, дурсгалт бичиг ба нөгөөтээгүүр улс төрийн сэтгэлгээний түүх бичлэг, түүний судалгаа хоёр хоорондоо нягт холбоотой боловч бас зарчмын ялгаатай, өөр өөр зүйл байдаг. Дэлхийн хэмжээний улс төрийн сэтгэлгээний түүхийн туршлагаас үзвэл, улс төрийн сэтгэлгээний түүх бичлэг нь уг сэтгэлгээний бодит түүхээс нэлээд хугацааны дараа, хожим нь бүрэлдэж бий болдог ажээ. Энэ нь монголын улс төрийн сэтгэлгээний түүх бичлэгт ч нийтлэг хамааралтай аж.

1921 онд Судар бичгийн хүрээлэн байгуулагдаж, улмаар эрдэм судлалынхаа нэгэн чухал чиглэлийг монголын түүх, соёл, уран зохиолын холбогдолтой ховор ном зохиол, сурвалж бичгүүдийг сурвалжлан эрж олох, цуглуулах болсон түүхтэй. Эл ажилд С.Жамьян, Ж.Цэвээн, Д.Дашням, Б.Ширнэндамдин болон бусад хүмүүс гар биеэр оролцсон нь бий. Түүний үр дүнд ховор чухал сурвалж бичиг, ном дэвтэр нэлээдийг олж цуглуулсны дотор Галсангийн *“Эрдэнийн эрхи”, “Арван буянт номын цагаан түүх”,* Лувсанданзангийн *“Алтан товч”* орсон байх ба *“Алтан товч”*-ийг 1937 онд нийтлүүлж уншигчдын хүртээл болгожээ. Эдгээр нь хожим монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг холбогдох сурвалж бичигт тулгуурлаж судлан боловсруулахад зайлшгүй шаардлагатай урьдач бэлтгэл болсноороо түүхэн ач холбогдолтой байв. Түүнчлэн монголын нийгэм-улс төр, хууль цаазын сэтгэлгээний түүхийг монголын эрдэмтэд өөрсдөө авч үзэж судлах шинэ чухал үйл хэрэгт анхны алхам, оролдлого хийсэн эрдэмтэн бол Ж.Цэвээн[13] юм. Тэрбээр А.Туруновтой хамтарч *“Халх журам”*-ын тухай бүтээлийг 1923 онд Эрхүүгийн их сургуулийн эрдэм шинжилгээний бичигт, хожим өөрөө дагнаж бичсэн “*Монгольские летописи XVII века”* хэмээх бүтээлээ 1936 онд Ленинградад нийтлүүлжээ. Жамсрангийн Цэвээн эл бүтээлдээ *“Цагаан түүх”* ба түүхийн бусад сурвалж бичгийн нийгэм-улс төрийн үзэл санааг хөндсөн нь туйлын сонирхолтой, чухал зүйл хэмээн үзэж болно. Холбогдох мэдээ баримт, ном зохиолоос үзэхэд 1920-иод оны сүүлч, 1930-аад оны эхээр монголын түүхийг судлах, түүхийн ном бүтээл хэвлэн гаргах үйл хэрэгт өмнөх үеүдээс чанарын ялгаатай ахиц ололт гарчээ. Энэ үед монголын түүхийг эртнээс тухайн үе хүртэлх үеэр цэгцтэй, шинэ цагийн түүхийн ухааны үлгэр жишээгээр авч үзэн гаргаж тавих эхлэл тавигджээ. Тухайлбал 1928 онд Ч.Бат-Очирын *“Монгол улсын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг”;* А.Дэндэвийн *“Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр”;* 1934 онд А.Амарын *“Монголын товч түүх”* тэргүүн дэвтэр; А.Дэндэвийн *“Монголын товч түүх”* нийтлэгдсэн бол Ч.Дэмчигдорж *“Юань улсын судар”*-ыг 1928 онд орчуулж дуусгажээ. Эдгээр түүхчид бүтээлүүддээ Монголын нийгэм, төрийн түүхийг ерөнхийд нь хураангуйлан өгүүлэх явцад монголын улс төрийн сэтгэлгээний талаар зарим зүйлийг дурдаж[14] тэмдэглэсэн байна. Нөгөөтээгүүр, хувьсгалын дараа Монголын нийгмийн амьдралын бүх хүрээнд шинэчлэлийн үйл явц өрнөсөн нь Монгол оронд хөгжлийн ойрын болон

[12] *Цогтсайхан Д. Монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Бүтээлийн эмхэтгэл. Эмхэтгэсэн. Жаргал Ц., Гэрэл Ц. Уб., 2015, 172 дахь тал*

[13] *Жүгдэр Ч. Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. ФСЭХ, ШУА. “Бэмби сан” ХХК. Уб., 2008. 507 дахь тал*

[14] *ФСЭХ., ШУА. XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред. Жамбал А. Уб., 2006, 11-12 дахь тал*

хэтийн хандлагыг бүрэлдүүлэх улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралд зарчмын хийгээд ардчилал, шинэчлэлийн үзэл санаа тууштай дэвшигдэх болжээ. Тухайлбал, улс төрийн салбар дахь өөрчлөлт нь Монгол оронд бүгд найрамдах засаг тогтоож, хуулийг дээдлэх үзэл санааг нийгэмд төлөвшүүлэн, улмаар Монголд парламентын ёсыг бүрэлдүүлэх угтвар нөхцөлийг бий болгоод зогсохгүй нийгмийн гишүүд гарал угсаа, хөрөнгө чинээний байдлаас үл хамааран адил тэгш эрхтэй болсон нь ардчилсан өөрчлөлтийн нэн чухал ололт байв. Түүнчлэн төр шашны харилцааг хуулиар зохицуулах, ард олны шүтэх бишрэх эрх чөлөөг төрөөс хангаж байсан бөгөөд монголын нийгэмд олон ургальч үзэл төлөвшиж эхэлсэн зэрэг нь тухайн үеийн монголын нийгэмд ардчилсан ёс бүрэлдэж эхэлсний нэн тодорхой илрэл болсон[15] хэмээн үзэж болох юм.

Хожим 1950-иад онд Монгол-зөвлөлтийн түүхчдийн хамтран зохиосон “БНМАУ-ын түүх” (1954) нийтлэгдсэн нь монголын түүхээр гарсан анхны дорвитой бүтээл болжээ. Үүний дараах үеэс манай эрдэмтэд монголын нийгэм, төрийн түүх, түүний тодорхой асуудлуудыг тусгайлан судалж эхэлсэн байна. Энэ явцад нийтлэгдэн гарсан бүтээлүүдийн дотроос монголын улс төрийн түүх, улс төрийн сэтгэлгээний түүхтэй холбоотой бүтээлүүдээс Ш.Нацагдоржийн *“Ар Монголд гарсан ардын хөдөлгөөн”* (1956), *“Чингис ба түүний дүү Хасар нарын зөрчил”* (1957), *“Цагаан түүхийн тухай хэдэн үг”* (1958), С.Жалан-Аажавын “*Халх журам бол Монголын хууль цаазын дурсгалт бичиг мөн”* (1958) хэмээх бүтээлүүдийг онцлон дурдах нь зүйтэй гэж үзэв. Чухам эдгээр бүтээл гарснаар монголчуудын улс төрийн сэтгэлгээний түүхийг түүний өөрийнх нь аспетээр тусгайлан судлах эхлэл тавигдсаныг гэрчилж буй хэрэг бөлгөө. Монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээ нь түүхэн хөгжлийн явцдаа уран зохиолтой нягт уялдаатай хөгжиж ирсэн онцлогтой юм. Үүнтэй холбоотойгоор Ц.Дамдинсүрэн 1957 онд *“Монголын уран зохиолын тойм”* бүтээлийг, 1959 онд “*Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой”* хэмээх цоморлогийг нийтлүүлсэн нь Монголын уран зохиолын судалгаа төдийгүй гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг судлах, тэдгээрийн эх сурвалж, дурсгалт бичгүүдийг цуглуулж нийтлэх ажлын үндэс суурь болжээ.

Энэ үеэс хойш монголчуудын улс төрийн сэтгэлгээний түүхийг тусгайлан судлах ажил амжилттай хийгдэх болсон. Тухайлбал, 1960-аад оны эхээс монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн тодорхой асуудлуудыг диссертаци, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээлийн түвшинд тусгайлан судлах болсноор эл чиглэлийн судалгаа бие даан хөгжиж, улмаар тодорхой амжилтад хүрч ирсэн нь бий. Тодруулбал, академич Ч.Жүгдэр 1960-аад оны эхээс 1980-аад оны хоёрдугаар хагаст мөнхүү дурдсан асуудлыг шат дараатай, системтэйгээр судалж *“XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил”* (Уб., 1972), *“З.Агваанбалдангийн гүн ухааны үзэл”* (Уб., 1978), *“XV-XVIII зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм”* (Уб., 1984), *“Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ”* (Уб., 1987) гэсэн дөрвөн томоохон цуврал бүтээл, олон тооны эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллүүдийг бичиж туурвисан нь монголын гүн ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг эртнээс XX зууны эхэн хүртэлх үеэр нь манайд анх удаа цогцолбор байдлаар судлан гаргаж тавьсан нь шинжлэх ухааны асар их ач холбогдолтой үйл хэрэг болсон юм. Мөн Ч.Жүгдэрийн бичсэн “*Монголын нийгэм-*

[15] *Дашдаваа Ч. Улаан түүх (Коминтерн ба Монгол). Хоёр дахь удаагийн хэвлэл. ред. Бат-Очир Л. Түүхийн хүрээлэн,, ШУА., СУИС, Улаанбаатар-Эрдэм судлал дээд сургууль. . “Бэмби сан” ХХК. Уб., 2019, 85 дахь тал*

*улс төрийн ба гүн ухааны сэтгэлгээний түүхэн хөгжлийн зарим асуудал"* хэмээх эрдэм шинжилгээний чухал өгүүлэл 1966 онд "ШУА-ийн мэдээ" сэтгүүл (1966, №3)-д нийтлэгдсэн бол, Ш.Нацагдорж *"То ван ба түүний сургаал"* хэмээх бие даасан судалгааны бүтээлийг 1968 онд тус тус нийтлүүлжээ. Түүнчлэн эрдэмтэн судлаач Г.Дэлэг *"Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл"* нэртэй эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт томоохон бүтээл туурвин 1965 онд нийтлүүлсэн бөгөөд түүндээ XX зууны эхэн үеийн тогтмол хэвлэлд туссан монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний тоймыг гаргаж тавих болсон. Үүний тод жишээ болгон академич Ш.Нацагдорж нарын манай эрдэмтэдийн дотроос анх удаа 1950-иад оны дунд үеэс, зарим талаар 1940-өөд оноос монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн зарим тодорхой асуудал, тухайлбал "*Монголын нууц товчоо", "Цагаан түүх", "Улаан хацарт", "Халх журам",* 1960-аад онд *"То вангийн сургаал",* 1980-аад оны сүүлчээр Чингисийн нийгэм-улс төрийн үзэл санаа болон нийгэм-улс төрийн ба хууль цаазын сэтгэлгээний бусад дурсгалт бичиг, эх сурвалжуудад анхаарал хандуулж, тэдгээрийн үзэл санааг судлан, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, товхимлуудыг нийтлүүлжээ. Энэ бол монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаа өөрийн аспетээр бие дааж ялгаран хийгдээгүй, гэхдээ түүнийг эхлүүлэхэд зайлшгүй шаардлагатай урьдач бэлтгэл судалгааны ажлын байдалтайгаар монголын түүхийн ерөнхий судалгаа, түүхийн сурвалж бичгүүдийг нягталж тайлбар үйлдэн нийтлүүлэх ажлын хүрээнд хийгдсэнээрээ онцлогтой. Цаашилбал, монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг бие даасан байдлаар судлан боловсруулах эрдэм шинжилгээний шинэ чиглэлийг бий болгох эхлэл тавигдсан гэж хэлж болохоор байна. Угтаа энэхүү судалгааны чиглэл нь тохиолдлын зүйл биш, харин ч тухайн үеийн монголын нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны амьдрал, монголын нийгмийн шинжлэх ухааны байдал, тэдгээрт нөлөө оролцоотой байсан бусад хүчин зүйлстэй нөхцөлдсөн нийгэм-соёлын чухал үзэгдэл байсныг энд онцлох нь зүйтэй.

Өгүүлэн буй сэдвийн хүрээнд монголын нийгэм, соёл, тэр дотор нийгмийн шинжлэх ухааны хувьд Дэлхийн II дайны уршгаар бий болсон хүн ам, нийгэм, эдийн засаг, аж ахуйн их хэмжээний хохирол, бэрхшээлийг даван туулах, улмаар эдийн засгийг цааш сэргээж шинэ шатанд гаргах, эрчимтэй хөгжүүлэхэд голлон анхаарах болжээ. Энэ нь социаль хүрээний хувьд эдийн засгийн өсөлтөд тулгуурлаж хүн амын материаллаг амьдралыг сайжруулах, эрүүл мэнд, соёл, боловсролын түвшнийг ахиулах, түүнчлэн улс төрийн амьдралд тухайн үед Монгол болон ЗХУ-д тогтон ноёрхож байсан ардчилсан бус, хатуу дэглэм аажмаар суларч, эдгээр дэглэмд зарим талын *"эерэг"* өөрчлөлт гарах болсны нөлөөгөөр нийгэм дэх улс төрийн болон үзэл суртлын хатуу хяналт, дарамт тодорхой хэмжээгээр багасаж, хүмүүсийн үзэл ухамсар, ялангуяа сэхээтэн, тэр дотор нийгэм-хүмүүнлэгийн салбарын сэхээтэн мэргэжилтнүүдийн оюун санаа, сэтгэхүйн хүлээс, айдас болгоомжлол мэдэгдэхүйц багасаж эхэлсэнтэй шууд холбоотой.

1970-аад оны эхэн үеэс монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаа үлэмж гүнзгийрч, улмаар доктор Д.Дашжамц *"Монгол дахь дэвшилт ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд: XIX-XX зууны зааг"* (Уб., 1970) нэртэй бүтээлийг, Ч.Жүгдэр *"XIX-XX зууны зааг дахь монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил"* (Уб., 1972) хэмээх нэгэн сэдэвт бүтээлийг тус тус нийтлүүлсэн байна. Энэ бол монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаанд академич Ш.Нацагдорж, академич Ч.Жүгдэр нарын оруулсан жинтэй хувь нэмэр төдийгүй, тэдний эл дурдсан суурь бүтээлүүдийн тухай товч боловч тусгайлан өгүүлэх зайлшгүй шаардлагатай болохыг харуулж буй хэрэг. Учир нь

дурдсан эрэг өөрчлөлттэй нөхцөлдөн манай оронд орчин үеийн шинжлэх ухаан, тэр дотор нийгмийн шинжлэх ухаан өмнөх үеийнхээсээ ахиж, хөгжлийн шинэ шатанд дэвших наашта й өөрчлөлт гарах болсонтой холбоотой. Өмнө нь түүх, хэл шинжлэл, уран зохиол судлал голлож байсан нийгмийн шинжлэх ухаанд дифференциац буюу салбар ухаануудын ялгарал явагдаж философи, ёс зүй, төр, эрх зүйн ухаан хийгээд тэдгээрийн түүх буюу философи, ёс зүй, нийгэм-улс төр, хууль цаазын сэтгэлгээний түүхийн ухааны эх үндэс бий болж тэдгээрийн мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдыг бэлтгэх болсон. Тухайлбал, дээр нэгэнтээ өгүүлсэнчлэн, академич Ш.Нацагдорж манайд 1950-иад оны дунд үе хүртэл тусгайлан судлагдаж байгаагүй монголын нийгэм-улс төр, хууль цаазын сэтгэлгээний түүхийг нийгмийн сэтгэлгээний түүхийн аспетээр, бие даасан байдлаар судлан боловсруулах шинэ судалгааг санаачлан эхлүүлсний гол илрэл мөн. Эл санаачилга нь цаашдаа түүний тодорхой, чухал асуудлуудыг шинжлэн авч үзэх, улмаар тухайлсан салбар шинжлэх ухааны судалгааны чиглэлийн үндэс суурийг тавьсан нь асар их ач холбогдолтой үйл хэрэг болсон юм.

Учир ахул, дэлхийн олон янзын чиглэл сургууль, онол сургаалын янз бүрийн төлөөлөгчид, судлагчид улс төрийн сэтгэлгээний түүхийг судлахдаа олон янзын арга зүй, хандлага, үзэл онолыг баримталсан байдаг. Үүнийг ч манай эрдэмтэд монголын ард түмний оюуны соёл, сэтгэлгээний хувьд мөн нэгэн адил нийтлэг шинжтэйг харуулахын сацуу улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаанд түүний онол, арга зүй чухал ач холбогдолтой болохыг онцолсон нь зүйн хэрэг ажээ. Ном бүтээлээс үзэхэд, судлаачид улс төрийн сэтгэлгээ бол *нэгдүгээрт,* тухайн цаг үеийн улс төрийн бодит байдал, улс төрийн амьдралыг тодорхой үзэл санаа, онол, сургаал, номлолын хэлбэрээр тусган илэрхийлсэн байдгийг, *хоёрдугаарт,* улс төрийн сэтгэлгээ нь бодит байдлын идэвхгүй тусгал төдий биш, өөрийн дотоод логик, онцлог, бие даасан байдал, идэвхт чанартай, энэ шинжээрээ улс төрийн амьдралаас заримдаа түрүүлж илүү хөгжсөн байдгийг, *гуравдугаарт,* улс төрийн сэтгэлгээг судлан шинжилж нэгтгэн дүгнэх гол, чухал зарчим бол асуудалд түүхэн тодорхой хандах зарчим байдгийг хүлээн зөвшөөрч баримталдаг байна. Энэ нь ч өнөөгийн олон эшт үзэл, чөлөөт сэтгэлгээний түвшнээс ахин дахин нягтлах, улмаар улс төржсөн эсхүл үзэл сурталжсан байр сууринаас хандалгүйгээр илүү шинжлэх ухаанч зарчмаар хандахыг биднээс шаардаж буй. Монгол хүн аливаад амьдралын хэрсүү ухаанаар уужуу тайван ханддаг, эв эеийг эрхэмлэдэг, төрд хандах хандлага нь үнэт зүйлс-ёс суртахууны шинжтэй гэж хэлж болно. Чингэхлээр монголчуудын төрт ёсны сэтгэлгээ тал нутгийн нүүдэлчдийн сэтгэхүй, үзэл бодол, хамтран аж төрөхүй, ёс заншлаас сурвалжтай нь эргэлзээгүй билээ. Нөгөө талаар, монголчуудын ертөнцийн тухай төсөөлөлд орон зайн ухагдахуун чухал байр эзлэх бөгөөд тэр нь дээд тэнгэр, эх нутаг, уул ус, гал голомт, өвөг дээдсээ шүтэн бишрэхээр дамжин төрөө дээдлэх уламжлалт үзэлд нэвт шингэсэн байдагтай шууд холбоотой.

### *Хоёр. Шинжлэх ухаан коммунизмын онол ба марксист-ленинист сургаалын үе (1972-1990)*

XIX-XX зууны зааг үе хүртэл үргэлжилж хөгжсөн монголын улс төрийн уламжлалт сэтгэлгээ ба түүний түүх бичлэг хийгээд 1920-иод оноос 1990-ээд оны эхэн хүртэл хийгдсэн улс төрийн чанартай судалгааг авч үзсэн асуудал, хандсан аспект, агуулгыг нь харгалзан үзэж дотор нь ерөнхий чиглэл, салбараар ангилан авч үзвэл дараах зураглал гарч буй.




1920-иод оноос 1990-ээд оны эхэн хүртэлх хугацаанд төр, улс төрийн нам, улс төр-олон нийтийн байгууллагын шинж чанар хосолсон үйлдвэрчний эвлэл, залуучууд, эмэгтэйчүүд, хүүхдийн байгууллага, бүхэлдээ улс төрийн системийн онол, түүх, түүнчлэн хувьсгал, нийгэм-улс төрийн хөдөлгөөн, анги, ангийн тэмцэл, дайн цэрэг арми, сонгуулийн асуудлаар олон талтай судалгаа хийгдэж улмаар олон арван ном бүтээл нийтлэгдэн гарчээ. Тэдгээрээс зарим нэг гол бүтээлүүдийг[16*] дараах байдлаар дурдвал:

| | |
|---|---|
| **улс төрийн түүх, хууль тогтоох үйл ажиллагааны талаар** | ○ Ц.Балхаажав. Төрийн тухай асуудал ба ардын төрийн хувьсгалт үйл ажиллагаа. Уб., 1966<br>○ С.Жалан-Аажав. Ардын хувьсгалт төрийн хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн чиглэл. (1921-1940). Уб.,1967<br>○ Б.Цэдэн. Монгол –Зөвлөлтийн найрамдал ба МАХН. Уб., 1967<br>○ Б.Сангиданзан. Хувьсгалт ардчилсан шатан дахь ардын төрийн гүйцэтгэсэн үндсэн үүргүүд. Уб., 1974<br>○ С.Дамба. БНМАУ-ын төрийн хөгжилт. Уб., 1974<br>○ М.Санждорж. Ардын төрийн түүх. Уб., 1974<br>○ Лу.Бат-Очир. Монгол оронд ард ангийн хувьсгалт нам үүсэн байгуулагдсан асуудалд. 1918-1921. Уб., 1979<br>○ О.Амархүү. Төрийн захиргааны дээд байгууллагууд. Уб., 1986<br>○ Б.Содовсүрэн. Хувьсгалын өмнөх монголын төр ба хууль цааз. 1911-1920. Уб., 1989 |

| | |
|---|---|
| **залуус, эмэгтэйчүүд, хүүхдийн байгууллагын талаар** | ○ А.Маамуу. МХЗЭ-ийн түүхээс. Уб., 1965<br>○ Ш.Магван. Монголын үйлдвэрчний эвлэлийн соёл, хүмүүжлийн ажил. Уб., 1971<br>○ О.Бямбажав. Монголын хувьсгалт залуучуудын эвлэл. Уб., 1972<br>○ Д.Цэрэндорж. Хувьсгалт уламжлал ба залуучууд. Уб., 1974<br>○ Э.Чимэдцэрэн. БНМАУ-д эмэгтэйчүүдийг нийгмийн дарлалаас чөлөөлсөн түүхэн туршлага. Уб., 1976<br>○ Д.Зундуй. БНМАУ-д эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг хамгаалж байгаа нь. Уб., 1979<br>○ С.Удвал. Монголын эмэгтэйчүүд 60 жилд. Уб., 1981 |

| | |
|---|---|
| **дайн, цэрэг арми, хууль хамгаалах, хянан шалгах байгууллагын талаар** | ○ Л.Тойвон. Дайнууд ба армийн гарал үүсэл, түүний мөн чанар. Уб., 1943<br>○ Хязгаарын цэргийн түүхэн замнал. Уб., 1965<br>○ П.Дорж. Улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх талаар МАХН-аас явуулсан бодлого (1929-1939). Уб., 1969<br>○ Монголын ардын армийн дайчин замнал. Уб., 1979<br>○ БНМАУ-ын зэвсэгт хүчин. Уб., 1981<br>○ М.Санждорж, Ч.Бавуу. БНМАУ-ын хянан шалгах байгууллагын түүхэн замнал. Уб., 1982<br>○ Д.Гомбосүрэн. Хувьсгалын ардчилсан шатан дахь БНМАУ-ын зэвсэгт хүчний байгуулалтын зарим асуудал. Уб., 1983<br>○ Д.Шагдар, П.Дагвадорж. Хилийн цэргийн 50 жил. Уб., 1983<br>○ Б.Даваасүрэн. МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа. Уб., 1990 |

---

[*] *ШУА-ийн Философин хүрээлэнгийн эрдэм шинжилгээний номын сангийн фондод бүртгэлтэй болон хадгалагдаж буй ном бүтээлүүдээс энд дурдсан болно.*

| | |
|---|---|
| улс төрийн намын түүх, түүний онолын асуудлаар | ○ Л.Санжаа. Намын программуудын тухай. Уб., 1967<br>○ С.Ичинноров. Монгол ардын нам гэдэг хувьсгалт байгууллага. Уб., 1973<br>○ Ц.Намсрай. Капитализмыг алгассан орнуудад социалист нийгмийн давхрага үүсэж хөгжсөн нь. Уб., 1975<br>○ Н.Дамба. МАХН-ын эгнээ хөгжиж бэхжсэн нь. Уб., 1975<br>○ Б.Лигдэн. МАХН бол социалист нийгмийн улс төрийн системийн удирдах хүч мөн. Уб., 1978<br>○ Ж.Болдбаатар. Социалист байгуулалтаар МАХН-ын удирдах роль өсөн нэмэгдэж байгаа нь. Уб., 1982<br>○ Ц.Буянтогтох. БНМАУ-ын улс төрийн системд МХЗЭ-ийн гүйцэтгэх үүрэг. Уб., 1985<br>○ С.Дамдинсүрэн. МАХН дэлхийн коммунист хөдөлгөөнтэй холбоо тогтоож хөгжүүлсэн нь. (1921-1940). Уб., 1971<br>○ МАХН-ЗХУКН, Социализмын төлөө ах дүүгийн ёсоор хамтран тэмцсэн түүхэн туршлага. Хамтын бүтээл. Уб., 1971<br>○ Д.Даш. Ардын хувьсгалын манлай хүчин. Уб., 1972<br>○ Б.Лигдэн. БНМАУ-ын гадаад харилцааг хөгжүүлэх талаар МАХН-аас явуулсан үйл ажиллагаа (1945-1970). Уб., 1976<br>○ Б.Лхамсүрэн. МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь. Уб.,1975<br>○ Г.Лхагвасүрэн. Ардын хувьсгалын үе дэх МАХН-ын стратеги, тактикийн зарим асуудал. Уб., 1977<br>○ МАХН ба Коммунист Интернационал (орос хэлээр). Хамтын бүтээл. Уб., 1979<br>○ МАХН үүсэж хөгжихөд олон улсын коммунист хөдөлгөөний тусламжийн роль, ач холбогдол. Уб.,1978<br>○ Х.Магсаржав. МАХН-ын эгнээ өргөжин бэхжсэн нь (1921-1924). Уб., 1979 |

| | |
|---|---|
| хувьсгал, нийгэм-улс төрийн хөдөлгөөн, анги, ангийн тэмцлийн асуудлаар | ○ Л.Тойвон. БНМАУ-ын сонгуулийн систем. Уб., 1950<br>○ Ш.Нацагдорж. Ар монголд гарсан ардын хөдөлгөөн. Уб., 1956<br>○ Б.Түдэв. БНМАУ-ын ажилчин ангийн түүх. Уб., 1963<br>○ Д.Цэдэв. Их шавь. Уб., 1964<br>○ С.Норовсамбуу. Капитализмын өмнөх харилцаа ноёрхон байсан орнуудад ялсан ардчилсан ба социалист хувьсгалын харьцаа, онцлогууд. Уб., 1965<br>○ С.Пүрэвжав, Д.Дашжамц. БНМАУ-д сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь (1921-1940). Уб., 1965<br>○ Б.Ширэндэв. Монгол ардын хувьсгалын түүх. Уб., 1969<br>○ Октябрийн хувьсгал ба Монгол орон. Хамтын бүтээл. Уб., 1969<br>○ Б.Лигүү. Монгол ардын хувьсгал ба шинэ сэхээтэн. Уб., 1971<br>○ Ц.Балхаажав. БНМАУ-ын ангийн харилцааны хөгжил. Уб., 1972<br>○ И.Дашням. БНМАУ-ын сонгуулийн систем. Уб., 1975<br>○ Ш.Жумдаан. БНМАУ-д ажилчин анги, хоршоолсон ардын эдийн засгийн холбоо үүсэж тогтож хөгжсөн тухай. Уб., 1978 |

| | |
|---|---|
| төрийн гадаад бодлого, олон улсын харилцааны асуудлаар улс төрийн аспекттэй судалгаа | ○ Ц.Пунцагноров. Америкийн империализм бол монголын ард түмний заналт дайсан мөн. Уб., 1953<br>○ Б.Лхамсүрэн. Внешняя политика МНР (1943-1957). Уб., 1958<br>○ Б.Лигүү. Из истории русско-монгольских отношении в конце XIX начале XX века. (диссертаци). 1958<br>○ Д.Хүрэлбаатар. Монгол гүрний элчин харилцаа. (XIII зуун) Уб., 1964<br>○ Ш.Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа (1850-1919). Тэргүүн дэвтэр. Уб., 1971<br>○ Н.Дангаасүрэн. Гурав дахь ертөнц. Эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал. Уб., 1977<br>○ Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх (1921-1976). Хамтын бүтээл. Уб., 1981<br>○ Ц.Самдангэлэг. Зөвлөлт-Монголын армиуд Халх голд Японы түрэмгийлэгчдийг бут цохисон нь. Уб., 1981<br>○ С.Дамдинсүрэн. Монгол Ардын Хувьсгал-дэлхийн хувьсгалт үйл явцын бүрэлдэхүүн хэсэг. Уб., 1983<br>○ Л.Бат-Очир. МАХН фашизм, милитаризмын эсрэг тэмцэлд ард түмнээ зохион байгуулсан нь (1941-1945). Уб., 1985<br>○ Ж.Бор. Монголын улс төрийн гадаад бодлого, дипломатын уламжлалын зарим асуудал. Уб., 1988<br>○ Өнөөгийн Ази: Дайн энхийн асуудал. Хамтын бүтээл. Уб., 1989 |

Тэгвэл, 1940-өөд оноос хойш хийгдсэн түүхийн судалгааны хүрээнд монголын төр, цэрэг, намын зүтгэлтэн, удирдагчид бүхий түүхэн бие хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааг бодит баримт түшин, тэдний аж төрж, зүтгэн тэмцэж байсан түүхэн нөхцөл, цаг үетэй холбож авч үзэж судалсан олон ном бүтээл нийтлэгдсэн байна. Тэдгээр нь улс төрийн шинжлэх ухааны хошуучлал буюу лидер судлалын чиглэлтэй нэлээд ойролцоо байгаа нь ажиглагддаг. Гэхдээ энэ нь тэдгээр судалгаанд лидер судлалд баримталдаг үзэл баримтлал, арга зүй, ойлголт, ангилал, судалгааны аргуудыг хэрэглэсэн гэсэн үг биш юм. Манай орны түүхийн ухаанд төр, цэрэг, намын нэрт зүтгэлтнүүдийн амьдрал үйл ажиллагаа, намтрыг судлан бичих явдал 1940-өөд оноос чухал болон тавигдаж бие даасан ном зохиол нийтлэгдэх болжээ. Ийнхүү түүхэн зүтгэлтнүүдийн намтар судлал, бичлэг идэвхэжсэн нь Дэлхийн II дайны үед хүмүүсийг цэрэг эх оронч үзлээр хүмүүжүүлэх зорилт нэн чухал болсонтой нягт холбоотой байжээ. Эдгээрээс өгүүлэн буй сэдвийн хүрээнд холбогдох зарим нэгийг

нь онцлохыг зорив.

| | |
|---|---|
| **Түүхэн зүтгэлтнүүдийн намтар судлал** | Ц.Цэдэнжав. Хатанбаатар Магсаржав. Уб., 1941<br>Ц.Цэдэнжав. Партизан Хасбаатар. Уб., 1942<br>Х.Чойбалсан. Ардын Хатанбаатар Магсаржав. Уб., 1942<br>Ш.Нацагдорж. Сүхбаатарын намтар. *(Д.Сүхбаатарын амьдрал, цэрэг-улс төрийн үйл ажиллагаа)*. Уб., 1943<br>Г.Навааннамжил. Дайсны ард нэвтэрсэн нь. Уб., 1944<br>Г.Навааннамжил. Жанжин Чойбалсан баруун замын байлдаанд. Уб., 1945<br>Ш.Нацагдорж. Манлайбаатар Дамдинсүрэнгийн товч намтар. Уб., 1945<br>Ю.Цэдэнбал. Нөхөр Чойбалсангийн амьдрал, үйл явдлын тухай. Уб., 1945 |
| | |
| **цэрэг эх оронч үзлээр хүмүүжүүлэх хүрээнд** | Г.Навааннамжил. Зоригт баатар Тогтохын намтар. Уб., 1946<br>Манай их удирдагч нөхөр Янжмаагийн 25 жилийн хувьсгалт бүтээл. Уб., 1946<br>Х.Чойбалсан. Сүхбаатар бол МАХН-ын жолоодогч бөгөөд түүнийг зохион байгуулагч мөн. Уб., 1955<br>Б.Ширэндэв. Хичээнгүй сайд Цэрэндорж (1868-1928). Уб., 1965<br>Сүхбаатарын тухай дуртатгалууд. Уб., 1965<br>Д.Ядамсүрэн. Ардын төрийн ахмад зүтгэлтэн Балингийн Цэрэндорж. Уб., 1967<br>Л.Бат-Очир, Д.Дашжамц. Д.Сүхбаатарын намтар. Уб., 1969<br>Б.Ширэндэв. Ардын Хатанбаатар Магсаржавын намтар. Уб., 1978<br>С.Ичинноров. Монголын ард түмний гарамгай хүү. Уб., 1983<br>Д.Даш. Д.Сүхбаатарын тухай түүхэн тэмдэглэл. Уб., 1988<br>А.Дашням. Солийн Данзан. Уб., 1990<br>Л.Бат-Очир. Бодоо сайд. Уб., 1991 |

Дээр дурдсанчлан 1990-ээд оноос өмнө хийгдэж байсан улс төрийн түүхийн судалгааны хүрээнд түүхэн бие хүмүүсийн намтар судлал нь түүний нэгэн чиглэл болон тавигдаж түүгээр XX зууны эхэн үе, ялангуяа 1921 оны ардын хувьсгал ба түүний дараах нийгмийн хувьсгалт өөрчлөлтийн үйл хэрэгт хүчин зүтгэж байсан монголын төр, нам, цэргийн томоохон зүтгэлтэн бүхий түүхэн бие хүмүүс, нэг ёсны лидерүүдийн амьдрал, нийгэм-улс төр, цэргийн үйл ажиллагааг судлан илэрхийлэхийг чухалчилж байв. Чингэхдээ урьд нь үзэл суртал, улс төрийн тодорхой учир шалтгаануудын улмаас авч үзэж судалж байгаагүй, бие даасан ном зохиол, бичигдээгүй төр, нам, цэргийн зүтгэлтнүүдийн талаар олон ном бүтээл нийтлэгдэн гарсныг энд тэмдэглэх хэрэгтэй. 1990-ээд оноос дээрх нөхцөл, шалтгааныг илүү тодруулах, тэдгээрийн нийгэм-улс төрийн үзэл санааны давуу болон сул талуудыг тодруулахыг зорих болсон нь ийнхүү төр, нийгмийн зүтгэлтэн түүхэн бие хүмүүсийн намтар судлал эрс идэвхжих суурь болсон гэж үзэж болно.

Манай оронд 1990-ээд оноос өмнөх үед түүх, философи, төр, эрх зүйн асуудал, зарим тохиолдолд монголын уран зохиол судлалаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажлын дотроос монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхээр хийгдсэн судалгаа, түүний үр дүнд гарсан ном зохиолууд өнөөгийн улс төрийн шинжлэх ухаанд шууд учир холбогдолтой, ихээхэн ач тустай байгааг онцлон тэмдэглэвэл зохино. Учир нь улс төрийн сэтгэлгээ, сургаалын түүх бол улс төрийн шинжлэх ухааны бүтцэд чухал байр суурь эзэлдэг, түүний үзэл санааны түүхийг бүрдүүлдэг онцлогтой. Тэр ч утгаараа 1990-ээд оноос өмнө монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхээр хийгдсэн судалгаа, ялангуяа академич Ч.Жүгдэрийн туурвисан цуврал суурь бүтээлүүд “*Улс төрийн боловсролын анхны мэдэгдэхүүн”* (Уб., 1972), түүнчлэн Д.Дашжамц, Б.Дүгэр *“Нийгэм улс төрийн товч толь”* (Уб., 1973), *“Улс төрийн мэдлэгийн үндэс”* (Уб., 1975), *“Улс төрийн лавлах”* (Уб., 1986) зэрэг эрдэмтдийн ном бүтээлүүдээс харагддаг. Улс төрийн аспетээр судалгаа боловсруулалтын хүрээн дотор улс төрийн ерөнхий мэдлэг бүрдүүлж бий болгох, түүнийг холбогдох сурах бичиг, гарын авлага, сэдэвчилсэн эмхэтгэл, толь бичиг, лавлах материал зэрэг хэлбэрээр эмхлэн системчилж их, дээд, тусгай, дунд болон техник-мэргэжлийн сургуулиудын оюутан, суралцагчид, нам, үйлдвэрчний болон залуучуудын эвлэлийн улс төрийн сургуульд зориулж нийтлэн гаргаж байсныг энд тэмдэглэх хэрэгтэй. Тухайн үед одоогийн улс төрийн шинжлэх ухааныг албан ёсоор

хүлээн зөвшөөрдөггүй, бие даасан тусгай шинжлэх ухаан гэж үздэггүй байсны улмаас түүний онолын мэдлэгийн тогтолцоог *"улс төрийн мэдлэг", "улс төрийн мэдлэгийн үндэс"* гэх зэргээр нэрлэн томъёолж марксист онол, сургаалын үндсэн дээр боловсруулж нийтэд судлуулан түгээдэг байсныг ийнхүү тухайлан онцлох учиртай.

Үүнээс үзэхүл, манай оронд 1920-иод оноос 1990-ээд он хүртэлх үед эрх баригч ганц нам буюу МАХН-ын үйл ажиллагааны онол-үзэл суртлын үндэс нь марксизм бөгөөд түүний ленинист хувилбар орших болсноор марксизм-ленинизмийн онол сургаалын гурван үндсэн бүрдэл хэсгийн нэг болох шинжлэх ухааны коммунизмын онол бат бөх оршин тогтносон нь тухайн үедээ марксизмын нийгэм-улс төрийн сургаал мөн хэмээн үзэж байв. Үүний хэтийн зорилгыг тодорхойлохдоо капитализмыг хувьсгалт ёсоор халж, түүний оронд социалист нийгэм, ирээдүйд коммунист нийгэм байгуулах зүй тогтол, арга замыг судлах явдал хэмээн тодорхойлжээ. Тиймээс ч Монгол оронд социалист нийгэм байгуулах зорилт тавигдаж улмаар түүнийг хэрэгжүүлэхийн төлөө тууштай тэмцэж байсан учраас шинжлэх ухаан коммунизмын онолыг их дээд сургуулиудад тусгай хичээл болгон зааж судлуулах зорилгоор МУИС-д Шинжлэх ухаан коммунизмын онолын тэнхимийг, ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнд Шинжлэх ухаан социализмын онолын секторыг 1978 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор тус тус байгуулан ажиллуулж ирсэн[17] түүхтэй. Үүний тод илрэл бол:




Энд дурдан буй аж төрөх ёсны судалгааны үр дүнд *"БНМАУ-д социалист аж төрөх ёс төлөвшин хөгжиж буй асуудал" (ШУА, ФСЭХ, Уб.,1982)* хамтын бүтээл хэвлэгдэн гарчээ. Эл бүтээлд нийгэм, бие хүний аж төрөх ёс, амьдралын хэв маягийг судлах онол, арга зүйн асуудал, Монгол оронд хүмүүсийн хуучин аж төрөх ёс өөрчлөгдөж шинэ шинжтэй болсон үйл явц, тус оронд шинэ аж төрөх ёсыг хэвшүүлж хөгжүүлэх, нийгэм, эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, соёл, ёс суртахуун, гоо зүйн асуудлуудыг тал бүрээр судлан боловсруулсан онол, арга зүйн хүрээнд авч үзэж, нэгтгэн дүгнэсэн байна. Гэсэн авч, эл бүтээлийг өнөөгийн өнцгөөс харвал шүүмжлэх асуудал багагүй байдаг. Тухайлбал, тухайн үзэгдлийг шинжлэх ухааны үүднээс үнэн бодитойгоор авч үзэхийг хичээсний сацуу тухайн цаг үеийн үзэл суртлын өнцгөөс хандсан хандлага, улс төрийн бодлого, нийгмийн бодит байдлыг үнэн зөвөөр боловсруулан гаргаж чадаагүй зэрэг дутагдал бий. Гэхдээ энэ бүтээл нь тухайн цаг үедээ хөндөгдөж байсан зорилт, амьдрал, түүнийг онол-арга зүйн зохих түвшинд авч үзсэн төдийгүй тухайн үеийнхээ нийгэм-улс төр, философи, социологийн сэтгэлгээний түүхийн онцлогийг бүрэн тусгаж чадсанаар судалгааны чухал баримт болсон ба одоог хүртэл үнэ цэнээ алдаагүй байна.

Бидний дараагийн дурдах бүтээл бол Монгол Улсад оршсоор ирсэн нийгэм, түүний нийгэм-улс төр, оюун санаа, бие хүн болоод түүний хүмүүжил, залуучуудын

*17 Чулуунбаатар Г., Дашжамц Д. Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн түүхийн хураангуй (1972-2000). ред. Пүрэв Ц. Уб., 2002, 62 дахь тал*

асуудлуудыг судлан боловсруулах нь шинжлэх ухаан-коммунизмын онолын нэг чухал чиглэл байв. Тухайлбал, Монгол Улс дахь бие хүний төлөвшлийн асуудал, хуучин нийгэм, өнгөрсний үлдэгдэл, өнөөгийн сөрөг, харш үзэгдэл, монголын залуучуудын нийгмийн идэвхийн асуудлаар онол-арга зүй, нийгэм, улс төр, социологийн, ёс зүйн аспеттэй, олон талтай судалгааг явуулсан. Үүний үр дүнд гарсан *“Өнгөрсний үлдэгдэл, өнөөгийн сөрөг үзэгдэл, түүнийг даван туулах асуудал” (ШУА, ФСЭХ, Уб.,1988)* хамтын бүтээлд социализм бол өмнөх капиталист, зарим оронд феодалын нийгмийг халсны үр дүн болж гарч ирэх шинэ нийгэм бөгөөд социализм өмнөх нийгмээс уламжлагдаж үлдэх өнгөрсний хуучирч хоцрогдсон олон янзын үзэгдэл, социализмын үед шинээр гарч ирэх олон янзын шинэ, сөрөг элдвийн харш үзэгдэл монголын нийгэмд нийтлэг буйг дурджээ. Цаашлаад өнгөрсний үлдэгдлийн гол илрэл бүхий үзэгдэл бол шашны мухар сүсэг, үндсэрхэх үзэл, хувийн өмчийн үзэл санаа, хоцрогдож хуучирсан, шинэ амьдрал, хөгжилд саад болж буй элдэв сөрөг үзэгдэл хэмээн үзсэн бол социализмын үед гарч буй элдэв сөрөг, хор холбогдолтой үзэгдлийн тоонд хүнд суртал, хэлбэрдэлт, хуурч мэхлэх явдал, шунахай хэрэглээ, хуучирсан сэтгэлгээ, арга барил, хариуцлагагүй, сахилгагүй байдал, хөдөлмөрийн бус орлого, архидан согтуурах, албан тушаал эрх мэдлийг хортойгоор ашиглах, хөрөнгөтний үзэл суртал, аж төрх ёсны гаж нөлөө түүнд автагдах явдал зэргийг багтаан үзжээ. Чингэвч, тухайн үеийн намын бодлого, үзэл суртал хийгээд нийгэм судлалд ноёрхож байсан ягшмал, догматик онол, өрөөсгөл арга зүй, судлаачдын болгоомжлол, бүтээлч бус хандлага, байр суурь, ухаалаг зоримог бус шийдэл тусгагдсан байдал ажиглагддаг.

XX зууны хориод оноос ерээд он хүртэлх хугацаанд Монгол оронд хийгдэж хэрэгжсэн нийгмийн олон талт өөрчлөлт, шинэчлэлийн бодит үр дүн, чухал ололтуудын нэг бол шинэ маягийн хүн бий болсон явдал мөн бөгөөд үүнийг үгүйсгэх аргагүй. Энэ талаар *“БНМАУ дахь социалист бие хүний төлөвшил хөгжлийн асуудал” (ШУА, ФСЭХ, Уб.,1988)* хамтын бүтээлд бие хүний судалгааны онол арга зүй, монголд шинэ бие хүн төлөвшсөн явц, бие хүний үзэл санаа-улс төрийн төлөвшил, хүмүүжил, мөн шинэ хүний хөдөлмөр, эдийн засгийн хүмүүжил, эх оронч ба интернациональч үзэл, ёс суртахуун, хамтач үзэл, сахилга хариуцлага, гоо сайхны үзэл, бие бялдрын хөгжил зэрэг шинэ бие хүний талаарх марксист ба бусад үзэл баримтлалын асуудлыг хөндсөн нь ихээхэн сонирхол татдаг. Энэхүү судалгааны үр дүнд *“Нийгмийн харилцааны төгөлдөржил ба бие хүн” (Д.Чулуунжав, Уб.,1980)* нэг сэдэвт бүтээл гарсан ба түүнд нийгэм, нийгмийн харилцаа ба бие хүний төлөвшил, хөгжил, хүмүүжил нь хоорондоо нягт холбоо хамааралтай болохыг тухайн үеийн монголын амьдралын жишээн дээр гаргаж тавьсан нь ихээхэн онцлогтой.

Энэ бүхнээс үзвэл, бидний өгүүлэн буй цаг үед шинжлэх ухааны коммунизмын онол, марксист-ленинист улс төрийн философи сэтгэлгээний онцлогийг тодорхой хүрээнд илэрхийлэх нь чухал. Шинжлэх ухааны уламжлалт бүтэц, зохион байгуулалтын бүрдэл нь үндсэндээ судалгаа, хамтын ажиллагааг хялбаршуулах, эсвэл санаатай болон санамсаргүй зорилтод чиглүүлэхэд оршино. Шинжлэх ухааны хоршсон хүрээ нь ямар нэгэн зугаа цэнгэл төдийхнөөр бус аливаад тууштай, бүтээлчээр хандаж гэмээ нь өөрийн мөрөн дээрх том саад бэрхшээлийг даван туулж чадна. Мэдээж хэрэг, агуу том амжилтыг бүтээн цогцлуулах боломжтой авч, юуны түрүүнд аливаад бүтээлчээр хандаж, хичээл зүтгэлтэй байсны эцэст түүнийхээ үр шимийг хүртэж чаддаг байх нь тэдний өөрсдийн оруулсан хувь нэмрээ дараагийн үеийн жирийн нэгэн дадлагажигчдад бэлэглэж чаддаг сэтгэлийн тэнхээтэй байхын тулд сэтгэл

зүйн хувьд бэлтгэлтэй[18] байх нь чухал зүйл. Учир нь бид бүхний өвөг дээдсээс өвлөн авсан шинжлэх ухааны уламжлал нь орчин цагийн практиктай хосолж байж гэмээ нь бидний хүсэж мөрөөддөг тэрхүү ардчилсан, шударга, хүмүүнлэг энэрэнгүй нийгмийн орчныг бүрдүүлж, улмаар нэг үзэл санаанд нэгтгэгдэн нэгэн цагт хүчирхэгжүүлэх боломжийг нээж өгөх нь цаг хугацааны асуудал мөн.

Тэр утгаараа манайд улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн үеийн эхэн үе бүхэлдээ *“марксист”* улс төрийн ухаан буюу шинжлэх ухааны коммунизмын онолын арга зүйд суурилж байв. Тухайн үед улс төрийн нэг нам, түүний удирдагчийн санаа бодлыг бүх талаар зөвтгөж дэмжихэд чиглэгдсэн *хэт намчирхаж хэлбэрдсэн, үзэл сурталжсан, бусдыг даган дуурайсан* судалгааны онол, арга зүй ноёрхсоор байв. Хэдий тийм боловч, энэ цаг үеийн улс төр судлаачид судалгааны тэрхүү хэлбэржсэн, намжсан онол, арга зүйн хүрээнд ч Монголын нийгмийн тухайн цаг үеийн тулгамдсан суурь асуудлыг олон талаас нь аль болохоор үнэн баримттай, бодитой судлан шинжлэхийг чармайж ирснийг үгүйсгэх боломжгүй. Энэ үйл хэрэгт тухайн үеийн ФСЭХ-ийн Шинжлэх ухааны социализмын онолын секторын эрдэмтэн судлаачид гол үүрэг гүйцэтгэсэн байдаг. Тэд тухайн цаг үеийн Монголын нийгмийн амьдралын улс төрийн тулгамдсан суурь асуудал болох социалист аж төрөх ёс, нийгмийн бүтэц, социалист бие хүний төлөвшил, залуучуудын хүмүүжил, сэтгэлгээ, нийгэм дэх сөрөг үзэгдэл, түүний хор уршиг, нийгмийн ухамсрын төлөвшлийн асуудлыг дагнан судалж, олон арван суурь бүтээлийг туурвин үлдээсэн байдаг. Тухайлбал, 1986-1990 онд монголын залуучуудын нийгэмшил, хүмүүжил, нийгмийн идэвхийн асуудлыг нийгэм-улс төрийн ба социологийн аспетээр судлан боловсруулах төлөвлөгөөт ажлыг тухайн үед үүсгэсэн нь өнөөг хүртэл шинэ сэтгэлгээ, онол, арга зүй, үзэл баримтлалын шинэ эрэл хайгуулын илрэл болсон. Энэ бол “*Монголын залуучуудын хүмүүжил, төлөвшил, нийгмийн идэвх” (Уб.,1991)*-ийн талаар өгүүлсэн эл судалгааны хамтын бүтээлийг шинэ цаг үеийн уур амьсгалын урьдчилан таамагласан, шинэлэг зоримог сэтгэлгээгээр урьд өмнө нэг их хөндөгддөггүй байсан хурц асуудлуудыг дэвшүүлж, нэлээд шүүмжлэлт байдлаар бичсэн нь цаг үеэ олсон бүтээл байв. Нөгөөтээгүүр, 1980-иад оны сүүлчээр өрнөсөн өөрчлөлт шинэчлэлийн давалгаанд Монголын нийгэм бүхэлдээ татагдан орж нэг талаас нийгмийн шинжлэх ухааны шинэлэг онол, чиглэлийн бүтээлч зоримог шүүмжлэлт сэтгэлгээ дээшилж хөгжихөд нөлөөлж буй хүчин зүйлс, нийгмийн шинэчлэлт нь нийгмийн ухааны өмнө цоо шинэ зорилт, хурц асуудлуудыг[19] дэвшүүлэн тавьснаараа онцлогтой. Энэ бол монгол оронд байгуулсан нийгэм чухам мөн чанараараа социалист нийгэм бус, ихээхэн гажуудсан, ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч, зах зээлийг боож хаасан тоталитар нийгэм байсан гэдгийг хүлээн зөвшөөрснөөр шинжлэх ухаан коммунизмын онол нийгэм дэх статусаа алдаж, улмаар түүний онол, арга зүй, танин мэдэхүй, судалгаа шинжилгээ нь хямралд орж, шинжлэх ухааны тавцангаас шахагдахад энэ мэтчилэн олон янзын нөхцөл байдал, хүчин зүйлс шалтгаалсан. Тухайлбал, тоталитар төр, эрх баригч нам байгууллага түүний догматик үзэл суртал, улс төрийн бодлогын хатуу хараа хяналтад орж, цаашлаад шинжлэх ухааны бүтээлч, шүүмжлэлт шинж чанар алдагдаж, үнэн хэрэгтээ бусармаг үзэл суртал болж хувирсанд түүний эмгэнэлт байдал оршино. Тиймээс өдгөө тэрхүү бүтээл туурвилын үр дүнг авах гээхийн ухаанаар шүүн тунгааж, алдсаныг нь засаж залруулан, оносныг нь бүтээлчээр авч ашиглах нь эрдэм судлалын ажлын залгамж чанарын шинэлэг үргэлжлэл, шинжлэх

*18 ФСЭХ., ШУА. “Философи эрхийн судлал- XXIII”. Эрдэм шинжилгээний цуврал. Уб., 2008. 300, 301 дэх талууд*

*19 Чулуунбаатар Г., Дашжамц Д. Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн түүхийн хураангуй (1972-2000). ред. Пүрэв Ц. Уб., 2002, 68 дахь тал*

ухааны ёс зүй, уламжлалын жам ёс мөн билээ.

Түүхэн баримтаас үзвэл, МАХН-ын XVII их хурал нийгмийн шинжлэх ухааны энэ цаг үеийн судалгааны чиглэл, агуулга, зорилтыг тодорхойлохдоо *“...манай орны байгалийн нөөц баялгийг хамгаалах, үр бүтээлтэй ашиглах, үйлдвэрлэх хүчийг хөгжүүлэх, социалист үйлдвэрлэлийн харилцааг боловсронгуй болгох, цаашлаад улс ардын аж ахуй, соёлын янз бүрийн салбарыг хөгжүүлэх гол зангилаа асуудлыг судлан шинжилж, боловсруулахад бүх анхаарал, эрдэм шинжилгээний хүчээ төвлөрүүлэх чухал зорилт тулгарч буйг дэвшүүлсэн байна. Мөн социалист байгуулалтын онол-практикийн нэн чухал асуудлуудыг гүнзгий судлах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, эдийн засгийг төлөвлөх, удирдах ажлыг улам боловсронгуй болгох, түүнчлэн шинжлэх ухаан-техникийн дэвшлийн ололтыг улс ардын аж ахуйд нэвтрүүлэх, хөдөлмөрчдийн ертөнцийг үзэх үзлийг төлөвшүүлэх. Зөвлөлт Холбоот Улс болон ах дүү социалист бусад орнуудтай бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг гүнзгий судлахыг манай шинжлэх ухааны ажилтан нараас нам хүлээж байна”*[20] гэж заажээ. Энэхүү заалттай уялдуулан олон арван судалгааны өгүүллүүдийг хэвлүүлсэн байдаг. Тэдний заримаас нь жишээ болгон ишлэхэд дараах сонирхолтой дүр зураг ажиглагдсан нь өнөөгийн судлаачдад онолын хийгээд практик ач холбогдол буйг харуулна. Тухайлбал, судлаач С.Ядам[21] *“...Социалист ардчилал бол хөдөлмөрчдөд нийгэм-улс төрийн эрх, чөлөөг хангаж, тэднийг үйлдвэрлэлийг удирдахад оролцуулах хамгийн үр ашигтай хэрэгсэл мөн. Иймээс үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийг улам бүр ардчилсан ёсоор хөтлөн зохион байгуулах үйлсэд үлэмжхэн хүчтэй хэрэгсэл болох социалист уралдааны асуудлыг судалж, түүнийг улам боловсронгуй болгох нь онол практикийн чухал ач холбогдолтой юм...”* хэмээн үзжээ. Харин судлаач Д.Чулуунжав[22] “*...үйлдвэрлэлийн удирдлагыг өөртөө багтаадаг төлөвлөгөөт зохион байгуулалт бол социалист үйлдвэрлэлийн харилцааны онцлог шинж юм. Социализмын үед үйлдвэрлэлийн процессын төлөвлөгөөт зохион байгуулалт нийгмийн үйлдвэрлэлийг бүхэлд нь хамарч, үйлдвэрлэлийг түүхэнд анх удаа нийт нийгмийн хэмжээнд, нийт нийгмийн эрх ашгийн үүднээс нэг төвөөс удирдах бололцоо олгодог”*[23] хэмээн өөрийн хэд хэдэн өгүүлэлдээ онцолсон байх жишээтэй. Тэгвэл профессор С.Норовсамбуу МАХН-ын XVIII их хурлын талаар “МАХН-ын XVIII их хурал ба социализмын онолын зарим асуудал”[24] эрдэм шинжилгээний өгүүлэлдээ *“...орчин үеийн шинжлэх ухаан, техникийн дэвшлийн ололтыг үндэс болгож социалист нийгмийн үйлдвэрлэх хүчнийг бүхий л талаар хөгжүүлэх, нийгмийн социалист харилцааг боловсронгуй болгох, социалист соёлыг түргэн хурдацтай өрнүүлэх, хөдөлмөрчдийг коммунист ёсоор хүмүүжүүлэх ажлыг хүчтэй болгох, улмаар ард түмний аж амьдралын байдал, соёлын хэмжээг цаашид дээшлүүлэх явдал мөн”* хэмээн социализм байгуулж дуусгах үеийн үндсэн агуулгыг тодорхойлох санааг дэвшүүлсэн нь үнэхээр сонирхол татахуйц дүр зураг байлаа.

**Энэ бүхнээс дүгнэвэл**, өгүүлэн буй үеийн эрдэмтэн судлаачид нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг нарийвчлан судалж, нэгтгэн дүгнэж, улмаар тус орны хөгжлийн

*20 Цэдэнбал Ю. Монгол Ардын Хувьсгалт Намын XVII их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл. Уб., 1976. 54-55 дахь тал*

*21 Ядам С. “Социалист уралдаан үйлдвэрлэл дэх ардчиллын хэлбэр болох нь”. Философи эрхийн судлал-II. ФСЭХ, ШУА. ШУА-ийн Хэвлэл. Уб., 1980. 145 дахь тал*

*22 Чулуунжав Д. “Социализмын үйлдвэрлэлийн харилцааны онцлогийн асуудалд”. Философи, эрхийн судлал-III. ФСЭХ, ШУА. ШУА-ийн Хэвлэл. Уб., 1980. 55 дахь тал*

*23 ФСЭХ, ШУА. Философи, эрхийн судлал-III. ШУА-ийн Хэвлэл. Уб., 1980. 60 дахь тал*

*24 ФСЭХ, ШУА. Философи, эрхийн судлал-IV. ШУА-ийн Хэвлэл. Уб., 1982*

онол, практикийн асуудлыг судлан боловсруулахад гол анхаарлаа хандуулж байсан нь илэрхий. Чингэхдээ БНМАУ-ын капиталист бус хөгжлийн зам болон социалист байгуулалтын онолын зарим асуудлыг судлах, нийгмийн социалист харилцааг хөгжүүлэн боловсронгуй болгох, хөдөлмөрчдийн коммунист хүмүүжил, социалист аж төрөх ёсыг хэвшүүлэн тогтоох онол, практикийн асуудлуудыг судлан боловсруулж байжээ. Нөгөө талаас, судалгааны ажлыг зохион байгуулахад судлаачдын эгнээг өргөтгөх, мэдлэг боловсрол, ур чадварыг нь дээшлүүлэх асуудал чухлаар тавигдсаар иржээ. Үүний тод жишээ бол, судлаачдын онол, арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар МАХН-ын XVII их хурлын нэгэн илтгэлд *"...эрдэм шинжилгээний ажлын онолын хэмжээ, эдийн засгийн өгөөжийг дээшлүүлэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийг нягт холбоотой болгох, эрдэм шинжилгээний боловсон хүчний бэлтгэлийг сайжруулах, тэдэнд үзэл суртал-улс төрийн хатуужил суулгах, байгаль болон нийгмийн үзэгдлийг задлан шинжлэхэд эрдэм шинжилгээний ажилтан нарыг марксист-ленинист аргаар зэвсэглэх явдал эрдэм шинжилгээний газрын удирдлага, тэдгээрийн дэргэдэх намын байгууллагын анхаарлын төвд ямагт байх ёстой"*[25] хэмээн тодорхой тусгасан байна. Энэ нь хэдийгээр марксист-ленинист үзэл суртлыг нийгэмд тулгаж байсан ч судалгаа шинжилгээний үр дүнг нийгэмд түгээж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарч байсны илрэл мөн.

Энэхүү үйл явцад тухайн үеийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын болон их сургуулийн энэ чиглэлийн судалгааг дагнан хийдэг судлаачид ч манлайлан оролцож, онол-практикийн чухал санал, санаачилгуудыг өрнүүлж байсан түүхийг мартах ёсгүй. Ийнхүү дурдсан өрнөлт нь угтаа хамгийн бага түвшинг маш өргөн хүрээнд хүртээж чадаж гэмээ нь туйлын хүсэл тэмүүллийг бий болгож түүнийг хувьсган өөрчлөх их оролдлого байв. Өөрөөр хэлбэл, *"энгийн үндэслэл"*-ээс нийтлэг хэлцлийг нэмэгдүүлснээр улс төрийн шинжлэх ухааны мэргэжил дэх *"мэргэжлийн хамгийн энгийн чадвар"*-аар тодорхойлогддог онцлог гэж болно. Тиймээс, улс төрийн шинжлэх ухаанд эрүүлжих явдал хамгаас чухал байдаг бөгөөд түүнийгээ өөрийн хүрээний дэд онцлог шинж бүрд хамруулж, цаашлаад дотоод давуу талаа ашиглан улс төрийн фракцын гишүүн бүртэй ойлголцож, тэдэнд тодорхой хэмжээнд хариуцлага тооцон ажиллах нэн чухал. Тэрхүү *"эрүүлжүүлэх"* амин дэм нь их өргөн утгатай, хоорондоо харилцан холбоотой дэд онцлогуудаас бүрдсэн утгын нарийн шүтэлцээ бүхий том цогц зүйл байх учиртай.

Ийнхүү 1990-ээд оноос өмнө хийгдэж байсан улс төрийн түүхийн судалгааны хүрээнд түүхэн бие хүмүүсийн намтар судлал нь түүний нэгэн чиглэл болон тавигдаж түүгээр XX зууны эхэн үе, ялангуяа 1921 оны ардын хувьсгал ба түүний дараах нийгмийн хувьсгалт өөрчлөлтийн үйл хэрэгт хүчин зүтгэж байсан монголын төр, нам, цэргийн томоохон зүтгэлтэн бүхий түүхэн бие хүмүүс, нэг ёсны лидерүүдийн амьдрал, нийгэм-улс төр, цэргийн үйл ажиллагааг судлан илэрхийлэгдэж байв. Түүнчлэн 1990-ээд оноос өмнөх үед түүх, философи, төр, эрх зүйн асуудал, зарим тохиолдолд монголын уран зохиол судлалаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажлын дотроос монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхээр хийгдсэн судалгаа, түүний үр дүнд гарсан ном бүтээлүүд өнөөгийн улс төрийн шинжлэх ухаанд шууд учир холбогдолтой, ихээхэн ач тустай байгааг онцлон тэмдэглэвэл зүйтэй. Учир ахул, улс төрийн сэтгэлгээ, сургаалын түүх бол улс төрийн шинжлэх ухааны бүтцэд чухал байр суурь эзэлдэг, түүний үзэл санааны түүхийг бүрдүүлдэгээрээ онцлогтой.

---

*25 Цэдэнбал Ю. Монгол Ардын Хувьсгалт Намын XVII их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл. Уб., 1976. 55 дахь тал*

Нөгөө талаар, 1990-ээд он хүртэлх үед манайд хийгдэж байсан улс төрийн аспектээр судалгаа боловсруулалтын хүрээн дотор улс төрийн ерөнхий мэдлэг бүрдүүлж бий болгох, түүнийг холбогдох сурах бичиг, гарын авлага, сэдэвчилсэн эмхэтгэл, толь бичиг, лавлах материал зэрэг хэлбэрээр эмхлэн системчилж их, дээд, тусгай, дунд болон техник-мэргэжлийн сургуулиудын оюутан, суралцагчид, нам, үйлдвэрчний болон залуучуудын эвлэлийн улс төрийн сургуульд зориулан нийтэлж, хэвлэн гаргаж байсныг энд дурдвал зохино.

Эцэст нь хэлэхэд, XX зууны 20-иос 90-ээд оны эхэн үед төр, нам, улс төрийн бусад үзэгдэл, үйл явдлын асуудлаар хийгдсэн улс төрийн судалгаа, түүний үр дүнд нийтлэгдсэн ном зохиол, бусад бүтээл, хуримтлагдсан туршлага, баримт материал, мэдээллийн бааз, дурдсан чиглэлээр судалгаа хийж, мөн их, дээд сургуульд хичээл зааж бэлтгэгдсэн эрдэмтэн судлаачид багагүй хүч нөөцийг бүрдүүлж байсныг үгүйсгэх аргагүй. Чухамхүү эл оюуны хүч нөөц нь 1990-ээд оноос манай оронд орчин цагийн улс төрийн шинжлэх ухааны үндэс суурь тавигдаж, цааш төлөвших хөгжих эхлэл, суурь хөрс нь болоход чухал хувь нэмэр оруулсныг онцлох хэрэгтэй. Нэг үгээр хэлбэл, Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжлийн тухай яриа нэлээд эртнээс яригдах учиртай[26] бөгөөд манай оронд улс төрийн шинжлэх ухаан огт хоосон газар гэнэт бий болсон биш гэдгийг энд зориуд тэмдэглэхийг бид зорив. Нөгөөтээгүүр, эл шинжлэх ухаан өөрийн онол, арга зүй, зарчим, бүтэц, зохион байгуулалт, судалгааны арга техникээрээ бие даасан шинжлэх ухаан болохын хувьд бидэнд шинэ зүйл байсныг мартах учиргүй. Өөрөөр хэлбэл 1990-ээд оноос өмнөх улс төрийн судалгаа нь онол-танин мэдэхүй, нийтлэгдсэн ном зохиол, мэдээллийн бааз, багтаамжийн хувьд хэдийгээр чухал ач холбогдолтой, үнэ цэнтэй ч гэсэн өөрийн мөн чанар, шинжлэх ухааны статусаараа өрнийн орнуудад хөгжиж ирсэн улс төрийн шинжлэх ухаантай ижил төстэй биш, зарчмын чанартай олон зүйл бүхий үзүүлэлтүүдээрээ ялгаатай өөр судалгаа байв. Тиймээс ч түүнийг тогтолцоогоор нь халж, өөрчлөх, чингэхдээ өмнөх үеийнхний өвлүүлэн үлдээсэн үндэсний онцлог бүхий үнэ цэнтэй ололт, амжилт, нөөц хүчийг нь зүй зохистой хадгалах, өөрчлөх, ашиглах замаар өрнийн нэгэнт тогтож төлөвшсөн улс төрийн шинжлэх ухааныг шинээр нутагшуулан цогцлоох, төлөвшүүлэн хөгжүүлэх чухал бөгөөд бэрхшээлтэй зорилт зайлшгүй тавигдсан билээ. Энэ талаар дараагийн хэсэгт тухайлан авч үзэх болно.

[26] *Ганболд Ц. Монголын их дээд сургуулиудад улс төр судлалын хичээлийг зааж буй байдал. Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны өнөөгийн түвшин. ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. ред. Ганбат Д. Улс төрийн шинжлэх ухааны холбоо. "Бэмби сан" ХХК. Уб., 2006, 42 дахь тал*

**Ном зүй**


1. Ганболд, Ц. (2006). Монголын их дээд сургуулиудад улс төр судлалын хичээлийг заах буй байдал. Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны өнөөгийн түвшин. ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. ред.Ганбат Д. УШУХ. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
2. Дашжамц, Д. (1970). Монгол дахь дэвшил ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд (XIX-XX зууны зааг). ШУАХ. Улаанбаатар, Монгол Улс
3. Дашдаваа, Ч. (2003; 2019). Улаан түүх (Коминтерн ба Монгол). II хэвлэл. ред. Бат-Очир, Л. Түүхийн хүрээлэн,, ШУА., СУИС, Улаанбаатар-Эрдэм судлал дээд сургууль. . “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
4. Жүгдэр, Ч. (1987). Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ (Эртнээс XIY зуун хүртэл). Улаанбаатар, Монгол Улс
5. Жүгдэр, Ч. (1972). XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. ШУАХ. Улаанбаатар, Монгол Улс
6. Жүгдэр, Ч. (1984). XV-XVIII зууны монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. Улаанбаатар, Монгол Улс
7. Жүгдэр, Ч. (2008). Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. ФСЭХ, ШУА. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
8. Нацагдорж, Ш. (1966). То ван ба түүний сургаал. ШУА-ийн мэдээ сэтгүүл. ШУАХ. Улаанбаатар, Монгол Улс
9. ФСЭХ., ШУА, (1980). “Философи, эрхийн судлал-III”. ШУА-ийн Хэвлэл. Улаанбаатар, Монгол Улс
10. ФСЭХ., ШУА, (1982). “Философи, эрхийн судлал-IV”. ШУА-ийн Хэвлэл. Улаанбаатар, Монгол Улс
11. ФСЭХ., ШУА, (2006). XIII-XIV зууны Монголын улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Хамтын бүтээл. ред. Жамбал А. Улаанбаатар, Монгол Улс
12. ФСЭХ., ШУА, (2008). “Философи эрхийн судлал- XXIII”. Эрдэм шинжилгээний цуврал. Улаанбаатар, Монгол Улс
13. Цогтсайхан, Д. (2015). Монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний зарим асуудал. Бүтээлийн эмхэтгэл. Эмх. Жаргал Ц., Гэрэл Ц. Улаанбаатар, Монгол Улс
14. Цэдэнбал, Ю. (1976). Монгол Ардын Хувьсгалт Намын XVII их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэл. Улаанбаатар, Монгол Улс
15. Чулуунбаатар, Г., Дашжамц Д. (2020). Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн түүхийн хураангуй (1972-2000). ред. Пүрэв Ц. Улаанбаатар, Монгол Улс
16. Чулуунжав, Д. (1980). Социализмын үйлдвэрлэлийн харилцааны онцлогийн асуудалд. “Философи, эрхийн судлал-III”. ФСЭХ, ШУА. ШУА-ийн Хэвлэл. Улаанбаатар, Монгол Улс
17. Ядам, С. (1980). Социалист уралдаан үйлдвэрлэл дэх ардчиллын хэлбэр болох нь. “Философи эрхийн судлал-II”. ФСЭХ, ШУА. ШУА-ийн Хэвлэл. Улаанбаатар, Монгол Улс

# УЛС ТӨР СУДЛАЛЫН САЛБАРТ 1990-ЭЭД ОНООС ХОЙШ ХЭРЭГЖСЭН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ, АРГА ЗҮЙ БА ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ *

*(төгсгөл хэсэг)*

О.Хатанболд, *доктор (PhD)*
А.Хишигдаваа, *докторант*
*ШУА-ийн Философийн хүрээлэнгийн*
*Улс төр, эрх зүйн салбар*

*Бидний толилуулан буй энэхүү тойм өгүүлэлд Монгол Улс дахь улс төрийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний онол, арга зүйн төлөв байдлыг 1990 оноос өмнөх ба хойш хэмээн хоёр үндсэн хэсэгт хуваан үзсэн нь тодорхой шалтгаантай. Учир нь Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны хөгжил хийгээд судалгааны өнөөгийн байдал, цаашдын хандлагыг тодруулахад судалгаа, шинжилгээний онол, арга, зүй, төлөв байдлыг нэгтгэн дүгнэж, тоймлох хэрэгтэй болно. Өгүүллийн тэргүүн хэсэгт Монголчуудын улс төрийн сэтгэлгээ, түүний мөн чанарын талаар, мөн Монгол Улс дахь улс төрийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний онол, арга зүйн төлөв байдлыг 1990 оноос өмнөх үеийн буюу шинжлэх ухааны коммунизмын онол болон марксист-ленинист сургаалын үе (1972-1990)-ээр хуваан тусгайлан шинжилсэн хэсгээ багтаасан. Харин энэхүү төгсгөл хэсэгтээ улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд тулгарч байсан шинэ сорилт хийгээд шинэ онол, арга зүйг эрэлхийлсэн шилжилтийн үе (1990-2000)-ийг, мөн улс төрийн шинжлэх ухааны шинэ төлөвшилт (2000-2010) болон улс төрийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний өнөөгийн байдал, цаашдын хандлага (2010 оноос хойш) зэргийг дараах байдлаар тодруулахаар бэлтгэсэн болно.*

*There is a good reason why this review article divides the political science research, analysis theory and methodological situation in Mongolia into two main parts: pre-1990 and post-1990. This is because in order to clarify the current state and future trends of political science development and research in Mongolia, it is necessary to review research theory, methods, methods and attitudes. In the first part of the article we dealt with the political thinking of Mongolians and its nature, as well as the theory and methodology of political science research in Mongolia before the 1990s, the theory of scientific communism and the Marxist-Leninist period (1972-1990. And in this final section, we will look at the new challenges facing the development of political science and the transition period (1990-2000) in search of new theories and methods, as well as the new development of political science (2000-2010) and political science research and development. The current situation and future trends (since 2010) are prepared as follows.*

* *Эл эрдэм шинжилгээний өгүүллийг ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөний 2.2-т тусгагдсан "1990-ээд оноос хойш Монголын нийгэмд гарсан хувиралт өөрчлөлтийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, тохиолдож буй бэрхшээл сорил, тулгамдаж буй асуудлуудын гарц шийдлийн зохист хувилбарыг санал болгох" ажлын хүрээнд бэлтгэн боловсруулав.*

### *Нэг. Шинэ онол, арга зүйг эрэлхийлэхүй буюу шилжилтийн үе (1990-2000)*

Зөвлөлт холбоот Улс (ЗХУ) задарч, дэлхийн социалист систем нуран унасан энэ үед АНУ дэлхийн бусад улс орнуудад ардчиллын итгэлийг өрнүүлэх бүхэл бүтэн кампанит ажил зохион байгуулж, улмаар ардчиллын төлөөх үндэсний хандивын сан хэмээхийг үүсгэн байгуулж, түүнийгээ үлэмж ихээр санхүүжүүлж *"ардчиллыг түгээн дэлгэрүүлэх"*-д дэмжлэг үзүүлсэн нь дэлхий дахины, бүс нутгийн хэмжээнд ардчиллын хөгжүүлэхэд хүчтэй нөлөөлсөн гэж болно. Эл бодлогын агуулгыг 1990-ээд оны эхээр АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш, түүний засаг захиргаа, тухайлбал, Төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бэйкер *"Бидний шинэ үүрэг, зорилго бол ардчиллыг хөхиүлэн дэмжих явдал"* хэмээн тодорхойлсон бол, 1992 онд Билл Клинтоны[1] засаг захиргаа ч мөн адил өөрийн бодлого, үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлийг ардчиллыг дэмжих явдал болохыг тунхаглаж, түүнээс хойш үндсэндээ одоогийн Ерөнхийлөгч Д.Трамп хүртэл үе үеийн ерөнхийлөгчид тууштай хэрэгжүүлсээр ирлээ. Хүйтэн дайны дараах ертөнцөд ардчиллыг түгээн дэлгэрүүлэх гэсэн бодлогын үр дүн олон орны ард түмний хувьд хүсэл зоригийг нь мохооход хүргэсэн юм. Учир нь ардчиллын замыг сонгосон улс орнуудад өрнөдийн хамтрагчдаас *"нөхөрсөг дарангуйлагчид"* -ийн асуудалтай тулгарах болсон нь нөхөрсөг дарангуйлагч эсвэл нөхөрсөг бус ардчиллын хооронд сонголт хийхийн төвөгтэйг бидэнд харуулсан хэдий ч дэлхий дахинд либерал ардчилал ялсан. Тэрхүү ялалт нь бидний ирээдүй үзэл бодлын хурц тэмцлийн явцад гарч ирсэн төдийгүй эдийн засгийн болон техникийн асуудлуудыг энхийн аргаар шийдэхэд эл хичээл зүтгэл зориулагдсан хэмээн судлаач Фрэнсис Фукуяама[2] дүгнэжээ.

Энэ агуулгаар бол, аливаа жижиг улс орны хөгжлийн хэтийн төлөвт дотоод хүчин зүйлээсээ гадаад хүчин зүйл илүү нөлөөтэй тусдагийг 1990-ээд оны Монголд болсон ардчилсан үйл явц харуулсан[3] хэмээн түүхчид дүгнэсэн байдаг. Үнэндээ, Монгол Улс дэлхийн хөгжлийн нийтлэг хандлагаас улам бүр хоцорч, Зөвлөлт гүрний улс төр, эдийн засгийн стратегийн хүчтэй нөлөөнд орсон хэвээр байсан[4] нь манай орны нийгэм, улс төр, эдийн засагт болж өнгөрсөн шинэтгэл, өрнөл, буурaлт нь үргэлж гадаад талаасаа шалтгаалж байсантай ч шууд холбоотой. Нөгөө талаар, тухайн үед хоёр Герман нэгдэж, дэлхийн социалист систем задран унасан нь манай оронд улс төр, нийгэм, эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт хийх гадаад үндэс суурь нь болсон. Үүнээс үзвэл, аливаа зайлшгүй өөрчлөлт, шинэтгэлийг өдөөгч нь цаг хугацааны болон учир шалтгааны хувьд өөр өөр байдгийг харуулж буй нь энэ. Жишээлбэл, Монгол Улсад социализм байгуулах асуудал 1980-аад оны төгсгөл рүү улам ээдрээтэй болж, улмаар социализмын материал-техникийн бааз байгуулах үйл явц мухардалд орсон юм. Учир нь 1989 оны сүүл үеэс улс орны өмнө хэд хэдэн чухал асуудал тулгарч, нийгэм эдийн засгийн байдал хүндэрсэн нь нэг талаас тус улсын төсвийн 80 орчим хувийг санхүүжүүлдэг хуучин ЗХУ эл санхүүжилтээ 1990 онд бүрэн зогсоосон явдал байв. Энэхүү бэрхшээл хүндрэлийг гэтлэх асуудал тухайн үед шинээр байгуулагдсан Ардын их хурал (АИХ), Улсын бага хурал (УБХ), засгийн газрын өмнө тулгарсан бөгөөд монголчуудын хувьд ардчиллын төлөөх олон түмний дэмжлэгийн хүчээр эрх чөлөө, тусгаар тогтнолоо эмзэг хэврэгхэн[5] байдлаас

1 *Хантингтон С. Иргэншил хоорондын мөргөлдөөн, шинэчлэгдэж буй дэлхийн дэг журам. орч. Баярхүү Д. ННФ. "Адмон принт" ХХК. Уб., 2005, 11, 208-209 дэх тал*

2 *Francis Fukuyama. The March of Equality. Journal of Democracy, Volume 11, #1, 2000, p.13*

3 *Монгол Улсын түүх. V боть. Уб., 2003, 401 дэх тал*

4 *Монгол Улсын түүх. V боть. Уб., 2003, 403 дэх тал*

5 *Билэгсайхан С. Шинэтгэл, Шинэ Монгол. "Соёмбо принтинг" ХХК. Уб., 2012, 101 дэх тал*

гаргаж чадсан нь түүхэн үйл явдал юм. 1990 оны эхээр улс оронд өөрчлөлт, шинэчлэлийн хөдөлгөөн өрнөж, улс төрийн олон нам байгуулагдаж, МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, улмаар 1992 оны 1 дүгээр сард Монгол Улсын "шинэ" Үндсэн хуулийг баталж, хүний эрх, эрх чөлөөг хангах, улс төрийн олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрөх, зах зээлийн эдийн засагт шилжих, түүний дотор хувийн өмч, өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрөх зэргийг баталгаажуулсан юм. Нөгөөтээгүүр, 1921-1990 оныг хүртэл Монголын ард түмний бүтээж, байгуулж ирсэн гэгдэх нийгэм-төрийн тогтолцоо нь Монгол орныг асар богино хугацаанд хөгжлийн социалист, коммунист зам дээр капитализмыг алгасуулан гаргах гэсэн волюнтарист туршилтын үр дүн буюу ташаа онол, гуйвуулга, төөрөгдлийн биелэл мөн болохынхоо хувьд удаан амьдрах чадваргүй, жам ёсны бус, хиймэл зүйл байсны[6] илрэл байв. Үүнийг бид нэгийг бодож, хоёрыг тунгаан, авах гээхийн ухаанаар хандах нь эрдэм шинжилгээ, судалгааны аналитик шинжийг үлэмж нэмэгдүүлэх шаардлага цаг хугацаа улиран өнгөрөх тусам тодрон харагдаж байна.

Ийнхүү, нийгмийн сэтгэхүйд асар том өөрчлөлт гарах боломжийг 1989-1990 оны заагаас Монгол Улсад өрнөсөн ардчилал олгож, улмаар ардчилсан шинэ үндсэн хуулиа бүх ард түмнээр хэлэлцэн баталж, улс орныхоо тусгаар тогтнолыг гагцхүү ард түмэн, хувь хүний үзэл бодлын эрх чөлөөт байдлаас юуны түрүүнд хамаарч, баталгаажихыг энд дурдан буй үеэс л ухамсарлах боломжтой болсон гэж хэлж болно. Нэг үгээр, ардчилал бол ард түмний амьдрал дунд нийгмийн харилцаанаас өөрөөс нь төрж, бас хөгжиж эсвэл хязгаарлагдаж байдаг өргөн олон түмнийг хамарсан үзэгдэл бөгөөд чухамдаа хамтын үйл хэрэг хийгээд хамтын бүтээл байдаг болохоор түүнийг хэн нэгэн, тэр тусмаа ямар нэг улс төрийн хүчин өмчилж болдог эд бараа биш. Түүний зохиогч нь гагцхүү ард түмэн л байдаг учраас түүний зохиогчийн эрхийг хэн ч булааж авах учиргүй. Үүнээс үзэхүл, бидний мэдэх улс төрийн хүчин бол ардчилал хөгжихөд ард түмэнд тусалдаг үйлчлэгч, зарц мөн бөгөөд үйлчлэгчээ солих ч эрхтэй. Учир нь хувь хүн бол гэр бүл, нийгмийн бүлгийн амьдрах арга, орчин, хэрэгцээгээр нөхцөлдөн бий болж, нийгмийн амьдралын түвшинд нийгмийн бүлгүүдийн ялгаатай, зарим талаараа зөрчилтэй ашиг сонирхол нь тэдгээрийг хөдөлгөгч хүчин зүйл болох боломжтой гэсэн үг.

Яг энэ утга агуулгаар бол, монголчуудын язгуур аж төрөхүй нь нүүдэлчний аж төрөхүйгээс үүдэлтэй учраас нүүдлийн амьдрал нь биднийг нутаг усаа шинжих, байгаль эхээ шүтэх, угсаа гарлаа дээдлэх зэрэгтэй нөхцөлдүүлэн холбож буй. Тиймээс монголчуудын хувьд насан туршдаа хэрэн тэнэж, тохиолдлын орлогоор амь зууж явдаг овог аймгуудын амьдралаас огт өөр, нүүдлийн иргэншлийн сонгодог хэлбэрийг бүрдүүлэн оршсоор ирсэн нь бусдаас онцлог юм. Энэ мэтчилэн түүхийн он цагаас эхлүүлээд монголын нүүдлийн уламжлалт соёл нь өнөөгийн монголчуудын оршихуйд тулгамдаж буй олон саад бэрхшээлийг даван туулахад бидний нэрлэж заншсан *"1990 оны ардчилсан хувьсгал"* чухал үүрэгтэй. Тэрхүү ардчилсан хувьсгалаар сталинист маягийн социалист нийгэм, түүний улс төрийн хатуу хяналт нуран унаж, нийгэм бүхэлдээ чөлөөтэй болж эхэлсэн нь энэхүү түүхэн том эргэлтийн үр дүнд социалист нийгэм төдийгүй социалист онол сургаалд ч том цохилт[7] болсон. Энэхүү ардчилсан хувьсгалын үр дүнд монголын нийгмийн оюуны санааны амьдрал

*6 Чулуунжав Д. Монголын нийгмийн өвөрмөц байдалд тохирох төрийн засаглалын зохистой хэлбэр, хэмжээ, бүтэц, үүргийн асуудалд. ред. Чулуунбаатар Г. "Бэмби сан" ХХК. Уб., 2004, 92 дахь тал*

*7 Чулуунбаатар Г., Дашжамц Д. Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн түүхийн хураангуй (1972-2000). ред. Пүрэв Ц. Уб., 2002, 68 дахь тал*

чөлөөлөгдөж олон эшт үзэл санаа бүрэлдэн тогтох үндэс болсон. Цаашлаад, хуучин шинжлэх ухааны социализмын онолын эдэлж байсан байр суурь болоод түүний социологи, нийгмийн философи, улс төрийн шинжлэх ухааны үүргийг хамтатгаж үзэл сурталжсан байдлаар гүйцэтгэж ирсэн үүргийн орон зайг нөхөх хэрэгцээ, шаардлага нэгэнт бий болов.

Учир ахул, улс төрийн шинжлэх ухаан барууны орнуудад аль XIX зууны сүүл үеэс хөгжиж ирсэн, мэдлэг ухааны салбар бөгөөд манай оронд, цаашлаад нийт социалист орнуудад бие даасан статустай шинжлэх ухаан болон төлөвшин тогтох гол үндэс болсон юм. Энэ бол монголын нийгмийн эрс өөрчлөлт шинэчлэлт, оюун санаа тэр дотор нийгмийн шинжлэх ухааны эрх чөлөөг хангах болсноор 1990 оноос хойших шинэ нөхцөлд улс төрийн шинжлэх ухааныг албан ёсоор хүлээн зөвшөөрч түүнийг 1992 оноос эхлэн их дээд сургуулиудад тухайлбал, МУИС-д анх удаа улс төр судлалын шинэ ангийг нээн, улмаар ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнд Шинжлэх ухаан социализмын онолын секторыг татан буулгаж, түүний оронд Улс төр судлалын салбарыг 1995 онд бий болгон өргөжүүлж монголын нийгмийн улс төрийн тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлт, улс төрийн шинэ тогтолцооны үеийн сонгуулийн системийн төлөвшил, онцлогийг[8] судлах эхлэлийг тавьсан юм.

1990-ээд оноос эхлэн Монгол орон улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт нэгэн зэрэг шинэчлэл явуулж, бүс нутагтаа ардчилсан хөгжлийн загварыг харьцангуй тогтвортой, тайван замаар хөгжүүлж буй улс бөгөөд улс төр, эдийн засгийн шинэтгэлийг ядуу буурай оронд нэгэн зэрэг хийсэн нь, Азийн орны явах зам биш хэмээх ойлголтыг эвдэж чадсан билээ. Монгол оронд өрнөсөн ардчиллын үйл явцаар манай нийгэмд улс төрийн үзэл бодол, иргэний ашиг сонирхол, улс орноо хөгжүүлэхэд оролцох арга хэлбэр зэргээрээ ялгаа бүхий нийгмийн бүлгүүд үүсэн бий болсноороо монголчууд өөрсдийн үзэл баримтлал, итгэл үнэмшлээ дагасан улс төрийн үйл ажиллагаа явуулах, олон намын тогтолцоо цоо шинээр бүрэлдэн тогтох чухал үйл явцын эхлэлийг тавьсан юм. Энэ үйл явцын тусгал болж түүнтэй нягт холбоотойгоор монголын нийгмийн улс төрийн амьдралд олон ургальч ардчиллын хэлбэр хөгжиж, ардчилсан үйл явцын өрнөл, нийгмийн улс төрийн амьдралын шинэчлэл, өөрчлөлтийн агуулгыг тодорхойлох[9] болсон. Энэ утгаараа, Монгол орон ардчилсан өөрчлөлтийн замаар замнаж эхэлсэн ерээд оны үеэс тус оронд орчин үеийн улс төрийн шинжлэх ухаан хөгжих суурь үндэс тавигдсан гэж хэлж болно. Гэхдээ улс төрийн орчин үеийн онол, шинжлэл хөгжин жигдрэх үйл явц амаргүй төвөгтэй байсны дээр онол, арга зүйн болон мэргэжилтэй боловсон хүчин, судалгааны ажлын шинэ арга чадамж, боломжийн хувьд хүрэлцээгүй зэрэг олон бодит бэрхшээл, сорилт бидэнд тулгарсан хэвээр байгаа билээ.

Дээр нэгэнтээ дурдсанчлан 1980-аад оны дунд үеэс эхэлсэн социалист нийгмийн зогсонги байдал нь тухайн үеийн социалист орнуудын хөгжлийн чиг хандлагад огцом өөрчлөлтийг бий болгоод зогсохгүй өөрчлөн байгуулалт хийх гадаад хүчин зүйл нэгэнт буй болсныг харуулсан юм. Учир нь социалист системийн гол цөм болж байсан ЗХУ өөрчлөн байгуулалтыг хэрэгжүүлж эхэлсэн явдал нь бусад социалист орнуудад таатай боломжийг олгож, улмаар социалист системийг богино хугацаанд задран унахад хүргэсэн. Энэ бол социализм мухардалд орж, түүнийг өөрчлөх уур амьсгал нийгэмд бий болсноор *“нийгмийн тогтолцоог боловсронгуй болгож өөрчлөх,*

8 *Чулуунбаатар Г., Дашжамц Д. Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн түүхийн хураангуй (1972-2000). ред. Пүрэв Ц. Уб., 2002, 69-70 дахь тал*

9 *Хатанболд О. Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр. ред. Чулуубаатар Г., Ганбат Д., Цэцэнбилэг Ц. “Соёмбо принтинг” ХХК. Уб., 2017, 6 дахь тал*

*ардчилал, ил тод байдлыг дэлгэрүүлэн хөгжүүлэх, үзэл бодлын чөлөөт байдлыг хязгаарлан хумих байдлыг халах зэрэг үзэл санааг далд, болгоомжтой байдлаар хөндсөн нийтлэлүүд төвийн сонин хэвлэлүүдэд гарах болжээ. Энэ байдал олон нийтийн санаа бодол, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж, нийгэмд бүтээлч сэтгэлгээ, өөрчлөлт шинэчлэлийн үзэл санаа, уур амьсгал идэвхтэй сэргэж”*[10] эхэлсэн нь ийнхүү өөрчлөлт, шинэчлэлийг эхлүүлэх дотоод хүчин зүйл болжээ. Улмаар 1989 оны эцсээр олон хүний нүдэнд харагдахуйц газруудад тухайн үеийн төр засгийн бодлого шийдвэрийг шүүмжилсэн өнгө аяс бүхий ухуулах хуудас наах, эрх чөлөө, шударга ёсны төлөө тэмцэх цаг болсныг сануулах, өөрчлөлт, шинэчлэлтийг хийх уриалга үлэмж нэмэгджээ. Үүний цаана үйл ажиллагаагаа далд хэлбэрээр зохион байгуулдаг улс төрийн бүлэглэлүүд бий болж, улмаар хүрээгээ өргөтгөн тэлж, олон жилийн турш оршин тогтносон захиргаадалт, хүнд суртлын тоталитар дэглэмийн эсрэг олон түмний тэмцлийг зохион байгуулалтын хэлбэрт оруулан хошуучлах зорилго бүхий улс төрийн эвсэл холбоод дуу дуугаа аван байгуулагдсан түүхтэй. Өөрөөр хэлбэл, үндэстэн нийтээр үл тэвчихийн гол утга, зорилго бол монголын нийгмийн зогсонги, мухардмал байдалд оруулсан улс төрийн тоталитар тогтолцоо, эдийн засгийн төвлөрсөн төлөвлөгөөт байгууллыг нэн даруй өөрчлөх замаар нийгмийн амьдралын бүх талын хямрал, уналтаас чадвал сэргийлж, тойрч өнгөрөх, эс чадвал түүнийг ядаж хохирол багатай туулж гарахад бэлтгэх явдал[11] нэн тэргүүнд тавигдах болсон нь энэ байв. Энэ нь Монгол Улсад улс төрийн шинэ намууд үүсэн байгуулагдах улс төр, нийгмийн үндсэн бааз суурийг бүрдүүлсэн төдийгүй *“Улс төрийн намууд үүсэн бүрэлдэхэд олон түмний улс төрийн идэвх, оролцооны шинж чанарт гарсан өөрчлөлт, шинээр байгуулагдсан эвсэл холбоодын үйл ажиллагааны цаашдын өрнөлт, түүнээс үүдэн гарсан улс төрийн шаардлага, түүнд хандах эрх баригчдын байр суурь, хандлага, төлөв байдал үүнийг идэвхжүүлэхэд”*[12]нөлөө үзүүлсэн явдал байлаа.

Энэ нь ардчиллын эхэн үед нэг талаас олон арван жилийн турш судалгааны суурь үндэс болгон дагаж мөрдөж асан марксист арга зүй, тэр дундаа марксист улс төрийн онол, арга зүйн тогтолцоо бүхэлдээ цаг үеийн нөхцөл байдалтай илтэд зөрчилдөн, үгүйсгэгдэх болсон нь нэг талаасаа, ардчиллын сонгодог үзэл санаа түүний нийгмийн сэтгэлгээнд нэвтрэн нэвчиж, улмаар лавшран хэрэгжих үйл явц удаан байсан зэрэг нь тус орны нийгмийн шинжлэх ухааны салбарт *“хоосон орон зай”* бий болоход хүргэсэн байна. Ийм нөхцөлд Монгол дахь ардчилсан өөрчлөлтийн хүрээний шинэлэг үзэгдэл, үйл явцыг бодитой судлан шинжлэх үйл ажиллагаанд хүндрэл учирч байсан нь илт. Үүнийг судлаач Д.Дашцэдэн гярхайгаар олж харан *“... намаас дэвшүүлсэн зорилтын дагуу цаашид ардчиллыг өргөн хүрээтэй хөгжүүлэн боловсронгуй болгох асуудлыг философи, хууль зүйн шинжлэх ухааны үүднээс нэгтгэн дүгнэж, баяжуулан хөгжүүлэх, зарим чухал асуудлыг онол, практикийн хувьд дахин боловсруулж, шийдвэрлэх нь чухал байна”*[13] хэмээн нэгэн өгүүлэлдээ дүгнэн бичсэн байдаг. Энэ нь угтаа, социализмаас татгалзах, түүний оронд бий болох ёстой нийгмийн байгууламд түүхэн шилжилт хийх, нийгмийг хувьсгалт ёсоор өөрчлөх

10 *Чулуунбаатар Г. XX, XXI зууны зааг үеийн монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт (Эрдмийн бүтээлийн эмхэтгэл). “Сансудай” ХХК. Уб., 2008, 14 дэх тал*

11 *Чулуунжав Д. Монголын нийгмийн өвөрмөц байдалд тохирох төрийн засаглалын зохистой хэлбэр, хэмжээ, бүтэц, үүргийн асуудалд. ред. Чулуунбаатар Г. “Бэмби сан” ХХК. Уб., 2004, 94 дэх тал*

12 *Болд-Эрдэнэ Д. Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил. “Бэмби сан” ХХК. Уб., 2008, 54 дахь тал*

13 *ФСЭХ., ШУА. Философи, эрхийн судлал-XIV. Дашцэдэн Д. Социалист ардчиллыг хөгжүүлэх зарим чухал асуудал. Улсын хэвлэлийн газар. Улсын хэвлэлийн газар. Уб., 1990, 103-112 дахь тал*

үйл явц үндсэндээ тухайн үеийн нөхцөл байдал, цаг үе, үүсэн өрнөх болсон үйл явдлуудын аясаар нягт нямбай бодож боловсруулсан үзэл баримтлал, үндэслэлтэй *"философи"*-гүйгээр явагдсан[14] болохыг онцолсон явдал байв. Түүнчлэн судлаач А.Жамбал тоталитаризмын талаарх онол, танин мэдэхүйн өнгө аяс бүхий бэсрэг өгүүлэлдээ[15] тус дэглэмийн онцлог, үүссэн түүх, хэрэгждэг механизм, хэлбэр, улс төр судлаачдын судалсан байдал зэргийг товчлон өгүүлсэн нь багш, оюутнууд, сонирхон судлаач нарт онолын мэдлэгийн хүрээгээ тэлэх боломжийг олгож, шинэ эрэл хайгуулыг бий болгох оролдлого болжээ. Үүний дараа доктор (Ph.D) Н.Чимэг "Хүнд суртал нийгэм-улс төрийн үзэгдэл болох нь"[16] хэмээх өгүүлэлдээ *"...хүнд суртал нь нийгмийн зохион байгуулалтын өвөрмөц маягийн хувьд хэд хэдэн үндсэн хэлбэр маягтай байж болох нь харагдаж байна. Хүнд суртал нь нийгмийн зохион байгуулалт, "оновчтой чанарын" хувьд улс орны хөгжилд дэвшилттэй болон сөрөг нөлөөтэй байдаг юм. Ялангуяа нийгмийн хяналтыг хэрэгжүүлэхэд хүчин түлхэц болдог болович эцсийн дүндээ тэрхүү хяналтыг хэлбэр төдий, ёс төдий шинжтэй болгоно"*[17] гэж дүгнэсэн нь тухайн цаг үеийн өнгө аяс, мөн чанарыг илтгэх гэсэн оролдлого байв. Мөн түүнчлэн ерээд оны дунд үеэс Монголын улс төрийн шинэ тогтолцооны үеийн сонгуулийн системийн төлөвшил, түүний онцлогийн талаар шинжлэх ухааны суурь судалгаа хийгдсэн байна. Тэрхүү судалгаагаар сонгуулийг судлах онол, арга зүйн асуудлууд, 1921-1990 оны үеийн сонгуулийн тогтолцоо, 1990 оноос хойших үеийн сонгуулийн шинэ тогтолцооны төлөвшлийн асуудлыг улс төр судлалын аспектээр авч үзэж, шинжилсэн нь тухайн үед шинэлэг судалгаа[18] байжээ.

Бидний мэдэхээр, 1989 оны сүүлээс өрнөсөн ардчилсан хувьсгалын өөрчлөлтийн үйл явцын судалгаа харьцангуй өргөн хүрээнд хийгдсэн нь харагдаж байгаа бөгөөд эдгээр судалгаанд гол төлөв барууны улс оронд түгээмэл хэрэглэгддэг латин гаралтай "*democracy*" гэдэг үгийг *"ардчилал"* гэж монгол үгээр хөрвүүлэн орчин үеийн өрнөдийн нийгэмд дэлгэрсэн түгээмэл утгаар нь хэрэглэх болсон явдал байв. 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуульд *"ардчилал"*-ыг хамгийн өргөн утгаар нь буюу ард түмэнд төрийн дээд эрх мэдлийг эдлүүлэх агуулгаар *"хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх"*[19] эрхэм зорилгын хэмжээнд тунхагласан байдаг. Угтаа шинэ Үндсэн хуулийн үзэл санааг онолынх нь талаас авч үзвэл үндсэндээ орчин үеийн ардчиллын хамгийн гол үнэт зүйлсийг багтаасан сонгодог хийгээд либерал онолын тулгуур зарчмуудад үндэслэсэн байдагтай хэн ч маргахгүй билээ. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд ардчиллын үзэл санаа олон нийтийн хувьд сэтгэл хөдлөлөөс хальж, тэдний өдөр тутмын аж байдал, үйл хэрэг[20] болон хувирсан нь маргашгүй үнэн. Судалгаа, шинжилгээний хувьд ардчиллын тухай асуудлыг судлахдаа гол төлөв философи, арга зүйн асуудлаас эхлээд түүний үнэт зүйлс, институтийн төлөвшил, хэлбэр загварын асуудал зэрэг олон талаас нь судалж эхэлсэн байдаг. Тэгвэл үүнийг арай өөр байдлаар үзсэн зүйл бол, XX зууны монголын нийгмийн харилцаанд үйлчилж ирсэн ардчиллын парадигмуудыг эхлээд марксист онолын *"пролетарийн буюу социалист ардчилал"*-ын тухай сургаалыг,

14 *ФСЭХ., ШУА. Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. ред. Даш-Ёндон Б. "Сансудай" ХХК. Уб., 2008, 302 дахь тал*

15 *ФСЭХ., ШУА. Гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ. №12. Уб., 1992, 136 дахь тал*

16 *ФСЭХ., ШУА. Гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ. №15. Уб., 1998, 150 дахь тал*

17 *Мөн тэнд., 163 дахь тал*

18 *ФСЭХ., ШУА. Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо. Хамтын бүтээл. "Бэмби сан" ХХК. Уб., 2000*

19 *ХЗҮТ., ХЗДХЯ. 1992 оны Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн оршил хэсэг. Уб., 2007. 3 дахь тал.*

20 *Хатанболд О. Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр. ред. Чулуубаатар Г., Ганбат Д., Цэцэнбилэг Ц. "Соёмбо принтинг" ХХК. Уб., 2017, 17-18 дахь тал*

дараа нь марксист биш онолын *"либерал буюу чөлөөт ардчилал"*-ын тухай үзлийг баримжаалж ирснийг харуулдаг. Гэхдээ социалист ардчиллыг хэрэгжүүлэх гэсэн оролдлого 1990-ээд онд мухардалд орж тасалдсан, либерал ардчиллыг хэрэгжүүлэх үйл явц гуч шахам жил үргэлжилж байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд бэрхшээлтэй учрах, удаашрах, зарим талаар ухрах байдал ажиглагдах[21] болсон. Цаашид хэрхэх тухай асуудалд бүтээлч бодол санааны эрэл хайгуул хэрэгтэй байна. Ийм эрэл хайгуул эхлээд арга зүйн асуудалд төвлөрөх нь чухал[22] байгааг судлаачид тэмдэглэдэг. Тодруулбал, судалгааны ерөнхий философи, арга зүйн асуудлын хувьд монголын ардчиллын тухай судалгаа арга зүйн талаасаа ардчиллын түгээмэл мөн чанар буюу ардчилал бол хүн төрөлхтний нийгэмшиж иргэншсэн хөгжлийн атрибут (зуршмал) шинж гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс эхэлдэг. Хэрэв ардчиллыг хүн төрөлхтний атрибут шинж гэж үзэх нь арга зүйн хувьд нэг талаас дэлхийн ямар ч улс үндэстэнд ардчилал хэрэгжих түгээмэл боломжийг, нөгөө талаас ардчилал ийнхүү хэрэгжихдээ түрүүлж хөгжсөн улс үндэсний ололт, туршлагыг "гаднаас" хүлээн авч идээшүүлэх, мөн өөрийн хөрснөөс ардчиллын үнэт зүйлсийг "ургуулж" хөгжүүлэх үйл явцын хослолыг хамтад нь илэрхийлэх нь зүйтэй хэмээн бид үзэж ийнхүү цухас дурдаж буй нь энэ юм.

Тэгвэл, 1990-ээд оны сүүл үеэс иргэний нийгмийн орчин үеийн хандлагыг онцгойлон судлах болж, чингэхдээ орчин үеийн иргэний нийгмийн талаарх алтернатив тодорхойлолтуудаас иргэний нийгмийн үр ашигтай бодитой хяналт, нөлөөллийн арга хэмжээ, төрийн албан хаагчдын үйл ажиллагаа болон ёс суртахууны байдалд хяналт тавих, иргэдийн үнэт зүйлс, итгэл үнэмшил зэрэг нийгмийн харилцааны хэм хэмжээ, ардчиллын практикийг илэрхийлэх оролдлогууд хийгдэх болсон. Учир нь ардчилсан нийгэмд иргэний нийгмийн оролцоог чухалчилдаг бөгөөд түүнийг ардчилал хөгжих нэг үндсэн суурь дэвсгэр хэмээн үздэг. Тиймээс иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, түүний нийгмийн хүрээллийн асуудлыг төр засгаас гарч буй алив согогтой бодлого, үйл ажиллагаанд эргээр нөлөөлөх зөвшилцлийн зарчмыг баримтлан шийдвэрт нөлөөлөхдөө иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны ач холбогдлын бүрэн төгс ойлголтыг таниулахыг чухалчлах болсон. Энэ талаар профессор Г.Чулуунбаатар нэгэн бүтээлд *"XX, XXI зууны зааг үеийн Монгол Улсад ардчилсан өөрчлөлтийн явцаар бүрэлдэн төлөвшиж буй иргэний нийгмийн онол, практикийн асуудал болон иргэний нийгмийн тухай дэлхийн нэрт сэтгэгчдийн үзэл онол, монголд төлөвшин хөгжиж буй иргэний нийгэм, түүний өвөрмөц онцлогийг судлах арга зүйн асуудал, иргэний нийгмийн үнэт зүйлсийн түүхэн хөгжил, иргэний нийгмийн төлөвшилд гарч буй ахиц өөрчлөлт, хүндрэл, бэрхшээл, ардчилсан иргэний нийгмийг цогцлоон хөгжүүлэх, монголчуудын амьдралын хэв маягийн өөрчлөлтийн төлөв хандлагын тулгамдаж буй асуудлыг"*[23] философи, улс төр, социологи, иргэншлийн үүднээс хөндсөн байдаг. Түүнчлэн доктор Х.Гүндсамбуу, Г.Чулуунбаатар нар XX, XXI зууны зааг үеийн Монголын залуучуудын дүр төрх, XXI зууны залуучуудын амьдралын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн судалгааны нэгэн бүтээлдээ *"ардчилсан тогтолцоонд шилжин орсон тухайн цаг үеийн залуучуудын амьдралд гарч буй*

*21 ФСЭХ., ШУА. Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт. УБ., 2006, 2008, 2010, 2013; ФСЭХ, ТБШХ, НҮБХХ. Монголын залуучуудын ардчилал, улс төрийн идэвх оролцоо. Уб., 2014;//ҮСХ. ӨНЭЗС. Ардчилсан засаглал модуль. Уб., 2012, 2013, 2014.*

*22 УТШУХ. Үндэсний өвөрмөц соёлын орчин дахь ардчиллын зарчмын үйлчлэл. Эрдэм шинжилгээний грант-төслийн тайлан. Уб., 2008. 16 дахь тал*

*23 Чулуунбаатар Г. XX, XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, хөгжил. "Бэмби сан" ХХК. Уб., 1999*

*өөрчлөлт, тэдний нийгмийн төлөвшлийн үйл явц, судалгаанд суурилсан ажиглалт зэргээс залуучуудын амьдрал ахуй, ажил үйлсийнх нь хүрээнд бий болоод байгаа ээдрээтэй асуудлууд"*-ыг шийдвэрлэхэд залуучуудын талаарх иж бүрэн судалгаа чухал болохыг[24] онцолсон байдаг нь хожмын үеийн судлаачдын нэн тэргүүнд судлан шинжлэх судлагдахуун болсон хэмээн үзэж болно. Тэгвэл, нийгмийн байгуулалд түүхэн шилжилт хийх нь өөрчлөлтийн үйл явцаар дамжуулан тухайн үеийн нөхцөл байдал, цаг үеийн байдлыг нягт нямбай тунгаан бодож боловсруулсан үндэслэлтэй өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байхыг шаардаж буйн нэгэн тусгал болсон *намын системийн эрх зүйн үндэс бүрдэж бий болох нь нэг хэрэг, гагцхүү нэгэнт бий болсон эрх зүйн суурь үндсийг өргөжүүлж, цаашид амьдралын өөрчлөлт, хөгжлийн шаардлагад нийцүүлж улам боловсронгуй болгон сайжруулж байх нь нэн чухал*[25] болсон. Учир нь Монголын нийгэмд ардчилсан үзэл санаа үр хөврөл хэрхэн бий болж, ямар байдлаар уламжлагдаж байгааг иргэдийн улс төрийн ухамсар, соёлын онцлогтой холбож үзэх нь ардчиллын судалгааны арга зүйд холбогдох гол зарчмуудын[26] нэг болон төлөвших үндэс болсныг илтгэж байв. Энэ хандлага монголын ардчиллын талаарх манай эрдэмтдийн судалгаанд цөөн биш хөндөгдсөн байдаг. Тухайлбал, доктор Б.Дэлгэрмаа улс төрийн талаар хувь хүний санаа бодол, байр суурь, үнэт зүйлсийн чиг баримжааг *танин мэдэхүйн, сэтгэл хөдлөлийн, үнэлэлт дүгнэлтийн* гэсэн гурван түвшинд авч үзэж болох саналыг дэвшүүлсэн бөгөөд эдгээр гурван хүрээний илрэл харилцан шүтэлцээтэйгээр улс төрийн соёлыг тодорхойлдгийг онцолсон байна. Үүнийг лавшруулан үзвэл, улс төрийн тогтолцоо, үйл явцын тодорхой мэдлэг, ойлголтгүйгээр байр сууриа илэрхийлж, үнэлэлт дүгнэлт өгөх аргагүй нь тодорхой[27] гэдгийг ч энд онцолсон нь ардчиллын улс төрийн соёл, түүний үндэсний уламжлалыг судлахад арга зүйн хувьд харгалзах учиртай чухал санаа болохыг илтгэнэ. Түүнчлэн улс төрийн орчны хүрээнд ардчиллыг бодит дэмжигчдийн жин нөлөө бүс нутгийн улс орнуудтай харьцуулахад бага байгаа нь монголчууд ардчиллыг ерөнхий идеал агуулгаар хүлээн зөвшөөрч буй болохоос бус, тэдэнд түүний талаар сайтар ухааран таньсан тодорхой ойлголт, үзэл төсөөлөл хараахан бүрэлдэж чадаагүйг харуулж буй.

Өнөөдөр бид ардчиллыг ам булаалдан сайрхан магтах эсвэл эс дэмжин, сэтгэлийн хөөрлөөр муучлан гутаах туйлшралаас хэтрэхгүй байна. Уламжлалт нийгмийн инерци сэтгэлгээ хүчтэй, ардчиллын үндэсний гэхээр түүхэн туршлага, уламжлал байхгүй манайх шиг улс орны хувьд ардчиллыг зөв ойлгон ухаарч, төлөвшүүлэх нь үнэхээр амаргүй ажил байв. Энэ бүхэн нь угтаа монголын өнөөгийн улс төрийн орчныг нэн ерөнхий агуулгаар нь ардчилсан хэв шинжийн орчин гэж үзэж болохоор. Монголын улс төрийн орчныг нэгэнт ардчилсан хэв маяг бүхий орчин хэмээн үзэж буй тохиолдолд улс төрийн орчны судалгааны үндсэн судлагдахуун нь Монголын ардчиллын төлөвшлийн хүрээний асуудлууд байх нь илэрхий.

Үүнтэй холбогдуулан ардчиллын үе шат, үнэлгээ, бэрхшээл сорилт, нөхцөл,

24 *Гүндсамбуу Х., Чулуунбаатар Г. XXI зууны босгон дахь Монголын залуучууд. Хамтын бүтээл. Монголын мэргэжлийн социологичдын "Зотол" клуб. ЭМНХЯ-ны Залуучууд, гэр бүл, эмэгтэйчүүдийн газар. Уб., 1998.*

25 *ФСЭХ., ШУА. Гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ. № 16. Болд-Эрдэнэ Д. Монголын олон намын системийн эрх зүйн тулгуур үндэс бүрэлдэх үйл явцын онол-түүхийн асуудал. Уб., 2000. 236 дахь тал*

26 *Хатанболд О. Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2016, 27 дахь тал*

27 *Дэлгэрмаа Б. Улс төр судлал. Уб., 2001. 5 дахь тал.//Дэлгэрма Банзрагчийн. Демократические преобразования в Монголии на рубеже XX и XX вв. Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. ИМБТ СО РАН, Гумманитарный институт Монгольского университета науки и технологий. Улан-Үдэ. 2005. стр 138-139.*

хүчин зүйл, чанар, хэв загвар, улс төрийн тогтолцоо, хэм хэмжээ, улс төрийн соёл, ухамсрын хүрээний олон цогц асуудлыг онцолж болохоор юм. Учир нь улс төр судлаачид монголын улс төрийн орчны хэв шинжийн тухайд олон янзын байр суурийг илэрхийлдэг. Тухайлбал, тэд монголын улс төрийн орчныг хэв шинжийн хувьд “шилжилтийн”, “завсрын”, “хөгжмөл бус” эсхүл “харьцангуй төлөвшсөн”, “үндсэндээ төлөвшсөн” гэх зэргээр томъёолон тодорхойлдог. “Шилжилтийн үе” хэмээх нэр томъёог улс төрийн орчны төлөвшилтийн үйл явцтай холбогдуулан хэрэглэх эсэх тухайд судлаачдын байр суурь өнөө хэр нэгдмэл болоогүй байна. Сүүлийн үед судлаачдын нэг хэсэг нь өнөөгийн улс төрийн орчныг шилжилтийн гэж үзэхээс татгалзахыг санал болгож байна. Харин нөгөө хэсэг нь шилжилтийн үе үргэлжилж байна гэцгээдэг.[28] 80-90-ээд оны зааг үеэс монголчуудын ардчиллыг хөгжлийн гол зам хэмээн сонгосон сонголт шинэ зуунд ч хэвээр байх нь эргэлзээгүй.

Эдгээрийг хураангуйлан үзвэл, бидний тал бүрээс нь тайлбарлахыг хичээдэг олон янзын загварт тодорхой учир шалтгаан гэж байхгүй хэдий ч түүнийг тодруулах хүчин зүйлс гэж бий.  Тэдгээр хүчин зүйлс нь их бага хэмжээгээр нийгмийн өнөөгийн байдалд тохирох эсэх нь олон янзын түвшинд илэрч болно. Нөгөө талаар улс төр судлалд шинжлэх ухааны тодорхой үе шат, томьёолоолоор тодруулах байдал элбэг тохиолддог бөгөөд тэдгээр нь улс төрийн шинжлэх ухааны позитивист загварын алдаа оноог шүүн хэлэлцэх үүднээс гол эх сурвалжуудыг тодруулах, түүний субьектив мөн чанарын талаар ташаа ойлголтуудыг бодит нөхцөлтэй уялдуулах, нийгмийн шинжлэх ухааны ялангуяа улс төрийн шинжлэх ухааны өнөөгийн шинжүүдийг тодруулах зэрэгт ихээхэн нөлөө үзүүлдэг. Тиймээс ч, улс төр судлаачдын улс төрийн шинжлэх ухааны орчин үеийн үзэл хандлага, онол арга зүйн эрэл хайгуулд эргэлт буцалтгүйгээр зүтгэж, дээр дурдсан бэрхшээлийг даван туулж, эрдэм судлалын арвин баялаг мэдлэг, мэдээллийн санг бүрдүүлж гэмээ нь улс төрийн шинжлэх ухааныг орчин үеийн агуулга, чиглэлээр нь хөгжүүлэх үндэс суурь тавигдаж, улмаар сонгуулийн тогтолцоо, улс төрийн нам судлал, улс төрийн дэглэм судлал, хүнд суртал, улс төрийн сэтгэлгээний түүх, онолын судалгааны бодитой эхлэлүүдийг тавьж чадсан цаг үе байсан хэмээн нэгтгэн дүгнэж болох юм.

### ***Дөрөв. Улс төрийн шинжлэх ухааны шинэ төлөвшилтийн үе (2000-2010)***

Монгол Улс Азийн пост-социалист орнуудаас ганцаараа ардчиллын замыг тууштай сонгож, улмаар улс төр, эдийн засгийн шилжилтийг хооронд нь уялдуулж, тодорхой утгаар зэрэгцүүлж, бас тайван замаар хийснээрээ онцлогтой. Ийнхүү ганц хэмээн онцлохын учир нь Хятад, Хойд Солонгос, Вьетнам, Лаос зэрэг Азийн социалист байсан орнууд бидэнтэй адил замыг сонгоогүй шалтгаан нь тухайн орнууд (Хойд Солонгосоос бусад) бүгд л зах зээлийн эдийн засгийн харилцаа, нээлттэй эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх замаар харьцангуй амжилттай хөгжиж ирсэнтэй холбоотой. Чингэхлээр, аливаа улсын хөгжлийг хэмжих шалгуур юунд орших вэ гэдэг нь гагцхүү тэдний сонгосон засаглал уу аль эсхүл хөгжлийн төлөөх чинхүү сэтгэлээр төрийн залгамж чанараа үргэлжлүүлэн авч явсан зорилго уу гэдгийг олж тогтоох нь чухал санагдана. Үнэндээ, ардчилал, зах зээлийн замыг сонгон авсан л бол өөрийн улсын үндэсний онцлогт нийцүүлж, хөгжлийнхөө зам, загварыг бүтээхийн учир агуулгаа өнөөгийн Япон, Өмнөд Солонгос, Тайланд зэрэг Азийн өндөр хөгжилтэйд тооцогдох дорнын соёлтой, ардчилсан тогтолцоотой улс орнуудын өнөөдрийн дүр зураг бидэнд харуулж байна. Эндээс урган гарч буй чухал санаа бол, нийгмийн өнөөгийн шинж, ардчилал, засаглалын төлөв байдал хэрхэн

28 *Даваадаш Ч. Монголын нийгмийн шилжилтийн зарим онцлог, ээдрээ. Өдрийн сонин. №187. Уб., 2015.*

төлөвшиж буйг тодруулахдаа үндэсний онцлогоо түлхүү шингээсэн, олон улсын хэмжээний ерөнхий арга зүйн ололттой талуудтай хослуулах замаар орчин цагийн хөгжлийн хурдыг улс төр, эдийн засгийн харилцааны өвөрмөц онцлог бүхий дотоод гүний бодит байдлыг бүрэн тусгасан үндэсний онцлогтой нийгэм, соёлын болон улс төр-эрх зүйн нээлттэй, шударга, ёс зүйтэй, тэгш эрхийн зарчмыг шингээж чадсан байх нь чухал. Цаашлаад ардчилсан легитимт чанарыг дээдэлсэн хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоосон, нэгдмэл улсын мөн чанарыг агуулсан хөгжлийн замыг сонгох нь өнөөгийн Монгол Улсын хөгжлийн гарцын суурь илэрхийлэмж мөн гэдгийг бид бүхэн мэднэ.

Гэхдээ бидэнд тулгарч буй сорилт, бэрхшээл багагүй байсаар ирсэн. Үүний нэг нь нийгмийн хөгжлийн суурь болох хувьсал, өөрчлөлтийн үйл явц хэт удаашралтай эсхүл тогтонги байдалтай явагдаж буй нь эцэстээ эргэлзэж тээнэгэлзсэн аль эсхүл хэт туйлширсан байр суурь, сөрөг хандлагууд газар авах болсонтой холбоотой. Хэдийгээр зарим үр дүн нэлээд хугацаанд тогтвортой байж дараагийн илүү сайн үйлийн үндэс суурь болж байгаа авч, зарим нэг тодорхой хугацаанд тогтвортой байх боломж цаашдаа хүсээгүй, хүн нийгэмд хэрэггүй муу бүхний эхлэл болох явдал ч байсаар байна. Үүнийг шүүмжлэлт талаас нь үзвэл, өнөөгийн нийгмийг улс төр, засаглал, ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаа, байгалийн баялгийн ашиглалт зэрэг нь улс орны хөгжилд, тухайлбал, жирийн монгол хүний хөгжил, түүний эрүүл, аюулгүй, нээлттэй, ил тод байх Үндсэн хуульд заасан бүхий л эрхийн хүрээнд хангалттай сайхан амьдарч, бас тэднийг амьдруулж, хөгжүүлж, хамгаалж чадаж байна уу гэвэл зөрчилтэй, ээдрээтэй дүр төрх, мөн чанар оршсон хэвээр л байна.

Тэгвэл энэ бүхний эхлэл юунд байв гэдгийг оношилбол, бид төр улсынхаа хувьд оршин хөгжсөн түүхийнхээ бүхий л үед нүүдлийн болон суурин иргэншлийг хослуулан хөгжиж ирсэн бөгөөд энэ нь бидний өнөөгийн монголын нийгмийн харилцааны дахин давтагдашгүй, язгуурын онцлог шинжтэй холбоотой мэт. Бидний мэдэхээр, суурин иргэншил гэхээр хүн ам төвлөрсөн хот, суурины, харин нүүдлийн хэмээх төсөөлөл маань байгалийн хишиг даган нүүж, сууж амьдардаг хүмүүсийг ойлгосоор ирсэн өнгөц мэт төсөөллийг энд онцлох нь чухал биш, гагцхүү нүүдэл, суурьшлын хослол бүхий өвөрмөц тогтолцоо, шинж байдлыг онцлох явдал юм. Тодруулбал, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хурдацтай өсөн хөгжиж буй байдал, шашин, соёл, зан заншил, ёс зүйн хийгээд ёс суртахууны боловсрол, сэтгэл зүй, төр ёс, аж ахуй эрхлэх уламжлалт арга ухаан, үр хойч ирээдүйгээ өсгөх сурган хүмүүжүүлэх ур ухаан, гэр бүл, айл хотлоороо, төрөл саднаараа хамтран ажиллаж амьдрах зэрэг нийгмийн харилцааны хамгийн энгийн төрөл, шинжүүдийг мөнхүү хоёр иргэншил хослуулан хөгжүүлэх аваас дээр дурдсан зүйлсийн бүхий л үр дагаврыг харгалзан үзэхгүйгээр үндэсний онцлогоо шингээсэн давтагдашгүй онцлогийг бүтээж үл чадна. Цаашлаад төр, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх үзэл онол, хандлагын хүрээнд ээдрээтэй зөрчил бий болсон нь өнөөгийн бидний оршин амьдарч буй нийгмийн шинж төрхийг харуулж буй маш энгийн үзүүлэлт юм. Харин нөгөө чухал зүйл нь эдийн засаг мөн бөгөөд эдийн засаг бол нийгмийн хөгжлийн үндэс мөн гэдэгтэй хэн ч маргахгүйтэй адил эдийн засгийн гол хөшүүрэг нь юу байхыг тодруулах нь зүйтэй. Угтаа тэрхүү хөшүүрэг нь ард түмэндээ юу өгч, ард түмэн нь эдийн засгийнхаа гол хөшүүргийг ажиллуулахад яаж оролцож байна вэ гэдгийг давын өмнө ярих асуудал мөн болохыг бидний дурдан буй цаг хугацаанд онцолсоор ирсэн билээ.

Энэ бүхэн, угтаа Монгол Улс улс төрийн ардчилсан системд шилжих суурь нөхцөл бүрэлдсэн тэр үеэс улс төрийн шинжлэх ухаан хөгжих боломж бүрдэж

эхэлсэн түүхтэй. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний түүхэн хөгжлийн турш үйлчилсэн хамгийн чухал зүй тогтлын нэг бол залгамжлал мөн бөгөөд тэрхүү залгамжлал бол хөгжлийн процесс дэх хуучин шинийн хоорондын бодит холбоос мөн болохынхоо хувьд хөгжлийн нэг төвшнөөс нөгөөд шилжих шилжилтийн үндэс болж[29] байдаг. Тэр утгаараа, уламжлал бол өвлөгдөж буй юмс. Үнэлэмж, хэм хэмжээ, зан үйл, нийгмийн зохион байгуулалт, үзэл санаа уламжлагддаг[30] жамтай. Энэ агуулгаараа, бидний дурдан буй энэ цаг үед Монголд болж асан ардчиллын тухай яриа, судалгаа, сурталчилгааны ажлын дийлэнх нь *"Монгол дахь ардчиллын"* тухай үзэл санааны далбаан доор явагдаж улмаар улс төрийн хүрээнийхэн, улс төр судлаачдын дотор ийм үзэл санааг талархан дэмжигчид үнэмлэхүй олонхыг бүрдүүлж байна. XX зуунд монголчууд ардчиллын тухай ярьдаг, бичдэг, бас ч судалдаг болсон. Энэ нь бидний өмнөх хэсэгт дурдсанчлан эхлээд марксист онолын *"пролетарийн буюу социалист ардчилал"*-ын тухай сургаалыг, дараа нь марксист биш онолын *"либерал буюу чөлөөт ардчилал"*-ын тухай үзлийг баримжаалсантай холбоотой. Тийм болохоор өөрөөр байх бололцоо ч хязгаарлагдмал байсан тал бий. Гэхдээ социалист ардчиллыг хэрэгжүүлэх гэсэн оролдлого 1990-ээд онд мухардалд орж тасалдсан, либерал ардчиллыг хэрэгжүүлэх үйл явц гуч орчим жил үргэлжлэхдээ хямрал, удаашрал, ухралт бий болсон[31] нь бидэнд цаашид хэрхэх тухай асуудалд бүтээлч бодол санааны эрэл хайгуул хэрэгтэй байна. Ийм эрэл хайгуул эхлээд арга зүйн асуудалд төвлөрөх нь чухал[32] төдийгүй энэ талаар бидний ахмад үеийн эрдэмтэд өөрсдийн бүтээлдээ хэрхэн судалж, эрэлхийлж байсныг тодруулахыг зорьж буй энэ бөлгөө.

Нийгмийн зохион байгуулалт, үзэл санаа уламжлагддагийн адил дээр өгүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд өмнөх үеийн судлаачдын улс төрийн шинжлэх ухааны хөгжилд оруулсан хувь нэмэр гүйцэтгэсэн үүрэг, өвлүүлэн үлдээсэн уламжлалыг дурдахгүй өнгөрөх нь зүйд үл нийцнэ. Тиймээс бид дараах эрдэмтэн судлаачдыг, тухайлбал, доктор Ж.Болдбаатар, А.Цанжид, В.Отгоннасан, Ш.Содном, Д.Содномгомбо, Г.Чулуунбаатар, Д.Ганхуяг, Ё.Довчин, Ц.Ганболд, Д.Дашцэдэн, Г.Совд, Б.Чимид, Ч.Энхбаатар, Д.Лүндээжанцан, Н.Лүндэндорж, Лха.Юндэндорж нарыг онцолж байна. Түүнчлэн улс төрийн шинжлэх ухааныг шинэ тутам үүсгэж төлөвшүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн мэргэжилтнүүд, их дээд сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтнууд, судлаачид (Д.Чулуунжав, Д.Болд-Эрдэнэ, А.Жамбал, И.Лхам, Ц.Ганболд, Ш.Содном, Н.Содномномбо, Ё.Довчин, С.Цэнд-Аюуш, Н.Чимэг, Л.Ариунболд, Х.Ганбаатар, Ч.Өлзийсайхан, А.Юндэндорж, Ю.Атар, С.Одхүү, О.Эрдэнэчимэг, Э.Тамир, Ц.Гомбосүрэн, Л.Пүрэвдорж гм) улс төрийн сэтгэлгээний түүх, уламжлалын асуудлаар тодорхой тооны өгүүлэл бичиж нийтлүүлсэн байдаг. Жишээлбэл, доктор Д.Болд-Эрдэнэ "Их Монгол Улсын үеийн ардчилсан уламжлалын зарим асуудал" хэмээх өгүүлэлдээ *"Чингис хааны нэгдсэн төр улсаа байгуулж, бэхжүүлсэн 1206-1227 хүртэлх түүхэн цаг үеийг тусгайлан сонгон авч, энэ үеийн ардчилсан уламжлалын онол, түүхийн асуудлын зарим*

*29 Жүгдэр Ч. Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил (МЭӨ III-МЭ XX зуун). ФСЭХ., ШУА. Бэмби сан ХХК. Уб., 2006. 94 дэх тал*

*30 Кравченко А.И.2001. Культурология: Учебное пособие для вузов. 3-е изд. Академический проект. М., РФ*

*31 ФСЭХ., ШУА. Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт. УБ., 2006, 2008, 2010, 2013. ФСЭХ, ТБШХ, НҮБХХ. Монголын залуучуудын ардчилал, улс төрийн идэвх оролцоо. Уб., 2014.//ҮСХ. ӨНЭЗС. Ардчилсан засаглал модуль. Уб., 2012, 2013, 2014.*

*32 УТШУХ. Үндэсний өвөрмөц соёлын орчин дахь ардчиллын зарчмын үйлчлэл. ЭШ-ний грант-төслийн тайлан. Уб., 2008. 16 дахь тал*

*зүйлсийг тодруулан үзэх зорилго тавьсан"*[33], судлаач Д.Загджав "Монголын төр ёсны түүхэн дэх иргэдийн улс төрийн оролцооны уламжлал, шинэчлэлийн зарим асуудал" өгүүлэлдээ *"... иргэдийн улс төрийн оролцооны шинж байдлыг монголын түүхэн цаг үеүдээр дурдан авч үзэж, монголын нийгэм бол дорнын нийгэм учраас улс төрийн байгууламжийн төлөвшил, хөгжил өвөрмөц онцлогтой, өрнийн улс төрийн онол, арга зүйгээр гүйцэт судлан илэрхийлэх боломжгүй"* хэмээжээ. Түүнчлэн Д.Болд-Эрдэнэ, И.Лхам нар "Хүннүгийн төрийн тогтолцоо, улс төр, эрх зүйн түүхэн уламжлал" өгүүлэлдээ *"... Монголчуудын эртний овог болсон хүннүчүүд нь төр, төрт ёсны арвин баялаг уламжлалтай байсан бөгөөд энэ уламжлал нь тус орны улс төр, эрх зүйн сэтгэлгээний анхдагч эх сурвалж, орчин үеийн Монголын төрт ёсны үлгэр авах чухал эрхэм үнэт зүйлс болж байна гэж үзэх бүрэн үндэстэй юм"*[34] гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Мөн профессор Д.Чулуунжав "Монголын байлдан дагууллын шалтгаан, нөхцөл, үр дагаварын асуудалд"[35] өгүүллийг, профессор А.Жамбал "Д.Бодоогийн нийгэм, улс төрийн үзэл санааны зарим асуудал"[36] сэдэвт өгүүллээрээ XX зууны эхэн үеийн монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний цөөн тооны гол төлөөлөгчдийн нэг болох Д.Бодоогийн улс төрийн үзэл санааг онцлон гаргахыг зорьсон нь сонирхол татдаг.

Нэмж хэлэхэд улс төрийн шинжлэх ухааныг төлөвшүүлэхэд энэ чиглэлийн эрдэмтэд, тухайлбал, ШУА-ийн ФСЭХ-ийн Улс төр судлалын салбарын үе үеийн эрдэм шинжилгээний ажилтнууд, МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, МУБИС-ийн Улс төр, социологийн тэнхим, Удирдлагын академи, Улс төрийн боловсролын академийн болон бусад төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиудын эрдэмтэн багш нар, судлаачид чухал үүрэг гүйцэтгэсээр ирснийг дурдах хэрэгтэй. Тухайлбал, Монгол Улс ардчилалд шилжсэнээр улс төрийн соёлын асуудлыг орчин үеийн улс төр судлалын онол, парадигмын дагуу судлах боломжтой болсон төдийгүй бидний дурдан буй энэ үе бол түүний төлөвшлийн эхэн үе байсан ба, 1990-ээд оноос улс төрийн соёлын онол, практикийн асуудлаар зарим төрлийн судалгаа шинжилгээ хийгдэж эхэлсэн боловч суурь судалгааны түвшинд хийгдэж байгаагүй. Гэхдээ манай судлаачдаас сүүлийн жилүүдэд туурвисан бүтээл чамлахааргүй. Үүний зэрэгцээ улс төрийн соёлын асуудлыг судлаачдын бүтээлд хавсарга байдлаар судлагдах нь түгээмэл байна. Монголын нийгмийн ардчилсан өөрчлөлт, улс төрийн систем, төр, улс төрийн нам, улс төрийн болон сонгуулийн үйл явцыг судлахдаа улс төрийн соёлын асуудлыг ямар нэгэн хэмжээгээр хөндөн уг асуудлын талаарх өөрсдийн байр суурийг илэрхийлсэн байдаг. Тодруулбал, Д.Содномгомбо, Ч.Найдансүрэн, Ш.Содном, Г.Чулуунбаатар, А.Жамбал, Д.Болд-Эрдэнэ, Ё.Довчин, А.Цанжид, Д.Ганбат, Д.Мандах, Ц.Гомбосүрэн Т.Дорждагва, Н.Сарантуяа, Ж.Долгорсүрэн, Ц.Ганболд, Ж.Төртогтох, Д.Баасансүрэн, С.Зульфикар, С.Мөнхбат, Н.Чимэг, Д.Чулуунжав, Р.Ариунболд, А.Хишигдаваа, О.Хатанболд, У.Батцэрэн нарын судалгааны ажилд энэ асуудал тодорхой хэмжээгээр судлагдсан байдаг. Тодруулж хэлбэл, Т.Дорждагва, Н.Сарантуяа, Ж.Долгорсүрэн нар *"Соёл бол хүмүүний хүмүүнлэг чанар илрэн хэрэгжих түүхэн тасралтгүй үйл явц, түүний үр дүн мөн"* гэж түүнийг улс төрийн үйл ажиллагааны үйл явц талаас нь тодорхойлсон байдаг бол, доктор Ц.Гомбосүрэн "*Соёл бол байгалийн зүйлийг нийгмийн зүйл болгодог мөн нэгэнт бий болгосон нийгмийн зүйлийг улам бүр боловсронгуй болгодог зохистой арга мөн"* хэмээн соёлыг улс төрийн арга, арга хэрэглэл талаас нь тус тус томъёолон тодорхойлсон.

33 *ФСЭХ., ШУА. Философи эрхийн судлал- XVII. Уб., 2001. 154 дэх тал*

34 *ФСЭХ., ШУА. Философи эрхийн судлал- XVII. Уб., 2001. 102 дахь тал*

35 *ФСЭХ., ШУА. Философи эрхийн судлал- XVII. Уб., 2001. 207 дахь тал*

36 *Мөн тэнд., 230 дахь тал*

Харин доктор Ё.Довчин улс төрийн соёлын асуудлыг тусгайлан судалж *"Монгол дахь улс төрийн соёл ба ардчиллын төлөвшил"* сэдвээр эрдмийн зэрэг хамгаалсан байдаг. Эндээс үзвэл, соёл хэмээх үзэгдэл нь зайлшгүй хүнтэй холбогдож гарч ирж байгаа бөгөөд түүнийг хүнээс салгаж авч үзэх боломжгүй гэдэг нь илэрхий байна. Соёлыг хүн тээж авч явж, илэрхийлж байдаг гэдэг тал дээр үе үеийн гүн ухаантан, сэтгэгчид, судлаачид нэгдмэл байр суурьтай байж ирсэн нь цаашид уг асуудлыг гүнзгийрүүлэн судлахад чухал ач холбогдолтой болохын илрэл юм. Нэг хэсэг судлаачид улс төрийн соёлыг уламжлалтай холбож, нийгмийн өв гэж үзэж байхад, нөгөө хэсэг нь соёлын хэм хэмжээлэг шинжийг онцолж, тухайн нийгмийн аж төрөх ёсыг тодорхойлох дүрмүүдийн цогц хэмээн тайлбарлаж, гурав дахь хэсэг нь байгаль, нийгмийн орчны тодорхой нөхцөлд хүн дасан зохицох явдлыг нөхцөлдүүлэх соёлын зохицуулалтын үүрэг талаас нь онцолсон нь буй. Манай эрдэмтдийн улс төрийн соёлын талаар хийсэн судалгаануудаас Д.Содномгомбо, Ч.Найдансүрэн нарын *"Улс төрийн соёл, түүний Монгол дахь төлөвшлийн асуудал"*[37] судалгаа нь дорвитой бүтээл болсон хэмээн үзэж байна.

Улс төрийн шинжлэх ухааны төлөвшилт харьцангуй богино хугацаанд эрчимтэй хөгжиж эхэлсэн ч гэлээ улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн өнөөгийн байдалд сорил бэрхшээл тулгарч буйг УТБА-ийн гүйцэтгэх захирал, доктор Д.Ганбат[38] мөнхүү сорилтыг дараах хэдэн шалтгаанаар тодорхойлсон оновчтой санагдана.




Доорх зурагт харуулсанчлан *улс төрийн шинжлэх ухааны судалгааны цар хүрээ* голчлон улс төрийн ардчилсан систем, тогтолцооны үйлчлэл, сонгууль, улс төрийн намын хөгжил зэрэг сэдвийг дагнан судалгаа, эрдэм шинжилгээний ажил явагдаж байгаа хэдий ч монголын улс төрийн хөгжлийн зүй тогтол, хандлага зэргийн суурь хүчин зүйлсийг тандах, таамаглал, үндэслэгээ дэвшүүлэх, харьцуулах зэрэг эрдэм шинжилгээний суурь ажил хангалттай хэмжээнд хийгдэхгүй[39] буйг онцолж

37 Содномгомбо Д., Найдансүрэн Ч. Улс төрийн соёл, түүний монгол дахь төлөвшлийн асуудал. Уб., 2000

38 УТШУХ. "Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны өнөөгийн түвшин". ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. ред. Ганбат Д. "Бэмби сан" ХХК. Уб., 2006, 12-17 дахь тал

39 Ганбат Д. Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн өнөөгийн байдал. "Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны өнөөгийн түвшин". ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. Улс төрийн шинжлэх ухааны холбоо. ред. Ганбат Д. "Бэмби сан" ХХК. Уб., 2006, 14-17 дахь тал

байна.

**4.Улс төрийн шинжлэх ухааны судалгааны цар хүрээ**
Энэ нь нэг талаас өнөөгийн улс төрийн ерөнхий дүр зураг, Үндсэн хуульд тусгалаа олон ардчилсан нийгмийн төлөвшлийг үнэлж дүгнэх зэрэг нэг талаас маш тодорхой тулгамдсан асуудлыг судлах, чингэхдээ улс төр судлалын арга зүйг системтэй хэрэглэх явдал чухал байна.

Улс төр судлалын хүрээний судалгааны чанар категори, ухагдахууныг нэг мөр цэгцлэх явдал чухлаар нөлөөлсөөр байна. Тодорхой ухагдахуун, категорийг тодорхой үзэгдэл, үйл явц зэрэгтэй шууд холбож ойлгох ассоциатив сэтгэлгээ бидний хүрээнд цэгцрэхгүй байгаа нь улс төр судлал шинжлэх ухааны хувьд хөгжлөө олохгүйд хүрнэ.

**5.Мэдээллийн бааз, ном, сурах бичгийн байдал**
Улс төр судлалын хэл болсон англи хэлний асуудал чухал хэвээр байна. Багш нарын дотор энэхүү хэлийг эзэмшсэн хүний тоо цөөн байсаар байгаа нь мэдээллийн баазыг өргөтгөх, ном, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарим талаар саад бэрхшээл болж байна.

Улс төр судлалын голлох бүтээлийг эзэмшихэд хэлний мэдлэг чухал бөгөөд оюутнуудад шинэ мэдээлэл түгээх боломж үүнээс шалтгаан хаалттай байх явдал байсаар буйд анхаарах хэрэгтэй. Гадаад хэл эзэмшээгүй оюутнуудад бүх юмыг монгол хэлнээ хөрвүүлэх ажил зохион байгуулах уу, эсвэл оюутнуудаа гадаад хэл заах асуудлыг тэргүүн зэрэгт тавьж хэрэгжүүлэх үү гэдгийг шийдэх хэрэгтэй.

**6.Улс төр судлалаар мэргэшиж буй оюутан, магистрант, докторантын байдал**
Улс төр судлалын хөгжилд тулгамдаж буй дээр дурдсан асуудлууд бүгд энэ мэрэгжлийг эзэмших гэж байгаа оюутан, эрдмийн зэрэг ахиулах гэж буй магистр, докторантуудад шууд тусдаг тул дараах зүйлд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

- элсэлтийн шалгалтанд англи хэлний мэдлэгийг чухалхлан үзэх,
- суралцах явцад судалгааны арга зүйг эзэмшүүлэхээс гадна судалгааны бодит ажилд тулгуурласан дипломын ажил бичүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны дадал эзэмшүүлэх,
- англи хэлийг сургалтын явцад нь TOEFL-ийн төвшинд эзэмшүүлэх арга хэмжээ авах,
- ЭШ-ний ажил эрхлэх, онол, арга зүйн чанартай өгүүлэл бичих явдлыг ЭШ-ний ажил эрхэлж буй гол үзүүлэлт болгон төлөвшүүлэх гм

Энд дурдсан сорилт бэрхшээлүүд нь тухайн цаг үеийн нийгмийн шинжлэх ухааны дийлэнх боловсон хүчин марксизм-ленинизмийн онолоор бэлтгэгдэж, ажилчин ангийн манлайлал бүхий нийгмийн бүтэц, түүнийг хангах нэгдсэн зохион байгуулалт бүхий удирдлагын тогтолцоог судлах, мөнхүү чиглэлээр эрдмийн ажил гүйцэтгэж ирсэн нь маргашгүй үнэн. Гэвч ардчилсан тогтолцоо, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн эхний жилүүдэд нийгэм, түүний улс төрийн харилцааны асуудлыг танин мэдэх, улмаар судлан шинжлэхэд монголын судлаачид, багш нарын мэдлэг, чадвар үнэхээр дутагдаж байсныг дурдахгүй өнгөрөх боломжгүй. Нэг үгээр хэлбэл, нийгмийн хөгжлийг танин мэдэх, судлан шинжлэх өөрийн тогтсон дэг сургууль буюу *"школ"* бүрэн тогтоогүй нь ийнхүү сөргөөр нөлөөлөх гол зүйл байв. Энэ нь цаг хугацаа улиран өнгөрөх тусах олон шинжлэх ухааны уулзвар, орчин үеийн судалгааны онол, арга зүй олонлог, өрсөлдөөнт олон ургальч үзлийг тэтгэх нийгмийн харилцааг судлан таамаглахад түлхүү ашиглагдах болсон нь энэхүү үечлэлийн гол шалгуур болон хувирсан гэж дүгнэж болохоор байна. Тодруулбал, социализмын үед улс төрийн шинжлэх ухаан хаалттай байсан явдал нь угтаа тоталитар дэглэм, улс төрийн практик өөрийгөө зөвтгөж удаан хугацаагаар оршин тогтнох таатай хүчин зүйлс болсон хэмээн үзэж байна.

Чухам тиймээс ардчилсан нийгэмд аливаа асуудалд бодитойгоор хандаж, улмаар танин мэдэж шүүмжлэн няцаах улс төрийн шинжлэх ухааны зөв зохистой зүй тогтлыг бүрдүүлэхэд улс төрийн шинжлэх ухааны шинэ төлөвшилтийн үе чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ нь манай эрдэмтэдээс улс төрийн шинжлэх ухааны олон янзын асуудлаар хийсэн судалгааны дорвитой бүтээл, судалгааны үр дүнд тулгуурласан нэгэн сэдэвт болон хамтын бүтээл, судлаачдын дагнан судалж буй судалгааны товхимлууд, сурах бичиг, гарын авлага гарах болсон нь улс төрийн шинжлэх ухааныг богино хугацаанд төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр болов. Үүний нэг тод жишээ бол 2002 онд БСШУЯ-ны сайдын 32 дугаар тушаалаар Улс төрийн шинжлэх ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах анхны төрөлжсөн зөвлөл

байгуулагдсан[40] явдал байв. Түүнчлэн МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүй, сургалт практикийн мэргэжлийн тогтмол хэвлэл болох "Политологи" сэтгүүлийг эрхлэн гаргах болсон. Үүнээс хойно 2005 онд Монголын улс төрийн шинжлэх ухааны холбоо байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлснийг[41] энд дурдах нь зүйтэй. Мөнхүү дурдан буй цаг үед улс төрийн шинжлэх ухааны хичээлийг их, дээд сургуулиудад заах, эрдэм шинжилгээний ажил эрхлэхээс гадна, төрийн болон төрийн бус байгууллагууд улс төрийн шинжлэх ухааны тодорхой чиглэлүүдээр судалгаа шинжилгээний ажлуудыг гүйцэтгэхийн хамтаар энэ салбарын институционал бүтцийг бэхжүүлэн төлөвшүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах болсон. Тухайлбал, профессор Ц.Ганболд нэгэн илтгэлдээ 1990-ээд оны эхээр оросын эрдэмтдийн орчуулгын бүтээлийг ашиглаж, улс төр судлалын анхны лекцүүдийг уншиж байсан үеийг бодоход Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны онол, судалгааны арга зүй, цаашлаад хүний нөөцийн хувьд дахин бэлтгэгдэж, улмаар улс төрийн шинжлэх ухааны институционал бүтцүүд бий болж,[42] үндэсний сурах бичиг, орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны шинэ гарын авлага, ном бүтээлүүд бий болсон нь ийнхүү шинэ үе гарч шинэчлэгдэж, судалгаа, шинжилгээний шинэ чиглэл, судлагдахуун төлөвших гол үндэс, суурь болсон хэмээн дүгнэсэн байдаг. Тэдгээрээс зарим нэгэн тодорхой эрдэмтэн судлаачдын бүтээл, туурвилыг энд онцлохыг бид зорив.

Тухайлбал, төрийн тухай монгол онолын талаар Ц.Эрдэмт абугай улс төрийн шинжлэх ухаан дахь ус төрийн язгуур хэллэг, хэрэглэж буй ойлголт, нэр томьёоны хэрэглүүрээрээ эдүгээ мөрдөгдөж буй төрийн барууны онолуудаас илүү баялаг, тэдгээрээс харьцангуй түлхүү боловсрогдсон болохыг нэгэн бүтээлдээ дэвшүүлжээ. Түүнийхээр бол, монголчуудыг төрт ёсны балар эртний уламжлалтай ба Өрнөдийн дэргэд монголчууд нэр томьёоны хэрэглүүрээрээ илүү хөгжсөнийг харуулж буй хэмээсэн нь дэлхийн төрийн онолын хөгжилд өөрийн өвөрмөц дуу хоолойг нэмэрлэж буй явдал төдийгүй "*Монголд эдүгээ баримталж буй либерал-ардчилсан төрийн онол нь хязгааргүй эрх чөлөө, чөлөөт өрсөлдөөнт зах зээлийн эдийн засаг, төр бол 'шөнийн манаач', хүн бүр амь амиа хичээх ёстой хэмээх зарчмууд дээр тулгуурласан байдаг учир хүний эрхийн хувьд шашин шүтэх, эс шүтэх, төрийн байгууллагад сонгох, сонгогдох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх болон бусад хувийн эрх чөлөөний хувьд амжилтыг олсон авч....*"[43] үнэн хэрэгтээ Монголд ядуурал, оюун сэтгэлгээний хомсдол, нийгмийн хөндийрөл, ганцаардал, эдийн засгийн уналт үлэмж нэмэгдэх байдал ажиглагдаж буйг мөнхүү бүтээлдээ тусгайлан анхааруулжээ. Тэгвэл, доктор А.Цанжид "Монгол Улсын хөгжлийн бодлогын зарим асуудал" хэмээх нэгэн бэсрэг өгүүлэлдээ "*Монгол орны онцлог, дэлхийн бусад улсууд, үүний дотор Азийн орнуудын хөгжсөн туршлагыг харгалзан хөгжлийн зарчмуудыг зөв томьёолохоос стратегийн боловсруулалт эхлэх ёстой. Чухам үүнээс тус орны онцлогт тохирсон өвөрмөц шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн цогцолборыг хөгжүүлэх зэрэг үндсэн алхмуудыг зарчим*

40 *Ганболд Ц. Монголын их, дээд сургуулиудад улс төр судлалын хичээлийг зааж буй байдал. "Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны өнөөгийн түвшин". ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. Улс төрийн шинжлэх ухааны холбоо. ред. Ганбат Д. "Бэмби сан" ХХК. Уб., 2006, 45 дахь тал*

41 *Жамбал А. Монгол Улсад улс төрийн шинжлэх ухааны үүсэн төлөвшиж байгаа нь. "Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны өнөөгийн түвшин". ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. Улс төрийн шинжлэх ухааны холбоо. ред. Ганбат Д. "Бэмби сан" ХХК. Уб., 2006, 32 дахь тал*

42 *Мөн тэнд., 48 дахь тал*

43 *Эрдэмт Ц. Төрийн тухайт Монгол онол: түүх, философи, хуулийн эш. Нэмж засварласан II хэвлэл. Уб., 2018, Choijil Publishers Co Ltd., 114-115, 152 дахь талууд*

*болгон хөгжүүлэх нь хөгжлийн бодлогод нийцсэн шинжлэх ухаан, технологийн судалгаа, хүний хүчин зүйлийн бодлогыг шат бүрд тодорхойлох хэрэгтэй"*[44] хэмээн мэдлэгээр жолоодогддог эдийн засаг, мэдлэгт суурилсан нийгэм буй болгох дэлхийн нийтийн чиг хандлагатай нийцэхийг онцолсон байна.

Чингэхлээр аль ч улс, үндэстний хувьд төв төр нь нийгмийн зайлшгүй хэрэгцээ болж анх үүсээд, мөн зайлшгүй улмаас оршиж, хувьссаар өдийг хүрсэн байгаль-нийгмийн шинж, гарвальтай түүхэн үзэгдэл аж. Түүгээрээ хүмүүс төрөлх заяагдмал эрхүүдээ бусдаас хамгаалах, хэрэгцээгээ төв төр хэмээх байгууллагын тусламжтайгаар хангахад хүрээгүйсэн бол төр гэдэг зүйл үүсэхгүй, оршихгүй бас өнөөдөр ч байхгүй байх аж. Харин нийгэм нь амьд байгалийн хөгжлийн үр дүн болох тул төрийн үүслийн нэгэн өвөг, дам шалтгаан нь байгаль, өөрөө мөн учраас төр төв нь байгаль ба нийгмийн шинж, гарвальтай үзэгдэл болохыг профессор Д.Чулуунжав[45] өөрийн бүтээлдээ цохон тэмдэглэжээ. Тэгвэл төрийн бодлого нь хүмүүсийн алс хэтийн язгуур сонирхол, хүсэл эрмэлзлийг өөртөө агуулж улс орон, ард түмнийхээ санаа бодлыг илэрхийлж байх утга учиртай ахул төрийн бодлогын гол хүрээ нь нийгмийн социаль харилцаа бөгөөд тэрхүү харилцааны асуудал дээр тулгуурлан эдийн засаг, соёл, үзэл суртальд хандах харилцаанаас бүрэлддэг аж. Тэрхүү бүрдэл нь монгол төрийн бодлогын үнэт зүйл мөн бөгөөд түүний гол систем нь эв нэгдэл, тусгаар тогтнолын үзэл санаа юм. Тусгаар тогтнол нь ямар нэг харийн улс орны эрхшээл, шахалтад орохгүйгээр зөвхөн үндэсний эрх ашиг, ард түмнийхээ хүсэл зорилгод нийцүүлэн, төрийн гадаад, дотоод бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх боломж, энэ тухай улс төр, эрх зүйн үндэсний болон олон улсын шинжтэй баталгаат нөхцөл бүрэлдэхийг хэлнэ. Энэ нь монгол төрийн үйл ажиллагааны гол тулгуур чиглэл болох түүний бодлогын үнэт зүйлс хийгээд төрийн бодлогын үнэт зүйлсийг хэрэгжүүлэхдээ үнэт зүйлсийн бүх хэлбэрийг жигд тогтвортой хэрэгжүүлэх, аль нэгийг нь нөгөөгөөс нь дутуу буюу онцгойлох нь төрийн бодлогын нэгдмэл шинжийг адагдуулахад хүргэж болзошгүйг ямагт бодолцож, бас анхаарч байхыг "Монгол төрийн бодлогын үнэт зүйлсийн хэрэгжилт" хэмээх бэсрэг өгүүлэлд[46] онцолжээ. Үүнээс үзвэл, улс төрийн шинжлэх ухаан, тэр дундаа улс төрийн философийн судлах асуудлын тухайд ухах ахул, улс төрийн ертөнц буюу нийгмийн улс төрийн ахуй бол баялаг агуулгатай, нарийн нийлмэл бүтэцтэй, хүний амьдралд чухал үүрэгтэй болохыг харуулахын хамт монголын нийгмийн улс төрийн түүх, ба өнөөгийн ээдрээтэй амьдралыг улс төрийн философийн үүднээс судлан шинжилж нэгтгэн дүгнэх, үнэлэлт өгөх хэрэгцээ бодитоор бий болсныг харуулж байна. Угтаа, нийгмийн улс төрийн амьдралд хийсэн шинэчлэлт нь *"иргэдийн тэгш эрхийг хангах, улс төрийн системийн элементүүдийн хооронд зөв зохистой, үр ашигтай харилцааны механизмыг тогтоох замаар нийгмийн улс төрийн ардчилсан шинэ тогтолцоог төлөвшүүлэхэд нэн чухал алхам"*[47] болоод зогсохгүй Монголын нийгэмд өрнөсөн ардчилсан өөрчлөлт нь ололт, амжилт, зөрчил бэрхшээлийн аль алийг нь өөртөө

44 *Цанжид А. Монгол Улсын хөгжлийн бодлогын зарим асуудал. "Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны өнөөгийн түвшин". ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. Улс төрийн шинжлэх ухааны холбоо. ред. Ганбат Д. "Бэмби сан" ХХК. Уб., 2006, 59, 60 дахь талууд*

45 *Чулуунжав Д. Монголын нийгмийн өвөрмөц байдалд тохирох төрийн засаглалын зохистой хэлбэр, хэмжээ, бүтэц, үүргийн асуудалд. ред. Чулуунбаатар Г. "Бэмби сан" ХХК. Уб., 2004// ФСЭХ., ШУА. Философи, эрх зүйн судлал-XXII. Чулуунжав Д. Төрийн хөгжлийн түүхэн тойм, логик төгсгөл. "Сансудай" ХХК. Уб., 2007, 158 дахь тал*

46 *Хишигдаваа А. Монгол төрийн бодлогын үнэт зүйлсийн уламжлал, хэрэгжилт. ФСЭХ., ШУА. Философи, эрх зүйн судлал-XXII. "Сансудай" ХХК. Уб., 2007, 225-232 дахь тал*

47 *Дашдаваа Ч. Улаан түүх. Түүхийн хүрээлэн., ШУА, СУИС. ред. Бат-Очир Л. "Адмон" ХХК. Уб., 2003, 82 дахь тал*

агуулсан түүхэн үйл явц болон төлөвшиж буйг харуулсан зүй тогтол юм.

Нөгөө талаас хууль тогтоох, гүйцэтгэх, хууль хэрэглэх онол арга зүйн хоцрогдол, хууль зүйн мэргэжлийн чадварлаг боловсон хүчний дутмагшлыг арилгах, практикт хууль зүйн онол, шинжлэх ухааныг үгүйсгэж, туршлагаас эх сурвалж авах хандлага газар авсан зэрэг, мөн нийгэмд төрд итгэх уламжлал, эрх зүйг үгүйсгэх сэтгэлгээ амь бөхтэй байгаа зэргээс шалтгаан ардчиллын суурь хэм хэмжээнүүд бодит биелэл болохгүй байгаа. Эл байдал зарим талаар өнөөг хүртэл амь бөхтэй оршсоор байгаа нь ардчилал, эрх зүйт ёсны сорилт болон Монгол Улсын нөхцөл байдалд тулгарч буйг судлаачид[48] онцлох болсон. Чухамдаа ардчилсан Үндсэн хууль бол монголчуудын нийгэм, улс төр, эдийн засаг, оюуны амьдралын цоо шинэ харилцааны эрх зүйн үндэс суурийг бий болгож, эрх чөлөө, хүний эрхийг орчин цагийн хүн төрөлхтний ойлголт ухаарлын түвшинд тавьж, төрийн байгууламж, тогтолцоог одоо цагийн бодит нөхцөлд нийлэхүйц, бусдын туршлага өөрийн ололтыг нэгтгэн шингээж төрийн ажил үйлийн салаа мөчрүүдийн харилцан хамаарал, эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэржилт, харилцан хяналтыг үйл ажиллагааны хэм хэмжээ болгон мөрдөхийг чухалчилсан ард түмний хамтын бүтээл учир хүн тань мэдсэн зүйлээ дээдэлж эрхэмлэдэг жамтай. Эс тэгвээс хууль зөрчихийн шалтгаан нь түүнийг таньж мэдээгүйн харгай гэж үзэхийг профессор Л.Дашням[49] дурджээ. Энэ бол нэн чухал санаа бөгөөд ардчилсан шинэ Үндсэн хуулийн (1992 оны) эхийг баригч, хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хууль Б.Чимид агсны нэгэнтээ онцолсон Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс хэмээхүйн ихэс дээдэст юуны өмнө хандсан өчил бөгөөд Үндсэн хуулиа таниулах, ойлгуулах санаанаас үүдсэн болов уу гэлтэй.

Нийгэмд ганц үзэл суртал ноёрхох бус олон үзэл санаа, хандлага байж болох ба илт харгис бус бол үзэл бодлоор хүмүүсийг гадуурхаж эрх чөлөөг нь хязгаарлаж болохгүй. Ардчиллын нэг үндсэн зарчим бол тухайн улсын иргэн, насанд хүрсэн хэн боловч сонгох, сонгогдох эрх эдэлдэг үүнийгээ ч Үндсэн хуульд тунхагласан. Энэ бол угтаа төр, засгийн бүх эрх мэдэл ард түмний гарт байх тухай асуудал төдийгүй өнөөгийн ардчилсан нийгэмд тэр тусмаа шийдвэр гаргах, бодлого боловсруулах түвшинд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх явдал нь "*...засаглалыг ардчилан төгөлдөржүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах, ядуурлыг бууруулах, ард иргэдийн тогтвортой сайн амьжиргааг хангах талаар дорвитой өөрчлөлт гаргах гэж зорьж байгаа тохиолдолд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг нь эрхэмлэн, ялангуяа улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо, чадамж боломжийг олгоход бид өөрсдийн ажлыг чиглүүлэх шаардлага гарч буйг дурдахын хамт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, чадамж, боломжийн талаарх үзэл номлолын өөрчлөлт зэрэг нь улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны асуудлыг агуулгын хувьд цоо шинээр авч үзэн*[50] *хөгжлийн бодлогод тусгах, улмаар улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог улам дээшлүүлэхийн тулд төр засгаас эмэгтэйчүүдийн мэдлэг, чадавх, нөөц бололцоо, туршлага, идэвх зүтгэлийг ашиглан тэдэнтэй хамтран ажиллах, төрийн болон иргэний нийгмийн хоорондын сайн харилцааг бэхжүүлэхэд тодорхой алхам хийх нь улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог жинхэнэ утгаар нь ойлгож, хэрэгжүүлж чадсанаар эмэгтэйчүүд хүн*

48 *Тэмүүжин Х. Монгол Улс дахь эрх зүйт ёсны төлөвшил, сорилт, бэрхшээл. "Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны өнөөгийн түвшин". ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. Улс төрийн шинжлэх ухааны холбоо. ред. Ганбат Д. "Бэмби сан" ХХК. Уб., 2006, 85 дахь тал*

49 *ФСЭХ., ШУА. Философи, эрх зүйн судлал-XXII. Дашням Л. Үндсэн хуулийг дээдлэн сахих, хамгаалж хөгжүүлэх асуудалд. "Сансудай" ХХК. Уб., 2007, 167 дахь тал*

50 *Социализмын дараах орны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг улс төрийн манлайлагч болоход илүү тохиромжтой гэж үздэг улс төрийн соёлтой аж. Дэлгэрэнгүйг http://www.idea.int/gender/upload/Matland/ ээс үзнэ үү.*

*амын тэн хагас нь байдгийн нэгэн адил шийдэл бүрийн тэн хагасыг эмэгтэйчүүд хариуцаж тэдний улс төр, нийгэмд эзлэх байх суурь, хувийн жин өсч, жендерийн асуудал бодит биеллээ олохыг чухалчлахыг..."*[51] нэн тэргүүнд авч үзэх нь зүйн хэрэг. Нэг үгээр хэлбэл, шинэ цагийн нийгмийн харилцаанд тулгарч буй сорилтын нэг бол шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх асуудал хурцаар тавигдаж буйн гол илрэл мөн. Судалгааны энэхүү чиглэлээр болон түүний илүү гүнзгийрүүлсэн судлагдахуунаар Ч.Өлзийсайхан, С.Түмэндэлгэр, Ц.Мөнхцэцэг, Я.Төгөлдөр, Ц.Одгэрэл, Т.Бүрэнжаргал, А.Саруул нарын олон эрдэмтэн судлаачид нэлээд тооны нарийвчилсан судалгаануудыг хийж байгаа нь энэ чиглэлийн судалгааг цаашид гүнзгийрүүлэхэд үлэмж ач холбогдолтой.

Социологийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Х.Гүндсамбуу XX зууны монголын нийгмийн бодит байдал бөгөөд түүний өөрчлөлт, хувьсал, эргэлтийг өргөн хүрээтэй, олон талт байдлаар Монголын нийгмийг үндсэн давхраануудын нийгмийн хөргийг нийгмийн бүтэц, давхраажил, түүхэн социологи зэрэг социологийн салбар ба тусгай онолын түвшинд зураглан гаргах чингэхдээ шилжилтийн үеийн нийгмийн давхраануудын сэргэлт, үүсэл, төлөвшил, ойрын ирээдүйг тодорхойлохыг давхраажлын онол-арга зүйн үүднээс судалсан байдаг. Тэрбээр өнөөгийн монгол төрийн байгууламжийн хувьд яахын аргагүй нэгдмэл нэг улс бөгөөд нүүдлийн болон суурин иргэншил зэрэгцсэний хувьд хоёр бүрэлдэхүүнт, олон хэсэглэл бүхий улс яахын аргагүй болчхоод байна. Иймд улсад барууны сонгодог ардчилал бус, харин арай энгийн эгэлдүү, хамгийн гол нь үндэсний эрх ашгийг дээдэлсэн нэгдэхүйн ардчиллыг хүлээн авч, түүгээр дамжин сонгодог ардчилалд дэвшин шилжиж магадгүй. Ардчиллыг олон ургальч үзлийн үүднээс бус, аль нэгийг нь туйлчлах явдал ардчилалд хүрэх бус, харин ч ухралт болох аюултайг дурдсан[52] байдаг. Тэрээр мөн Монгол Улсын шинэ үндсэн хуульд зааснаар *"эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилго"*[53] бодит биеллээ олох амин чухал нөхцөл бол ангиудад зохиомлоор хуваагдмал бус, харин жам ёсоороо давхраажих нийгэм байгуулах явдал мөн гэж үзсэн байна. Тэрбээр цааш нь *".... социалист Монголын нийгэм-ангийн бүтэц нь нийгмийн өмчийн харилцаагаар нөхцөлдөн үүсэж, төлөвшин хөгжиж байсан бол өнөөгийн Монголын нийгмийн давхраажил нь хувьчлал, түүний үр дагавар болох өмчийн олон хэлбэр, аж ахуйн олон хэвшилд үндэслэн бүрэлдсэн"* хэмээн дүгнэжээ. Ингэхээр аливаа нийгэмд хүмүүний эзлэх байр суурь тэгш бус, тэр нь хүмүүсийн хоорондын бүтэцлэг ялгарлаар тодорхойлогддог нийгмийн давхраажлаас шийдвэрлэх хэмжээгээр хамаардаг. Энэ утгаараа хувьчлал нь давхраажлын гарааны зурхай бөгөөд түүний эцсийн үр дүнгээс эсхүл нийгмийн үр дагавраас нийгмийн өнөөгийн давхраануудын үүсэл, төлөвшил, хөгжил шалтгаалах тул энэ асуудлыг олны санал бодлын үүднээс тусгайлан судалж[54] үр дүнд задлан шинжилгээ хийсэн нь өнөөгийн бидэнд чухал суурь үндэслэгээ болж байна.

Нөгөө талаар, энэхүү үүссэн нөхцөл байдал, учир шалтгааны мөн чанарыг шинжлэх зорилгоор профессор Г.Чулуунбаатар орчин үеийн Монгол дахь иргэншлийн өөрчлөлтийн үйл явцыг тодорхойлохдоо "*Монголын ард түмэн, монгол үндэстний*

---

51 ФСЭХ., ШУА. Философи, эрх зүйн судлал-XXII. Хатанболд О. Ардчиласан парламент дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх нь. "Сансудай" ХХК. Уб., 2007, 217-222 дахь тал

52 Гүндсамбуу Х. Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага (XX зуун). ред. Түдэв Ш. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академи. Уб., 2002, 5, 8 дахь талууд

53 АИХ. Монгол Улсын Үнсэн хууль. Уб., 1992, 3 дахь заалт

54 Гүндсамбуу Х. Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага (XX зуун). ред. Түдэв Ш. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академи. Уб., 2002, 609 дахь тал

*түүхэн уламжлал, онцлог шинэчлэлийн цогцол болсон "нэг улс-хоёр иргэншил" бүхий тогтолцоо нь олон зууны турш тогтнон хөгжихдөө уламжлал, шинэчлэлийн залгамж холбооны өвөрмөц хэлбэрийг бий болгосоор ирсэн нь эдүгээ дэлхий дахины хөгжлийн ерөнхий төлөв хандлагад хүн, байгаль хоёрыг эн сацуу эрхэмлэж тэдгээрийн зохицлыг дээдэлсэн иргэншил ирээдүйтэй болохыг бараг нийтээр хүлээн зөвшөөрч байна. Энэ хандлага нь дэлхий дахиныг хамарсан эрс өөрчлөлтийн үетэй давхцан хэрэгжиж байгаа нь түүний ирээдүйг улам баталгаажуулж"*[55] байгаа аж. Энэ бол, иргэд нь төрөө дээдэлж, төр нь иргэддээ үйлчлэн хамгаалах монгол ёс, хууль цаазыг эрхэмлэн сахих нарийн журам нь ардчилсан тогтолцоо болон иргэний ардчиллын орчин үеийн ололттой хослон хөгжих өргөн чадавхтай[56] болохыг онцолж буй хэрэг мөн. Түүнийхээр бол улс төрийн амьдралд дэлхийн иргэншлийн сүлжээний нөлөөлөл хоёр үндсэн чиглэлтэй бөгөөд түүний нэг нь дэлхийн улс төрийн амьдралд гарч байгаа дэвшилт өөрчлөлтийг судлан таньж түүгээр үндэсний иргэншлээ баяжуулах өргөн боломж олгож байгаа явдал, нөгөө нь үндэсний дэвшилт уламжлалаа бүрхэгдүүлэн орхигдуулах сөрөг чиглэл[57] аж. Чингэхлээр энэ хоёр чиглэлийн нөлөөллийн зохистой харьцааг зөв барьж нийгэм иргэншлийнхээ тогтолцоог уламжлан шинэчлэхэд манай өнөөгийн улс төрийн бодлогын гол агуулга чиглэгдэх ёстойг анхааруулж буй бөлгөө. Нөгөөтээгүүр, эрхэм профессорын эрдмийн бүтээлийн нэгэн эмхэтгэлд тусгайлан дэвшүүлсэн санаа бол *"... монголын нийгмийн улс төрийн өөрчлөлт, төрийн байгууламж, ардчилал болон засаглалын хөгжилд гарсан ахиц дэвшил, зогсолт, ухралт, тулгамдаж буй асуудал зэргийг тухайн түүхэн тодорхой цаг үед нь хөндөж судалсан нь Монгол оронд өрнөсөн ардчиллын үйл явцаар нийгэмд улс төрийн үзэл бодол, иргэний ашиг сонирхол, улс орныг хөгжүүлэхэд оролцох арга хэлбэр зэргээрээ ялгаа бүхий нийгмийн бүлгүүд үүсэн бий болсноор тэдний үзэл баримтлал, итгэл үнэмшлээ дагасан улс төрийн үйл ажиллагаа явуулах болсноор манайд олон намын тогтолцоо бүрэлдэж, улмаар монголын нийгмийн улс төрийн амьдралын олон ургальч ардчиллын хэлбэр хөгжиж ардчилсан үйл явцын өрнөл, нийгмийн улс төрийн амьдралын шинэчлэл, өөрчлөлтийн агуулга"*[58] тодорхойлогдох ажээ. Тиймээс ч нийгэмд нэгэнт бий болсон улс төрийн өөр хоорондоо ялгаа бүхий эрх ашгийг тодруулж, үзэл бодол, итгэл үнэмшлээ дагаж хүмүүс улс төрийн аливаа тэмцэл, хөдөлгөөнд нэгдэж нийлэхийн хамтаар улс төрийн намын нийгмийн төлөөллийг бүрдүүлж, мөн иргэдийг улс төрийн тэмцэлд сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдан нэгдэж, ардчилсан аргаар үзэл бодлоо илэрхийлэх боломжийг өрнүүлэх болсон нь монголын улс төрийн тогтолцоог олон талаас судлан тодорхойлох, задлан шинжлэх үндэс суурь болжээ.

Тэгвэл, эл суурь онцлогийг монгол хүний менталитеттэй хослуулан судлах оролдлогыг судлаач Д.Ганхуяг хийсэн байдаг. Тэрбээр нийгмийн аливаа өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэх эсэх нь аливаа улс үндэстний түүх, хөгжиж ирсэн нөхцөл байдал, газар зүйн орчин зэрэг нь өөр өөр байдаг нь угтаа түүнийг бусдаас ялгаатай үзэл бодол, зан үйлийн хэвшмэл шинжтэй болгодог бөгөөд тэрхүү

55 *Чулуунбаатар Г. Орчин үеийн Монгол дахь иргэншийн өөрчлөлтийн үйл явц. Социально-политические трансформации: идентичности и структурации в меняющемся мире. Доклады научно-практической конференции. ИФСиП МАН., Институт социологии РАН. "Сансудай" ХХК. Уб., 2010, 46 дахь тал*

56 *Чулуунбаатар Г. XX, XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. Эрдмийн бүтээлийн эмхтгэл. ФСЭХ., ШУА. "Сансудай" ХХК. Уб., 2008, 222 дахь тал*

57 *Мөн тэнд 225 дахь тал*

58 *Чулуунбаатар Г. XX, XXI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. Эрдмийн бүтээлийн эмхтгэл. ФСЭХ., ШУА. "Сансудай" ХХК. Уб., 2009, 11, 116 дахь талууд*

ялгаа нь менталитетыг хэр зэрэг харгалзсанаас[59] шалтгаалдгийг онцолсон. Энэ бол бодит байдлын субьектив дүр бөгөөд хүмүүсийн ертөнцийг ойлгох, ертөнцийг мэдрэх явдлыг тодорхойлж байдаг харьцангуй өнгөц, хувьсамтгай төсөөллийн цаад, тогтвортой өвөрмөц систем мөн аж. Өөрөөр хэлбэл, Монголд менталитетын суурь өөрчлөлт хоёр удаа болсон бөгөөд түүний эхнийх нь XIX зууны сүүлч, XX зууны эхээр Монгол Улс уламжлалт нийгмээс орчин үеийн нийгэмд шилжих тухайн үед нийгмийн асар их донсолгооны үе бөгөөд эл үед "уламжлалт" монгол хүний хэв маяг "социалист" монгол хүн болон өөрчлөгдсөн. Удаах суурь өөрчлөлт нь 1990-ээд оны өөрчлөлт шинэчлэлээр эхэлж, одоо үргэлжилж байгаа бөгөөд "социалист" монгол хүн "капиталист" монгол хүн болон өөрчлөгдөх үйл явц болон хувирсан болохыг *"Шинжлэх ухаан наашаа луйварчид цаашаа (2011-2013)"*[60] бүтээлдээ дурджээ. Энэ нь угтаа уламжлалт, социалист, капиталист гурван хэв маяг хүний амьдралын гурваас дөрөвхөн үеийн дотор солигдсон нь монгол хүний менталитет, тухайлбал, үнэт зүйлс, эрхэмлэл, зан араншныг ихээхэн зөрчилтэй, тодорхойгүй, чиг баримжаагүй болгож, нийгмийн харилцааг үлэмж зөрчилтэй бөгөөд ихээхэн онцлогтой болохыг харуулна.

Үүний зэрэгцээ Монголд өрнөсөн ардчиллын үйл явцын үр дүнд улс төрийн намууд шинээр үүсэж, олон намын тогтолцоо бүрэлдэх үйл явцыг улс төрийн шинжлэх ухааны хүрээнд нам судлалын тухайлсан салбар бий болон хөгжиж эхэлсэн нь төрийн засаглалыг хэрэгжүүлэх ардчилсан арга механизмыг бий болгоход чухал хувь нэмэр болсон. Энэ чиглэлээр Ж.Болдбаатар, А.Цанжид, В.Отгоннасан[61], А.Юндэндорж, М.Энхсайхан, Д.Баярхүү, Х.Гүндсамбуу, Ш.Содном, Б.Дэлгэрмаа[62], Б.Батжаргал, Д.Ганхуяг, Ч.Тамир нар зохих судалгааг хийсээр ирсэн билээ. Тухайлбал, доктор Д.Болд-Эрдэнэ монголын улс төрийн нам, намын системийн төлөвшлийн асуудлаар[63] гүнзгийрүүлэн судалж бие даасан нэг сэдэвт бүтээл туурвисан байдаг. Тэрхүү бүтээл нь орчин үеийн ардчилсан хэв шинж бүхий нам, намын системийн асуудлыг монголын өнөөгийн улс төрийн намуудын төлөвшил, хөгжлийн улс төр-философийн асуудлуудыг хөндсөн байна. Түүнээс гадна, монголын нам, намын системийн төлөвшилт, хөгжлийн статик хийгээд динамик зүй тогтлыг нээн илрүүлж, тэдгээрийн үйлчлэн илрэх өвөрмөц онцлог, үндсэн шинж, хандлагыг нь тодорхойлох явдлыг гол зорилго болгожээ. Цаашлаад 1990-ээд оноос хойш Монголд оршин үйлчилж байгаа нам, намын системийн онол практикийн асуудлыг хамарснаараа онцлогтой. Нам судлалын асуудлаар дагнан судалгаа хийж, эрдмийн зэрэг хамгаалсан шинэ үеийн

*59 Ганхуяг Д. Монгол хүний менталитетын асуудалд. Социально-политические трансформации: идентичности и структурации в меняющемся мире. Доклады научно-практической конференции. ИФСиП МАН., Институт социологии РАН. "Сансудай" ХХК. Уб., 2010, 84 дэх тал*

*60 Судлаач Х.Д.Ганхуяг. Шинжлэх ухаан наашаа луйварчид цаашаа (2011-2013 он). II боть. Тех.редактор. Доржсүрэн Т. "Мөнхийн үсэг" ХХК. Уб., 2016, 502 дахь тал*

*61 Отгоннасан В. Социология партийной работы: предмет, структур, функции и проблемы эффективности исследований. На опыт МНРП. Диссертацич на соискание ученой степени кандидата социологических наук. М., 1990*

*62 Дэлгэрмаа Б. Өнөөгийн монголын нийгэм дэх олон намын тогтолцооны төлөв байдал. "Шинэ толь" сэтгүүл. Уб., 2007, №59*

*63 Болд-Эрдэнэ Д. Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил. Улс төр, нам судлалын шинжилгээ. Нэмж засварласан II хэвлэл. ред. Чулуунбаатар Г., Содном Ш. ФСЭХ., ШУА. Уб., 2008, 5, 10, 13 дахь талууд*

төлөөлөл болох С.Мөнхбат[64], Э.Гэрэлт-Од[65], Т.Гантулга[66], Б.Эрдэнэдалай[67] нарын судалгаанд олон чухал шинэлэг санаа дүгнэлт дэвшигдсэн байх бөгөөд тэдгээрийн судалгаанд улс төрийн намын дотоод зохион байгуулалт, дотоод ардчилал, намын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр шинэлэг үнэ цэнтэй санаа, үндэслэлийг дэвшүүлсэн байдаг нь Монгол дахь нам судлалыг цаашид хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж байна. Тодруулбал, доктор (Ph.D) Э.Гэрэлт-Одын "*Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал (1990 оноос хойш)"* хэмээх зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлд[68] онцолсоноор бол, улс төрийн нам орчин үеийн ардчилалд улс төрийн төлөөллийг хэрэгжүүлэх, иргэдийн сонирхлыг илэрхийлэх, нэгтгэх онцгой үүрэгтэй институц болж байгаа нь гарцаагүй төлөөллийн ардчиллын бүтээгдэхүүн бөгөөд бид ардчиллын энэхүү хэлбэрээс гажих боломжгүй аж. Нөгөөтэээгүүр, улс төрийн нам дотоод ардчилалтай болсноор ардчиллыг хэрэгжүүлэгч институт болж төлөвшихийн сацуу олон түмний хүсэл зоригийг илэрхийлэх, улс төрийн амьдралд олон түмнийг идэвхтэй оролцуулах, нийгмийн өмнө хариуцлага хүлээх чадвартай болгох, төрийн албанд мэргэшсэн боловсон хүчин бэлтгэн элсүүлэх, олон түмнийг улс төрийн хувьд гэгээрүүлэх улмаар нийгэм төрийг холбох, ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг төлөвшүүлэх зэрэг үүргийг гүйцэтгэхийг чухалчилсан байна. Харин доктор (Ph.D) С.Мөнхбат *"Монгол дахь улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын асуудал" (Уб., 2009)* зэрэг горилсон бүтээлдээ[69] орчин үеийн улс төрийн намуудын нийгмийн төлөөллийн бүрдэлт, төлөвшилтийн үйл явцад нэлээд өөрчлөлт гарах хандлага ажиглагдах болсон нь өнөөгийн намууд нийгэм дэх тодорхой бүлэг, давхарга гэхээсээ илүү нийгмийн өргөн давхарга, сонгогч олон түмний санаа бодол, сэтгэл зүйд илүүтэй суурилах болсон. Үүний үндсэн шалтгаан нь дэлхий нийтийн амьдралын чанар, хүрээгээ тэлэхийн хэрээр нийгмийн социаль бүлгийн ашиг сонирхлыг урьтал болгосон бүлгийн шинжтэй уламжлалт намын хэв маягууд үеэ өнгөрөөж эхэлсэн явдал хэмээн үзсэн. Тэрбээр мөн манай намууд гишүүнчлэлээр хэтэрхий хөөцөлдөж, массын гишүүнчлэл бүхий олон түмний нам болон хувирсныг харуулж буй талаар онцолжээ.

Үүнээс дүгнэвэл, дэлхийн хоёрдугаар дайны дараагаас олон улсын харилцаа, улс төрийн бодит нөхцөл байдлын өөрчлөлт, хувьсалын шинж байдлаас хамааран улс төрийн намын үйл ажиллагааны хүрээ өргөжин, нийгэмд гүйцэтгэх үүрэг нөлөө улам бүр өргөжих болсонтой холбоотой намын улс төрийн үйл ажиллагаа хийгээд түүний санхүүжилтийн харилцааг нарийвчлан зохицуулах шаардлага, хэрэгцээ зүй ёсоор гарч ирэх болсон. Энэ нь намуудын сонгуульд оролцох оролцоо нэмэгдэж, улмаар тухайн цаг үеийн улс төрийн нөхцөл байдалд дасан зохицох, аялдан дагалдах байдал бий болсонтой холбоотой гэж үзэж болно. Үүнээс улбаалан, өнөөгийн улс төр, мөнгөний харьцааг зохистой хянах, намуудыг төлөвшүүлэх, эрүүл цэвэр улс төрийг хэлбэршүүлэх үүднээс улс төрийн намын санхүүжилт түүнд тавих хяналтыг дэлхийн

*64 Мөнхбат С. Монгол дахь улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын төлөвшлийн асуудал. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2009*

*65 Гэрэлт-Од Э. Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал (1990 оноос хойш). Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2009*

*66 Гантулга Т. Улс төрийн намуудын бодлого, үйл ажиллагааны шинэчлэлийн зарим асуудлууд. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2009*

*67 Эрдэнэдалай Б. Монгол дахь улс төрийн намын санжүүжилт: улс төр-эрх зүйн шинжилгээ. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2015*

*68 Гэрэлт-Од Э. Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал (1990 оноос хойш). Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2009, 126-128 дахь тал*

*69 Мөнхбат С. Монгол дахь улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын төлөвшлийн асуудал. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2009, 106, 109-110 дахь тал*

улс орнууд онцгой анхаарах[70] болсон. Энэ бүхэн намууд тодорхой тохиолдолд төрийн болон хувийн эх үүсвэрийн санхүүжилтээс харилцан хамааралтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Чингэхдээ улс төрийн орчны хүчтэй нөлөө хамаарал үр дүн чухал хэрэгтэйн дээр намуудын хувьд улс төр, удирдлага, зохион байгуулалтын хүч чармайлт гаргах нь эргэлзээгүй болохыг харуулж байна. Энэ чиглэлээр хэвлэгдсэн зарим өгүүллүүдийг тоймлон үзвэл, доктор (Ph.D) Д.Болд-Эрдэнэ орчин үеийн ардчилсан нийгэмд улс төрийн намуудын гүйцэтгэх үүрэг, байр суурийн асуудлыг онол шинжлэлийн түвшинд авч үзэж, энэ талын судлаачдын үзэл байр суурийг харьцуулан шинжлэхийн хамт Монголын өнөөгийн улс төрийн намуудын гүйцэтгэж буй үүрэг ардчилсан нийгэм дэх тэдний эзэлж буй байр суурь, жин нөлөөг нарийвчлан судалж “Ардчилсан нийгэм дэх улс төрийн намын чиг үүрэг” өгүүллийг нийтлүүлсэн байдаг. Мөн тэрбээр “Төрийн засаглалын харилцаан дахь нам”[71], “Нам, намын шинэчлэлийн философи”[72] болон “Монголын өнөөгийн намын систем: шинж, хандлага” (Д.Болд-Эрдэнэ, Г.Мөнхзул нар) өгүүллүүдэд намын философи хэмээхүйн талаар философийн хийсвэр оюунлаг язгуур агуулгаар нь бус харин нам, намын шинэчлэлийн эмпирик онол, философи, бодлого талаас онцолсон байдаг нь энэ чиглэлийн судалгааг гүнзгийрүүлэх, онол-практикийн үндэслэлийг тавих оролдлого байлаа.

Монгол дахь улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд манай эрдэмтдийн оруулсан нэг санаачилга бол дарангуйлагч дэглэмээс ардчилалд шилжилт хийж буй орнуудын улс төрийн тогтолцооны нэгэн чухал үйл явц болох сонгуулийн үйл явц түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгааг эрчимтэй хөгжүүлсэн явдал байлаа. Үнэндээ нийгмийн бүхий л салбарын ололт амжилт улс төрөөс хамааралтай бөгөөд улс төр хэрхэн төвхнөх нь сонгуулиа яаж явуулахаас эхэлнэ. Өөрөөр хэлбэл, сонгуулийн кампанит ажил гэдэг нь сонгогчдод сонголтоо хийх бүхий л боломж бололцоог бүрдүүлж өгдөг[73] үйл явц юм. Угтаа сонгуулийн тогтолцоог эрх баригч болон тухайн улс оронд гол үүрэг гүйцэтгэж буй том намууд өөртөө ашигтайгаар сонгох нь түгээмэл байдаг бөгөөд эл тохиолдолд жижиг намууд хүссэн, хүсээгүй уг тогтолцоонд захирагдан улс төрийн үйл ажиллагааны хүрээ нь хязгаарлагдаж, нэн ялангуяа сонгуульд амжилт олохгүй байх магадлал өндөрсдөг болохыг дурдсан нь мөнхүү сэдвийн цар хүрээг үлэмж нарийвчлан судлах оролдлого[74] болсон байна. Энэ чиглэлээр сүүлийн үед олон судлаачид нэлээдгүй судалгаа хийх болсон. Тухайлбал, доктор Ц.Мөнхцэцэг сонгуулийн кампанийн коммуникацыг Монгол Улсын жишээн дээр судлахдаа улс төрийн намуудын төлөвшил, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон түмний улс төрийн боловсрол, иргэний соёл зэрэг судалгааны болон практикийн мөн чанарыг тухайлан судалсан байна. Тэрбээр дээр дурдсан гурван субьектын хооронд явагдаж буй коммуникацын үйл ажиллагаа болох сонгуулийн кампанийг судалснаар улс төрийн коммуникацын чиг хандлагын асуудлыг илрүүлэн гаргахыг зорьж, улмаар Монголын сонгуулийн кампанийн коммуникацыг 2008 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн жишээн дээр авч үзсэн нь сонгуулийн үйл явцыг

70 *Эрдэнэдалай Б. Монгол дахь улс төрийн намын санжүүжилт: улс төр-эрх зүйн шинжилгээ. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2015, 17-18, 22 дахь талууд*

71 *ФСЭХ., ШУА. Философи, эрх зүйн судлал- XXVII. Уб., 2012*

72 *ФСЭХ., ШУА. Философи, эрх зүйн судлал- XXVIII. Уб, 2013, 196-209 дэх тал*

73 *Оюунчимэг Д., Өлзийсайхан Ч. Сонгуулийн компанийн үе дэх улс төрийн намууд, нэр дэвшигчдийн хариуцлага. “Ардчилал-нийгмийн хариуцлага”. Эрдэм шинжилгээний онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэл. ФСЭХ, МУИС, УТДС, Прогноз академи. “Сансудай” ХХК. Уб., 2010, 48-49 дэх тал*

74 *Философийн хүрээлэн., ШУА. “Философи эрхийн судлал-XXX”. Батболд Ц., Ганчимэг А. “Сонгууль ба ардчиллын онол, практикийн асуудалд”. “Тод бичиг” ХХК. Уб., 2015. 206-219 дахь талууд*

боловсронгуй болгоход эрх зүйн орчин чухал үүрэг гүйцэтгэхийг[75] чухалчилсан. Харин доктор Д.Баасансүрэн *"Монгол дахь сонгуулийн кампанийн технологи (Улс төрийн онолын шинжилгээ)"*[76] сэдвээр улс төрийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилж бичсэн нэг сэдэвт бүтээлдээ ардчиллын нөхцөлд сонгууль, сонгуулийн үйл явцтай холбоотой гарсан ямар нэгэн асуудлыг соргог мэдрэн оношилж, цаг тухай бүр нь нэг тийш нь шийдвэрлэхгүй бол цаг улирах тусам уг асуудал даамжран шийдвэрлэхэд төвөгтэй улс төрийн ноцтой үр дагаварт хүргэж болохыг манай орны туршлага, сургамж бэлхнээ харуулж буйг онцолсон байдаг. Түүнийхээр энэ нөхцөлд сонгуулийн тогтолцооны үйлчлэл, сонгууль явуулах арга технологитой холбогдсон олон чухал асуудлыг онцгой анхааран судлах, шинжлэх шаардлага бий болсныг тэмдэглэсэн байдаг. Цаашлаад монголын сонгуулийн кампанийн технологийг боловсронгуй болгох бодлого-зохицуулалтын механизм нь сонгуулийн үйл явц, технологийн шударга, ардчилсан мөн чанарыг бэхжүүлэх, түүний суурь үндсэн зарчмыг бодитой хэрэгжүүлэх, сонгуулийн кампанийн шинжлэх ухаанч чанарыг сайжруулахад чиглэгддэг тактик-зохицуулалтын механизмыг сонгуулийн дотоод үйл явцын технологитой хослуулан, улмаар эрх зүй-зохицуулалтын механизм бүхий сонгуулийн ардчилсан, чөлөөт, шударга мөн чанарыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц орчныг бүрдүүлэн түүнийг тууштай хэрэгжүүлснээр сонгуулийн үйл явц боловсронгуй болгосноор "цэвэр модернжсон" бүрэн төлөвшсөн хэлбэрийг бүрдүүлэх болно хэмээх сонирхолтой саналыг дэвшүүлсэн байна.

Бидний дэвшүүлсэн улс төрийн шинжлэх ухааны шинэ төлөвшилтийн үед судлаачид улс төрийн шинжлэх ухааны онол, практикийн олон арван өгүүлэл нийтлүүлснээс ийнхүү тоймлон үзвэл, улс төрийн сэтгэлгээ, уламжлалын асуудал, нам судлал, улс төрийн оролцоо, улс төрийн дэглэм, хүнд суртал, ардчилал судлал, сонгууль судлал, улс төрийн соёл, иргэний нийгэм, имиж судлал, эрх мэдэл хуваарилалт, глобалчлал, иргэдийн оролцоо, залуучуудын улс төрийн идэвх, улс төрийн сонирхлын бүлгийн асуудлууд багтаж байна. Түүнчлэн Монголын нийгмийн язгуур шинэчлэлтийн нөлөөгөөр улс төрийн шинжлэх ухааныг улс орондоо үүсгэн хөгжүүлэх, улмаар түүнийг төлөвшүүлэн бэхжүүлэх нь нийгмийн ерөнхий хэрэгцээ хийгээд түүнийг хангаж хэрэгжүүлэхэд шаардлагатай, тааламжтай нийгэм, улс төр, оюун санааны дотоод нөхцөл, бололцоо 1990-ээд оны эхэнд нэгэн зэрэг бий болж, хоорондоо онолдон шүтэлцсээр ирснийг бидэнд харуулж байна. Угтаа, энэ бол тухайн шинжлэх ухааны өөрийнх нь гадаад орчин нөхцөл болох дэлхийн улс төрийн шинжлэх ухааны зуу гаруй жилийн түүхэн замнал, хөгжлийн өндөр түвшинд хүрсэн байдал зэрэг нь түүнийг өөртөө нээж судлан эзэмших, тэрхүү шимтэй, бэлэн хөрсөнд үндэсний хэмжээнд нутагшуулан хөгжүүлэх явдал нэн чухал зорилт байсныг илтгэж байна. Тиймээс аливаа шинжлэх ухааны нэгэн адил улс төрийн шинжлэх ухааныг манайд жигдрүүлэн төлөвшүүлэх, цааш хөгжүүлэхэд чадварлаг мэргэжилтэн судлаач, багш бэлтгэх, судалгаа шинжилгээ, сургалт боловсролын байгууллагыг тийм мэргэжилтэн, хүрэлцээтэй орон тоо, санхүү, техник хэрэгсэл, хэвлэл мэдээлэл, зохион байгуулалт, гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар бэхжүүлж, хангахыг тэргүүн зэрэгт тавих хэрэгтэй. Чингэж гэмээ нь, энэ чиглэлийн судалгаа шинжилгээний чанар, хүртээмж нэмэгдэхийн зэрэгцээ дээр өгүүлсэн сорилт бэрхшээлийн асуудлуудыг шийдвэрлэх, өнөөгийн Монголд улс төрийн шинжлэх ухаан үүсэл төлөвшлийн аль шатад, ямар байдалтай байгаад тодорхой хэмжээгээр

*75 Мөнхцэцэг Ц. Сонгуулийн кампанийн коммуникац (Монгол Улсын жишээн дээр). Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2009, 3, 130 дахь талууд*

*76 Баасансүрэн Д. Монгол дахь сонгуулийн кампанийн технологи (Улс төрийн онолын шинжилгээ). Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2012, 3, 159, 161 дэх талууд*

хариу өгөх боломжийг олгож буй хэмээн бид үзэж байна. Хэдийгээр түүний үүсэл төлөвшлийн түвшин, төлөв байдлыг үнэн бодитой тогтоох нь цаашид тавих зорилт, шийдвэрлэх асуудлыг зөв тодорхойлж эл шинжлэх ухааныг үр нөлөөтэй хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой хэмээн дүгнэж болох юм.

***Тав. Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны судалгааны өнөөгийн байдал, цаашдын хандлага (2010 оноос- өнөөг хүртэл)***

Сүүлийн 20-иод жилийн хугацаанд Монгол Улс дахь улс төрийн шинжлэх ухааны салбарын хөгжил шинэ шатанд гарсан гэж үзэж болно. Учир нь их, дээд сургуулиудад мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ангиуд олноор буй болохын зэрэгцээ судлаачид орчин үеийн судалгааны онол, арга зүйг эзэмшиж, эрдэм судлалын ажилдаа өргөнөөр хэрэглэх болсон. Тэдгээрийн заримаас буюу сүүлийн хориод жилд гарсан томоохон суурь бүтээлүүдийн судалгааны үзэл баримтлал, дэвшүүлсэн санаа, авч үзсэн учир шалтгааныг энд он дарааллын байдлаар танилцуулахыг зорив. Чингэсэн нь Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны судалгааны өнөөгийн байдал, цаашдын хандлага хэрхэн хувьсан өөрчлөгдөж, улмаар бид юунд түлхүү анхаарах хэрэгтэйг олж мэдэхэд бага ч болов хувь нэмэр болох болов уу хэмээн үзэв.

Дурдан буй сэдвийн хүрээнд бид эхлээд эрдэм шинжилгээ, судалгааны хамтын бүтээлүүдэд хийсэн шинжилгээг энд оруулахыг зорилоо. Жишээлбэл, доктор, профессор Н.Лүндэндоржийн *"Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал"*[77](Уб.,2010) хэмээх бүтээлийн эмхэтгэлд улс төрийн тогтолцооны өөрчлөлт нь иргэдийн эрх тэгш байх, улс төрийн амьдралд шууд оролцох, хувийн шийдвэр гаргах бололцоо бүхий төрийн байгуулал, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдэж байна уу эсвэл улс төр-эдийн засгийн онцгой бүлгийн эрх ямбыг бататган тогтоох зүг рүү алхам хийж байна уу гэдгийг ажиглан харж, амьдралын идэвхтэй байр суурь баримталж байх нь шилжилтийн орнуудын иргэдийн нэн чухал үүрэг болохыг тухайлан авч үзсэн явдал байв. Тэрбээр улс төрийн тогтолцооны өөрчлөлтийг бид өнөөдрийг хүртэл ихэвчлэн бүтэц, зохион байгуулалтын талаас авч үзээд байдаг атлаа тэрхүү тогтолцооны зөөгч, агуулагч болсон хүний улс төрийн соёл, сэтгэлгээний өөрчлөлт, хувьслыг тэр болгон судалж тодорхойлохыг хичээдэггүй. Угтаа өнөөгийн монголчуудын улс төр, эрх зүйн сэтгэлгээнд гарсан эерэг хувьсал, өөрчлөлтийг зөв тодорхойлох нь судалгааны төдийгүй шинжлэх ухаанч улс төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцын нэг чухал хэрэглэгдэхүүн болохыг онцолжээ. Бүтээлийн төгсгөлд, зохиогч дурдан буй үеийн монголын улс төр, эрх зүйн сэтгэлгээнд гарсан хувьсал, өөрчлөлтийг *"... нэгд, ангич, намч онол, үзэл суртал, намын бодлого шийдвэрийг дээдэлдэг үзэл сэтгэлгээ Үндсэн хууль, хууль дээдлэх сэтгэлгээгээр солигдох нөхцөл бүрэлдэж буй; хоёрт, намаар хамгаалагдаж, амьдралын баталгаагаа бүрдүүлнэ гэсэн үзэл сэтгэлгээ хуулиар хамгаалуулж, хувийн ашиг сонирхлоо хэрэгжүүлж амьдарна гэсэн үзэл санаагаар өөрчлөгдсөн; гуравт, хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөө үндэслэхээ болих, хүний эрх, эрх чөлөө хуулийн үндэс болох чиг хандлагыг баримтлах болсон; дөрөвт, хуулийн амин сүнсэнд намын бодлого, шийдвэр, үзэл суртал давамгайлж байсан үеийг даван туулж, хууль тогтоомж өөрийн зүй ёсны амин сүнснүүдийг тодорхой хэмжээгээр агуулж, чөлөөт ардчилсан сонгуулиар ард түмнээс мандат авсан элч төлөөлөгчид хууль тогтоодог түгээмэл жишиг, технологиор хууль тогтоодог болсноор хууль дээдлэгдэх, хүлээн зөвшөөрөгдөх сэтгэлгээ бүрэлдэн төлөвшиж буйг; тавд, төрийн эрх мэдлийг харилцан тэнцвэр,*

77 *Лүндэндорж Н. Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал. Бүтээлийн эмхэтгэл. Засгийн газрын хэвлэх үйлдвэр. Уб., 2010, 7, 192-193 дахь талууд*

*хяналт бүхий бие даасан өндөрлөгүүдэд хуваарилж, хүний эрх, эрх чөлөөний Үндсэн хуулийн баталгааг бүрдүүлснээр иргэд Үндсэн хуулиар олгосон, хамгаалуулсан механизмын дагуу эрхээ эдэлж, үүргээ хэрэгжүүлэх ухамсар, соёл бүрэлдэнэ хэмээн итгэдэг болсон; зургаад, нам төвтэй улс төрийн тогтолцооноос төр төвтэй улс төрийн тогтолцоонд шилжих, хүний эрх, эрх чөлөө хууль дээдэлсэн эрх зүйт төрийн үзэл баримтлалыг Үндсэн хуулиараа тунхагласан нь ардчилсан төрийн тогтолцоонд шилжих, төр ард түмнээс эх үндэстэй, иргэнлэг шинж чанартай болох улмаар хууль дээдлэгдэх, төр хүлээн зөвшөөрөгдөх үзэл, сэтгэлгээг төлөвшүүлэх эхлэл болсон; долоод, монголын ард түмэн төрд үйлчилнэ гэсэн тоталитар сэтгэлгээнээс хөндийрч, “төр иргэний нийгмийг бус иргэний нийгэм төрийг нөхцөлдүүлнэ” гэсэн үзэл санаанд шилжих, иргэний нийгэм төр харилцан тэнцвэртэй, хяналттай орших хууль зүйн бололцоог бүрдүүлэхэд сэтгэлгээний болоод үйл ажиллагааны ахиц өөрчлөлт гарах болсон; наймд, сонгуулийн ардчилсан тогтолцоонд шилжсэнээр төрийг удирдах үйл хэрэгт ард түмэн оролцох, төрийн эрх мэдэл ард түмнээс эхтэй, засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна”* хэмээхүйн сонгодог үндэслэлүүдийг дэвшүүлсэн байна. Эдгээрийн утга санааг тайлах ахул Монголын улс төр, эрх зүйн сэтгэлгээнд төлөвшиж, үйл ажиллагааны хүрээнд шилжсэн явдал ажээ.

Тэгвэл, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр судлалын салбарын эрдмийн хамт олон дээрх үйл явцтай хөл нийлүүлэн алхаж, суурь судалгааны төслүүдийг хэрэгжүүлж, нэг сэдэвт болон хамтын бүтээлүүд, олон арван эрдэм шинжилгээний өгүүллүүдийг нийтлүүлсэн байна. Тэдгээрээс дурдвал, тус хүрээлэнгийн Улс төр судлалын салбар 2011 онд *“Монголын ардчиллын төлөвшил”*[78] сэдэвт хамтын бүтээлийг боловсруулан туурвиж эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны үйл ажиллагаанд нэвтрүүлжээ. Тус хамтын бүтээлд оролцсон судлаачид дараах үндсэн зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлэхийг хичээсэн байна. Үүнд *(i) Монголын нийгмийн улс төрийн хүрээний өөрчлөлтийн өнгөрсөн 20 жилийн ололт амжилт, туршлага сургамжийг нэгтгэн шинжлэх; (ii) энэ хугацаанд хийгдэж амжаагүй, дутуу бодож шийдсэн одоо хүндрэл бэрхшээл учруулж буй тулгамдсан асуудлыг судлан тодруулах; (iii) тэдгээр бэрхшээл асуудлыг шийдвэрлэх арга замын талаар* тодорхой зөвлөмжийг санал болгох оролдлогыг хийсэн байна. Ингэхдээ Монголын нийгмийн улс төрийн хүрээний өөрчлөлтийн хүрсэн түвшин энэ хүрээнд хуримтлагдсан олон төвөгтэй асуудлыг шийдвэрлэх өнөөгийн цаг үеийн зайлшгүй шаардлага хэрэгцээг эш үндэс болгон тавьжээ. Цаашлаад Монголын ардчиллын туулж ирсэн амаргүй замналыг нэгтгэн авч үзэхдээ түүний хүрээнд хэрэгжиж буй ардчилал, ардчиллын үзэл санаа төрийн байгууламжийн төлөвшил, улс төрийн нам, намын тогтолцоо болон иргэний нийгмийн байгууллага, ард түмний улс төрийн соёлын төлөвшилтийн үйл явцын содон онцлог, бэрхшээл асуудал, тэдгээрийг шийдвэрлэх, боловсронгуй болгоход нөлөөлж буй хүчин зүйл, зохистой арга замыг онол, практикийн үүднээс угтан баримжаалах оролдлого хийжээ. Тодруулбал, Монголын улс төрийн тогтолцоог боловсронгуй болгоход дээр дурдсан хүчин зүйлс ямар үүрэг нөлөөтэй болохыг судлан шинжлэх явцдаа тэдгээрийн цаашдын төлөв хандлагын тойм дүр зургийг гаргахыг хичээсэнд энэхүү бүтээлийн гол ач холбогдол оршиж байна.

Тэгвэл, Философийн хүрээлэнгийн эрдмийн хамт олны туурвисан *“Монголын нийгмийн өөрчлөлт”*[79] *(Уб., 2008, I хэвлэл)* хамтын бүтээлийн бүх сэдэвчилсэн гарчиг

---

78 *ФСЭХ., ШУА. Монголын ардчиллын төлөвшил. Хамтын бүтээл. ред. Чулуунбаатар Г., Ганбат Д., ба бусад. ХҮЗХ-ийн хэвлэх үйлдвэр. Уб., 2011*

79 *ФСЭХ., ШУА. Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. I дэх хэвлэл. ред.Даш-Ёндон Б.”Сансудай”*

тус бүрд иргэний нийгмийн төлөвшилт, авлига, төрийн үйл ажиллагааны байдалд шүүмжлэлтэйгээр хандсан байдаг. Учир нь хамтын бүтээлийн зохиогч нар субьектив санаа бодол байр сууринаас хандахаас аль болох зайлсхийж, харин яаралтай засаж залруулбал зохих, түгшүүрийн дохио өгсөн хэрээс хэтэрсэн түвшинд хүрээд байгаа зүйлсийн бодит байдлын тусгалыг олж гаргахыг хичээсэн. Тодруулбал, бүх хүн амжилтад хүрэх, хүн бүрийг сайхан амьдруулах, хүн бүрийг хөгжүүлэх өргөн уудам бөгөөд эн тэнцүү боломжийг нээж гаргах нь жинхэнэ шударга ёсны үндсэн агуулга байдаг тул энэ нь төрийн бодлогоор шийдэгдэх ёстой гол углуурга асуудал гэдгийг онцолжээ. Тэрхүү шударга ёсыг зөвхөн хуваарилалтын зарчим дээр бодох, эсхүл хүн бүр хуулийн өмнө тэгш байх зарчимтай хутгах, эсхүл ёс суртахууны энэ тайлал ойлголтыг холих зэргээс зааг гарч чадахгүй байгаа нь эцэстээ хэсэг, бүхэл хоёрын ялгааг гарган мөрдөж чадахгүй далайц муутай цар хүрээндээ хумигдсан явцуу сэтгэлгээ улс орны хөгжилд саад тотгор учруулж болзошгүй. Ийм тохиолдолд шинжлэх ухаанч, алсыг харсан, бүхнийг хамарсан өргөн цар хүрээтэй улс төрийн бодлогын дүнд л монголчууд бидний улс орондоо зайлшгүй хэрэгтэй гарц, гаргалгааг гарган түүнийг төлөвшүүлэх хөгжих гарцыг эл бүтээлд чухалчилсан. Тэгвэл хамтын бүтээлийн хоёр дахь хэвлэлийг[80] дээрхээс даруй таван жилийн дараа гаргахад нөхцөл байдал урт биш ч гэлээ хагас арваны хугацаанд хэрхэн өөрчлөгдсөнийг тодруулахад мөн л сонирхолтой дүр зураг гарсан байдаг. Тухайлбал, ардчиллыг хөгжүүлэх тухайд гэвэл эхлээд эрх чөлөө байх ёстой ингэж байж шударга ёс биелэх учиртайг харуулсан. Нөгөө талаар ганцаар эзэгнэн захирагчийг бүлэг бялдуучид тойрон хүрээлсэн, шүүмжлэл хаалттай нийгмийн нийцэлд шударга ёсны тухай ярих боломжгүйтэй адил ардчилал нь боловсорсон, хөгжсөн, нээлттэй болсон гэх утгаараа нийгэм бүрд адилгүй байж болох авч ардчилал нь тухайн ард түмний өнгөрүүлсэн түүх, уламжлал, улс төрийн институт, хүмүүжүүлдэг арга учраас тэр нь хүмүүсээс хамаардаг болохыг зохиогчид онцлон тэмдэглэсэн байна. Нөгөө талаар, монголын нийгмийн өөрчлөлтийн асуудлыг сонгон авч оролдсон энэхүү судалгаа нь зүгээр нэг өөрчлөлтийн байдлыг харуулах бус, гагцхүү судалгаанд оролцсон эрдэмтэд нийгмийн амьдралын жам хуулийг сануулж, бидний амьдралд зөв хандлагад оруулах санаа бодлоо хэлэхэд гол анхаарлаа хандуулсан нь чухал байв. Ийнхүү Монголын нийгмийн өөрчлөлтийн асуудлаар өмнө нь болон энэ удаа хийсэн судалгаа нь үндсэндээ өнөөгийн хүрсэн бодит байдлыг харуулах, цаашлаад санаа өгөх, сэдэл болох чиглэлтэй байснаараа чухал ач холбогдолтой болохыг онцлох нь зүйтэй болов уу.

Бидний дараагийн дурдан буй бүтээл бол "*Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал*"[81] *(Уб., 2014)* хэмээх хамтын бүтээл юм. Эл хамтын бүтээлийн зохиогчид (i) Монгол Улсын сүүлийн хорь гаруй жилийн иргэний нийгмийн төлөвшил, хөгжлийн төлөв байдал, ололт амжилт, туршлага, сургамжийг философи, улс төр, эрх зүйн үүднээс нэгтгэн шинжлэх; мөн (ii) эл хугацаанд иргэний нийгэм байгуулах явцад гарч буй хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлуудыг судлан тодруулах; (iii) иргэний нийгмийн төлөвшлийн цаашдын чиг хандлагын талаар санаа бодлоо илэрхийлэх; (iv) иргэний нийгмийг цогцлуулан хөгжүүлэхэд учирч буй бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх арга замыг шинжлэх зэрэг зорилтыг дэвшүүлсэн байна. Энэ зорилтын гарц шийдлийг тодруулж

*ХХК. Уб., 2008, 397-407 дахь тал*

80 *ФСЭХ., ШУА. Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. II дахь хэвлэл. ред.Чулуунбаатар Г., Даш-Ёндон Б. "Бэмби сан" ХХК. Уб., 2013. 400-402 дахь тал*

81 *ФСЭЗХ., ШУА. Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал. Хамтын бүтээл. ред. Амарсанаа Ж., Ган-Өлзий Ч., Болд-Эрдэнэ Д. "Бэмби сан" ХХК. Уб., 2014. 8-10 дахь тал*

дараах сонирхолтой, шинэлэг дүгнэлтийг хийжээ. Тухайлбал, Монгол Улс дахь иргэний нийгмийн төлөвшлийн өнөөгийн төлөв, хандлагын талаар "Иргэний нийгэм зохих ёсоор хөгжиж чадаагүй боловч хөгжлийн эхэн шатанд дундаж түвшинтэй байна"; Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах явцад учирч буй гол бэрхшээлийг "... иргэд иргэний нийгэм, сонирхлын бүлэг, иргэний оролцооны талаар мэдлэг, мэдээлэл хомс байгаа явдлыг...."; Иргэний нийгмийн байгууллагын төлөвшил, хөгжлийн талаар "Иргэний нийгмийн байгууллагын дотоод институтчлэл эхлэл төдий, гадаадын байгууллагаас санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлдэг учир чадавх сул, тодорхой чиглэлээр мэргэшээгүй, хувийн хэвшил, төрийн байгууллагатай хамтран ажиллах соёл, эрх зүйн орчин төлөвшөөгүй..."; мөн иргэдийн улс төрийн оролцооны хувьд идэвхгүй хэлбэр давамгайлах хандлагатай байгаа зэргийг онцлон дүгнэжээ.

Эл бүтээлээс гарсан дүгнэлтүүдийг бусад төрлийн судалгаатай харьцуулахад харьцангуй дөхөж очсон дүгнэлт болжээ хэмээн үзэж болохоор. Тухайлбал, доктор (Ph.D) Ж.Төртогтохын[82] туурвисан нэг сэдэвт бүтээлд иргэний нийгэм төлөвшин хөгжих нь хэрэг дээрээ ардчилсан эрх үүрэг, эрх чөлөөний бүх хэлбэр, хувийн санаачилга, бие даасан үйл ажиллагааны эрх чөлөө, улс төр, соёлын аливаа мэдээллээр үйлчлүүлэх эрх чөлөө зэрэг нийгмийн социаль хүрээн дэх нэгэн төрлийн орон зайг бий болгох үйл явц ажээ. Тэрбээр дээрх санаагаа дэлгэрүүлэн тайлбарлахдаа эрх зүйт төр, иргэний нийгэм, хүний эрх, эрх чөлөөний асуудлыг хөндөөд орхих бус, харин ч иргэний нийгмийг нийгэм-эдийн засаг, соёл, шашны үндсэн уулзвар дээр судалж, улмаар төрийн шууд оролцоогүйгээр өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх боломцоогоор хангагддаг бие хүмүүс, хамт олны нийтлэг мөн чанартай болохыг тодорхойлсон нь сонирхол татахуйц дүгнэлт юм. Нөгөө талаар, иргэний нийгмийг төлөвшүүлэхэд иргэдийн оролцооны асуудал чухал бөгөөд ардчилсан засаглал дахь иргэний нийгэм болоод нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог идэвхтэй татан оролцуулж, "*иргэдийн санаачилгыг өрнүүлэх*" орчин нөхцөлийг бүрдүүлэх явдал мөн. Ингэхдээ эрх зүйн оновчтой зохицуулалт, дэмжлэгээр хангаж, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө идэвхийлэн оролцох замаар ардчилал, ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэх манлайллыг бий болгоход ард түмэн өөрөө засаглах эрхийг бодитой хянах бүх талын боломцоог хангахад шаардлагатай хүчин зүйлсийг тодруулахыг зорих ёстой. Угтаа иргэний нийгэм нь өөрөө хүмүүс хоорондоо бие биеэ дэмжих зорилгоор өөрсдийн хэрэгцээ шаардлагыг олж таних, хамтын шийдвэр гаргах, харилцан мэдээлэл солилцох замаар өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд чиглэгдсэн байж чадах аваас аливаа хурцадмал асуудлуудыг шийдвэрлэх, шийдвэр гаргах үйл явцад оролцох байдлаар илэрхийлэгддэг хамтын үйл ажиллагааны боломжийг бүрдүүлэх зохист хувилбарыг дэвшүүлэн, тэдгээрийн ач холбогдлыг бий болгох явдал болохыг[83] онцлох хэрэгтэй. Түүнээс гадна, иргэд, иргэний нийгмийн төлөөллийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь иргэний нийгэм оршин байх үндэс мөн. Чингэхдээ ардчилсан засаглалтай дийлэнх улсад засгийн эрхийг зөвхөн ард түмэн эрхэлнэ гэдгийг тусгайлан зааж өгсөн байдаг. Монгол Улс 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д *"...итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй..."* хэмээн заасан нь эрх зүйн хувьд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө баталгаажсаны үр дүн юм. Эрх зүйн талаас эрх чөлөө гэдэг нь хүн өөрийн үзэл

*82 Төртогтох Ж. Үндсэн хуулийн политологийн шинжилгээ. МУИС. "Соёмбо принтинг" ХХК. Уб., 2010*

*83 ФСЭЗХ., ШУА. Философи, эрх зүйн судлал- XXVIII. Хатанболд О. Ардчилсан засаглал дахь иргэний нийгмийн зарим асуудал. "Бэмби сан" ХХК. Уб., 2013, 231-253 дэх тал*

баримтлал, үйл ажиллагаандаа гадныг ямар нэг дарамтгүйгээр тусгаар тогтносон байхыг хэлдэг. Хувь хүний эрх чөлөөний зарчим нь иргэний нийгэм болон төрийн байгууллагад оролцох эрхээр баталгаажиж байдаг. Иймд оролцоог бодитой болгохын тулд аливаа ардчилсан улс нь иргэдийнхээ үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй[84] билээ. Энэ талаар доктор (Sc.D), профессор Д.Дашпүрэв "Монгол дахь иргэний нийгэм ба улс төрийн бодлого" (Уб., 2014) өгүүлэлдээ *"Монгол дахь иргэний нийгмийн олон талт асуудлыг цогцоор нь авч үзэхийг зорьсонгүй. Зөвхөн төр, засгийн явуулж буй улс төрийн бодлоготой уялдуулан асуудлын зарим нэг талыг авч үзлээ"* хэмээн онцлон тэмдэглэсэн нь бий.

Дээр дурдсан хамтын бүтээлүүд, судалгаа шинжилгээний өгүүллүүдээс гадна улс төрийн шинжлэх ухааны төлөвшилд судалгааны мэргэшсэн чиглэлүүдийг нэмэгдүүлэхэд энэ салбарын эрдэмтэн судлаачид чухал хувь нэмэр оруулж ирснийг дурдах нь зүйтэй болов уу. Тухайлбал, Монголын ардчиллын үнэлгээ, онол, арга зүйн асуудлыг нарийвчлан судлахад доктор Д.Ганбат, доктор О.Хатанболд нарын бүтээлүүд чиглэгдсэн байдаг. Тодруулж хэлбэл, доктор (Ph.D) Д.Ганбат монголчууд ардчиллыг ерөнхий идеал агуулгаар хүлээн зөвшөөрч буй болохоос бус тэдэнд түүний талаар сайтар ухааран таньсан тодорхой ойлголт, үзэл төсөөлөл хараахан бүрэлдэж чадаагүйг нэлээд онцолсон байдаг. Тухайлбал, өнөөдөр бид ардчиллыг ам булаалдан сайрхан магтах эсвэл эс дэмжин, сэтгэлийн хөөрлөөр муучлан гутаах туйлшралаас хэтрэхгүй байгаагийн зэрэгцээ монголчууд ардчиллыг аман дээрээ дэмжиж буй боловч ажил хэргээр төдийлөн бодитой дэмжих нь дутмаг байгаа нь угтаа *"өнөөдөр ардчиллыг зөвхөн амаараа дэмжих нь бараг нийтлэг дүр зураг болсон"-ыг* илэрхийлсэн нь үүний нэг тод илрэл юм. Тэрээр цааш нь дүгнэхдээ "*ардчилал нь хамт амьдарч, хамтран ажиллах үйл явц бөгөөд хөдөлгөөнгүй хөшүүн биш харин байнга хувьсан өөрчлөгддөг үйл явц хийгээд, гагцхүү иргэн бүрээс хамтран ажиллах, харилцан буулт хийх, хүлцэнгүй хүлээцтэй байхыг шаарддаг. Үүнийг жам ёсоор нь хөгжүүлэх нь амаргүй боловч хүнд бэрх зүйл. Эрх чөлөө гэдэг нь хариуцлага гэсэн үг болохоос хариуцлагаас ангид чөлөөтэй байх гэсэн үг биш юм. Тодруулбал, ардчилал нь эрх чөлөө, санаа бодлоо илэрхийлэх эрхэм нандин зүйлийг өөртөө шингээсэн байдгаас гадна хүний төрөлхийн чанарыг бас бодолцдог гэж хэлж болно. Тиймээс ч ардчилал бол иргэн бүрээ өв тэгш авьяас билэг төгөлдөр байхыг шаарддаггүй, харин хүн бүр хариуцлагатай байхыг хүсэмжилдэг зүйл юм. Тэгвэл, ардчилал хэмээгчийн янз янзын бүрэлдүүлэгч хэсэг нь давхцахаас гадна бас нэг нэгнээсээ хамаардаг зүйл юм. Энэхүү харилцаа уялдааг тодорхойлохын тулд бид ардчиллын чанарыг нэгэн бүхэл тогтолцоо гэж үзвэл, нэг хэмжүүрийн сайжралт нь нөгөөдөө эргээр нөлөөлөх учиртай"*[85] хэмээн тодорхойлсон байна.

Үүнээс үзвэл, монголын ардчилал хийгээд монголчууд бид ардчиллаар олсон ололт амжилт, алдаа дутагдал бүхнээ өргөн хүрээтэй, цогц үзэгдэл хэмээн үзэж, улмаар улс төрийн ээдрээтэй сонголт бүрийн цаана томоохон саад тотгор бийг ухааран ойлгож, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа бүрийнхээ нарийн цогц стратегийг хэрэгжүүлэхэд тулгарч буй төвөгтэй асуудлыг хамтдаа үнэнч шударга, бодитоор олж танин шийдвэрлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, бидний цааш явах гарц бол аливаа нэг засаглалын шинэчлэл хийхдээ улс төрийн хүсэл зориг, шаргуу оролдлого, тэсвэр тэвчээртэй, ухаалаг алсыг харж тунгаасан цэгцтэй байдлыг шаардах болно. Эндээс

*84 Мөн тэнд., 257 дахь тал*

*85 Ганбат Д. Ардчиллагдах үйл явц ба монголчуудын үнэлэмж. "Хүний эрхийг хангаж ардчилсан засаглалыг бэхжүүлэх мянганы хөгжлийн зорилго". Үндэсний зөвлөлдөх уулзалтын илтгэлийн эмхтгэл. "Сансудай" ХХК. Уб., 2008. 66-68 дахь тал*

л бидний эрх мэдлийг төвлөрүүлэхээс сэргийлж, хариуцлага хүлээх чадвартай улс төрийн системийг урамшуулдаг ардчилсан механизмтай байх хариуцлагын тогтолцоог нэн яаралтай цогцлоохыг шаардана. Тиймээс бидний ирээдүйн алхам бол чөлөөтэй, шударга явагддаг сонгуультай байх, түүний төлөөллийг хангасан, мэдрэмжтэй засаглалын институцийг бэхжүүлэх, хэвлэлийн эрх чөлөөг хангах, ард түмэнд санал бодлоо илэрхийлэх боломжийг улам бүр баталгаажуулах, хариуцлага хүлээх чадвартай бүх төвшний иргэдийн практик дээр суурилсан өөрсдийн эрхийн тухай мэдлэг, төрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл, мэдээллийн чөлөөт урсгал, үнэн зөв бодитой төлөвлөлт, бүх шатны төрийн байгууллагуудын дүрэм журам, үйл ажиллагааны ил тод байдлаас шалтгаалахыг *"Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр"*[86] *(Уб., 2017)* хэмээх бүтээлд онцолсон байна. Түүнчлэн энэ талаарх санаа нь орчин үеийн ардчиллын суурь онолуудын хүрээнд дэвшигдэж буй *"ард түмний засаглах дээд эрх мэдэл"*-ийн тухай концепц, иргэдийн амьдрал дахь ардчиллын төрөлхийн үнэ цэнийн тухай үндэслэл, улс төрийн шийдвэрт ардчилал инструментал (арга хэрэгслийн) болон конструктив (бүтээцийн) учир холбогдолтой болох үзэл санааг монголын ардчиллын үнэлгээний онол, арга зүйн суурь болгох арга замыг нарийвчилсан онолын логик матриксыг боловсруулан тодорхойлох оролдлого хийсэн нь энэ төрлийн судалгаанд шинэлэг арга зүй болсныг "*Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс"* сэдвээр улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээлээс харагдана. Тиймээс Монгол Улс ардчилалд шилжсэн гуч орчим жилийн хугацаанд ардчиллын тухай Монгол хүний ойлголт, төсөөлөл өвөрмөц байдлаар хувьсан өөрчлөгдөж ирснийг тодруулах оролдлого хийсэн нь илт. Ингэхдээ эхлээд ардчилал бол дан ганц зөвхөн "эрх чөлөө" гэсэн тунхаглалын шинжтэй ойлголт давамгайлж байсан бол дараа нь ардчилал бол *"шударга чөлөөт сонгууль"* гэсэн үзэл баримтлал давамгайлах болсныг судалгааны үр дүнгээр нотолжээ. Гэвч сүүлийн жилүүдэд ардчиллын хөгжилд гардаг сөрөг үзэгдлүүд, тухайлбал, улс төр-бизнесийн бүлэглэл бий болж, нам, бүлгээр талцан олон түмнийг бухимдуулах явдал газар авснаас ардчиллын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх хандлага бий болсныг онцолжээ. Үүний үр дүнгээр *"ардчилал бол иргэдийн оролцоо, иргэний нийгмийн идэвхтэй үйл ажиллагаагаар шударга ёс тогтоох явдал"* гэсэн үзэл ойлголт хүчтэй дэлгэрэх болсон[87] хэмээн дүгнэсэн нь ийнхүү дэвшилттэй санаа байв.

Тэгвэл, улс төрийн ухааны доктор (Ph.D), профессор Д.Болд-Эрдэнэ *"Монголын улс төрийн орчин дахь нам"*[88] сэдвээр улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон бүтээл бичиж хамгаалсан байна. Энэхүү бүтээлд дэвшигдсэн гол санаа нь 1990-ээд оноос хойших Монголын нийгмийн улс төрийн хүрээн дэх намын төлөвшил, хөгжлийн үйл явцыг судлахдаа монголын нийгмийн улс төрийн харилцааг судалгааны гол обьект болгон авч, улмаар улс төрийн орчин, улс төрийн намын харилцан хамаарал тэдгээрт нөлөөлж буй нөхцөл, хүчин зүйлсийг судалгааныхаа судлагдахуун болгожээ. Түүнчлэн, монголын өнөөгийн улс төрийн орчин дахь намуудын төлөвшил, засаглалын харилцаан дахь намын нөлөө, оролцоо, байр суурь, статус, гүйцэтгэх чиг үүрэг, түүний хүрээнд үйлчилж буй жам ёсны хандлага хийгээд өвөрмөц байдлыг нээн илрүүлж, намын шинэчлэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зохистой арга замын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахыг

*86 Хатанболд О. Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр. ред. Чулуунбаатар Г., Ганбат Д., Цэцэнбилэг Ц. "Соёмбо принтинг" ХХК. Уб., 2017*

*87 Хатанболд О. Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2016. 127, 129 дэх тал*

*88 Болд-Эрдэнэ Д. Монголын улс төрийн орчин дахь нам. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 2016, 11, 247 дахь талууд*

голлон анхаарсан нь түүний дэвшүүлсэн зорилт гэж болно. Тэрбээр эл зэрэг горилсон бүтээлдээ улс төрийн орчин дахь намуудын чиг үүргийг намуудын нийгэмд гүйцэтгэж буй чиг үүрэг, хэв шинжийн байдлаар нь хоёр үндсэн чиглэлээр буюу улс төрийн тогтолцоон дахь намуудын институциональ чиг үүрэг, нийгмийн харилцаан дахь намын функциональ чиг үүрэг хэмээн ангилан үзсэн. Ингэхдээ Монгол дахь улс төрийн намуудын хувьд нийгэм дэх чиг үүргээ зохих хэмжээгээр хэрэгжүүлж буй авч, түүнийг агуулга, чанар, үр дүнгийн талаас авч үзвэл учир дутагдалтай, хангалтгүй хэмээн дүгнэжээ.

Энэ бүхэн нь улс төрийн шинжлэх ухааны судалгааны үндсэн чиглэл гол төлөв монголын нийгмийн харилцааны онцлог, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг илүү нарийвчлан судлахад чиглэгдэх болсныг харуулна. Тухайлбал, судлаач Д.Ганхуяг монголын нийгмийн харилцааны онцлогийг тодорхойлохдоо *“Монголын нийгмийн системийн хамгийн гол онцлог нь хүн амын тоо цөөн бөгөөд түүний хөдөөгийн хэсэг нь мал аж ахуйд түшиглэн ерөнхийдөө уламжлалт маягаар амьдардаг, харин хотын хэсэг нь үйлдвэржсэн салбаруудад түшиглэн суурин байдлаар европжуу маягаар амьдардаг, өөрөөр хэлбэл амьдралын европ болон уламжлалт хэв маяг байнгын зөрчилт хөдөлгөөнд өвөрмөц байдлаар сүлжилдэн нэгдэж байгаад оршино”* гэжээ. Тэрбээр цааш нь газар зүйн хувьд хөдөө, үйлдвэрлэлийн хувьд суурьшмал газар тариалан болон голдуу ашигт малтмал ашиглах зориулалт бүхий суурин газрууд, засаг захиргааны төвүүдэд хүн амын нэлээд хэсэг нь амьдардаг. Нийгмийн нэг системийн дотор амьдралын хоёр хэв маяг, хоёр соёл зэрэгцэн оршиж зөрчилдөж нэгдэж байгаа энэ онцлог нь нэлээд холын ирээдүйтэй ч хадгалагдан үлдэж, Монголын нийгмийн шинж, түүний хөгжлийн хандлагыг[89] тодорхойлсныг онцлоход илүүдэхгүй буйзаа.

Нөгөөтээгүүр, ардчилсан нийгмийг шүүмжлэлт байр сууринаас тольдон тодруулахыг зорьсон зарим нэг судлаачид тухайлбал, Ж.Бор, Д.Баатар нарын хамран зохиосон нэгэн бүтээлд[90] ардчилал хэмээх сүлжээнд 1990-ээд оноос Монгол Улсыг хаман оруулж, *“тэмцэлгүй түрэмгийлэх”* аргаар *“гар бариад бугуй барим, бугуй бариад мөр барих”* гэгчийн үлгэрээр эрх нөлөөндөө улам бүр оруулж авсаар байна. Үүний уршгаар Монгол соёл иргэншлийн үнэт зүйлс эрс бүдгэрч Монгол хүний өвөрмөц сэтгэлгээ, оюун ухааны өвөрмөц загвар дарангуйлагдаж, эдийн засаг хиймэл хямралд идэгдэж, зохиомол өрийн сүлжээнд автуулж байгаагаараа аймшигтай дүр төрх бий болсныг халаглан ундууцсан үзэл санаа энэхүү бүтээлд нэлээд түгээмэл хөндөгдсөн байна. Бүтээлд мөн улс төрийн монгол унаган үзэл хэмээх өвөрмөц үзэл баримтлалыг дэвшүүлсэн байх бөгөөд тэр нь чөлөөт энэрэнгүй үзэл хэмээхүй агаад түүнийг эртний Монголын язгуур соёл дахь *“байгалиас заяагдмал эрх”*-ийн тухай уламжлалт үзэл санаан дээр тулгуурласан монгол унаган үзэл бүр анунак-монголчуудын үед үүсэж улам бүр төгсжин боловсорсоор ирсэн хэмээжээ. Тэрхүү чөлөөт энэрэнгүй үзэл баримтлал нь хүнд байгалиас заяасан үндсэн зарчмуудаас буюу хүний амьдрах эрх, эрх чөлөөтэй байх, шударгаар олсон өмчөө өмчлөх үндсэн эрхээс урган гардаг. Нэг үгээр хэлбэл, чөлөөт энэрэнгүй үзэл нь бусдыг хүндэтгэх *“тэнгэрийн дор төрж, төрийн ор амьдрахдаа”* өөрийнхөө чухам юу хүсэж байгаагаа ямар нэгэн хэмжээгээр мэдэж, мэдэрч байдгийг хэлж буй ажээ. Эцсийн дүндээ энэ бол цомхон чадварлаг засаг төртэй байхыг хэлж буй явдал аж. Хэмжээнээсээ

*89 Судлаач Х.Д.Ганхуяг. Шинжлэх ухаан наашаа луйварчид цаашаа (2011-2013 он). II боть. Тех.редактор. Доржсүрэн Т. “Мөнхийн үсэг” ХХК. Уб., 2016, 507 дахь тал*

*90 Бор Ж., Баатар Д. Монголын улс төр: төр ёсны монгол үзэл ба засаглалын доройтолд рашааны дусал. “Адмон принт” ХХК. Уб., 2015, 6, 9, 143, 188 дахь талууд*

хэтэрсэн нүсэр засаг бидний амьдралд засгийн оролцоог ихэсгэж, татварыг өндөрсгөж, эдийн засгийн өсөлтийг бууруулж, эрх чөлөөг үгүй хийх тал руу явдаг. Тиймээс чадварлаг, цомхон төрийн байгуулал гэдэг нь засаг захиргааны цар хэмжээ, засгаас бидний хувийн болоод бизнесийн хэрэгт оролцох оролцоо, татварыг багасгаж өгдөг байх хэрэгтэй. Нөгөө талаар төр улс сайнаар оршин тогтнож чадах эсэх нь нийгэм дэх дотоод үйл явцаас ихээхэн шалтгаалдаг. Чухамдаа хууль зүй, төрийн ухамсар хүмүүст хэр зэрэг бат тогтвортой байх нь зөвхөн төрийн үйл ажиллагаатай холбоотой. Тэгэхлээр тухайн улсын хууль ямар түвшинд байна, иргэдийн зан чанар мөн тийм түвшинд байдаг гэсэн эл дүгнэлт улс төрийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд нэгийг бодогдуулна.

Үүнээс улбаалан Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны судалгааны өнөөгийн байдал, цаашдын хандлагыг тодорхойлоход 1990-ээд оноос хойших хугацаанд улс орны нийгмийн амьдралд гарсан хувиралт өөрчлөлт, түүний дотор ардчиллын төлөвшил, иргэдийн улс төрийн оролцооны асуудлаар манай эрдэмтэн судлаачдын туурвисан зарим бүтээлүүдийг шүүрдэн үзэхүл сонирхолтой дүр зураг ажиглагдсаныг та бүхэнтэй хуваалцаж байна.

Тэдгээрийн нэг бол бүтээлийн агуулга, дэвшүүлсэн санаа, дүгнэлтийг энд дурдахыг зорив. чухал хувь нэмэр оруулах бүтээл бол *“Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо”*[91]-г тодорхойлсон суурь судалгааны хүрээнд гарсан хамтын бүтээлд тус улсад шууд ардчиллыг төлөвшүүлэн нутагшуулах асуудал огт судлагдаагүйг харгалзан үзэж төслийн хүрээнд судалж буй асуудлаар мэргэшлийн өндөр түвшинд үнэлэлт дүгнэлт өгөх чадвар, зохих дадал туршлага бүхий эрдэмтэн судлаачдын дунд хийсэн шинжээчдийн санал асуулгыг зохион байгуулж, гарсан үр дүнг судалгаандаа ашигласан байна. Чингэхэд Монгол Улс дахь төлөөллийн ба шууд ардчилал, иргэдийн улс төрийн оролцооны харилцан хамаарал, төлөөллийн ба шууд ардчиллыг илүү үр дүнтэй ашиглах арга зам, нөхцөлийг судлан тогтоох, иргэдийн улс төрийн оролцооны арга зам, хэлбэр, загварын зохистой хувилбарыг тодруулах, улмаар Монгол Улс дахь төлөөллийн ба шууд ардчиллын хэтийн төлөв хандлагыг тодорхойлсон нь эл хамтын бүтээлийн ач холбогдол оршиж байна. Дурдан буй сэдвийн хүрээнд Монгол дахь төлөөллийн болон шууд ардчиллыг тойрсон онол, практикийн бүхэл цогц асуудлыг аль болохоор өргөн хүрээнд судалгааны бодит баримтад түшиглэн тодорхой авч үзэж судлахыг хичээсэн нь төлөөллийн болон шууд ардчиллын түүхэн болон улс төрийн философи үндэс, оролцооны ардчиллын тухай орчин үеийн үзэл баримтлал, түүний хөгжил өөрчлөлтийн төлөв хандлага, иргэний нийгэм дэх иргэдийн улс төрийн оролцооны хэв маяг, иргэдийн өөрөө удирдах ёс зарчим, нутгийн удирдлагын төлөвшил, энэ хүрээний бэрхшээлтэй асуудал, төлөөллийн ардчиллын нөлөө, хүчин зүйл, боловсронгуй болгох боломж, арга зам зэрэг олон талт сэдэв, асуудлыг судалгааны гол судлагдахуун болгон гарц шийдлийг тодруулсан. Мөн шууд болон төлөөллийн ардчиллыг манай нөхцөлд зохистой байдлаар хэрэгжүүлэх нь төр, иргэд, олон түмний хооронд үүссэн хүнийрхлийн хоосон орон зайг ойртуулах, төрд итгэх олон түмний итгэлийг бэхжүүлэх, нийгмийн эв нэгдлийг хангах, ардчиллын хөгжлийг зөв голдиролд оруулахад чухал нөлөө үзүүлнэ хэмээн хамтын бүтээлийн зохиогчид дүгнэжээ.

Дээрх судалгааны суурь бүтээлтэй зэрэгцэн гарсан өөр нэгэн бүтээл бол харьцуулсан улс төр судлалын шинжилгээний аргаар боловсруулсан *“Орос,*

---

*91 Философийн хүрээлэн., ШУА. Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо. Хамтын бүтээл. ред. Баасансүрэн Д. “Соёмбо принтинг” ХХК. Уб., 2017, 4, 282-287 дахт талууд*

*Монголын залуучуудын улс төрийн идэвх, оролцоо"*[92] сэдэвт орос, монголын судлаачдын хамтран боловсруулсан судалгааны үр дүн юм. Бүтээлд 1990-ээд оноос эхлэн Монгол орон улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт шинэчлэл явуулж, бүс нутагтаа ардчилсан хөгжлийн загварыг харьцангуй тогтвортой, тайван замаар хөгжүүлж байгаа цөөн улсын нэг. Энэ бүх үйл явцын тэргүүн шугамд залуучууд манлайлсан. Гэхдээ монголчууд ардчилал, эрх чөлөөнийхөө ололтоор бахархахын зэрэгцээ хүн амын өсөлтийн цонхтой холбоотойгоор залуучуудын нийгэмд гүйцэтгэх үүрэг улам бүр өсөх хандлагатай байгаа өнөө үед улс төр, ардчилал, засаглалын хүрээнд хүрсэн түвшин алдаа, оноо, туршлага, сургамжаа залуучуудынхаа улс төрийн төлөвшилтэй холбон анхаарч судлах шаардлага нэгэнт бий болсон. Тэгвэл, ОХУ-ын судлаачдын баг Оросын ШУА-ийн Социологийн хүрээлэнгээс Оросын нийгмийн өөрчлөлт, дунд ангийн төлөвшил, оросын залуучуудын өнөөгийн түр төрх, улс төрийн идэвх оролцооны талаар сүүлийн жилүүдэд хийсэн томоохон судалгааны дүнг багтаажээ. Ингэснээрээ Орос, Монголын залуучуудын нийгэм, улс төрийн дүр төрх, нийгэмд тэдний гүйцэтгэж буй үүрэг, ялангуяа, хоёр орны залуучуудын улс төрийн идэвх, оролцооны шинж байдал, өөрчлөлт хандлагыг харьцуулан судлах анхны оролдлого болоод зогсохгүй цаашид хоёр орны залуучуудын социологийн тодорхой асуудлуудаар хамтарсан судалгаа хийх эхлэлийг тавьж буйгаараа эл бүтээлийн ач холбогдол оршиж байна. Түүнчлэн зохиогчид иргэдийн улс төрийн оролцоонд бий болж байгаа энэ шинэ хандлага нь юуны өмнө залуу үеийнхний улс төрийн идэвх, оролцооны түвшнээр илэрхийлэгдэж байгаа нь дараах гол дүгнэлтүүдийг хийхэд хүргэсэн байна. Үүнд: (i) залуучуудын нийгэм, улс төрийн сонирхол, идэвх оролцоог судлахдаа тэдний оролцоо, оролцооны хэлбэр, мэдлэг, сонирхол, эсэргүүцэл, үзэл бодлоо илэрхийлэх хэлбэрт нөлөөлж буй гадаад хүчин зүйлс асар өргөжиж, маш хурдацтай хөгжиж байгааг харгалзан ерөнхийд нь бус үзүүлэлт тус бүрээр нарийвчлан богино хугацаанд, тогтмол давтамжтай судалдаг байх хэрэгцээ бий болгох; (ii) улс төрийн тогтолцоог гажуудуулж буй төрийн эрх бүхий нам, эвсэл холбоодын үйл ажиллагаа нь иргэдийн ялангуяа манай орны хувьд залуучуудад улс төрөөс залхах, хөндийрөх, нийгмийн аливаа үйл ажиллагаанд идэвхгүй хандах байдлыг бий болгож буйд анхаарах; (iii) нийгмийн улс төрийн идэвх залууст төлөвшиж дээшлэх нь өөрийн зүй тогтол, эрэмбэ шаттай бодит үйл явц боловч ерөнхийдөө нийгмийн бодит нөхцөл орчин, субъектив хүчин зүйл, тухайлбал нийгмийн хүмүүжлээс багагүй хэмжээгээр шалтгаалдаг гэдгийг тооцохгүй байна. (iv) Залуучуудын үзэл бодлыг тусгайлан судлан дорвитой бодлого, арга хэмжээнд тусгахгүй байгаа ба зөвхөн аль нэг улс төрийн нам, эвслийн цөөн тооны залуучуудын үзэл бодол, саналаар хязгаарлаж байгаа талаар тус хамтын бүтээлд онцлон дүгнэсэн байна.

Үүнээс үзэхүл, дэлхий нийт даяарших болсноор улс үндэстэн шинэчлэгдэн өөрчлөгдөхийн хэрээр залуу хойч үе маань үндэсний соёлоо огоорох, үл тоох, соёл эвдрэх улмаар төр улс хэврэгших аюул занал буй болсон өнөө үед төрт ёсны тухай асуудлыг судлан шинжлэх ухааны онолын түвшинд хүргэх асуудал чухлаар тавигдаж байна. Ялангуяа төр улсын тухай номлолд либерал хэмээх үзлийн хэт илүүрхэх байдал үлэмж нэмэгдэх болсон нь төрийн үйл ажиллагаанд ч, ард олны оюун санааны эрхэмлэлд ч доголдол гарах эрсдэл нүүрлээд байна. Чухам энэ эмзэг байдлыг нарийвчлан судлах, чингэхдээ монголын төрт ёсны үүсэл, гарваль,

*92 Энэхүү хамтын бүтээлийг Монгол Улсын БСШУСЯ, ШУТС болон ОХУ-ын Хүмүүнлэгийн шинжлэх ухааны сангийн санхүүжилтээр хэрэгжсэн "Орос, Монголын залуучуудын улс төрийн идэвх, оролцоо (харьцуулсан шинжилгээ)" хамтарсан төслийн хүрээнд гаргажээ. "Орос, Монголын залуучуудын улс төрийн идэвх, оролцоо". Хамтын бүтээл. ред. Горшков М.К., Чулуунбаатар Г., ба бусад. Философийн хүрээлэн ., ШУА. ОХУ-ын ШУА-ийн Социологийн хүрээлэн, Дорно дахины хүрээлэн. "Соёмбо принтинг" ХХК. Уб., 2017*

тулгуур үзэл, бүрэлдэхүүнийг онолын болон амьдралын хэрэгцээг буй болгоход чиглэгдсэн судалгааг олон талаас нь эргэцүүлэн шинжилж, тэдгээрийн талаар шинэ тодорхойлолтыг санал болгосон судалгааг доктор (Ph.D), профессор А.Цанжид хийжээ. Тэрбээр *"Монголын төрт ёс: улс төр, түүхийн шинжилгээ"*[93] *(Уб.,2018)* сэдвээр улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл туурвиснаас гадна тэрхүү зэрэг горилсон бүтээлээ улс төрийн шинжлэх ухаанаар дагнан судалгаа хийж буй залуу судлаачид, сонирхогчид, оюутнуудад зориулан *"Монголын төрт ёс"*[94] *(Уб.,2019)* ном болгон гаргасан нь нэн чухал санагдана. Түүний эл бүтээлд монголын төрт ёсны уг гарвалийг хөөн судлах явцдаа нүүдэлчдийн нийгмийн политогенезийн суурин нийгмийнхээс ялгарах онцлогийн талаарх санал дэвшигдсэн бүтээлийн онолын ач холбогдол илэрхийлэгдсэн бол, Монгол төр улсын оршин тогтнохуйтай бат нягт холбоотой төр барихуйн ухаан буюу Монгол төрийн бодлого, үйл ажиллагааны зарчмуудыг сэргээн хэрэглэхүй буюу төрт ёсны уламжлалыг сэргээн сануулсанд бүтээлийн практик ач холбогдол оршиж байна. Доктор А.Цанжид энэхүү судалгаандаа герменевтик, системийн онол, дедуктив номологийн арга, түүхэн хандлага болон палеолингвистийн зэрэг онол номлолыг арга зүй болгон ашигласан нь ийнхүү бүтээл өвөрмөц, шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой болоход нөлөөлсөн гэж болно. Бүтээлийг бүхэлд дүгнэх ахул, XX зуунд дэлхий дээр үндэсний олон улс тусгаар тогтносон улс болон явдал нь шинжлэх ухаанд төрт ёс хэмээх ойлголтыг судлах шаардлагыг буй болгосон. Гэвч улс төр болон бусад шинжлэх ухааны олон салбарын эрдэмтэд төрийн тухай судалгааг эртнээс одоог хүртэл хийж байгаа авч, төрт ёсны тухай судалгаа тун хомс байгаа нь ийнхүү энд хөндсөн монголын төрт ёсны асуудлыг эл судалгааны үр дүнгээр батжуулан (i) төрийн тухай; (ii) төрт ёс; (iii) Монголын төрт ёсны үүсэл, нүүдэлчдийн политогенезийн онцлог; (iv) нүүдэлчид болон суурин ард түмний харилцааны шинж байдал; (v) нүүдэлчид, түүний дотор Монголын төрт ёсны залгамжит чанар, өвөрмөц шинж; (vi) Монголын төрт ёсны тулгуур үзлүүд; (vii) Монголын төр барихуй ухаан; (viii) Монголын төрийн тухай үзлийн сонгодог уламжлал; (ix) Засаг захиргааны уламжлал, өөрчлөлт; (x) Монголын төрт ёсонд эрх зүйн эртний уламжлал; (xi) Монголын түшмэл; (xii) Монгол төрийн ёс; (xiii) Төрийн хэл зэргээр санал дүгнэлтүүдийг зохиогч дэвшүүлснийг энд маш хураангуй байдлаар дурдав.

Дээр дэвшигдсэн эрдэмтэн, судлаачдын санаанууд нь урьд өмнөхтэйгөө ойртон нягтрах түвшинд хүрч чадаагүй ч гэлээ түүнд хүрэх арга замыг олж мэдэх, шинээр хэлбэржсэн аливаа хэв загваруудад шинжлэх ухааны гэгээлэг тархалтыг бүрдүүлэх оролдлого хийснээрээ нэн чухал. Үүний нэг жишээ бол, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрдэмтэн багш нар Монгол дахь ХБНГУ-ын Конрад Аденауэр Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр *"Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-2019)"* сэдэвт хамтын бүтээлийг туурвисан байна. Энэхүү хамтын бүтээлийн *"Ардчиллын бэхжилт, төрийн эрх мэдлийн институтийн зарим асуудал"* бүлэгт ардчиллын хөгжил, бэхжилтийн тулгамдсан асуудал, засгийн газрын тогтворгүй байдлын асуудал, шүүх эрх мэдлийн зарим тодорхой асуудлуудыг хөндсөн бол, *"Ардчиллын институцийн хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал"* хэмээх дэд бүлэгтээ сонгуульт, улс төрийн нам, иргэний нийгмийн зарим чухал асуудлыг, *"Монгол дахь ардчиллын эдийн засаг, нийгэм-сэтгэл зүйн олон талт өөрчлөлт, тулгамдсан асуудал"* хэмээсэн гурав

93 Цанжид А. Монголын төрт ёс (улс төр, түүхийн шинжилгээ). Улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб. 2018, 3,7, 263 дахь талууд

94 Цанжид А. Монголын төрт ёс. ред. Отголжий С. "Соёмбо принтинг" ХХК. Уб. 2019

дахь бүлэгт эдийн засаг дахь улс төрийн бодлогын нөлөө, нийгмийн социал, сэтгэл зүйн хүрээнд гарсан өөрчлөлт, тулгамдсан асуудлуудыг авч үзжээ. Ингэхдээ бүлэг тус бүрийг агуулгын хүрээнд томьёологдсон тус бүр гурван дэд хэсгийг багтаасан нь ардчиллын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг цаашид улам гүнзгийрүүлэн судлах санаачлагыг давхар бүрдүүлжээ. Түүнээс гадна эл хамтын бүтээлийн зохиогчид нь үндэсний залуу, дунд үеийн судлаачид, тухайлбал улс төр судлаач, эрх зүйч, эдийн засагч, социологич, сэтгэл зүйч зэрэг мэргэжлийн салбартаа тогтмол идэвхтэй судалгаа хийж, үр дүн бүтээлээ дотоод, гадаадад хэлэлцүүлсэн судлаачдаас бүрдсэн нь уг бүтээлийг олон шинжлэх ухааны уулзвар зааг дээр хослуулан туурвих боломжийг мөн бүрдүүлж өгснийг онцлох нь зүйтэй.

Улс төрийн мөн чанарыг ойлгон таниулах, энэ талаарх зөв үнэлгээ дүгнэлтийг өгөх улс төрийн мэдлэгийг бий болгоход улс төрийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг өндөр. Энэ утгаараа ч МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг “Политологи” эрдэм шинжилгээний сэтгүүлийн анхны дугаар (2002 оноос) хэвлэгдсэн гарснаас хойш даруй 534 дэх удаагийн дугаар (2020 оны 8 дугаар сарын байдлаар) тасралтгүй гарч улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүй, сургалт практикийн мэргэжлийн тогтмол хэвлэл болон төлөвшсөн байна. Өнөөдөр бидний оршин буй энэ цаг хугацаанд улс төрийн шинжлэх ухааны онол-арга зүй, судалгааны арга хэрэгсэл, улам нарийсан хөгжиж онолын болон эмпирик судалгаа шинжилгээний мэдлэгүүд даяарших болсон нь дэлхий дахин, бүс нутаг, улс орнуудад ардчилсан хөгжлийн ололт амжилтыг баталгаажуулах, түүнийг хөгжлийн шинэ шатанд гаргахад тус сэтгүүл чухал үүрэг гүйцэтгэж байгаагийн зэрэгцээ Монголд шинээр үүсэн төлөвшиж буй улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэн, судлаачдыг татан оролцуулах, тэдний мэдлэг оюуныг түгээн дэлгэрүүлэх, сургалт, судалгааны чанарыг дээшлүүлэхэд түүний үүрэг, хариуцлага чухал бөлгөө. Ийнхүү дурдахын учир нь, сэтгүүлийн энэ оны (2020) дугаарт улс төрийн онол, үзэл баримтлал, улс төрийн институт, ардчиллын онол, практик, харьцуулсан улс төр, эмпирик судалгаа зэрэг улс төрийн шинжлэх ухааны олон чухал сэвүүдээр эрдэмтэн судлаачдын бичсэн өгүүллүүд нийтлэгдсэн[95] явдал үүнийг бэлхнээ илтгэнэ.

Сүүлийн хориод жилийн хугацаанд Монгол Улс дахь улс төрийн шинжлэх ухааны салбарын хөгжил шинэ шатанд гарсныг дээр дурдсан суурь бүтээлүүд нотлон харуулж буй. Энд бид улс төрийн шинжлэх ухааны судалгаанд нэн сүүлийн үед хийгдсэн нэгэн судалгааны үр дүнд гарсан хамтын бүтээлийг онцлон дурдах нь зүйтэй гэж үзэв. Энэ бол Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарт 2017-2019 онд хэрэгжсэн *“Монголын улс төрийн үйл явцын хөгжилд улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг”* сэдэвт суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн судалгааны үр дүн болох “*Монгол Улс дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе”*[96] *(Уб.,2020)* хамтын бүтээл юм. Эл бүтээл нь судлаачдын багийн судалгааны хүрээнд явуулсан шинжлэх ухааны эрэл хайгуулын бодит үр дүнд тулгуурлан Монгол орон дахь улс төрийн соёлын төлөвшлийн түүхэн уламжлал ба орчин үеийн асуудлыг цогц байдлаар буюу уламжлал, орчин үеийн холбоон дээр судлан тодорхойлсноороо онцлогтой. Түүнчлэн хөрш зэргэлдээ хийгээд пост-коммунист орнуудын болон Монголчуудын улс төрийн соёлын түүхэн уламжлал, өнөөгийн монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлага, орчин

*95 Конрад Аденауэр Сан., МУИС-ийн Улс төр судлалын тэнхим. Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-2019). Хамтын бүтээл. ред. Төртогтох Ж., Ганзаяа С. Адмон принт ХХК. Уб., 2019*

*96 МУИС-ийн Улс төр судлалын тэнхим. “Политологи” Эрдэм шинжилгээний бичиг. №18 (534). МУИС-ийн хэвлэх үйлдвэр. Уб., 2020, 6 дахь тал*

үеийн хэв маяг, онцлог зэргийг улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулж, шинжлэх ухааны эргэлтэд оруулж байгаа нь энэхүү хамтын бүтээлийн ач холбогдол оршино. Энэхүү хамтын бүтээл нь энэ төрлийн судалгааны ажлаас ялгагдах нэг давуу тал нь урьд өмнө судлагдаагүй байсан асуудлыг шинжлэх ухааны түвшинд анхлан судалж, өнөөгийн монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлага, орчин үеийн хэв маягийн талаар шинэ мэдлэг, мэдээлэл, тоо баримт, санал дүгнэлтийг улс төр судлалын онол, арга зүйн үүднээс боловсруулж шинжлэх ухааны эргэлтэд оруулсан явдал хэмээн үзэж болох юм. Өнөөгийн Монгол Улс дахь улс төрийн соёлын төлөвшил, хөгжлийн түвшин, тулгарч буй саад бэрхшээл, тэдгээрийг засаж залруулах арга зам, боловсронгуй болгох боломж нөхцөл зэргийг энэ чиглэлээр мэргэшсэн шинжээчдийн үнэлэлт, гаргалгаанд тулгуурласан байна. Эцэст нь дүгнэвэл, манай орон дахь улс төрийн соёлын төлөвшил дундаас доош буюу бүрэлдэх  шатандаа явж байна гэсэн тааруу дүгнэлтэд хүрч байна. Үүний гол шалтгаан нь  боловсрол, мэдлэг багатай хүмүүс улс төрд орох явдал ихэссэн, мөн улс төрч хүний бие хүний төлөвшил, ёс суртахуун дутагдалтай, улс эх оронд хөгжлийн ахиц бага, тогтвортой бодлого үгүйлэгдэж буй явдал юм. Үүнийг сүүлийн 5 жилтэй харьцуулахад, Монгол Улсад улс төрийн соёл *дордсон, огт өөрчлөлтгүй* байгаа зэрэг нь үүнд давхар нөлөөлж буйн дээр нийгэмд хувиа хичээсэн үзэл бодол дэлгэрч, бизнес эрхлэгч нар улс төрд зүтгэж байгаатай шууд холбон дүгнэж буй. Судалгааны бас нэг чухал шинэлэг давуу тал бол Алмонд, Верба нарын улс төрийн соёлын ангилал, хэв маягчлах сонгодог аргачлалыг ашиглан өнөөгийн монголын улс төрийн соёлын орчин үеийн хэв маягуудыг судлан тодорхойлсон явдал. Өөрөөр хэлбэл, өнөөгийн Монгол оронд уламжлалт, албат болон оролцооны хэв маягийн аль хэлбэр зонхилох хандлагатайг тодруулбал, холимог улс төрийн соёлын хэв маяг давамгайлж, оролцооны улс төрийн хэв маяг хамгийн бага хувьтай байгаа нь улс төрийн үйл явцын шат бүрд нөлөө үзүүлэх зэрэг идэвхтэй оролцоо хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Улс төрийн соёлын чиг баримжааны хувьд өрнийн, дорнын, уламжлалт эсвэл холимог хэв маягийн ангиллаар авч үзвэл, Монгол Улсад улс төрийн соёлын аль алины холимог маягийн тэр ч бүү хэл, улс төрийн соёлын аль нэг хэв маяг одоогоор бүрэн төлөвшөөгүй байна. Тодруулбал, улс төрийн соёлын төлөвшил харьцангуй сул төлөвшсөн хэмээн үзэхэд мөн л улс төрийн намуудын төлөвшил сул, улс төрчдийн хууль мөрддөггүй, ёс зүйгүй, хариуцлагагүй байдал, улс төрчид, албан тушаалтнуудтай хариуцлага тооцох механизм дутмаг байгаа зэрэг гол шалтгаан болж байна. Эл хамтын бүтээл нь Монгол Улс дахь улс төрийн соёлын төлөвшлийн асуудлыг цаашид гүнзгийрүүлэн судлах онол, практикийн чухал эх сурвалж, хэрэглэгдэхүүн болохуйц судалгаа болсонд түүний шинжлэх ухааны үнэ цэн оршиж буй хэмээн судалгааны багийн гишүүд[97] үзсэн байна.

Нэг үгээр бол, эрдэмтэн судлаачид, сөрөг хүчнийхэн бүр үзэл бодлын үндсэн элементүүдийн хувьд янз бүрийн санаа бодолтой байдаг ч тэд дуртай, дургүй хүлээн зөвшөөрч буулт хийх нь тодорхой зүйл. Тэд *“амьдрах ба амьдрахыг хүлээн зөвшөөрөх”* хэмээх олон ургальч үзлийг бүрдүүлж чадсан хэдий ч пост-модерн хандлагын *nihilism*[98*] (уламжлалт үнэлэмж, итгэл үнэмшлийн үзэл санаа)-ыг түүнээс бага түвшинд авч үзсэн байна. Түүнчлэн өнөө үеийн улс төрийн шинжлэх ухааны эрдэмтэд илүү хувийн үзэл бодлын үүднээс эсвэл нийтэч буюу хамтын хүрээнд байж харилцан ойлголцох болсон нь тэдний өмнөх үеийнхнээсээ уламжлагдсан баялаг

*97 Философийн хүрээлэн., ШУА. Монгол дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе. Хамтын бүтээл. ред. Баасансүрэн Д., Хатанболд О. “Соёмбо принтинг” ХХК. Уб., 2020*

*98* nihilism - a viewpoint that traditional values and beliefs are unfounded and that existence is senseless and useless. The Merriam Webster Dictionary, Springfield, Massachusetts, USA, 1997*

туршлагыг хуримтлуулж чадсанд оршино.

Ийнхүү Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны чиглэлээр нийтлэгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлүүдийн талаарх тоймыг ерөнхий байдлаар гарган танилцуулсан нь цаашид судалгааны онол, сэдэв чиглэлээр нарийвчилсан дүн шинжилгээ бүхий өгүүллийг бэлтгэн нийтлүүлбэл энэ чиглэлийн судалгаа шинжилгээ хийж буй судлаачид, оюутнууд нэг дороос мэдээлэл авах боломж бүрдэхийн зэрэгцээ улс төрийн шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр болох учиртай хэмээн бид үзэж байна. Үнэндээ, шинжлэх ухааны салбарынхан, эрдэмтэн судлаачид бид төрийн бодлогод бодитой нөлөөлөхийн тулд тухайн дэвшүүлж буй асуудлынхаа гол мөн чанар, түүнээс гарах үр дагавар, хүчин зүйлсийг нарийн тооцоолон үзэх нь зүйн хэрэг мөн.

Үүнийг хураангуйлан дүгнэвэл, өнөөгийн улс төрийн амьдрал бол иргэд, улс төрчдийн нягт хамтын ажиллагааг өрнүүлж, харилцан бие даасан, хараат бус байдлыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтойн дээр тэдний хооронд үүссэн аливаа хил заагийг багасгаснаар чанарын хувьд ахиц гарч болно. Нөгөө талаас, сонгогдсон улс төрчдийн зүгээс аливаа асуудлаар улс төрийн шийдвэр гаргахдаа өөрсдийн эрх мэдлээр давамгайлах явдлыг бууруулж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд иргэдтэй харилцан зөвшилцөж, тэдний санаа бодлыг сонсох, үзэл бодлоо хуваалцах замаар шийдвэрлэх шаардлагаар илэрхийлэгдэнэ. Цаашлаад иргэдийг улс төрийн үйл явцад оролцохдоо юуны өмнө өөрсдийн шийдвэр гаргах эрх мэдлийг бүрэн ухаарч ойлгосон, бодит төлөвшилтэй болгож, улмаар өөрсдийн гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээх, бодитоор оролцох замаар ардчиллыг идэвхжүүлж, төлөөллийн тогтолцоог ард иргэддээ ойртуулж, тэдний үг хэлэх, дуу хоолойгоо илэрхийлэх, улс төрийн шийдвэр гаргах үйл явцаас хүнийсэж, хөндийрөх байдлыг саармагжуулахад бидний нийгмийн өмнө хүлээсэн шинжлэх ухаанч үүрэг мөн бөлгөө.

**Ном зүй**


1. АИХ, (1992). Монгол Улсын Үнсэн хууль. Улаанбаатар, Монгол Улс
2. Баасансүрэн, Д. (2012). Монгол дахь сонгуулийн кампанийн технологи (Улс төрийн онолын шинжилгээ). Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, Монгол Улс
3. Билэгсайхан, С. (2012). Шинэтгэл, Шинэ Монгол. “Соёмбо принтинг” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
4. Болд-Эрдэнэ, Д. (2008). Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил. Улс төр, нам судлалын шинжилгээ. Нэмж засварласан II хэвлэл. ред. Чулуунбаатар Г., Содном Ш. ФСЭХ., ШУА. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
5. Болд-Эрдэнэ, Д. (2016). Монголын улс төрийн орчин дахь нам. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, Монгол Улс
6. Бор, Ж., Баатар, Д. (2015). Монголын улс төр: төр ёсны монгол үзэл ба засаглалын доройтолд рашааны дусал. “Адмон принт” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
7. Ганбат, Д. (2008). Ардчиллагдах үйл явц ба монголчуудын үнэлэмж. “Хүний эрхийг хангаж ардчилсан засаглалыг бэхжүүлэх мянганы хөгжлийн зорилго”. Үндэсний зөвлөлдөх уулзалтын итгэлийн эмхэтгэл. “Сансудай” ХХК. Улаанбаатар, Монгол

Улс

8. Гантулга, Т. (2009). Улс төрийн намуудын бодлого, үйл ажиллагааны шинэчлэлийн зарим асуудлууд. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, Монгол Улс
9. Ганхуяг, Д. (2010). Монгол хүний менталитетын асуудалд. Социально-политические трансформации: идентичности и структурации в меняющемся мире. Доклады научно-практической конференции. ИФСиП МАН., Институт социологии РАН. “Сансудай” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
10. Гүндсамбуу, Х. (2002). Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага (XX зуун). ред. Түдэв Ш. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академи. Улаанбаатар, Монгол Улс
11. Гүндсамбуу, Х., Чулуунбаатар, Г. (1998). XXI зууны босгон дахь Монголын залуучууд. Хамтын бүтээл. Мэргэжлийн социологичдын “Зотол” клуб. ЭМНХЯ-ны Залуучууд, гэр бүл, эмэгтэйчүүдийн газар. Улаанбаатар, Монгол Улс
12. Гэрэлт-Од, Э. (2009). Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал (1990 оноос хойш). Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, Монгол Улс
13. Даваадаш, Ч. (2015). Монголын нийгмийн шилжилтийн зарим онцлог, ээдрээ. Өдрийн сонин. № 187, Улаанбаатар, Монгол Улс
14. Дашдаваа, Ч. (2003). Улаан түүх. ШУА., Түүхийн хүрээлэн, СУИС. ред. Бат-Очир Л. “Адмон” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
15. Дэлгэрмаа, Б. (2001). Улс төр судлал. Улаанбаатар, Монгол Улс
16. Дэлгэрмаа, Б. (2007). Өнөөгийн монголын нийгэм дэх олон намын тогтолцооны төлөв байдал. “Шинэ толь” сэтгүүл. №59. Улаанбаатар, Монгол Улс
17. Жүгдэр, Ч. (2006). Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил (МЭӨ III-МЭ XX зуун). ФСЭХ., ШУА. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
18. Конрад Аденауэр Сан., МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, (2019). Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-2019). Хамтын бүтээл. ред. Төртогтох Ж., Ганзаяа С. “Адмон принт” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
19. Лүндэндорж, Н. (2010). Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал. Бүтээлийн эмхэтгэл. Засгийн газрын хэвлэх үйлдвэр. Улаанбаатар, Монгол Улс
20. Монгол Улсын түүх. (2003). V боть. Улаанбаатар, Монгол Улс
21. Мөнхбат, С. (2009). Монгол дахь улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын төлөвшлийн асуудал. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, Монгол Улс
22. Мөнхцэцэг, Ц. (2009). Сонгуулийн кампанийн коммуникац (Монгол Улсын жишээн дээр). Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, Монгол Улс
23. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, (2020). “Политологи” Эрдэм шинжилгээний бичиг. №18 (534). МУИС-ийн хэвлэх үйлдвэр. Улаанбаатар, Монгол Улс
24. Отгоннасан, В. (1990). Социология партийной работы: предмет, структур, функции и проблемы эффективности исследований. На опыт МНРП. Диссертацич на соискание ученой степени кандидата социологических наук. Москва., Российская Федерация
25. Оюунчимэг Д., Өлзийсайхан Ч, (2010). Сонгуулийн компанийн үе дэх улс төрийн

намууд, нэр дэвшигчдийн хариуцлага. “Ардчилал-нийгмийн хариуцлага”. Эрдэм шинжилгээний онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхэтгэл. ФСЭХ., ШУА, МУИС, УТДС, Прогноз академи. “Сансудай” ХХК. Улаанбаатар, Монгол Улс

26. Содномгомбо Д., Найдансүрэн Ч, (2000). Улс төрийн соёл, түүний монгол дахь төлөвшлийн асуудал. Улаанбаатар, Монгол Улс
27. Ганхуяг, Х. Д. (2016). Шинжлэх ухаан наашаа луйварчид цаашаа (2011-2013 он). II боть. Тех.редактор. Доржсүрэн Т. “Мөнхийн үсэг” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
28. Төртогтох, Ж. (2010). Үндсэн хуулийн политологийн шинжилгээ. МУИС. “Соёмбо принтинг” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
29. Улс төрийн шинжлэх ухааны холбоо, (2006). “Улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны өнөөгийн түвшин”. ЭШБХ-ын илтгэлийн эмхэтгэл. ред. Ганбат Д. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
30. Улс төрийн шинжлэх ухааны холбоо, (2008). Үндэсний өвөрмөц соёлын орчин дахь ардчиллын зарчмын үйлчлэл. Эрдэм шинжилгээний грант-төслийн тайлан. Улаанбаатар, Монгол Улс
31. ҮСХ., ӨНЭЗС, (2012;2013;2014). Ардчилсан засаглал модуль. Улаанбаатар, Монгол Улс
32. Философийн хүрээлэн., ШУА, (2015). Философи эрхийн судлал-ХХХ. “Тод бичиг” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
33. Философийн хүрээлэн., ШУА, (2017). Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо. Хамтын бүтээл. ред. Баасансүрэн Д. “Соёмбо принтинг” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
34. Философийн хүрээлэн., ШУА, (2020). Монгол дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе. Хамтын бүтээл. ред. Баасансүрэн Д., Хатанболд О. “Соёмбо принтинг” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
35. Философийн хүрээлэн., ШУА. ОХУ-ын ШУА-ийн Социологийн хүрээлэн, Дорно дахины хүрээлэн, (2017). Орос, Монголын залуучуудын улс төрийн идэвх, оролцоо. Хамтын бүтээл. ред. Горшков М.К., Чулуунбаатар Г, ба бусад. “Соёмбо принтинг” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
36. ФСЭЗХ., ШУА, (2013). Философи, эрх зүйн судлал- XXVIII. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
37. ФСЭЗХ., ШУА, (2014). Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал. Хамтын бүтээл. ред. Амарсанаа Ж., Ган-Өлзий Ч., Болд-Эрдэнэ Д. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
38. ФСЭХ., ТБШХ., НҮБХХ, (2014). Монголын залуучуудын ардчилал, улс төрийн идэвх оролцоо. Улаанбаатар, Монгол Улс
39. ФСЭХ., ШУА, (1990). Философи, эрхийн судлал-XIV. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар, Монгол Улс
40. ФСЭХ., ШУА, (1992). Гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ. №12. Улаанбаатар, Монгол Улс
41. ФСЭХ., ШУА, (1998). Гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ. №15. Улаанбаатар, Монгол Улс
42. ФСЭХ., ШУА, (2000). Гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ-№16. Улаанбаатар, Монгол Улс
43. ФСЭХ., ШУА, (2001). Философи эрхийн судлал- XVII. Улаанбаатар, Монгол Улс
44. ФСЭХ., ШУА, (2007). Философи, эрх зүйн судлал-XXII. “Сансудай” ХХК. Улаанбаатар, Монгол Улс

45. ФСЭХ., ШУА, (2012). Философи, эрх зүйн судлал- XXVII. “Бэмби сан” ХХК Улаанбаатар, Монгол Улс
46. ФСЭХ., ШУА, (2013). Философи, эрх зүйн судлал- XXVIII. “Арвин судар” ХХК Улаанбаатар, Монгол Улс
47. ФСЭХ., ШУА, (2000). Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо. Хамтын бүтээл. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
48. ФСЭХ., ШУА, (2006;2008;2010;2013) Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт. Улаанбаатар, Монгол Улс
49. ФСЭХ., ШУА, (2008). Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. I дэх хэвлэл. ред. Даш-Ёндон Б.”Сансудай” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
50. ФСЭХ., ШУА, (2011). Монголын ардчиллын төлөвшил. Хамтын бүтээл. ред. Чулуунбаатар Г., Ганбат Д., ба бусад. ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр. Улаанбаатар, Монгол Улс
51. ФСЭХ., ШУА, (2013). Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. II дахь хэвлэл. ред.Чулуунбаатар Г., Даш-Ёндон Б. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
52. Хантингтон, С. (2005). Иргэншил хоорондын мөргөлдөөн, шинэчлэгдэж буй дэлхийн дэг журам. орч. Баярхүү Д. ННФ. “Адмон” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
53. Хатанболд, О. (2016). Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, Монгол Улс
54. Хатанболд, О. (2017). Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр. ред. Чулуубаатар Г., Ганбат Д., Цэцэнбилэг Ц. “Соёмбо принтинг” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
55. ХҮЗТ., ХЗДХЯ, (2007). 1992 оны Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн оршил хэсэг. Улаанбаатар, Монгол Улс
56. Цанжид, А. (2018). Монголын төрт ёс (улс төр, түүхийн шинжилгээ). Улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, Монгол Улс
57. Цанжид, А. (2019). Монголын төрт ёс. ред. Отголжий С. “Соёмбо принтинг” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
58. Чулуунбаатар, Г. (1999). XX, XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, хөгжил. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
59. Чулуунбаатар, Г. (2008). XX, XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт (Эрдмийн бүтээлийн эмхэтгэл). “Сансудай” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
60. Чулуунбаатар, Г. (2009). XX, XXI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. Эрдмийн бүтээлийн эмхэтгэл. ФСЭХ., ШУА. “Сансудай” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
61. Чулуунбаатар, Г. (2010). Орчин үеийн Монгол дахь иргэншийн өөрчлөлтийн үйл явц. Социально-политические трансформации: идентичности и структурации в меняющемся мире. Доклады научно-практической конференции. ИФСиП МАН., Институт социологии РАН. “Сансудай” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
62. Чулуунбаатар, Г., Дашжамц, Д. (2002). Философи, социологи, эрхийн

хүрээлэнгийн түүхийн хураангуй (1972-2000). ред. Пүрэв Ц. Улаанбаатар, Монгол Улс

63. Чулуунжав, Д. (2004). Монголын нийгмийн өвөрмөц байдалд тохирох төрийн засаглалын зохистой хэлбэр, хэмжээ, бүтэц, үүргийн асуудалд. ред. Чулуунбаатар Г. “Бэмби сан” ХХК. Улаанбаатар, Монгол Улс
64. Эрдэмт, Ц. (2018). Төрийн тухайт Монгол онол: түүх, философи, хуулийн эш. Нэмж завсарласан II хэвлэл. Choijil Publishers Co Ltd., Улаанбаатар, Монгол Улс
65. Эрдэнэдалай, Б. (2015). Монгол дахь улс төрийн намын санжүүжилт: улс төр-эрх зүйн шинжилгээ. Улс төрийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, Монгол Улс

***Англи хэл дээр***

1. Fukuyama, F. (2000). The March of Equality. Journal of Democracy, Volume 11, #1. John Hopkins University, USA
2. The Merriam Webster Dictionary, (1997). Springfield, Massachusetts, USA

***Орос хэл дээр***

1. Дэлгэрма, Б. (2005). Демократические преобразования в Монголии на рубеже XX и XX вв. Диссертация на соискание ученой степени кандидата историчеких наук. ИМБТ СО РАН, Гумманитарный институт Монгольского университета науки и технологий. Улан-Үдэ, Республика Бурятия, Российская Федерация
2. Кравченко, А. И. (2001). Культурология: Учебное пособие для вузов. 3-е изд. Академический проект. Москва., Российская Федерация

# КОНЦЕПЦИИ ИНФОРМАЦИОННОГО ОБЩЕСТВА КАК ТЕОРИИ СОЦИАЛЬНОГО ЗНАНИЯ [1]

Ивлева М.Л.
*Российский университет дружбы народов, Москва, Россия*
Иноземцев В.А.
*МГТУ имени Н.Э. Баумана, Москва, Россия*
Баграмянц Н.Л.
*Департамент человеческих ресурсов, Спортмастер*

***Аннотация.*** *В статье выделяются и исследуются два основных подхода к изучению современного общества: концепции постиндустриального общества и концепции информационного общества. Устанавливается, что в концепциях информационного общества главное внимание обращается на понимание информации и знания как главного стратегического ресурса общества. В работе концепции информационного общества рассматриваются как теории социального знания*

***Ключевые слова:*** *информационное общество, постиндустриальное общество, концепции, социальное знание.*

***Abstract.*** *The article highlights and explores two main approaches to the study of modern society: the concept of post-industrial society and the concept of the information society. It is established that in the concepts of the information society, the main attention is paid to understanding information and knowledge as the main strategic resource of society. In the work, the concepts of the information society are considered as theories of social knowledge.*

***Keywords:*** *information society, post-industrial society, concepts, social knowledge.*

В настоящее время возникает настоятельная необходимость изучения социального знания в условиях современной техногенной цивилизации, формирующейся под воздействием информационно-компьютерной революции (цифровой революции), следствием которой является становление и развитие информационного общества. Оно отличается от предшествующих обществ тем, что информация как средство накопления и сохранения знания становится в нем главным стратегическим ресурсом [2 - 4]. Осознание данного обстоятельства дало жизнь таким понятиям, как “общество, основанное на знаниях” (“the knowledge-based society”) или “общество знаний” (“the knowledge society”).

В таком новом типе общества основной прибавочный продукт добывается в информационной сфере; большая часть трудоспособного населения занята в информационном секторе экономики; развита информационная структура,

---

*1 Исследование выполнено при финансовой поддержке РФФИ и Министерства культуры, образования, науки и спорта Монголии в рамках научного проекта № 19-511-44003 (“Социальное знание: вызовы современной техногенной цивилизации”).*

обеспечивающая возможность каждому индивиду получать любую необходимую ему информацию в любом месте и в любое время. Следствиями набирающей темпы информатизации общества становятся интеллектуализация профессиональной деятельности почти любого специалиста и виртуализация коммуникации, и медиатизация информационного пространства. Страны с развитой информационной экономикой гораздо легче преодолевают последствия мирового финансового кризиса и оказываются более конкурентоспособными на мировой арене.

В момент вступления техногенной цивилизации в информационную фазу своего развития необходимость создания фундаментальной социальной теории, адекватно описывающей его коммуникативный характер, является очевидной. Требуется содержательная философская концептуализация происходящих в условиях современной техногенной цивилизации глобальных изменений социального знания, а не просто анализ частных вопросов различных обществоведческих дисциплин.

По мере развития цифровой революции, современная техногенная цивилизация превращается, с одной стороны, в глобальную силу планетарного масштаба, способную к невиданным ранее конструктивным технологическим решениям. С другой стороны, ориентиры развития этой техногенной цивилизации угрожают равновесию сложившихся социокультурных структур. В последние десятилетия человечество оказывается перед выбором: сможет ли оно адаптироваться к новейшим технико-технологическим возможностям или же грозящий вследствие их интенсивного развития экологический кризис станет неразрешимым. Современная техногенная цивилизация проходит фазу бифуркации, когда и оптимальные варианты ее дальнейшего устойчивого развития, и катастрофические варианты её дальнейшего неустойчивого развития становятся равновероятными. В точке бифуркации принципиально невозможно предсказать, в какое состояние перейдет современная техногенная цивилизация. Социальный детерминизм вступит в силу только после того, как в итоге реализации в техногенном социуме определенных информационных процессов будет осуществлен выбор одной из обозначенных альтернатив. Каким станет этот выбор ещё не совсем понятно.

В последней трети XX столетия социокультурный контекст, особенности развития современной науки, распространение информационно-коммуникационных технологий во всех сферах жизни социума приводят к появлению концепций современного общества, которые пытаются объяснить противоречия в развитии современной техногенной цивилизации, наметить перспективные направления их преодоления.

Можно выделить два основных подхода к изучению современного общества, а именно: концепции постиндустриального общества, и концепции информационного общества. Приверженцы первого подхода придерживаются точки зрения, согласно которой коренной сдвиг в социуме происходит за счет перемещения общественных интересов из сферы индустриального производства в сферы потребления и услуг.

В разработках представителей концепций постиндустриализма социум представляется как определенная система соотношения процессов производства, распределения и потребления. Рассмотрение этого соотношения носит преимущественно функциональный характер, связанный с анализом недостатков прежнего индустриального общества. При этом не акцентируется внимание на внутренних причинах появления нового информационного по преимуществу общества.

Основоположником концепции постиндустриального общества можно считать американского исследователя Д. Рисмена, который в конце 1950-х – начале 1960-х годов впервые предлагает данный термин для осмысления нового этапа развития современного общества. Еще одним из предтеч идеи постиндустриализма можно считать австралийского экономиста К. Кларка, который в работе, опубликованной в конце 1950-х годов, пишет о приближении общества информации и услуг, общества с новой экономикой и технологией, которое приходит в промышленно развитых странах Запада [7].

Один из наиболее признанных теоретиков постиндустриализма Д. Белл существенную черту постиндустриального общества видит в переходе от производства вещей к производству услуг, связанных с образованием, наукой, медициной и управлением. В последующем его концепция постиндустриализма перерастет в концепцию информационного общества. Знания и информация, по мнению Белла, становятся стратегическим ресурсом постиндустриального общества и главным фактором социального развития. При этом он отмечает особую роль новых технологий: “В наступающем столетии решающее значение для экономической и социальной жизни, для способов производства знания, а также для характера трудовой деятельности человека приобретет становление нового социального уклада, зиждущегося на телекоммуникациях” [1, с. 45]. Согласно Д. Беллу, симбиоз социальных организаций и информационных технологий создает возможность внедрения информационных технологий также в социальную сферу, что выражается в создании интеллектуальных технологий.

Будучи продуктом индустриального мира, постиндустриализм берет на себя роль одновременно его продолжения и его ценностного отрицания. К 1970-м годам в интеллектуальном мире становится понятным, что необходима переориентация экономического развития западной цивилизации, смещение парадигмы прогресса в сторону гуманизации общества и производства, отказ от гонки роста потребления материальных ценностей в пользу удовлетворения и духовных потребностей.

Главным действующим лицом постиндустриального общества, по мнению его приверженцев, станет не гегелевский “дух”, не марксов “класс”, не нация, а совокупная пара “человек - окружающая среда”. И как индивиду потребляющему (элементу экосистемы со своими природными свойствами и качествами), и как субъекту познающему (элементу управляющей и преобразующей деятельности), и как личности (элементу социосреды, со своим местом в динамике социокультурного развития), человеку эпохи постиндустриализма будут свойственны ускоренные изменения. Увеличение объема головного мозга человека и его полезного использования приведет к постепенным превращениям естественного эволюционного процесса в подконтрольную функцию собственной деятельности. Решение сохраниться как биологический вид, защищая экосистему и окружающую среду, позволит постиндустриальному человеку взять будущее в свои руки; активное вмешательство ученых в работу мозга - генетическое “улучшение” человеческой популяции и создание искусственного интеллекта - приведет к созданию более совершенных существ.

Согласно второму подходу к изучению современного общества, представленному в концепциях информационного общества, коренной перелом системы общественных отношений происходит вследствие того, что информация становится основанием любого социального взаимодействия. Оба направления (концепции постиндустриализма и концепции информационного общества)

сближает общий методологический подход к изучению общества с позиций анализа системы взаимодействия различных факторов: технологии, науки, социальной структуры, динамики потребностей и других. Вместе с тем следует отметить, что понятие постиндустриального общества не является главной характеристикой современного и будущего общества. В отличие от него понятие информационного общества более адекватно отражает суть этого общества, формируемого в процессе всесторонней информатизации.

В концепциях информационного общества главное внимание приверженцев данного подхода привлекают информация и знания. Представители данного подхода уделяют также значительное внимание усложнению общественной системы, нелинейности протекания исторических процессов, усилению значимости взаимосвязей социально-деятельностной и культурной подсистем, моделированию сценариев будущего развития. В этом контексте становление и развитие информационного общества рассматривается ими как закономерный этап исторического развития, а общество как саморазвивающаяся система.

Первыми термин “информационное общество” почти одновременно на рубеже 1960-х - 1970-х годов употребляют француз Л. Лаборит, американец Ф. Махлуп и японец Ю. Хаяши. Почти одновременно для обозначения современного общества Дж. Мартин вводит понятие “телематического общества”. В 1970-е годы используются термины “общество третьей волны” и “супериндустриальное общество” Э. Тоффлера, “программируемое общество” А. Турена, “цивилизация услуг” Ж. Фурастье, “общество сервисного класса” и “посткапиталистическое общество” Р. Дарендорфа. В качестве синонимов информационного общества применяются также термины “электронное общество” и “всемирная деревня” М. Маклюэна, “информационно-компьютерное общество” Й. Масуды, “технотронное общество” З. Бржезинского и другие. С 1980-х годов для характеристики современного общества общепринятым и устойчивым термином становится понятие информационного общества. Несмотря на различные определения нового типа общества, все исследователи отмечают, что приоритеты этого типа общественного устройства направлены на производство услуг и информации.

Одну из первых разработанных концепций информационного общества предлагает японский исследователь Й. Масуда, который называет информационным обществом “компьютеризированное общество, в котором движущей силой общественного развития является производство нематериального, информационного продукта” [8, р. 29]. Фундаментом этого общества он считает компьютерные технологии. Информационная революция сделает возможным массовое производство когнитивной информации, новых технологий и знания. Масуда рассматривает информационное общество преимущественно в экономическом контексте. По его мнению, в условиях нового общества должна измениться сущность самого производства, продукт которого станет информационноемким. Благодаря этому “производство информационного продукта, а не продукта материального будет движущей силой образования и развития общества” [8, р. 29]. Ведущей отраслью экономики, по его мнению, станет интеллектуальное производство, продукция которого будет создаваться и распространяться с помощью информационно-коммуникационных технологий.

Следующий теоретик информационного общества Э. Тоффлер основную роль в развитии общества также отводит информационным технологиям. Компьютеры только тогда станут оказывать воздействие на социальный организм, когда их

применение станет системным и соотнесенным с характером социальных связей. Тоффлер отмечает, что “компьютерные технологии и информационные сети, являются символами нового общества, приходя на смену фабрикам - символам индустриального общества” [6. с. 34].

Такой представитель концепций информационного общества, как М. Кастельс осуществляет анализ тенденций развития этого общества. Он определяет границы информационно-технологической парадигмы. Информация в его концепции является сырьем технологии. Информационная технология активирует сетевую логику изменений социальной системы. В качестве одной из важнейших характеристик этой парадигмы выступает конвергенция конкретных информационных и телекоммуникационных технологий в высоко интегрированной системе [5].

Первоначально процесс развития современной техногенной цивилизации рассматривается зарубежной социально-философской мыслью в конце 1960-х - середине 1980-х годов преимущественно в виде концепций постиндустриального общества, что является одним из возможных вариантов социально-философского и теоретико-футурологического исследования. С середины 1980-х годов окончательно утверждаются в качестве концепций современного общества концепции информационного общества. При этом будущее современной техногенной цивилизации начинает связываться с реализацией стратегии устойчивого развития.

Общим итогом информационного подхода является выделение в качестве существенных особенностей современного общества возможностей быстрого обмена информацией и ее преобразование в новое знание, а также экспоненциальное увеличение объемов производимой и потребляемой в этом обществе информации. Информационным следует считать общество, которое характеризуется созданием глобальных сетей, посредством которых осуществляется сбор, переработка, распространение и хранение массивов информации, а также возможностью свободного доступа к информации любого вида. Информационное общество характеризуется также новым видом человеческой деятельности - информационной активностью. Информационное общество это не только глобальные компьютерные сети, новые информационно-коммуникационные технологии, но в первую очередь люди, способные воспринимать и работать с этими новыми технологиями, использовать их в своей повседневной деятельности.

Завершая анализ концепций постиндустриального общества и концепций информационного общества, сопоставим термины “постиндустриальное общество” и “информационное общество”. Термин “постиндустриальное общество” отражает результат эволюции индустриального общества. Постиндустриальное общество представляет собой такую форму существования современного общества, которая не определяет его сущность, а лишь указывает на его место в историческом процессе, как на общество, которое следует за индустриальным, но каким будет это общество, это название не определяет. Понятие же “информационного общества” задает специфику развития современного общества, определяет существенную характеристику его как такого общественного устройства, в котором исключительную роль играют знания, информация и информационно-коммуникационные технологии.

**Библиография**


1. Белл, Д. Грядущее (1999). постиндустриальное общество, Опыт социального прогнозирования. - М.
2. Иноземцев, В. А., Ивлева, М. Л., Ивлев, В. Ю. (2012). Становление новой философско-методологической парадигмы современной науки в условиях информационного общества: Монография. - М.: "ИТО СЕМРИК".
3. Иноземцев, В. А., Удовик, В. Е. (2011). Информационно-компьютерная революция и становление информационного общества // Исторические, философские, политические и юридические науки, культурология и искусствоведение. Вопросы теории и практики. - Тамбов. №8 (14).-С. 69- 74.
4. Информационное общество и формирование новой эпистемологической парадигмы современной науки: Монография / В.А. Иноземцев [и др.]. - М.: "ИТО СЕМРИК", 2013.
5. Кастельс, М. (2000). Информационная эпоха: экономика, общество и культура. - М.
6. Тоффлер, Э. (2002). Шок будущего. - М.
7. Clark, C. (1957). The conditions of economic progress. - London.
8. Masuda, Y. (1981). The Informational Society as Post-Industrial Society. – Washington.

# НИЙГМИЙН ДЕФОРМАЦИЙН МЕХАНИЗМ

Д.Ганболд, доктор (PhD)
*ШУТИС. Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

***Товч утга:*** *Дэлхийн улс орнуудын нийгэм судлаачдын хэлэлцэж буй асуудлын төвд нийгмийн дегуманизаци голлох байр суурь эзэлж байна. Үүний учир нь орчин үеийн нийгэмд амьдарч буй хүний үйлдлийн мотив янз бүрээр илэрч байгаатай холбоотойгоос гадна хүн өөрөө дотооддоо зөрчилт чанарыг агуулж явдагтай холбож үзэх ёстой. Орчин үеийн хүн дотооддоо зөрчилтэй, дотоод атгаг санаа ихтэй (амбиц) тул энэ асуудлыг зүгээр л хараад суугаад байж болохгүй. Үүнд нь тайлбар хийх заавал шаардлага амьдралаас нэхэгдэж байна. Дегуманизацийн хандлагын ямар ч хэлбэрийн олон үр дагавар эцсийн нийлбэр дүнгээрээ нийгмийн деформацийг бий болгож байгааг хүн төрөлхтөн XX зуунаас эхлэн яс махаараа мэдэрч байна.*

***Түлхүүр үг:*** *Гуманизм, гуманитар хөгжил, дегуманизаци, деморализаци, деградаци, нийгмийн деформаци, нийгмийн деформацийн механизм, тайлбарлагч парадигм, Нийгмийн деформацийн тулгуур механизм, нийгмийн дэг журам, нийгмийн хяналт, нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлс, нийгмийн харилцааны нөхөн үйлдвэрлэлийн механизм, нийгмийн эмгэг, нийгмийн үнэт зүйлс, нийгмийн харилцаа, нийгмийн хэм хэмжээ, нийгмийн институтүүд, нийгмийн институтүүдийн хямрал*

***Abstract:*** *Social dehumanization is at the heart of the debate among sociologists around the world. This is due not only to the fact that in modern society the motives of human actions are manifested in different ways, but also to the fact that man himself has internal contradictions. Modern man should not just sit and watch this issue because he has internal conflicts and ambitions. There is a real need to explain this. Since the twentieth century, humanity has felt that many consequences of any form of dehumanization tend to ultimately lead to social deformation.*

***Keywords****: Humanism, humanitarian development, dehumanization, demoralization, degradation, social deformation, social deformation mechanism, explanatory paradigm, fundamental mechanism of social deformation, social order, social control, social norms, values, social relations compensation mechanism, social pathology, social values, social relations, social norms, social institutions, crisis of social institutions*

**Оршил**

Нийгмийн гуманитар хөгжлийн онолын цөм нь **гуманизм.** Хүн төрөлхтний шилдэг оюун ухаантнууд эрт үеэс энэ асуудалд ухаанаа уралдуулсаар ирсэн. Эртний грекийн гуманизм Аристотель, Демокрит, Эпикур, Лукреций, Протагор, Сократ, Сэргэн мандлын үед сонгодог гуманизм Френсис Бэкон, Боккаччо, Эразм Роттердамский, Монтень, Томас Мор, Петрарка, XIX-XX зууны үед гуманизм Лев Толстой, Махатма Ганди, Мартин Лютер Кинг нарын бүтээлүүдэд тусгалаа олсон байдаг.

Эдүгээ эрдэмтэд **гуманизмыг соёлын үзэгдэл** мөний хувьд дараах чиглэлүүдээр

судалж байна. Үүнд:

*1. түүхэн уламжлалын судалгаа*

*2. парадигмчилсан хэлбэрийн судалгаа*

*3. мэдлэгийн систем зэрэг болно.*

Эдгээрээс парадигмчилсан хэлбэрийн судалгааны чиглэл нийгмийн деформацийн механизмыг тайлбарлахад чухал юм. Энэ чиглэл дотроо дараах дэд чиглэлүүдэд хуваагддаг. Үүнд:

а/ хувьслын гуманизм (Ж.Хаксли, Д.Симпсон, К.Уоддингтон, Ж.Хемминг, Ж.Бёркс);

б/ Ноосферийн гуманизм (В.И.Вернадский, А.А.Богданов, Н.А.Умов, А.Л.Чижевский, О.Райзер, Н.Н.Моисеев, И.М.Борзенко);

в/ экологический гуманизм (Н.В.Тимофеев-Ресовский, Е.А.Когай, Г.Парсонс, Ф.Рейгал, Флорис ван ден Берг);

г/ Иргэний гуманизм (В.Л. Гинзбург, Г.В. Гивишвили, А.Г. Круглов, В.А. Кувакин, Г.Г.Шевелев, С.С.Перуанский, А.С.Шутов, В.Д.Жукоцкий) зэрэг болно.

Парадигмчилсан хэлбэрийн судалгааны чиглэл ёсоор шинжлэх ухаан болон шүүмжлэлт сэтгэлгээг хүний оршихуйн өргөн цар хүрээтэй асуудлын хүрээнд ашиглахыг (шинжлэх ухааны танин мэдэхүй, шашин шүтлэг, ёс зүйн дилеммүүд, иргэний амьдрал гэх мэт) чухалчлан үздэг тул өнөөгийн гуманитар хөгжлийн асуудлын үндэслэлд нэн чухал ач холбогдолтой.

Нийгмийн гуманитар хөгжлийн асуудлаар ОХУ-ын эрдэмтэд 2050 он хүртэл Оросын нийгмийг хөгжүүлэх талаар судалгаа бүхий дорвитой бүтээлүүдийг туурвисан байдаг[1].

Монголын нийгэм судлаачдын бүтээлүүдэд нийгмийн гуманитар хөгжлийн асуудал гуманистикийн талаас ямар нэг дам байдлаар тусгагдсан байдаг[2].

Орчин үеийн глобал асуудлыг гуманизмын байр сууринаас шийдвэрлэхэд нийгмийн хөгжлийн эрч хүчийг алдуулж буй **деформацийн механизмын үйлчлэлийг** тодорхойлох нь зайлшгүй.

Нийгмийн гуманитар хөгжил дэх нийгмийн деформацийн асуудлыг гуманизмын байр сууринаас шийдвэрлэхэд нийгмийн философийн үүргийг тайлбарлагч парадигмын үүднээс тодорхойлоход дараах үндсэн зорилтуудыг анхаарах нь чухалчлах хэрэгтэй. Үүнд:

- Орчин үеийн глобал асуудалд гуманизмын байр сууринаас хандаж, тулгарч буй бэрхшээл зөрчлийг шийдвэрлэхэд нийгмийн философийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох;

*1 Кузык Б.Н., Яковец Ю.В. «Россия - 2050: стратегия инновационного прорыва». Второе издание, дополненное. М., 2005. Коптюг В.А., Матросов В.М., Левашов В.К. Новая парадигма развития Росии в XXI веке. Комплексные исследования проблем устойчивого развития: идеи и результаты. Изд.2. М., 2000*

*2 Б.Батчулуун. Философи дахь хүний асуудал. УБ., 2001, Б.Даш-Ёндон. Сэтгэлгээгээ шинэчлэх нь хямралаас гарч дэвжихийн үндэс. - Бодрол бясалгал. УБ., 1993, №1-2, Н.Хавх. Нийгмийн гүн ухаан. УБ., 1997., Н.Хавх. Монголын нийгмийн гүн ухаан. УБ., 1999., Д.Дашпүрэв. Монголын нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн үе шатууд. УБ.2005., Монголын нийгмийн өөрчлөлтүүд. (хамтын бүтээл) УБ., 2008., К.Зардыхан, Г.Чулуунбаатар. Социализм уу эсвэл хөгжлийн гажил уу?. УБ., 1992., Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил хөгжил. УБ., 1999., С.Цэдэндамба. Буддизмын философи ба тогтвортой хөгжлийн үзэл баримтлал. - Гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ (соёл иргэншил: гүн ухаан, хөгжил). №15. УБ., 1998., Ү.Нямдорж. Соёлын философи Монгол соёл УБ., 1996., Б. Сумъяа. Монголын нүүдэлчдийн соёл: оршихуй, эс оршихуй. УБ., 1998., Т.Дорждагва. Соёлын философи-түүхэн товчоон. УБ., 2003., Ш.Ганхуяг. Соёл иргэншил дэх байгалийн ба соёлын хүчин зүйлийн хамаарал. УБ., 2004.*

- Нийгмийн гуманитар хөгжилд тулгарч буй **дегуманизаци, деморализаци, деградаци,** чиг хандлагуудыг деформацитай харьцуулан тогтоох;
- Нийгмийн гуманитар хөгжлийг философийн шинжлэх ухааны талаас үндэслэх;
- Нийгмийн гуманитар хөгжлийн тулгуур ойлголтуудын нийгэм-философийн утга холбогдлыг илэрхийлэн гаргах;
- Монголын нийгмийн гуманитар хөгжил дэх нийгмийн деформаци, бодит байдал, бэрхшээлд нийгмийн экспертиз -философийн анализ хийх;
- Нийгмийн гуманитар хөгжил ба засаглалын хариуцлагын асуудал
- Хариуцлагагүй засаглалаас хариуцлагатай засаглалд шилжих нийгмийн императив;
- XXI зууны нийгмийн гуманитар хөгжлийн шинэ парадигмийн эдийн засгийн философийн үндсийг ерөнхий байдлаар тайлбарлах зэрэг болно.

Нийгмийн гуманитар хөгжил дэх нийгмийн деформацийн механизмыг тайлбарлахад өнөөгийн нийгмийг гуманитар бүх шинжлэх ухаануудын хувьд нэгтгэх үүрэг бүхий нэг фундаменталь социеталь (нийгмийг бүхэллэг зүйл хэмээн үзэх) онол байх ёстой хэмээн үздэг тайлбарлагч парадигм илүү чухал.

**Нийгмийн деформаци ба нийгмийн деформацийн механизм**

Ер нь нийгмийн деформацийн тулгуур механизм гэж юу болох талаар хариулт өгөхгүйгээр үүнийг тайлбарлах боломжгүй юм. Хүн төрөлхтөн байгалийн хөгжлийн олон мянган жилийн хугацаанд амьд тэсэн үлдэх эсэх нь түүний өөрийнх нь тоо толгойн нөхөн үйлдвэрлэхээс шууд хамаарч байв. Ингэхдээ бодгаль хүн бусдын зан төлөвийг зүгээр ч нэг хуулбарлах замаар хөгжсөнгүй. Хүний нөхөн үйлдвэрлэлтэй зэрэгцэн нийгмийн хэм хэмжээ болон үнэт зүйлс ч нөхөн нөхөн үйлдвэрлэгдэж байв.

Нийгмийн дэг журам нийт гишүүдээс нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг шаарддаг. Нийгмийн дэг журамгүйгээр хүмүүс хоорондын харилцан үйлчлэл утгаа алддаг. Иймд нийгэм өөрийн гишүүдийн үйлдэл бүхэн нийгмийн тулгуур хэм хэмжээнд тохирч буй эсэхийг нийгмийн хяналтын тусламжтайгаар баталгаажуулж байдаг.

Нийгмийн хяналт гэдэг нь нийгмийн хэм хэмжээ болон цээрлэлт хэмээх эрх зүйн зохицуулалтын тусламжтайгаар нийгэм хэмээх системийг эмхлэн цэгцэлж өөрийгөө тохируулж байдаг арга юм. Нийгмийн хэм хэмжээний хэрэгжилт үнэхээр чухал асуудал. Учир нь нийгмийн хэм хэмжээ нийгэмд болж буй үйл явцын чиг хандлага, эрч хүчийг тодорхойлоод зогсдоггүй. Хамгийн гол нь нийгэмд хяналт, тогтвортой байдлыг үүсгэн бэхжүүлж байдаг. Хэрэв нийгмийн хяналт байхгүй бол энэ нь ихэнх тохиолдолд цус асгаруулсан тэмцлээр дуусдаг байсныг түүхийн олон баримт нотолдог. Өөрөөр хэлбэл, нийгмийн аноми буюу ямар ч хууль үйлчлэхээ больдог. Энэ үед нийгмийн гишүүдийн хувьд шударга, үнэ цэнтэй, эрхэм дээд гэж тооцогдож байсан бүх зүйл үнэ цэнгүй болж, нийгмийн тогтвортой байдал алдагдаж, задрал, мөхлийн аюул тулгардаг.

Хэрэв **нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлс** нийгмийг системлэг шинжтэй болгож чадах ахул нийгмийн гишүүдийн ухамсарт сайшаан дэмжих болон цээрлэх зүйлийг зааглан төлөвшүүлж өгдөг. Гэхдээ үүнийг нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлс дангаараа хянаж хэрэгжүүлж чаддаггүй. **Нийгмийн харилцааны нөхөн үйлдвэрлэлийн механизм** нийгмийн хяналтын үүргийг өөртөө тээж явдаг. Нийгмийн хяналт нь хэм хэмжээ (нийгэмд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зан үйлдлийн дүрэм), цээрлэл (дээрх хэм хэмжээг мөрдөөгүй тохиолдолд үзүүлэх цээрлүүлэх арга хэмжээ) гэсэн

хоёр элементээс бүрддэг. Нийгмийн хэм хэмжээ болон цээрлэлийг чанд сахин хэрэгжүүлснээр нийгэм дэх хүмүүсийн зан үйлдлийг урьдаас хянах боломжтой байдаг. Нийгмийн хэм хэмжээ бүрд тохирсон цээрлэл бий. Ямар нэг хэм хэмжээ цээрлэлгүй болчихвол энэ нь уриа лоозонгоос хэтрэхээ больдог. Нийгмийн хяналтын суурь элементийн үүргээ алддаг. Ийм учраас нийгмийн хяналтыг нийгмийн харилцааны тогтворжилтын тулгуур үндэс хэмээн тооцдог. Хэрэв энэхүү үндэс ганхвал нийгмийн гаж үйлдэл (девиац), нийгмийн бухимдал, тогтворгүй байдал нийгэмд үүсдэг. Нийгмийн гишүүдийн зарим нэг хэсгийн зан үйлдэл девиант (гэмт хэрэг, архидалт, тэнүүчлэл, золбинтолт гэх мэт бусад нийгмийн эмгэгүүд) байх нь зайлшгүй бөгөөд үүнийг "үндсээр нь устгана" гэвэл боломжгүй. Хэдийгээр нөхцөл байдал иймэрхүү хүнд байсан ч нийгмийн хяналтын ачаар **нийгмийн эмгэгийн** (патологи) тоог зохицуулж, улмаар нийгмийн үйл явцыг удирдах боломжтой. Үүний тулд төр болон нийгмийн зүгээс тухайн улс оронд дагаж мөрдөх хэм  хэмжээ болон эрхэмлэх үнэт зүйлс, нийгмийн хяналтын сайтар бодож боловсруулсан нэгдмэл систем байх нь юунаас ч илүү чухал. Ийм системийг хийгээгүй цагт нийгэм дэх тогтворгүй байдал даамжирч, төрийн статус суларч удирдлагагүй байдал, хямрал нүүрлэсээр байдаг. Төрийн статус суларснаар асуудлыг шийдвэрлэх чадвар мохож, аливаа асуудлыг шийдвэрлэж чадахгүйгээр үл барам улс төрийн зориг, шийдэмгий чанар үгүй болдог. Энэ нь улс орон даяар хүчирхийлэл, хууль ёсгүй байдал хавтгайрахад хүргэдэг. Төр өөрөө ч дотроосоо гэмт хэргийн сүлжээнд идэгдэж эхэлдэг.

Нийгмийн деформаци нарийн, олон талт, энгийн шулуун үйл явц биш гэдэг нь практикаас тодорхой. Энэ үйл явцын цар хүрээ бодгаль хүний деформациас эхлээд глобал деформаци (хүн байгалийг эвдлэн сүйтгэж буй) хүртэл олон янз. Нийгэм судлалын, тухайлбал, социологийн ном зохиолуудад нийгмийн деформаци, нийгмийн мөргөлдөөн, нийгмийн девиаци (хүний үйлдэл нийгмийн норм хэмжээнээс хазайх), нийгмийн бухимдал зэрэг нь цорын ганц, үндсэн нэг хүчин зүйлээс шалтгаалдаг хэмээн эрж судлах нь утгагүй гэдэг нь нэгэнт тогтоосон үнэн. Орчин үеийн нийгмийг Р.Дарендорф үзэхдээ: "Энэ нийгэм хоёр дүр төрхтэй: нэг нь тогтвортой байдал, зохирол, үзэл санааны нэгдмэл цулын төрх, нөгөө нь хувьсал өөрчлөлт, мөргөлдөөн, бухимдлыг агуулсан төрх"[3] гэжээ. Орчин үеийн нийгмийн хувьд хоёр дахь төрх бодитойгоор байна гэдэг нь хялбархан харагдана.

Хэрэв нийгмийн амьдралын хувьсал өөрчлөлтийн явцад хамгийн их өргөн оролцдог элементүүдийг авч үзвэл **үнэт зүйлс, нийгмийн харилцаанууд, хэм хэмжээ, институтүүдийг** юуны өмнө нэрлэж болно. Эдгээрийн аль элементээс нийгмийн деформаци эхэлсэн бэ? гэсэн асуудал зүй ёсоор тавигдана. Энд шууд хариулт өгөхөд хэцүү. Нийгмийг эвдлэн бөхөөдөг элемент гэж үзвэл энэ нь нарийн асуудал. Учир нь хөшүүн царцанги тогтолцоог уг элемент нурааж байна гэвэл нийгмийн дэвшилд буянтай хэрэг болно. Үүний зэрэгцээ тухайн нийгмийн систем гадны нөлөөгөөр эвдрэн нурж байна хэмээвээс "жам ёсны өөрийн нь хөгжил" гэхээс өөр аргагүй. "Жам ёсны өөрийн хөгжил" гэдгийг хашилтад авсан нь тодорхой утгатай. Системийн өөрийн хөгжил нь бүрэлдэж буй нийгмийн бүтцийг эвдэн сүйтгэж хямралд хүргэж байгаа нь жам ёсных болох тухай асуулт урган гарна. Өнөөгийн нийгмийн деформаци үнэндээ ингэж л явагдаж эхэлсэн гэж үзэхээс өөр аргагүй.

Хэрэв үнэт зүйлс, нийгмийн харилцаанууд, хэм хэмжээ, институтүүдийн хувьслыг сайтар нягтлан авч үзвэл **хямрал институтүүдээс улбаатай** болохыг төвөггүй мэдэх болно. Ер нь нийгмийн институтийн нийгэмд гүйцэтгэх гол үүрэг

*3 Darendorf R. Out of utopia: Toward a Reorientation of Sociological Analysis. – "American Journal of Sociology". 1958, №64, p.127*

бол системийн элементүүдийн хооронд тогтвортой харилцааны хэв маягийг бий болгох, өөрөөр хэлбэл, нийгмийн тодорхой хэрэгцээг хангах явдал юм. Нийгмийн институтүүд тогтвортой оршин тогтнож энэ үүргээ амжилттай гүйцэтгэх гол нөхцөл нь нэлээд хэдэн хүчин зүйлээс шалтгаалдаг. Үүнд:

- үйл ажиллагааны зорилго, функц, арга нь хэрхэн тодорхой байхаас;
- нийгмийн гадаад болон дотоод холбоог хэрхэн зүй зохистой зохион байгуулснаас;
- хүмүүсийн үйлдлийн деперсонализацийн (нийгмийн институтүүдийн биелүүлэх ёстой функц хүмүүсийн ажлын үүргийг сайн чадварлаг хуваарилах, уг үүргийг албан тушаал хашиж биелэлтийг нь хангадаг механизмын бүрэн бүтэн ажиллагаанаас шууд хамаарахыг хэлнэ) зэрэг хэмжээ, функцийг хэрхэн объективчилж байгаагаас, тухайлбал, институтын практик ач холбогдол, нийгэм болон нийгмийн бүлгүүдэд үзүүлж буй үр нөлөөнөөс зэрэг болно.

Эдгээр шаардлагууд зөрчигдөөд эхлэмэгц нийгмийн институт зайлшгүй биелүүлэх үүргээ гүйцэтгэж чадахгүй болж утгаа алддаг. Ийм байдал эдийн засгийн удирдлагын бүтцүүд, шинжлэх ухааны ололт амжилтын ашиглалт, хөдөө аж ахуй болон аж үйлдвэр дэх хөдөлмөр зохион байгуулалт, боловсрол соёлын хөгжилд юуны түрүүнд мэдрэгдэж эхэлдэг. Үүний гол шалтгаан нь төрийн засаглал, удирдлагын системийн байгууллагын үйл ажиллагааны бүтэц нь өөрчлөгдөж буй нийгмийн орчинд тохирохоо больж, орчин үеийн нийгмийн технологийн, социаль амьдралын, зан суртахууны хамгийн энгийн шаардлагуудыг хангаж чаддаггүй. Үүнээс институтүүд үндсэн үүргээ биелүүлж чадахгүй байна гэсэн дүгнэлт хийж болно.

Нийгмийн институтүүдийн биелүүлэх ёстой функц алдагдсанаар эдгээр нь деградацид ордог. Төрийн удирдлагын аппаратын “толгой данхайж” хүнд сурталд идэгддэг. Энгийн үүргээ биелүүлэх явдал хүндрэлтэй байдлаас бүр зогсонги байдалд шилждэг. Дараа нь албан ёсны байгууллагуудын идэвхгүй байдлыг “нөхөн орлох” зорилготой “сүүдэр” параллель бүтцүүд бий болно.

Эдгээрийг үр дагавруудын зөвхөн нэг хэсэг нь хэмээн үзвэл зүйд нийцнэ. Нийгмийн институтүүдийн деформаци нийгмийн амьдралын бусад хэсгүүдэд дараах 4 замаар үргэлжлэн нөлөөлнө. Үүнд:

- Нийгмийн институтийн деформаци хүмүүсийн нийгмийн хүлээлтийг биелүүлж чадаагүй тул нийгэмд бухимдлыг бий болгоно.
- Үүнээс улбаалж төрийн болон удирдлагын албан ёсны бүтцийг албан бус холбоо харилцаагаар солиход олон түмэн тэмүүлж эхлэнэ. Энэ нь хүний эрхийн эсрэг шинжтэй хэлбэрээр ч байж болно.
- Нийгмийн институтүүдийн үйл ажиллагаанд урт хугацаагаар функцийг нь алдагдуулсан (дисфункц) шинжтэй үйл явц үргэлжилсний улмаас нийгмийн зан суртахууны дүр төрхөд муугаар нөлөөлж, хүмүүсийн үнэт зүйлсийн баримжаа болон үйлдлийн шалтгаан (мотиваци) алдагдана.
- Нийгмийн институтүүдийн хяналтын функц суларснаар нийгмийн хэв журмыг зөрчигчид ял шийтгэл хүлээдэггүй байдал газар авч, нийгэм нийтээрээ хариуцлагагүй болж хувирна. Энэ нь цаашид улам гүнзгийрч нийгмийн систем ямар үр дагавартайгаар үргэлжлэхийг урьдчилан харах бололцоогүй болж бүхэлдээ суларна. Хувь хүмүүсийн зүгээс хийх үйлдэл нийгмийн норм хэмжээнээс хазайж, нийтийг хамарсан шинжтэй болж улам их аюулыг араасаа дагуулах болно. Нийгмийн зан суртахууны норм, норматив алдагдана. Энэ мэтээр деградаци хүчтэй явагдаж үйл явц хяналтаас гарч нийгмийн задрал, мөхлийн замын үүд нээгддэг.

Нийгмийн институтүүдийн систем нийгмийн хурдацтай өөрчлөлтийн үед хамгийн ихээр деформацид ордог. Иймээс олонх уламжлалт институтүүдийн өмнө дилемм үүсдэг. Үйл ажиллагаагаа шууд зогсоох, эсхүл шинэ зорилтыг шийдвэрлэхэд дасан зохицох гэх мэт. Нийгмийн шинэ институтүүдийг нийгмийн шинэ үнэт зүйлс, нормын үндсэн дээр дахин шинээр зохион байгуулахад цаг хугацааны урт үе шаардагддаг. Зан байдлын шинэ үйлдлийн стандартыг богино хугацаанд хүмүүсийн ухамсарт суулгаж, сэтгэл зүйг түргэн өөрчилж болдоггүй. Нийгмийн харилцаа хараахан зохистойгоор зохион байгуулагдаж амжаагүйн улмаас хүмүүс амьдрал үйл ажиллагааныхаа уламжлалт хүрээнд нийгмийн дэг журмыг сахин биелүүлэхийн тулд нэлээд бэрхшээлтэй тулгардаг. Заримдаа барьц алдах ч бий. Нийгмийн уламжлалт институтүүдийн ийм зохион байгуулалтгүй нийгмийн шилжилтийн үеийг Э.Дюркгейм **аноми** хэмээн нэрлэсэн нь буй. Энэхүү ойлголтыг хамгийн ерөнхий утгаар авч үзвэл хуулийг уландаа гишгэсэн деформаци хэмээн нэрлэж болно.

### Ном зүй


1. НҮБ-ийн Хүний хөгжлийн илтгэл. (2004). Культурная свобода в современном многообразном мире – Доклад о развитии человека.
2. Монгол Улсын Үндсэн хууль (1992). УБ.
3. Дашпүрэв, Д. (2005). Монголын нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн үе шатууд. УБ.
4. Ганболд, Д. (2007). Философи.Техникийн их, дээд сургууль, коллежид суралцагсдад зориулсан сурах бичиг. УБ. 187-188 дахь тал
5. Ганболд, Д. (2008). Шинжлэх ухааны философи. //ШУТИС-ийн докторантурын сургалтад зориулсан хичээлийн шинэ сурах бичиг. II, IV хэсэг. УБ.
6. Ганболд, Д. (2011). Глобалчлал ба нийгмийн гуманитар хөгжил. //Д.Ганболд. Техникийн философи. Магистрын сургалтад зориулсан гарын авлага. УБ.
7. Ганболд, Д. (2011). Гуманизм ба хүн төрөлхтөн. //Д.Ганболд. Техникийн философи. Магистрын сургалтад зориулсан гарын авлага. УБ. 2011.
8. Ганболд, Д. (2011). Гуманизмын философи үндэслэл //Д.Ганболд. Техникийн философи. Магистрын сургалтад зориулсан гарын авлага. УБ.
9. Ганболд, Д. (2011). Ёс суртахуун, зан суртахууны үнэт зүйлс, эрх зүй, шударга ёс. //Ганболд, Д. Техникийн философи. Магистрын сургалтад зориулсан гарын авлага. УБ.
10. Ганболд, Д. (2011). Миграци ба мультикультурализм. //Д.Ганболд. Техникийн философи. Магистрын сургалтад зориулсан гарын авлага. УБ.
11. Ганболд, Д. (2011). Нийгмийн гуманитар хөгжлийн тухай шинэ үзэл баримтлалын төлөвшилт. //Ганболд Д. Техникийн философи. Магистрын сургалтад зориулсан гарын авлага. УБ.


### *Орос хэл дээр*


1. Печчеи, А. (1980) Человеческие качества. Прогресс, Москва.
2. Леви-Стросс, К. (1984). Печальные тропики. М.: Мысль,
3. Демоз, Л. (2000). Психоистория. Ростов/Дон: Феникс,
4. Довгуша, В. В., Тихонов, М.Н. (1996). Нет войнам! //Жизнь и безопасность, №4.

5. Дьяконов, И. М. (1994). Пути истории. От древнейшего человека до наших дней. М.: “Восточная литература” РАН.
6. Келле, В. Ж., Ковальзон М.Я. (1981). Теория и история: Проблемы теории исторического процесса. М.
7. Кеннеди, П. (1997). Вступая в двадцать первый век. М.: Весь Мир,
8. Коптюг, В. А. (1993) Конференция ООН по окружающей срде и развитию (Рио-де-Жанейро, И. 1992. Информацонный обзор. Новосибирск.
9. Леви-Брюль, Л. (1930) Первобытное мышление. М.: Атеист.
10. Рапопорт, А. (1993) Мир - созревшая идея. Дармштадт: “Дармштадт Блеттер”,
11. Семченко, А. Т. (1989). Современный апокалипсис М.,
12. Скворцов, Л. В. (1992). Цивилизованная власть: политические и нравственные основания //Человек: образ и сущность: Ежегодник. М., № 3.
13. Тимирязев, К. А. (1949). Исторический метод в биологии. Десять общедоступных чтений. В кн.: Избр. Соч. в 4-х томах, т.Ш. М.: Сельхозгиз,
14. Фрэзер, Дж. (1983). Золотая ветвь. М.: Политиздат, Diamond J. Guns, germs, and steel.
15. Энгельгардт М. А. (1899). Прогресс как эволюция жестокости. СПб.: Ф. Павленков.

***Англи хэл дээр***

1. Diamond J. Guns, (1999). germs, and steel. The fates of human societies. N-Y., London: W.W. Norton & Company,
2. Joy, B. (2000). Why the future doesn’t need us. // Wired, April.
3. The fates of human societies. N-Y., London: W.W. Norton & Company, 1999.

# МОНГОЛЫН НИЙГМИЙН МОДЕРНИЗАЦИЙН ҮЕ ШАТНЫ АСУУДЛААР МАНАЙ ОРОНД ХЭРЭГЖИЖ ИРСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Д.Дашпүрэв, доктор (Sc.D), профессор
*Олон улс судлалын дээд сургууль*

***Товч утга**: Монгол үндэстэн ардчилсан өөрчлөлтийг амжилттай хийсэн нь модернизацийн тухай судлахад чухал суурийг гарган өгч байна. Энэ явцад урган гарч, өөрчлөгдөж буй Монголын модернизацийн талаарх үзэл баримтлалууд ба өөрчлөгдөж буй нөхцөл байдлын тухай уг өгүүлэлд авч үзнэ. Зөвлөлт Холбоот Улс ба Дэлхийн Социалист Тогтолцоо унаснаас хойш Монголын тухай судалгаа өрнөд эрчимтэй хийгдэх болов. Гэвч орчин үеийн Монгол дахь ардчиллын үйл явцад залгамж, тогтвортой чанар дутагдаж байна. Хэдий тийм ч модернизаци явагдсан хэвээр байгаа юм.*

***Түлхүүр үг**: Монгол нийгэм, нийгмийн хөгжил, нийгмийн өөрчлөлт, иргэншил, нүүдлийн иргэншил, нийгмийн модернизаци*

***Abstract**: Mongolia, as the non-western nation that has succeeded in reaching the democratic changes, provides an important basis for studies of modernization. This paper investigates the changing climate of opinion and views of Mongolian modernization that arose during the process. Scholarly studies of Mongolia have had a remarkable growth in the western countries since the end of Soviet Union and the World Socialist System. However, it is one thing that the democratic movement and democratization in modern Mongolia lacked continuation and perseverance. Of course, modernization is going as well as before.*

***Keywords**: Mongolian society, social development, social change, civilization, nomadic civilization, social modernization*

1990-ээд оноос хойш монголын академик хүрээлэлд нийгэм, улс төрийн философи, онолын чиглэлээр хийгдсэн судалгааны ажлын нэг хэсэг бол “монгол нийгмийн модернизаци”-ийн асуудал юм.

Модернизацийн онолын байр сууринаас XX зууны монголын нийгмийн “өөрчлөлт”, “хөгжил”-ийн асуудлыг авч үзэхдээ шууд хатуу “марксист-ленинист онол”-ын бус байр сууринаас хандаж байгаа учраас “уламжлалт монгол нийгэм” гэдэг ухагдахууныг тодорхойлон нийгэм судлалын сэтгэлгээний эргэлтэнд оруулсан билээ. Уг ухагдахууны агуулгыг задлан илэрхийлэх явцад “билчээр-нүүдлийн мал аж ахуй” /пастобышное кочевое скотоводство”/, гэсэн нэрийдлүүдийн/”термина”/ утгыг шинэлэг үзэл санаагаар тайлбарлах шаардлага гарч ирсэн байна.

Юуны өмнө “уламжлалт монгол нийгэм” гэдэг ямар нийгэм бэ? Энэ бол бүр хоёр мянга гаруй жилийн өмнөөс үүсэн бүрэлдсэн бөгөөд “билчээр”-ийг дагасан нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэл дээр суурилсан аж амьдралын хэв маягтай, угсаа гарал нэгтэй, уламжлан бүрэлдсэн адил зан заншил, шүтлэг бишрэлтэй, нийтлэг хэл яриа ба үсэг бичигтэй, нэгэн төрийн дор зохион байгуулагдсан монгол

гэгдэх хүмүүсийн нэгдмэл оршихуй байлаа. Тэднийг нүүдэлчид /"nomadic people"/ гэх боловч тэдэнд төрийн тогтолцоо, соёлын бие даасан хэв шинж, аж амьдралын тогтсон хэв маяг, хаашаа ч нүүж явсан үндсэн хэсэг нь заавал эргэж ирдэг нутаг орон, түүхээ юун дээр ч болов тэмдэглэн бичиж үлдээдэг үсэг бичиг, нийтээр дагаж мөрддөг хууль ёс, амьдралынхаа гол хэрэгсэл болох мал сүргээ даган тархай бутархай суух боловч тасалдалгүй ажилладаг харилцаа холбооны түргэн шуурхай хөдөлгөөнт механизмтай байжээ. Товчхон хэлбэл, "уламжлалт монгол нийгэм" бол туйлын өвөрмөц хөгжилтэй "цивилизаци" /иргэншил/ бүхий нийгэм байв.

Энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажлын явцад монголын уламжлалт нийгмийн үйлдвэрлэлийн үндэс бол билчээр-нүүдлийн мал аж ахуй байжээ гэсэн дүгнэлт хийгдсэн байна. Билчээр-нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэл нь уламжлалт монгол нийгмийн түүхийн урт удаан хугацаанд түүний тогтвортой оршин тогтнох үндэс болж байсныг судалгаагаар нотлон харуулсан юм.

Билчээр–нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн дээр "нүүдлийн иргэншил" үүсэн бүрэлдэж, хөгжин цэцэглэж, оршин тогтнож ирсэн түүхэн үйл явцыг судлан харуулах ажил хийгдсэн билээ. Ер нь иргэншлийн онолд "нүүдлийн иргэншил /кочевая" эсвэл "номадик" иргэншил/ гэж байх боломжгүй гэсэн үзэл санаа оршиж байгааг няцаах оролдлого хийгдсэн байна.

"Нүүдлийн мал аж ахуй" ба " нүүдлийн иргэншил" бүхий уламжлалт монгол нийгэм XX зуунд хэрхэн өөрчлөгдөж, хөгжиж ирсэнийг "нийгмийн модернизаци"-ийн онолын концепцийн үүднээс авч үзэхэд уг нийгмийн амьдралд XX зууны эхнээс авахуулаад эцсийг нь хүрэх хугацаанд болж өнгөрсөн олон түүхэн үйл явцыг шинээр авч үзэх, судлах шаардлага тулгарсан. Үүнд: юуны өмнө 1911 ба 1921 онуудын хувьсгалын үйл явцууд, уламжлалт монгол нийгмийн амьдралын олон талыг төрийн механизмыг ашиглан хүч хэрэглэн эвдэх, устгах, өөрчлөх арга замаар модернизацийн зорилтуудыг хэрэгжүүлж байсныг судлан үнэлэлт дүгнэлт өгсөн байна.[1]

Хүч түрж хийсэн хувьсгалт модернизацийн жилүүд буюу өмнө нь оросчилсон буюу большвик марксист-ленинист онолын концепцийн хүрээнд бол "хөрөнгөтний биш хөгжлийн зам"-ын үед хийгдсэн хувьсгалт устгалт ба "хувьсгалт эллюминаци"-ийн үед:

– Уламжлалт монгол нийгмийн язгууртнууд, тухайлан Чингисийн алтан ургийнхныг ар монголд зөвлөлт КГБ ба монголын дотоод яамны хийсэн тусгай бүртгэлийн дагуу буудан устгасан. Үүнийг бид "Political terror" гэдэг.
– Монголын ламанист буддын шашны сүм хийдүүдийг нурааж, тэдгээрийн толгойлогч хутагт, хувилгаад, дээд мяндагтан лам нарыг буудан устгаж, шашин-соёлын бүтээлүүдийг эвдэж, ном судрыг шатааж устгасан. Үүнийг бид "cultural terror" гэдэг.
– Уламжлалт монгол нийгмээ эрх биш мэдэх, шинэ хувьсгалт хүчирхийллийн үед өсч бойжсон ба түүнд оролцож явсан шинэ үеийн сэхээтний давхрагыг "эсэргүүн" гэдэг нэрээр буудан устгасан. Үүнийг бид "репрессия" буюу /улс

*1 D.Dashpurev. Usha Prasad. Mongolia: Revolution and Independence 1911-1992. Jawaharlal Nehru University. New Delhi, 1993. D.Dashpurev. Mongolia: Society, Revolution and Independence. Revised second edition, The Institute of International studies. The Institute of Philosophy Sociology and Political Science /Mongolia/. Published in USA. 2014.*
*D.Dashpurev. S.K.Soni, Reign of terror in Mongolia 1920-1990. Jawaharlal Nehru University. New Delhi, 1992. D.Dashpurev. Reign of Political terror and Repression in Mongolia 1920-1990.Printed in Japan, 2013. /In Japanese/ D.Dashpurev. Reign of Political terror and Repression in Mongolia 1920-1990. Third edition. Published in USA. 2014*

төрийн хэлмэгдүүлэлт/ гэдэг.

- Эдгээр хүч түрэн монгол нийгэмд хийсэн хувьсгалт модернизацийн үе шат 1940-өөд онд өндөрлөсөн байна. Түүний дараа монгол нийгмийн модернизацийн социалист шат эхлэсэн билээ. Энэ шатанд:
- Хувийн мал аж ахуйтны мал сүргийг хураан авч нийгэмчилэн өөрсдийг нь хоршооллосон /нэгдэлжсэн/ анги болгосон.
- Үндсэний бичиг үсгийг хориглож, нийтээр нь криллжүүлсэн.
- Монголчуудын хэдэн мянган жилийн уламжлалт ахуйн соёлыг гутаан доромжилж, "соёлын хувьсгал" хийсэн,
- Эцсийн үр дүн нь болгож "зөвлөлтжүүлэх", "орос хэлжүүлэх" компанит ажлыг хэрэгжүүлсэн,

Энэ шатанд үндсэндээ аж үйлдвэржилтийн мануфактурын түвшний чанаргүй бүтээгдэхүүн хийдэг, эцсийн дүндээ эдийн засгийн талаар ямагт алдагдалтай ажилладаг үйлдвэр, аж ахуйн газруудыг олноор байгуулсан нь улс орноо мөнгө-санхүүгийн байнгын өрөнд оруулдаг гинжин хэлхээг буй болгож чадсан. Үр дүнд нь ЗХУ монголоос маш хямд төрөл бүрийн түүхий эд авч чаддаг болсон.

Энэхүү зөвлөлт маягийн "колончлол"-ын үйл явц дэлхий дахины "хүйтэн дайн"-ы үр дагавaруудаар нөхцөлдөж байсныг харгалзан үзэх ёстой.

1990 онд тэр үеийн дэлхийн социалист систем гэж нэрлэгдэж байсан бөгөөд дэлхийн хоёрдугаар дайнаас хойш бүрэлдэн тогтсон энэхүү "зүүний" гэгдэх орнууд нь тэрхүү түүхэн он жилүүдэд явагдсан "хүйтэн дайн"-ы фронтын "зүүн тал" болж явсаар хоёр ертөнцийн "үзэл суртлын дайн"-д ялагдал хүлээж задран бутрахуйяа монгол оронд ардчилсан хувьсгал тохиож нийгмийн байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлтийн буюу модернизацийн шинэ үе шат эхлэв. Энэхүү түүхэн зурвас цаг үед монгол орноо тохиосон үйл явцыг академик хүрээлэлд судлах явцдаа харилцан зохих ялгаатай үнэлэлт, дүгнэлтүүдийг өгч байгаа. Бид бол өөрийн судалгаагаар 1990-ээд онд монгол оронд тохиосон нийгмийн үйл явцууд нь тус улсын нийгэм-улс төрийн тогтолцоог ардчилсан хувьсгалаар өөрчилжээ гэж дүгнэдэг юм.

1990 оны монголын ардчилсан хувьсгалын үр дүн болж 1992 онд батлагдсан "Монголын үндсэн хууль"-иар тус оронд төрийн шинэ механизм байгуулагдсан. Эрх зүйт төр улс буй болж төрийн эрх мэдлүүд хуулиар хуваарилагдсан. Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хуулиар тогтоосон. Нийгмийн амьдрал нь хувийн өмч, чөлөөт зах зээл дээр суурилах болов. Чингэж монгол оронд капиталист модернизацийн үе шат эхлэсэн байна.[2]

Монгол орны хөгжлийн капиталист модернизацийн шатанд:

- Хувийн өмч давамгайлсан эдийн засаг бүрэлдэж байна. Цаашдаа төрийн монопольт капитализм уу, олигархижсан капитализм уу, эсвэл чөлөөт өрсөлдөөний /хувьцаат/ капитализм уу гэдэг сонголтууд хүлээгдэж байна.
- Урбанизацийн үйл явц эхлэсэн, гэхдээ уламжлалт билчээр-нүүдлийн мал аж ахуй оршин тогтносоор байх хандлагатай байгаа.

*2 Д.Дашпүрэв, Этапы модернизации монгольского общества. Российская академия наук. Институт философии. Монгольская академия наук. Институт философии и социологии. УБ. 1995, /На русс. яз./. Д.Дашпүрэв. Монголын нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн үе шатууд. Олон улс судлалын дээд сургууль. Философи, социологи, политологийн хүрээлэн. УБ. 2005. Дашпүрэв Данзанхорлоогийн. Этапы модернизации монгольского общества. /Социально-философский анализ/. Российская академия наук, Институт философии Монголия Институт философи, социологи, политологии. Институт международных исследований. Издание третье. Издано в США. 2018. /На русс.яз./*

– Баруунжих үйл явц эхлэсэн, түүнийг саатуулах улс төр, үзэл суртал, ёс суртахууны оролдлогууд хүчтэй байгаа ч гэсэн зогсолтгүй үргэлжлэх хандлагатай. Энэ нь үндэсний соёл, зан заншил, уламжлалыг устгах чиглэлээр хөгжих боломжгүй. Харин түүнийг шинэчлэн модерн болгох чиглэлээр явагдаж байгаа. Гагцхүү хүний эрх, чөлөөт сонголт, хуульт ёсны эрх чөлөө бодитой байх хэрэгтэй.
– Монгол нийгмийн амьдралыг бүхэлд нь зөвхөн хуулиар зохицуулдаг болох туршлага бүрэлдэн тогтож байна.

Монгол нийгмийн модернизацийн цаашдын явцад нийгмийн амьдарлыг улс төр, үзэл суртал, ёс суртахууны үнэлэмжээр асуудлыг шийдвэрлэхээр оролдох, устгах арга хүчтэй эрэлхийлэгдэж байгаа боловч тэр нь аажмаар эрч хүчээ алдсаар байх хандлагатай.

Өнөөгийн монгол нийгэмд цоо шинэ социаль бүтэц бүрэлдэн тогтноод байгаа. Үүнд:

– хоёр мянган оны арваад оноос эхлэн төрийн хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх засаглалын дээд, дунд, доод шатны удирдлага, хууль хяналтын байгууллагын шат дамжлагуудын шийдвэр гаргах хэмжээний албан хаагчдын эгнээнээс авилга ба албан тушаалын гэмт хэрэг үйлдэх замаар хөрөнгөжиж үүссэн баячуудын бүлэглэлүүд,
– гол төлөв худалдаа, үйлчилгээний салбараас орлого олж хуримтлуулах замаар төрсөн дундаж ангийн эх үүсвэр,
– төрийн үйлчилгээний албаныхан аж амьдралын хувьд ядууран доройтох хийгээд орлого нь буурах замаар үүссэн нийгмийн ядуулаг бүлгийнхэн,
– ихэнх тэтгэвэрийнхэн ба улирлын ажилчид, ажилгүйчүүдээс үүссэн ядуучуудын давхраа гэхчилэн өнөөгийн монгол нийгмийн анги, бүлэглэлүүдийн нийгмийн бүтэц бүрэлдэн тогтнох процесс явагдаж байна.[3]

Сүүлийн 10-15 жил үргэлжилж байгаа капиталист монгол нийгмийн социаль бүтэц бүрэлдэн тогтнох нийлмэл үйл явцад уул уурхайн салбар дахь хэт их хөрөнгөжигсөд, байгалийн баялагийн лицензийг гадаадынханд наймаалагчид, дээд зиндааны эрх мэдэлтнүүдийн дундаас олон тэрбумаар хахууль авагчдын эгнээнээс төрсөн олигархи бүлэглэл үүсэв. Тэднийг нийгэмд “гучин гэр бүл” гэдэг оноосон нэр томъёогоор илэрхийлдэг бөгөөд энэ бүтцийг тойрсон хөрөнгөжсөн бүлэглэлийг нийгэмд “МАНАН” гэж ангилдаг. Энэ дотор “олигархи” гэсэн олон улсын нэр томъёогоор хаяглагдагсад оршино. Тэдний дунд банк-санхүүгийн салбарын мөнгө хүүлэгчдийн бүлэг оролцож “олигархи”-ийн зарчмыг идэвхжүүлж байгаа. Нийгмийн энэ процесс бол дуусаагүй үйл явц юм.

Монгол нийгмийн “модернизаци”-ийн түүхэн үйл явцыг задлан шинжлэх академик судалгааны ажлын хүрээнд онолын шинжтэй, үзэл баримтлалын ялгаатай хандлагууд судлагчдын дунд буй болж байна. Тухайлбал: зарим судлагчид орчин үеийн монгол нийгэм 1990-ээд оноос хойш “өөрчлөлт”-ийн замаар явж байна гэж

*3 Д.Дашпүрэв, Этапы модернизации монгольского общества. Российская академия наук. Институт философии. Монгольская академия наук. Институт философии и социологии. УБ. 1995, /На русс. яз./. Д.Дашпүрэв. Монголын нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн үе шатууд. Олон улс судлалын дээд сургууль. Философи, социологи, политологийн хүрээлэн. УБ. 2005. Дашпүрэв Данзанхорлоогийн. Этапы модернизации монгольского общества. /Социально-философиский анализ/. Российская академия наук, Институт философии Монголия Институт философи, социологи, политологии. Институт международных исследований. Издание третье. Издано в США. 2018. /На русс.яз./*

үздэг[4].

“Монгол нийгмийн өөрчлөлт”-ийн онолын асуудлуудаар бичсэн энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсэн судлагчид 1990-ээд оноос хойш монгол нийгэм өөрчлөгдөж байгаа, тэгэхдээ 1990 оны эхээр монгол оронд ардчилсан хувьсгал болоогүй, энэ нь монгол нийгэмд гарч байгаа өөрчлөлтүүдийг эхлүүлсэн ээргүүцлийн хөдөлгөөн байлаа гэсэн үзэл санааг дэвшүүлэн тавьсан байдаг. Үүнийгээ тодруулж “1990-ээд оноос манайд ардчилсан өөрчлалт эхэлсэн. Энэ өөрчлөлт ардчилсан гэдэг утгаараа эдүгээ нэгэнт дууссан. ... 1990-ээд онд манай улсад болсон жагсаал цуглаан,өлсгөлөн, суулт зэрэг нь зөвхөн эсэргүүцлийн хөдөлгөөн байлаа. Энэ эсэргүүцлийг тэр үед эрх баригч нам, төр засаг хүлээн авч ардчилсан өөрчлөлтийг дэмжиж хөхүүлсэн юм” [5] гэжээ.

Энэ төсөл нь Монгол улсын Шинжлэх ухааны академийн “ Философи, социологи”-ийн хүрээлэнд улсын төсвөөр санхүүжиж, 1990-ээд оноос 1996-оныг хүртэл МАХН-ын дарга асан философийн ухааны доктор, Монгол улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, Б.Даш-Ёндонгийн удирдсан судлагчдын хамтлагаар хийгдсэн улсын төлөвлөгөөт чухал ажил юм.

Энэ бүхнээс үзэхэд бид цаашдаа “нийгмийн өөрчлөлт”, “нийгмийн хөгжил” гэсэн нэр томъёонуудыг тодорхой ойлголцох хэрэгтэй юмуу даа гэж бодогдож байна. Үүнд: хэдийгээр нийгэм-улс төрийн янз бүрийн үзэл санааны урсгалууд өвөр хоорондоо дээрх нэр томъёонуудыг өөрөөр ойлгох боловч нилээд нийтлэг төсөөлөл бас байж болно. Жишээлбэл, нийгэм өөрчлөгдөж байгаа ч тэнд бас хөгжил явагдаж байгаа юу, үгүй юу? Эсвэл “өөрчлөлт” нь илүү ерөнхий ойлголт юм бол түүний ямар шинж чанар бүхий хэсэг нь “хөгжил” байх вэ? гэж асуудлыг дэвшүүлж болно. Мөн орчин үед хүний нийгмийн өөрчлөлт хаашаа чиглэж байна вэ? гээд илүү дэвшилттэй бас зөв гэж болох чиглэл нь юу болж байна вэ хэмээн эргэцүүлэн дүгнэлт хийж болох байх. Энэ бүх бодомжуудыг тал бүрээр тунгаан үзсэний эцэст орчин үеийн нийгэмд болж байгаа өөрчлөлтүүд нь “эдийн засаг, нийгэм, соёл, шинжлэх ухааны талаар илүү давамгай түвшинд гарсан “нийгэм”-д хүрэх чиглэлтэй явагдаж байвал зөв хандлагаар явагдаж байна гэх буюу “хөгжиж”, “орчин үечлэгдэх хандлага чиглэлээр өөрчлөгдөж байна”гэж үздэг бие даасан үзэл санаа, онолын нэг урсгал байна. Үүнийг “модернизацийн онол” гэж товчоор нэрлэж байдаг. Чухам энэ байр сууринаас асуудалд хандах юм бол өндөр хөгжилд хүрсэн “барууны орнууд” гэх улс орнуудын нийгмийн хүрсэн хэм хэмжээг баримжаалан нийгмээ өөрчлөх үйл явцыг зөв чиг баримжаагаар “хөгжиж” байна гэж үзэх нь зохистой болов уу гэж зохиогч бодож байна.

Энэхүү хөгжил нь тухайн улс, үндэстний уламжлалт иргэншил, соёл, түүхийн үнэт зүйлсийг үгүйсгэх, устгах, үл тоомсорлох явдал гаргаж болохгүй, харин сайнаар хүндэтгэн хандаж уламжлан боловсронгуй болгож хөгжүүлэн баяжуулах хэрэгтэй гэж үздэг. Иймд модернизацийн үйл явц бол улс, үндэстний түүхэн уламжлалт нийгмийн үнэт зүйлсэд ер дайсагнадаггүй юм. Гэхдээ нийгэм, тухайлан “уламжлалт монгол нйигэм” орчин үежиж, шинэчлэгдэж хөгжих, баруунычлагдах чиг баримжаагаар өөрчлөгдөхийг эсэргүүцэгчид, тэр үйл явцыг үгүйсгэгчид байдаг бөгөөд тэдний зүгээс “монгол нийгэм” орчин үежиж өөрчлөгдөхийг “хөгжил” гэж үзэхгүй байгааг тодорхой ялгаж, салгаж ойлгох хэрэгтэй болов уу.

Энэ талаар орчин үеийн дэлхийн нэрд гарсан философичид зарчмын чухал

[4] *Д.Дашпүрэв. Монгол нийгэм /философийн анализ/. УБ, 2017. 94-99 дэх талууд. Д.Ганболд XX зууны эцэс XXI зууны эхэн үеийн нийгмийн гуманитар хөгжил ба деформацийн асуудал. УБ. 2018.*

[5] *Монголын нийгмийн өөрчлөлт /Нэмж засварласан хоёр дахь хэвлэл/. УБ, 2013. 16-19 дэх талуудад үзнэ үү.*

баримтлалуудыг томъёолсон байдаг. Юуны өмнө дэлхийн философийн холбооны ерөнхийлөгч асан бөгөөд эдүгээ хүндэт ерөнхийлөгч Ioanna Kucuradi “The Idea of development, its past and its present” гэсэн өгүүлэлдээ: “хөгжил” гэдэг ухагдахууныг “under-developed”-хийгээд “developing countries” гэсэн “термин”-ээр тодруулан авч үзэх нь зохистой. Тэгэхийн хамт хөгжиж буй орнууд хөгжилтэй гэгдэх түвшинд хүрсэн “барууны орнууд”-ын “загвар”-т агуулагдах үзүүлэлтүүдэд хүрэх зорилгыг өмнөө тавьдаг. Энэ цогцолбор үйл явц бол “модернизаци” гэж ерөнхийдөө нэрлэгдэж байдаг гэсэн өргөн агуулгатай үзэл санааг дэвшүүлсэн байна.[6]

Мөнхүү үзэл санааг “Дэлхийн философийн холбоо”-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар бидний залуу цаг болох 1980-аад онд олон жил ажилласан, дараа нь уг байгууллагын Ерөнхийлөгч асан Evandro Agazzi “Philosophical reflections on the concept of development” өгүүлэлдээ “хөгжил” гэдэг ухагдахууны агуулгыг өнөөгийн хүн төрөлхтний хөгжлийн “зүгээр нэг өөрчлөлт гэж бүрхэгдүүлэх биш/ “дэвшил”-тэй холбон ихэд тодруулан гүнзгийрүүлж авч үзэж байна.[7] Гэхдээ өнөөгийн хөгжиж байгаа улс, орнуудын хөгжлийн энэ ерөнхий хандлага нь өөртөө маш өргөн агуулгатай онолын концепци юм. Жишээлбэл, “зөвлөлтийн империˮ задарч мөхсөний дараах үеийн оросын нийгэм-улс төрийн философийн утга зохиолд “өөр” европын модернизацийн онолын баримтлал нилээд хүлээн зөвшөөрөгдөх болсон. Тэр үзэл баримтлалын үүднээс 1990-ээд оноос хойшхи үеийн монгол нийгмийн хөгжил үндсэндээ тэрхүү “өөр” европын модернизацийн хүрээнд хамаарах юм. [8]

Энэ бүхнийг дурьдаж байгаагийн учир бол илтгэгч “нийгмийн өөрчлөлт” гэдэг бүрхэг нэр томъёоноос “хөгжил” гэдэг нэр томъёог ялгаатай ойлгож байгаа юм. Түүгээр ч зогсохгүй “монгол нийгэм” XX зуунд, мөн XXI зууны эхэнд модернизацийн арга замаар улам бүр орчин үежин хөгжиж байгаа ба монгол нийгмийн модернизацийн үйл явц нь төрийн хүчээр хийсэн “хувьсгалт модернизацийн шат”, “модернизацийн социалист шат” гэсэн хоёр үе шатыг туулаад эдүгээ “капиталист модернизаци”-ийн үед ороол явж байна гэж үзэж байгаа юм.

Орчин үеийн “монгол нийгэм”-ийн тухайд холбогдох үзэл санаа, онолын баримтлалын хоёр өөр чиг хандлага илэрч байгааг зохиогч тодорхой ялган салгаж, зохиогчоос ялгаатай байгаа үзэл санааны баримтлалд туйлын хүндэтгэлтэй хандаж байна. Аль нь зөв болохыг нийгэм-түүхийн практик л шийднэ шүүдээ. Гэхдээ практик улс төрч бодлоготнуудын алдаж онох нь зохиогчид бол харин холбогдолгүй зүйл юм.

### Ном зүй


1. Ганболд, Д. (2018). XX зууны эцэс XXI зууны эхэн үеийн нийгмийн гуманитар хөгжил ба деформацийн асуудал. УБ.
2. Дашпүрэв, Д. (2017). Монгол нийгэм /философийн анализ/. УБ.
3. Шинжлэх ухааны академи. (2013). Философийн Монголын нийгмийн өөрчлөлт /Нэмж засварласан хоёр дахь хэвлэл/. хүрээлэн. УБ.

***Англи хэл дээр***

1. Agazzi, E. (1993). Philosophical reflections on the concept of development. “The


*6 Мөн тэнд. 17-р талд үзнэ үү.*

*7 Ioanna Kucuradi. The idea of development. Its past and its present” The idea of development between its past and its future” Ankara. 1993, Please see: Pp. 5-7,*

*8 Evandro Agazzi, Philosophical reflections on the concept of development. “The idea of development between its past and its future”. Ankara. 1993, Please see: Pp. 21-23*

idea of development between its past and its future”. Ankara.

2. Dashpurev, D., Usha Prasad, (1993). Mongolia: Revolution and Independence 1911-1992. Jawaharlal Nehru University. New Delhi,
3. Dashpurev, D, (2014). Mongolia: Society, Revolution and Independence. Revised second edition. The Institute of international studies. The Institute of philosophy, sociology and political science /Mongolia/, Published in USA, Dashuprev.D, S.K.Soni, Reign of terror in Mongolia 1920-1990. Jawaharlal Nehru University. New Delhi, 1992. D. Dashpurev.D, Reign of Political terror and repression in Mongolia 1920-1990. Printed in Japan. 2013 /In Japanese/, Dashpurev.D, Reign of Political terror and repression in Mongolia 1920-1990. Third edition. Published in USA. 2014.
4. Ioanna, Kucuradi. (1993). The idea of development. Its past and its present. “The idea of development between its past and its future”. Ankara.

***Орос хэл дээр***

1. Дашпүрэв. Д. Этапы модернизации монгольского общества. Российская Академия Наук. Институт философии, Монгольская Академия Наук. Институт философии и социологии. УБ, 1995. /на русс. яз./ Дашпүрэв Данзанхорлоогийн. Этапы модернизации монгольского общества /Социально-философиксий анализ/. Российская Академия Наук. Институт философии. Монголия. Институт философии, социологии, политологии. Институт международных исследований. Издание третье. Издано в США. 2018, /на рус. яз./
2. Федотова. В. Г. Модернизация “другой” европы. Российская Академия Наук. Институт философии. Москва, 1997.

# 1990 ОНООС ХОЙШ ҮЕ ДЭХ МОНГОЛЫН ФИЛОСОФИЙН СУРГАЛТ, СУДАЛГААН ДАХЬ ОНОЛ, АРГА ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ, СУРГАМЖ

М.Отгонбаяр, доктор (PhD)
Б.Дагзмаа, доктор (PhD)
Ц.Нямсүрэн, доктор (PhD)
*МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим*

***Товч утга:*** *Энэхүү өгүүлэл нь Монгол улс дахь философийн сургалт, судалгааны төлөвшил болон түүнд гарсан онол, арга зүйн өөрчлөлтийн үйл явцыг авч үзэхийг зорьсон болно. Монгол улс дахь философийн мэргэжлийн сургалт, судалгааны ажлыг XX зууны 90-ээд оноос өмнөх ба 90-ээд оноос хойших гэсэн онол, арга зүйн хувьд эрс ялгаатай хоёр үе шатанд хуваан үзэж байна. 1990-ээд оноос өмнөх үеийн Монголын философийн судалгаа агуулгын хувьд ШУКО, түүхийн материализмын сэдэв зонхилсон, арга зүйн хувьд диалектик материализмыг хатуу баримталсан шинжтэй байв. Энэ нь тухайн үеийн улс төрийн эрх баригч коммунист намын үзэл суртлын цор ганц зэвсэг болох марксизм-ленинизмийн хүрээнд байхаас өөр аргагүй байсан нөхцөл байдлын үр дүн юм. Харин XX зууны 90-ээд оноос эхэлсэн философийн хөтөлбөрийн өөрчлөлтийн үйл явц бараг 20 жил үргэлжилсэн, энэ үе бол философийн мэргэжлийн хөтөлбөрийг орчин үеийн дэлхийн их сургуулиудын философийн мэргэжлийн хөтөлбөртэй нийцүүлэн шинэчлэх шилжилтийн үе болохыг дүгнэн авч үзсэн болно.*

***Түлхүүр үг:*** *марксизм-ленинизм, ШУКО, диалектик материализм, түүхийн материализм, сургалтын хөтөлбөр, шилжилтийн үе, ахисан түвшний сургалт*

***Abstract:*** *This article examines the development of philosophical learning and research in Mongolia as well as the theoretical and methodological changes taking place during that process. Professional philosophical education and research in Mongolia are divided into theoretically and methodologically very different two stages, namely, before the 90s and after the 90s of the twentieth century. Until the 1990s, Mongolian philosophical inquiries were dominated by scientific communist theory, historical materialism and strictly abided by dialectical materialism in terms of methodology. It resulted from a situation in which they had to be fitted in the framework of Marxism-Leninism, the only ideological weapon for the ruling communist political party of the given time. However, the process of changing the philosophical curriculum, which began in the 1990s, lasted almost 20 years and is concluded as a transitional period for reforming the curriculum for professional philosophy courses following the philosophical curricula of contemporary world-class universities.*

***Keywords:*** *Marxism-Leninism, scientific communist theory, dialectical materialism, historical materialism, curriculum, transition period, postgraduate studies*

Социализмын үед олон арван жилээр явуулсан сургалт, сурталчилгааны үр дүнд манай онолын салбарынхан улс төрийн албадлагын эрхээр төдийгүй бүр итгэл

үнэмшлийнхээ үүднээс марксизм-ленинизмд тууштай, үнэнч ханддаг байв. Ер нь түүнийг шүүмжлэх нь хаалттай бөгөөд хориотой байсан юм. Харин өнгөрсөн зууны 80-аад оны дунд үеэс социалист системийн орнуудад тухайн үеийн коммунист нам, төрийн дээд удирдлагын алдаатай бодлого, үйл ажиллагааг ил тод шүүмжилж эхэлсэн нь манай орны улс төрийн амьдралд ч мөн хүчтэй нөлөөлсөн билээ. Ийнхүү 90-ээд оны үед социалист системийн орнуудад өрнөсөн өөрчлөн байгуулалт, ардчиллын үйл явц тухайн нийгмийг системээр нь өөрчилж, манай оронд ч олон намын тогтолцоо бүхий парламентат ёс тогтож, зөвхөн нийгмийн өмчийг л зөвшөөрдөг хууль ёсны бодлого, практикаас татгалзан, өмчийн олон хэлбэр үүсэж, хүн амын итгэл үнэмшил, үзэл бодол, бас онол шинэчлэгдэх замд орсон билээ.

Хэрэв онол оршин буй баримттай зөрчилдвөл тэрхүү баримтыг тайлбарлах шинэ шинэ таамаглалууд дэвшигдэн гарч тэдгээрийн өрсөлдөөний дүнд тохирох шинэ онол гарч ирдэг нь танин мэдэхүйн бодит үйл явц байдаг. Социалист системийн улс орнуудын нийгмийн шинжлэх ухаан, түүний онол, арга зүйн үндэс болох марксизм-ленинизмийн хувьд нийгмийн улс төрийн болон эдийн засгийн хүрээнд гарсан тулгуур өөрчлөлтүүд, бодит практиктай зөрчилдөж, тухайлбал Монголд шинэ нийгэм, шинэ харилцааг тайлбарлах шинэ онол шаардлагатай болсон юм.

Онолын талбарын энэ өөрчлөлт нь тэрхүү онолыг сургах, сурталчлах, судлах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг тэргүүлэх институциуд болох их, дээд сургуулиудын мэргэжлийн тэнхимүүд болон хичээлүүдийн нэрийг өөрчлөх практик ажлаас эхэлсэн юм. Тухайлбал, 1990 оноос их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнөөс марксизм-ленинизмийн багц хичээлийн[1] зарим нь хасагдаж, зарим хичээлийн нэр өөрчлөгдсөн тэр үед МУИС-д Марксист-ленинист философийн тэнхимийг Философийн тэнхим/ 1990/, Шинжлэх ухааны коммунизмын онолын тэнхимийг Улс төр судлалын тэнхим /1992/, Улс төрийн эдийн засгийн ухааны тэнхимийг Эдийн засгийн онолын тэнхим /1994/ болгон өөрчилжээ.

Нэрийн өөрчлөлттэй хамт сургалт, судалгааны ажлын агуулга, арга зүйн шинэчлэл хийх зайлшгүй хэрэгцээ тулгамдсан. Гэвч энэ бол боловсон хүчин, номын сан, цаг хугацаа зэрэг олон төрлийн нөөцийн хувьд тийм ч амархан бөгөөд богино хугацаанд хийгдэх боломжгүй зүйл байв. Социалист байгуулалтын он жилүүдэд МАХН-аас бүх түвшинд явуулсан суртал нэвтрүүлгийн ажлын үр дүнд хэвшин тогтсон нийгмийн оюун санааны инерци гэнэт өөрчлөгдөх боломжгүй байсан юм.

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт, нийгмийн өмчид суурилсан эдийн засагтай социалист нийгэм, улс төрийн тогтолцооноос зах зээлийн эдийн засагтай, ардчилсан нийгэмд шилжих үйл явцад их, дээд сургуулийн сургалт төлбөртэй болсон (1992), хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд байгуулагдан үйл ажиллагаа явуулах болсон, их, дээд сургуулиуд бие даан үйл ажиллагаа явуулах болсон, дээд боловсролын сургалт бакалавр, магистр, докторын (4+2+3) гэсэн шинэ шатлалтай болсон, сургалтад кредит системийг нэвтрүүлж эхэлсэн зэрэг олон шинэ үзэгдлээр дамжин дээд боловсролын тогтолцоо ч бүхэлдээ шинэчлэгдэж ирсэн билээ.

*Философийн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт*

Монгол улс дахь философийн мэргэжлийн сургалт, судалгааны ажлыг XX

*1 Марксист-ленинист философи: Диалектик материализм/диамат/, Түүхийн материализмын/истмат/ хоёр хичээл Философи, Капитализмын ба социализмын улс төрийн эдийн засгийн ухаан/УТЭЗУ/ гэсэн хоёр хичээл Эдийн засгийн онол нэртэй болсон. Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Намын/ЗХУКН/ Түүх, Монгол Ардын Хувьсгалт Намын/МАХН/ түүх, Шинжлэх ухааны Коммунизмын онол/ШУКО/ хичээлүүд хасагдаж, нийт хичээл их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрөөс хасагдсан юм. Удалгүй ШУКО-ын хичээлийн оронд Улс төр судлал нэртэй хичээл зааж эхэлсэн.*

зууны 90-ээд оноос өмнөх ба 90-ээд оноос хойших гэсэн онол, арга зүйн хувьд эрс ялгаатай хоёр үе шатанд хуваан үзэж байна.

1990-ээд оноос өмнөх үеийн Монголын философийн судалгаа агуулгын хувьд ШУКО, түүхийн материализмын сэдэв зонхилсон, арга зүйн хувьд диалектик материализмыг хатуу баримталсан шинжтэй байв. Энэ нь тухайн үеийн улс төрийн эрх баригч коммунист намын үзэл суртлын цор ганц зэвсэг болох марксизм-ленинизмийн хүрээнд байхаас өөр аргагүй байсан нөхцөл байдлын үр дүн юм. МУИС-ийн философийн мэргэжлийн сургалтын хөтөлбөр хуучин ЗХУ-ын тухайлбал, Москвагийн улсын их сургуулийн философийн факультетын хөтөлбөрийн бүтэцтэй адилхан байсан ба ерөөс социалист системийн орнуудын их, дээд сургуулиудын марксист-ленинист философийн сургалтын хөтөлбөр, агуулга ижил байсан юм.

XX зууны 90-ээд оноос эхэлсэн философийн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн бүтэц ба хичээлүүдийн нэршлийн өөрчлөлтийг авч үзвэл:

*Диалектик материализм*ын хичээл “материалист” хэмээх тодотголоо орхин “Диалектик” гэсэн нэртэй болж 90-ээд оны төгсгөл хүртэл заагдсан ба мөн үеэс түүний оронд “Метафизик ба онтологи” гэдэг хичээл шинээр орж эхэлжээ. Харин логик, математик логик, танин мэдэхүйн онол, шинжлэх ухааны философийн хичээлүүд мэргэжлийн заавал үзэх хичээлийн ангилалд багтан заагдаж иржээ.

*Философийн түүх* эртний, дундад зууны, германы сонгодог, орчин үеийн өрнөдийн философи гэсэн ангиллаар задарч, багц хичээл болжээ. Мөн 90-ээд оны дунд үеэс философийн түүхийг өрнө, дорно гэсэн ижил үнэлэмж бүхий хоёр хэсэгт хуваан, түүхийн үе шатуудаар бүлэглэж зааж эхэлсэн байна. Урьд нь европ төвт философийн түүхийг судалдаг байсныг ийнхүү халсан юм.

*Түүхийн материализм*ын хичээл “Нийгмийн философи” нэртэй болов. XXI зууны эхэн үеэс улс төрийн, эрх зүйн, түүхийн зэрэг салбар философи хичээлүүд сонгон судлах хичээл байдлаар хөтөлбөрт оржээ. Өмнөх үеийн марксист-ленинист ёс зүй, марксист-ленинист гоо зүйн хичээл марксист-ленинист гэсэн тодотголоо орхин ёс зүй, гоо зүй, шашингүйн үзлийн түүх ба онол хичээл шашин судлал гэсэн нэртэй болсон юм.

Хөтөлбөрийн бүтэц дэх мэргэжлийн хичээлийн нэршил, нэмэгдсэн болон хасагдсан хичээлийг авч үзвэл зарим талаар тэнхимийн эрхлэгчийн итгэл үнэмшлээс хамааралтай байдал харагддаг юм. Үүний зэрэгцээ боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон сургуулиас хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах тухай шийдвэр гарсан, МУИС-ийн хэмжээнд үзэх хичээлүүдийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх, сонгон үзэх хичээлүүдэд оногдох багц цаг тэнхимээс үл хамаардаг болсон зэрэгтэй бас холбоотой юм. Мөн философийн мэргэжлийн хичээлүүд болон МУИС-ийн нийт оюутанд заадаг ерөнхий Философи хичээл нь түүнийг заадаг багшийн мэргэшлийн ба хэлний мэдлэг, чадвар болон бусад хүчин зүйлээс хамааран агуулга, арга зүйн хувьд ихээхэн ялгаатай байж ирсэн юм.

Энэ үед манай их, дээд сургуулийн философийн сургалтыг шинэчлэх, философи, нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, багш нарын мэргэжил дээшлүүлэх, давтан сургах зэрэг асуудлаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зарим ажил хэрэгжүүлсэн байна. Мөн Монголын Нээлттэй нийгэм хүрээлэнгээс санхүүжүүлж “Философийн сургалт ба арга зүйн сонголтын эрх чөлөө” сэдэвт симпозиум /1998/, “Их, дээд сургуулиудад зааж буй философийн хичээлийн агуулга, бүтцийн шинэчлэлийн зарим асуудал”

/2000/ сэдэвт семинар зэргийг улсын хэмжээнд зохион байгуулсан юм. Энэ семинараас их, дээд сургуульд зааж буй философийн хичээлийн стандартыг: философи, мэдлэгийн системд түүний эзлэх байр суурь; онтологи; танин мэдэхүйн онол; методологи; соёлын ба үнэлэмжийн философи; нийгмийн философи гэсэн бүтэцтэй байхаар тогтоон Монгол улсын гэгээрлийн яам, нийт их, дээд сургуулийн удирдлагад хандаж зөвлөмж гаргасан юм. МУИС-ийн бүх оюутанд заадаг ерөнхий суурь философи хичээлийн хөтөлбөр 2000, 2005, 2008, 2014 онуудад өөрчлөгдөж ирсэн ч 2000 оны зөвлөмжөөс гарсан тэр стандартыг хадгалж иржээ.

Ер нь 90 оноос эхэлсэн философийн хөтөлбөрийн өөрчлөлтийн үйл явц бараг 20 жил үргэлжилсэн, энэ үе бол философийн мэргэжлийн хөтөлбөрийг орчин үеийн дэлхийн их сургуулиудын философийн мэргэжлийн хөтөлбөртэй нийцүүлэн шинэчлэх шилжилтийн үе юм.

Шилжилтийн үеийн эхний арван жилд гарч байсан философийн сурах бичиг, хичээлийн хөтөлбөр, мэргэжлийн сэтгүүлд нийтлэгдэж асан өгүүллүүдийн агуулгыг үзэхэд цөөн биш багшийн сургалт, судалгаанд марксист-ленинист философийн агуулга, арга зүй ил тод биш ч хадгалагдаж байв. Тухайлбал, Монголын нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/-ээс санхүүжүүлж Нээлттэй философи нийгэмлэгээс 1998 оны 6 дугаар сард зохион байгуулсан “Философийн сургалт ба арга зүйн сонголтын эрх чөлөө” сэдэвт симпозиумд зориулан зохиогчоос явуулсан тандалтын судалгаанд “Таны бодлоор философи гэж юу вэ?” гэсэн асуултад философийн багш, эрдэм шинжилгээний ажилтан, нийгмийн ухааны оюутнуудын 33,3% нь “философи бол түгээмэл хууль зүй тогтлын тухай шинжлэх ухаан мөн” гэсэн марксист тодорхойлолтыг өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт байв. Харин “одоогийн философийн сургалтын агуулга, хөтөлбөр, төлөвлөгөөг өөрчлөх шаардлагатай юу?” гэсэн асуултад “тийм” гэсэн хариултыг санал асуулгад оролцогчдын 60,8% нь, түүний дотроос философийн багш нарын 71,4%, эрдэм шинжилгээний ажилтны 81,8%, салбарын оюутнуудын 65,8% нь өгсөн нь агуулгын өөрчлөлт тулгамдсан болохын нэг үзүүлэлт байлаа.

Философийн сургалтын хөтөлбөрийн өөрчлөлттэй уялдан философийн сурах бичгийг шинэчлэн гаргах ажил тулгамдаж байсан ба цөөнгүй тооны сурах бичиг шинээр[2] болон орчуулагдан гарсан юм.

Энэ үед марксист-ленинист философийн илт үзэл сурталжсан сэдвүүд, ялангуяа шинжлэх ухааны коммунизмын онолын сэдвүүдийг шууд орхисон мэт боловч диамат ба истматын ойлголтуудаар философийг төлөөлүүлэн тайлбарлаж байсан. Мөн өмнөх үед нэгэн цул байж, нийгмийн оюун санааны амьдралыг тогтоож асан марксизмын орон зайг түүнтэй ижил төстэй бусад үзлээр орлуулан нөхөх гэсэн оролдлого бас хийж ирсэн юм. Тухайлбал:

---

*1. Гүн ухааны товчоо. УБ.: 1995 он. /ред. Д.Дагвадорж, Л.Дагдан. /МУБИС/*
*2. Б.Бадарч, Л.Дагдан. Өрнийн гүн ухааны сэтгэгчдийн үзэл баримтлалын товч тойм. УБ.: 1999 он.*
*3. Философи эхлэн суралцах бичиг. УБ.: 2000 он. Нээлттэй философи нийгэмлэг. /ред. Ц.Гомбосүрэн, М.Отгонбаяр.*
*4. Л.Дамбийням. Гүн ухаан. УБ.: 2000 он. /ред. Д.Баттөмөр.*
*5. Философи сурах бичиг. УБ.:2002 он. МУИС-ийн философийн тэнхим. /ред. Ц.Гомбосүрэн.*
*6. Б.Батчулуун. Философи гэж юу вэ? УБ.: 2004 он.*
*7. Д.Содномгомбо, Р.Дарьхүү. Философи. УБ.: 2004 он. /ред. Г.Чулуунбаатар.*
*8. Д.Ганболд. Философи. УБ.:2007 он.*
*9. Ц.Гомбосүрэн. Философи. УБ.: 2008, 2011, 2012, 2014, 2020 он. /ред. М.Отгонбаяр*

- *Диалектикийг* философийн гол төлөөлөл, танин мэдэхүй, шинжлэх ухааны танин мэдэхүйд цорын ганц зөв арга зүй хэмээн сургаж, сурталчилж байв. Энэ нь нийгэм, хүмүүнлэгийн ухааны бусад салбарт ч онолын тайлбарлал болсоор байв.
- *Буддизм, монголын уламжлалт гүн ухааны сэтгэлгээ* сэргэх хэрээр монголчуудын арга-билгийн үзэл, буддизмын зарим философи сургаал, ялангуяа төв үзлийг диалектиктай адилтган тайлбарлах болсон. Түүгээр ч барахгүй тэдгээрийг орчин үеийн философи, шинжлэх ухааны онолтой адил үнэ цэнтэй хэмээн сурталчлах болсон. Бас түүнийг ердийн ухамсрын мэдлэг байдлаар сурталчилж ирэв.
- *Нийгэм эдийн засгийн формацийн* /НЭЗФ/ онолыг баримтлан нийгмийн түүхийн үе шатуудыг ангилан тайлбарлаж байсан. Мөн НЭЗФ-ийн үзлийг германы философич Шпенглерийн иргэншлийн онолтой нэгтгэн тайлбарлах талаар судалгааны зарим ажил хийгдсэн. Тухайлбал, Философийн тэнхимд 1990-2005 онд иргэншлийн онол ба буддизм, шашин судлалын гэсэн хоёр чиглэлээр эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлсэн байдаг.
- Өрнийн философийн орчин үеийн чиглэлүүдийг судалж, сурталчилсан үйл ажиллагааг гоочлох, элдэв нэр хоч өгөх зэрэг үйлдэл цөөнгүй гаргаж ирсэн билээ.

Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг сайжруулах“ дэд төслийн хүрээнд тус тэнхимийн зарим багш нар Философи, Логик хичээлийн гарын авлага боловсруулан, 2007 оноос сургалтад хэрэгжүүлж эхэлжээ. Төслийн багийнхан монгол улсын их, дээд сургуулиудад зааж буй философийн хичээлийн тодорхойлолт, хөтөлбөр, сурах бичиг, гарын авлага зэрэг бичиг баримтад агуулгын анализ хийх, өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудын философийн хөтөлбөртэй харьцуулах, тэдгээр орны их сургуулийн философийн сурах бичгүүдийг орчуулах, мөн сургалтад оролцогч талуудаас тоон болон чанарын судалгаа авах, шинэ хөтөлбөрийн дагуу сургалт явуулах, сургалтын үр дүнд анализ хийх зэрэг ажлыг 2 жил гаруй хугацаанд хийж гүйцэтгэсний эцэст Хууль зүйн мэргэжлээр суралцах оюутанд зориулсан Философи хичээлийн хөтөлбөр боловсруулжээ.

2014-2015 оны хичээлийн жилд МУИС-ийн хэмжээнд хийгдсэн бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Философи, шашин судлалын тэнхимийн багш нар хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан юм. Үүнд:

- *Мэргэжлийн заавал судлах хичээл*: Метафизик: онтологи ба методологи, Эртний Грек, Ромын философи, Дорно дахины философи, Дундад зууны ба сэргэн мандалтын европын философи, Буддын гүн ухаан, логик, Монголын философийн түүх, Шинэ үеийн өрнийн философи, Шинжлэх ухааны философи, Нийгмийн философи, Үнэлэмжийн онол, Ёс зүйн түүх, онол, Танин мэдэхүйн онол, Орчин үеийн философи I (амьдралын тухай философи, феноменологи, экзистенциализм, фрейдизм, герменевтик, прагматизм, реалист чиглэлүүд), Орчин үеийн философи II (структурализм, хэл шинжлэлийн философи, постструктурализм, постмодернизм), Симболик логик;
- *Философийн түүх ба орчин үе сэдвээр мэргэших хичээл*: Хэлний тухай

философи ба семиотик, Платон ба Аристотель, И.Кантын философи ба орчин үе, Байгаль шинжлэлийн философи, Веданта философи, Күнзийн философи ба орчин үе, Феминист философи, Японы философи, Оюун санааны философи;

- *Үнэлэмжийн онол ба ёс зүй сэдвээр мэргэших хичээл*: Соёлын философи, Урлагийн философи, Хэрэглээний ёс зүй, Философийн хүн судлал, Монголчуудын уламжлалт ёс зүйн сэтгэлгээний түүх ба орчин үе, Эрх зүйн философи, Улс төрийн философи, Шашны тухай философи, Орчин үеийн шашны философи, Мета ёс зүй, Түүхийн философи, Экософи, Боловсролын философи гэсэн хичээлүүдийн хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулжээ.

Өнөөдрийн МУИС-ийн философийн мэргэжлийн хөтөлбөр 1. Философийн онолын хичээлүүд, 2. Философийн түүх болон салбарын философийн хичээлүүд, 3. Мэргэших буюу сонгох хичээл гэсэн бүтэцтэй байна. Сонгон судлах хичээлүүдийн тухайд тэнхимийн багш нарын мэргэшсэн, судалгаа хийдэг чиглэлтэй холбоотой байгаа боловч орчин үеийн философийн чиглэлүүдээс орхигдсон салбар салбар үгүй байна. Цаашид 2014 онд баталж хэрэгжүүлж буй өнөөгийн хөтөлбөрийг дахин боловсруулах, шинэчлэх шаардлага ч бас тулгамдаж байна.

*Ахисан түвшний сургалтын судалгааны ажлын арга зүйн өөрчлөлт*

1990 оноос өмнөх үед философийн мэргэжлийн салбарт суралцан төгсөгчдийн бичсэн нийт 215 дипломын ажлын 89% нь ШУКО, түүхийн материализм, марксист-ленинист ёс зүйн сэдвээр байна[3]. Харин 1990 оноос хойш үед бичигдсэн философийн бакалаврын дипломын ажлын 32% нь нийгэм улс төрийн/19%/, ёс зүйн /13%/ сэдвээр болж цөөрсөн боловч орчин үеийн философи, танин мэдэхүйн онол, шинжлэх ухааны философи, дорно дахины философи, хүний философи зэрэг шинэ салбарууд гарч иржээ.

1994 оноос эхэлсэн магистрантурын сургалтаар 100 орчим судалгааны ажил хийснийг сэдвийн хувьд ангилан авч үзвэл дараах байдалтай байна.




Энд нийгмийн философи, ёс зүйн сэдэв 33%-ийг эзэлж буй нь өмнөх үеийнхтэй харьцуулахад буурсан боловч бусад сэдвүүдээс илүү өндөр байгаа нь манай

[3] *Марксист-ленинист философи: Диалектик материализм /диамат/, Түүхийн материализмын /истмат/ хоёр хичээл Философи, Капитализмын ба социализмын улс төрийн эдийн засгийн ухаан /УТЭЗУ/ гэсэн хоёр хичээл Эдийн засгийн онол нэртэй болсон. Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Намын /ЗХУКН/ Түүх, Монгол Ардын Хувьсгалт Намын /МАХН/ түүх, Шинжлэх ухааны Коммунизмын онол /ШУКО/ хичээлүүд хасагдаж, нийт хичээл их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрөөс хасагдсан юм. Удалгүй ШУКО-ын хичээлийн оронд Улс төр судлал нэртэй хичээл заадж эхэлсэн.*

суралцагчид түүхийн ямар ч үед нийгэм, улс төр, ёс зүйн сэдвүүдийг илүү өргөн хүрээнд сонирхдогтой холбоотой юм.

Манай оронд 1970-аад оны дунд үеэс философийн ухаанаар докторын зэрэг  хамгаалуулж эхэлсэн ба 1990 оноос өмнө Монголд философийн ухаанаар дэд докторын зэрэг хамгаалсан нийт 7 диссертацийн сэдвийг авч үзвэл монголын философи сэтгэлгээний түүх 2, социологи 2, философийн түүх 1, танин мэдэхүйн онол 1, гоо зүй 1 байна. Тухайн үед гадаадад/ЗХУ-д/ философийн ухаанаар дэд докторын зэрэг хамгаалсан бүх ажлыг олж, анализ хийх нь цаг хугацааны болон бусад нөөцийн хувьд одоогоор боломжгүй тул зөвхөн тус тэнхимд багшилж байсан, ЗХУ-д дэд докторын зэрэг хамгаалсан нийт 12 эрдэмтний судалгааны ажлын сэдвийг авч үзвэл тэдгээрийн 75%/9/ нь нийгэм, улс төрийн сэдвээр судалгаа хийжээ.

Ийнхүү социализмын үед философийн сургалт, судалгаанд нийгэм, улс төрийн сэдэв зонхилж /бараг 90%/ байсан нь уг системийн нуралтын дараа буурч, бусад шинэ салбаруудад орон зай өгчээ. Тухайлбал, 1990 оноос МУИС-ийн философийн тэнхимд аспирант элсүүлдэг болсон ба  энэ хугацаанд тус тэнхимд докторантурын сургалт дүүргэж, докторын /Ph.D/ зэрэг хамгаалсан нийт 30 диссертацийн ажлын сэдвийг авч үзвэл дараах зураглал гарч байна.




90-ээд оноос хойш ШУА-ийн дэргэд философийн ухааны доктор /Sc.D/-ын зэрэг олгох ажил явагдаж иржээ. Энэ хугацаанд зөвхөн МУИС-ийн философийн тэнхимд багшилж байсан болон төгсөгч 9 хүн философийн ухаанаар Sc.D докторын зэрэг хамгаалсан байна.

Монгол улс ардчилал, зах зээлийн нийгмийг сонгосон 30 жилийн хугацаанд социалист системийн улс орнуудын хоёр шатлалт эрдмийн зэрэг /дэд доктор, доктор/ олгодог байсан практикийг дээд боловсролын өөрчлөлттэй уялдуулан нэг мөр болгож цэгцлээгүйгээс өнөөдөр манай академик орчинд өөр өөр системийн эрдмийн зэрэг, цолны үнэлэмжийн ялгаваргүй байдал үүссэн нь зарим сөрөг үр дагаврыг төрүүлж байна. Тухайлбал:

- ШУА-ийн дэргэд шинжлэх ухааны доктор (Sc.D) хэмээх эрдмийн зэргийг хамгаалуулж байгаа нь гадаад, дотоодын их сургуульд докторын (Ph.D) зэрэг хамгаалсан хүмүүсийнхээс давуу үнэлэмжтэй болж, эрдмийн зэргийн илүү нэмэгдэл авах, “суурь судалгааны төсөл” авах зэрэг нийгмийн үр ашиг нь тодорхой шалгуураар хэмжигдэхгүй зүйлд татвар төлөгчдийн мөнгөнөөс урсгах нэгэн суваг болж байна.
- Философийн ухааны доктор, философийн шинжлэх ухааны доктор хоёр нь

эрдмийн зэргийн хоёр өөр шатлал уу? эсвэл мэдлэгийн хоёр өөр төрлийн эрдмийн зэрэг үү? гэсэн асуултад нэг утгаар хариулт өгөх боломжгүй байдалд байна. XX зууны 90-ээд оны үеэс манай философийн нийгэмлэгийнхний дунд өрнөж асан нэгэн хурц гэмээр маргааны сэдэв бол "философийн шинжлэх ухаан" хэмээх нэр томъёо юм. Асуудал өрнөж эхэлсэн тэр үед манай зарим философичид уг асуудлын марксист агуулгыг ойлгохгүйгээр "философи бол шинжлэх ухаан мөн" хэмээн тунхаглаж, түүнээс нь өөр зүйл ярьж бичсэн хүмүүсийг бүр их сургуулиас хөөлгөх арга чарга хайж, оролдож байсан түүхтэй.

- Хэрэв хуучин системийнх шиг хоёр өөр шатлалын эрдмийн зэрэг бол эл зэргийг хамгаалах ажлын онол, арга зүйн шалгуур, шаардлагыг өндөрсгөх, шинэчлэх шаардлагатай болох байх. Гэтэл үүнтэй зэрэгцэн дэлхийн ихэнх их сургуульд эрдмийн дээд зэрэг хэмээн хүлээн зөвшөөрч олгодог Ph.D докторын зэргийг, мөн гадаад орнуудын их сургуульд Sc.D зэрэг хамгаалж ирсэн шинжлэх ухааны салбарын эрдэмтдийн докторын зэргийг хэрхэн үнэлэх тухай асуудал маргаан дагуулах болно.

Цаашид философийн докторын диссертацийн нэгдсэн сан үүсгэх, дотоодод хамгаалсан диссертацийн чанарын судалгаа хийх ажил тулгамдаж байна.

Онолын мэдлэгийн салбар бүр өөрийн судлагдахуун, судалгааны арга зүй, онолын хэлийг байгуулах, үндэслэгдэх байдал зэргээс хамааран ялгаатай байдаг. Байгалийн шинжлэх ухаан, ялангуяа физикийн шинжлэх ухаанд онолыг илэрхийлэх үндсэн хэл бол формаль математик хэл юм. Харин нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбаруудын тухайд онолын хэл нь философийн баримтлалууд байдаг онцлогтой. Ийм учраас марксизм-ленинизмийг онол, арга зүйгээ болгож ирсэн нийгэм, хүмүүнлэгийн ухааны /улс төр, эрх зүй, нийгэм судлал, хүн судлал, боловсрол судлал, түүх, хэл шинжлэл гэх мэт/ онол, арга зүйн шинэчлэлт нь чухамхүү философийн онол, арга зүйн шинэчлэлтэй холбоотой юм. Гэтэл манайд нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургалт, судалгааны онол, арга зүй нь мэргэжлийн институцийн түвшинд төдийлөн шинэчлэгдээгүй, тухайн салбарт ажиллаж буй цөөн зарим мэргэжлийн боловсон хүчний хувь хүний чанарууд, манлайлал зэргээс хамаарч янз бүр байдалтай байна.

**Ном зүй:**


1. Гүн ухааны товчоо. УБ.: 1995 он. /ред. Д.Дагвадорж, Л.Дагдан /МУБИС/
2. Б.Бадарч, Л.Дагдан. Өрнийн гүн ухааны сэтгэгчдийн үзэл баримтлалын товч тойм. УБ.: 1999 он
3. Философи эхлэн суралцах бичиг. УБ.: 2000 он. Нээлттэй философи нийгэмлэг. /ред Ц.Гомбосүрэн, М.Отгонбаяр
4. Л.Дамбийням. Гүн ухаан. УБ.: 2000 он. /ред. Д.Баттөмөр
5. Философи. Сурах бичиг. УБ.: 2002 он. МУИС-ийн философийн тэнхим. /ред. Ц.Гомбосүрэн
6. Б.Батчулуун. Философи гэж юу вэ? УБ.: 2004 он
7. Д.Содномгомбо, Р.Дарьхүү. Философи. УБ.: 2004 он. /ред Г.Чулуунбаатар.
8. Д.Ганболд. Философи. УБ.: 2007 он
9. Ц.Гомбосүрэн. Философи. УБ.: 2008, 2011, 2012, 2014, 2020 он. /ред М.Отгонбаяр.
10. М.Отгонбаяр. Монгол Улсын Их Сургуулийн Философийн салбар 50 жилд: өчигдөр, өнөөдөр. УБ.: 2015 он

# 1990-ЭЭД ОНООС ХОЙШИХ МОНГОЛ УЛС ДАХЬ НИЙГМИЙН АНТРОПОЛОГИЙН СУДАЛГАА

Г.Мөнх-Эрдэнэ, магистр (MA)
*ШУТИС-ийн хүмүүнлэгийн тэнхим*

***Товч утга:*** *Монгол антропологичид 1990 оноос хойш Монголд гарч ирсэн өөр өөр нийгмийн асуудлуудыг хэрхэн авч үзсэн тухай уг өгүүлэлд нэгтгэн дүгнэх болно. 1990 онд болсон социалист тогтолцооны уналт ба ардчилсан дэглэмийг дагаад олон урьгалч үзэл, нээлттэй байдал, бүтээлч шүүмж гэх мэт зүйлс тус улс дахь нийгмийн шинжлэх ухааны өөр өөр салбарт нэвтрэн орж ирэв. Тэдгээрийн дундаас, өмнө нь угсаатан судлал эсвэл угсаатны зүй гэж томъёологддог байсан нийгмийн антропологийн салбар Зөвлөлтийн өвийг даган хоёр өөрөөр хөгжих болсон юм. Эхний хэлбэр нь Зөвлөлтийн нийгмийн шинжлэх ухаанаас ихээхэн нөлөө авч урьдын арга зүйд тулгуурлан хөгжжээ. Дүрслэн бичих аргад тулгуурлаад бүс нутаг ба орон нутгийн түвшинд Монголчуудын зан үйл, ёс заншил, түүх ба соёлын өв гэх мэт 'уламжлалт судалгааны асуудлууд'-ыг судлах оролдлогууд хийсэн байна. Хоёр дахь хэлбэр нь өрнийн, тэр дундаа Англи-хэлтэй орнуудын академик судалгааны үйл ажиллагаатай илүү холбогдож конструктив шүүмжлэлт судалгааны үзэл баримтлалыг хөгжүүлэх оролдлого хийжээ. Энэ нь 'уламжлалт-бус асуудлууд' болох капитализм, хөгжил, орон нутгууд дахь олон улсын төсөл, уул уурхай ба тус улсын хөгжлийн асуудлууд зэргийг авч үзэхэд илүү хүчин чармайлт гаргасан байна.*

***Түлхүүр үгс:*** *Антропологи, угсаатны зүй, угсаатан судлал, соёл, оролцон ажиглах судалгааны арга*

***Abstract:*** *This article reviews studies of Mongolian anthropologists on different social issues in Mongolia which took place since 1990s. Following the collapse of the socialist system and the rise of the democratic regime in the country in 1990, pluralism, openness, and productive criticism were introduced to different branches of social sciences in the country. Among these branches, social anthropology which was previously known as ethnology or ethnography due to the Soviet legacy is developed in two different ways since that time. The first way is more based on the former methodological practice that was heavily influenced by Soviet social sciences. Drawing on the descriptive writing method, this approach focuses on a regional and local level and attempts to study 'traditional research topics' –Mongolian ritual, custom, history, and cultural heritage. The second way engages more the Western especially English-speaking academic world's research activities and tries to encourage constructive critical research views. This way also makes more effort to study 'non-traditional issues'– capitalism, development, and international projects among locals, mining, and development problems in the country.*

***Keywords:*** *Anthropology, ethnography, ethnology, culture, participant observation method*

**Удиртгал: Судалгааны аргаас салбар ухаан руу**

Антропологи, илүү нарийвчилбал нийгэм-соёлын антропологи хэмээн ухаан нь XIX зууны дунд үеэс нийгмийн шинжлэх ухааны нэгэн салбар болон төлөвшин тогтсон юм. Улс орон бүрийн шинжлэх ухааны онцлог, зорилго чиглэлээс болж уг ухаан өөр өөрөөр хөгжсөн бөгөөд жишээ нь, АНУ-д антропологи хэмээх товч нэрийн дор биологийн, соёлын, хэл шинжлэлийн антропологи болон археологи гэсэн дөрвөн салбар ухааныг багтаадаг[1]. Зарим улсад тэр дундаа Европын улсуудад эдгээр дөрвөн салбар тус тусдаа байх нь ч бий. Мөн Их Британи, Европд нийгмийн антропологи, АНУ-д соёлын антропологи гэж нэрлэдэг салбар ухаан нь үндсэндээ нэг л ухаан юм. Гэтэл Францын уламжлалыг дагасан Зөвлөлт Холбоот Улс угсаатны зүй (энтографи), угсаатан судлал (этнологи) нэрийн дор уг ухааныг хөгжүүлж байжээ[2]. Тиймээс уг өгүүлэлд дээрхийн адил олон янзаар нэрлэгдэж байгаа ч үндсэндээ антропологи гэсэн ерөнхий нэг л ухааны тухай ярих болно.

Харин Монгол Улсад социализмын үеэс ЗХУ-ын нөлөөгөөр уг салбар ухааны судалгаа нэвтэрч, эрчимтэй хөгжсөн байдаг. Хүйтэн дайны үеийн Монгол Улсад 1950-аад оны сүүлээс Зөвлөлтийн шууд нөлөө, сургаалаар Шинжлэх ухааны хүрээлэнгийн (өнөөгийн Шинжлэх Ухааны Академи) бүрэлдэхүүнд Археологи-этнографийн тасаг байгуулагдсан нь угсаатны зүйн судалгааны цөм байгууллага болжээ. Гэвч уг салбар ухааны чиглэлээр урьд өмнө ажиллаж байсан судлаач эрдэмтдийн бүтээлийн үнэ цэнийг дутуу үнэлж болохгүй. Хэдийгээр яг тухайлан угсаатан зүйч юм уу, угсаатан судлаач, эсвэл антропологич гэсэн мэргэжил албан ёсоор эзэмшээгүй ч Ж.Цэвээн, Б.Ринчен зэрэг эрдэмтдийн судалгаа энэ талын олон өв үлдээсэн юм[3]. Тэдний судалгаа ч 1921 оны хувьсгалын дараах олон үйл явдал, тэр дундаа ард иргэдийг олон угсаатны бүлэгт (ястан) хуваах, иргэний үнэмлэх олгох зэрэг түүхэн хэрэгт жинтэй нөлөөлсөн байдаг[4].

1990 оны нийгмийн өөрчлөлтөөр Монголын шинжлэх ухааны салбарууд Зөвлөлтийн нөлөөтэй онол сургаалаас татгалзаж, нээлттэй чөлөөт сонголтыг эрхэмлэх болсон нь бидний ярьж буй ухаанд ч нөлөөлж, зуу гаруй жил Барууңд хөгжсөн антропологи, тэр дундаа нийгэм-соёлын антропологийн ухааны онол сэтгэлгээтэй танилцах боломж нээгдэв. Өмнө дурдсан ШУА-ийн Археологи-этнографийн тасаг аль 1980-аад оны дундуур Угсаатны зүйн сектор болсон байснаа 1990-ээд оноос Угсаатан судлалын салбар, улмаар 2015 онд Угсаатан судлал, нийгмийн хүн судлалын салбар болж нэрээ солив. Уг үйл явцын адилаар МУИС 1989 онд Монгол судлалын лаборатори байгуулсан нь 1990-ээд оны дундуур Угсаатан судлалын тэнхим, 2006 онд Нийгэм-соёлын антропологийн тэнхим, 2015 онд Антропологи, археологийн тэнхим болон өөрчлөн зохион байгуулагдав.

Энэ бүхнийг дээрх хоёр байгууллага нэрээ солиод байсан хэрэг гэхээсээ илүү Монголын нийгмийн судалгааны онол арга зүй, сэдэв гэх мэт өргөн хүрээнд гарсан өөрчлөлт гэж үзэх учиртай юм. Энгийн үгээр бол уг ухаан жирийн нэгэн арга зүйн шинжтэй байснаа сая нэг шинжлэх ухааны зүй шаардлагад нийцсэн салбар ухаан болсон шилжилт 1990 оноос хойш өрнөжээ. Учир нь 1990 оноос өмнөх нийгмийн тогтолцоо буюу төрөөс бүхнийг төлөвлөж хянадаг социалист засгийн үед шинжлэх ухаанд нэгэн онол ноёрхож, түүнийг шүүмжилсэн, өөрөөр харах гэсэн хандлага дарагдаж байсан байдаг. Тийм ч учраас угсаатан зүй, угсаатан судлал гэж аль ч

*1 Мөнх-Эрдэнэ болон Чулуунбат, 2017, х. 4*
*2 Бум-Очир, 2006, х. 49-50*
*3 Булаг, 2011-аас үзнэ үү*
*4 Зөвлөлтийн Монгол дахь угсаатанчлах бодлогын тухай Мөнх-Эрдэнэ, 2012-ийг үзнэ үү.*

нэрээр нэрлэлээ гэсэн уг салбар ухаан тогтсон онолын хүрээнд л Монгол улсын хүн зоны ахуй амьдралын тухай баримт цуглуулж байжээ. Цуглуулсан баримтаа зарим тохиолдолд бага сага задлан шинжлэх ч өнөөх л тогтсон онолын хүрээнээс хальж гарах хориотой байв. Иймээс ихэнх тохиолдолд цуглуулсан баримтаа тодорхой учир зүйн дараалалд оруулан, алив нэгэн шүүмжлэлт сэтгэлгээ, тогтсон онолыг хянан нягтлах гэх мэт шинжлэх ухаанд зайлшгүй байх ёстой зүйлсээс зориуд зайлсхийн хэвлүүлдэг байжээ. Жишээ нь: угсаатан зүйч эсвэл судлаач Монголын нэгэн угсаатны бүлгийн тухай бичих болбол уг угсаатны түүх, аж ахуй, эдийн болон оюуны соёл, шашин гэсэн таван дэд сэдвийг зайлшгүй хөндөх ёстой[5]. Мэдээж эдгээрээс өөр нэмэлт сэдэв багтаан судлах боломж бүрэн бий. Тиймээс л энэ үед тус ухаан нь шинжлэх ухааны шүүмж, бүтээлч задлан шинжилгээ дутмаг, гадаадын бусад улсын болоод дэлхийн чиг хандлагыг хангалттай хэмжээнд тусгаж авах боломжгүй байсан юм. Энэ бүхнээс нь үндэслэн тухайн үеийн уг ухааныг судалгааны арга зүй шинжтэй байсан гэж дүгнэж буй юм.

Гэвч дээрх судалгааны арга барил зарим нэг талаар өөрчлөгдөгсөн ч өнөө болтол хүч, нөлөөгөө алдаагүйг дурдах хэрэгтэй. Одоогоор уг хандлагыг ерөнхий утгаар нь “түүхийн” болон “соёлын” гэж хоёр ангилж болмоор байна. Өөрөөр хэлбэл: угсаатан судлал эсвэл угсаатны зүй гэсэн нэрийн дор өнөөгийн нийгмийн гэхээсээ илүү уламжлал, түүх, өв судлах ёстой гэсэн хандлага одоо ч байгаа гэсэн үг юм. Энэ үүднээсээ бидний ярьж буй салбар ухаан нь нийгмийн ухаан гэхээсээ илүү хүмүүнлэгийн тэр дундаа түүх, хэл шинжлэл, соёл судлалтай илүү холбоотой, бүүр тэдгээрийн нэг салбар ч гэж үзэх явдал байна[6]. “Түүхийн хандлагийг” баримтлагчид бидний ярьж буй салбар ухааныг илүү аман түүх, эмпирик баримт цуглуулж, түүнийгээ архивын баримт сэлттэй харгуулан үзэж, судлан буй асуудлаа түүхчилж, он цагийн дараалын дагуу харахыг чухал гэж үздэг. Энэ талаас нь үзвэл угсаатан судлал, угсаатны зүй, антропологи нь түүхийн ухаанаас зөвхөн хээрийн шинжилгээ эсвэл оролцон ажиглах гэж нэрлэгддэг судалгааны аргаараа л ялгаатай болж таарах юм. Тийм ч учраас түүх, хэл шинжлэх, соёл судлалын мэргэжил эзэмшсэн хүмүүс өөрөө хүсвэл антропологийн судалгаа хийж чадах төдийгүй тус ухаанаар зэрэг хамгаалах боломжтой ажээ. Тиймээс ч түүх, археологи, антропологи гэх гурван өөр ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөл нь хамт, салбар бүрийн эрдэмтдийг багтаасан бүтэцтэй байгаа юм.

Улмаар уг хандлага улс төрийн үзэл сурталтай холбогдон, шинжлэх ухааны чигч, хөндлөнгийн оролцоогүй байх учиртай шугамаасаа үе үе халих нь бий. Шинэ ерөнхийлөгч сонгогдох, аль нэг нам Улсын Их Хуралд олонх болон Засгийн газар байгуулах үед “улс үндэстний эрх ашиг, түүх соёлыг хамгаалахын төлөө” эсвэл “орон нутаг дахь соёлын өвийг хадгалан хамгаалах, хөгжүүлэхийн төлөө” гэх зэрэг уриа лоозонгийн дор шинжлэх ухааны гэхээсээ илүү санхүүжилт дагасан “судалгаа” хэвлэгдэх болсон юм. Энэ санаачилга цааш өргөжин уул уурхай, барилга байгууламж, засмал зам зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой, тэдгээр төслийн хамрах нутагт археологи, палентологийн хайгуул хийхийг шаардсан хуулийн заалт, практикаар сэлбэгдэн соёлын өвийн тухай бие даасан салбар шахуу болоод байна[7]. Энэ тухай дор дэлгэрүүлэх тул энд хүрээд түр зогсъё.

Уг уламжлалт хандлагын өөр нэгэн салбар болох “соёлын хандлага” гэж нэрлэж болох соёл судлалын салбарынхны хувьд бидний ярьж буй ухаан соёл судалдаг тул

*5 Булаг, 2011, х. 218*
*6 Илүү дэлгэрэнгүйг Дорждагва, 2010-аас үзэж болно*
*7 Bumochir & Munkherdene, 2019*

тэдний судалгаанд ойрхон[8] санагдсан бололтой байдаг. Тийм ч учраас зарим судлаач санаатай болоод санамсаргүйгээр төстэй нэрийн дуудлагаар нь тухайлбал АНУ-д байх соёлын антропологийг Зөвлөлт Холбоот Улсад хөгжиж байсан соёл судлалтай (Културлогия) холбон үзэж, нэгэн ухаан мэтээр мэтгэж байгаа юм□. Түүнчлэн 1960-аад оноос Их Британид үүсэж англи хэлт ертөнц болон Барууңд түгэн дэлгэрсэн соёл судлалын ухаан (Cultural Studies), соёлын антропологи болоод Зөвлөлтийн соёл судлал (Културлогия) хэмээх гурван өөр ухааны хооронд нь хольж хутгасан[9] байх нь ч бий. Үнэндээ Зөвлөлт, ОХУ-ын соёл судлал (Културлогия) болоод Барууны соёл судлал (Cultural Studies) нь орчин үеийн нийгмийн соёлын үзэгдэл, тэр дундаа хотын амьдралын асуудалд анхааралаа хандуулдаг юм. Харин антропологи нь илүү уламжлалт гэгддэг нийгмийн асуудалд төвлөрдөг билээ.

Харин 1990-ээд оноос хойш тус салбар ухаан урьдын адил баримт цуглуулахаас гадна түүнийгээ задлан шинжлэх, дэлхийн бусад улсын судлаачдын судалгаатай харьцуулах, бүтээлч шүүмж өрнүүлэх, тус салбар ухааныхаа онол, арга зүйг хянан нягталж эхэлсэн юм. Энэ боломж бололцоог ашиглаж, Зөвлөлт маягийн онол сургаалаас татгалзан Барууны шүүмжлэлт судалгааны арга барилыг Монголд нэвтрүүлэх, хөгжүүлэх санаачилга хүчтэй түрч, зохих үр дүнд хүрээд байгаа юм. Өөрөөр хэлбэл: уламжлалт маягийн зөвхөн Монгол Улсын монголчуудыг судалдаг, монгол хэлээр судалгаагаа хэвлүүлдэг орон нутгийн шинжтэй байсан тус салбар илүү багтаамжтай, олон бүс нутаг, ард түмнийг хамарсан судалгаа хийж, үр дүнгээ олон хэлээр хэвлүүлэх болсон юм. Үүнийг 1990-ээд оноос хойш хөгжсөн антропологийн ухаан нь судалсан сэдэв, хамарсан бүс нутгийн хувьд төдийгүй Барууны өндөр зэрэглэлийн хэвлэлийн газар, сэтгүүлд хэвлүүлсэн судалгаагаараа нийгмийн ухааны салбаруудыг тэргүүлж буйгаар баталж болох юм. Мөн түүнчлэн эрдэм шинжилгээний зайлшгүй чухал үзүүлэлт болох дэлхийн тэргүүлэх сургуулиудад эрдмийн зэрэг хамгаалсан, тэнд уригдаж ажилласан, олон улсын судалгааны тэтгэлэг, төсөл хөтөлбөрт шалгарсан антропологийн салбарын мэргэжилтний хувь хэмжээг бусад нийгмийн ухааны салбартай харьцуулахад илүү хувьтай байгааг ч дурдах хэрэгтэй. Ийм учраас 1990 оноос хойш тус ухаан нь судалгааны аргаасаа илүү салбар ухаан болон хөгжсөн хэмээн зориглон дүгнэж буй юм.

### *1990-ээд оноос хойших нийгмийн антропологийн судалгааны голлох чиглэл*

Өнгөрсөн гучин жилийн Монголын нийгмийн антропологийн судалгааг хоёр үндсэн хэсэгт тоймлон үзэж болно. Нэгдүгээрт, өмнөх хэсэгт цухас дурдсан шиг уламжлалаа илүү хадгалсан, аман түүх, архивын баримт зэрэгт тулгуурлаж Монголын түүх, соёл, зан заншлыг судлах, тэдгээрийн талаар дүрслэн бичих гэсэн хандлага. Хоёрдугаарт, мөн л өмнөх хэсэгт товчхон өгүүлсэнтэй адил оролцон ажиглах болон угсаатны зүйн судалгааны аргаар судалгаа хийж, цуглуулсан мэдээ баримтаараа антропологи хэмээх нийтийг хамарсан ухааны онол, арга зүйд хувь нэмэр оруулах, бүтээлч шүүмжлэл, үр дүнтэй задлан шинжилгээ хийхийг чухалчилсан хэсэг гэж болмоор байна. Энэ хоёр хэсгийг нэг нь нөгөөгөөсөө илүү, дэвшилтэт, хөгжсөн гэсэн утгаар бус нэг нэгнээсээ ялгаатай, өөр өөр судалгааны чиг баримжаа гэсэн утгаар ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл: нэгдүгээр хандлага илүү Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх монголчууд, тэдний ахуй байдал, зан суртахууныг судлах, өөрчлөлтийг нь баримтжуулан үлдээх чиглэлд голчлон ажиллаж байгаа бол удаах хандлага нь зөвхөн Монгол Улс бус Дотоод Ази гэх мэт бүс нутгийн хэмжээний

*8 Дорждагва, Сарантуяа ба Долгорсүрэн, 1998*
*9 Илүү дэлгэрэнгүйг Мөнх-Эрдэнэ 2015-аас үзнэ үү*

цаашлаад дэлхий дахины монголчууд, монголчуудтай ойр, адил аж ахуй соёлтой нүүдэлчин ард түмний соёлыг судалж, антропологийн ухаанд өөрийн хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байгаа гэж болно. Энэхүү хоёр хэсгийн тухай доор дэлгэрүүлж өгүүлэх болно.

***Эргүүлж мөлжихөд хүзүү сайхан буюу шинэ дээлтэй хуучин танил***

Энэ хэсгийн гарчгаар сүүлийн гучин жилийн нийгмийн антропологийн судалгааг хоёр үндсэн хэсэгт ангилсны нэгдүгээр хэсгийг төлөөлүүлэх гэж үзжээ. Өөрөөр хэлбэл: бидний ярьж буй нэгдүгээр хэсэг нь социализмын үеэс уламжилсан судалгааны арга, онол, сэдвээ өнөөгийн цаг төрхөнд тааруулан үл ялиг өөрчилсөн ч бүтээлч шүүмж, шинжлэх ухааны маргаан мэтгэлцээн өрнүүлэх тал дээр харьцангүй сулавтар байгаа юм. Тиймээс энэ хандлагад багтааж буй судалгаа нь аливаа судалсан сэдвээ тодорхойлж, тоочиж бичсэн, баримтын цуглуулга маягтай, нэвтэрхий толь, зурагт катологи, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл зэрэг шинжтэй байна. Энэ бүхэн нь шинжлэх ухааны тодорхой үнэ цэнэтэй ч хөндлөнгийн хяналтгүй хэвлэгддэг дутагдалтай байгааг засаж залруулах зайлшгүй хэрэгцээ байна. Эс тэгвээс эрдэм шинжилгээний судалгаа болоод эрдэм шинжилгээний бус зүйл хоёрын ялгаа зааг бүдгэрэх гэмтэй юм.

Сүүлийн хорин жил Монгол Улсын төр засгийн байгууллагууд, соёл урлагийн газрууд, салбарын судлаачид үндэсний соёлыг сэргээн хөгжүүлэх, хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах нэрийн дор олон хууль тогтоомж гаргаж, ЮНЕСКО зэрэг олон улсын байгууллагуудын олон арван гэрээ, конвенцид нэгдсэн орсон байна□. Гэвч судлаач Б.Цэцэнцолмоны үзэж буйгаар тэрхүү хичээл зүтгэл нь үнэндээ социализмийн үед хийж байсан олон компанит ажил, социалист хүн бүтээх зорилготой судалгааны дүрээ хувиргасан, өөр нэгэн хувилбар үргэлжлэл төдий үйл хэрэг ажээ[10]. Тухайлбал, Монгол Улс 2007 онд ЮНЕСКО-гийн “Соёлын илэрхийллийн олон талт байдлыг хадгалах хамгаалах тунхагт”□ нэгдэж, түүнийг дагах холбогдох хууль тогтоомждоо өөрчлөлт оруулжээ. Ингээд хуучин социализмийн үед төр албаны үйлд ч судалгаа шинжилгээний хэрэгт оюуны соёл гэж нэрлэж байсан соёлоо “биет бус соёлын өв”, материллаг соёл гэж нэрлэж байсан соёлоо “биет соёлын өв” гэж өөрчлөн нэрлэх болсон ч тэдгээрийн талаар явуулж буй бодлого, судалгаа нь хуучнаараа үлдсэн байна□.

Энэ мэт онцын өөрчлөлт гараагүйн нэгэн тод жишээ нотолгоо нь ярьж буй энэ хэсэгт хамаарах зарим судалгаа одоо болтол судалж буй сэдвийнхээ талаар идэвхгүй тоочимж, дүрслэн бичих арга барилаасаа салаагүй байгаа явдал юм. Энэхүү аливааг дүрслэн тоочдог бичлэгийн арга зүй нь XIX зууны үеийн Хаант Оросын зүгээс монгол нутаг, монголчуудын тухай тагнуулын мэдээ цуглуулах, уг бүс нутаг үйл ажиллагаагаа идэвхижүүлэх зорилготой илгээж байсан олон тооны тагнуул-судалгааны ангийн арга барил юм. Энэхүү шинжлэх ухааны гэхээсээ илүү улс төр, эдийн засаг, геополитикийн арга барил тус улсад монгол судлал дэлгэрч хөгжих нэгэн хөдөлгүүр нь болсон байдаг. Гэтэл ямар нэгэн эрдэм шинжилгээний судалгаа гэдэг задлан шинжилгээ, бүтээлч шүүмж, урьд өмнө тухайн сэдвээр нь хэвлэгдсэн судалгааны үр дүн, дүгнэлтийг хянан нягталсан, шүүмжилж сайжруулсан, тэдгээрээс өөрийг, илүү итгэл үнэмшил төрүүлэхүйц санал дүгнэлт гаргасан байх зарчимтай. Мөн тухайн сэдвээр нь дэлхийн өөр газар орон, бүс нутагт хийгдэж буй, хэвлэгдэн гарсан судалгааны үр дүнг харьцуулах, санал дүгнэлтийг нь ч нягтлан

10 *Мөнх-Эрдэнэ болон Наранцацралт, 2015, х. 34*

үзэж, тухайн шинжлэх ухааныхаа онол сэтгэлгээ, арга зүйд өөрийн хувь нэмрээ оруулах ёстой юм.

Түүнчлэн бидний ярьж буй нэгдүгээр хэсэгт хамаарах зарим судалгаа нь өмнө өнгөцхөн дурдсан шиг шинжлэх ухааны зарчим, зүйг дагахаасаа илүү гарч ирсэн боломж, цаг зуурын хөөсийг дагасан шинжтэй байгаа юм. Ямар нэгэн аймаг, сумын ой, хэн нэгэн төр нийгмийн зүтгэлтний насны ойг угтаж судалгаа хийх эсвэл уул уурхайн компани, дэд бүтцийн хөгжлийн төслийг хамрах нутагт л ажиллах гэх мэт шинжтэй байгаа билээ. Социалист тогтолцооны үед Монголын судлаачид хүн амаа олон ястанд хуваaж, олон төрлийн соёл “бүтээсэн”[11] бол өнөө цагт аль нэг аймгийн, сумын соёл аль эсвэл нэг томоохон уул уурхай, дэд бүтцийг хөгжлийн төслийн нэртэй соёл ч үүсэж болохуйц болжээ[12]. Энэ бүхний үр дүн эрдэм шинжилгээний бус саарал судалгаа (grey literature) хэвлэгдэх, судалгааны чанар муудах эрсдэл үүсэж байгаа болно. Үүнээс гадна нутгийн зөвлөл, ойн хурал, нутгийн улс төрч, уул уурхайн компани болон дэд бүтцийг хөгжлийн төсөл гэсэн шинэхэн олдсон санхүүжилт, эдийн засгийн нөөцийн төлөө судлаачид хоорондоо талцах ч аюул байна. Мөн түүнчлэн зарим дарга нар энэхүү санхүүжилт, нөөцийн төлөө хууль тогтоомж, дүрэм журмыг өөрчлөх, төсвөөс санхүүждэг, улсын судалгааны байгууллагын бүтцийг өөрчлөх, хүний нөөцийг тарамдуулах байдал гарах болсон юм[□]. Нэгэнтээ ингэж олны анхаарлыг соронздсон энэ санхүүгийн нөөц болон үүнийг дагалдан газар авч байгаа “соёлын өвийг уламжлан тээгч” гэх мэт нэр алдрын төлөө жирийн иргэд ч хоорондоо тэмцэлдэн талцаж, урьд хэвийн байсан нийгмийн харилцаа зөрчил тэмцэлд хүрсэн жишээ цөөнгүй байна.

Энэ бүхнийг олон дахин нуршиж буй нь угсаатан судлал, нийгмийн антропологийн уламжлалт сэдвүүд одоо хэрэггүй, үеэ өнгөрөөсөн гэсэн санааг илэрхийлээгүй болно. Мөн соёлын өвийн асуудал, түүний хадгалалт хамгаалалтын ач холбогдлыг ч дутуу үнэлээгүй юм. Үүний адилаар уул уурхайн болон дэд бүтцийг томоохон төслийн хамрах нутагт ч хайгуул судалгаа хийх, тухайн нутгийн соёлын өвийг баримтжуулах, баталгаажуулах, хадгалж хамгаалахыг чухлыг үгүйсгээгүй билээ. Харин энэ бүх судалгааг илүү шинжлэх ухаанчаар, тухайн салбар ухааныхаа арга зүй, ёс зүйн хүрээнд хийж, цуглуулсан баримт сэлт, гарсан үр дүнгээ шинжлэх ухаанчаар задлан шинжилж, тухайн ухааныхаа онол сэтгэлгээнд хувь нэмрээ оруулсан, хөндлөнгийн хяналттай эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэх тухай ярьж байгаа болно.

### *Нутгийн дээс алхах буюу нийтийн шинжлэх ухаантай холбогдохуй*

Энэ хэсгийн гарчгаар 1990-ээд оноос хойших Монголын нийгмийн антропологийн судалгааг хоёр үндсэн хэсэгт ангилсны хоёрдугаар хэсгийг илэрхийлсэн болно. Энэ хэсэг хамаарах судалгаа нь зөвхөн Монгол Улсын газар нутаг дээр монголчуудаар тогтохгүй бүс нутгийн, дэлхий даяар амьдарч буй монголчууд, Монгол угсаатай ард түмэн, монголчуудтай төстэй аж ахуй соёлтой ард түмний амьдралыг сонирхон судалж байна. Зөвхөн судлаад зогсохгүй антропологи хэмээх нэгдсэн нэгэн ухааны онол сэтгэлгээ, арга зүйг өөрийн судалгааны баримтаар хянан нягталж, шүүмжлэн сайжруулж, няцаан халирааж, санал дүгнэлтийг дэвшүүлж байна. Иймээс энэ хэсэг хамаарах судалгаа нь 1990 оноос өмнө түгжигдмэл байсан угсаатан судлал юм уу, антропологийн ухааныг нээлттэй, дэлхийн зэрэгт хүрч, хөл нийлүүлэн алхахад хамгийн гол хувь нэмрээ оруулсан гэсэн үг. Тухайлбал, үндэсний үзэл, монгол

*11 Tsetsentsolmon, 2014a болон 2014 б*
*12 2015, х. 119-123*

угсаатан, төрийн тухай судлаач Л.Мөнх-Эрдэнийн хэд хэдэн өгүүлэл нь Барууны зэрэглэл өндөр сэтгүүлд хэвлэгдснээс гадна гадаад дотоодын олон судлаач эшлэн ашигласан байна. Уг судлаач дундад зууны үеэс өгсүүлэн монголчуудын төр хэмээх ойлголт, төр улс, эзэнт гүрэн байгуулсан учир шалтгааны тухай судлахдаа монгол сурвалжуудын мэдээг үр дүнтэй ашиглаж, эрдэм судлалд тогтсон байсан хэд хэдэн чухал ойлголтод няцаалт өгөөд байна. Уламжлалт эрдэм судлалаар бол монголчууд XIII зуунд эзэнт гүрэн байгуулахдаа бусдаас загвар авч, “хуулсан” гэдэг. Учир нь тэр үеийн монголчууд төрийн тухай ойлголт сэтгэлгээтэй байх боломж бага аж. Гэтэл судлаач Мөнх-Эрдэнийн үзэж буйгаар бол монголчууд “улс, иргэн” гэх хоёр ойлголтоор нэлээд нарийн утга учрыг илэрхийлж байжээ. Жишээ нь, эзэлж авахаасаа өмнөх алив хүмүүсийг улс буюу Хэрэйд улс, Найман улс гэх зэргээр нэрлэх бол эзэлж авсаныхаа дараа иргэн гэж нэрлэж байв[13]. Түүнчлэн Чингис хаанаас ч өмнө Дотоод Азийн нүүдэлчин төр улсуудын дунд байсан эзэн харьяатын нарийн дэг журам, улс төр, нийгмийн зохион байгуулалт нь Монголын эзэнт гүрэн байгуулагдах үед улам төгөлдөржин төр улс бүрэлдэхэд хүргэсэн тухай санал гаргажээ[14].

Өөр нэгэн бүлэг судалгаа бол Монгол дахь капитализмын тухай болон хөгжлийн бодлогын тухай хэд хэдэн судалгаа болно. Судлаач Д.Бум-Очирын үзэж буйгаар бол ардчилал, капитализм гэх зүйлстэй монголчууд зөвхөн 1990 оноос танилцсан биш ажээ. Аль өнгөрсөн зууны эхнээс л Монголын удирдагчид Дай Чин гүрнээс туурга тусгаарлахдаа ч, 1921 онд хувьсгалын үйл хэргийг үүсгэхдээ ч тусгаар тогтнол, бие даасан байдлаа батжуулахын тулд хоёр хөршөөсөө өөр ангид сонирхолтой гуравдахь хөрш улсын эрэлд хадаж, тэдний улс төр, нийгмийн байгуулал, үзэл сэтгэлгээг сонирхон, өөрсдийн байгуулсан улсдаа хэрэгжүүлэх гэж оролдож байжээ. Түүний нэгэн хэлбэр нь ардчилсан үзэл санаа, капиталист эдийн засгийн хөгжлийн загвар байжээ. Хэдийгээр энэ бүх хүсэл тэмүүлэл сая л 1990 оноос Монгол улсад хэрэгжих боломж гарсан ч түүний уг үүсгэл, анхны санал санаачилгыг дутуу үнэлж болохгүй ажээ[15]. Түүнчлэн тэрээр 1990 оноос хойш Монгол улс неолиберал дэглэмд шилжилж, өрнөдийн үзэл суртал хийгээд материаллаг бараа таваар гэх мэт олон зүйлээр бялхаж бялуурч байгаа ч тэр чигтээ Барууны хуулбар, неолиберал хүүхэлдэй болоогүй, өөрийн онцлогтой олон үзэл санаа, эд зүйлс бодит амьдрал дээр байгааг иргэний нийгэм, байгаль хамгаалах үзэл санаа болон алтны уурхайн жишээн дээр дэлгэрэнгүй тайлбарлан нэгэн сэдэвт бүтээл хэвлүүлжээ[16]. Таштрамд хэлэхэд сүүлийн хэдэн жил түүнээс өөр монголын эрдэмтэн Барууны өндөр зэрэглэлийн хэвлэлийн газраар нэгэн сэдэвт бүтээлээ хэвлүүлж хараахан амжаагүй байна.

Энэ сэдэвтэй уялдан судлаач И.Бямбабаатар 1990-ээд оноос хойш Монгол улсад дан ганц капиталист эдийн засгийн тогтолцоо л оршин байгаа мэтээр сэтгэж, мэтгэх нь учир дутагдалтай болохын нотолж Монголын эдийн засагт байсан, байгаа капиталист бус эдийн засгийн олон хэлбэрийг судлан гаргажээ[17]. Мөн судлаач Г.Мөнх-Эрдэнэ өнөөгийн Монголын нийгмийн хөгжлийн тухай голлох онол сэтгэлгээ болох либерал, либертариан сэхээтнүүдийн бүтээл, орчуулга зэргийг судалж, зарим төлөөлөлтэй нь уулзаж ярилцлага хийснийхээ үндсэн дээр тэдний дэвшүүлж буй хөгжлийн загвар нь социализмын үед хүчтэй байсан диелактик материализм, Марксизмтай адил алив нийгэм нэгэн доод шатнаас нөгөө дээд шатруугаа дэвшин хөгждөг гэж үзсэн, шинэ харагдаж байгаа ч хуучин зүйлээ л давтсан шинжтэй

*13 UNESCO, 2003*
*14 Tsetsentsolmon, 2015, х. 120*
*15 Bumochir, 2017 болон 2018*
*16 Bumochir, 2020*
*17 Byambabaatar, 2018*

хөгжлийн загвар байна[18] хэмээн мэтгэжээ. Учир нь энэ мэт аливаа улс хөгжлийн нэг шатнаас нөгөө шатруу шатлан хөгждөг гэдэг онол сэтгэлгээ, ойлголт тэртээ 1970-аад оны үед хүчтэй шүүмжлүүлэн, нийгмийн ухааны судалгаанаас хаягдан хоцорсон юм.

1990 оноос хойш Монголын улс төр, эдийн засаг, нийгэмд газар авсан нэгэн үзэгдэл бол гадаад улсын болоод олон улсын байгууллагын зээл тусламж, хөгжлийн төдийгүй тусламжийн төсөл хөтөлбөрүүд юм. Судлаач Г.Мөнх-Эрдэнэ Кэмбрижийн Их Сургуулийн Антропологийн профессор Дэвид Снийттэй хамтран бичил юм уу эсвэл нинжа уурхайчин гэж нэрлэгддэг хүмүүсийн дунд хэрэгжиж буй хөгжлийн төслийг судалжээ. Тэдний үзэж буйгаар бол хууль бус нинжа уурхайчдыг албан ёсны болгох, тэднийг байнгын орлого, амьжиргаатай болгох зорилго өвөртлөн 10 гаруй жил хэрэгжсэн хөгжлийн төсөл эцэстээ антропологийн олон судалгаагаар илэрч гарсан олон тооны жишээтэй адилаар бүтэлгүйтсэн үйл хэрэг болжээ. Учир нь уг төсөл нь 1990 оноос хойш Монголд хэрэгжиж байгаа неолиберал өөрчлөн байгуулалтын үр дүн болсон газар, өмчийн харилцааг анхнаасаа бүрэн дүүрэн тооцож үзээгүйгээс болсон ажээ. Судлаач И.Бямбабаатар докторын судалгаагаараа энэ мэт хөгжлийн төсөл хөтөлбөр тэр дундаа малчдын дунд хэрэгжиж буй төслийн тухай судалжээ[19]. 1990 оноос хойш мал аж ахуйн салбар хэдэн арван хууль тогтоомж, дүрэм журам, бодлогын баримт бичиг гарсан нь бүгдээрээ шахуу олон улсын байгууллагын төслийн шугамаар, түүний тусламжид дулдуйдаж байсан байна. Мөн малчдын амьжиргааг сайжруулах зорилготой хэдэн арван сая америк доллараар үнэлэгдэх төсөвтэй хэдэн арван хөгжлийн төсөл хэрэгжив. Бодит байдал дээр тэр олон бодлого баримт бичиг төдийгүй тэр олон хөгжлийн төсөл тэр бүр амжилттай хэрэгжиж, тавьсан зорилгодоо хүрч байсангүй. Гэвч энгийн монгол малчид тэр бүр өнөөх олон төслийг үр дүн, үйл ажиллагааг муу хэлж, голж гоочилдоггүй “амны бэлгэ” бодож өнгөрөөх нь их байдаг аж[20].

Энэ бүхнээс гадна монголчуудын шашин шүтлэгийн тухай антропологийн цөөнгүй судалгаа байна. Тухайлбал, судлаач Ж.Лхагвадэмчиг Далай лам, Жэвзундамба хутагтын дараагийн дүр тодрохтой холбогдуулан Монгол, Хятад хоёр улсын харилцаа, дипломат ёс, Монгол Түвэдийн хоорондох Бурханы шашны холбоо хэрхэх талаар судлан үзжээ[21]. Хятад улс Далай ламын дараагийн дүрийг Хятадын нутаг дэвсгэрт төрөх ёстой гэсэн хатуу байр суурьтай байгаа бол өнөөгийн Далай лам дараагийнхаа дүрийг Энэтхэгт, тэр бүү хэл Монголд ч төрж болох тухай өгүүлсэн нь байдаг. Судлаач Ж.Лхагвадэмчигийн үзэж буйгаар Монгол улсад айлчилсан сүүлийн айлчлалаараа Далай лам Жэвзундамба хутагтын дараагийн дүр мэндэлсэн нь тодорхой байна хэмээн айлдсан нь өөрийнхөө дараагийн дүрийг тодруулах хэрэгт нэгэнт төрчихөөд хараахан тодроогүй байгаа Жэвзундамба хутагтын нэр нөлөөг ашиглах гэсэн санаа бололтой[22].

1990-ээд оноос хойших Монголын антропологийн голлох судалгааны чиглэлийг тоймлон үзэхэд ийм байна. Гэвч энд нэг зүйлийг онцгойлон дурдахгүй бол болохгүй. Монголын антропологийн судалгаа гэдэгт Монгол улсын эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудад ажиллаж байгаа антропологичидын судалгааг багтаан үзсэн болно. Гадаад улсын их сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагад

*18 Munkherdene, 2018*
*19 Munkherdene болон Sneath, 2018*
*20 И.Бямбабаатар, 2019*
*21 Мөн тэнд, х. 190*
*22 Ж.Лхагвадэмчиг, 2018*

ажиллаж байгаа судлаачдын бүтээлийн тухай тусад нь бичихгүй бол энд багтахгүй их зүйл болно. Мөн антропологийн судалгаа гэдэгт хөндлөнгийн хяналттай, мэргэжлийн сэтгүүл, хэвлэлийн газрын хэвлэсэн нэгэн сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл зэргийг багтааж байгааг онцгойлон дурдах хэрэгтэй. Тэр бүхэнд багтаагүй, эрдэм шинжилгээний бус хэвлэмэл бүтээгдэхүүн, тайлан, хээрийн шинжилгээний баримт зэргийг энд багтаах боломжгүй биз ээ.

**Дүгнэлт**

Антропологи тэр дундаа нийгэм-соёлын антропологийн судалгааг тоймлон үзэхдээ тэдгээрийн эрдэм шинжилгээний үнэ цэнийг голлох шалгуураа болгон авлаа. Энэ шалгуур ёсоор 1990-ээд оноос хойших Монгол улсын антропологийн судалгааг хоёр үндсэн хэсэг ангилж үзэж болмоор байна. Эхний хэсэгт уламжлалт судалгааны онол сэтгэлгээ, арга зүйгээ баримтлан дэлхий нийтийн антропологийн ухаантай төдий л холбогдохгүй байгаа судалгааг багтаав. Мөн энэ хэсгийн судалгаа нь бие даасан, эрдэм шинжилгээний судалгааны санхүүжилт гэхээсээ илүү академик бус санхүүгийн эх үүсгэвэртэй холбогдож, хэрэглээний шинжтэй судалгаа хийж байгаагаараа онцлог. Түүнчлэн судалгааны сэдэв нь ч илүү уламжлалаа дагасан юм уу эсвэл цаг үеийн шинжтэй байх нь түгээмэл. Судалгааны арга зүйн хувьд ч бүтээлч шүүмжлэлт арга барилаас илүү тоочих, дүрслэн бичих, баримтжуулах тал давамгайлсан хэв маягтай юм. Мөн судалгааны үр дүнгээ хөндлөнгийн хяналттай олон улсын болоод дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын сэтгүүл, хэвлэлийн газраар харьцангуй бага хэвлүүлдэг нь ажиглагддаг.

Харин дараагийн хэсэгт хамаарч байгаа судалгаанууд нь онол сэтгэлгээ, арга зүйн хувьд дэлхий нийтийн антропологийн ухаантайгаа холбогдсон, хөл нийлүүлэн алхаж яваа, тус ухааны сүүлийн үеийн чиг хандлага, маргаан мэтгэлцээнд оролцдог шинжтэй байна. Судалгааны санхүүжилтийн хувьд ч эрдэм шинжилгээний бус гэгддэг улс төр, хувийн компани зэрэг хөндлөнгийн ашиг сонирхолоос ангид, бие даасан судалгааны сан, хөтөлбөрт түшиглэсэн байх нь харагдана. Судалгааны арга зүйн хувьд шүүмжлэлт сэтгэлгээнд тулгуурласан, олсон баримт сэлтээ задлан шинжлэх, бүтээлч шүүмж өрнүүлэхийг оролдож байгаа нь ажиглагдлаа. Судалгааныхаа үр дүнг ч олон улсын нэр хүндтэй, импакт фактор өндөртэй, хөндлөнгийн хяналттай сэтгүүл, тэргүүлэх дэсийн хэвлэлийн газраар хэвлүүлж байгаа юм.

Дээрх ангилал нь хувь судлаач миний ажиглалт тул тэр бүр хэн хүний санаанд нийцэхгүй байж болно. Мөн энэ хоёр ангилалыг эсрэгцүүлэн өрсөлдүүлж, сайн муу, сайхан муухай болгон хийсвэрлэн төсөөлөх ч хэрэггүй биз. Антропологийн судалгаа гэдэг аливааг хар цагаан гэж буй юм шиг хатуу нот хоёр хуваах гэхээсээ илүү яагаад ийм байдалд хүрснийг, яагаад ийм байгааг тайлан тайлбарладаг нэгэн төрлийн тайлбарлахуйн ухаан гэсэн хандлага антропологич Клиффорд Гирцээс хойш хэлбэршин тогтсон байдаг. Иймээс 1990 оноос хойш Монголын антропологийн судалгаанд гарсан олон чиг хандлагыг хоёр хэсэг болгон хялбаршуулан ангилж, өөрийн ойлгосон хэмжээгээр тоймлон буулгахад ийм дүр зураг гарлаа.

## Ном зүй


1. Булаг, У. (2011). Монголын угсаатны зүйн үндэс. *Угсаатан судлал, 20*(15), 210-227.
2. Бум-Очир, Д. (2006). Нийгэм соёлын антропологи, угсаатан судлал, угсаатны зүйн үүсэл хөгжил. *Угсаатан судлал, 17*(7), 49-60.
3. Бямбабаатар, И. (2019). Монгол дахь хөгжлийн байгууллагын интервенц: мал аж ахуй, байгаль хамгааллын жишээн дээр. (докторын судалгааны ажил). МУИС, Улаанбаатар.
4. Дорждагва, Т. (2010). *Соёл судлал*. Улаанбаатар: Admon.
5. Дорждагва, Т., Сарантуяа, Н., болон Долгорсүрэн, Ж. (1998). *Соёл судлалын үндэс.* Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
6. Лхагдавэмчиг, Ж. (2018). Хаана төрөхыг, төрүүлэхийг мэднэ: Хутагт хувилгаад ба төр. *Монголын хутагт хувилгаадын судалгаа.* Хуудас 53-59. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
7. Мөнх-Эрдэнэ, Г. (2015). Аль соёл судлал вэ: талбараа тодорхойлох шаардлага. *Орчин үеийн Монголын хэл, түүх, соёлын судалгаа, 3*(1), 153-165.
8. Мөнх-Эрдэнэ, Г., болон Наранцацралт, Д. (2015). Соёл судлалын удиртгал хичээлийн хөтөлбөрийг өөрчлөх нь. *ШУТИС-ийн Бизнесийн удиртлага хүмүүнлэгийн сургуулийн эрдэм шинжилгээний бичиг, 3*(1), 32-38.
9. Мөнх-Эрдэнэ, Г., болон Чулуунбат, П. (2017). *Нийгэм-соёлын хүн судлалын удиртгал.* Улаанбаатар: МУИС Пресс.
10. Мөнх-Эрдэнэ. Л. (2012). Монголын тусгаар тогтнолын ёгт үр дагавар: Монголчуудыг Монголжуу, Монгол улсыг олон ястны болгосон нь. С.Чулуун (эмх.), *Монголын тусгаар тогтнол ба монголчууд.* Хуудас 25-40. Улаанбаатар: Соёмбо Принтинг.


### *Англи хэл дээр*


1. Bumochir, D. (2017). ‘Mongolia’. In *Routledge Handbook of Civil Society in Asia*, Akihiro Ogawa (eds.), 95-109. London: Routledge.
2. Bumochir, D. (2018). Generating capitalism for independence in Mongolia, *Central Asian Survey, 37*(3), 357-371.
3. Bumochir, D. (2020). *The State, Popular Mobilisation and Gold Mining in Mongolia: Shaping ‘Neo-Liberal’ Policies*. London: UCL Press.
4. Bumochir, D., & Munkherdene, G. (2019). Revitalisation of Cultural Heritage in Mongolia, *Inner Asia*, *21*(1), 83-103.
5. Byambabaatar, I. (2018). Collaboration for survival in the age of the market: diverse economic practices in postsocialist Mongolia, *Central Asian Survey*, *37*(3), 386-402.
6. Munkh-Erdene, L. (2006). The Mongolian Nationality Lexicon: From the Chinggisid Lineage to Mongolian Nationality (From the seventeenth to early twentieth century)”, *Inner Asia*, *8*(1), 51-98.
7. Munkh-Erdene, L. (2011). Where did the Mongol Empire come from? Medieval Mongol Ideas of People, State and Empire”, *Inner Asia*, *13*(2), 211-237.

8. Munkh-Erdene, L. (2018). The rise of the Chinggisid dynasty: pre-modern Eurasian political order and culture at a glance. *International Journal of Asian Studies, 15*(1), 39-84.
9. Munkh-Erdene, L. 2016. Political order in pre-modern Eurasia: imperial incorporation and the hereditary divisional system. *Journal of the Royal Asiatic Society, 26*(4), 633-655.
10. Munkh-Erdene, L. 2017. In accordance with the great tцгь: pre-modern Mongol concept of moral order, law and government. In: IAMS: International Association for Mongol Studies (ed.). *Mongol sudlal ba togtwortoj khцgzhil: olon ulsyn mongolch erdemtnij XI; ikh khurlyn "Mongolyn gadaad kharilcaa sudlal" IV salbar khuraldaany iltgelььd*. Muvgqhul sudulul. Ulaanbaatar: IAMS: International Association for Mongol Studies, pp. 247-255.
11. Munkherdene, G. (2018). The formation and distribution of procapitalist perspectives in Mongolia, *Central Asian Survey*, *37*(3), 372-385.
12. Munkherdene, G., & Sneath, S. (2018). Enclosing the Gold-Mining Commons of Mongolia. *Current Anthropology, 59*(6), 814-838.
13. Tsetsentsolmon, B. (2014а). Хуваалцах уу, үгүй юу: Биет бус соёлын өвийн тухай монголчуудын маргаан. *Studia Ethnologica, 21* (22), 246–54.
14. Tsetsentsolmon, B. (2014б). The 'gong beat' against the 'uncultured': contested notions of culture and civilization in Mongolia. *Asian Ethnicity, 15*(4), 422-38.
15. Tsetsentsolmon, B. (2015). Music in cultural construction: nationalisation, popularisation and commercialisation of Mongolian music. *Inner Asia,* 17(1), 118-40.
16. UNESCO. 2003. *Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage.* Paris: UNESCO.

# МОНГОЛЫН НИЙГМИЙН ДАВХРААЖЛЫН СУДАЛГААН ДАХЬ ПАРАДИГМЫН ӨӨРЧЛӨЛТ

О.Мөнхбат, доктор (PhD), профессор
*МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэн*

***Товч утга:*** *Энэхүү өгүүлэл нь Монголын нийгмийн давхраажлын судалгааны онол арга зүйн хувьсал өөрчлөлтийг авч үзэж, парадигмын халаа сэлгээ, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс зэргийг шинжилсэн байна. Монголын нийгмийн давхраажлын онол арга зүйн үндэс голлон позитивист чиглэлийн Нийгмийн баримт сэлтийн парадигм дээр тулгуурлаж ирсэн агаад тоон байдлаар хэмжигдэхүйц орлого хөрөнгө чинээ, боловсрол зэрэг шалгуурууд зонхилсоор ирсэн болохыг зохиогч тэмдэглээд орчин цагийн судалгаанд ажиглагдаж буй олон хэмжээст, чанарын хандлагыг онцолсон байна. Зохиогч энэ чиглэлийн судалгааны парадигмын өөрчлөлтийг судлагдсан байдлыг шинжлэн, улмаар позитив тоон үзүүлэлтийг интерпретив чанарын парадигмын үзүүлэлттэй хослох зүй тогтол илэрч байгааг онцолжээ. Тэрээр өөрийн судалгааны хүрээнд чанарын шинжилгээний аргыг ашиглах замаар холбогдох ном зохиол, хэрэгжсэн судалгааны тайланг тоймлон судалж, дүгнэлт хийжээ.*

***Түлхүүр үг*****:** *парадигм, нийгмийн ялгарал, давхраажил, дунд анги, нэг болон олон хэмжээст шалгуур үзүүлэлт*

***Abstract****: This article examines the theoretical and methodological changes in the study of social stratification in Mongolia and analyzes the paradigm shift and the factors influencing it. The author emphasizes the multidimensional and qualitative trends observed in modern research, noting that the theoretical and methodological basis of Mongolian social stratification has been based mainly on the positivist paradigm of social facts, and that quantitatively measurable criteria such as income, wealth and education have prevailed. The author analyzes the study of changes in the research paradigm in this area, and then points out that there is a pattern of combining positive quantitative indicators with interpretive qualitative paradigms. As part of his research, he reviewed the relevant literature and research reports using qualitative analysis methods.*

***Keywords:*** *paradigm, social discrimination, stratification, middle class, one and multidimensional criteria*

**Удиртгал: Парадигмыг ойлгох нь:**

Нийгмийн социаль бүтэц, давхраажлын судалгаа нь зөвхөн социологи төдийгүй нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухааны суурь асуудлын хувьд судлаачдын байнгын анхаарлын төвд оршсоор иржээ. Нийгмийн хөгжил өөрчлөлтийг даган энэ чиглэлийн судалгаа шинжилгээ ч хувьсан өөрчлөгдөж байгаа бөгөөд ялангуяа түүний онол арга зүй ч хувьссаар байна. Энэ утгаараа нийгмийн давхраажлын судалгааны парадигм хэрхэн өөрчлөгдөж байгааг авч үзэхийн өмнө “парадигм” хэмээх ойлголтыг товч авч үзье. Парадигм гэсэн ойлголтыг Америкийн эрдэмтэн Томас Самуэль Кун “Шинжлэх Ухааны

Хувьсгалуудын бүтэц” номдоо анхлан шинжлэх ухааны хөгжлийг тайлбарлах арга зүй болгон авч үзсэн бөгөөд “... шинжлэх ухааны хөгжил нь хуучин мэдлэг дээр шинэ мэдлэгийг аажмаар нэмэн хуримтлуулах замаар биш харин тэргүүлэх ач холбогдол бүхий мэдлэг төсөөллүүд үндсээрээ өөрчлөгдөн халагдах байдлаар буюу шинжлэх ухааны хувьсгалуудаар дамжин явагдана хэмээн үзсэн байна.[1] Тэр бээр “парадигм”, “шинжлэх ухааны нийгэмлэг”, “шинжлэх ухааны хувьсгал” гэсэн гурван ойлголтын тусламжтайгаар шинжлэх ухааны бүрэлдэн тогтох хөгжих үйл явцыг тайлбарлажээ.

Т.Куны үзсэнээр судлаач эрдэмтэд өөрсдийн итгэл үнэмшил, танин мэдэхүйн үнэт зүйлсээс хамааран хуваагдаж, олон тооны нийтлэгийг үүсгэдэг бөгөөд эл нийтлэгийг шинжлэх ухааны нийгэмлэг хэмээн нэрийдэх ба эл нийгэмлэг бүр ямар нэгэн парадигмыг баримтлан дагаж хүлээн зөвшөөрсөн байдаг гэжээ. Ийн үзэхдээ Т.Кун аль нэг шинжлэх ухааны гол субьект болох эрдэмтэд, судлаачдыг нэгэн цул нийтлэг хэмээн үздэг хандлагаас татгалзан үзэл бодлын олон урьгалч үзэлд суурилж, харилцан үйлдэл, харилцаагаар холбогдсон өвөрмөц бүтэц/нийгэмлэг мөн гэсэн санааг дэвшүүлжээ.

Парадигм бол шинжлэх ухааны нийгэмлэгийн гишүүдийг нэгтгэж буй зарчим, үнэт зүйлс болон уг парадигмыг хүлээн зөвшөөрсөн хүмүүсээс бүрддэг ажээ. Шинжлэх ухааны нийгэмлэг нь аливаа шинжлэх ухааны бүтцийг бүрдүүлэх бөгөөд эл бүтэц олон тооны түвшнийг агуулах аж. Жишээлбэл, байгалийн ухааны бүхий л судлаачид нэгэн глобал нийгэмлэгийг бүрдүүлэх ба дотроо физикчид, химичид гэх мэт нийгэмлэгүүдэд хуваагдахын сацуу тодорхой парадигмыг баримталж байгаагаар мөн хуваагдана гэж Т.Кун бичиж байлаа.

Нэгэнт олон тооны нийгэмлэг хийгээд баримталж байгаа өөр өөр парадигмууд байгаа хойно тэдний дунд өрсөлдөөн бий болох нь ойлгомжтой бөгөөд чухамхүү энэ өрсөлдөөн нь хөгжлийн түлхэгч хүч болох хувьсгалд хүргэдэг байна. Эл хувьсгалын онцлог бол нэг нь нөгөөгөө нухчин дарах, устгах зэрэг зорилгыг агуулдаггүйгээрээ нийгмийн хувьсгалаас ялгаатай бөгөөд зөвхөн академик эрх чөлөө, чөлөөт эрэл хайгуулын явцад нэг парадигмын онол аргазүйн давамгайллыг нөгөөгөөр халан солиход оршино.[2]

Тухайлсан шинжлэх ухааны эрдэмтдийн нийгэмлэгүүдийн танин мэдэхүй хийгээд практик хэрэглээний явцад бий болсон шинэ мэдлэг, технологийн амжилт дээрх өрсөлдөөний эцсийн үр дүнг тодорхойлох бөгөөд ялагдал хүлээсэн парадигм устан алга болохгүйгээр барахгүй дараа дараагийн өрсөлдөөнд оролцсон хэвээр, дахин давамгайлах магадлал ч хэвээр хадгалагдсаар байдаг аж.

Түүнчлэн Кун шинжлэх ухааны хувьсал гэсэн ойлголтоо мөн хоёр түвшинд авч үзжээ. Макро утгаараа Коперник, Ньютон, Дарвин болон Эйнштейн нарын нэртэй холбоотой томоохон хувьсгалуудыг, микро утгаараа аливаа нэгэн шинжлэх ухааны нийгэмлэгийн баримталж байсан горим журам үнэт зүйлсийн өөрчлөгдөх үйл явцыг илэрхийлж байгаа ажээ.

Ийнхүү Т.Кун шинжлэх ухааны хөгжлийг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

1. *Парадигмын өмнөх үе буюу статусгүй үе.* Энэ үе бол тухайн ухааны үүсэн бий болох эхэн үеийг хэлэх бөгөөд дотоод институцлэгдэх үйл явц өрнөж, судлагдахууны талаарх төсөөлөл, ойлголт ухагдахууны аппарат бүрэлдэн, онолууд үүсэн бий болох үе аж.
2. *Шинжлэх ухааны хөгжилд 1-р парадигмын дангаар ноёрхож буй хэвийн үе.*

1 *Kuhn.T.S (1970) The Structure of scientific revolutions. Chicago: Press of Chicago University*

2 *Кун.Т (1975) Структура научных революций. Москва: Прогресс.*

Эл үед шинжлэх ухааны дотоод институцлэгдэх үйл явц эрчимжин, улмаар ном сэтгүүлүүд хэвлэгдэн, сургалт судалгааны нэгжүүд үүсэх зэрэг гадаад институцчлэл эхлэнэ. Шинжлэх ухааны статус үндсэндээ хүлээн зөвшөөрөгдөж, шинжлэх ухаануудын тогтолцоонд өөрийн эзлэх байр суурийг баталгаажуулж, тодорхой онол үзэл баримтлал давамгайлахын сацуу өөр өөр онол сургаал үүсэх үйл явц нэгэнт эхэлсэн байна. Хөгжлийн энэ үеийн гол зорилго бол Куны тэмдэглэсэнчлэн “толгой эргүүлсэн” асуудал буюу тухайн шинжлэх ухаан судалгаа шинжилгээний тэргүүлэх чиглэлийг сонгох, цаашдын хөгжлийн чиг баримжааг тодорхойлоход чиглэсэн асуудлыг шийдвэрлэхэд оршдог аж. Шинжлэх ухааны хэвийн үеийг Кун “..:ач холбогдол бүхий баримт сэлтийг тодорхойлох, тэдгээрийг онолын үүднээс харьцуулан тайлбарлах, улмаар аль нэг онолыг боловсруулах үйл ажиллагаа явагдаж гүйцнэ..”□ хэмээн тодорхойлжээ.

3. *Уг парадигм ноёрхлоо алдаж алтернатив парадигмуудын хооронд өрсөлдөөн өрнөсөн хямралын үе буюу аномали байдал.* Шинжлэх ухааны танин мэдэхүйн хүрээнд төдийгүй практик хэрэглээнээс үүдэн гарч ирж байгаа шинэлэг асуудлыг томьёолон тавьж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг эрж хайх явцад шинэ онолууд бүрэлдэн улмаар уламжлалт парадигмтай өрсөлдөж эхлэнэ. Кун үзэхдээ үүсэж байгаа асуудлуудыг уламжлалт парадигм амжилттай шийдэж байгаа үед хямрал гарахгүй, харин ингэж чадахгүй болсон үед л хямралт байдал бий болох бөгөөд “үйлдвэрлэлд байдгийн нэгэн адил шинжлэх ухаан тоног төхөөрөмжөө солих хэрэгцээ үүсдэг байна.”□
4. *Парадигмууд, тэдгээрийг баримтлагч шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн өрсөлдөөний явцад аль нэгэн парадигм шалгаран гарах хувьсгалын үе.* Шинээр үүсэж байгаа асуудлыг уламжлалт парадигм өөрийн онол аргазүйн хүрээнд шийдэж чадахаа болих үеэс хямрал буй болж, улмаар шинэ парадигм руу шилжих шилжилт эхлэнэ. Шилжилтийн үед шинэ болон хуучин парадигмууд асуудлыг зэрэгцэн орших байдлаар шийдвэрлэсэн хэвээр байх боловч шийдвэрлэж байгаа тэдний арга барил огтхон ч давхацдаггүй аж. Шинэ парадигм хямралтай зэрэгцэн бий болдоггүй бөгөөд ихэвчлэн “хямралыг гүнзгийрэхээс өмнө, түүнийг хүлээн зөвшөөрч ухамсарлахаас өмнө үүссэн байдаг”□ байна. Түүнчлэн шинэ парадигм бол хуучны өнгөн засал хийсэн хувилбар биш бөгөөд зарчмын шинэ шийдэл, шинэ аргазүй, итгэл үнэмшлийг илэрхийлнэ.
5. *Ялан дийлсэн 2-р парадигм буюу хөгжлийн хэвийн үе.* Шинэ хуучин парадигмын өрсөлдөөн хувьсгалаар шийдэгдэх бөгөөд эл хувьсгал нь асуудлыг ойлгох шинэ төсөөлөл, шийдвэрлэх шинэ арга барил, шинэ итгэл үнэмшил зэрэг дэвшлийг авчирдаг байна. Шинэ парадигм бий болж хэсэг хугацаанд тухайн шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл байх бөгөөд аажмаар хямрал дахин нүүрлэж, улмаар дээрх байдлаар шийдвэрлэгдэх зэргээр тасралтгүй өрнөж байдаг байна.

**Парадигмыг хэрэглэхүй: Социологи олон парадигмт шинжлэх ухаан болох нь:**

Социологийг олон парадигмт шинжлэх ухаан мөн гэдэг дээр олонх эрдэмтэд санал нийлдэг бөгөөд энэ нь түүний судлагдахууны олон талт байдал, баялаг агуулгаас хамаардаг хэмээн үздэг. Харин ямар ямар парадигм байдаг, тэдгээрийн онцлог нь юу гэдэг дээр санал зөрөлдөх нь бий.[3]

Парадигмын тусламжтайгаар социологийн онолын хөгжлийг ангилан үзсэн

*3 Тэмдэглэл: Нэгэн үзэл суртал, намын ноёрхлын үед эл өрсөлдөөн улс төрийн өшөө авалт болж хувирдгийг*

ангиллыг АНУ-ын социологич Жорж Рицэр хийсэн нь эдүгээ зонхилох байр суурьтай болжээ. Тэрээр орчин үеийн социологийн онол үзэл баримтлалуудыг сонгодог төлөөлөгч хийгээд танин мэдэхүйн эх сурвалж, социологийн судлах зүйлд хандах хандлага, төсөөлөл, судалгааны аргууд болон тулгуур онолуудын ижил төсөөтэй байдал гэсэн үзүүлэлтийг ашиглан хувааж дараах гурван бие даасан парадигмыг санал болгосон байна.

Үүнд:

- Социаль баримт сэлтийн парадигм (The Social-Facts paradigm)

Социаль баримт сэлтийн парадигмын хувьд сонгодог төлөөлөгч нь Францын социологич Э.Дюрхэйм бөгөөд түүний “Социологийн аргын дүрмүүд” болон “Амиа хорлохуй” бүтээл эл парадигмын танин мэдэхүйн эх сурвалж болдог байна,

1. Энэ парадигмын гол төвлөрөл (focus) нь нийгмийн баримт бэлт буюу нийгмийн томоохон социаль институт, социаль бүтцүүд бөгөөд эдгээр баримт сэлт хүмүүсийн амьдрал хийгээд үзэл бодол, үйлдэлд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг гэж үзнэ,
2. Эл парадигмын хүрээнд ярилцлага- анкетын асуулга болон түүхэн харьцуулалтын аргууд түгээмэл хэрэглэгддэг бөгөөд юмс үзэгдлийг бидний ажиглалтад өртөж байгаа гадаад шинж тэмдэг дээр нь тулгуурлан дүрслэн зураглах нь түлхүү байна,
3. Бүтэц-функционализм болон зөрчилдөөний онол нь энэхүү парадигмын тулгуур онолуудыг бүрдүүлнэ. Түүнчлэн системийн үзэл баримтлал мөн харьяалагдана.

- Социаль дефиницийн парадигм (The Social-Definition paradigm)

Энэ парадигмын хувьд:

1. Германы социологич М.Вебер бол энэхүү парадигмын сонгодог төлөөлөгч нь бөгөөд түүний Ойлгож буй социологи болон нийгмийн үйлдлийн тухай бүтээлүүд нь мэдлэгийн эх сурвалж нь болно.
2. Социологийн судлагдахуун бол хүмүүсийн үйлдэл, харилцан үйлдэлд төвлөрөх ёстой бөгөөд тэдгээр агуулагдаж буй субьектив утга учир бол танин мэдэхүйн үндсэн асуудал юм гэсэн байр сууриас эл парадигм хандана,
3. Ярилцлага, анкет асуулгын зэрэгцээ ажиглалтын арга тус парадигмын судалгааны аргын үндсэн яс модыг бүрдүүлнэ,
4. Тулгуур онолын хувьд феноменологи социологи, символик интеракционизм болон этнометодологи хамаарна.

- Социаль зан үйлийн парадигм (The Social-Behavior paradigm). Нийгмийн зан үйлийн парадигмыг дээрх үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу авч үзвэл:

1. Сонгодог төлөөлөгч, эх сурвалжийн хувьд Б. Скиннер болон түүний бихевиорист чиглэлээр туурвисан бүтээлүүд орно,
2. Социологи нь хүний зан үйлд анхаарлаа хандуулах ёстой хэмээн үздэг бөгөөд урамшуулал хийгээд шийтгэл нь хүний аливаа зан үйл үйлдлийг урьдчилан нөхцөлдүүлдэг гэж үзнэ,
3. Эл парадигмын судалгааны үндсэн арга бол туршилтын арга бөгөөд,
4. Тулгуур онолуудын хувьд бихевиорист социологи, солилцооны онол болон

---

*хуучин ЗХУ-д байгалийн ухааны эрдэмтдийн дунд өрнөсөн үйл явц мөн харуулдаг.*

сүлжээний үзэл баримтлалууд орно.

Ж. Рицэрын үзсэнээр социологийн ухааны эрдэмтдийн нийгэмлэг өөрсдийн үнэт зүйлс, үзэл бодол, итгэл үнэмшилд суурилсан онол арга зүйн баримжааллын дагуу дээрх гурван парадигмд хуваагдаж, танин мэдэхүйн хүрээнд өрнөж буй мэдлэгийн өрсөлдөөнд оролцдог байна.

Дээрх парадигм бүр орчин үеийн нийгмийн онол үзэл баримтлалууд дээр суурилж, тэдний тусламжтайгаар социологийн ухааны онол хийгээд эмпирик эрэл хайгуул, судалгаа шинжилгээг удирдан явуулах арга зүйн үндэс нь болдог байна.

Орчин үеийн социологийн онол, эмпирик судалгааны орон зайд дээрх гурван парадигмууд зэрэгцэн оршиж байгаа бөгөөд дэлхийн улс орнуудын нийгмийн хөгжлийн обьектив хийгээд субьектив нөхцөл байдлаас хамааран аль нэг нь давамгайлах юм уу, зогсонги байдалд орох зэргээр Куны тодорхойлсон хувьсгал, өрсөлдөөний журмаар оршин тогтнож байна.

Эдгээр парадигмууд нь баримт сэлтийн тайлбарлалын тухайд харилцан адилгүй бөгөөд жишээ нь нийгмийн баримт сэлтийн парадигмын тулгуур онолууд юмс үзэгдлийг обьектив зүй тогтлын дагуу оршдог хэмээн үздэгийн хувьд дүрслэн зурагласан дескриптив тайлбарлалыг санал болгодог бол харин дефиницийн хийгээд зан үйлийн парадигм субьектив хүчин зүйлийг онцолсон интерпретив тайлбарлалыг голчилдог ажээ. Парадигмуудын эл онцлогоос үүдэн бид эмпирик судалгааг тоон буюу чанарын хэмээн ангилан үзэх боломжтой болж байгаа юм.

Нийгмийн давхраажлын судалгааны хувьд нийгмийн баримт сэлтийн парадигм нь 1.Шалгуур үзүүлэлтүүд нь эд хөрөнгө, боловсрол зэрэг тоон байдлаар хэмжигдэхүйц обьектив хүчин зүйл, хууль зүй тогтол байх ёстой, 2. Эдгээр шалгуур үзүүлэлтийг мөн асуумж, ажиглалт, туршилт зэрэг обьектив тоон аргаар судлах ёстой гэсэн зарчмыг баримталдаг байна.

Энэ утгаараа энэхүү парадигм нь позитивист чиг баримжааны хэмээн нэрлэгдэх боломжтой бөгөөд Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ 20 дугаар зууны турш чухамхүү энэ чиглэлээр хөгжиж ирснийг бид ном зүйн тоймоос харж болно. Мөн өмч, өмчийн харилцаа гэсэн дан ганц эдийн засгийн үзүүлэлтээр нийгмийн бүтцийн зураглалыг би болгодог тул бид “нэг хэмжээст” бүтэц гэсэн ангиллыг ижил утгатайгаар авч хэрэглэж байгаа болно.

Харин нийгмийн дефиницийн парадигм нь нийгмийн давхраажлын хувьд олон хэмжээст буюу өмч, эд хөрөнгийн зэрэгцээ эрх мэдэл, нэр хүнд, үзэл бодол зэрэг олон шалгуурыг санал болгодог бөгөөд 1. Нийгмийн үзэгдэл юмсыг дан ганц обьектив шалгуураар бус тоон хэмжилтэд үл өртөх субьектив хүчин зүйлийг харгалзан үзэх, 2. Энэ зүйлсийг судлахдаа юмс үзэгдлийн бидэнд үл ажиглагдах шинж чанарыг нээхэд чиглэсэн чанарын аргуудыг ашиглах ёстой хэмээн үздэг аж.

**Нэг хэмжээст болон олон хэмжээст нийгмийн давхраажил, тэдгээрийн суурь парадигмууд**

Нийгмийн социаль бүтэц, давхраажлын тухай социологийн судалгаа нь хөгжлийн явцдаа ихэвчлэн нийгмийн баримт сэлтийн парадигмын тулгуур онолууд болох бүтцийн, функциональ, системийн онол үзэл баримтлалын хүрээнд хэрэгжиж ирсэн байна. Үүний зэрэгцээ нийгмийн давхраажлын тогтолцоог хэмжин үзэж буй зарчим, үндсэн шалгуурууд, социаль ялгарлын хэтийн төлөвийн хандлагын талаарх үзэл бодлоор нь бүлэглэж нэг хэмжээст болон олон хэмжээст онол сургаалууд гэж бүлэглэж болох бөгөөд энд анх удаа позивист бус парадигмын нөлөө гарч үздэг

байна.

1. Нэгэн хэмжээст онол үзэл баримтлалд эдийн засгийн буюу өмч хөрөнгө гэсэн нэг багц шалгуур үзүүлэлтээр нийгмийн давхраажлыг тодорхойлж байгаа онол сургаалыг багтаан үзэж байгаа бол өмч хөрөнгийн байдал төдийгүй боловсрол, эрх мэдэл, албан тушаал, нийгмийн нэр хүнд зэрэг олон тооны шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлдог онол сургаалыг олон хэмжээст хэмээн тодорхойлно.

Нэгэн хэмжээст онол сургаалд голлон марксист болон позитивист чиглэлийн үзэл баримтлал орох бөгөөд үл гүйцэлдэх социалист үзэлтэн Т.Мор, Т.Компанелла, Ш.Фурье, Сен Симон нарын сургаалаас эхлэлээ авч, анхлан хүч үл хэрэглэн хөрөнгө мөнгөтэй ангийнхныг ойлгон ухааруулах замаар, нийгмийн тэгш бус байдлын эх үндэс болсон өмчөөс нь татгалзуулан хүн хүндээ нөхөр, анд бий болсон ангигүй тэгш шударга нийгмийг байгуулж болох юм гэсэн утга санаанд суурилан бий болжээ. Нэгэн хэмжээст онол сургаалд голлон марксист болон позитивист чиглэлийн үзэл баримтлал орох бөгөөд үл гүйцэлдэх социалист үзэлтэн Т.Мор, Т.Компанелла, Ш.Фурье, Сен Симон нарын сургаалаас эхлэлээ авч, анхлан хүч үл хэрэглэн хөрөнгө мөнгөтэй ангийнхныг ойлгон ухааруулах замаар, нийгмийн тэгш бус байдлын эх үндэс болсон өмчөөс нь татгалзуулан хүн хүндээ нөхөр, анд бий болсон ангигүй тэгш шударга нийгмийг байгуулж болох юм гэсэн утга санаанд суурилан бий болжээ.

Ангит нийгмээс ангигүй нийгэмд шилжих боломжтой гэсэн эл санаа К.Маркс, Ф.Энгельс нарын сургаалд тусгалаа олсон юм. К.Маркс, Ф.Энгельс нарын ангийн болон ангийн тэмцлийн тухай онолыг боловсруулан нийгмийн бүтцийг өөрсдийн нийгэм эдийн засгийн формацийн онол баримтлалтай холбон тайлбарлажээ. Тэд бүхий л нийгмийн түүхийг дарлагч баян, дарлагдагч ядуу гэсэн хоёр үндсэн ангийн тэмцлээр тайлбарлан хүн төрөлхтний хувьд ангигүй нийгэм зөвхөн туулж өнгөрүүлсэн үе, хүй нэгдлийн овгийн байгуулал биш бөгөөд ангийн тэмцлийн дунд пролетариуд хөрөнгөтнийг ялснаар ангигүй коммунист нийгэмд хүрч болно хэмээн номлож байв.

Ф.Энгельс К.Маркс нарын дээрх үзлийг В.И.Ленин үргэлжлүүлэн ангийг “Нийгмийн үйлдвэрлэлд эзлэх байр, нийгмийн хөдөлмөрийн зохион байгуулалтад гүйцэтгэх үүрэг, нийгмийн баялгаас хүртэх арга, хувь хэмжээ” гэсэн шинжүүдээр нь тодорхойлсон байдаг. Улмаар ангит нийгмээс ангигүй нийгэмд шилжих шилжилт нь пролетарийн диктатураар дамжин хэрэгжинэ гэж үзэж байв.

Марксизмын сонгодог төлөөлөгчдийн үзэл баримтлалын (түүний дотор нийгмийн ялгарал, түүний цаашдын чиг хандлагын тухай сургаалын) нөлөөн дор хуучин зөвлөлтийн болон социалист орнуудын нийгэм судлаач эрдэмтэд социаль бүтцийн асуудлыг авч үзэж судалсаар ирсэн билээ.

Эдгээр эрдэмтдийн дотроос хуучин ЗХУ-ын А.А.Амбрасов, С.Н.Надель, А.А.Галкин, К.И.Микульский, А.Н.Мельников, М.Н.Руткевич, В.С.Семёнов, Ю.Д.Квашнин. З.Т.Голенкова, Е.Д.Игитханян, Л.М.Романенко, М.Ф.Черкыш, И.Б.Артюхова, О.А.Афанасивна, А.Д.Вайсман болон Югослав, Польш Чехийн нэр бүхий эрдэмтэн судлаачдыг дурдаж болно.

Социаль бүтцийн позитивист парадигмыг баримталж асан эдгээр судлаачид нийгмийг ихэвчлэн эрх тэгш ажилчин, тариачин (Монголд бол малчин хэмээх хоёр анги ба нэг давхарга /хөдөлмөрийн сэхээтэн/) гэсэн гурамсан бүтэцтэй хэмээн үзэж тайлбарласан байдаг.

Дээрх судалгаа шинжилгээ социаль анги бүлэг давхрааны дифференцачлагдах шинж чанарт бага анхаарч, харин тэдний ялгаа арилах, улмаар нэгэн төрөлт нийгмийн тогтолцоонд шилжих тухай асуудалд голлон анхаарлаа хандуулж байсан

нь анги, бүлэг социализм коммунизмын үед мөхөн арилна хэмээдэг марксизмын сонгодог төлөөлөгчдийн онол баримтлалаас үүдэлтэй, түүний шууд нөлөөллийн үр дагавар байлаа.

Энэ чиглэлийн парадигмын төлөөлөгчид нийгмийн ялгарлын гол үндсийг өмч, өмчийн харилцаатай холбон авч үзэж нийгмийн нэгэн хэмжээст бүтцийг зураглан гаргасан байдгаараа нийтлэг юм.

Нийгмийн социаль бүтцийн олон хэмжээст онолын эх суурийг Немецийн социологич М.Вебер тавьсан гэх үндэслэлтэй бөгөөд эрх мэдлийг нийгмийн ялгарлын үндэс болгон үзсэнээрээ асуудалд хандах цоо шинэ хандлагыг бий болгосон билээ.

Түүний үзсэнээр нийгмийн дотор бий болсон анги, статусын бүлгүүд, страт бол мөн л эрх мэдлийн хуваарилалтын хүрээнд хамрагдах зүйлс ажээ. М.Вебер “анги”-ийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

“Анги бол хамтын нийгэмлэг биш юм. Ангиуд нь хамтын үйлдлийн бололцоот бааз суурийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл:

- Тэдний амьдралын боломж бололцоог хөндсөн өвөрмөц учир шалтгааны хүчин зүйлсээр нэгдсэн олон тооны хүмүүс,.
- Энэхүү учир шалтгааны хүчин зүйлс нь бараа таваар авах, орлого олох гэсэн эдийн засгийн ашиг сонирхлоор илэрхийлэгдэнэ.
- Энэ учир шалтгааны зүйл нь бараа таваарын болон хөдөлмөрийн зах зээл дэх нөхцөл байдлаар нөхцөлдсөн тохиолдолд л бид анги гэж ярих эрхтэй” хэмээн М.Вебер бичжээ.

Улмаар социологийн сонгодог төлөөлөгчидөөс П.Сорокин, Э.Дюркхайм[4], орчин үеийн өрнөдийн социологичдоос Т.Парсонс, Р.Мертон[5], К,Дэвис, Л.Уорнер, Б.Барбер, Ж.Бурдье[6] нарын судалгаа шинжилгээ нийгмийн давхраажлын олон хэмжээст, позитивист бус онол парадигмыг бүрэлдэн тогтоход чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Олон хэмжээст парадигмын гол төлөөлөгчид нь нийгмийн ялгарлыг дан ганц эдийн засгийн үзүүлэлт төдийгүй ажил мэргэжил, боловсрол, эрх мэдэл, албан тушаал гэх зэрэг социаль шинжүүдийн тусламжтайгаар хэмжиж олон хэмжээст нийгмийн бүтцийг тодорхойлдгоороо нийтлэг ажээ. Ер нь энэ онолын төлөөлөгчид нийгмийн бүтцийн элементүүдийн ахуйн, үзэл бодол, үнэт зүйлсийн салбар дахь ялгарлыг сайтар судлан боловсруулсан болох нь харагддаг.

**Монголын нийгмийн давхраажлын судлагдсан байдлын тойм:**

Монголд социологи үүссэн бий болсон цагаас нийгмийн анги, давхаргын судалгааг хэрэгжүүлж ирсэн бөгөөд дээр дурдсанчлан найрамдалт харилцаат Малчин, Ажилчин анги, Сэхээтэн гэсэн давхарга гэсэн бүтцийн хүрээнд судалж иржээ. Эдгээр судалгаанд давхраа, давхраажил гэсэн ойлголт хэрэглэдэггүй байсан агаад анги, давхарга, нийгмийн бүтэц гэсэн нэр томьёонууд нь ойлголт ухагдахууны аппаратын гол цөмийг бүрдүүлж байлаа.

Нийгмийн бүтэц төдийгүй Монгол дахь социологийн шинжлэх ухааны хөгжилд 1970 –аад оны эхээр МУИС дээр байгуулагдсан социологийн сектор чухал үүрэг

*4 Кун.Т (1975) Структура научных революций. Москва: Прогресс. Стр 55*
*5 Мөн тэнд Стр 105*
*6 Мөн тэнд Стр 117*

гүйцэтгэсэн болохыг судлаачид тэмдэглэдэг[7] бөгөөд улмаар ШУА-ын Философи, Социологи, Эрхийн хүрээлэнд социологийн сектор үйл ажиллагаагаа эхэлсэн нь дээрх хөгжилд түлхэц болжээ.

1974 оноос "Монголын ажилчин ангийн нийгмийн бүтэц, хөдөлмөр, соёл ахуй" гэсэн суурь судалгаа анх эхэлсэн бөгөөд ажилчдын хөдөлмөрийн нөхцөл, норм, төлөвлөгөө, цалин хөлс, чөлөөт цаг, гэр бүлийн харилцаа зэрэг сэдвүүдэд анхаарал хандуулжээ. Улмаар "БНМАУ-ын нийгмийн бүтэц" гэсэн сэдэвт ажлын хүрээнд ажилчин, малчин ангийг судлахдаа а. Нийгмийн бүтэц, б. Хөдөлмөрт хандах хандлага, в. Соёл, г.Чөлөөт цаг, д.Ухамсар, сүсэг бишрэл гэсэн чиглэлээр судалжээ.[8]

Судлаач Х.Гүндсамбуугийн "Залуу малчдын нийгмийн төрх" гэсэн бүтээл гарсан нь нийгмийн гишүүдийг дээр дурдсан чиглэлийн хүрээнд насны үзүүлэлтээр түүвэрлэн шинжилсэн байна. Улмаар сэхээтэн гэсэн нийгмийн бүлгийн судалгааны дүнд "Өнөөгийн сэхээтний нийгмийн төрх" хамтын бүтээл 1987 онд хэвлэгджээ. Сэхээтэн бол соёл, урлаг, эрүүл мэнд гэх зэрэг салбаруудаар мэргэжилтэн, албан хаагч гэсэн оюуны хөдөлмөр эрхэлдэг нийгмийн бүлэг гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Онцлон дурдахад боловсрол, эрхэлж буй ажил гэсэн шалгуур гол үзүүлэлт байлаа.

Дээр дурдсан судалгааны мэдээлэл цуглуулах арга нь голлон асуулгын буюу анкет/асуумж зэрэг тоон шинжтэй аргууд давамгайлж байлаа.

Нийгмийн бүтцийн сэхээтэн хэмээх давхаргын судалгаа тэр үед мөн хийгдэж байлаа. Эдгээр судалгаа шинжилгээ а. Түүхийн чиглэлээр, б. Социологийн чиглэлээр голлон өрнөжээ. Тухайлбал *түүхийн* **(Б.Лигүү,** Ч.Дашдаваа, Ц.Готов, Д.Өлзийсайхан[9],), *социологийн,* (В.Отгоннасан, **Ц. Уртнасан**[10]**, Ч.Дашдаваа, Н.Хавх,** Х.Гүндсамбуу[11], С.Гомбо, Ц.Пүрэв[12], Р.Вандангомбо) эрдэмтэн судлаачдыг энд дурдаж болно.

1990-ээд оны эхэн үеэс Монгол дахь нийгмийн бүтцийн судалгаа нь онол арга зүйн хувьд өрнөдийн социологийн онол, парадигмуудыг ашиглаж, олон хэмжээст нийгмийн давхраажлын тогтолцоог зураглахад чиглэж эхлэв.

1992 онд Шинжлэх ухааны Академийн Философи Социологийн хүрээлэнгээс явуулсан "Нийгмийн бүтцийн өнөөгийн төлөв хандлага"[13] сэдэвт социологийн судалгаа нь нийгмийн нэг тогтолцооноос нөгөө шилжих шилжилтийн үед Монголын нийгмийн бүтцэд гарч буй өөрчлөлтийн төлөв байдал, цаашдын чиг хандлагын тандсан ач холбогдолтой судалгаа байлаа.

Улмаар 2000 оны үеэс нийгмийн давхраажлын чиглэлээрх судалгаанд орчин үеийн Монголын нийгмийн давхраажил, түүнийг бүрдүүлэгч нийгмийн анги давхрааны асуудлаар Х.Гүндсамбуу, Ц.Уртнасан[14], Ц.Пүрэв[15] нийгмийн давхраажлын тогтолцооны онол арга зүй, шалгуур үзүүлэлтийг судалсан О.Мөнхбат[16] нар ном бүтээлдээ нийгмийн давхраажил, түүний олон хэмжээс шалгуур үзүүлэлтийн асуудлыг хөндөн судалжээ.

---

*7 Ц.Уртнасан (2017) "Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ" УБ: Соёмбо принтинг ХХК*
*8 Мөн тэнд, 12 дугаар тал*
*9 Д.Өлзийсайхан (2004) Ардчилал: сэхээтний нийгмийн төлөв. УБ., 82 дугаар тал*
*10 Ц.Уртнасан (2017) Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ. УБ: Соёмбо принтинг ХХК*
*11 Х.Гүндсамбуу (2002). Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага (XX зуун). УБ:Хэвлэх үйлдвэр*
*12 Ц.Пүрэв (2013) Монголын нийгмийг социологиор шинжлэхүй. УБ: АМЖА Принтинг*
*13 ШУА, Философи, социологи, эрхийн хүрээлэн (1993) Нийгмийн бүтцийн өнөөгийн төлөв хандлага*
*14 Ц.Уртнасан (2017) . Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ. УБ: Соёмбо принтинг ХХК*
*15 Ц.Пүрэв (2013) Монголын нийгмийг социологиор шинжлэхүй. УБ: АМЖА Принтинг*
*16 О.Мөнхбат (2000) Социаль бүтцийн социологи. УБ: МУИС-ийн Хэвлэх үйлдвэр*

Энэ үеийн судалгаа нь

**а.** Шинэ онол арга зүйн эрэл хайгуул буюу уламжлалт позивист марксист хандлагыг өрнөдийн онол парадигмтай хослуулан хэрэглэх,

**б.** Шинэ арга зүйн үүднээс Монголын нийгмийн давхраажлыг судлах буюу эмпирик байдлаар судлах гэсэн шинжтэй байснаараа онцлог байв.

Мөн ийм хандлага бүхий судалгааны тоонд нийгмийн давхраажил, нийгмийн социаль бүтэц, дунд ангийн асуудлаар МУИС-ийн Социологийн тэнхимээс эрхлэн хэрэгжүүлж, Монгол Улсын ШУБЯ санхүүжүүлсэн “Монголын нийгмийн давхраажилт, төлөв байдал, чиг хандлага” 1993-1998 онд хэрэгжсэн суурь судалгаа /түүвэр 3000 хүн/ болон Монгол Улс, Гэгээрлийн Яамны захиалгаар тус тэнхимээс хэрэгжүүлсэн “Монголын нийгмийн дотоод ялгарал” 1998-2000 он /түүвэр 1500 хүн/[17] зэрэг судалгааг дурдаж болно. Эдгээр судалгаа нь 1990 оноос Монголын нийгэмд өрнөсөн нийгэм, улс төр, эдийн засгийн асар өөрчлөлтийн нөлөөн дор шинээр бүрэлдэн үүсэж байгаа Монголын нийгмийн давхраажил, түүний тулгуур анги давхраа, бүлгүүдийг судалсан суурь судалгааны төсөл байлаа. Эдгээр төслийн хүрээнд Монголын нийгмийн давхраажлын шалгуур үзүүлэлтийг Эд баялаг ба орлого, Боловсрол, Мэргэжил, Албан тушаал ба эрх мэдэл гэсэн 4 гол шалгуур үзүүлэлтээр тодорхойлно гэж үзжээ.[18]

2012 оноос МУИС-ийн Социологи нийгмийн ажлын тэнхим, МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэнгээс хамтран “21-р зууны Монголын нийгмийн харилцааны өөрчлөлт, цаашдын төлөв хандлага” суурь судалгааг 6 жилийн турш хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ төслийн хүрээнд хүн амын амьжиргааны түвшин, орлого болон хэрэглээний харьцаа, иргэдийн нийгмийн давхраажлын талаарх төсөөлөл зэрэг асуудлыг судалж ирсэн байна.

Мөн судлаач М.Батбаатар Монгол дахь орлогын давхраажлын асуудал[19] илтгэл хэлэлцүүлсэн нь давхраажлын нэг шалгуур үзүүлэлтийн дүр зургийг гаргах оролдлогын нэг байлаа.

Эдгээр судалгаанууд нь ядуурал, нийгмийн анги давхрааны асуудлыг нийгмийн баримт сэлтийн парадигм буюу позитивизмын нөлөөн дор хийгдсэн хэдий ч олон хэмжээст шалгуур үзүүлэлтүүд ялангуяа эрх мэдэл, нэр хүнд зэрэг чанарын хүчин зүйлсийг Монголын нийгмийн давхраажлын судалгаанд оруулж байгаагаараа онцлог юм.

Нийгмийн давхраажил, ялгарлын асуудлаар судалгаа шинжилгээ хийдэг төрийн байгууллагуудаас Үндэсний статистикийн хороог (ҮСХ) онцлон дурдах хэрэгтэй юм. Энэ байгууллагаас хэрэгжүүлдэг ядуурлын судалгаа нь Монголын нийгмийн давхраажлын шинжилгээнд чухал байр эзэлдэг. ҮСХ-ноос хүн амын хэрэглээний мэдээллийг цуглуулж амьжиргааны түвшин, ядуурлын үзүүлэлтийг тооцох боломжтой өрхөд суурилсан “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” (ӨНЭЗС)-г Дэлхийн банкны техникийн дэмжлэгтэй явуулдаг. Энэ судалгаа нь тус хорооноос урьд өмнө зохион байгуулж байсан түүвэр судалгаануудын (“Монгол Улсын хүн амын амьжиргааны түвшний үнэлгээ” 1995 он, “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа” 1998 он, “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа” 2002-2003 он) үргэлжлэл бөгөөд 1966 оноос эхлэн тасралтгүй явагдаж

*17 О.Мөнхбат (2000) Социаль бүтцийн социологи. УБ: МУИС-ийн Хэвлэх үйлдвэр*

*18 Мөн тэнд*

*19 М.Батбаатар (2017) Монгол дахь орлогын давхраажил: нийгэм хүн амзүйн зарим асуудал. “Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ” симпозиумын эмхэтгэл. УБ*

байгаа "Өрхийн орлого, зарлагын судалгаа"-тай бүрэн хэмжээгээр нэгтгэгдэж, жил бүр тогтмол явагдаж байна.[20]

Арга зүйн хувьд ядуурлыг хувь хүний аж байдлын доройтол, гачигдалтай байдал, эрүүл мэнд, боловсрол, оюуны болон биеийн чадавх доройтох, хоол тэжээлийн гачигдал, бараа үйлчилгээний дутагдалд орох, дэд бүтцийн үйлчилгээнүүдийн хүртээмж хязгаарлагдмал байх, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар хангалтгүй зэрэг олон хэмжээст бүрдэл хэсгүүдээр хэмжихийг эрмэлзсэн байна.[21]

Төрийн бодлогын баримт бичгүүдэд дунд давхраag өргөжүүлэх стратегийн зорилт дэвшүүлсэнтэй холбоотой шинжлэх ухааны зарим байгууллагууд дунд ангийн шинжтэй судалгааг хийж эхэлж байна. Энд, тухайлбал, 2017 онд Удирдлагын академийн судлаачдын хийсэн "Нийгмийн дунд давхрааны төлөв байдал: Улаанбаатар хотын өрхийн судалгаа".[22] Түүнчлэн З.Манлайбаатар, Б.Цэндсүрэн нарын "Монголын дундаж давхаргын судалгаа[23] зэргийг мөн дурдууштай.

Удирдлагын академийн судлаачдын ашигласан нийгмийн дунд давхраag хэмжих хувьсагч нь олон хэмжээст шинжтэй бөгөөд

а. Хүн ам зүйн

б. Эдийн засгийн төлөв

в. Амьдралын хэв маяг

г. Амьдралын үнэлгээ зэрэг үзүүлэлтүүдийг хэрэглэсэн байна.

Дээр дурдсан бүхий л судалгаа шинжилгээний анхдагч мэдээлэл цуглуулах арга нь ихэвчлэн асуумж, статистик баримт сэлтийн шинжилгээ зэрэг тоон судалгааны аргууд зонхилж байлаа.

**Товч дүгнэхүй**

- Монголын нийгмийн давхраажлын судалгаанд позитивист хандлага буюу нийгмийн барим сэлтийн парадигм, түүний тулгуур онолууд хүчтэй нөлөөлсөөр иржээ.
- 1990 оноос өмнөх нийгмийн бүтцийн судалгаа нь нэгэн хэмжээст буюу эдийн засаг, боловсрол гэсэн тоон үзүүлэлт бүхий шалгуур үзүүлэлтүүдэд голлон түшиглэж ирсэн бөгөөд арга зүйн хувьд ангийн ялгарал устан үгүй болно гэсэн Марксист үзэл баримтлал дээр хөгжиж ирсэн байна.
- 1990-ээд оноос хойших нийгмийн давхраажлын судалгаа нь олон хэмжээст шалгуур үзүүлэлтийг эрхэмлэх хандлагатай болж эрх мэдэл, нэр хүнд зэрэг тоон байдлаар шууд эс хэмжигдэх чанарын шинжилгээ рүү шилжиж эхэлсэн хэдий ч өнөөг хүртэл орлого, эд баялаг зэрэг үзүүлэлтийг түгээмэл хэрэглэсээр байна.
- Энэ утгаараа нийгмийн давхраажлын судалгаа шинжилгээнд чанарын үзүүлэлтүүд нэвтрэх болсон нь позитивист хандлага бүхий баримт сэлтийн болон зан үйлийн парадигмын зэрэгцээ феноменологи хандлага бүхий нийгмийн дефиницийн парадигм зэрэгцэн орших болсныг гэрчилж байна.

*20 Үндэсний статистикийн хороо (2020) Ядуурлын дүр төрх. Улаанбаатар. http://www.nso.mn*

*21 Мөн тэнд*

*22 Б.Нарантунгалаг болон бусад (2017) Нийгмийн дунд давхрааны төлөв байдал: Улаанбаатар хотын өрхийн судалгаа. УБ: Мөнхийн үсэг ХХК*

*23 З.Манлайбаатар, Б.Цэндсүрэн (2016) Монголын дундаж давхрагын судалгаа. Улаанбаатар*

- Улмаар нийгмийн давхраажлын судалгаанд позитивист хийгээд феноменологи хандлага хэрэглэгдсэнээр давхраажлын шалгуур үзүүлэлтийг дан ганц тоон хэмжилтийн байдлаар шалгаж болох үзүүлэлтээс гадна мөн респондентын зан үйлд агуулагдаж буй субьектив утга учир, ач холбогдлыг илрүүлж чадахуйц чанарын үзүүлэлтийг хөгжүүлэх шаардлага тулгамдсан асуудал болж байна.

**Ном зүй**


1. Гүндсамбуу, Х. (2002) Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага (XX зуун).
2. Манлайбаатар, Ц., Цэндсүрэн, Ц. (2016) Монголын дундаж давхаргын судалгаа.
3. Мөнхбат, О. (2008) Социологийн онол. УБ: UB принтинг
4. Мөнхбат, О. (2005) М.Веберын социологийн үзэл баримтлал. Социологи сэтгүүл №5.
5. Нарантунгалаг, Б. болон бусад (2017) Нийгмийн дунд давхрааны төлөв байдал, Улаанбаатар.
6. Өлзийсайхан, Д. (2004) Ардчилал: сэхээтний нийгмийн төлөв. УБ.
7. Уртнасан, Ц. (2017) “Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ” УБ: Соёмбо принтинг ХХК
8. Уртнасан, Ц. (2017) Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ. УБ: Соёмбо принтинг ХХК
9. Пүрэв, Х. (2013) Монголын нийгмийг социологиор шинжлэхүй. УБ: АМЖА Принтинг

***Англи хэл дээр***

1. Kuhn, T. S. (1970) The Structure of scientific revolutions. Chicago: Press of Chicago University.
2. Merton, R. K. (1967) On theoretical sociology. Five essays, old and new. Toronto: The Free Press
3. Merton, R. K. (1957) Social theory and Social structure. Illinois: The Free Press
4. Parsons, T. (1966) Societies: Evolutionary and comparatives. Englewood: Prentice-Hall. Parsons, T. (1936) Structure of social action. N.Y: McGraw-Hill
5. Parsons, T. (1953) “Working papers in the theory of action”. Free Press.
6. Ritzer, G. (1996) Sociological Theory. The McGraw- Hill Companies, Inc.
7. Ritzer, G. (1996) Sociological theory. The McGraw- Hill Companies, Inc.

***Орос хэл дээр***

1. Кун, Т. (1975) Структура научных революций. Москва: Прогресс.
2. Володина, А. И. (1982) Утопический социализм. М: Наука
3. Маркс, К. (1962) Капитал. М: Наука
4. Маркс, К., Энгельс, Ф. Восемьнадцать бромере Л.Бонапарта. Т-4
5. Ленин, В. И. Великий почин. ПСС, Т-39
6. Амбросов, А. А. (1978) От классовой дифференциации к социальной

однородности общества. М: Прогресс
7. Вебер, М. (1990) Избранные Произведения. Пер. с нем. М.: Прогресс.
8. Вебер, М. (1994) Основные понятия стратификации, Социологичиеские исследования, №5
9. Дюркгейм, Э. (1990) О разделении общественного труда. Метод социологии Пер.с фр.-М., Наука
10. Парсонс, Т (1965) Уровни организации социальной структуры. В кн: “Социология сегодня” перевод с англ. М.
11. Бурдье, П. (1993) Социология политики. Пер с фр. М: Наука

# МОНГОЛЫН НИЙГМИЙН ФИЛОСОФИЙН СУДАЛГААГ ТОЙМЛОСОН НЬ

Ц.Нямсүрэн[1], доктор (PhD)
М.Отгонбаяр[1], доктор (PhD)
Б.Дагзмаа[1] доктор (PhD)
*МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим*

***Товч утга:*** *Энэхүү судалгаагаар 1990 оноос хойших Монголын нийгмийн философийн судалгаан дахь зорилго, зорилт, онол, арга зүйн хандлага, судалгааны ерөнхий агуулгыг нэгтгэн харуулахыг зорилоо. Ингэхдээ Монгол дахь нийгмийн философийн онцлог шинжийг тодорхойлох, онол арга зүйн хандлагыг багцлан тоймлох, үндсэн сэдэв, агуулгыг ангилан харуулах зорилт дэвшүүлэв. Судалгааны хүрээг философийн салбарт хийгдсэн, нийгмийн философитой холбоотой, 1990 оноос хойших докторын ажил болон тус талбарт шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан судлаачдын нэгэн сэдэвт бүтээлээр хязгаарлав. Загвар, аргын тухайд харьцуулсан судалгааны загвараар баримтын шинжилгээний фремвок анализын аргыг ашиглан гүйцэтгэлээ.*

***Түлхүүр үг:*** *нийгмийн философи, фремвок анализ, нийгмийн философийн агуулга, арга зүй*

***Abstract:*** *In this article, we aimed to summarize and review the goals, objectives, theoretical and methodological trends, and overall contents of researches conducted in the social philosophy field in Mongolia since the 1990s. The scope of our study was limited by doctoral dissertations and monographs referred to the social philosophy in the given periods. The authors applied a comparative study design and used the framework method. Our results indicated that the social philosophy boundaries were somewhat unclear, the method and methodology section of any studies in this field were tricky, and most of the contents of dissertations and monographs was devoted to all disciplines within practical philosophy.*

***Keywords:*** *social philosophy, framework analysis, contents of social philosophy, methodology*

Судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг нийгмийн философи, нийгмийн тухай философи, нийгмийн гүн ухаан, монголын нийгэм, монголын нийгмийн хөгжил гэсэн түлхүүр үгсээр шүүж, 1997-2018 оны хооронд бичиж хамгаалсан 7 докторын дипломын ажил, 1997-2017 оны хооронд хэвлүүлсэн нэгэн сэдэвт 13 зохиол илрүүлснээс судалгааны хүрээ, шалгуурт нийцүүлэн 16 бүтээлийн зохих хэсгийг электрон хэлбэрт хөрвүүлэв.

Хэрэглэгдэхүүнийг электрон хэлбэрт хөрвүүлсний дараа өгөгдлийн сангийн бусад хэсэгтэй харьцуулан харах боломжтой байх үүднээс тэдний агуулгыг ангилан кодолж бүлэглэсэн юм. Ингэхдээ зохиогч, бүтээлийн нэр, арга зүй, зорилго, зорилт гэсэн нийтлэг үзүүлэлтээр кодлохоос гадна анализын явцад хоорондоо холбоотой

ойлголт, санаануудыг багцлан зангидах үүднээс Германы философич Д.Хорстерийн тодорхойлсончлон (Horster, 2005) салбар философийн асуудал; тодорхойлон тоочигч социологийн эсрэг хандлага; цаг үеийнхээ оношийг тайлбарлах үйл ажиллагаа; улс төрийн философи; нийгмийн эмгэг зүйн асуудал; философийн онол, нийгмийн практик шинжлэх ухаан хоорондын харилцаа; хувь хүн, нийгэм хоорондын харилцаа




**Зураг 1. Хэрэглэгдэхүүнийг хөрвүүлсний дараах байдал**

гэсэн үндсэн долоон категорийг дедуктив маягаар урьдчилан тодорхойлж аналитик фремвокоо боловсрууллаа.

**Хүснэгт 1. Үүсгэсэн зангилаа сэдэв, түүний товч тодорхойлолт**

| Зангилаа сэдэв | Тодорхойлолт |
|---|---|
| Хувь хүн, нийгэм хоорондын харилцаа | Нийгэм, хүн хоорондын харилцаа, үүнээс үүдэх асуудлыг хэлэлцсэн байх |
| Философи, нийгмийн тодорхой шинжлэх ухаан хоорондын харилцаа | Философийн онолын асуулт, таамаглалын хариуг нийгмийн шинжлэх ухааны судалгаагаар дамжуулж хайх, судлах |
| Улс төрийн философи | Зүй ёс, тэгш байдал, улс төрийн институт, хууль ёсны шинж гэх мэтийн талаар түлхүү хэлэлцсэн байх |
| Техно иргэншлийн асуудал | Техник, технологийн дэвшилтэй холбоотойгоор нийгмийн асуудал, нийгмийн харилцааг авч үзсэн байх |
| Салбар философийн асуудал | Эдийн засаг, соёл, түүх, заншил, ёс зүй, шашин, боловсрол, гэр бүл, хувь хүн, оюун санааны амьдрал, хүний хөгжил, нийгмийн хөгжлийн зүй тогтол гэх мэт салбар философийн талбарт хамаарах сэдвийг хэлэлцсэн байх |
| Оношилж тайлбарлах үйл ажиллагаа | Цаг үедээ онош тавьж, тайлбарласан агуулгатай байх |
| Нийгмийн эмгэг зүй | Буруу хөгжил, эмх замбараагүй байдал буюу “нийгмийн эмгэг судлал” гэж үзэж болох нийгмийн хөгжлийн үйл явцыг тодорхойлон хэлэлцэхэд голлон анхаарсан байх |
| Дескриптив социологийн эсрэг утга | Дескриптив социологиос ялгаатай, хэм хэмжээг заавварласан агуулгатай байх |

Судалгааны хэрэглэгдэхүүнийг хоёр бүлэгт багцлан фремвок матриц үүсгэн, үр дүнг тайлбарлав. Эдгээр алхмыг фремвок анализийн процедурын (Gale, Heath,

Cameron, Rashid, & Redwood, 2013) дагуу хийж гүйцэтгэлээ. Нэгтгэсэн өгөгдлийг боловсруулахдаа НВиво 11 Плас (NVivo 11 Plus) программыг ашиглав.

**Удиртгал**

Нийгмийн үзэгдэл, үйл явцыг түүхийн материализмын үүднээс л шүүн шинжилдэг хандлагыг өөрчлөх хэрэгцээ 1990 оны үйл явдлаар нөхцөлдөж, үүнээс тав орчим жилийн дараа нийгмийн философийн бусад чиглэлийн үзэл баримтлалыг тусгасан анхны бүтээл, судалгааны үр дүнгүүд хэвлэгдэж эхэлжээ. Нийгмийг судлахдаа түүх, улс төр, эдийн засаг, социологи, хүн ам зүй, ёс зүй, гоо зүй, эрх зүй гэх мэт олон салбарын үүднээс тал бүрээс нь судалж болно. Эдгээр салбар ухаантай нягт холбоотой хэдий ч нийгмийн философи бол нийгмийг бүхлээр нь, бүрэлдэхүүн бүх хэсгийн харилцан хамаарлын нэгдмэл тогтолцоонд нь судлахыг зорьдог онцлогтой. Гэвч нийгмийн философи өнөөдөр тодорхой бус хил хязгаар бүхий салбар (Petersen, 2012) болжээ. Түүнд нийгмийг судалдаг философийн бүрэлдэхүүн гэдгээс эхлээд нийгмийн тогтолцооны бүтэц, функц, нийгмийн нэгдэл, дэвшил, өөрчлөлт, задралд нөлөөлөгч хүчин зүйлсийг танин мэдэгч, нийгмийн гэмт хэрэг, хүүхдийн хөдөлмөр, хүйсийн ялгавартай байдал, шударга бус, тэгш бус байдал зэрэг нийгмийн эмгэг зүйн шалтгааныг олж илрүүлэгч арга ажиллагаа, шинжлэх ухаан, технологийн хүний нийгэмд үзүүлж буй нөлөөллийг тусган эргэцүүлэгч, нийтлэг сайн сайхан, аз жаргал, энх тайван, аюулгүй байдал, шударга ёс, эрх чөлөө зэрэг нийгмийн үнэт зүйлийг тодорхойлогч, шашин шүтлэг, гэр бүл, гэрлэлт зэрэг нийгмийн уламжлалт институцүүдийг шүүн шинжлэгч салбар ухаан гэх хүртэл олон янзын утга агуулагдаж байна. Судлагдахууны хил хязгаарын тодорхой бус байдал монголын нийгмийн философийн талбар ч мөн адил илэрч байна.

**Формациас деформаци хүртэл**

Монголын нийгмийг философийн үүднээс судалсан бүтээлүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг хураангуйлан авч үзвэл дараах маягтай байна. Үүнд, нийгмийн бүрэлдэхүүн хэсгийн хөгжих, оршин тогтнох зүй тогтлыг тайлбарлах (Хавх, 1997), нүүдэлчдийн нийгмийг задлан шинжлэх (Гантөмөр, 1997), нүүдлийн ба суурин соёл иргэншлийн харилцан нөлөөллийн үүднээс Монголын нийгмийг авч үзэх (Ганхуяг, 1998), Монголд нээлттэй нийгмийн санаа тогтносон үйл явц (Лхам, 1999), XX зууны монголын нийгмийн оюун санааны амьдралд гарсан өөрчлөлтийг судлах (Эрдэнэтунгалаг, 1999), нийгмийн тухай философид интеграль чиглэлийн онол, арга зүйн зарим асуудлыг боловсруулах (Гомбосүрэн, 1999), иргэншлийн болон формацийн онолын уулзвар зааг дээр монголын нийгэм, иргэншлийн бодит байдлыг задлан шинжлэх (Чулуунбаатар, 1999), Монголын бодит байдал, цаашдын хандлагыг үнэлэхэд чухал арга зүйн тохиромжтой үндэслэл боловсруулах (Эрдэнэбаяр, 2000), Монголын нийгмийн гүн ухаан нь өөрийн гэсэн түгээмэл арга зүйтэй гэдгийг харуулах (Хавх, 2000), аж үйлдвэржсэний дараах нийгмийн баримтлал нийгмийн практикт хэрхэн холбогдож буйг судлах (Батбаяр, 2013) орчин үеийн глобаль асуудлуудыг гуманизмын байр сууринаас шийдвэрлэхэд нийгмийн хөгжлийн эрч хүчийг алдагдуулж буй деформацийн механизмын үйлчлэлийг тодорхойлох (Ганболд, 2013), Монголын хөгжлийн бодлогын философийг боловсруулахад хувь нэмэр оруулах (Даш-Ёндон, 2014), иргэний нийгмийн төлөвшил, хөгжлийн төлөв байдал, ололт амжилт, туршлага, сургамжийг нэгтгэн шинжлэх (ФСЭХ, 2014), Монголыг хөгжүүлэх бодлогын нэгдсэн онол-философи гэж байх ёстойг үндэслэх (Даш-Ёндон, 2017), Монгол нийгмийг философийн үүднээс судлах (Дашпүрэв, 2017) зэрэг зорилго, зорилтыг дэвшүүлжээ.

Эдгээр нь хөгжлийн зүй тогтлыг тайлбарлах гэдгээс эхлээд формаци,

иргэншлийн онолын үүднээс монголын нийгмийг судлах, нээлттэй нийгэм, иргэний нийгмийн төлөвшил, хөгжлийг шинжлэх, нийгмийн судалгаа, хөгжлийн онол, арга зүй боловсруулах, нийгмийн зарим үзэл баримтлалын практик илрэлийг мөшгөх, нийгмийн хөгжлийг алдагдуулдаг деформацийг тодорхойлох, монголын нийгмийн хөгжлийн бодлогын философи боловсруулах хүртэл өргөн хүрээг хамарч байна.

Үүнийг цааш нь нарийвчилж үзвэл нийгмийн улс төрийн байгуулал, нийгмийн ухамсар, түүнээс гадна мөн түүхэнд ард олон, суут хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, нийгмийн хийгээд соёл иргэншлийн хувьсгал зэргийг авч үзэх (Хавх, 1997), орчин үеийн нийгмийн шинжилгээний шинэ арга зүй, ялангуяа соёл иргэншлийн болон формацийн хандлагаар нийгмийг шинжилж, ардчилсан өөрчлөлтийг гүнзгийрүүлэх явцад хөгжлийн зохистой хувилбарыг олоход тус дөхөм болох зарим асуудлыг нийгэм гүн ухааны үүднээс судлах (Гантөмөр, 1997), нийгэм, түүхийн философи сургаалыг боловсруулсан арга зарчмын тоймлох, нүүдлийн ба суурин соёл иргэншлийн харилцаа холбоог судлан тодорхойлох (Ганхуяг, 1998), нээлттэй нийгмийн санаа үүссэн логикийг илрүүлэх, нээлттэй ба хаалттай нийгмийн үндсэн шинжүүдийг харьцуулах (Лхам, 1999), нийгмийн тухай философид харьцангуй бие даасан интеграль хувилбарын эхлэлийг тавих (Гомбосүрэн, 1999), нийгмийн буюу иргэншлийн хөгжлийн хэлбэр, тодорхойлогч хүчийг авч үздэг XIX-XX зууны зарим сонгодог онолын баримтлалыг харьцуулан шинжлэх (Эрдэнэбаяр, 2000), орчин үеийн судалгааны эргэлтэд байгаа аж үйлдвэржсэний дараах нийгэм, супер аж үйлдвэржсэн нийгэм, мэдээллийн нийгмийн баримтлалын нийтлэг болон ялгаатай арга зүйн үндэслэл, түүний даяар шинжийг тодорхойлох (Батбаяр, 2013), улс орныхоо тусгаар тогтнолыг баттай хамгаалах онол-философийг боловсруулахад сэдэл өгөх (Даш-Ёндон, 2014), иргэний нийгэм байгуулах явцад гарч буй хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлуудыг судлан тодруулах, иргэний нийгмийн төлөвшлийн цаашдын чиг хандлагын талаар санаа бодлоо илэрхийлэх, иргэний нийгмийг цогцлуулан хөгжүүлэхэд учирч буй бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх арга замыг шинжлэх (ФСЭХ, 2014) гэх мэтээр дэлгэрүүлж болно.

Нэгэн сэдэвт бүтээлүүдийн хувьд монголын нийгмийг судлах, тайлбарлахад тулгуур болох онол, арга зүй, философи бий болгохыг голчлон зорилго болгосон бол докторын дипломын ажлуудад формацийн онолыг иргэншлийн онолтой хослуулах замаар нийгмийн бүтцийг тайлбарлах, иргэний нийгэм бүрэлдэх, орчин үежих, аж үйлдвэржих зэрэг үйл явц, деформацийн үүднээс монголын нийгмийг тайлбарлах зэрэг зорилгыг гол болгожээ.

**Арга зүйн хайгуулд**

Социалист дэглэмээс ардчилсан дэглэмд шилжсэн шилжилтийг дагаад нийгмийн шинжлэх ухаан, түүний онол, арга зүйн үндэс суурь болсон, монголын нийгмийн хөгжлийг тайлбарлахад төдийлөн нийцдэггүй байсан марксизм-ленинизмээс ангижрах шаардлага зүй ёсоор тулгарсан боловч өмнөх нийгмийн тогтолцоонд хэвшиж тогтсон хандлага, итгэл үнэмшлийн эрч тийм амархан сулраагүй нь тодорхой хуулийн утгаар ч жам ёсны үзэгдэл байв. Монголын нийгмийн өөрчлөлттэй зэрэгцэн нийгмийн хөгжлийг өөрөөр тайлбарлах арга зүйн эрэл хайгуул хийгдэж байсан боловч энэ нь марксизмын онолын үндэс болох Гегелийн гурвалын зарчимд тулгуурлах эсвэл формацийн үзэл баримтлалыг иргэншлийг тайлбарладаг үзэл баримтлал юмуу төв үзэлтэй хослуулахтай ихээхэн холбогдож байлаа. Энэ бүхэн нь нийгмийн философийн судалгааны арга зүйн хэсгээс тодорхой харагддаг.

Нийгмийн үзэгдэл, үйл явцыг авч үзэн тайлбарласан судалгааны ажлуудын арга,

аргачлалыг тоймлон үзэхэд зөрчилд нь буюу шүтэн барилдлагаанд нь авч үзэх зарчим, нэгдэл, тэмцэл буюу арга, билгийн шүтэлцэн барилдлагаа, арга, билгийн квадратын дагуу сэтгэх арга зүй, гурвалжныг ашиглан арга, билгийн тогтолцоог ойлгох арга зүй, төв, хүрээний үүднээс авч үзэх арга, арга билгийн графикийн дагуу сэтгэх арга зүй, гурвалын дагуу сэтгэх арга зүй, Гаусын тэнцвэрт тогтолцооны муруйн дагуу сэтгэх арга зүй, таван махбодоор сэтгэх арга: арга, билиг, эх, хүүгийн харьцаа, махбод хийгээд хөгжлийн улиран дэвших ахиц шат (Хавх, 1997), төв үзлийн үндсэн зарчим, шинжлэх ухааны танин мэдэхүйн түгээмэл зарчим (Гантөмөр, 1997), формаци, иргэншлийн онолын арга зүй (Ганхуяг, 1998), эртний Энэтхэгийн гүн ухааны нэрт төлөөлөгч, монголд үлэмж дэлгэрсэн төв үзлийн онолыг үндэслэгч Нагаржуна болон түүний залгамжлагчдын боловсруулсан хоосон чанарын сургаал, орчлон ертөнцийн үндэс язгуурыг танин мэдээд төв сэтгэж, төлөв үйлдэх, сэтгэлийн дотоод ариуслыг олох, аливаад өрөөсгөл талыг барьж туйлшрахаас зайлсхийж голч байх, зөрчилт олон талын шүтэн барилдах тэнцвэрийг олж суурилах зэрэг төв үзлийн үндсэн зарчмыг судалгаандаа тууштай баримтлахыг эрмэлзэхийн зэрэгцээ Өрнө, Дорнын гүн ухааны түүхээр шалгаран боловсорсон диалектикийн үндсэн зарчмууд, орчин үеийн нийгмийн танин мэдэхүйд ч чадварлаг ажиллаж буй шинжлэх ухааны танин мэдэхүйн түгээмэл зарчим (Чулуунбаатар, 1999), жишилт, экстраполяци, загварчлал, бүтэцлэх, материалист, идеалист (тухайлбал феноменологи), скептик (тухайлбал фальсификатив), индуктиктив зэрэг арга ба арга зүйн хандлагуудыг (Гомбосүрэн, 1999), рациональ шүүмжлэл, анархист эпистемологи (Лхам, 1999), түүхэн ба логик арга (Эрдэнэтунгалаг, 1999; Эрдэнэбаяр, 2000; Гомбосүрэн, 1999; Чулуунбаатар, 1999), харьцуулах, этнометодологийн арга (Эрдэнэтунгалаг, 1999), жишилт, индукци, дедукци (Эрдэнэбаяр, 2000), түүхэн харьцуулалт, сүлжээний хандлага, шүүмжлэлт болон тайлбарлалын арга зүй (Батбаяр, 2013), герменевтик арга зүй, прагматик үзэл баримтлал, судалгааны ерөнхий аргууд болон баримт бичиг судлах арга, түүхэн зарчим, нийгмийн үйл явцыг үндэслэхүйн (интерпретаци) парадигмыг механизмчлах хандлагатай хослуулах (Ганболд, 2013), нийгмийн философийн модернист урсгалын байр сууринаас аналитик аргыг хэрэглэх (Дашпүрэв, 2017), юмс үзэгдэл шүтэн барилдахуйн онол, танин мэдэхүйн диалектик, түүхчлэл-түүхийн философийн зарчим, судлагдахууныг орон зай, цаг хугацааны дотор хөдөлгөөнд нь авч харьцуулах, жиших, нотлох, төсөөлөх, асуудал дэвшүүлэх (Даш-Ёндон, 2017) аргыг ашиглажээ.

Судалгааны арга зүйн хэсэгт шүтэн барилдлага, формаци, иргэншлийн онолын арга, экстраполяци, загварчлал, бүтэцлэх, сүлжээний хандлага, рациональ шүүмжлэл, анархист эпистемологи, этнометодологийн арга, аналитик, герменевтик, прагматик арга, баримт бичиг судлах арга, жишилт, индукци, дедукци, харьцуулалт, түүхэн ба логик арга зэргийг ашиглана хэмээн илэрхийлэх боловч эдгээрийг хэрхэн ашиглах алхам, үр дүнг хэрхэн үнэлэх аргачлалыг тайлбарлахгүй зөвхөн тоочин дурдсан байдал түгээмэл ажиглагдав. Түүнээс гадна эдгээрийн дийлэнх нь танин мэдэхүйн түгээмэл арга буюу аль ч талбарын судалгаанд өргөн хэрэглэгддэг арга учраас монголын нийгмийн философийн судалгаа нь судлагдахууныг шинээр харах, үнэлэх, тайлбарлах өвөрмөц арга зүйгээр дутагдаж байна гэж хэлж болно.

**Нийгмийн философийн талбарт шинэ сэдвийг танилцуулсан нь**

Германы философич А.Хоннетийн тэмдэглэснээр нийгмийн философи нь Герман хэлт ертөнцөд хачин жигтэй салбар болж доройтохын ирмэг дээр байгаа бол Англи-Саксон улсуудад түүний онолын талбарын хязгаарлалт нь түүнийг улс төрийн философийн дэд салбар болгож, бие даасан ямар ч шинжийг ахиж хэзээ

ч олж чадахааргүй болтол тэгж их хувиргажээ (Honneth, 2007). Зарим толь бичигт тайлбарласанчлан нийгмийн философи нь улс төрийн норматив философийн доторх хязгаарлагдмал талбартай (Bunnin & Yu, 2004) ихээхэн давхацдаг. Эндээс улс төрийн философи нь бидний ярилцан буй сэдэвтэй ямар их холбоотой байхыг олж харж болно. Гэвч энэхүү талбар нь монголын нийгмийн философийн судалгаанд 2000 он гартал төдий л танил биш байв. Харин *Орчин үеийн зүй ёсны онолууд хийгээд монголын бодит байдал* (Батчулуун, 2002), *Пост-коммунист нийгэм дэх төр иргэний харилцаа* (Батчулуун, 2003) гэсэн бүтээлүүд хэвлэгдэн гарч, зүй ёсны онол, арга зүй хийгээд улс төрийн философийн асуудлыг монголын нийгмийн философийн талбарт танилцуулсан юм.

Хиймэл оюун ухааны ёс зүй: сорилт ба хариуцлага ..................................................56

**М.Хүрэлтогоо, А.Мөнхшагай**

Дижитал сурах бичигт тавих шаардлага, шалгуур..................................................64

**Ч.Нямсүрэн, Б.Мөнхдорж**

Хиймэл оюун ухаан ба криминологийн хөгжлийн чиг хандлага..................................................71

**Ц.Батбаяр**
Цахим орчин дахь хүүхэд, залуусын эсрэг гэмт явдал,
түүнд хийсэн шинжилгээ ........................................................................85

**Б.Дэлгэрмаа, Д.Ариунжаргал**
Монголын нийгэм дэх цахим орчны судалгаа..................................................91

**Ж.Бямбасүрэн**
Цахим орчны нөлөөнд өртсөн монгол ахуй. ..................................................103

**Б.Өнөрболд**
ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын эрүүл мэнд,
хөгжилд компьютер тоглоомын үзүүлж буй нөлөө .......................................108

**Ж.Хулан**
Вирус хүн төрөлхтний амьдралд хэрхэн нөлөөлж болох вэ? .......................122

**Д.Чулуунгэрэл**
Мэдээлэл технологийн орчин үеийн чиг хандлага ..................................... 127

**А.Энхцэцэг**
Хиймэл оюун ухаан ба философи .................................................................131

**Б.Цэрмаа, Ц.Эрдэнэбат**
Монгол хүний ёс суртахууны өөрчлөлт ба цахим орчин .............................140

Философи: үйл явдал, бүтээл - 2020 ............................................................147

## МЭНДЧИЛГЭЭ

2020 оны 11 дүгээр сарын 19
Улаанбаатар хот, Монгол Улс

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид, хатагтай, ноёдоо,

ЮНЕСКО-ийн Нийгмийн өөрчлөлтийн удирдлага хөтөлбөрийн Монголын үндэсний хорооны дэд дарга, Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн захирал Б.Пүрэвсүрэн,

Юуны түрүүнд энд хүрэлцэн ирсэн Та бүхэнд Дэлхийн философийн өдрийн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

“Философи нь бидний дэлхий ертөнц, хүмүүний оршин тогтнолын талаарх гайхшралаас төрдөг”. Иймдээ ч философи нь ертөнцийг өгөгдсөн зүйл биш, харин үл мэдэгдэх зүйл хэмээн үзэж, аливааг эргэцүүлэн бодож, утга учрыг нь олоход чиглэсэн мөнхийн эрэлхийлэл юм. Философи нь 3000 гаруй жилийн тэртээх эртний Хятад, Грек, Ойрх дорнодоос эхтэй хэдий ч ач холбогдол нь одоог хүртэл бууралгүй харин ч цаг тутамд нэмэгдсээр байгаа бөгөөд өнөөгийн нарийн төвөгтэй нийгэмд урьд өмнөхөөсөө илүү чухал болоод байна.

Бид өнөөдөр цахим эрин үед амьдарч, цахим хувьсгалын гэрч болж байна. КОВИД-19 цар тахлаас үүдэн дэлхий нийтэд тодорхой бус байдал давамгайлж, эрүүл мэнд, нийгэм, улс төр, эдийн засгийн томоохон сорилтууд урган гарч буй энэ үед дижитал шилжилт, цахимжилт, дэвшилтэт технологийн шийдлүүд улам бүр газар авч бидний хүрээлэн буй орчин, нөхцөлтэй нягт уялдаа, холбоо бүхий амьдралын салшгүй нэг хэсэг болжээ. Цахим худалдаа, үүлэн тооцоолол, ухаалаг гар утас, онлайн сургалт, олон нийтийн сүлжээ гээд өдөр тутмын цахим хэрэглээ эрс нэмэгдэхийн хирээр дэвшилтэт технологийн хэрэглээ ч мөн нийгэмд хурдацтайгаар нэвтэрч байна. Үүний нэг жишээ нь мэдээж хиймэл оюун ухаан билээ. Хиймэл оюун ухааны хөгжил цаг, минутаар хэмжигдэж шинжлэх ухаан, боловсрол, соёл, хөдөлмөрийн зах зээл гээд бүх л салбарт ашиглагдах болсноор хүн төрөлхтөнд эерэг, сөрөг олон үр дагаврууд гарч байна.

Түүнчлэн, цахим орчны нөлөөлөл нэмэгдэх тусам нийгмийн уламжлалт жишгүүд өөрчлөгдөж байгаа бөгөөд үүнийг дагаад хувь хүний үнэт зүйлс, хандлага, ухамсар, сэтгэлгээ ч бас хувьсан өөрчлөгдөж байна. Энэ асуудал нь цаашлаад үндэсний онцлог, эв нэгдэл алдагдах аюулыг дагуулж буй тул технологи ба хүмүүний уялдаа холбоог хэрхэн ёс зүйтэйгээр хангаж, цахимжилт, техник технологийн дэвшлээс урган гарч буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж, цаашдын төлөв хандлагыг хэрхэн тодорхойлж болох талаар философийн үүднээс тунгаан бодох зайлшгүй шаардлага бий болоод байна.

Өнөөдрийн энэхүү эрдэм шинжилгээний хурлыг энэ хэрэгцээ, шаардлагыг үндэслэн зохион байгуулж байна. Энэ сэдэвт ач холбогдол өгөн үнэ цэнтэй санал,

зөвлөмж, судалгаагаа хуваалцахаар ирсэн эрхэм эрдэмтэн судлаач, багш, профессор та бүхэнд болон философийн үр өгөөжийг олон нийтэд түгээн дэлгэрүүлж сурталчлахад байнгын дэмжлэг үзүүлж ирсэн Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн хамт олон ба ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газарт гүн талархлаа илэрхийлье.

Ингээд та бүхэнд Дэлхийн философийн өдрийн мэндийг дахин хүргэж, эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

*ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комиссын*

*Ерөнхий нарийн бичгийн дарга С.Уянга*

# МОНГОЛЫН ФИЛОСОФИЙН ХОЛБООНЫ МЭНДЧИЛГЭЭ

“Монголын нийгэм дэх цахим орчны нөлөөлөл: философи асуудлууд” эрдэм шинжилгээний хуралд оролцогч Та бүхэнд Дэлхийн философийн өдрийн мэнд хүргэе.

Дэлхий даяар тархсан КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр манай улсад хөл хорио тогтоосон цаг үед энэ хурлыг зохион байгуулж байгаа бөгөөд сэдвийн хувьд цахим технологийн философи асуудлыг сонгосон нь онол, практикийн нэн чухал ач холбогдолтой болж байна.

КОВИД-19 цар тахал нь анагаах ухаан, эдийн засгийн салбарт нэгэн зэрэг хүнд сорилтууд бий болгохын зэрэгцээ биднээс аж төрөх арга барил, оршихуйн ёс, амьдралын үнэ цэн, итгэл үнэмшлийнхээ талаарх эргэцүүлэл дүгнэлт, тодруулгыг нэхэж байна. Лийдс, Дублин, Нью-Йорк, Оксфорд, Хумбольдт, Лейбниц зэрэг дэлхийн нэр хүндтэй их сургуулийн философич эрдэмтдээс Elsevier, Springer–ийн сэтгүүлд цар тахалтай холбоотой эпидемологийн философи, эпистемологи, ёс зүйн асуудлаар хэвлүүлсэн өгүүллүүдэд эртний грекийн сэтгэгч Сократ, стоицизм, дарвинизм, гуманизмаас эшлэн, экзистенциализм дахь үхэл, айдас, зовнил, жам ёсны эрх, сонголт зэрэг ойлголттой холбон тайлбарласан нь цөөнгүй байна. Мөн био ёс зүйн нарийн төвөгтэй асуудлууд, тэдгээрийн үндэслэл, үр нөлөөг тайлбарлажээ.

Цахим сүлжээ, хэвлэлүүдээс харахад, манай иргэд цар тахалтай холбоотой төрөл бүрийн таамаг, сэрэмж бүхий мэдээлэл түгээхийн зэрэгцээ уламжлалт сэтгэлгээний буюу нүүдэлчдийн байгальтай хандах зан үйл, хорио цээр, буддизмын шүтэн барилдахуйн зарчим, хамаг амьтан хийгээд юмсын “би” ашид үгүй, мөнх бус, үйлийн үр, гэгээрлийн тухай сургаал, уламжлалт анагаах ухааны тайлбаруудтай холбосон санаа бодол илэрхийлсэн байна.

2012 оноос хойш ШУА-ийн Философийн хүрээлэн, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комиссоос хамтран Дэлхийн философийн өдрийг тохиолдуулан 7-н удаа эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, илтгэлийн эмхэтгэлийг хэвлүүлэн сургалт, судалгааны эргэлтэд оруулжээ. Манайд техникийн философийн асуудлаар ШУТИС-ийн Бизнесийн Удирдлага, Хүмүүнлэгийн Сургуулийн эрдэмтэн багш нар ном сурах бичиг орчуулж, хэвлүүлснийг тэмдэглэх хэрэгтэй.

ЮНЕСКО 2019 оноос эхлэн хиймэл оюун ухааны ёс зүйн зөвлөмжийг боловсруулах Олон улсын эрдэмтдийн багийг бүрдүүлэн ажиллаж, энэ онд гишүүн орнуудаас санал авч буй юм. Чухам эл үед МУИС, ШУА-ийн Философийн Хүрээлэн, ХААИС, Боловсролын Хүрээлэн, ШУА-ийн Математик, Тоон Технологийн Хүрээлэн, СУИС, АШУҮИС, Дотоод Хэргийн Их Сургууль зэрэг байгууллагын философи, математик, биологи, хууль зүй, сэтгэл судлал, боловсрол судлал, соёл

судлалын салбарын эрдэмтэн судлаачид хүний ахуй, соёл, нийгэм дэх мэдээллийн технологийн нөлөө, хиймэл оюун ухааны ёс зүй, цахим сургалт, дижитал сурах бичгийн хэрэглээ, криминологийн хөгжил дэх хиймэл оюуны нөлөөлөл, цар тахлын үеийн нийгмийн сэтгэл зүйн асуудлаар илтгэлүүд хэлэлцүүлж байна.

Эдүгээ бид цахимжсан иргэншлийг бүтээж, дижитал технологийн эерэг, сөрөг нөлөөг мэдэрч байна. Цахимжилт, хиймэл оюун ухаан бидний амьдралын сонголт, төлөвлөлтөд эрчимтэй нөлөөлөх боллоо. Хүн төрөлхтний бүхий үйл ажиллагаа дижитал орчинд өрнөж буй цахим хөгжлийн эрин үед хүмүүний өөрийн тэнгэрлэг байдал (dignity) ба хиймэл оюун ухааны эсрэгцэл, нийлэмж; цахим дахь семиотик дүрслэлүүд хийгээд тэдгээрийг зохиогч, хүлээн авагчийн харилцаа; цахим орчны ёс зүй; Big Data-г бүтээх хийгээд хүний сайн сайханд ээлтэйгээр ашиглах арга; технологийн дэвшлээс үүдэх эрсдэл, тулгарч буй сорилтуудыг хэрхэн даван туулах зэрэг тулгамдсан асуудлыг философийн үүднээс шүүн тунгааж, хэлэлцэх нь чухал билээ.

Энэхүү эрдэм шинжилгээний хуралд оролцогчид, эрдэмтэн судлаачдад талархал илэрхийлж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

*Монголын Философийн Холбооны Ерөнхийлөгч,*
*доктор (Ph.D) Д.Гантөмөр*

## ӨМНӨХ ҮГ

Дэлхийн философийн өдрийг тохиолдуулан нийт философичид, философийг сонирхон судалж, оюуны соёлыг хүндлэн дээдэлдэг, эрдэм ухааны эрэлчид болсон судлаач, багш хэн бүхэнд баярын мэндийг хүргэе.

ЮНЕСКО-ийн санаачлагаар 2005 оноос тэмдэглэж эхэлсэн Дэлхийн философийн өдөр өнөө жил арваннэгдүгээр сарын арван есөнд тохиож байна. Монгол дахь философийн сургалт, судалгааг өргөтгөх, дэлхийн философи сэтгэлгээний баялаг өв, монголын гүн ухааны уламжлалаас суралцах, зүй ёсоор хүртэх иргэн бүрийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ санаа, шинэлэг сэтгэлгээ, бүтээлч оюунлаг хэлэлцүүлгийг хөхиүлэн дэмжихэд энэхүү тэмдэглэлт өдөр чухал нөлөөтэй билээ.

Мэдлэг ухааны өвөрмөц төрөл хэлбэр төдийгүй оюуны соёл, ойлгохуй, ухаарахуй, эргэцүүлэхүй, сэтгэхүй, задлан шинжлэхүйн үйл бөгөөд үзэгдэл болсон философийг улс орон бүрийн боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь энэхүү чиг үүргийг бүх талаар дэмжих нь дамжиггүй бөгөөд үүрэгтэй билээ. Монгол Улсын хувьд 2019 онд салбарын яамнаас философийн хичээл сургалттай холбоотой зохих шийдвэр гаргасныг энд зориуд сайшаан дурдалтай.

Оюунлаг, бүтээлч, иргэн бүрт философийг тэгш хүртээмжтэй байлгахын төлөө, төдийгүй ирээдүйн сорил болоод сонголт, бэрхшээл, хөгжлийн шийдэл бүрийг хамтын хэлэлцүүлэг, ухаалаг мэтгэлцээн, дүн шинжилгээний үр дүнд тогтвортойгоор даван гарах үйл хэрэгт энэ өдөр зориулагддаг.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын энэхүү он жил хүмүүний ертөнцөд тулгарах шинэ сорилтуудыг харуулж, түүний нэгэн болох цахим технологи, түүний хэрэглээ болоод соёлд илүүтэй суралцах хэрэгцээ буй болсныг хүн төрөлхтөнд сануулж байна. Дэлхийн дэг журам ч ковидын өмнөх болон дараах гэсэн шинэ хувилбар луу шилжиж буй талаар өгүүлэх болжээ. Даяаршил дотроо ээдрээт учиг зангилаа ихтэй харийн нийлмэл, нэгэн чиг шулуун хөдөлгөөн биш болох нь энэ үед улам бүр тодорхой болж түүнтэй эн зэрэгцэн дангааршихын утга учрыг ч давхар сануулсаар байна.

Байгаль, нийгмийн бодит байдлаас виртуаль бодит байдалд ажил амьдралаа үргэлжлүүлэх, цахим харилцааны салаа мөчир бүрт амь амьдрал, сэтгэл оюунаа холбож, электрон жаалаас е-“өвгөн” болтлоо аж төрөх нигууртай аж үйлдвэржсэн нийгмийн технологи, инженерчлэлийн буулганаас бултах эрхгүй ч, бултайж торойж гарах хиймэл оюун хэмээх “үл үзэгдэгч гар”-н үзүүрээс, супер тархины тооцооллоос холдохын аргагүй болж байна.

Хэл яриа таних системээс эхлээд хүмүүн төрөлхтний асуудлыг шийдвэрлэхэд ч хиймэл оюун ухаан хэмээх мэдлэгт суурилсан “хиймэл” нэртэй ч хийгүй, алдаагүй “зохиомол” төлөвтэй ч зоргоороо ажиллах системийн жолоо цулбуурыг

тааруулахын тулд ёс зүйн асуудал ундран гардаг.

Чухам энэ хүрээнд цахим шилжилтийн алдаа оноог дэнслэн дүгнэх залуур юуг нь тааруулахуйн үүднээс философийн хэлэлцүүлэгт хиймэл оюун, түүнийг дагасан ёс суртахууны ээдрээт болон дилемм болсон асуудлыг олны анхааралд оруулж ирэх, учирч болох эрсдэлээс уршиг багатай тойрч болон туулж гарахын зорилго, зорилтын үүднээс энэхүү хурлыг шинжлэх ухаан, техник технологийн салбар эрдэмтэн судлаачдын хүч оюунаар уухайлан байж хуран чуулж байна.

Энэ жилийн философийн өдрийн хуралд оролцож байгаа Монголын их дээд сургуулийн болон ШУА-ийн хүрээлэнгийн судлаач, профессор багш нар та бүхэндээ талархал илэрхийлж, цаашдын хамтын ажиллагаанд амжилт хүсье.

*Философийн хүрээлэнгийн захирал,*
*доктор (Ph.D), дэд профессор Б.Пүрэвсүрэн*

# ОРЧИН ҮЕИЙН НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ОНОЛУУД ДАХЬ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН НӨЛӨӨЛЛИЙН АСУУДАЛ *

**Б.Дагзмаа, М.Отгонбаяр**
*Доктор (Ph.D), профессор*
*Монгол Улсын Их сургууль*
**В.А.Иноземцев**
*Доктор (Sc.D), профессор*

***Абстракт.*** *Капитализм хөгжлийнхөө шинэ шатанд шилжсэн нөхцөл байдлыг шинжлэх ухаан, технологийн контекстоор авч үзсэн пост аж үйлдвэржсэн нийгэм, пост капиталист нийгэм, мэдлэгийн нийгэм, мэдээллийн нийгэм хэмээх үзлүүдийг харьцуулан авч үзлээ. Өрнөдийн өндөр хөгжилтэй нийгэмд XX зууны хоёрдугаар хагасаас хойш гарсан суурь өөрчлөлтүүд, ялангуяа социаль болон үйлдвэрлэлийн хүрээнд гарсан шинэ шинэ өөрчлөлт бол шинжлэх ухааны мэдлэг, мэдээлэл, компьютерийн технологийн хөгжилтэй холбоотой байна. Аж үйлдвэржсэний дараах буюу мэдээллийн нийгмийн стратегийн үндсэн нөөцүүд бол мэдлэг ба мэдээлэл болсон. Мэдлэгийн нийгэм ба мэдээллийн нийгмийн онол аль аль нь шинжлэх ухаан, технологи, нийгмийн бүтэц, нийгмийн хэрэгцээний өөрчлөлт зэрэг хүчин зүйлсийн системд анализ хийх арга зүйгээрээ ижил байна.*

***Түлхүүр үг:*** *мэдлэг, мэдээлэл, технологи, мэдлэгийн нийгэм, мэдээллийн нийгэм, аж үйлдвэржсэний дараах нийгэм*

Мэдлэг гэж юу болох, түүнийг хэрхэн бүтээдэг, хэрхэн үндэслэх зэрэг асуудлаархи анхны эргэцүүллүүд Платоны Диаологи болон Аристотелийн бүтээлүүдэд бий. Шинэ үеэс хойш онол танин мэдэхүйн асуудлын гол төвд шинжлэх ухааны мэдлэг гарч ирж, шинжлэх ухааны мэдлэгийн загвар нь анхандаа математик, яваандаа физик болсон. XX-XXI зууны зааг үеэс шинжлэх ухааны философи ба танин мэдэхүйн онолд гүнзгий суурь өөрчлөлтүүд гарсны нэг нь хүмүүнлэгийн ухааны арга болон мэдлэгийн бүтэц, зохион байгуулалтын асуудал, шинжлэх ухааны бус мэдлэгийн төрлүүдийн арга, хэлбэрийн асуудал юм. Үйлдвэрлэл дэх техникийн өсөн нэмэгдэх үүрэг ба мэдлэгийн түгэлтийн асуудал тэргүүн эгнээнд яригдаж буй зэрэгтэй холбоотойгоор мэдлэг бол соёлын феномен хэмээн ойлгох болсныг[2] тойрон сонгодог биш эпистемологид онол танин мэдэхүйн асуудлуудыг өөрөөр авч үзэж байна.

Орчин цагт мэдлэг ба нийгмийн өөрчлөлтийн талаарх үзэл, онолуудын хүрээнд "мэдлэгийн нийгэм" хэмээх нэр томьёо , түүний философи, социологийн статусын асуудал тулгамдах болжээ. Философичид зах зээлийн болон удирдлагын салбар дахь шинэ шинэ үйл явцын талаарх судалгааны үр дүнд гарч ирсэн ойлголтуудад

[1] "Нийгмийн ухаан: техноугшилт иргэншлийн сорилтууд" Монгол Оросын хамтарсан төслийн хүрээнд бичсэн илтгэл.

[2] В.А.Лекторский. Эпистемология классическая и неклассическая. М.: Эдиториал УРСС, 2001. С. 9.

үндэслэн "мэдлэгийн нийгэм"-ийн асуудлыг тавьж байна. Улс төр, эдийн засгийн амьдрал, мэдээлэл, шинжлэх ухаан ба нийгмийн байгууллын хоорондын харилцаанд болж буй үйл явцыг эргэцүүлэх зорилгоор социологи, эдийн засгийн онол, менежментийн онол зэрэг олон салбарынхан "мэдлэгийн нийгэм" хэмээх ойлголтыг XX зууны 60-аад оноос хэрэглэж эхэлжээ. Түүхэн утгаар мэдлэг ба нийгмийн харилцааны асуудлыг Платоны идеаль төр, Бэконы Шинэ Атлантид, Сен Симоны нийгмийн өөрчлөн байгуулах тухай үзэл зэрэгтэй ч холбож болох юм.

Мэдлэгийн нийгмийн тухай санааг анх менежментийн онолч Дракер /Drucker P.F/ дэвшүүлсэн ба Ф.Махлуп, Д.Белл, Р.Лэйн зэрэг хүмүүс ижил төстэй санааг дэвшүүлж, XX зууны 90-ээд оноос эл ойлголтыг нийгмийн ирээдүй гэдэг утгаар өргөн хэрэглэж эхэлсэн байна. Мэдээлэл харилцааны технологийн хөгжил ба модернизацийн үйл явц, шинжлэх ухаан-технологийн дэвшлийн нөлөөгөөр өрнөдийн аж үйлдвэр өндөр хөгжсөн улс орнуудад мэдэгдэхүйц өөрчлөлтүүд гарч эхэлсний дотор мэргэшсэн мэргэжилтнүүд буюу цагаан захтан ажилтны тоо үйлдвэрийн ажилчдын тооноос давж гарсан XX зууны 60-аад оны үед Дракер "knowledge worker" буюу мэдлэгтэй мэргэжилтэн гэх нэр томьёог анх хэрэглэжээ. Компьютерийн техник болон мэдээлэл дамжуулах хэрэгслийн хөгжлийн явцад интернэт үүсэж, үйлдвэрлэлийн уян хатан шинэ систем хөгжсөн "өнөөгийн нийгмийг "мэдлэгийн нийгэм" хэмээн урьдчилан хэлж болох ч өнөөдөртөө бид мэдлэгийн үндсэн дээр бүтээх эдийн засгийн системийн тухай л ярьж болно. Бидний оршин амьдарч буй нийгэм бол посткапиталист нийгэм мөн"[3], "мэдлэг бол хүч төдийгүй, шинэ нийгмийг бүтээгч хүч мөн" гэж Дракер дүгнэжээ. Посткапитализмын үед хувийн өмч, зах зээлийн харилцаа зэрэг нь хэвээр байсаар боловч зах зээлийн хүрээнд мэдлэг хүч түрэн орж ирж, газар, ажиллах хүчин зэрэг шавхагдах нөөцийн оронд мэдлэг гол нөөц болсон ажээ.

Дракер мэдлэгийн нийгэмд шилжих гурван үндсэн шатыг ангилжээ. Нэгд, XVIII зууны дунд үеэс XIX зууны дунд үе хүртэлх эхний шатанд мэдлэгийн хэрэглээний ач холбогдол чухал нөөц болсоноор аж үйлдвэрийн хувьсгалын суурь тавигдаж, техникийг бүтээх, материаллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд мэдлэгийг хэрэглэж эхэлсэн. Хоёрт, Америкийн инженер Фридрих Уинслоу Тейлор хөдөлмөрийн үйл явцыг төлөвлөх, бүтээлч үйл ажиллагаанд анализ хийхэд мэдлэгийг хэрэглэснээр хоёр дахь шат /1881 онд/ эхэлжээ. Энэ шатанд үйлдвэрлэлийн бүтээмжид хувьсгал гарсан, үйлдвэрийн удирдлага өмч эзэмшигчээс мэргэжлийн удирдлагын гарт шилжсэн, ажиллах хүчин үйлдвэрийнхээ ашиг орлогод анхаарах болсон зэрэг өөрчлөлтүүд гарснаар Марксын пролетари нар "хөрөнгөтөн" болон хувирчээ. Гурав дахь шат дэлхийн II дайны дараагаас эхэлж, "мэдлэгийн үйлдвэрлэлд мэдлэгийг хэрэглэх болжээ. Цаашид чухам ямар мэдлэг хэрэгтэй болох, тэрхүү мэдлэг нь зорилгод нийцсэн эсэх, мэдлэгийн хэрэглээний үр ашгийг хангахын тулд юу хийх хэрэгтэй болох зэрэгт мэдлэгийг систем, зорилготойгоор өнөөдөр

[3] Дракер. Посткапиталистическое общество. //Новая постиндустриальная волна на Западе. Антология. Под ред В.Л.Иноземцова. М.: Academia. 1999. С.71.

мэдлэгийг хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл шинэ зүйл, инновацийг системтэй хэрэгжүүлэхэд мэдлэг хэрэгтэй ажээ. Дракер XYIII зууны дунд үе хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн хэрэгсэлд шингэсэн мэдлэгээс өөр утгаар буюу мэдлэгийн статус дахь хувьсгалт өөрчлөлтүүдийн дүр зургийг гаргасан ажээ.

“Өнөөдөр мэдлэг бол тодорхой үр дүнд хүрэхэд үйлчилдэг практик ач холбогдол бүхий мэдээлэл мөн. Энэхүү үр дүн нь хүнээс гадна буюу нийгэмд, эдийн засагт болон мэдлэгийн өөрийнх нь хөгжилд илэрч байна”[4] гэж мэдлэгийн тухай орчин үеийн ойлголтыг гаргасан байна. “Мэдлэг бол эдийн засаг, нийгмийн хөгжил, нийгмийн удирдлагын гол хөдөлгөгч хүч мөн” гэдэг нь мэдлэгийн нийгмийн тухай үзлийн гол санаа болж байна. Мэдлэгийн нийгэм хэмээх ойлголтыг янз бүрээр тодорхойлон бичиж буй хэдий ч юуны өмнө мэдлэгийн үйлдвэрлэл, мэдлэгийн хэрэглээ бол хөгжлийнх нь гол хөдөлгөгч хүч болсон тэр нийгэм мөн. Мэдлэгийн хэрэглээ гэдгийн дор үйл ажиллагааны олон янз төрөл, түүний дотор мэдлэг эзэмших, дэлгэрүүлэх, хэрэглэх үйл ажиллагааг ойлгож байна. Мэдлэгийн нийгэм бол нийгэм-эдийн засгийн хөгжлийн шинэ шат мөн.

Мэдээлэл-компьютерийн /тоон/ хувьсгалын үр дүнд бүрэлдсэн өнөөдрийн мэдээлэлжсэн нийгэмд мэдээлэл бол мэдлэгийг хуримтлуулах, дамжуулах гол хэрэгсэл, нийгмийн гол нөөц болон хувирсан. “Өнөөдөр мэдлэг нь эдийн засаг, улс төр, соёлын маш өргөн хүрээний судлагдахуун болсон бөгөөд нийгмийн чанарын байдлыг тодорхойлоход хэрэглэгддэг уг ойлголтын хүрээ нь бидний өмнө дөнгөж зурагдаж эхэлж байна”. Нийгмийн шинэ идеаль болох мэдлэгийн нийгэм нь үндэсний, бүс нутгийн, олон улсын бүтэц дэх стратегийн чиг хандлагыг тодорхойлж байна. ЮНЕСКО-оос 2005 онд гаргасан “Мэдлэгийн нийгэмд” хэмээх тайланд соёлын ба хэлний олон янз байдлыг бүрэн илэрхийлсэн нэгдмэл дүр зураг, нэг түлхүүр гэж байхгүй гэдэг утгаар нийгэм хэмээх ойлголтыг олон тоон дээр хэрэглэсэн ажээ. “Ямар ч нийгмийг байгуулахад мэдлэг ба соёлын янз бүрийн хэлбэр түүний дотор орчин үеийн шинжлэх ухаан техникийн дэвшил оролцдог. Гэхдээ технологийн детерминизм, фатализмын дагуу мэдээллийн технологи ба коммуникацийн хүрээн дэх хувьсгал нь нийгмийн хөгжлийн цорын ганц боломжит хэлбэр гэж үзэж болохгүй”[5] хэмээн тайланд онцолжээ. Мэдлэгийн нийгэм бол салан тусгаарлах нийгэм биш, харин мэдлэгийг хамтаар эзэмшдэг нийгэм мөн.

Өнөөгийн нийгэм-философийн судалгаанд “мэдлэгийн нийгэм”-ийн зэрэгцээгээр орчин үеийн нийгмийн тухай хоёр үндсэн хандлага байна. Энэ бол пост аж үйлдвэржсэн нийгэм ба мэдээллийн нийгмийн тухай үзэл юм.

Анх австралийн эдийн засагч К.Кларк өрнөдийн өндөр хөгжилтэй улс орнууд XX зууны 50-иад оны төгсгөл, 60-аад оны эхэн үед шинэ эдийн засаг ба технологи бүхий мэдээлэл ба үйлчилгээний нийгэм рүү шилжиж байгаа тухай[6] бичсэн бол Америкийн судлаач Д.Рисмен орчин үеийн нийгмийн хөгжлийн шинэ үе шатыг

4 Там же. С. 99.
5 К обществам знания. Всемирный доклад ЮНЕСКО. Париж. Изд ЮНЕСКО. 2005. С.1-19.
6 См. Clark C. The conditions of economic progress. – London.,1957.

илэрхийлэх зорилгоор уг ойлголтыг анх хэрэглэсэн ажээ. Улмаар XX зууны 70-аад он гэхэд өрнөдийн нийгмийн ажиллах хүчний бүтцэд томоохон өөрчлөлт гарсан, үйлчилгээний салбар өргөжсөн, дунд болон дээд боловсрол шаарддаг ажлын байрны эрэлт нэмэгдсэн, эрдэмтэд ба инженерүүдийн тоо өссөн, электроник, оптик, тооцоолох техник, химийн үйлдвэрлэл зэрэг мэдлэг шингээсэн үйлдвэрлэлийн салбарууд хүчтэй хөгжсөн.

Америкийн нийгэм судлаач Д.Белл 1973 онд хэвлүүлсэн “The coming of post-industrial society. A Venture in Social Forecasting” (Айсуй пост аж үйлдвэржсэн нийгэм) хэмээх бүтээлдээ нийгмийн хөгжлийн тухай шинэ онолоо толилуулсан. Түүний үзэлд Кейнс, Хикс, Кузнец зэрэг эдийн засагч эрдэмтдийн макро эдийн засгийн судалгаа нөлөөлсөн гэдэг. Зарим судлаач аж үйлдвэржсэний дараах нийгэм бол хөгжлийн энэ шатан дахь экологийн асуудлуудтай холбоотой хэмээн тайлбарладаг, харин зарим нь энэ бол цөөнхийн нийгэм, учир нь хэн ч өөрийгөө олонхид хамаардаг хэмээн үздэггүй, бүгд ямар нэгэн бага, цөөнх бүлгийн /амьдралын хэв маяг, сонирхол, улс төрийн байр суурь гэх мэт/ төлөөлөгч болдог гэдэг.

Д.Белл үйлдвэрлэл ба техникийн хөгжил дэх шинжлэх ухааны мэдлэгийн өсөн нэмэгдэгч үүргийн гол үзүүлэлт болох “шинжлэх ухааны судалгаа ба боловсруулалт” хэмээх феноменийг онцолж, аж үйлдвэржсэний дараах нийгэмд шилжих үйл явцад гарч буй бодит өөрчлөлтийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Компьютер, электрон, оптик, полимерийн техник гэх мэт шинжлэх ухааны мэдлэг шингээсэн үйлдвэрлэлийн салбаруудын хөгжлийн үр дүнд нийгмийн институцийн үндсэн үнэлэмж шинжлэх ухаан ба мэдлэгийн үүрэг бэхэжсэн.

Эдийн засаг, техник, нийгмийн асуудлуудыг илүү үр ашигтай, рациональчаар хандан шийдэх системийн анализ, шийдвэр гаргах онолууд ба загварчлалын технологийн үндэс болсон компьютерийн шугаман программчлал, математик, эдийн засгийн шинэ аргуудад тулгуурласан оюуны шинэ технологиуд бий болсон.

Техникийн мэргэжилтнүүд ба мэргэшсэн ажилтны анги буюу мэдлэгийг зөөгч ангийн тоо өссөн. Товарын үйлдвэрлэлээс үйлчилгээний үйлдвэрлэлд шилжсэн. Юуны өмнө хүмүүнлэгийн /эрүүлийг хамгаалах, боловсрол, нийгмийн үйлчилгээний/ салбарт шинэ шинэ үйлчилгээнүүд нэвтрэхийн хамтаар мэргэжлийн болон техникийн мэргэшсэн ажилтнуудын тоо өсч, боловсрол ба мэргэжлийн үнэлэмжээр нийгэмд байр сууръ эзэлдэг меритократи тогтолцоо бүй болсон.

Хөдөлмөрийн шинж чанарт өөрчлөлт гарсан. Шинжлэх ухаан ба технологийн харилцаа нь өнөөдрийн нийгмийн хэрэгцээг тодорхойлох болсон бөгөөд мэдлэг олж авах, судалгаа явуулах чөлөөт бололцоог буй болгоход шинжлэх ухааны институт нь чухал үүрэг бүхий болсон.

Ситус/situ- нийгмийн захирах ба захирагдах босоо эрэмбэ бүхий нэгж/ бол аж үйлдвэржсэний дараах нийгмийн улс төрийн гол нэгж болсон. Шинжлэх ухааны,

техникийн, захиргааны, соёлын гэсэн дөрвөн төрлийн функциональ ситус, эдийн засгийн байгууллага, төрийн байгууллага, их сургууль ба эрдэм шинжилгээ-судалгааны төвүүд, нийгмийн комплексууд/ эмнэлэг, нийгмийн үйлчилгээний төв/, арми гэсэн таван төрлийн институцийн ситус байна гэж Белл үзжээ.

**Мэдээллийн эдийн засгийн онол.** Мэдээлэл бол хамтын бүтээл учраас мэдлэгийн маш өргөн хүрээний дэлгэрэлт ба хэрэглээ нь хамтын ажиллагааны шинэ стратегийг нээж өгч буй энэхүү шинэ нөхцөл байдал нь нийгэм судлаачдын өмнө шинэ шинэ асуудал, сорилтуудыг тавьж байна.

Мэдлэг, мэдээлэл бол аж үйлдвэржсэний дараах нийгмийн үндсэн нөөцүүд бөгөөд нийгмийн хөгжлийн гол хүчин зүйл болжээ. Мөн “шинэ технологи онцгой үүрэгтэй учир ирж буй шинэ зуунд эдийн засаг болон нийгмийн амьдрал, мэдлэг үйлдвэрлэх арга, хүний хөдөлмөрийн шинжид телекоммуникацид суурилсан нийгмийн шинэ хэвшил шийдвэрлэх үүрэгтэй болно” [7] гэж Белл үзжээ. Тэрээр аж үйлдвэржсэний дараах гэдэг нэр томьёог нэгд, өрнөдийн нийгэмд гарч буй өөрчлөлтийг онцлох, хоёрт, нийгмийн хөгжлийн чиг хандлагын тэнхлэгийг тодорхойлох зорилгоор хэрэглэсэн ажээ.

Аливаа нийгэм бол эдийн засаг, технологи, улс төр, соёлын төрөл бүрийн системийн холимог учир түүнийг дэвшүүлэн тавьсан зорилгоосоо хамааран олон талаас нь авч судалж болно. Беллийн хувьд шинэ технологиуд нь нийгмийн ямар ямар өөрчлөлтөд хүргэж, түүний үр дүнд ямар ямар асуудлыг нийгэм, улс төрийн систем шийдвэрлэх ёстой болохыг судлах анализын зэвсэг гэдэг утгаар технологийн нөлөөллийн асуудлыг авч үзсэн байна.

Аж үйлдвэржсэн нийгэмд капитал ба хөдөлмөр гол элементүүд нь болж, машины технологид суурилдаг. Харин аж үйлдвэржсэний дараах нийгэм нь оюуны технологид тулгуурладаг ба мэдээлэл, мэдлэг гол хүчин зүйл нь мөн. Ийм учраас тэдгээрийн эдийн засаг, нийгмийн байгууламж нь ч ялгаатай юм. Аж үйлдвэржсэний дараах нийгмийг өртгийн хөдөлмөрийн онолоор биш, харин мэдлэгт суурилсан өртгийн онолоор тодорхойлно. Энэ нийгэмд мэдлэг бол “хамтын баялаг” бөгөөд мэдлэг бүтээгдмэгцээ бүхэнд хамаатай болж байна. Техникийн хувьд тоон мэдээллийн технологид тулгуурлан хөгжиж буй компьютинг сүлжээнд тохирох бүтэц бол гол асуудал болж байна.

Мэдээллийн нийгмийн тухай санааг анх XX зууны 40-өөд оны сүүлчээр австралийн эдийн засагч А.Кларк, 50-иад оны дунд үед Америкийн эдийн засагч Ф.Махлуп[8] нар дэвшүүлж байсан боловч Токиогийн Технологийн институтийн профессор Ю.Хаяши “мэдээллийн нийгэм” хэмээх нэр томьёог анх хэрэглэн, “компьютерчлалын үйл явц хүмүүсийг нэгэн хэвийн хөдөлмөрөөс чөлөөлж, мэдээллийн найдвартай эх сурвалжийг бүрдүүлэн, нийгэмд автоматчиллын

7 Белл Д. Грядущее постиндустриальное общество. Опыт социального прогнозирования. - М., - 1999. С. 45.

8 Clark C. The conditions of Economic Progress. L.1957; Machlup F. The Production and Distribution of Knowledge in the United States. Princeton, 1962.

өндөр түвшинг хангаж өгсөн" нийгэм мөн гэжээ. Японы мэдээллийн нийгмийн институтийн захирал И.Масуда "мэдээллийн нийгэм бол ангигүй, зөрчилгүй бөгөөд төрийн аппарат маш бага хэмжээнд очих зөвшилцлийн нийгэм мөн. Мэдээллийн нийгмийн гол үнэлэмж бол цаг бөгөөд шинэ соёлын утгатай болсоноороо өмнөх аж үйлдвэржсэн, хэрэглээний нийгмээс ялгаатай" гэж бичжээ.

Мэдээллийн нийгэм бол нэгд, компьютерийн техникийн, мэдээллийн, телекоммуникацийн технологийн өндөр түвшин, хоёрт, мэдээллийг бүх иргэдэд хүргэх боломцоо, гуравт, мэдлэг ба мэдээлэл нь үндсэн стратегийн нөөц олон хувирсан /өмнөх нийгэм бол байгалийн, санхүүгийн, хүний нөөцөөр хязгаарлагдаж байв/ нийгэм мөн.

Мэдээллийн нийгмийн тухай онолын гол төлөөлөгчид мэдээллийн ба харилцааны технологийн хөгжлийн явц дахь шинжлэх ухааны, онолын мэдлэгийн үнэ цэнийг онцлон үзжээ. Яваандаа шинжлэх ухааны биш мэдээллийн ач холбогдлыг онцлох байдал хүчтэй болсон нэг нь америкийн социологич, постмодернист Т.Постер "мэдээллийн нийгэмд шинжлэх ухааны мэдлэгийн байр суурь суларч, шинжлэх ухааны дискурс өөрийн онцгой эрх ямбаа алдана"[9] гэжээ. Постерийн үзлээр компьютерийн сүлжээнд хэрэгжиж буй нийгмийн харилцааны шинэ хэлбэрийг лингвистик хэмжилтээр илэрхийлэх зорилт бүхий уг онолыг эдийн засгийн метафор мэтээр авч үзэж болохгүй ажээ.

Пост аж үйлдвэржсэн нийгэмд мэдлэг дараах үүрэг гүйцэтгэж байна.

Мэдлэгийг үйлдвэрлэх, дамжуулах үр ашигтай систем ажиллаж байна.

Мэдлэг бол үйл ажиллагааны ямар ч хүрээнд амжилтад хүрэх гол хүчин зүйл болж байна.

Шинэ бүтээгдэхүүн гаргах, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, шинэ асуудлыг шийдвэрлэх зэрэгт шинэ мэдлэг ямагт хэрэгцээтэй байна.

Мэдлэг бол зөвхөн тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд төдийгүй, мөн шинэ хэрэгцээг буй болгож байна.

Нийгэмд мэдлэгийг үйлдвэрлэгч систем, дэд систем төдийгүй материаллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг систем, дэд системүүд харилцан үр ашигтайгаар бие биедээ нөлөөлж байна.

Шинжлэх ухааны бүтээлүүд нь зөвхөн тухайн эрин үеийнхээ бүтээгдэхүүн байдаггүй бөгөөд танин мэдэхүйн болон нийгмийн хөгжлийн хэтийн хэрэгцээтэй холбоотой байдаг гэдгийг орчин үеийн нийгмийн өөрчлөлтүүд баталж байна. Энэ бүх өөрчлөлт тухайлбал, XX зууны эхэн үед физикийн онолын тулгуур судалгааны хүрээн дэх асуудлуудыг тавьж шийдвэрлэсний үр дүн бөгөөд цахилгаан соронзон оронгийн хуулиуд, атомын цөмийн хуваагдлын хууль, электрон энергийн нэг түвшнээс нөгөө түвшинд шилжих явц дахь атомын цацралын квантын хууль гэх мэт олон хуулийг нээхэд хүргэжээ. Энэ бүх ололт нээлтүүд нь инженер техникийн

[9] См. Poster M. The Mode of Information: Poststructuralism and Social Context. Cambridge. Polity Press, 1990.

хавсарга судалгааны үндсийг тавьж өгсөн ба тэр нь үйлдвэрлэлд нэвтэрснээр техник технологийн хувьсгалд хүргэж радио электрон аппаратууд, атомын цахилгаан станц, лазерийн байгууламж зэргийг үүсгэжээ. “Тоон субъект”-ийн статус, мөнх, мөнх бус, дижитал санамж зэрэгт илрэх ой санамжийн асуудал, шинэ мэдээллийн нөхцөлд хүний дасан зохицох тухай, электрон харилцааны ёс зүй, шинжлэх ухааны ба шинжлэх ухааны биш мэдлэгийн харилцааны зэрэг олон асуудал шинээр тавигдсан учраас мэдээллийн нийгмийн асуудал бол зөвхөн эдийн засаг, шинжлэх ухаан, социологийн судалгааны талбар төдийгүй философи эргэцүүллийн талбар болсон юм.

Зөвхөн эдийн засагт төдийгүй хүний үйл ажиллагааны бүх салбарт шинэ мэдлэгийн хэрэгцээ гарч ирж буй орчин үед нийгмийн үйлдвэрлэлийн үр ашигтай ажиллагч систем ба мэдлэгийн үйлдвэрлэл, дамжуулалт нь өндөр хөгжсөн мэдээлэл-харилцааны технологигүйгээр боломжгүй юм. Мэдээлэл, мэдлэгийг улам бүр олон хүнд шууд хүргэх боломжийг олгогч мэдээллийн хүчирхэг суурь бүтэц, мэдээлэл бол нийгмийн стратегийн нөөц болон хувирсан зэрэг нөхцөл байдлаас үзэхэд мэдлэгийн нийгэм ба мэдээллийн нийгэм хоёрын хооронд хатуу зааг байхгүй юм. Нөгөө талаар “мэдлэгийн нийгэм” хэмээх ойлголт нь мэдээлэл-харилцааны технологийн хөгжил төдийгүй үйл ажиллагааны бусад салбар дахь технологи, тухайлбал нанотехнологи, биотехнологи, цөмийн технологи, когнитив технологи гэх мэтийг өөртөө агуулж байна. Ийм учраас аж үйлдвэржсэний дараах нийгэм бол мэдлэгийн ба мэдээллийн нийгэм байна.

Зарим судлаач аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай үзэл бол нийгмийн хөгжлийн дараалсан үе шатыг илэрхийлсэн, харин мэдээллийн нийгмийн онол бол нийгмийн аливаа харилцааны үндэс суурь нь мэдээлэл болж хувирсны үр дүнд нийгмийн харилцааны системд тулгуур өөрчлөлт гарсан гэж үздэг. Мэдлэгийн нийгэм ба мэдээллийн нийгмийн онол аль аль нь шинжлэх ухаан, технологи, нийгмийн бүтэц, нийгмийн хэрэгцээний өөрчлөлт зэрэг хүчин зүйлсийн системд анализ хийсэн арга зүйгээрээ ижил юм. Хэдийгээр эдгээр онол нь нийгмийн төлөгчлөлтэй холбоотой ч ирээдүйг угтан харах гэхээс илүүтэйгээр оршин буй нийгэмд гарсан системийн шинжтэй өөрчлөлтийн учир шалтгааныг шинжлэх ухаан, технологийн дэвшилтэй холбон тайлбарласнаараа онцлог юм.

# КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН НИЙГМИЙН СЭТГЭЛЗҮЙ ЦАХИМ ОРЧИНД

**Ц.Нямсүрэн, А.Ган-Эрдэнэ, Т.Жаргалсайхан**
*АШУҮИС, Нийгмийн эрүүл мэндийн сургууль*
**М.Л.Ивлева**
*Российский Университет Дружбы Народов*

***Түлхүүр үг:*** *цахим орон зай, цахим орчин, цахим медиа, нийгмийн сүлжээ, дижитал технологи, шинэ корона вирус, цар тахал, КОВИД-19, нийгмийн сэтгэл зүй*

***Үндэслэл:*** Шинэ корона вируст халдвар (КОВИД-19)-аас үүдсэн зай барих, өөрийгөө тусгаарлах гэх мэт арга хэмжээ, мөн эдийн засгийн хямрал, ажилгүйдэл зэрэг нийгэм, эдийн засгийн нөлөөгөөр хүмүүсийн хамтын болон хувийн амьдралд олон өөрчлөлт гарч байна. Хөл хорионы үед хүмүүс цахим орчинд зарцуулах хугацаа энгийн үеийнхээс хэд дахин нэмэгдсэнээр хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээн дэх өвчний тухай мэдээлэл, түүний тодорхойгүй байдал, нийгмийн бухимдал зэргээс шалтгаалж айдас, түгшүүр, сэтгэл гутрал зэрэг сэтгэл зүйн хямралд өртөх эрсдэл (Ahmad & Murad, 2020) нэмэгдэж байна. Энэ удаагийн цар тахлын үеийн мэдэгдэхүйц нэг онцлог нь сандарсан худалдан авалт юм. Энэ нь аюулд эмзэг, мэдрэмтгий байгааг маань харууллаа (Sim, Chua, Vieta, & Fernandez, 2020).

Бидний дотоод төлөв байдал, үйл явц, араншинг илэрхийлэх хэл үгүй бол нийгмийн амьдрал үндсэндээ танин мэдэгдэшгүй болно (Gergen, 2000). Тэрхүү дотоод төлөвийг илэрхийлэх нэг хэл нь цахим орон зайд илэрч буй юм. Цахим орон зай гэдэг нь өргөн дэлгэрсэн, хоорондоо холбогдсон дижитал технологийг тодорхойлдог ойлголт боловч компьютерийн сүлжээгээр дамжин харилцаа холбоо илэрдэг төсөөллийн орчинг (Oxford Dictionary, 2020) бас илэрхийлнэ. Энэ үг интернэт, сүлжээ, дижитал харилцааны хэрэглээ эрс өссөн 1990-ээд онд түгээмэл болж, уг нэр томьёо шинээр гарч ирсэн олон шинэ санаа, үзэгдлийг төлөөлөх болжээ (Lance, 1999). Технологи өөрийгөө дотно байдлын маань архитектор болгон дэвшүүлж (Turkle, 2012), интернэт хөгжсөнөөр нийгэм нь хүмүүс хоорондын харилцаагаар бялхаж, энэ ертөнцөд тодорхой сонирхлоо хуваалцдаг, өөрсдийн онцлох шинжээ нийтийн болгож, уг сүлжээнд бусадтай харилцдаг бие хүмүүс нийгмийн сүлжээг бүрдүүлэх болжээ. Эдгээр сүлжээний хамгийн тод илрэл бол сая сая хэрэглэгчтэй фейсбүүк, твиттер зэрэг цахим хуудсууд болно. Нийгмийн энэхүү сүлжээнд Р.Декартын алдарт үг “би холбогдсон байна, иймээс оршин байна” (Gergen, 2011) гэдгээр солигдоход хүрч байна.

Фейсбүүк, твиттер зэрэг нийгмийн цахим талбар нь олон нийтийг бүрдүүлэх, алсад байгаа хамаатнуудыг холбох, мэргэжлээрээ ахихад хөшүүрэг болох, тэр бүү

хэл улсын Ерөнхийлөгчийг сонгох чадалтай хүчирхэг хэрэгсэл байхын хамт бодит байдлын талаарх хамтын үнэлэмжийг маань өөрчилсөн сэтгэл зүйн олон асуудлыг дагуулдаг. Эдгээр талбар нь олж илрүүлж, задлан шинжилж болох бүх төрлийн зан араншин байдаг газар (Sherry, 2016) болжээ. Хамгийн өргөн хэрэглэгддэг мэдээллийн эх сурвалжийн нэг болсон нийгмийн сүлжээний талбар нь хялбар, хямд хүртээмжийг бий болгосон төдийгүй тэдгээрт бүртгэлтэй олон тооны хэрэглэгч нь мэдээллийг түгээх хамгийн энгийн, бүтээмжтэй арга замыг бүрдүүлжээ (Daniel & Leonardo, 2020). Нийгмийн сүлжээн дэх олон нийтийн хайлтын хандлага, бодит байдал дээрх үйл явдлын өрнөл хооронд буй тодорхой уялдаа холбоо нь байгалийн гамшиг, спортын томоохон үйл явдал, өвчний дэгдэлт зэрэгт ихээхэн ажиглагдана (Abd-Alrazaq, Househ, Hamdi, Shah, & Alhuwail, 2020).

Цахим орон зай бол сэтгэцийн дотоод ертөнцийн маань сэтгэл зүйн гадаад өргөтгөл (Sherry, 2016) бөгөөд хүмүүс мэдээ байршуулж, шинэчлэх шаардлага нь А.Маслоугийн хүний хэрэгцээний шатлалтай нийцдэг (King University Online, 2019) төдийгүй нийгмийн ба сэтгэл хөдлөлийн чухал нөлөө бүхий (Goh, Ang, Chua, & Lee, 2009) байдаг. Нийгмийн сүлжээнд мэдээлэл хуваалцахыг эерэг эргэх холбоо, өөрийгөө хүндлэхтэй холбож (Anthony & Nicolette, 2017) бас болох бөгөөд хүмүүс ерөнхийдөө хариу хүссэн сэтгэл хөдлөлийн байр сууринаас мэдээлэл байршуулдаг. Нийгмийн сүлжээний гол мөн чанар нь харилцаан дээр төвлөрдөг тул мэдээлэл байршуулах анхдагч сэдэл нь бусадтай холбоо тогтоох гэсэн сэтгэл зүйн үүднээс гарна (King University Online, 2019). КОВИД-19 цар тахлын нийгэм, сэтгэлзүйн нөлөөг нийгмийн сүлжээний мэдээллийг ашиглан судлахад сэтгэцийн эрүүл мэндийн шинж тэмдэг хийгээд дэмжлэг илтгэх илэрхийлэл эрс нэмэгджээ (Koustuv, John, Eric, & Munmun, 2020). Нийгмийн сүлжээний идэвхтэй талбарууд нь КОВИД-19-тэй холбоотой мэдээлэл, сэтгэгдлээр дамжуулан үйл явдлыг урьдчилан таамаглах (Abd-Alrazaq, Househ, Hamdi, Shah, & Alhuwail, 2020) боломж олгож байна.

Дэлхийн 216 улс оронд бүртгэгдсэн коронавируст халдварт 2020 оны 11 сарын 08-ны байдлаар нийт 49,106,931 хүн өртөж, 1,239,157 хүн тус өвчний улмаас нас баржээ. Монгол Улсын хувьд зөөвөрлөгдсөн 362 тохиолдол бүртгэгдсэн байна (Эрүүл мэндийн яам, 2020). КОВИД-19 цар тахлаас шалтгаалан үүсэж буй нийгэм, сэтгэл зүйн сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх, түүний үр дагаврыг бууруулахын тулд нийгмийн цахим сүлжээнд байршуулсан мэдээлэл, сэтгэгдлээр дамжуулан олон нийтийн зан үйл, сэтгэл зүйн үзэгдлийг судлах шаардлагатай байна.

**Зорилго:** КОВИД-19 цар тахлын үеийн олон нийтийн зан үйл, нийгмийн сэтгэл зүйг нийгмийн цахим сүлжээгээр дамжуулан судлах

**Арга, хэрэглэгдэхүүн:** 2020 оны 1 сараас эхлэн фейсбүүк, твиттер хуудсанд монгол хэлээр байршуулсан жиргээ, мэдээлэл, сэтгэгдлүүдийг шинэ корона вирус, цар тахал, КОВИД-19 тархалт, зохиомол хомсдол, анхны тохиолдол, батлагдсан тохиолдол, тохиолдлын тоо, зөөвөрлөгдсөн тохиолдол, сэжигтэй тохиолдол, тусгаарлалт, халдвар тархах зэрэг түлхүүр үгээр шүүж, агуулгыг НВиво 11 Плас

программаар задлан шинжлэв.

**Үр дүн:** КОВИД-19 халдварын эхэн үед хөл хорио тогтоох, хүнсний бүтээгдэхүүн нөөцлөх, халдварын сэжигтэй олон тохиолдол, хөл хорио зөрчих, халдварын анхны тохиолдол зэрэг сэдвүүдэд олон нийтийн санаа бодол төвлөрч байсан бол сүүлийн саруудад эмнэлгийн мэргэжилтнүүдэд талархах, гадаадад байгаа иргэдийг авчрах, тусгаарлах зэрэг сэдэв рүү шилжсэн байна (Хүснэгт 1).

*Хүснэгт 1. КОВИД-19 цар тахлын үед сошиал хуудсаар иргэдийн дунд тархсан онцлох мэдээлэл*

| Огноо | Медиа | Хуваалцсан тоо | Сэтгэгдэл | С/+Оролцогч | Юу ярив? |
|---|---|---|---|---|---|
| 20200127 | Иргэн | 1700 | 781 | Яруу найрагч Эмүжин | Хүнсний зохиомол хомсдол үүсгэж байгаа нь буруу |
| 20200212 | Иргэн | 1000 | 217 | Шуурхай Тэгшээ | Хөл хориог 3 сарын 31 хүртэл сунгаж 2 сарын 13-наас Нийслэл өндөржүүлсэн бэлэн байдалд шилжлээ. |
| 20200310 | Pafarazzi.mn | 2100 | 1600 | УОК-ийн дарга Ө.Энхтүвшин | Монгол Улсад КОВИД-19 халдварын анхны тохиолдол бүртгэгдлээ |
| 20200413 | Tv5 Mongolia | 916 | 597 | ХӨСҮТ захирал Д.Нямхүү | 13 хүнээс КОВИД-19 илэрч батлагдсан тохиолдол 30 боллоо. |
| 20200520 | Иргэн | 477 | 495 | М.Зоригт | ОХУ-аас ирсэн оюутан ирэх замдаа халдвар авсан. |
| 20200610 | Ikon news | 353 | 513 | УОК-ийн шуурхай штабын дарга Б.Ууганбаяр | Сонгуулийн үеэр халдвар тарвал хариуцлагыг би хүлээе. |
| 20200715 | Ikon news | 77 | 138 | ХӨСҮТ захирал Д.Нямхүү | Афганистан улсаас ирсэн цэргийн албан хаагчдын 18-аас нь халдвар илэрлээ. |

Нийгмийн эрүүл мэндийн ноцтой үйл явдлын үед мэргэжлийн байгууллагын мэдээлэл тодорхойгүй, салаа утгатай байвал олон нийтийн эргэлзээ, үл итгэх байдал ихэсж, цуу яриа, шүүмжлэлд автамтгай, бусдын сэтгэгдлийг дагамхай болдог нь КОВИД-19 цар тахлын эхэн үе буюу 1-2 дугаар сард ажиглагдлаа. Тухайлбал, корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар 2020 оны 1 сарын 26-ны өдрийн Засгийн Газрын хуралдаанаас хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Энэ тухай Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

С.Амарсайхан мэдээлэхдээ ***“Зах худалдааны төвийг аль болох эрсдэл гаргахгүй байхаар зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд Онцгой комисс болон бусад бүтцээр хэлэлцэн шийдвэрлэнэ”*** хэмээн мэдэгдсэнийг medee.mn, news.mn зэрэг олон мэдээллийн хэрэгсэл ***“Зайлшгүй тохиолдолд зах худалдааны төвийн хаана”*** (Зураг 1) гэсэн гарчигтайгаар нийтэлжээ. Энэ нь олон нийтийг өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнийг нөөцлөх, сандралд оруулах нөхцөл болсон байх үндэслэлтэй.




*Зураг 1. Засгийн Газрын шийдвэрийг мэдээллийн хэрэгслүүд дамжуулсан байдал*

КОВИД-19 цар тахалтай холбоотой олон нийт хүнсний бүтээгдэхүүнийг ихээр нөөцлөх үзэгдэл хоёронтоо тохиосон бөгөөд эхний удаад албан эх сурвалжийн мэдээллийн тодорхойгүй байдал (Зураг 2) нөлөөлсөн бол анхны тохиолдол илэрсэн хоёр дахь удаад хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн ***“Шаардлагатай тохиолдолд зах худалдааны төвийг хаана”*** хэмээсэн мөнөөх мэдэгдлээс үүдсэн болгоомжлох, урьдчилан сэргийлэх зан үйлтэй холбоотой байв.




*Зураг 2. Улсын онцгой комиссын мэдэгдэл болон мэдээллийн хэрэгслүүдийн мэдэгдлийн дараалал*

Түүнчлэн болж буй үйл явц, төр, захиргаанаас гаргаж буй шийдвэр нь тодорхойгүй, ойлгомжгүй, салаа утгатай, иргэдийн ойлголтоос зөрсөн бүх тохиолдолд олон нийтийн дунд үл итгэх байдал, цуу яриа нэмэгдэж, бухимдал ихэсч байна (Хүснэгт 2). Ялангуяа хоёрдугаар сард Завхан, Баян-Өлгий, Орхон аймаг, Багануур дүүрэг зэрэг олон газар КОВИД-19 халдварын шинж тэмдэг илэрсэн, тодорхойгүй олон тохиолдлын мэдээлэл тархаж байснаас үүдэн халдварыг үнэн зөв илрүүлж байгаад эргэлзэх, айх, үл итгэх байдал үүсч байжээ.

*Хүснэгт 2. КОВИД-19 цар тахлын үед иргэдийн дунд үүсэж байсан тодорхойгүй байдал, эргэлзээ*

| № | Хугацаа | Үйл явдал | Иргэдийн дунд үүссэн эргэлзээ, тодорхойгүй байдал |
|---|---|---|---|
| 1 | 1 сар 27 | Шаардлагатай тохиолдолд зах, худалдааны төвийг хаах эсэхийг Улсын онцгой комисс болон шаардлагатай бүтцээр хэлэлцэж шийдвэрлэх тухай зарлав. | Зах, худалдааны төвийг хаах, үгүй нь үл мэдэгдэх тодорхойгүй байдалд орсон. |
| 2 | 2 сар | Сэжигтэй тохиолдлууд илэрсэн тухай мэдээлэв | КОВИД-19 халдварын сэжигтэй тохиолдол удаа дараа илэрч, бүгд хариу сөрөг гарч байгаад эргэлзэн, үл итгэж эхэлсэн. |
| 3 | 3 сар 10 | Франц улсын иргэнээс КОВИД-19 халдварын анхны тохиолдол илрэх үед тухайн иргэн хөдөө орон нутагт байв. | Халдвар авах өндөр эрсдэлтэй орноос ирсэн иргэдийг 14 хоног тусгаарлаагүй шалтгааныг иргэд гайхширч хүлээн авав. |
| 4 | 4 сар 1 | Турк улсын хоёр иргэнээс КОВИД-19-ийн халдвар илрэв. Энэ тухай ХӨСҮТ захирал мэдээлэл хийв. | Ямар эрх зүйн баримт бичигт гадны орны, дипломат албанд ажиллаж байгаа иргэдийн (элчин сайдын) гэр бүлийг нэвтрүүлэхийг заасан байдаг тухай тодорхой хэлээгүй.<br>Тэрхүү заалт нь онцгой нөхцөл байдалд үйлчлэх, эсвэл энгийн нөхцөлд үйлчилдэг эсэх нь тодорхойгүй. |
|  | 4 сар 20 | Эрсдэлийн үнэлгээгээр Монгол улс халдвар тархах эрсдэл маш өндөр гарчээ. | Ямар судалгаа хийгээд, ямар үзүүлэлтээр үнэлээд эрсдэл өндөр гарч байгааг тодорхой мэдээлээгүй. |
|  | 5 сар 31<br>6 сар 30 | Өндөржүүлсэн бэлэн байдлыг 5 сарын 31-с 6 сарын 30, 6 сарын 30-с 7 сарын 15 хүртэл сунгав. | Өндөржүүлсэн бэлэн байдлыг сунгаж, халдвар тархах эрсдэл өндөр хэмээн зарласан боловч сонгууль, наадам хийхээр төлөвлөсөн нь иргэдийн дунд эргэлзээ үүсгэв. |

| | | |
|---|---|---|
| 8 - 9 сар | Тусгаарлалт | Гадны улс орнуудаас ирж байгаа иргэдээс тусгаарлалтын зардал 1050000 төгрөг авч байгаа боловч тусгаарлаж байгаа газруудын чанар, үйлчилгээ маш их ялгаатай байгаа нь иргэдэд тодорхойгүй байдал үүсгэж байна. Мөн иргэд ямар үндэслэлээр тусгаарлалтын хоногийг 21 болгож буйд эргэлзэж, эсэргүүцэж байна. |

Телевиз болон мэдээллийн сайтуудын мэдээлэл нь иргэдийн цахим орчинд мэдээлэл авах гол эх сурвалж болж байна. Дээрх мэдээллийн хэрэгслүүдийн мэдээг иргэд цахим орчинд хуваалцах, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, сэтгэгдэл бичих байдлаар цааш түгээдэг. Үүнд хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээний гарчиг болон иргэдийн тухайн мэдээлэлд өгч буй хариу үйлдэл анхаарал татаж байна. Иргэд эерэг гарчигтай мэдээллийг эерэгээр, сөрөг гарчигтай мэдээллийг сөргөөр хүлээж авч хариу үйлдэл үзүүлдэг нь түгээмэл ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл мэдээллийн гарчиг (агуулга) болон иргэдийн хариу үйлдэл шууд хамааралтай байна (Зураг 3).  Мөн түүнчлэн иргэдийн цахим орчинд нийтэлж буй мэдээллийн агуулга эерэг, сөрөг байхаас шалтгаалан түүнийг уншсан иргэдийн сэтгэгдэл нийтэлсэн мэдээллийн хандлагатай адилхан байна. 1-р зурагт Монгол Улсад 30 дахь тохиолдол бүртгэгдсэн тухай мэдээлэлд иргэдийн хариу үйлдэл үзүүлсэн байдал. 2-р зурагт “Коронавирус илрээд биеийн байдал нь хүнд байсан хоёр хүн сайжирсан бол бусдынх нь бие тогтвортой байна” гарчигтай мэдээлэлд иргэдийн үзүүлсэн хариу үйлдэл. *Эх сурвалж: ikon.mn*




*Зураг 3. Эерэг болон сөрөг мэдээлэлд үзүүлж буй иргэдийн хариу үйлдэл*

3 сарын 10-ны өдөр Монгол улсад КОВИД-19 халдварын анхны тохиолдол илэрсэн тухай мэдээг хүлээн авсан иргэд хилээ хаагаагүй, гаднаас ирсэн иргэдийг хөл хорионд байлгаагүйд хамгийн их бухимдаж, гадаадын иргэд, албан тушаалтанд жирийн иргэдээс ялгаатай хандсан хэмээн Улсын онцгой комиссыг буруутгаж байлаа. Мөн хөл хорионд өөрийгөө тусгаарлаж байх ёстой хүн гадуур явж байсан нь иргэдийн дунд тодорхойгүй, үл итгэх байдлыг үүсгэжээ.

КОВИД-19 халдварын анхны тохиолдлын мэдээлэл болон 5 сарын 14-нд ОХУ-аас ирсэн оюутнуудаас халдвар олноор илэрсэн мэдээллийн үеийн иргэдийн

сэтгэгдлийг харьцуулж үзэв (Зураг 4). КОВИД-19 халдварын анхны тохиолдлын үеэр иргэдийн дунд үл итгэх, халдвар илэрсэн иргэнийг үзэн ядах, Улсын онцгой комиссоос шаардах, залбирах зэрэг үзэгдэл давамгайлж байсан бол 5 сарын тохиолдолд болгоомжлох, оюутнуудаа авчирсныг зөвтгөх, эмч нарт итгэх, сэтгэл санаагаар дэмжих, эерэг уриалга гаргах нь давамгайлж байжээ.




*Зураг 4. КОВИД-19 халдвар илэрсэн анхны тохиолдол болон ОХУ-аас ирсэн 55 оюутнаас халдвар илэрсэн тухай мэдээлэл дэх иргэдийн хариу үйлдлийн харьцуулалт*

Олон нийтийн дунд эрсдэл үүсэх үйлдэл хийсэн, тодорхойгүй байдал үүсгэсэн аливаа тохиолдолд олон нийтийн зүгээс үндэс угсаагаар ялгаварлах хандлага гаргаж байгаа нь ажиглагдлаа. 3 сарын 10-нд КОВИД-19 халдварын анхны тохиолдол болсон Франц улсын иргэн, тусгаарлагдаж байх ёстой хугацаандаа буюу 3 сарын 27-ны өдөр Баян-Өлгий аймгаас ирж байгаад замдаа саатуулагдсан казах иргэн, 4 сард ирсэн Турк улсын элчин сайдын гэр бүлээс халдвар илэрсэн зэрэг тохиолдлуудад тэднийг үзэн ядах, ялгаварлах хандлага өндөр байжээ (Зураг 5).

3 болон 4 сард болсон үйл явдлуудаас иргэд Турк улсын элчин сайдын гэр бүл болон Франц иргэнд иргэдийн адил шаардлага тавиагүй хилээр нэвтрүүлсэн, хөл хориондд байлгаагүй зэрэг үйл явдлыг буруутгаж, иргэдийн дунд тодорхойгүй байдал үүсгэж буй УОК болон холбогдох байгууллагуудад үл итгэж, буруутгаж байсан нь ажиглагдлаа.




*Зураг 5. Монгол улсад КОВИД-19 халдварын анхны тохиолдол илэрсэн мэдээнд үзүүлсэн иргэдийн сэтгэгдлээс*

КОВИД-19 цар тахлын үед Монголчуудын бэлгэдэлт сэтгэлгээ, аливаа зүйлд өөдрөгөөр хандах, найдах байдал тод илэрч буй нь ажиглагдав. Аливаа зүйлд муу ёрлохгүй гэдэг хандлага хүчтэй илэрч байна. Мөн КОВИД-19 халдварын анхны тохиолдол илэрсэн Франц иргэнийг дахин Монголд халдвар илрэхгүй байхыг бэлгэдэж нийтээрээ Анх-Отгон хэмээн нэрлэсэн нь монголчуудын бэлгэдэлт сэтгэлгээний тод илрэл болжээ. Эрсдэл тохиолдсон үед нутгийн уулс ус, байгаль дэлхийдээ залбиран даатгах, муу ёрлохгүй байж амны бэлгээрээ аливаа эрсдлийг сайнаар хүлээж авах хандлага иргэдийн сэтгэгдэлд багагүй хувийг эзэлж байна. Монголчуудын дунд Монголын агаар, ус, цаг агаарын онцлог нөлөөлнө. Монголчуудын хэрэглэдэг уламжлалт хүнс, малын мах чанартай учир бид дархлаа сайтай, вирус тэсэхгүй, Монголчууд халдвар авсан ч хөнгөн, хурдан эдгэнэ гэсэн итгэл үнэмшил байсан байна (Зураг 6).




*Зураг 6. Иргэдийн дунд илэрч буй эерэг хандлага, найдвар*

Иргэд өөрсдөө онцгой байдлын дэглэмийг сайтар сахиад дотооддоо халдвар гарахгүй байхад гаднаас халдвартай иргэдийг зөөж авчраад хөл хориог сунгаад байгаад бухимдаж эхэлсэн байна. Ялангуяа 4 сараас эхлэн зөөвөрлөгдсөн халдварын тоо олноор нэмэгдэх үед иргэдийн энэхүү бухимдал нэмэгджээ. Мөн үйлчилгээний газруудын үйл ажиллагаа тодорхой цагийн хязгаартай нээсэн боловч сургуулийн үйл ажиллагаа нээгээгүй нь иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэсэн байна (Зураг 7).




*Зураг 7. КОВИД-19 халдварын талаарх иргэдийн дунд тархсан мэдээллийн үгийн сонголт, давтамж*

КОВИД-19 цар тахал гарснаас хойш нийгэмд дараах нийтлэг хэм хэмжээ тогтсон нь ажиглагдлаа. Иргэд дор бүрнээ хичээж, халдвараас урьдчилан сэргийлэх дэглэм сахиж, иргэн бүр хичээж халдвар гаргахгүй байхад анхаарах ёстой гэсэн хандлага тогтжээ. Үүн дээр 2 сарын 27-ны өдөр Монгол улсын ерөнхийлөгч БНХАУ-д айлчилж ирснийхээ дараа хөл хorионд орсон нь иргэдэд улам итгэл өгч, урам зориг нэмсэн байна (Зураг 8).

Зөөвөрлөгдсөн тохиолдол бүрийг сайтар хянан тусгаарлаж, гадагш алдалгүй эдгээж байсан нь эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд итгэх итгэлийг нэмэгдүүлжээ. Энэ нь цаашлаад гадны улс орнуудаас иргэдээ авчрах үйл ажиллагааг иргэд дэмжих, иргэдээ авчраад эмчлэх нь зөв, манай эмч нар чадвартай, чадна гэдэг итгэл найдвар үүсгэсэн байна.






*Зураг 8. Монгол КОВИД-19 халдварын анхны тохиолдол илэрсэн тухай мэдээнд бичсэн иргэдийн сэтгэгдэл*

КОВИД-19 цар тахлын үеийн иргэдийн дунд тархсан мэдээллийн агуулгыг дараах сэдвүүдэд зангидаж шинжилсэн болно. Айдас, буруутгах, найдах, талархах, бухимдах, шаардах зэрэг сэдвүүд хамгийн олон удаа давтагдсан байна. Эдгээр сэдвүүд цар тахлын үеийн иргэдийн дундах харилцааны гол агуулгыг бүрдүүлж байжээ.

*Хүснэгт 4. Үүсгэсэн зангилаа сэдэв, түүний эх сурвалж, дурдагдсан тоо*

| Зангилаа сэдэв | Эх сурвалжийн тоо | Дурдагдсан тоо |
|---|---|---|
| Айх | 22 | 180 |
| Болгоомжлох | 11 | 14 |
| Буруутгах | 25 | 155 |
| Бухимдах | 12 | 75 |
| Найдах | 24 | 106 |
| Өмгөөлөх | 10 | 33 |
| Соёлын онцлог | 15 | 35 |
| Талархах | 17 | 42 |
| Тодорхойгүй байдал | 15 | 63 |
| Уриалах | 25 | 53 |
| Хардах | 18 | 40 |
| Шаардах | 18 | 47 |
| Эсэргүүцэх | 10 | 14 |

качеству от студентов Кемеровского филиала РГТЭУ в качестве проблем оценки качества образования назвали отсутствие традиции привлечения студентов к такой работе и неготовность студентов к общественной работе и независимому контролю [4. С. 65]. К этому перечню следует добавить и ряд других проблем. Дело в том, что опросы, в том числе с участием студентов, в большей степени отражают общие настроения, чем отношение к образованию. Студенты редко проявляют активность, часто ведут себя пассивно, опасаясь санкций или будучи недостаточно мотивированными для выполнения общественной работы. Очевидна неготовность студентов к выполнению оценочных функций, отсутствие программ подготовки студентов к оценочной деятельности, и ситуацию усугубляет сменяемость участников студенческих ассоциаций по окончании обучения в вузе. Еще одна проблема — степень искренности студентов при проведении опросов. К сожалению, и руководство вуза не всегда доверяет студентам или видит пользу от подобного рода мероприятий [10].

Анализ практики оценки качества образовательного процесса в нашей стране и за рубежом позволил обозначить условия и меры, обеспечивающие качество высшего образования. К ним можно отнести, в первую очередь, наличие программы, в которой система оценки качества подготовки специалистов полностью соответствовала бы задачам обучения, учитывала характеристики национальной образовательной системы и современные мировые тенденции развития образования. Важной задачей отечественного образования на будущее выступает совершенствование сферы управления высшим образованием, формирование «обратной связи» и системы оценки качества образования, развитие научно-методического обеспечения оценочной деятельности, системы стимулирования, мотивации и приобщения студентов к общественной работе, изменение роли и отношения студенчества к оценке деятельности вузов. Необходимо всячески способствовать восприятию студентами себя в этом процессе как равноправных партнеров, вести с ними прямой, открытый и конструктивный диалог, информировать о состоянии дел в образовательном учреждении, предоставлять льготы и поощрять. Эти меры окажут серьезную помощь в организации системы эффективной подготовки будущих специалистов и в приведении ее в соответствие с требованиями времени, позволят повысить качество высшего образования [7].

## Библиографический список


[1] *Абрамов В.А., Морозов И.В., Наскидашвили Д.А.* Оценка влияния качества современного образования на трудоустройство выпускников вузов // Образование и наука. 2019. № 1.

[2] *Борзов Е.В., Корягина И.И., Вотякова О.И., Курылева Н.В.* Управление качеством образования на основе мониторинговых исследований // Образование и наука. 2016. № 6.

[3] *Вишневская Н.Г.* Качество образования как индикатор конкурентоспособности выпускников вуза на рынке труда // Вестник Башкирского университета. 2015. Т. 20. № 1.

[4] *Власенко Н.Ф.* Участие студентов в системе гарантии качества высшего образования // Вестник ТГПУ. 2012. № 2.

[5] Горшков М.К., Шереги Ф.Э. Молодежь России: социологический портрет. М., 2010.

[6] *Ерофеева О.В.* Качество высшего образования: роль студенчества в процессе улучшения образовательного процесса в вузе // Вестник ПГГПУ. Серия 1. 2014. № 2–2.

[7] *Ивлева М.Л., Курмелева Е.М., Рудановская С.В.* Человек и общество в контексте современности (обзор всероссийской научной конференции с международным участием) // Вопросы философии. 2018. № 4.

[8] *Ивлева М.Л., Курилов С.Н.* Проблема формирования социальной парадигмы экоцентризма: опыт философского осмысления социологического исследования в вузе // Вестник РУДН. Серия: Социология. 2019. № 4.

[9] *Игнатьев В.П., Варламова Л.Ф., Степанов П.А.* Привлечение студентов к оценке качества образования // Современные наукоемкие технологии. 2016. № 12–1.

[10] *Калугина Д.А.* Качество содержания, процесса и результата образования глазами студентов: результаты социологического исследования // Образование и наука. 2013. № 6.

[11] Концепция Федеральной целевой программы развития образования на 2016–2020 годы (утверждена распоряжением Правительства РФ от 29.12.2014 г. № 2765-р) // URL: http://www.lexed.ru/search/detail.php? ELEMENT_ID=4264.

[12] *Кучина А.В., Воронцов Д.Б.* Участие студентов в оценке качества высшего профессионального образования // Вестник КГУ им. Н.А. Некрасова. 2008. Т. 14. № 6.

[13] *Медведева Е.А.* Анализ занятости выпускников системы высшего профессионального образования и их востребованности на рынке труда // Science Time. 2015. № 10.

[14] *Меликян А.В.* Обеспечение качества высшего образования в странах ОЭСР // Вестник международных организаций. 2008. № 7–8.

[15] *Нарбут Н.П., Троцук И.В.* Социальное самочувствие молодежи постсоциалистических стран (на примере России, Казахстана и Чехии): сравнительный анализ страхов, надежд и опасений (часть 2) // Вестник РУДН. Серия: Социология. 2018. Т. 18. № 2.

[16] *Нарбут Н.П., Пузанова Ж.В., Ларина Т.И.* Жизнь студента в европейском измерении // Социологические исследования. 2017. № 5.

[17] Норвегия: воплощение в жизнь элементов Болонского процесса // URL: https://www.hse.ru/data/2010/05/12/1217370860/15.pdf.

[18] *Павлюченко А.В.* Обеспечение гарантий качества образования в вузе с привлечением студенчества // Молодой ученый. 2015. № 11.

[19] Федеральный Закон от 29.12.2012 г. № 273-ФЗ «Об образовании в Российской Федерации».

[20] *Alaniska H., Codina E.A., Bohrer J., Dearlove R., Eriksson S., Helle E., Wiberg L.K.* Student Involvement in the Processes of Quality Assurance Agencies. Helsinki, 2006.

[21] *Cirimiunna R., Meneguzzo F., Pecoraino M., Pagliaro M.* Reshaping the education of energy managers // Energy Research and Social Science. 2016. No. 21.

[22] Embedding Quality Culture in Higher Education. A Selection of Papers from the 1st European Forum for Quality Assurance // URL: https:// www.eua.be.

[23] *Geven K.* Quality assurance is a process of growing up // Quality Assurance Review. 2010. Vol. 2. No. 1.



**Информация о финансировании**

Статья подготовлена при финансовой поддержке РФФИ. Проект № 19-511-44003 «Социальное знание: вызовы современной техногенной цивилизации»

DOI: 10.22363/2313-2272-2021-21-2-225-238

# Student assessments of the higher education (on the example of the monitoring survey of the MPEI graduates)*

**M.L. Ivleva[1], S.N. Kurilov[2], Baldo Dagtcmaa[3]**

[1]RUDN University
*Miklukho-Maklaya St., 6, Moscow, 117198, Russia*

[2]National Research University Moscow Power Engineering Institute
*Krasnokazarmennaya St., 14, Moscow, 111250, Russia*

[3]National University of Mongolia (NUM)
*Ikh Surguuliin Gudamj-1, 46a/523, 14201, Ulaanbaatar, Mongolia*
(e-mail: ivleva-ml@rudn.ru; kurilov85@mail.ru; dagzmaa@gmail.com)

**Abstract.** The authors make an attempt of solving the task of providing the students with a possibility to assess the quality of the organization and content of the higher education. The authors consider the Russian and Western practices of engaging students in such assessing activities as one of their main actors. The article identifies the most common forms of student participation in ensuring the quality of education, some of its problem areas and unused resources. Thus, the basic form of student participation in evaluation and control activities in the university is to fill out various questionnaires in order to express their assessments and opinions about the courses taken during the training period. The authors considered some relevant practices of foreign and Russian universities, in particular, the experience of the RUDN University, North-Eastern Federal University, Institute of Quality Student Commissioners of the Kemerovo branch of the RSTEU, and the Center for Applied Sociological Research of the MPEI. The article presents the results of the sociological study of opinions and assessments of the MPEI graduates in technical and social-humanitarian areas, which was conducted in 2017–2019 on the issues of basic and professional training. The monitoring study revealed a number of factors that affect the quality of practical training at the university, which allowed the authors to identify the key problems of marketing educational services by the contemporary university and to show the need to study the issues of self-realization of graduates, their demand in the labor market, and to search for new criteria for assessing the quality of higher education. The authors believe that we need a new ideology of quality management in the higher education, and propose some conditions and measures that would ensure the high quality of the higher education in Russia.

**Key words:** quality of education; higher education; students; monitoring research; university graduates; marketing of educational services; professional self-realization; criteria for assessing the quality; quality assurance

**Funding**
The study was supported by the Russian Foundation for Basic Research. Project No. 19-511-44003 “Social knowledge: The challenges of modern technogenic civilization”

## References

[1] Abramov V.A., Morozov I.V., Naskidashvili D.A. Otsenka vliyaniya kachestva sovremennogo obrazovaniya na trudoustroystvo vypusknikov vuzov [Assessment of the impact of

* © M.L. Ivleva, S.N. Kurilov, Baldo Dagtcmaa, 2021
*The article was submitted on 16.10.2020. The article was accepted on 03.12.2020.*

the quality of contemporary education on the employment of university graduates]. *Obrazovaniye i Nauka;* 2019; 1. (In Russ.).

[2] Borzov E.V., Koryagina I.I., Votyakova O.I., Kuryleva N.V. Upravlenie kachestvom obrazovaniya na osnove monitoringovykh issledovaniy [Management of the quality of education on the basis of monitoring research]. *Obrazovaniye i Nauka*. 2016; 6. (In Russ.).

[3] Vishnevskaya N.G. Kachestvo obrazovaniya kak indikator konkurentosposobnosti vypusknikov vuza na rynke truda [Quality of education as an indicator of the university graduates' competitiveness in the labor market]. *Vestnik Bashkirskogo Universiteta*. 2015; 20 (1). (In Russ.).

[4] Vlasenko N.F. Uchastie studentov v sisteme garantii kachestva vysshego obrazovaniya [Student participation in the system of ensuring the quality of higher education]. *Vestnik TGPU*. 2012; 2. (In Russ.).

[5] Gorshkov M.K., Sheregi F.E. *Molodezh Rossii: sotsiologichesky portret* [Russian Youth: A Sociological Portrait]. Moscow; 2010. (In Russ.).

[6] Erofeeva O.V. Kachestvo vysshego obrazovaniya: rol studenchestva v protsesse uluchsheniya obrazovatelnogo protsessa v vuze [The quality of higher education: The role of students in improving the university educational process]. *Vestnik PGGPU. Seriya 1.* 2014; 2–2. (In Russ.).

[7] Ivleva M.L., Kurmeleva E.M., Rudanovskaya S.V. Chelovek i obshchestvo v kontekste sovremennosti (obzor vserossiyskoy nauchnoy konferentsii s mezhdunarodnym uchastiem) [Man and society in the context of modernity (a review of the conference)]. *Voprosy Filosofii*. 2018; 4. (In Russ.).

[8] Ivleva M.L., Kurilov S.N. Problema formirovaniya sotsialnoy paradigmy ekotsentrizma: opyt filosofskogo osmysleniya sotsiologicheskogo issledovaniya v vuze [The development of the social paradigm of eco-centrism: A philosophical interpretation of the sociological research in university]. *RUDN Journal of Sociology*. 2019; 4. (In Russ.).

[9] Ignatiev V.P., Varlamova L.F., Stepanov P.A. Privlechenie studentov k otsenke kachestva obrazovaniya [Student engagement in assessing the quality of education]. *Sovremennye Naukoyemkie Tekhnologii*. 2016; 12–1. (In Russ.).

[10] Kalugina D.A. Kachestvo soderzhaniya, protsessa i rezultata obrazovaniya glazami studentov: rezultaty sotsiologicheskogo issledovaniya [The quality of the content, process and results of education in the student perspective: The results of the sociological research]. *Obrazovaniye i Nauka*. 2013; 6. (In Russ.).

[11] Kontseptsiya Federalnoy tselevoy programmy razvitiya obrazovaniya na 2016–2020 gody [Concept of the Federal Target Program for the Development of Education for 2016–2020] (utverzhdena rasporyazheniem Pravitelstva RF ot 29.12.2014 g. No. 2765-r). URL: http://www.lexed.ru/search/detail.php? ELEMENT_ID=4264. (In Russ.).

[12] Kuchina A.V., Vorontsov D.B. Uchastie studentov v otsenke kachestva vysshego profes-sionalnogo obrazovaniya [Student participation in assessing the quality of higher professional education]. *Vestnik KGU im. N.A. Nekrasova*. 2008; 14 (6). (In Russ.).

[13] Medvedeva E.A. Analiz zanyatosti vypusknikov sistemy vysshego professionalnogo obrazovaniya i ikh vostrebovannosti na rynke truda [Analysis of the employment of the higher professional education graduates and demand for them in the labor market]. *Science Time*. 2015; 10. (In Russ.).

[14] Melikyan A.V. Obespechenie kachestva vysshego obrazovaniya v stranakh OESR [Ensuring the quality of higher education in OECD countries]. *Vestnik Mezhdunarodnykh Organizatsiy*. 2008; 7–8. (In Russ.).

[15] Narbut N.P., Trotsuk I.V. Sotsialnoe samochuvstvie molodezhi postsotsialisticheskikh stran (na primere Rossii, Kazakhstana i Chekhii): sravnitelny analiz strakhov, nadezhd i opaseniy [The social well-being of the post-socialist countries' youth (on the example of Russia, Kazakhstan and Czech Republic): Comparative analysis of fears and hopes (part 2)]. *RUDN Journal of Sociology*. 2018; 18 (2). (In Russ.).

[16] Narbut N.P., Puzanova Zh.V., Larina T.I. Zhizn studenta v evropeyskom izmerenii [Student life in the European dimension]. *Sotsiologicheskie Issledovaniya*. 2017; 5 (In Russ.).
[17] Norvegiya: voploshchenie v zhizn elementov Bolonskogo protsessa [Norway. Implementation of the Bologna process elements]. URL: https://www.hse.ru/data/2010/05/12/1217370860/15.pdf. (In Russ.).
[18] Pavlyuchenko A.V. Obespechenie garantiy kachestva obrazovaniya v vuze s privlecheniem studenchestva [Ensuring the quality of university education with the student participation]. *Molodoy Ucheny*. 2015; 11. (In Russ.).
[19] Federalny Zakon ot 29.12.2012 g. No. 273-FZ "Ob obrazovanii v Rossiyskoy Federatsii" [Federal Law from December 29, 2012 No. 273-FZ "On Education in the Russian Federation"]. (In Russ.).
[20] Alaniska H., Codina E.A., Bohrer J., Dearlove R., Eriksson S., Helle E., Wiberg L.K. *Student Involvement in the Processes of Quality Assurance Agencies*. Helsinki; 2006.
[21] Cirimiunna R., Meneguzzo F., Pecoraino M., Pagliaro M. Reshaping the education of energy managers. *Energy Research and Social Science*. 2016; 21.
[22] Embedding Quality Culture in Higher Education. A Selection of Papers from the 1st European Forum for Quality Assurance. URL: https:// www.eua.be.
[23] Geven K. Quality assurance is a process of growing up. *Quality Assurance Review*. 2010; 2 (1).

## ХАВСРАЛТ 9. ФИЛОСОФИ, ШАШИН СУДЛАЛ СЭТГҮҮЛИЙН 25 (580) ДУГААРЫН ӨГҮҮЛЛҮҮД

Сэтгүүлийн редакцийн тодорхойлолт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
**ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ**

14201 Улаанбаатар хот-46а ш/х-330, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 47, Утас (976-11) 32-54-35,
E-mail : sas@num.edu.mn, http://sas.num.edu.mn

2023/01/26 № ____________

танай ____________-ны № ____________-т

**Тодорхойлолт**

МУИС-ийн “Философи, шашин судлал” сэтгүүлийн 2023 оны дугаарт “Нийгмийн ухаан: орчин үеийн техноугшилт иргэншлийн сорилтууд” хамтарсан төслийн зүгээс доктор (ScD), профессор Ц.Гомбосүрэнгийн "Монголын хөгжлийн философийг боловсруулж буй үр дүнг шинжлэх нь", Философи шашин судлалын тэнхимийн доктор (PhD), дэд профессор Ц.Нямсүрэн нарын “"Эрх мэдлийн зарим илрэл"” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллүүд ирүүлснийг тус сэтгүүлийн редакцийн зөвлөл уншиж, хянаад дугаарт хэвлэхээр шийдвэрлэсэн болно.

Сэтгүүлийн дугаар хичээлийн жилийн төгсгөлд буюу 5 дугаар сарын сүүл, 6 дугаар сарын эхээр хэвлэгддэг журамтай.

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН
“ФИЛОСОФИ, ШАШИН СУДЛАЛ”
СЭТГҮҮЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.МӨНХЖАВХЛАН

My.Doc.a.bich. p. 1

# Монголын хөгжлийн философийг боловсруулж буй үр дүнг шинжлэх нь

**Ц.Гомбосүрэн**

МУИС. Философи, шашин судлалын тэнхим

***Түлхүүр үгс:*** *Асуудалд хандсан монист аргазүй. Асуудалд хандсан плюралист аргазүй. Улсын төслөөр Монголын хөгжлийн философи (МХФ)-ийг боловсруулсан нь, түүний гол төлөөлөгчийн онол.*

***Товч утга:*** *Манай философичид Монголын хөгжлийн философийг авч үзсэн арга зүйн монист (түгээмэлчлэгч) ба плюралист хоёр хэв маягт хуваагдаж байгааг энэ өгүүллийг зохиогч түүнийхээ удиртгал (оршил) хэсэгт онцолсон болно.*

*ШУА-ийн философийн хүрээлэнгээс хэрэгжүүлсэн Монголын хөгжлийн философийг боловсруулах улсын төсөлт ажлын үр дүнд хийсэн анализ энэ өгүүллийн үндсэн агуулгыг бүрдүүлэв. Тус анализаар дараах зарим дүгнэлтэд зохиогч хүрсэн байна. Үүнд:*

*1. Тус философийн хүрээлэнгийн энэхүү төсөлт ажил “хөгжил бол найрсал мөн” гэдэг практик утгатай томъёолол дэвшүүлж, гэхдээ бас философийн хувьд эцсийн эцэст марксист-ленинист онолыг, нэн түрүүнд түүний диалектикийг арга зүйгээ болгожээ.*

*2. Тус хүрээлэн энэхүү хувилбараа түгээмэлчилсэн монист байр суурийг сурталчилсан байна.*

*3. 1990-ээд оноос хойш философичдын маань нэлээд хэсэг болбоос хөгжлийн тухай асуудлыг авч үзэхдээ диалектик арга зүйгээс татгалзсан бөгөөд гэтэл диалектикийг туушитай сурталчилж байгаа хэсэг нь хүртэл хөгжил гэж юу болохыг тайлбарлахдаа тэрхүү арга зүйгээ баримтлахгүй буй тохиолдол цөөнгүй юм. Өгүүллийг зохиогч эдгээр дүгнэлтээ холбогдох баримтуудад үндэслэсэн болно.*

*4. Өгүүллийг зохиогчийн үзлээр бол Монголын хөгжлийн философийн өөр өөр хувилбар боловсруулах бололцоо манай үндсэн хуулиар нээлттэй бөгөөд тэдгээр хувилбарын аль нэгийг туйлчилж, бусдынх нь дээр өргөмжилбөл үзэл санааны плюрализмд харшилна*

***Abstract:*** *In the introduction part, the author emphasized that the method of our philosopher, who focuses on the Mongolian Development Philosophy, has been divided into monist and pluralist approaches.*

*The main body of the article is an analysis of the Philosophy Institute of Mongolian Academy of Sciences' attempt to formulate Mongolian Development Philosophy. As a result of this investigation, the author came to the following conclusions:*

1. *The Philosophy Institute's project promoted a practical motto, 'Development is Harmony'; however, the project eventually adopted Marxist-Leninist theory, particularly dialectics, as a method*
2. *The Institute advocated for a universal monist approach in their version.*
3. *From 1990, the majority of our philosophers departed from the dialectic method, yet in the project section, there was strong support for dialectics. But they did not consistently follow dialectics when explaining what development is. The author made this argument by presenting relevant facts.*
4. *The Mongolian Constitution allows for the formulation of many versions of Mongolian Development philosophy, but according to the author highlighting only one version and elevating it above others would be incompatible with pluralism.*

**ОРШИЛ. Асуудалд хандаж буй аргазүйн ялгаа**

1990 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурал чуулганаараа Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) бол төр, нийгмийг удирдан чиглүүлэгч цор ганц хүчин болох онцгой эрх олгосон 1960 оны Үндсэн хуулийн заалтыг хүчингүй болгож, улмаар 1992 онд баталсан Монгол улсын Үндсэн хууль ёсоор манай орон олон намын тогтолцоот парламент (Улсын Их Хурал), зах зээлийн эдийн засаг бүхий бөгөөд үзэл санааны олон ургальч зарчмыг (плюрализмыг) сахьдаг улс болох замд орсноор Монголын философийн амьдралыг хуучин тогтолцооны үеийнхээс нь өөр гүйцэтгэл (роль)-тэй болгож буй нь ойлгомжтой. Тэгээд улс орныхоо туулж ирсэн түүхийг үнэлэх болон өнөө ба ирээдүйнх нь хөгжлийг хэрхэн хангах арга зам зэрэг асуудалд манай философичид ийм шинэ нөхцөлд анхаарлаа хандуулж эхэлсэн юм. Гэхдээ онолын боловсруулалт хийсэн үр дүн нь өөр өөр агуулгатай байна.

Анхны мэдэгдэхүйц үр дүнг Н.Хавхын бүтээлүүд бий болгосон юм[1]. Тэрээр философийг шинжлэх ухаан гэж үзэж байгаа учраас, тэгээд бас түүхийн материализм бол ямар ч улс үндэстний хөгжлийн аль ч шатанд үйлчилдэг түгээмэл зүй тогтлыг илрүүлэн тайлбарладаг гэж үнэлдгээрээ гагцхүү түүнийг л орчин үеийн тэргүүлэгч тийм нийгмийн тухай философи хэмээн үзсэн байдаг. Гэхдээ тэгэнгээ хүн төрөлхтний ирээдүй Азид хамаарна гэдэг (хэрэг дээрээ үгүйсгэлийн үгүйсгэлийн тухай Гегелийн диалектик онолын дагуу байдаг) О.Шпенглерийн үзэл, бас Л.Н.Гумилевийн дэвшүүлсэн пассионари (эрчимт хүчний) онол зэргээр диалектик аргазүйдээ хүч сэлбэсний үндсэн дээр нийгэм-эдийн засгийн формацийн тухай марксист-ленинист сургаалыг, түүний дотор коммунист формацийн тухай онолыг нь шинжлэх ухааны доктор (Sc. D.)-ын зэрэг горилон бичиж хамгаалсан диссертаци зэрэг бүтээлүүддээ Н. Хавх зөвтгөн сурталчилсан буй.

[1] Энэ тухай өгүүлсэн анхны нэг бүтээл нь: Н.Хавх. Азийг зорьсон хүн төрөлхтөн. - Бодрол, бясалгал. 1991, №8.

Үүний зэрэгцээ нийгмийн тухай философийн талаарх Н.Хавх нарын үнэлгээг агуулга, арга зүйн хувьд үл зөвшөөрдөг байр суурийг манай зарим философич илэрхийлж иржээ. Жишээ гаргая. «Нийгмийн хувьсах, хөгжих объектив хууль, зүй тогтлуудыг нээсэн гэгдсэн нийгмийн марксист философи нь бараг тив болгонд туршигдаж нийгмийн практикаар няцаагдлаа. Нээгдсэн хэмээгдсэн "хуулиуд" нь түгээмэл зүй тогтол ч биш, объектив шинж чанар ч биш, хар аяндаа, сулдаа нийгмийг эрүүлжүүлж, бүх нийтэд жаргалант байдлыг … бэлэглэж байдаг обкъектив хүч, хамаарал ч биш болох нь нотлогдлоо»[2] хэмээн Д.Чулуунжав тайлбарладаг юм. Арга зүйн хувьд түүний үзэлтэй нийцэх байр суурийг өөр зарим философич 1990-ээд оны эхэн жилүүдээс илэрхийлж иржээ. Тухайлбал Д. Дашпүрэв монголын уламжлалт нийгмийн гол гол онцлог, 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалаас хойших үеийн Монголын нийгмийн модернизацийн шатууд зэрэг асуудлаар тасралтгүй судалгаа явуулж, улмаар олон өгүүлэл нийтлүүлсэн төдийгүй шинжлэх ухааны доктор (Sc. D.)-ын зэрэг хамгаалсан диссертаци бичин, түүндээ үндэслэсэн ном мөн "Монголын нийгэм (философийн анализ)" гэдэг нэг сэдэвт бүтээл тус тус туурвин хэвлүүлсэн юм.

Бас Ц.Гомбосүрэнгийн нийтлүүлсэн "Олон ургальч үзэл", "БНМАУ дахь нийгмийн байгуулал, түүнийг дэвшилттэйгээр хувирган өөрчлөх асуудал"(Ц.Ренчинбямбын хамт), «"Нийгмийн ахуй, нийгмийн ухамсар" гэдэг категориудын хуурамч ба бодит агуулгын асуудал», "Монголын нийгмийн хөгжлийг авч үзэх арга зүйн асуудал" зэрэг өгүүллүүд ба "Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү" (1995), "Нийгмийн тухай философийн интеграль (нэгтгэгч) хувилбарыг боловсруулах эхлэл(онол, аргазүйн асуудал)" зэрэг нэг сэдэвт зохиол бол онолын тайлбар болон арга зүйн зарчмуудаараа түүхийн материализмын өөрийгөө л түгээмэлчлэгч онол, арга зүйгээс татгалзсан үр дүн болж байдаг. Түүний эдгээр болон өөр олон бүтээлд нь онолын сэтгэлгээнд олон ургальч үзэл нэвтрэн баримтлагдахын ач холбогдлыг дурдаж, түгээмэл арга зүйн тухай диалектик сургаал манайд шүүмжлэгдэх болж буйн практик үндэслэгээнүүд гаргаж, "феодализм" гэдэг нийт хүн төрөлхтний хүчинтэй формаци байдаггүй гэсэн онолын ба түүхийн нотолгоонууд өгүүлсэн байна.

Манай философичдын баримталдаг аргазүйн монист ба плюралист ийм ялгааны нэг шалтгаан нь философийг ямар мэдлэг гэж тэд ойлгож байгаатай нь уялдаж иржээ. Үүнд, 1990-ээд оноос өмнөх олон арван жил дэх коммунист дэглэм бүхий монгол улс марксизм-ленинизмийг эрх баригч нам-төрийн нэгдмэл бодлого ба үйл ажиллагааныхаа албан ёсны үзэл суртал болгож, түүгээрээ ард түмнээ дагнан хүмүүжүүлж ирсэн билээ. Энэ нь 1960 онд батлагдсан БНМАУ-ын үндсэн хуулинд: МАХН бол бүхнийг ялагч марксист-ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгоно хэмээн тунхагласны хэрэгжилт болж ирсэн юм. Улмаар эрх баригч МАХН-ын 1966 онд батлагдсан программд:

[2] Д.Чулуунжав. Нийгмийн философи: Онол, туршилт, сургамж, шүүмж. УБ., 11 дэх тал

намаас хөдөлмөрчдийг "социализмд үнэнч байх үзэл, ертөнцийг үзэх марксист-ленинист үзлээр улам бүр хүмүүжүүлнэ" хэмээн энэ заалтыг бататгасан юм.

Тэгвэл тэр үеийн Монголын нийгмийн оюуны амьдралд дангаар ноёрхож байсан тийм уур амьсгалын нөлөөнөөс ямар нэг шалтгаанаар ангижирч чадаагүй өнөөгийн манай олон олон нэр хүндтэн цор ганц шинжлэх ухаанч хэмээн өөрийгөө онцолсон диалектик материалист философийг санаатай санаандгүй алинаар ч бай тухайлсан байгаа. Гэтэл бүр Гегелийн үед, ялангуяа онцгой нөлөө ба өргөн дэлгэрэлтийг нь тооцвол XIX зууны 30-40 онуудаас хойш үүссэн бүх философи болбоос өөрийгөө зөвхөн сэтгэхүйн (рациональ) үр дүн гэж үзэлгүйгээр, харин мэдлэг бол хэл, мэдрэмж зэрэг иррациональ зүйлсийн аль нэгээр юм уу зарим хэдийнх нь уялдаагаар үүсдэг гэж үзжээ. Ийм иррационалист үзлийн үүднээс бол аливаа философи, тэдгээрийн дотор өөрийгөө шинжлэх ухаан гэдэг философи бол угтаа онолын төвшний үнэлэмж, тодруулж хэлбэл хүн төрөлхтний үйлдлүүдээс онцолсон аль нэгд юм уу зарим хэдэд нь л хүчинтэй онол мөн. Энэхүү онолын үнэлэмжийн ("value theory-теория ценностей" гэдгийг ингэж орчуулах нь "үнэлэмжийн онол" хэмээн орчуулдгаас хэлзүйн хувьд оновчтой юм уу гэж боддог болов) аливаа чиглэл болбоос шинжлэх ухаан, шашин, урлаг зэрэг мэдлэгийн бусад төрлийн хүрээнд боловсруулсан онолоос юугаараа ялгаатай вэ? гэвэл: философи бол өөрийнхөө ололтоос төдийгүй мэдлэгийн бусад төрлийн холбогдох онолоос төрж, хөгждөг онол мөн. Тиймээс мэдлэгийн аливаа төрөл бол бусдаасаа илүү, дээд ч биш, бас дутуу, доогуур ч биш, харин өөр өөрийн гэсэн гүйцэтгэл бүхий байж, философийг шинжлэх ухаан хэмээн өргөмжилсөн дүр эсгэх илүүц байдаг (манай нэр хүндтэнгүүд философийг шинжлэх ухаан хэмээн зарладаг нь хэвээр байгаа тул тэдний нүд, чихэнд чийр болгохын тулд биш, харин үе үеийн залууст нөлөөлөхийн тулд боломжтой олон бүтээлдээ ийм тайлбараа би давтаж ирэв).

Манайд хөгжлийн талаар, тухайлбал Монголын хөгжлийн талаарх асуудлыг авч үзэхдээ уг асуудлаа диалектик онолыг бусад хэв маягийн философи зарим баримтлалтай болон шинжлэх ухааны зарим салбарын онолтой холбон арга зүй болгодог өөр ч зарим философичийг Н.Хавхаас гадна дурдах бололцоотой. Тухайлбал:

- Г.Лувсанцэрэн бол буддизм дахь мадхъямика (төв үзлийн гүн ухаан)-д байдаг хоосон чанарын тухай шашны, өөрөөр хэлбэл эзотерик мэдээг "Платоны эйдос, Демокритийн атом, Гегелийн туйлын санаа, Марксын материтай нэгэн эрэмбийн ухагдахуун"[3] хэмээн бичсэн нь марксизмын диалектикийг болбоос нийгмийг судлан тайлбарлах аргазүй болгож ирсэн практикаа аяндаа хадгалж ирснийх нь нэг гэрч болдог юм. Түүний эл философидолтын үндсэн дээр 1990-ээд онуудын эхний жилүүдэд МАХН (одоогийн нэрээрээ МАН) хутагт Нагаржунагийн гүн ухааныг улс төрийн бодлого, үйл ажиллагааныхаа арга зүй болгон тунхаглаж байсан удаатай.

---

[3] Г. Лувсанцэрэн. "Төв үзлийн философийн онолын үндэс. УБ., 2009" номондоо(тухайлбал 33 дахь талд) энэ тухай дэлгэрэнгүй бичсэн буй.

Тэрээр бас хоосон чанар бол чанад, үнэмлэхүй чанар мөн хэмээн төв үзлийн (мадхъямика) гүн ухааны дагуу зүйтэй бичсэн атлаа энэхүү эзотерик мэдээг (зохиогч би хувийн бодлоо илэрхийлэхэд үнэхээр хоосон чанар гэж байдаг бол) орчин үеийн шинжлэх ухаан нотолж чадна гэжээ.

- Г.Чулуунбаатар: "…шинжлэх ухааны диалектик, төв үзлийн гол зарчмын үүднээс хөгжил бол аливаа юмс үзэгдлийн зөрчилт олон талын шилжимтгий харилцаа, тэдгээрийн шүтэн барилдах зохицол, тэнцэл юм гэж үзэж болмоор байна. Энд яригдаж буй зохицол, тэнцэл бол ямар нэг тогтсон төлөв байдлын ойлголт биш, харин мөнхийн өөрчлөлт, хөдөлгөөний түгээмэл шинжийн тухай ухагдахуун юм. Хөгжлийн талаарх иймүзэл нь нийгмийн дэвшлийн үйл явцыг тайлбарлах шинэ арга зүй болж чадах үндэстэй"[4].

- Хэгелийн "харьцангуй чанар" гэдэг ойлголттой нь төв үзлийн "хоосон чанар" хэмээх ухагдахуун тэнцэх бололтой[5] гэж Ч.Ган-Өлзий үзэж байна.

1990-ээд онуудаас хойш ШУА-ийн Философийн Хүрээлэнгийн философи үйл ажиллагааг онолын нөлөө, аргазүйн сонголтоороо түүчээлцгээж байгаа гэж миний хувьд боддог энэ 3 академичийн бүтээлүүдэд би хүндэтгэлтэй хандаж, тэдгээрийг сургалтандаа ашиглаж, зөндөө иш татдаг билээ. Харин дээр дурдсан ишлэлүүдэд буддын шашин, энэ шашнаас уг сурвалжтай төв үзлийн гүн ухаан зэрэг дэх "хоосон чанар (шунъяата)" гэдэг нэр томъёогоор илэрхийлдэг эзотерик мэдээг иргэний зарим философийн ойлголттой болон диалектикийн зарим үндэслэлтэй мэргэжлийн биш байрнаас, формаль логикийн холбогдох дүрэм, шаардлагуудыг зөрчин байж зохиомлоор адилтгасан байна (уг нь: хоосон чанарыг үгээр илэрхийлэх аргагүй хэмээн номтой лам нар өгүүлсэн байдгийг Лууяа багш даган дурдсан байдагсан).

Гэхдээ эдгээр философич нар дээр ишилсэн дэх санаануудаа нийгмийн хөгжлийг авч үзэх аргазүй болгож гавиагүй нь миний бодлоор бол аргагүй юм.

## ӨГҮҮЛЛИЙН ҮНДСЭН АГУУЛГА

Эдүгээгийн нөхцөл дэх эх орныхоо хөгжлийн асуудлыг философи үндэстэй авч үздэг байхад ШУА-ийн Философийн хүрээлэн мэргэжлийн байгууллагын хувьд анхаарлаа чухалчлан хандуулж ирлээ. Тус хүрээлэн 2012-2014 оны хугацаанд "Монголын хөгжлийн философи" сэдэвт суурь судалгааны төсөлт ажил хэрэгжүүлсэн юм. Тэр ажлын тандан судалгаа нь болсон байж магадгүй зарим чухал арга хэмжээг ФХ зохион байгуулжээ. Үүнд: А. Цанжид, Т. Намжим зэрэг эрдэмтэд 1990-ээд оноос хойших Монгол улсын хөгжлийн бодлогын асуудлаар тавьсан илтгэлийг хэлэлцэж, 3 удаа тусгайлсан илтгэгчгүй чөлөөт ярилцлага өөрийнхөө хүрээлэн, МУИС зэрэг газар зохион байгуулсан юм.

[4] Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. УБ., 2011, 51 дэх тал

[5] Батын Ч.Ган-Өлзий. Хүмүүнлэгийн гурван ертөнцийн гоц чанарыг судлахуйн чандмань эрдэнэ. УБ., 2011, 21-22 дахь талд энэ тухай үзнэ үү.

Энэ 3 ярилцлагад оролцогсдын олон олон санал, дүгнэлтийг дараах хэдэн бүлэгт хувааж болохоор юм. Үүнд:[6]

- *Г.Чулуунбаатар, Б.Даш-Ёндон* нар: өнөөдөр манайд 1990-ээд оноос өмнө нь байсан бүх юмаа устгаад, сөнөөгөөд оронд нь огт байгаагүй юмыг бий болгох гэж учир утга муутай өөрчлөлт шинэчлэл гээч юм хэрээс хэтрээд байна. Өмнөх үед ашигтай юм, хэрэгтэй юм байв уу, залгамжлагдах юм байв уу гэдгийг олж харах сонирхол нийгмээрээ байхгүй болсон. Хөгжил бол залгамж холбоо, тасардаггүй үйл явц гэдгийн философи үндэслэгээг гаргах нь бидний судалгааны нэгэн зорилго.

Хөгжил бол оюун ухаанд түшиглэдэг үйл явц. Гэтэл өнөөгийн манай нийгэм хүмүүсийг мөнгөнөөс өөр юм бодохгүй болгоход аажмаар түлхээд байна. Хүнийг хүн болгодог юм нь үнэлэмж, соёл, ёс зүй. Тэрийг нь аваад хаячихвал хүн чинь үндсэндээ адгуснаас ялгарах юмгүй тул хүнлэг ухаалаг шинжийг нь бүдгэрүүлээд байгаа тэр хүчин зүйлийг яаж хязгаарлах ёстой вэ гэдгийн философи үндэслэгээ гаргахад бидний ажлын бас нэг зорилт оршино.

Эцсийн эцэст монгол хүний оюун ухаанаар төр, улсаа удирдахад юу хэрэгтэй вэ? гэдэг асуултанд философийн үүднээс хариулт өгөхөд бидний энэ ажил мөн чиглэгдэх учиртай.

- *Б.Даш-Ёндон, Ч.Хурц, Г.Чулуунбаатар, М.Золзаяа:* Монгол улсын хөгжлийн философи нь Үндсэн хуулиа тулгуур үндэслэл болгосон улс төрийн онол, номлол байж, манай хөгжлийг хөтлөгч байх болно. Хүрээлэнгийн энэ төсөлт ажлыг бид хийж чадвал аль ч улс төрийн хүч засгийн эрхэнд гарлаа, аль ч нам хөтөлбөрөө боловсруулла гэхэд энэхүү хөтлөгч улаан шугамыг барьдаг байх ёстой юм. Тэгснээрээ нийгмийн өнөө үе дэх задралуудыг нэг голдрилд оруулж, улсаа хөгжүүлж чадна. Монголын хөгжлийн философи нь улс орондоо болон нийт хүн төрөлхтөнд хүлээн зөвшөөрөгдсөн оюуны үнэт зүйлийн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэнэ. Хөгжлийнхөө үзэл баримтлалыг боловсруулах философи арга зүйн асуудал байх ёстой.

- *Р.Батмэнд, Д.Рэгдэл, С.Цэдэндамба, Ш.Ганхуяг, Ш.Ариунаа, С.Даваадулам*: Хөгжил бол маш олон талт үйл явц. Монголынхоо хөгжлийг энэ байр сууринаас харах ёстой. Ганц эдийн засгийн үүднээс биш. Үндэсний аюулгүй байдал, хүний хөгжил, боловсрол, мэдлэгийн эдийн засаг, албан ардчиллыг (өөрөөр хэлбэл ардчиллын үнэт зүйлсийг жинхнээр) хэрэгжүүлэх, шинжлэх ухаан ба технологийн ололт, эрүүл мэнд гэх мэт (хэлэлцүүлэгт оролцогч бүр эдгээр хүчин зүйлийг бүгдийг биш, харин заримыг нь л авч үзсэнийг нэгтгэн тоочив).

[6] Энэ тухай: Философи, эрх зүйн асуудал. XXVIII боть. ШУА-ын ФСЭХ. УБ., 2013. 5-100 дахь талд үзнэ үү. Бүлэглэлийн маань үндэс нь хэлэлцүүлэгт оролцогчдын илэрхийлсэн үзэл бодлын болон арга зүй баримтлалын ойролцоо ба адил хандлага болж өгөв.

- *А.Цанжид болон бусад:* Монголын хөгжлийн бодлогын арга зүйг тодорхойлох ёстой болов уу. Тэр нь байхгүй учраас л манай 1990-ээд оноос хойших бүх хөтөлбөр нь салбар салбарын сонирхолд хөтлөгдсөн мөрөөдлийн жагсаалтууд болжээ. Ерөнхий арга зүйн асуудалд нэгдүгээр байранд Монгол улсын аюулгүй байдал, ард түмний эв нэгдэл хоёр байхаар юм. Боловсрол, эрүүл мэнд, уул уурхайн ба хөдөө аж ахуйн асуудал гэх мэт бол бүгд энэ хоёртой холбогдоно.

- *Т.Дорждагва, Б.Гантөмөр:* Нийгмийн хөгжлийн янз бүрийн чиг хандлагаас философичид хоёрыг нь онцолдог. Нэг нь шугаман хөгжлийн загвар мөн. Энэ загвар европ төвт үзэлтэй холбоотой. Бусад ард түмэн Европын хөгжлийн араас мацаж маажих ёстой гэдэг загвар юм. Түүнээс сурах юм их тул муулах үндэсгүй. Нөгөөдөх нь орчилт хөгжлийн загвар мөн. Энэ загвар бол ард түмэн бүрийн соёлын тэгш байдлыг зөвшөөрдөг.

Тогтвортой хөгжлийг олон үндэслэлээр ярих ёстой.

- *Ц.Гомбосүрэн ба бусад:* “Монголын хөгжлийн философи” гэж яривал хоёр утга гараад байна. Нэг нь, яаж хөгжиж ирснээ философийн үүднээс дүгнэх. Нөгөөх нь, танай төслийн ажлын “хөгжлийн тухай үзэл баримтлал” гэсэн утгатай. Жишээ нь “аж үйлдвэржсэн нийгэм”, “аж үйлдвэржсэний дараах нийгэм” гэх мэт нийгмийн философи баримтлалууд бол урьдчилж хэлсэн зөгнөлүүд биш, харин нийгмийн хөгжлийн хүрсэн үр дүнгийн талаарх дүгнэлтүүд байдаг. Социологийн ерөнхий онолын үүднээс буюу нийгмийн философийн үүднээс ингэж философидож үр дүнг илэрхийлж бий болсон философи онолууд бол алдсан ч хохирол бага гаргадаг юм байна. Ирээдүйд ийм тийм сайхан нийгэм бий болгоно гээд философидон, одоо л бид нэг сүрхий онол гаргалаа гэж бодоход тэр нь коммунизмын тухай Маркс, Энгельсийн онол шиг сүрхий биш юмаа гэхэд ноцтой алдаа гаргах эрсдэлтэй байж магадгүй юм. Ирээдүйг урьдчилан харна гэдэг бол нэлээд тохиолдол, нөхцөлд их зөгнөлийн чанартай асуудал, гэтэл философид зөгнөл гол биш. Харин шинжлэх ухаан бол бодит урьдчилан харахуйтай байж чаддаг бололтой. Зарим философи хэдийгээр зүй тогтол гээд ярьдаг ч гэсэн хэрэг дээрээ нийгмийн амьдралд эерэг сөрөг, санаанд оромгүй тохиолдол дүүрэн байдаг. Сайн ч бай, муу ч бай, азтай ч бай, азгүй ч бай монголын хөгжлийн ирээдүйн асуудлыг боловсруулахад философитой харьцуулахад шинжлэх ухаан, эзотерик мэдлэг хоёр илүү гүйцэтгэлтэй байж таарна. Учир нь, философи бол үнэлэмжийн онол бөгөөд гаргасан дүгнэлт нь тодорхой үйлдэлд ба нөхцөлд л хүчинтэй байдаг.

- *Ц.Цэцэнбилэг.* Модернизацийн эсрэг онолууд XX зууны сүүлээс олон гарч байна. “Хөгжил” гэдэг ухагдахуун ялангуяа социологид их шүүмжлэгдэж, хэрэглэгдэхээ больж байна. “Нийгмийн хөгжил” гэдэг ойлголтын оронд “нийгмийн өөрчлөлт” гэдэг нэр томъёо гарч ирсэн.

Хэлэлцүүлэг дээр гарсан арга зүйн ач холбогдолтой байж чадах гол гол дүгнэлт ба саналыг ФХ-ийн эрхлэн гаргадаг “Философи, эрх зүй” сэтгүүлийн XXVIII (2013)-д гарсан нийтлэлийн агуулгаас тоймлон илэрхийлэхэд ийм юм.

Философийн хүрээлэнгийн энэхүү төсөлт ажлын агуулга, арга зүйг тодорхойлогч нь доктор(Sc. D.), профессор, Монгол улсын ардын багш Даш-Ёндон (Даашка багш мөн). Түүний бичсэнээс дурдахад «Монгол Улсын ШУА дэмжсэнээр «манай хүрээлэн "Монголын хөгжлийн философи" сэдэвт суурь судалгааг 2012-2014 онд хэрэгжүүлэхээр шийдэгдсэн юм.

Энэ суурь судалгаанд миний бие оролцож, төлөвлөгөөний дагуу "Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). УБ., 2017" гэдэг энэхүү ганц сэдэвт зохиолыг бичлээ"»[7] хэмээн мэдээлээд "…хөгжлийн философи нь үзэл баримтлалаа практикт, өөрөөр хэлбэл, салбарын бусад бодлогод тулгах бус, харин судалгааны үндсэн дээр практикаас урган гарч, практикт эргэж нөлөөлөх үүрэгтэй"[8] гэжээ. Гэтэл хүмүүсийн хөдөлмөр, зохих туршлага, оюуны чиглэсэн их чармайлт болон багагүй хөрөнгөөр бүтсэн Монголын хөгжлийн философи ямар үнэ цэнэтэй байх талаар Даашка маань үнэлгээ өгөхдөө нэг болохоор "…хөгжлийн философи албан ёсны баримт бичиг болж боловсрогдохгүй"[9] гэсэн атлаа нөгөө талаар "үзэл санаа нь дэлгэрэн тархаж, *заавал* ашиглагдах ёстой"[10]. "Хөгжлийн философийг боловсруулан төрийн бодлогод хэрэгжүүлэхэд Үндсэн хуулийн хэрэглээ нэн чухал юм"[11] гэх мэтээр бичжээ. Заавал ашиглах юм бол төрийн баримт бичиг баймаар гэж олон олон уншигч бодох биз.

Гэхдээ миний иймшүүмжлэлт тэмдэглэл бол уг бүтээл аваас философи, шинжлэх ухаан (ялангуяа түүхийн шинжлэх ухаан), ердийн, эрүүл ухааны сэхээрүүлэх бясалгал зэрэг мэдлэгийн өөр өөр төрөл ба төвшин дэх ажил хэрэгч, бүтээлч, шинэлэг зэрэг бүхий дүгнэлт арвинтай байгааг үгүйсгэх гээгүй юм.

"Монголын хөгжлийн философи" гэдэг энэ ном аваас Даашка багшийн өмнөх олон ном, өгүүлэл дэх гол гол философи үндэслэл, философи ойлголтыг шинэ санаагаар баяжуулан өөртөө багтааснаас гадна сүүлийн жилүүдэд түүний явуулсан судалгааны үр дүн болсон санаанууд, бодрол бясалгалынх нь үр шим юм. Жишээ нь "Нагаржунын гүн ухаан, ёс зүй (шүтэн барилдахуйн онол)" гэдэг 2016 онд хэвлүүлсэн номондоо нийгмийн хөгжлийн асуудлыг авч үзсэнийхээ үр дүнг энэхүү шинэ бүтээлдээ хэрхэн бататган баяжуулсныг дурдъя. Үүнд[12]:

*Бичил хөгжил* бол нийгмийн амьдралын салбар, салаа мөчрүүд дэх салангид, заримдаг ахиц мөн.

*Их хөгжил* бол салбарууд өвөр хоорондоо хийгээд салаа мөчрүүдтэйгээ нарийн уялдаа, авцалдаа холбоонд орж, бие биеэ "хамгаалан" найрсаж өөдлөн урагшлахуй мөн.

---

[7] Өөрийнх нь дурдан буй зохиол, 7 дахь тал
[8] Мөн тэнд, 55 дахь тал
[9] Мөн тэнд, 119 дэх тал
[10] Мөн тэнд
[11] Мөн тэнд, 131 дэх тал
[12] Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи, 11-21 дэх тал

Их хөгжил нь “баттай” хөгжил байх ёстой. Иймд бичил хөгжлийг их хөгжилтэй уяж холбох хэрэгтэй. Түүний хамт салбар, салаа мөчрүүдийн хөгжил их хөгжлийг буй болгож өгнө. Иймд их хөгжилд хүрэх бичил хөгжлийг анхааран тордох ёстой. Их хөгжил аяндаа бүтэж зүгшрэхгүй. Улс орныг бүхэлд нь, ойртой, холтой нь хамтран сэтгэж чадсан нэгдсэн бодлогын дунд л их хөгжилд хүрч болно.

Хөгжил гэдэг ойлголтыг нийгэм шинжлэлийн хувьд, **“шинэчлэл”** (обновление) гэдэг ойлголттой ч, **“түрүүлснийг дагах өөрчлөлт”** (модернизация) гэдэг ойлголттой ч хутгаж болохгүй.

Тэгэхдээ шинэчлэл, модернизаци хоёрыг, эсхүл аль нэгийг нь зөв хийвэл энэ хоёр нь хөгжлийг цагийг нь олж ахиулах чухал хүчин зүйл болдог.

- Шинэчлэл бол нийгэм, нийтийн эрх ашгийн үүднээс зогсонги байдалд орсон зүйлийг л амьдралын ахиц, дэвшилд нийцүүлэн өөрчлөхүй мөн. Иймд, эхлээд ахиц дэвшил гэж юу вэ гэдгээ зөв ухаарах, дараа нь юуны уршгаас болж зогсонги байдал үүсэв гэдгийг тогтоох ёстой.

- Хөгждөг аливаа юмсын дэвшин дээшлэх хөдөлгөөн нь байсан бүхнээ таягдан хаядаггүй, үеэ өнгөрөөдөггүй, цаашдын өрнөлтөд наад зах нь зайлшгүй хэрэгтэй бүхнээ өвлөх замаар явах нэгэн талтай. Энэ бол уламжлал. Бас, эл хөдөлгөөн нь нэгэнт үеэ өнгөрүүлсэн, дэвшилд саад болж эхэлсэн зүйлийг халж, солих, түүний оронд зохистой шинэ юмсыг бий болгох, өмнөх шатнаас уламжлагдан ирсэн бүхэнд шинэ утга санаа оруулах замаар явах нэгэн талтай. Энэ тал бол шинэчлэл. Хүмүүний ухаан шинэчлэлийн хир хэмжээг уламжлалаар нь хязгаарлан барьж чаддаг байвал зохино.

- Бидний амьдралын эдүгээгийн шат өөрийн энэ үеийнхээ эдийн засаг-нийгмийн болон шашны байдал, улс төрийн байгууламж, зан суртахуун, эрх зүйн тогтолцоо, хүмүүсийн ааш авиртай; бас энэ үеийнхээ шинжлэх ухаан, урлаг, соёл, боловсрол, хүч чадлын түвшинтэй байна. Чухам энэ байдал цаг үе бүхэнд ямагт байж байх ёстой бөгөөд янз янзын түвшинтэй байж, эргээд хөгжлийн шатаа илэрхийлж байдаг. Энэ бол хөгжлийг судлах чухал зарчим мөн.

- Эдүгээ үед “модернизация” гэдэг үгийг лав л Орост их л бүрхэг утгаар, гэхдээ газар сайгүй хэрэглэдэг болсон ажээ. Эл үгийг Орост нэг хэсэг нь “обновление” (шинэчлэл) гэдэгтэй адил утгаар, нөгөө хэсэг нь өндөр технологийн үйлдвэрлэлийг бий болгох утгаар, гуравдахь хэсэг нь аж үйлдвэр хөгжсөн “барууны” ардчиллын маягаархи орчин үеийн “модерн” нийгэмд шилжихийг заасан утгаар тус тус хэрэглэдэг байна.

- Өнөө цагт ихээхэн яригдаж буй даяарчлалын үед дотоод найрслаа гадаадын нөлөөтэй хэрхэн холбож бодох ёстой вэ? Энэ бол онолын агаад улс төрийн нарийн төвөгтэй асуудал юм. Тухайн асуудал дээр хоёр зүйлийг чухалчлан анхаарах нь зүйтэй. Даяарчлал, гадны тусламж хоёр ямар ялгаатай ба нэгдэлтэйг судлах чухал.

- Даяарчлалыг дотоодын найрсал руу оруулах боломжгүй. Харин гадаадын тусламжийг дотоодын найрсал руу оруулах боломжтой.

- Дашрамд онцлоход хөгжил, дэвшил хоёр чухал ялгаатай хэмээн өмнөх зарим бүтээлдээ Даашка багш бичиж байв. Үүнд: "…хөгжлийн тухай бид практик талаас нь ухаарч байгаа бол харин дэвшлийн тухайд онол талаасаа голдуу яригдах бололтой нь ажиглагдсан"[13] дэвшил бол бүтэцлэг үйл явц мөн гэж Б.Даш-Ёндон өгүүлжээ.

Одоо энэ зохиолоос нь нэлээд урт ишилье. Судлаачдын үздэгээр «дэвшлийн тухай үзэл баримтлал хэд хэдэн бүтцийг агуулсан байх ёстой ажээ. Нэгд, өнгөрсөн, одоо, ирээдүйн тасралтгүй байдлыг хангасан бөгөөд урагшлан ахиж буй эргэлт буцалтгүй цаг хугацааны ойлголт энд багтсан байвал зохино. Энэ талаас нь харвал, дэвшил гэдэг нь өнгөрсөн ба одоогийн (хүрсэн дэвшил) хоорондын, эсхүл одоо ба ирээдүйн (хүсэж буй дэвшил) хоорондын нааштайгаар үнэлэгдэж буй ялгаа юм. "Нааштайгаар үнэлэгдэх ялгаа" гэж би дурдан буй ялгаа ахиц урагшлалтын дүнд багасахыг хэлж байна. Хоёрт, нэг ч үе шат нь давтагдахгүй, сүүлийн шат нь өмнөхөө бодоход ирээдүйд хүссэнтэй илүү ойрхон байх чигт хөдөлгөөний тухай ойлголт энд байх ёстой. Гуравт, эсхүл алхам алхмаар аажим өгсөж буй, эсхүл чанарын үечилсэн үсрэлт дамжин хувьсгалт замаар өрнөж буй үйл явц энд орно. Дөрөвт, урагш ахисан сайжралтын тухай ойлголт орно.

Дэвшлийн агуулга гэгдэж буй энэ дөрвөн санаа чухамдаа нэг л зүйлийг хэлээд байгаа боловч дэвшлийг чухам юун дээр авч үзэж байна вэ гэдгээсээ хамааран ингэж ангилагдаж байгаа аж.

Бүхнийг эзэгнэн хамарсан дэвшил гэж байхгүй, дэвшлийн тухай санаа тодорхой үнэт зүйлстэй холбоотой, яагаад гэвэл, дэвшил өөрөө үнэт зүйлсүүдтэй уялдаж илэрдэг хэмээн судлаачид үзэж буй…

Дэвшлийн оньсон түлхүүр нь хүн юм. Хүн л дэвшлийн эзэн»[14] хэмээн тэрээр бичсэн байна.

Хөгжил, дэвшлийн тухай философи онолд ирээдүйн тухай ойлголт гарцаагүй хамаардаг гэж Б.Даш-Ёндон заасан байна. "Ирээдүй бол ирээгүй байгаа одоо цаг мөн. Ийм учраас ирээдүй бол бидний амьдран буй цаг хугацааны хэсэг нь юм.

Ирээдүй бидний амьдрал руу их хурдтайгаар, янз бүрийн үр дагавартайгаар орж ирж байна, орж ирэх гээд наашилж явна. Бид ч ирээдүй рүү Хорвоогийн жамыг даган зорьж явна.

Иймд бид ирээдүйд хандахдаа тосож авах, угтаж орох зөв тактик, стратегийг баримтлах хэрэгтэй байна. Энэ бол бид ирээдүйдээ сайтар бэлтгэнэ гэсэн үг. Харин энд

[13]Б.Даш-Ёндон. Цаг үе: Сэтгэл, бодрол, философи. УБ., 2012. 315 дах тал.
[14] Мөн тэнд, 316 дахь тал

хэрхэн яаж бэлтгэх вэ гэсэн бэлэн жор байхгүй, энд зөвхөн одоогоо тооцоолсноос гаргасан… бодлогын философи л хэрэгтэй”[15] гэж тэрээр үзэж байна.

Эдгээр өгүүлсэн дүгнэлт ба санааны зарим (жишээ нь “одоо”, “ирээдүй” хоёрын холбооны тухай) нь эргэлзээ, маргаан, үүсгэж болох ч нилээд хэсэг нь эмпирик үндэс, практик өгөөж бүхий чухал үнэ цэнэтэй гэж хувьдаа үнэлсний хувьд ийнхүү тоочлоо. Гэхдээ Даашка профессорын боловсруулан санал болгож буй Монголын хөгжлийн философийн агуулга нь эдгээрээр хязгаарлагдахгүй бөгөөд бас зарим логик зөрчил бүхий юм. Энэ тухай хойхнуур өгүүлэх болно.

Одоо нийгмийн хөгжлийн тухай асуудлыг Даашка нарынхаас өөр аргазүйгээр тайлбарладаг үзэлд анхаарлаа хандуулъя.

1. Доктор (Sc. D.), профессор Д. Дашпүрэв бол 1990-ээд оны дунд үеэс хойш өнөөгийн монгол нийгмийн хөгжлийн философи асуудлаар судалгаа явуулсан чухал чухал үр дүнгээрээ шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертаци бичсэнээ ОХУ-д хамгаалж, “Монголын нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийн үе шатууд”, “Монгол нийгэм” зэрэг хэд хэдэн дорвитой бүтээл бичин хэвлүүлсэн юм. Тэдгээрийнх нь агуулгыг авч үзэх зорилт манай өгүүлэлд багтаагүй тул зөвхөн сэдэвтэйгээ холбогдуулан дурдахад тэрээр 2017 онд хэвлүүлсэн “Монгол нийгэм” номныхоо Өмнөх үгэнд монголчуудынхаа өөрийнхөө үед хэвлэгдсэн ном зохиолуудыг бүгдийг нь агуулга ба аргазүйн хувьд басамжлан мэдээлсэн байна. Тэгээд тэрээр “монголын нийгэм дэх философийн чухал асуудлуудыг “нийгмийн философи” (social philosophy)-ийн хүрээн дотор өөрийн баримталдаг философийн үзэл, онол, баримтлалуудын үүднээс тавих оролдлого хийж байна”[16] хэмээжээ. Ийнхүү ёс болгосон даруухан хэллэгний өнгөн дээр зөвхөн өөрийнхөө бүтээлийг дөвийлгөжээ. Тэрээр өөрийнхөө онолын судалгаанд аргазүйн плюрализмын үүднээс хандсан боловч түүнээ дөвийлгөн түгээмэлчилсэн монист хандлага гаргаж, өөр хувилбарын плюралист хандлага төрөх бололцоог үл тоосон байна.

Нийгмийн философи ба улс төрийн философийн сэдвүүдээр туурвисан Д.Дашпүрэвийн бүтээлүүд бүхэлдээ бол манай философийн сургалт, сурталчилгаа, судалгааны нэн чухал эерэг хэрэглэгдэхүүн болж байдаг юм.

2. Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан доктор *Ж.Энхбаяр 2017 онд хэвлүүлсэн “Нийгмийн хөгжлийн тухай өгүүлэх нь” гэдэг* өгүүллийн гол гол философи үндэслэл нь практикийн жич жич зарим үзэгдэл, үйл явцын талаарх онолын мэдээтэй хэрхэн холбогдож буйг дурдъя.[17]

- Хөгжил гэдэг ойлголт нь норматив шинжтэй, Тиймээс үнэлэмжийн утгаар хөгжил бол нийгмийн хүсэл, хэрэгцээ шаардлагаас урган гарч байгаа нэг шатнаас нөгөө шатанд дэвших үйл явц, тухайлбал, хүн амын амьдралын чанар, нийгмийн халамж, улс төрийн оролцоог сайжруулахад чиглэсэн эдийн засаг, нийгэм улс төрийн өөрчлөлт мөн.

---

[15] Мөн тэнд, 317-318 дахь тал
[16] Д. Дашпүрэв. Монгол нийгэм(Философийн анализ). УБ. 2017, 11 дэх тал
[17] Тогтвортой хөгжил: оюуны соёл. ЭШБХ-ын эмхэтгэл. УБ.,2017, 17-22 дахь талд эдгээрийг дурдсан буй.

- Сүүлийн 50-60 жилд хөгжлийн эрин үе тохиож,  НҮБ, Дэлхийн банк, Олон улсын Валютын сан зэрэг дэлхийн улс төр, санхүү, мөнгөний бодлогын асуудлыг зохицуулдаг байгууллагууд байгуулагдан, хөгжлийн асуудлаар бодлогын баримт бичгүүд гаргаж иржээ. Дэлхийн банк, ОУВС болохоор улс орнуудыг хөгжлийн янз бүрийн үзүүлэлтээр, жишээлбэл, нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, боловсрол, эрүүл мэнд, насжилт зэргээр хүний хөгжлийн индекс гаргаж, зам харилцаа, мэдээлэл холбооны гэх мэт тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжиж хөгжлийн түвшинг эрэмбэлж ирлээ.

- Нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил хоёрыг шууд адилтгаж болохгүй, зарчмын ялгаатай нэг зоосны хоёр тал юм. Хөгжил нь байгаа зүйлээ өөрчлөх, байхгүй зүйлийг бий болгох, харин өсөлт бол байгаа зүйлд хамаатай. Гэхдээ нийгмийн хөгжлийн гол парадигм нь эдийн засгийн өсөлт байдаг.

- Дээр дурдсан байгууллагуудын гол баримталдаг онол нь хөгжил бол эрх чөлөө мөн гэдэг философийн агуулгатай.

- Орчин үед нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдлаас улс орны бүрэн бүтэн байдал, иргэдийн нэгдмэл байдал хамаардаг болжээ. Нийгмийн хөгжил нь эцсийн эцэст хүмүүсийн оршихуйн нөхцөл, чанар байдлаар тодорхойлогдоно. Тийм учраас л хөгжил дэвшил, ард түмний сайн сайхан амьдралыг бий болгохын төлөө ямар ч улс орон хүн ам, эмэгтэйчүүд, ажлын байр, халамжийн гэх мэт асуудлыг шийдэхтэй холбоотой зөв бодлого гаргаж, зүйтэй үйл ажиллагаагаа явуулахыг  хичээж байдаг.

- Соёл бол консерватив шинжтэй, гэвч огт өөрчлөгддөггүй тогтонги биш, динамик бодит байдал мөн. Тийм учраас соёлын динамик өөрчлөлт бол хөгжлийн асуудлыг тайлбарлахад чухал үүрэгтэй.

- Үйлдвэрлэл хангалттай хөгжөөгүй, шинжлэх ухаан, технологийн хөгжлөөр дэлхийн дунджаас доогуур улсын хувьд байгалийн баялаг, ашигт малтмалын экспорт л эдийн засгийг тэтгэх, санхүүгийн хуримтлал бий болгох, бэлэн мөнгөний урсгалыг нэмэгдүүлэх, хүмүүс болоод аж ахуйн нэгжүүдийг орлоготой байлгах гол эх сурвалж юм. Гэхдээ хүн амын тооноосоо хэдэн арав дахин олон мал сүрэгтэй боловч малын халдварт өвчнийг бүрэн хянаж чаддаггүй, жилд нэг удаа ургац хураадаг эрс тэс улиралтай манай орны хувьд хүн бол хөгжлийн үүрдийн нөхцөл юм. Тиймээс уул уурхайгаас бий болох хуримтлалаар  нийгмийн дэвшил гэдэгтэй адил утгатай ойлгогдох болсон боловсрол, боловсролын салбарын хөгжилд анхаарах ёстой.

- Нийгмийн хөгжилд шашны үзүүлэх нөлөө байхгүй болно гэж нийгэм судлалын том сэтгэгчид зөгнөж, шашин бол шинжлэх ухаан, технологийн хөгжлөөр шахагдан үгүй болно гэж байв. Гэтэл хөгжлийн бодлогоос шашныг орхиж болохгүй гэдэг нь өнөөгийн дэлхий дахинд болж буй үйл явдлаас харагдаж байна.

Тийнхүү хөгжил бол тухайн юмын үл тасралт, уламжлал хоёрыг биш, харин өөрчлөлт, үйл явц (процесс)  хоёрыг нэн түрүүнд илэрхийлдгийнхээ үндсэн дээр тэр юмын

тогтолцоот чанарыг хадгалдаг гэгч үнэлэмжийн үзлийн дагуу нийгмийн хөгжлийн асуудалд Ж. Энхбаяр ханджээ.

3. Энэ өгүүлэлд чухал хэрэглэгдэхүүн болгон ашиглаж буй “Философи, эрх зүйн судлал” цуврал ботийн XXVIII-д доктор (Sc. D.), профессор А. Цанжид “Монгол улсын бодлого (1990 оноос хойш) гэдэг нэн даацтай өгүүлэл хэвлүүлжээ. Тус өгүүлэлд: манай улсын хөгжлийн бодлогод онолын үндэс нь шинжлэх ухаан байх болно гэсэн төв санаа баттай байна.

* * *

Одоо Философийн хүрээлэн хэрэгжүүлсэн төслөө онолын хувьд хэрхэн үндэслэж байгааг бага зэрэг тодруулан авч үзье. Ингэхдээ гол онолч нь маргаангүй мөн буй Даашка багшийн философидолтонд үндэслэх болно.

- Б.Даш-Ёндон: “…нийгэм зүй тогтолтой, нийгэмд объектив хууль үйлчилж байгаа. Объектив хууль гэдэг бол үзэгдэл, үйл явцуудын өөр хоорондох тогтвортой, зайлшгүй, дахин давтагдаж буй бөгөөд хүний санаанаас үл хамаарах хэлхээ холбоо юм. Ийм хэлхээ холбоо нийгэмд, нийгмийн эдийн засаг, улс төр, оюун санааны амьдралд бий. Энд үйлчилж буй тусгай хуулиудыг нийгмийн олон шинжлэх ухаан, түгээмэл хуулиудыг нийгмийн философи судлан таньдаг байна”[18] хэмээн бичсэн юм. Тийнхүү түгээмэл хуулиудыг таньдаг нийгмийн философи нь эцсийн дүндээ диалектикийг арга зүйгээ болгодог сургаал байж таардаг. Тэрээр бас бичихдээ К.Попперийг орой дээрээ мандуулагч нар бий. Үүний зэрэгцээ: Поппер бол Платон, Гегель, Маркс нарын философийг гуйвуулсан; байгалийн ба нийгмийн шинжлэх ухааны онцлогуудыг ойлгоогүй гэх мэтээр онолын сэтгүүлүүдэд шүүмж бичигч нар түүнийг зэмлэдэг[19] хэмээн “Диалектик гэж юу вэ?” гэдэг том хэмжээний өгүүлэлдээ диалектикийг ноцтой шүүмжилсэн Карл Попперийн талаар үнэлгээ илэрхийлсэн юм.

- Тэрээр 2006 онд хэвлүүлсэн өөр нэг өгүүлэлдээ: “…хөгжил гэдэг бол аль нэгэн үзэгдэл хуучин чанараасаа шинэ чанарт шилжиж буй явц юм гэж сэтгэхүйн диалектик хэлдэг (сэтгэхүйн диалектик, бодит байдлын диалектик хоёр яв цав дүйцдэггүй гэж би үздэг тул сэтгэхүйн диалектик гэж зориуд хэлэв)”. Хэрэв тийм бол «…хөгжил гэдэг бол эсрэг тэсрэгийн “тэмцэл” мөн гэх ч юм уу, “хөгжлийн уг сурвалж нь зөрчил мөн” гэж хүний тархинд л байгаа сэтгэхүйн диалектикаар хөгжил гэж юу вэ гэдгийг тайлбарлаж амьдралд хэрэгжүүлнэ гэвэл юу болох вэ (тийнхүү Даашка багш диалектийн цөм үзлээс татгалзсан мэт. Тэрээр бас тэр өгүүллээсээ 16 жилийн дараа буюу энэ намар: “...юмсын диалектик санааны диалектикийг бий болгодог”[20] хэмээн В. И. Ленин “Философийн

[18] Б.Даш-Ёндон. Цаг үе: Сэтгэл, бодрол, философи. УБ., 2012. 326 дах тал.
[19] Мөн тэнд, 361 дэх талаас үзнэ үү.
[20] Монголын хөгжлийн философи, сэтгэлгээний өөрчлөлт. ОУЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. УБ., 2022, 45-46 дах талд энэ тухай үзнэ үү.

дэвтрүүд"-дээ тэмдэглэснийг олзуурхан ишилсэн байна. Тэр өгүүлэл дэх амаа бас буцаж байгаа юм болов уу).

Сэтгэхүйн диалектиктай холбогдон гарах метафизикийн иим элдэв бодомж, мэтгэлцээнийг орхиод прагматик чиглэлээр хөгжлийн асуудалд хандах нь үр өгөөжтэй болой…

Прагматик санааг баримталж бодлоо авцалдуулан үргэлжлүүлбэл: хөгжил, хөгжлийн явц, эсхүл хөгжлийн үзүүлэлт гэдэг бол нийгэм, үндэстэн, улс орон хэрэгцээндээ тулгарсан юмаа өөрөө үйлдвэрлэн бүтээх, ашиглах, эдгээр ажил хэргээ зохион байгуулах ур чадварын үе шат, сайхь үе шатны шинж чанар юм»[21] хэмээн Б.Даш-Ёндон бичсэн юм. Ер нь түүнтэй адилаар диалектик ба бусад зарим философийн мэдлэгийг аргазүйн хувьд чухалчлан тунхаглагч манай философичид Н.Хавхаас бусад нь яг үйл ажиллагаандаа бол иим прагматик байр суурьтай юм. Өөрөөр хэлбэл философийн хувьд аргазүйн монизмыг сурталчилдаг манай эрдэмтэд нийгмийн ба улс төрийн салбар дахь онолын тайлбартаа бараг бүгдээрээ олон ургалч үзлийн зарчмыг нилээд баримталж байна.

- Хөгжлийн тухай диалектикч онол бол хамгийн бүрэн дүүрэн, өрөөсгөл биш гэдэг В.И.Лениний онолыг Даашка багш дэмжин бичдэг атлаа энэ онолын холбогдох тодорхойлолтонд эсрэг утгаар: хөгжил бол **"өөрөөсөө салаалан цэцэглэж, салаалсан нь бие даан төгөлдөржиж, улмаар эргээд нэгдмэл болгодог холбоонд орж, найрсах үйл явц"**[22] гэжээ. XIX зууны үеийн философич Г.Спенсер хөгжлийн тухай диалектик сургаалын оронд гаргаж ирсэн хувьслын (эволюцийн) онолын агуулгыг манай зарим философич товч боловч байгаагаар нь тайлбарлаж ирсэн юм. Тэгвэл орчин үе дэх хөгжлийн тухай зонхилох философи үзэл, тухайлбал "тогтвортой хөгжил" гэдэг философи ойлголт болбоос "хувьсал (эволюци)" гэдэг нэр томъёо хэрэглэдэггүй ч гэсэн аргазүйн хувьд Г.Спенерийн үзлийг баримталдаг болжээ. Даашка багш Г.Спенсерээс улбаатай үзлийг сая иш татсанчлан шинэ номондоо сурталчилжээ. Ингэхдээ тэрээр уг үзлийн нэрийг "хөгжил" хэмээн өнөөгийн олон философич шиг сольжээ.

- Хөгжлийн философи бол хугацаа заадаг хөтөлбөр биш, биелүүлэх төлөвлөгөө төдий ч биш, харин улаан шугамаар шийдсэн нэгдсэн ойлголттой сэтгэлгээ байх тул хууль зүй, ёс суртахуун, улс төр гурав "нэг гэрт" нэгдмэлээр амьдрахын үндэс байна хэмээн Даашка багш уг номондоо бичжээ. Тэгэнгээ "…хөгжлийн философи Үндсэн хуулийн хэрэглээнд тулгуурлах ёстой"[23] гэсэн буй. Энэ сүүлийн өгүүлбэр дэх зөвлөгөө нь хөгжлийн философи болбоос үндсэн хуульд захирагдах ёстой гэв үү?, эсвэл түүнийг (Үндсэн хуулийг) захиран хэрэглэх ёстой гэв үү гэдгийг хэл зүйн найрлагаас нь шалтгаалж ойлгохгүй тохиолдол олон уншигчид гарахаар юм. Хөгжлийн философи аваас

[21] Мөн тэнд, 300 дах тал.
[22] Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). Нэмэн засварласан хоёрдахь хэвлэл. 27 дахь тал
[23] Мөн тэнд, 132 дахь тал

үндсэн хуулиас иш авч, үндсэн хуульд захирагдах ёстой гэсэн санааг энэ ишлэл өгүүлбэр илэрхийлсэн бол хөгжлийн философийг хугацаа заадаггүй нэгдсэн ойлголт мөн гэж тэрээр үзсэнд нь нийцэхгүй, зөрчилдөх тал гарахгүй юү? Үндсэн хууль өөрчлөгдөхөөр яах вэ? гэтэл бас хөгжлийн философи аваас хууль зүй, ёс суртахуун зэргийн нэгдмэлээр амьдрахын үндэс мөн юм бол, бас "улаан шугамаар шийддэг" юм бол үнэлэмжийн онолын мэдлэг биш, харин үндсэн хуулийн үндэс болдог шинжлэх ухааны юмуу хуульчлагдсан эзотерик(тухайлбал аль нэг шашны) мэдлэг гэх мэт байж таарахаар юм.

Харин хөгжлийн философийг үнэлэмжийн онол мөн хэмээн хүлээн зөвшөөөрч баримтлах юм бол дурдсан маягийн асуултууд гарах логик шалтгаанууд багасах, зарим уншигч нарт бүр байхгүй болохоор аж.

Энэ өгүүллийг зохиогч миний бие доктор (Sc. D.), профессор Б. Даш-Ёндон Монголын хөгжлийн философийг боловсруулах асуудлаар нухацтай судалгаа явуулсны үр дүн болсон гол гол онолын үндэслэлийг илрүүлэн тоочиж, тэдгээрийн нэг хэсэгт эерэг, өөр нэг хэсэгт нь шүүмжлэлтэй хандсаныхаа төгсгөлд хувийнхаа ерөнхий сэтгэгдлийг илэрхийлье.

## *ТӨГСГӨЛ*

Тэр үедээ МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга байсан доктор Б. Даш-Ёндон гол нь нийгмийн ба улс төрийн философи дахь арга зүйн асуудлаар бичиж нийтлүүлсэн өгүүллүүдээ эмхтгэж 1995 онд хэвлүүлсэн "Төв үзэл-сэтгэх арга. Ажиглалт, бодрол" гэдэг товхимолдоо диалектикийн цөм үзэл болох "эсрэг тэсрэгийн нэгдэл харьцангуй, харин тэмцэл нь абсолют" гэдэг үзлээс татгалзсан байр суурь илэрхийлсэн байдаг. Тэгээд энэ товхимолдоо болон дараа дараачийн бүтээлдээ: "их нэвтрэлт", "төв үзэл", "төв ёс", "дунджийн үзэл", "алтан дундаж" хэмээн философидож, эцэст нь "найрсал" гэдэг ойлголт дээр тогтож буй бололтой. Иймхүү диалектикаас философийн хувьд энэ эрдэмтэн татгалзаж эхэлж байгааг дардаг болжээ гэсэн сэтгэгдэл олон олон хүнд тэр товхимлын агуулгаас төрж байлаа.

Гэвч иим философи сэтгэгдлийг Б. Даш-Ёндонгийн дараа дараачийн онолын үйл ажиллагаа улам бүр бүдэгрүүлж, одоо баллуурдах шатанд байна. Тухайлбал тэрээр 2014 онд хэвлүүлсэн "Нийгмийг танихуй: түүх хөгжлийн философи" номныхоо 91-92 дахь талд тайлбарлахдаа: Маркс, Энгельс нар диалектикийг (өөрөөр хэлбэл байгаль, нийгэм, сэтгэхүйн ерөнхий хуулиудын тухай сургаалыг) шинжлэх ухаан болгоод зогсоогүй түүнээ арга болгон маш чадамгай ашигласан байна. Марксын философийн амин сүнс болсон диалектик арга зүй бол мөнхийн учир холбогдолтой гэх мэтээр бичсэн бол энэ намрын 9 дүгээр сард Философийн хүрээлэнгээс зохион байгуулсан ОУЭШХ-д тавьсан илтгэлдээ В.И.Лениний "Философийн дэвтрүүд" дэх "Диалектикийн 16 элемент", "Диалектикийн тухай асуудлаас" гэж алдаршсан 2 нооргийг онцолсон юм. Тэдгээр элементийн нэлээдээр нь Даашка профессорын дэвшүүлсэн "найрсал" гэдэг категорийг бататгая гэвэл болохоор юм. Үүний зэрэгцээ бусад элемент нь, ялангуяа диалектикийн өмнө дурдсан цөм үзэл, бас

"хөгжил бол эсрэг тэсрэгийн "тэмцэл" мөн" гэж В.И.Ленин тэмдэглэсэн зэрэгтэй холбон үзвэл "хөгжил бол найрсал мөн" гэдэг Дашка багшийн боловсруусан философи томъёолол нь диалектикийн баримтлалуудад уусаж, бие даан товойж чадахгүй байна.

Нэгэнт философи сэтгэдэл илэрхийсний хувьд хоёр зүйл учирлая. Нэгдүгээрт, би философийн зориулалтаар бичсэн буй том, бага аливаа сэдвийг агуулгын хувьд үнэмшил төрүүлж байгаа эсхийг нь бодохоосоо урьд тэр сэдэв үнэхээр мэргэжлийн төвшинд байна уу, өөрийнхөө дотоодод логик зөрчилтэй юм уу гэдгийн үүднээс үнэлгээ өгөхийг ганц энэ илтгэлдээ ч биш, ер нь аливаа нийтлэлдээ чухалчилдаг болоод 20 орчим жил болж байна. Философийн плюрализмыг баримтлахыг хичээдэг иймбайр суурьнаасаа хэлэхэд шинжлэх ухааны доктор, профессор Б.Даш-Ёндон хөгжлийг өөрийнхөө бие даан шинээр томъёолдгоороо "найрсал" гээд, тэгэнгээ тэрээр "хөгжил бол тэмцэл мөн" гэдэг үзлийг зөвтгөдөг диалектик онол, аргазүйг нэн чухалчилдаг төдийгүй "шинжлэх ухаан" гэж уламжлалт тунхгаа баримталсаар байгаа ийм тусгаарламал заагт хоёр үндэслэлийнхээ аль нэгийг нь сонгомоор юм. Сонгохгүй бол логик зөрчилтэй байна. Даашка багшийн дэвшүүлж буй "найрсал", диалектик хоёрын ийм эсрэг тэсрэг хоёр үзэл нь хоёулаа онолын үнэлэмж тул, өөрөөр хэлбэл шинжлэх ухааны биш, харин философийн үзэл учраас аль нь ч гэсэн тохирсон нөхцөлдөө хүчинтэй, тохирохгүй нөхцөлдөө хүчингүй байж таарна. Ер нь ямар ч философи үзэл ийм тавилантай нь түүхээрээ нотлогдож иржээ. Хоёрдугаарт, Даашка багш нэг талаар диалектик онол ба түүнийг аргазүйгээ болгодог марксист-ленинист сургаалыг үнэнчээр сурталчилдаг, нөгөө талаар сэтгэлгээгээ шинэчилсэн гэж бусдад харуулахыг хичээхдээ нөгөө л диалектикийнхаа өвөр, тэврээс салахгүй байгаа "дундаж үзэл", "найрсал" зэргээ диалектикаас гадуур мэт сурталчилдаг - ийм хоёрдмол байр суурь нь философиор эрх биш мэргэжсэн хүнд дээр дурдсан логик зөрчил анзаарагдаж байна. Онолын өөр ч олон жишээгээр тийнхүү нотлогдож байна. Тухайлбал энэ намар 9 дүгээр сард Философийн хүрээлэнгээс зохион байгуулсан ОУЭШХ-д Даашка багш "Монголын хөгжлийн диалектик" гэдэг нэртэйгээр тавьсан илтгэлдээ: нийгэм, эдийн засгийн хэлбэршлүүд (зарим зохиогч "формаци" гэдэг нэр томъёог "хэлбэршил" гэж орчуулдаг) дэвшин дээшлэх маягаар дэс дараалан халагдан солигдож хөгжсөн тухай К. Марксын онол бол диалектикийг хэрэглэсний үр дүн мөн хэмээн бахархалтайгаар дурдсан байна. Гэтэл тэрээр зарим зохиолдоо хөгжил гэж юу болохыг шүтээн диалектикийнхаа тодорхойлолтоос өөр утгаар, шууд хэлбэл XIX зуунд Г.Сенсерийн боловсруулсан хувьслын тухай онол (эволюционизм) дагуу, улмаар XX зууны сүүлийн хэдэн арван жилээс хойш сурталчлах болсон тогтвортой хөгжлийн тухай томъёолол дагуу дэлгэрэнгүй тодорхойлж, энэ нь "хөгжил бол найрсал мөн" гэж бас томъёолдогтой нь аргазүйн хувьд уялдаж буйг өмнө дурдсан билээ. Бас формациудын зүй тогтолт эцсийн дээд шат болох коммунист нийгмийн ялан мөнхрөх удирдлагын шалтгаан нь төрийн аажим мөхөл мөн гэж шаргуу баталсан Маркс, Ленин нарын онолыг Даашка багш баримтлахгүйгээ мэдэгджээ. Ийм байр суурь нь формацийн тухай бүхэл тогтолцоот марксист сургаалыг онолын хувьд үгүйсгэж, үгээрээ бас өөрөө өөрийгөө үгүйсгэж байна.

Одоо Монголын хөгжлийн философийг хэрхэн боловсруулах асуудлаар хувийн зарим философи дүгнэлт илэрхийлье.

- Хөгжил бол залгамж холбоо, тасардаггүй үйл явц гэдгийн философи үндэслэгээг гаргах нь бидний судалгааны нэг зорилт хэмээн төслийн гол хүмүүс мэдээлж байна. Ийм зорилтот мэдээлэл нь хөгжлийг практик талаас ухаарах ёстой гэж Даашка багш онолын анхааруулга өгдөгтэй нь, тухайлбал 1980-аад оны эцэс, 1990-ээд оны эхэн үеийн жилүүдэд монголын ард түмэн нийгмийн байгууллаа өөрчлөн шинэчлэхийн төлөө тэмцэн, үр дүнд нь нийгмийн ардчилсан тогтолцоог сонгон, түүнээ 1992 онд баталсан Үндсэн хуулийнхаа заалтууд дагуу бэхжүүлэхийн төлөө тэмцэж ирснийг, гэтэл түүгээр зогсохгүй улс орныхоо төрийн тогтолцоог шинэчлэх, тиймээс дахиад шинэ үндсэн хууль батлах санал хүн амын дотор өрнөж байгаа зэрэгтэй зөрөөд байна. Ер нь тэдний уг зорилт цэвэр философийн үүднээс ч бүтэхгүй. Учир нь, нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн ухааны янз бүрийн салбарт санаандгүй гардаг тасралт төдийгүй зориуд сонгодог тасалдаг арга бол тухайн судлагдахуун, түүний оршиж буй нөхцөл зэргийн онцлогоос хамаараад эерэг юм уу сөрөг аль нэг гүйцэтгэлтэй байдаг. “Залгамж холбоо” гэдэг холбоо үгээр “уламжлал” гэдэг ойлголтыг тэд тухайлсан байх гэж таагаад дурдахад тэр (уламжлал) нь бас л нөхцөл байдлаас хамаараад хөгжлийн нэн чухал хэрэгцээ, боломж, сэдэлт ч, эсвэл хөгжлийг саатуулагч, түүхийн эерэг сарнилыг зохиомлоор нэгтгэгч, шинийг бүдэгрүүлэгч ба үгүйсгэгч гэх мэт ч болдог. Энэ тухай асуудлыг М. Фуко зэрэг флософич нар нухацтай авч үзээд “дискурсив (жич уялдмал)” гэдэг тодотголтой философи арга боловсруулан дэвшүүлж байна.

- Дурдан буй дискурсив аргазүйг баримталж, миний дээрх тайлбарыг дэмжсэн уншигч байвал: “Монгол улсын хөгжлийн философи нь Үндсэн хуулиа тулгуур үндэслэл болгосон улс төрийн онол, номлол байх болно” гэдгийг тэр уншигч дэмжихгүй билээ. Учир нь, ФХ-гийнхний ийм зорилтоос өөр зорилт бүхий Монголын хөгжлийн философи боловсруулах боломж аваас манай Үндсэн хуулийн плюралист үзэл санааны үүднээс нээлттэй.

- Хэрвээ энэ төслийг хэрэгжүүлэгч нарын төдийгүй ер нь хэн хэний ч бай боловсруулсан Монголын хөгжлийн философийн хувилбарыг “хийж чадвал аль ч улс төрийн хүч засгийн эрхэнд гарлаа, аль ч нам хөтөлбөрөө боловсрууллаа гэхэд энэхүү хөтлөгч улаан шугамыг барьдаг байх ёстой” гэж мөрөөдөх нь марксизм-ленинизмийг нам-төрийн нэгдмэл, үйл ажиллагаанд онолын ба аргазүйн үндэс, өөрөөр хэлбэл “хөтлөгч улаан шугам” болгож байсантай адил хувилбар бүтээх зорилго юм. Учир нь, аль нэг хөгжлийн философийн хувилбар болбоос бүхнийг “хөтлөгч улаан шугам” байх боломж нь тэр хувилбарыг төрөөс хуульчлан баталсан нөхцөлд л бодит хэрэгжилт болох найдвартай. Гэтэл манай үндсэн хууль болбоос аль нэг философийг тухайн тодорхой улс төрийн нам, нэг юм уу бүлэг хүн даган баримтлахыг, бас өөрөө боловсруулан сурталчлахыг хориглодоггүй ч тэр философийг хууль, тогтоолоороо ёсчлон туйлшруулдаггүй. Тийм ардчилсан хэм хэмжээг бид чанд сахих ёстой.

- Харин Монголын хөгжлийг хэдийгээр учир дутагдалтайгаар боловч хөтлөгч улаан шугам байх бололцоо шинжлэх ухааны холбогдох танин мэдэхүйд ба ирээдүйг урьдчилан харахуйд байдаг. Аль ч философид эдгээр үйлийн тодорхой хувь байдаг ч бүхэлдээ бол үнэлэмж ноёрхож байдаг. Нөгөөтэйгүүр нийгмийн хөгжлийн хэчнээн даацтай философи байлаа гэхэд тэр нь бүхэлдээ бол үнэлэмжийн хэв маягийн онол байдаг. Тэгвэл өнөөгийн өдрүүд дэх Монголын хөгжлийг  хамгийн ерөнхий "хөтлөгч улаан шугам" нь Монгол улсын Их хурал 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоороо баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого юм. Энэ баримт бичгийн агуулга нь  зорилт, заалтуудынхаа заримын хувьд үндэслэгдсэн хэр хэмжээ дутагдалтай,, хийсвэр тунхаг шинжтэй, үнэлгээний шалгуурт ноцтой өртөхгүй байх магадлалтай гэх мэтээр шүүмжлэгдэж болох ч бүхэлдээ бол холбогдох бүх байгууллага ба мэргэжлийн хүмүүсийн зүгээс асуудлаа шинжлэх ухааны үүднээс авч үзсэний эерэг үр дүн юм.

Тийнхүү 1990-ээд оноос хойш философичдын маань нэлээд хэсэг болбоос хөгжлийн тухай асуудлыг авч үзэхдээ диалектик арга зүйгээс татгалзсаныг гэтэл диалектикийг тууштай сурталчилж байгаа хүмүүс нь хүртэл хөгжил гэж юу болохыг тайлбарлахдаа түүнээ баримтлахгүй буй тохиолдол цөөнгүй юм.

**Ном зүй**


1. Алсын хараа-2050. - Монгол улсын Их хурал. 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоол.
2. Батын Ч.Ган-Өлзий. Хүмүүнлэгийн гурван ертөнцийн гоц чанарыг судлахуйн чандмань эрдэнэ. УБ., 2011,
3. Б.Даш-Ёндон. Цаг үе: Сэтгэл, бодрол, философи. УБ., 2012.
4. Б.Даш-Ёндон. "Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). УБ., 2017
5. Д. Дашпүрэв. Монгол нийгэм(Философийн анализ). УБ., 2017.
6. Г. Лувсанцэрэн. "Төв үзлийн философийн онолын үндэс. УБ., 2009.
7. Философи, эрх зүйн асуудал. XXVIII боть. ШУА-ын ФСЭХ. УБ., 2013. Холбогдох материалууд
8. Н.Хавх. Азийг зорьсон хүн төрөлхтөн. - Бодрол, бясалгал. УБ., 1991.
9. Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. УБ., 2011.
10. Д.Чулуунжав. Нийгмийн философи: Онол, туршилт, сургамж, шүүмж. УБ., 2014.
11. А. Цанжид. Монгол улсын бодлого (1990 оноос хойш) Философи, эрх зүйн судлал" XXVIII боть ШУА-ийн Философийн хүрээлэн.
12. Ж.Энхбаяр. Нийгмийн хөгжлийн тухай өгүүлэх нь. Тогтвортой хөгжил: оюуны соёл. УБ.,2017.

# ЭРХ МЭДЛИЙН ЗАРИМ ИЛРЭЛ

Ц.Нямсүрэн[1], доктор (PhD)
Я.Хишигсүрэн[2], судлаач
[1]МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим
[2]Максима консалтинг ХХК

**Удиртгал:** Орчин үеийн улс төрийн либерализм, түүний онцлог институци тухайлбал хувь хүний эрх, төлөөллийн ардчилал бий болсноор хувь хүн нь илүү эрх чөлөөтэй болсон гэсэн ойлголтыг үгүйсгэх нь пост-структурализм, постмодернизмын нэг зорилго байв. Эдгээр чиглэлийн зарим төлөөлөгч жишээлбэл М.Фуко орчин үеийн либерал нийгмүүдийг дарангуйлагч, гэхдээ тэдний хэрэглэж буй дарангуйлах практик нь өмнөх үеийнх шиг ил тод байдаггүй гэж нотлодог. Дарангуйллын орчин үеийн хэлбэрүүд нь нийгмийн шинжлэх ухааны зарим салбараар зөвтгөгддөг учраас олж танихад бэрх юм. "Хэвийнжүүлэх" үйл явцаар нийгмийн ухаан нь нийгмийн зүгээс хүндлүүштэй, хүсүүштэй гэж тооцох зан үйлийг "хэвийн", "ухаалаг" хэмээн хаягласнаар өөр бусад зан үйл нь хэвийн биш, рациональ бус болж, сахилга, албадлагын хууль ёсны объект болон хувирдаг.

Жишээлбэл өнөөдөр бид галзуу, солиотой хүмүүстэй өнгөрсөн үеэс илүү хүнлэг харьцдаг болсон гэж итгэж үнэмшдэг билээ. Тэднийг эмнэлэгт хэвтүүлж, эм өгч, эмч, сувилагч нараар эмчлүүлж тойлдог. Гэтэл урьд сэргэн мандалтын үед тэд олон хүмүүсээр хүрээлүүлж, чөлөөтэй сэлгүүцэж болдог байв. Харин XVII зууны дундаас сэтгэцийн өвчтэй хүмүүсийг өршөөлгүй эмчилж, ангилдаг шинж хандлага гарч иржээ. Тэднийг бусадтай хамт амьдрахыг үл зөвшөөрч, ийн мэдрэл гэгдэх хүмүүсийг гэрийнхэнээс нь салган авч, тусгай өрөөнд түгжин, зүгээр өөр байгааг нь хүлцэхийн оронд эмчлэх гэж оролцддог болсон байна.

Түүнчлэн бид одоо илүү дээр эмчилгээ, эмтэй болсон хэдий ч XVIII зуунд мэргэжлийн эмч нар төрж, өвчтөн рүү үргэлж анагаахын ширтэлтээр хардаг хүмүүс мэндэлснээр өвдсөн хүнийг бие хүн гэхээсээ өвдсөн эд, эрхтэний цогц мэтээр хардаг хүнлэг бус хандлага дэлгэрэв. Ийн анагаахын ширтэлтэнд өртсөн хүн нь бүхэл нэг зүйл гэж ойлгогдох бие хүн биш харин бөөр, элэг гэх мэтийн буруу үйл ажиллагаа болж харагддаг.

Бүр цаашилбал орчин цагийн шорон, шийтгэлийн систем нь олон нийтийн өмнө дүүжилж, цаазалдаг байсан үеэс хол илүү хүнлэг болсон гэж боддог. Одоо эрх мэдэл эелдэг зөөлөн мэт харагдаж байгаа боловч тийм биш. Өнгөрсөн үед мэдээж эелдэг зөөлөн байгаагүй боловч үүнийг эсэргүүцэн босч чадаж байсанд асуудал оршино. Өнгөрсөн үед цаазын газар гэмтний бие хүндлэл, талархалын бай болж, гэмтэнээс илүү цаазлагч ичгүүртэй байдалд орж болдог байв. Мөн олон нийтийн өмнө цаазлах нь хоригдогчдын дэмжлэгтэй бослого болох нь элбэг байсан бол орчин үеийн шоронгийн тогтолцоог нээснээр бүгд тусгаар, цоожтой хаалганы цаана болдог болжээ. Хэн ч харж чадахаа болж, ийн хэн ч тэрийн эрх мэдлийг эсэргүүцэхээ больсон байна.

Энэ бүхний цаана дарангуйллын практик хэрэгжиж байгаа бөгөөд тус бүрдээ эрх мэдлийн илрэл болно. Энэхүү өгүүллээр орчин үеийн нийгэм-улс төрийн философийн онолын үзэл баримтлалын үүднээс манай нийгэмд өрнөсөн зарим  үзэгдлийг тайлбарлахыг зорилоо.

*2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр "Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх" төсөл батлах тухай засгийн газрын 58-р тогтоол* (Монгол Улсын засгийн газар, 2021) *гарлаа. Ингээд төслийн үр дүнд ажил, амьдралын гараагаа зөв эхлэх, ажил, мэргэжлийн чиг баримжааг олгох үйлчилгээнд хамрагдсан, хувь хүний хөгжлийн болон соёлын олон талт мэдлэг, мэдээллээр хангагдсан, гэр бүлийн хөгжил, улс орны хөгжлийн үндэс болохыг ойлгож, ухамсарласан, төсөлд жил бүр 5000 залуус хамрагдсан, тэдний 70 хувиас багагүй нь нэг жилийн дотор ажлын байраар хангагдсан, төслийн дараах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээнд хүсэлт гаргасан зорилтот бүлгийн залуучуудыг бүрэн хамруулсан* (НХХЯ, 2021) *байх хүлээлттэйгээр "Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төсөл"-г цар тахлын нөхцөл дунд, цар тахлын үеийн нийгмийн эрүүл мэндийн дэглэмийг сахих, олон хүн цуглуулахгүй гэсэн уриалга, дүрэм, журмаа зөрчин байж, чиглүүлэгч багш нар хичээлүүдээ бүрэн эзэмшиж дуусаагүй байхад эхлүүлэв. Гурван сар, түүнээс удаан хугацаанд хөдөлмөр эрхлэлгүй, халамж, хүнсний талон авдаг зорилтот бүлэг рүү чиглэсэн энэхүү төсөлд хамрагдсан эхний оролцогчид мужаан, гагнуурчин, өрлөгчин, үсчин, гоо сайханч гэх мэт тодорхой мэргэжлийг сонгоод 14 хоног мэргэжлийн мэдлэг эзэмшээд, дараа нь 14 хоног дадлага хийж цалин авна, өмнө эзэмшсэн мэргэжлээрээ ажилд зуучлуулна, ажлын байртай болно гэсэн төсөөлөл, итгэл үнэмшилтэй ирж байлаа. Гэвч тус төслийн сургалтын хөтөлбөр нь ажил, мэргэжлийн баримжаа олгох үндсэн агуулгаа орхигдуулсан, төслийн ерөнхий уриа болсон хөдөлмөрт сургах гэсэн нэрэндээ тохирохгүй боловсрогдсоноос гадна сургалтын агуулга нь хувь хүний хөгжилд түлхүү чиглэсэн, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, эрэлт, нийлүүлэлт, хандлага, мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрлөх эрх, түүний зөрчил, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, хувь хүний хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээг дурдаагүй, төслийн гол зорилго, зорилттой шууд холбогдохгүй сэдвээр дүүрчээ. Түүнчлэн монгол хүн, төрт ёс, хэл бичиг, өв соёл, урлаг, хөдөлгөөнөөр анагааж засахуй, хувь хүний манлайлал, цэрэгжилт болон бие бялдрын сургалтын хөтөлбөр нь нэгдсэн удирдамж болон ажлын дэвтрүүдэд тусгагдаагүй, ямар агуулгыг, хэрхэн заах нь ч тодорхойгүй байв. Гэсэн хэдий ч сургалтад бүрэн хамрагдаж, гэрчилгээ авсан оролцогчид 500 мянган төгрөгийн тэтгэлэг, мөн ажлын байрны дадлага дууссаны дараа дахин 500 мянган төгрөгийн тэтгэлэг авна гэсэн хүлээлтийн сэтгэл зүйгээр ихэнх оролцогчид цэнэглэгджээ. Харин энэхүү төслийн зорилгод дурдагдсан эрүүл, эртэч, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх ихэнх үйл ажиллагааг цэрэг армийн дэглэмээр гүйцэлдүүлэхээр тооцсон ч өглөө эрт босох, дасгал хөдөлгөөн хийх, гүйх, төрийн далбаа мандуулах, буулгах ёслол зэргийг оролцогчид сэтгэл зүйн асар их дарамттай хүлээн авч, төвөгшөөж байлаа.*

Энэ бол залуусыг ажил хийх хүсэл сонирхолгүй байна гэсэн төсөөлөл дээр суурилан, асран халамжлах хандлагад түшиглэж, эрх мэдлийн хүрээгээ тэлэх гэсэн үйл ажиллагааны нэгээхэн хэсэг юм. Төрийн зүгээс хэрэгжүүлж буй иймэрхүү төсөл нь уггаа хяналт тавих хэрэгслийн давхар утгатай. Яагаад гэвэл асран халамжлах нь хяналт тавих бололцоо ямагт мөн. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа, хувийн суурь ур чадвар олгох цогц хөтөлбөрийг дөрвөн яамны хамтарсан тушаалаар батласан гэх боловч энэ нь сургалт нэгэнт эхэлсний дараа нөхөж гарсан, сургалтын эцэст хүрэх үр дүн, хэрхэн үнэлэх зэргийг тусгаагүй, хэрэгжүүлснээсээ зөрүүтэй агуулгатай, оролцогчид мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг үгүйлсэн хэвээр байгаагаас төслийн гол үр дүнг биелээгүй гэж үнэлж болохоор байна. Эндээс төслийг анхнаасаа бүтэлгүйтсэн эсвэл өөр зорилгоор тухайлбал "дуулгавартай бие"-сийг бэлтгэх зорилгоор хэрэгжүүлсэн гэж дүгнэж болно.

“Дуулгавартай бие”-ийг бий болгох нь сахилгажуулах эрх мэдлийн үндсэн нэгж юм. Хувцасны жигдрэл, хагас цэрэгжилт зэрэг элементээс энэ бүхэн илт харагдана.



*Зураг 1. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийн үйл ажиллагааны хэсгээс (Ганчимэг, 2021)*

Мэргэжлийн цэрэгжилтээр төрийн олж авсан, үйлдвэр, нийтийн боловсролын байгууллага дахь хөдөлмөрийн хуваариар дамжин нийгэмд өргөн тархсан, эрх мэдлийн түүхэн өвөрмөц хэлбэр, шийтгэлийн утга бүхий сахилгын зорилго нь хувийн хөдөлгөөн бүрийг нь хянаж болох, эргээд хувь хүний сэтгэлзүйг удирдан хянаж болох “дуулгавартай биесийг” бий болгоход оршдог. Орчин үеийн эрх мэдлийн өвөрмөц шинж (сахилгын хяналт) нь хүмүүсийн хийгээгүй зүйлд, өөрөөр хэлбэл шаардлагатай стандартад тухайн хүн хүрч чадахгүй байгаад санаа зовдогоор илэрнэ. Энэхүү санаа зоволт нь хэм хэмжээнээс зөрсөн зан үйлийг засах гэсэн орчин үеийн сахилгын тогтолцооны үндсэн чиг үүргийг харуулдаг.

Дурдан буй төслийн тухайд хувь хүнийг хөгжүүлэх агуулгыг түлхүү тусган залуучуудыг “хэвийнжүүлэх”, ахин хүмүүжүүлэхийг оролджээ. Гэвч дийлэнх оролцогчид сургалтын ихэнхи агуулгыг эзэлж байгаа хувь хүн өөрийгөө хөгжүүлэх хичээлийг ерөнхий боловсролын сургуулиас эхлэн орох хэрэгтэй гэж үнэлсэн нь манай боловсролын тогтолцоонд хамгийн их үгүйлэгдэж байгаа агуулгыг илтгэхээс гадна оролцогчдын одооны хэрэгцээг биш, харин тэдний алдагдсан боломж, гарзанд харуусах, түүнийг нэхэн үгүйлэх сэтгэл зүйг илүүтэй илтгэнэ.

Хэм хэмжээнээс зөрсөн зан үйлийг засах ажиллагааны гол зорилго нь (орчин үеийн өмнөх эрүүдэн шүүдэг шийтгэл шиг) өшөө авах, айлгах жишээ болгох биш, харин эн

тэргүүнд нийгмийн жишиг, хэм хэмжээний дагуу амьдардаг болгож шинэчлэх явдал юм. Тус төслийн хувьд хамрагдах үндсэн шаардлагад ажил эрхлээгүй байх гэх мэт үзүүлэлтийг тусган нийгмийн эмзэг хэсгийг “зан чанарын согогт (Goffman, 1963)” тулгуурлан олны өмнө шившиглэн, “хэвийн бишчүүл” болгон харуулсан билээ. М.Фукогийн хэлсэнчлэн “Ажилгүй хүнийг хөөж явуулах юмуу шийтгэхээ болив; түүнийг улсын зардлаар гэхдээ хувь хүний эрх чөлөөнийх нь үнээр батлан дааж авлаа. Ажилгүй хүн, нийгэм хоёрын хооронд үүрэг хариуцлагын далд тогтолцоо бий болов: тэрээр тэжээлгэх эрхтэй, гэхдээ тусгаарлалтын биеийн болон ёс суртахууны хязгаарлалтыг хүлээн авах ёстой (Foucault, 1967).”

Оновчтой, нарийн хэм хэмжээ тогтоох замаар сахилгажуулах нь ("хэвийнжүүлэх") нь хуулиар зөвшөөрөгдсөн юм уу зөвшөөрөгдөөгүй үйлдэл бүрийг шүүдэг, шүүгдэж байгаа хүмүүсийг "хэвийн", "хэвийн бус" гэж хэлдэггүй шүүхийн хуучин шийтгэх тогтолцооноос тэс өөр. Хэвийнжүүлэх энэ санаа боловсролын хөтөлбөр, эмнэлгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн үйл явц, бүтээгдэхүүний үндэсний стандарт гэх мэтээр нийгэмд маань өргөн тархжээ. Сахилгын бүх институт хувь хүмүүсийн зан үйлийг ижил түвшинд хүртэл өөрчлөхийг оролддог (Kelly, 2021). Сахилгажуулан “сайн шийтгэх (Foucault, 1995)" эрх мэдлийн шинэ хэлбэр нь нийгмийг хянах хэрэгсэл болж байгаа бөгөөд маш гэмгүй зорилгоор боловсруулсан техник, институциуд сахилгын эрх мэдлийн орчин үеийн тогтолцоог бий болгож байна. Сахилгажуулах институтууд засан хүмүүжүүлэх байдлаар эрх мэдлийг хэрэгжүүлж, гэм буруутай үйлдлийг үгүй хийх, хүмүүсийн биеэ авч явах байдлыг зохицуулахаар хязгаарлагдахгүй тэднийг ажиглаж хянах үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн хөдөлмөрийг ёс суртахууны шинэчлэлийн дасгал ажил болгон ашиглаж байна. Энэ утгаараа хөдөлмөр лагерь маягийн тусгаарлалт нь ажилгүйчүүдийн үгүйрэл ядуурлыг халхлах зорилгоор тэднийг шингээх, мөн эсэргүүцлийн нийгэм, улс төрийн хохирлоос зайлуулах үүргийг гүйцэтгэж байна.

*2019 оны 12 дугаар сарын 31-нд Хятадын Ухань хотын эрүүл мэндийн хороо шалтгаан тодорхойгүй уушигны хатгалгаа өвчний кластер тохиолдол Хубэй мужийн Ухань хотод бүртгэгдсэн талаар мэдээлж, ДЭМБ-ын зүгээс 2020 оны 1 дүгээр сарын 5-нд шинэ вирусийн тухай мэдээг анх нийтлэн шинжлэх ухааны нийгэмлэг, нийгмийн эрүүл мэндийн олон нийт, дэлхийн хэвлэл мэдээллийнхэнд дөнгөж хүргэсэний маргааш буюу 2020 оны 1 дүгээр сарын 6-нд ЭМЯ, ХМХЕГ, ХӨСҮТ, ЗӨСҮТ хамтран эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг анх хийж, эрсдэлийн түвшинг дунд, идэвхжилийн зэргийг I хэмээн үнэлэв. Удалгүй эрсдлийн түвшинг дундаас өндөр, маш өндөр хэмээн нэмэгдүүллээ. Ингээд Хятад, Монгол улсын хоорондох агаарын болон газрын хилийн боомтыг 1 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн хаах, олон улсын нислэгийн болон зорчигч тээврийн галт тэрэгний хөдөлгөөнийг түр зогсоох, бүх нийтийн арга хэмжээ, хурал, спорт наадам, баяр зэргийг хязгаарлах, боловсролын байгууллагыг онлайн горимд шилжүүлэх, уламжлалт сар шинийн баярыг хориглох гэх мэт хариу арга хэмжээ авав. Иргэдийг халдварт нэрвэгдсэн улс орнууд руу зорчихыг хориглох, тэндээс ирсэн зорчигчид 14 хоногийн хөл хорионд байх, аяллын түүх, эрүүл мэндийнхээ талаар худал мэдүүлсэн аливаа этгээдэд торгууль ногдуулахаар зохицуулжээ. 2020 оны 3 дугаар сарын 10-нд зөөвөрлөгдсөн анхны тохиолдол бүртгэгдсэн бол 11 дүгээр сарын 11-нд дотоодын анхны тохиолдол бүртгэгдэв. Тухайн өдөр Засгийн газар шуурхай хуралдаж, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг, хатуу хөл хорио тогтоох шийдвэр гаргалаа. Таван өдрийн хугацаатай тогтоосон уг хатуу хөл хорионы үеэр иргэдийг гэрээсээ гарахгүй байхыг зөвлөж, зөвхөн хүнсний дэлгүүр, супермаркет, хүнсний зах, шатахуун түгээгүүр, эмийн сан, эмнэлэг, худаг усан хангамж, дулаан хангамж, цахилгаан станц, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, буяны үйл ажиллагаа,*

*хот хоорондын хүнсний тээвэрт хязгаарлалт хийхгүй байхаар тогтоов. Уг хориог 14 хоног сунгаад байсан бол дахин 12 дугаар сарын 11-нийг хүртэл үргэлжлүүлэх шийдвэрийг 2020 оны 11 дүгээр сарын 29-нд гаргалаа.*

Цар тахлын үеийн энэхүү үйл явдлууд эрх мэдэл гэдэг дан ганц төр, засаг эсвэл эрх барьж буй анги бүлэгт хамаатай зүйл биш гэдгийг хамгийн сайн харуулж өгсөн юм. Эрх мэдэл нь олж юмуу булааж авч болдог бараа биш, харин сүлжээсийн мөн чанартай, түүний нэхээс хаа сайгүй байдаг (Sarup, 1988). Дээрх тохиолдолд эрүүл мэндийн мэргэжилтэн халдвартай, халдваргүйг, эрсдэлийн түвшинг, хөл хорионы үндэслэлийг тогтоох асар их эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүний үр дүнд улс төрчдийг өөрсдийг нь оролцуулаад хэн хаашаа явж болох, болохгүйг шийдэх хүчтэй байна. Тусгаарлах, цагдах, хорих зэрэг эрх мэдлийн зарим илрэл цар тахлын үед хурцаар ажиглагдаад зогсохгүй өвчний тархалтыг тандах, хянах зорилгоор санаачилсан зарим ажил нь тухайлбал халдвартай хүний “туулсан зам”, “түүх”-ийг тогтоох гэсэн оролдлого нь халдвартай нэгнийг ялгаварлах, нийгмийн сүлжээнд гутаах үр дагавартай байлаа. Сонгодог үед (1500-1800) галзуу, солиотой хүмүүсийг жигших бай болгон тусгаарлаж байсанчлан КОВИД-19 халдварын эхний тохиолдлуудад халдвар авсан хүмүүсийг тийн үзэх болов. Мэргэжлийн эмч нар бий болсоноор сонгодог үеэс эхлэн тэд нийгмийн шинэ статус олж, тэдний ажлын талбар хүнийг илчлэх, шүүх, буруутгах хууль цаазын орон зай болжээ.

Зөөвөрлөгдсөн анхны тохиолдлын дараах хөл хорио, халдварын тохиолдол ахин бүртгэгдээгүй үед хориог цуцласан эсэх нь тодорхойгүй зуны улирлыг өнгөрүүлсэн зэрэг нь тодорхойгүй байдлыг даван туулах хүмүүсийн тэсвэр, хүлээц, хүмүүс хоорондын харилцаа гэх мэт социал капиталыг “үргүй зарсан” тохиолдол юм. Цар тахал нь уг чанараараа биологийн шинжтэй боловч цар тахлын талаарх төсөөлөл мэдрэмж нь угаас нийгмийн утга холбогдолтой гэдгийг харгалзах шаардлагатай юм. Нийгмийн холбоогоор хуримтлагдан нэмэгддэг социал капитал чухал учраас (Parks, 2020) бусад нөөцийн адил хямгадах шаардлагатай. Хэдийгээр цар тахлын нөхцөл байдал сахилга, хариуцлагыг хувь хүн бүрээс нэхэж байсан боловч үүгээр дамжуулж хүний нийгмийн мөн чанарыг хязгаарлах нь учир дутагдалтай юм.

Орчин үеийн сахилгын нийгэмд ажиглалт, хэвийнжүүлэх шийтгэл, үзлэг шалгалт гэсэн хяналтын гурван үндсэн техник бий. Том хэмжээнд хүмүүсийг хянах хяналтад (эрх мэдэлд) нь зөвхөн тэднийг ажиглах замаар л хүрч болно. Гэхдээ бүхнийг хянах нь ихэнхдээ боломжгүй байдаг тул ажигласан мэдээллээ доод түвшингээс дээшээ дамжуулах шаталсан дараалалтай ажиглагчдын "буухиа" шаардлагатай байдаг. Хэвийнжүүлэх санааг өмнөх жишээ дээр тодорхой өгүүлсэн тул энд ахин дурдахгүй орхиё. Харин үзлэг шалгалт (тухайлбал, эмнэлэгт хэвтэж буй эмчлүүлэгчдийн үзлэг) нь шаталсан ажиглалтыг хэвийнжүүлэх шийтгэлтэй хослуулсан хяналтын арга юм. Энэ бол "хүч хэрэглэн үнэнийг тогтоох (Foucault, 1995)" бүхэл болж хосолдог учраас эрх мэдэл/мэдлэг гэж Фукогийн нэрлэсэн зүйлийн тод жишээ болно. Ийнхүү түүний үзэлд мэдлэг нь чөлөөлөхүй байхаа больж, хяналт тандалт, зохицуулалт, сахилгын нэг төрөл болдог (Sarup, 1988). Аль ч тохиолдолд тэд үзлэг шалгалтад хамрагдсан хүмүүсийн тухай үнэнийг тодруулж (тэдний эрүүл мэндийн байдал ямар байгааг хэлж), зан үйлийг нь (тэднийг цогц эмчилгээнд орохыг тулгах замаар) хянадаг (Gary & Oksala, 2022). Үзлэг шалгалт нь хүмүүсийг "баримтжуулалтын талбарт" бас оруулдаг. Үзлэг шалгалтын үр дүнг энд хамрагдсан хүмүүсийн дэлгэрэнгүй мэдээллээр хангаж, эрх мэдлийн тогтолцоонд тэднийг хянах боломжийг олгодог баримт бичигт бүртгэдэг. Эдгээр бүртгэлд үндэслэн хянаж буй хүмүүс

мэдлэгийн үндэс эргээд болдог зүйлчлэл, дундаж, хэм хэмжээг томьёолж чадна. Үзлэг шалгалт нь тухайн хүнийг "кейс" буюу шинжлэх ухааны жишээ, асрахуйн объект болгодог. Өмнө өгүүлсэнчлэн энэ нь асрахуйн цаана хяналт давхар хэрэгжинэ.

Дотоодод халдварын анхны тохиолдол бүртгэсэнтэй холбоотой тухайн хүний регистрийн дугаар, эрхэлдэг ажил, зураг хөргийг нийгмийн сүлжээнд нийтэлж байсан нь хүний эрхийг хамгаалах хүрээнд олж авсан ололтуудаа баллуурдахаас гадна үйл явдал биш дүр, төсөөлөл гол болсон орчин үеийн орчин үеийн ертөнцийг тод харуулсан юм. Олон нийт цаанаа юу ч төлөөлөхгүй "дуураймал дүрд" автаж, түүгээр бодит байдлыг орлуулж, хэлэлцэж болдог нь энэ жишээнээс тод харагдана. Үүний ард шошголох, гадуурхах, гутаах замаар өөрсдөө давуу тал олж, эрх мэдлээ тэлэх гэсэн жирийн хүний ч үйл ажиллагаа илэрдэг.

Дүгнээд хэлбэл нийгэмд өрнөж буй жирийн зарим нэг үйл явдал ч танихад амаргүй эрх мэдлийн жишээ болдог бөгөөд эрх мэдлийн анализ нь хэн эрх мэдлийг эзэмшиж байна, тэд ямар санаа зорилготой байна гэсэн зорилгын түвшинд төвлөрөхөөс илүү ямар субъектүүд эрх мэдлийн үр нөлөөг бүрдүүлж байна гэсэн эрх мэдлийн хэрэглээний түвшинд төвлөрч болно гэдгийг харуулж байна. Иймээс дараа дараагийн судалгаанд нийгмийн амьдрал дахь эрх мэдлийн иймэрхүү нэхээст илүү анхаарал хандуулах боломж байна.

## Эшлэсэн материал


Foucault, M. (1967). *Madness and Civilization.* London: Tavistock.

Foucault, M. (1995). *Discipline and Punish* (2nd хян.). New York: Vintage.

Gary, G., & Oksala, J. (2022 October 22). *Michel Foucault*. (Z. N. Edward, Ed) The Stanford Encyclopedia of Philosophy: https://plato.stanford.edu/archives/fall2022/entries/foucault

Goffman, E. (1963). *Stigma: Notes on the Management of Spoiled Identity.* London: Penguin Books.

Kelly, M. (2021 October 27). *Michel Foucault: Political Thought.* The Internet Encyclopedia of Philosophy: https://iep.utm.edu/

Parks, V. (2020). The Critical Role of Social Capital During the COVID-19 Pandemic: Lessons from Disaster Research. *Population Briefs. 2*.

Sarup, M. (1988). *An Introductory Guide to Post-Structuralism and Postmodernism* . London: Harvester Wheatsheaf.

Ганчимэг, Г. (2021 09 08). *livetv.mn.* 2023 оны 10 12, https://livetv.mn/p/276350

Монгол Улсын засгийн газар. (2021).

НХХЯ. (2021). *Залуучуудын хөдөлмөрт бэлтгэх оролцоо төсөл.*

## ХАВСРАЛТ 10. "АЙСУЙ ХҮН: ДАЯН ДЭЛХИЙН ШИЛЖИЛТ ДЭХ ЁС ЗҮЙН СОРИЛТУУД" СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ШУТИС

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

SEE LEARNING MONGOLIA

АНУ-ын Эмори Их Сургуультай хамтарсан хөтөлбөр

# АЙСУЙ ХҮН

## ДАЯН ДЭЛХИЙН ШИЛЖИЛТ ДЭХ ЁС ЗҮЙН СОРИЛТУУД

### Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл

Улаанбаатар хот
2022 он

ШУТИС

SEE LEARNING MONGOLIA

АНУ-ын Эмори Их Сургуультай хамтарсан хөтөлбөр

# АЙСУЙ ХҮН

**ДАЯН ДЭЛХИЙН ШИЛЖИЛТ ДЭХ ЁС ЗҮЙН СОРИЛТУУД**

***/Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл/***

Улаанбаатар 2022

*МУИС-ийн 80 жилийн ойд зориулав.*

*Энэхүү бүтээлийг МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимд хэрэгжиж буй **"Нийгмийн ухаан: орчин үеийн техноугшилт иргэншлийн сорилтууд"** гадаадтай хамтарсан төсөл, **"Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал"** (ШуСс-2020/40), суурь судалгааны төслийн санхүүжилтээр хэвлүүлэв.*

# АЙСУЙ ХҮН:

## ДАЯН ДЭЛХИЙН ШИЛЖИЛТ ДЭХ ЁС ЗҮЙН СОРИЛТУУД

### ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА:

*МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Философи, шашин судлалын тэнхим*
*ШУТИС-ийн БуХС*
*“Нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцахуй” ТББ*

*Эмхэтгэсэн: Д.Оюунгэрэл, Б.Мөнхжавхлан*
*Хэвлэлийн эхийг: Б.Баянжаргал*
*Хэвлэлийн хуудас: 16 х.х*
*Хэвлэх үйлдвэр: Тотопресс ХХК*

*ISBN: 978-9919-521-18-9*

## АГУУЛГА


Өмнөх үг ........................................................................................................................ 4

**БОЛОВСРОЛЫН ЁС ЗҮЙ**

“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, агуулгад хийсэн шүүмжлэлт зарим эргэцүүлэл ........................................................................................................ 6

Монгол улсын боловсролын салбар дахь ёс зүйн тулгамдсан асуудлууд ........ 19

Академик орчин дахь их сургуулийн ёс зүйн асуудал: Олон улсын баримт бичгүүдэд хийсэн анализ ........................................................................................30

Их сургууль ёс зүйн боловсролын төв болох нь ................................................ 41

Сайн багшийн тухай ойлголт: Өнөөгийн монголын багш нарын ёс суртахууны байдал ба ирээдүйн чиг хандлага ..........................................................................49

Их, дээд сургуулийн ёс зүйн дүрэмд хийсэн системийн шинжилгээний үр дүн........................................................................................................................66

Цахим эрин дэх багшийн дүр төрх ........................................................................ 76

Багшлахуйн менежмент ба ёс зүй .......................................................................... 93

**ХҮЙС, ЖЕНДЭР, ЁС ЗҮЙ**

Спорт дахь хүйсийн ялгавар болон жендерийн асуудлыг ёс суртахууны философийн үүднээс хөндсөн тойм ................................................................... 100

“n” тооны жендэр ба жендэрийн зах зээл .......................................................... 109

Хүйсийн тэгш бус байдалд хандах эцэг эхчүүдийн зан төлөвийн онцлог (Дээд боловсролын жишээн дээр)...................................................................... 123

**ДИЖИТАЛ ШИЛЖИЛТИЙН ТӨВД ХҮНИЙГ ТАВИХУЙ**

Хиймэл оюун ухаан (AI), машин сургалтанд суурилсан эрүүл мэндийн технологийн хэрэглээний ёс зүйн зарим асуудал .............................................. 137

Цахим гадуурхлын талаарх оюутнуудын философи тайлбар.......................... 144

Цахим эрх чөлөө нь нийгмийн амьдралд оролцох боломжийг өргөжүүлэх үйл явц.......................................................................................................................149

Цахим орчин дахь хяналт ..................................................................................... 150

Шилжилтийн нийгэм дэх Z үеийнхний ёс зүйн зарим асуудал ....................... 153

**ИРЭЭДҮЙН АРДЧИЛАЛ БА ЁС ЗҮЙ**

Эрүү шүүлт ба түүний ёс зүйн асуудал ..............................................................162

Орчин үеийн залуучуудын үнэт зүйлсийн чиг хандлага ................................. 172

Богд Жэвзүндамба гэгээний “Аяа гайхамшигт бошго оршвой” лүндэн дэх ёс зүйн асуудлууд ................................................................................................. 183

# ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим нь уламжлал болгон зохион байгуулдаг ёс зүйн эрдэм шинжилгээний IX хурлыг Дэлхийн философийн өдөр, МУИС-ийн 80 жилийн ойд зориулан 2022 оны 11 сарын 18-ны өдөр ШУТИС-ийн БуХС, "Нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцахуй" ТББ-тай хамтран зохион байгууллаа.

ЮНЕСКО-оос энэ жилийн Дэлхийн философийн өдрийг "Айсуй хүн - Ирээдүйн хүн" сэдвийн дор зохион байгуулж байна. Бид энэ жилийн ёс зүйн хурлыг "Айсуй хүн: Даян дэлхийн шилжилт дэх ёс зүйн сорилтууд" гэсэн ерөнхий сэдвийн дор 1) Боловсролын ёс зүй, 2) Ирээдүйн ардчилал, ёс зүй, 3) Хүйс, жендэр, ёс зүй, 4) Дижитал шилжилтийн төвд хүнийг тавихуй гэсэн дэд сэдвийн хүрээнд илтгэлүүд хэлэлцэв.

Тус хуралд "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийн хөтөлбөр, агуулгад хийсэн шүүмжлэлт эргэцүүлэл, их, дээд сургуулиудын ёс зүйн дүрэмд хийсэн системийн шинжилгээ, академик орчин дахь ёс зүйн асуудлыг олон улсын баримт бичгүүдэд тулгуурлан авч үзсэн нь, Монголын боловсролын салбар дахь ёс зүйн асуудлууд зэрэг ёс зүйн боловсролын асуудал, мөн хүйс, жендер ёс зүй, дижитал шилжилтийн ёс зүйн асуудал зэрэг сэдвээр илтгэл хэлэлцүүллээ.

Зохион байгуулагчид

# БОЛОВСРОЛЫН ЁС ЗҮЙ

5

# "ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ" СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, АГУУЛГАД ХИЙСЭН ШҮҮМЖЛЭЛТ ЗАРИМ ЭРГЭЦҮҮЛЭЛ

*М.Отгонбаяр доктор (Ph.D), профессор*
*МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн эрхлэгч*
*Б.Дагзмаа доктор (Ph.D), профессор*
*МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим*

Бид энэ удаад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан "Иргэний ёс зүйн боловсрол" /ИЁЗБ/ хичээлийн хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомж, бодлогын бусад баримт бичгүүдтэй холбон review хийх, улмаар философи, ёс зүйн мэргэжлийн үүднээс зөвлөмж гаргах зорилго тавьсан болно. Энэ бол практик философийн тэр тусмаа ёс зүйн нэгэн чухал хэрэглээ юм.

**ИЁЗБ хичээлийн хөтөлбөр**

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамнаас 2019 оныг "Иргэний ёс зүйн боловсролын жил" болгон зарлаж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/390 дугаар тушаалаар "Иргэний ёс зүйн боловсрол сургалтын хөтөлбөр"-ийг батлан гаргажээ. "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийг өмчийн хэлбэр үл харгалзан бүх ерөнхий боловсролын сургуульд заах, тус хөтөлбөрийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхээр заасан байна. Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр ЕБС-ийн түүхэнд анх удаа бүх ангийн сурагчид ёс зүйн боловсрол эзэмшихийн зэрэгцээ, эцэг эхчүүд зөвлөгөө өгөх сургалтанд хамрагдаж буйгаараа онцлог ач холбогдолтой байна.

Манай бага, суурь, бүрэн дунд боловсролын 1-12 дугаар бүх ангид Математик 1610, Монгол хэл 1451, Англи хэл 789, Иргэний ёс зүйн боловсрол 782, Биеийн тамир 776 цагтай буйгаас монгол хэл, математик, иргэний ёс зүйн боловсрол гэсэн гурван хичээлийг 1-12 дугаар ангиудад үзэж байна. Үүнээс бага боловсролын түвшинд 320 цаг, суурь боловсролд 264 цаг, бүрэн дунд боловсролд 198 цаг нийтдээ 782 цаг зааж буй нь чамлалтгүй олон цаг юм.

ИЁЗБ хичээлийн сургалтын хөтөлбөр нь нийтлэг үндэслэл, зарчим, зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээ, хэрэглэгдэхүүн, сургалтын зохион байгуулалт гэсэн долоон бүлэг бүхий ба

хөтөлбөрийн удирдамж /сурагчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадлын тодорхойлолт, товч тайлбар, арга зүйн зөвлөмж, хавсралт хэсгээс бүрдсэн байна/. Энэхүү хөтөлбөрийн баримт бичиг орчин үеийн ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрийн баримт бичгийн шалгуур шаардлагын түвшинд боловсруулагдсан бүтэц, арга зүй бүхий байгаа нь сайшаалтай.

Хөтөлбөрийн агуулгыг философи, ёс зүйн мэргэжлийн үүднээс авч үзвэл засаж залруулах, өөрчлөх, шинэчлэх шаардлагатай асуудал цөөн биш байна. Мэргэжлийн үнэнч/шударга байдлын үүднээс ийн хандаж буйг маань зөвөөр ойлгож хүлээн авна гэж найдаж байна.

**Хөтөлбөрийн нэр томъёо**

Хөтөлбөрийн хавсралтад агуулга дахь үгийн /50 гаруй үг/ тайлбарыг Я.Цэвэлийн толь /УБ 1966 он/, Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь /УБ, 2018 он/ хоёрыг барин хийжээ. Жагсаалтад ердийн хэлний үг, философи, ёс зүй, эрх зүй, шашны категориудыг нэг эрэмбэд жагсаажээ.

Философи, ёс зүй, эрх зүйн онолын категориудыг зөвхөн монгол хэлний толь бичгийн тайлбараар /тухайлбал “ёс сурхууныг хэвшсэн тогтсон зан суртал”/ хэмээн орлуулсан нь тэдгээр нэр томъёоны агуулгыг гажуудуулсан байна. Мөн тодруулга, тайлбарлал шаардлагатай нэр томъёо /багшийг шүтэх ёс, төрөө дээдлэх ёс, ёс зүйн зан суртал гэх мэт/ цөөн биш байна. Хөтөлбөрт дурьдагдсан ёс зүйн болон бусад онолын нэр томъёонуудын жагсалтыг бүрэн гаргаж /ёс зүй, ёс суртахуун, үнэлэмж, ёс зүйн болон үнэлэмжийн боловсрол, ёс суртахууны боловсрол, иргэний боловсрол, шашны боловсрол, боловсролын ёс зүй гэх мэт/ зөв тайлбарлан тодорхойлох шаардлагатай. Үүний хамтаар хүний эрхэм чанар, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, тэгш байдал, хууль дээдлэх ёс зэрэг боловсролын сууринд байх ёстой эрхэмнэлүүдтэй холбох, агуулгад тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд ёс суртахууны болон үнэлэмжийн мэдлэгийг сурагчдын нас, бие, физиологи, психологийн онцлогийг харгалзан хэрхэн өгөөжтэй, практикчаар хүргэж эзэмшүүлэх тухай асуудал бол тийм ч амархан хэрэгжих асуудал биш гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ үүнийг сайтар тооцож, хичээлийг түвшин түвшингээр нь унших, эргэцүүлэх, хэлэлцэх тодорхой сэдвүүдэд боловсруулах, улмаар сэдвүүд дэх нэр томъёог

онолын утга агуулгыг нь алдагдуулахгүйгээр оновчтой буулган илэрхийлэх нь чухал юм.

Хөтөлбөрийн нэр томъёоны тухайд манай нийгэм, хүмүүнлэгийн ухааны онолын мэдлэг өнөө хир нь шилжилтийн үеэсээ ангижраагүй, социализмын үеийн марксист агуулгын оронд буддист нэр томъёог хүчээр орлуулан будилсан өнгөрсөн зууны 90-ээд оны үеийн онол, арга зүйн алдааны нөлөө энд ч хэвээр байсан гэж үзэж байна. Процессын хувьд энэ хөтөлбөрийг боловсруулах явцад мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө авсан эсэх, мэргэжлийн хамтлагийн дунд хэлэлцүүлэг өрнүүлсэн эсэх нь эргэлзээтэй байна.

**Нийтлэг үндэслэл**

Нийтлэг үндэслэлд өгөх зарим шүүмж байна. Тухайлбал:

1. МУ-ын Үндсэн хуулийн Оршил хэсэгт “**Монголын ард түмэн бид:**
   - улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
   - хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
   - төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
   - хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
   - эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.” хэмээн даяар олноо зарлан тунхагласан.
2. ИЁЗБ хичээлийн хөтөлбөрт “Монголын ард түмэн бид ... төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, ... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.” гэсэн хэсгийг л таслан авч үндэслэл болгожээ.

   Чухамхүү эндээс  уг хөтөлбөрийн агуулгын алдаа эхэлсэн гэж үзэж байна. Учир нь ИЁЗБ хичээлийн хөтөлбөрт заасан төрт ёс, түүх, соёлын уламжлал нь өөрөө хүний эрх, эрх чөлөө, шударга ёс зэрэгт нийцсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл үнэлэмжүүдийн эрэмбийг алдагдуулсан байна.
3. “Монголчууд бидний төрт ёс, түүх соёлын уламжлал нь монгол иргэний эх оронч үзэл, шударга ёс, энэрэнгүй сэтгэл,

хүн чанар, хариуцлага дээр суурилсан ёс зүйн зан суртлаар өвлөгдөн баталгаажснаар монгол соёл иргэншлийн өв соёл, үнэт зүйлс цаашид оршин тогтнох болно.” гэснийг авч үзэхэд төрт ёс, түүх, соёлын уламжлал нь шударга ёс, энэрэнгүй сэтгэл, хүн чанар, хариуцлага дээр суурилсан байх тухай дурьдаж буй мэт боловч эдгээрийн эхэнд эх оронч үзэл орж, улмаар эдгээр үнэлэмжүүд нь ёс зүйн зан суртлаар өвлөгдөн баталгаажна гэсэн нь агуулгын төдийгүй үнэлэмжийн эрэмбийн асуудал үүсгэж байна. Эндээс монголчуудын төрт ёс, түүх, соёлын уламжлал ёс зүйн зан суртлаар өвлөгдөн баталгааждаг уу? гэсэн асуулт зайлшгүй гарна. Ёс зүйн зан суртал гэдэг нь чухам ямар агуулга бүхий нэр томъёо болох нь ойлгомжгүй.

4. “Тус сургалтын хөтөлбөрийн агуулгын мөн чанар нь монгол өв соёл юм. Монгол өв соёл бол ёс зүйг чухалчилдаг бөгөөд “хүн”-ийг ёс суртахуунаар нь тодорхойлдог. Монгол хүний үнэт зүйл ёс суртахуунд нь оршдог.” гэсэн дүгнэлт, үндэслэлд хэд хэдэн зөрчил байна.

5. Юуны өмнө ИЁЗБ хичээлийн агуулга, үндсэн зорилго бол холбогдох хууль, бодлогын баримт бичигт тухайлбал, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 (ТХҮБ)-д заасан мэдлэгт суурилсан нийгэм ба “ур чадвар бүхий монгол хүнийг төлөвшүүлэх”, бага, дунд боловсролын тухай хуульд заасан “Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино.” хэмээх зорилгод нийцсэн байх ёстой.

   Бага, дунд боловсролын тухай Монгол улсын хуульд заасан бага, суурь, бүрэн дунд боловсролын агуулгаар хэрэгжүүлэх зорилтуудыг дахин нягталж харах, засварлах болон нэмж оруулах шаардлагатай боловч, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан баримт бичиг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцсэн байх учиртай.

Монгол өв соёл бол ИЁЗБ хичээлийн агуулга дахь зайлшгүй нэг чухал хэсэг мөн байж болох ч, агуулга болон багтаамжийн хувьд ИЁЗБ хичээлийг бүрэн төлөөлөх, түүний мөн чанар агуулгыг тодорхойлох хэсэг болж чадахгүй юм. Хөтөлбөрийн агуулгаас харахад “Уламжлалт өв соёлоосоо суралцъя” гэсэн гурав дахь хэсэгт эл агуулга багтсан байна.

Зөвхөн монгол хүний үнэт зүйл л ёс суртахуунд оршдог юм биш, ёс суртхуун бол хүн төрөлхтний, хүн байхын нэг чухал үнэт зүйл юм. Иргэний ёс зүйн боловсрол хичээлийг монгол өв соёл, монгол ёс суртахуунаар төлөөлүүлснээс болж сайн, муу, зөв, буруу, нэр төр, эрхэм чанар, үүрэг, хариуцлага, шударга ёс гэх мэт суурь үнэлэмжийн тухай ойлголт, мэдлэгийг олгох, дадуулах гол зорилго, зорилт агуулгад тусаагүй орхигджээ.

6. “Сурагчдыг өөрийг бус бусдыг эрхэмлэдэг, бусдыг бус өөрийгөө судалж танин мэддэг монголын уламжлалт өв соёлдоо тулгуурлан хүмүүжүүлж төлөвшүүлснээр ирээдүйн Монголын нийгмийн зөв үзэл бодолтой, ёс суртахуунтай иргэдийг бэлтгэж улмаар нэгдмэл хандлагаар улс орноо хөгжүүлэх боломж бүрдэнэ. Мөн манай улс ахуйн хөгжлөөр бус, хүнийхээ хөгжлөөр улсынхаа хөгжлийг хөтлөн дэлхийд үлгэрлэх үндэс суурийг бүрдүүлнэ.”

   “Өөрийгөө бус бусдыг эрхэмлэдэг, бусдыг бус өөрийгөө судалж танин мэддэг” гэдэг монголын уламжлалт өв соёлыг тодорхойлох гол категори мөн үү? гэдэг асуулт нээлттэй үлдэнэ. Эгоизм болон ёс зүйн бусад категориудын агуулгыг буруу тайлбарласан, монгол уламжлал, өвтэй холбон утгыг нь гажуудуулсан байна. *“Манай улс ахуйн хөгжлөөр бус, хүнийхээ хөгжлөөр улсынхаа хөгжлийг хөтлөн дэлхийд үлгэрлэх”* тухайд энэ бол орчин үеийн нийгмийн болон хүний хөгжлийн шалгуур үзүүлэлтээс хол зөрсөн “үлгэр” байна.

   Ёс зүйн боловсролын үндсэн агуулга бол өөрийгөө болон бусдыг эрхэмлэх, тэдгээрийн харилцаан дахь сайн ба муу, зөв, буруу, нэр төр, эрхэм чанар, нинжин сэтгэл, шударга ёс, үүрэг, хариуцлага гэх мэт категориудыг ойлгож, амьдрал үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвших явдал байдаг.

7. “Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх арга зам нь нийгмийн суурь үнэт зүйлс болох иргэний ёс зүй, ёс

суртахууны төлөвшилтэй зүй тогтлын хувьд зайлшгүй уялдаж тодорхойлогддог. Нийгмийн хөгжлийн үндэс нь хүний хөгжил бөгөөд хүний хөгжлийн суурь нөхцөл нь ёс зүйн боловсрол мөн. Уг суурь нөхцөлийг бүрдүүлэхийн тулд сурагчдад иргэний ёс зүйн боловсрол олгох хэрэгцээ шаардлага тулгарч байна. Түүнчлэн нийгэм хурдацтай өөрчлөгдөж буй өнөө цагт шинжлэх ухааны өндөр мэдлэг, чадвартай иргэн бэлтгэхийн зэрэгцээ тэдэнд иргэний ёс зүйн боловсролыг өв тэгш олгох сургалтын хөтөлбөрийг чухалчлан судлах ёстой болж байна."

Энд ИЁЗБ хичээлийн чухал болохыг үндэслэж буй бололтой. Гэхдээ хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийн тулд ирээдүй хойч үеийнхэндээ олгож буй ИЁЗБ хичээл нь ёс зүйн болон үнэлэмжийн суурь зарчим, хэм хэмжээнүүдийг эзэмшүүлэх биш, харин бие хэл сэтгэлээр үйлдэх нүгэл, өөрийгөө биш бусдыг эрхэмлэх, багш, ахмад настаны үг сургаалийг сонсох, багшийг дээдлэх, багшийг баярлуулах, бөхийн барилдаан, сур, шагайн хөрвөө, хурдан морины дэг ёс, буддын шашны дөрвөн үнэн, арга, билэг, зовлонгийн тухай сургаалийн тухай хичээл болсон байна.

8. "Нийгмийн хөгжлийн үндэс нь хүний хөгжил бөгөөд хүний хөгжлийн суурь нөхцөл нь ёс зүйн боловсрол мөн. Уг суурь нөхцөлийг бүрдүүлэхийн тулд сурагчдад иргэний ёс зүйн боловсрол олгох хэрэгцээ шаардлага тулгарч байна. ... Ийнхүү өнөөгийн Монгол Улсад хүмүүнлэг нийгмийг бүтээн байгуулах үндэс суурийг бүрдүүллээ." гэсэн нь энэ хөтөлбөр батлагдсанаар л Монгол улсад хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах үндэс суурь бүрэлдсэн мэт сэтгэгдэл төрүүлж байна.

**Хөтөлбөрийн агуулгын зарчим**

Хөтөлбөрийн агуулгын зарчим хэмээн тодорхойлсон 6 зүйл тус бүрт дараах тайлбар хийж болохуйц байна.

1. Монголын уламжлалт өв соёлын мөн чанарыг танин мэдэж, түүнээс суралцах, амьдралдаа хэрэгжүүлэхэд хөтлөх.

Хөтөлбөр мөн чанараараа иргэний ёс зүйн боловсрол биш, монгол уламжлалт өв соёлыг танин мэдүүлэх гэсэн зорилготой болсон учраас хичээлийн нэр агуулга хоёр зөрөхөд хүргэсэн. Иргэний ёс зүйн боловсрол хичээл бол орчин үеийн Монгол

улсын иргэн хүнд зайлшгүй сургаж, мэдүүлвэл зохих ёс суртхууны боловсролын агуулгыг оножтодорхойлох учиртай.

2. Монгол хүний амьдралын бодит байдлыг судлах.

   Үүнийг хичээлийн агуулгын зорилго, зарчим гэж үзэхэд маш бэрх байна. Монгол хүний амьдралын бодит байдлыг судлах гэдгийн дор чухам яг, юуг ойлгож байгаа нь ойлгомжгүй, хичээлийн агуулга, зорилго, зорилтод үл нийцэх зарчим тавьсан.

3. Агуулга нь ёс зүйн талаарх ойлголт ухагдахуунаас бүрдэх төдий биш, сурагч ёс зүйн боловсрол эзэмших арга ухааныг өөрөө бүтээхэд чиглэх.

   Өнгөц харахад энэ бол орчин үеийн боловсрол судлалд тавьж буй нэг гол зарчим шаардлага мэт боловч томъёоллын хувьд учир дутагдалтай. ИЁЗБ хичээлийн агуулга, зорилго бол уг чанартаа орчин цагийн иргэн  хүн зайлшгүй эзэмшсэн байх ёс суртхуун болон үнэлэмжийн суурь зарчим, хэм хэмжээнүүдээс бүрдэх ёстой. Эдгээр нь философийн, ёс зүйн, эрх зүйн гэх мэт онолын категориуд, тэдгээрийг тайлбарласан онол, үзэл баримтлалууд байдаг. Харин тэдгээрийг бага, дунд, ахлах ангийн сурагчдын нас бие, сэтгэхүйн онцлогт тохируулан, амьдралд нийцүүлэн буулгах, тохиромжтой, оновчтой жишээ, тохиолдол, баримтаар илэрхийлэх, багш хичээлийг онолын хийсвэр нэр томъёогоор заах биш, харин сурагчид өөрсдөө ойлгож, мэдэж авах арга зүйгээр заах, үүний тулд хичээлийн хөтөлбөрийг цогц байдлаар боловсруулах нь чухал байна.

4. Сурагчийн нас, сэтгэцийн онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн байх.

   Хөтөлбөрийн агуулга энэ зарчмын шаардлагыг хангасан уу гэдэг асуулт нээлттэй хэвээр үлдэж байна.

5. Ихийг гүехэн биш, багыг гүнзгий судлах.

   Ойлголтын агуулга багтаамжийн урвуу хамаарлын хуультай төстэй мэт боловч агуулгын хувьд логик зөрчилтэй илэрхийлэл байна. Ихийг гүехэн биш гэхээр багтаамжийн хувьд их хэмжээний мэдлэгийг гүнзгий агуулгаар өгөх гэж буй мэт, гэтэл багыг гүнзгий судлах гэхээр бага хэмжээний мэдлэгийг гүнзгий агуулгаар өгөх гэж буй мэт утга оноож болохгүй байна.

Иймэрхүү цэцэн болович утга нь ойлгомжгүй илэрхийлэл цөөн биш байна.

6. Анги ахих тусам өргөсөн гүнзгийрч, залгамж холбоотой байх.

   Хөтөлбөрийн агуулга хэсэгт холбогдох тайлбарууд өгсөн болно.

**Хөтөлбөрийн агуулга**

"Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөр "Бага, дунд боловсролын тухай хууль"-ийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үндсэн зорилготой ажээ. Эдгээр зорилтуудаас ёс зүйн боловсролтой холбоотой хэсгийг ялгаж үзэхэд бага, суурь, бүрэн дунд боловсролын залгамж холбоо болон мэдлэг чадварын ахин гүнзгийрэх байдлыг тооцон сайжруулах, үүнтэй уялдуулан ИЁЗБ хичээлийн хөтөлбөрийн агуулгын уялдааг ч мөн гаргах шаардлагатай гэж үзэж байна.

ИЁЗБ хичээлийн хөтөлбөрийн агуулгыг боловсролын түвшин бүрээр ялган үзвэл:

Хөтөлбөр бүх шатанд 1. Өөрийгөө таньж хөгжүүлье, 2. Бусдыг хүндэлж, баярлуулъя, 3. Уламжлалт өв соёлоосоо суралцъя гэсэн гурван хэсгээс бүрдэж буй учир БСШУСЯамнаас зөвшөөрөн хэвлүүлсэн "Монгол ёс хүмүүжил" (2019) I, II, III, IY, Y ангиудын сурах бичиг 1. Биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлье, 2. Ачлах ариун ёс, хүндлэх хүний ёс, 3. Уламжлалт аж төрөх ёс, зан үйл гэсэн бүлгүүдтэй, дунд болон ахлах ангийн "Иргэний ёс зүйн боловсрол" сурах бичгүүд 1. Өөрийгөө таньж хөгжүүлье, 2. Бусдыг хүндэлж, баярлуулъя, 3. Уламжлалт өв соёлоосоо суралцъя гэсэн гурван хэсэгтэй байна.

Хөтөлбөрийн **"Өөрийгөө таньж хөгжүүлье"** гэх 1-р бүлгийн бүлгийн агуулгаас үзэхэд хэлээр үйлдэх буян, нүгэл; биеэр үйлдэх буян, нүгэл ; сэтгэлээр үйлдэх буян, нүгэл; ангид уужуу, агуу ухаантай болох, амар амгалан, аз жаргалтай байхын тулд бясалгалыг дадуулах; ахлах ангид арга, билиг, дөрвөн үнэний сургааль үзэхээр эрэмбэлсэн; "Бусдыг хүндэлж, баярлуулъя" гэсэн хоёрдугаар бүлгийн агуулгад 1-р ангид Сайн сурагч: багш, эцэг эх, асран хамгаалагч, ахмад настны үг сургаалыг сонсох, эргэцүүлэн бодох, биелүүлэх, багшийг дээдлэх ёс; 2-р ангид Ахмад настныг хүндэлье: эцэг эх, асран хамгаалагч, төрөл садан, нутаг усныхан, ахмад настныг хүндлэхийн ач тус, эс хүндлэхийн гэмийг мэдэх, ... ачийг санах ...ыг хүндлэх;

3-р ангид Багшийг баярлуулах ёс: багшийг баярлуулсны ач тусыг ухаарах, багшийг баярлуулах; 4-р ангид Ахмад настныг баярлуулах: эцэг эх, асран хамгаалагч, төрөл садан, нутаг усныхан, ахмад настныг баярлуулсны ач тусыг мэдэх, баярлуулах; 6-р ангид үг сонсож сурах; 8-р ангийн асрахуй сэтгэл, бусдын ачийг хүртэх гэх мэт сэдвүүд байна.

Философи, ёс зүйн хувьд ИЁСЗБ хичээлийн хөтөлбөрийн 1 ба 2-р бүлэг нь Би Өөрөө буюу миний, хувь хүний, Бусад буюу нийгмийн, харилцааны ёс суртахууны болон үнэлэмжийн зарчим, хэм хэмжээний асуудал юм. Гэтэл хөтөлбөрт “Өөрийгөө таньж хөгжүүлье”, “Бусдыг хүндэлж байрлуулъя” болгож уг нэр томъёоны утга, агуулгыг нь өөр болгожээ.

Би Өөрөө буюу хувь хүний түвшинд өөрийгөө мэдэх, ойлгох, бусдаас ялгах, бусад буюу нийгмийн, харилцааны түвшинд намайг хүрээлэн буй зүйлсийг ялгаж мэдэх, улмаар хэм хэмжээ, эрх, үүрэг, ялгаатай байдал, онцгой байдал, хувь хүний эрхэм чанар, харилцаа, холбоо, ардчилал, иргэншил, миний болон бусдын үнэлэмж, тэдгээрийн адилсал ба ялгаа, миний, манай, дэлхий нийтийн, хүн төрөлхтний ирээдүй гэх мэт сэдвүүдээр ахин гүнзгийрэх учиртай. Ингэхдээ хувь хүний түвшинд хүүхдийн нас, бие, сэтгэлийн өөрчлөлт хөгжлийг тооцох, нийгмийн түвшинд эрх мэдэл, нөлөөлөл, ялгаа, ардчилал зэрэг агуулгаар ахиулан, улмаар шатлал бүр дэх холбогдох бусад хичээлүүдтэй холбон агуулгыг гүнзгийрүүлэх шаардлагатай.

Хөтөлбөрийн “Уламжлалт өв соёлоосоо суралцъя” гэсэн гуравдугаар бүлэгт 1-р анги таван хошуу малын нэршил, цагаан сарын баярын хүүхдэд хамаатай ёс заншил, 2-р ангид таван хошуу малын нас, цагаан сарын бэлгэдэл, цээр ёс, 3-р ангид монголчуудын идээ ундааг зүй зохистой хэрэглэх ёс, хурдан морины уралдааны дэг ёс, 4-р ангид монголчуудын цагаан идээг зүй зохистой хэрэглэх ёс, хурдан морины уралдааны дэг ёс, 5-р ангид зочныг хүндлэх ёс, сур харваа, шагайн харвааны дэг ёсыг үзэхээр хуваарилжээ. Дунд ангид ураг удмаа мэдэхийн ач тус, монголын үндэсний бичиг үсгийн баярын өдөр; амар амгалан, аз жаргалтай байхын тулд үйлийн үрийг мөрдөх, монгол бахархлын өдөр; мал өсгөн үржүүлэх уламжлалт арга, уламжлалт Бурханы шашны баяр ёслол; үндэсний хувцас, төрөө дээдлэх гэсэн сэдвүүдтэй байна. Ахлах ангиудад монголчуудын удам судар, монгол гэрийн ёс; шүтэн барилдлага, гүн үзэл, монгол цаг тоолол; монголчуудын номын өв соёл, монгол аж төрөх ухаан болон

газар усны нэр домог гэсэн сэдвүүд үзэхээр хуваарилжээ.

Тус сургалтын хөтөлбөрийн агуулга нь бүхэлдээ "Монголын уламжлалт өв соёл"-д тулгуурласныг түүний зарчим, агуулгад дурдсан бөгөөд 1-12 дугаар ангийн агуулга нь сурагчдыг монгол арга ухаанаар хүмүүжүүлэх тасралтгүй үйл явцад хөтөлсөн байна."[1] хэмээн хөтөлбөрт тэмдэглэжээ. "Уламжлалт өв соёлоосоо суралцъя" гэсэн бүлэгт уламжлалт өв соёлоос ёс зүйтэй холбогдох сэдвүүдийг л оруулах нь зүйтэй. Гэтэл эрийн гурван наадам, бурханы шашны баяр ёслол,  цаг тоолол, монгол гэртэй холбоотой ёс зэргийг оруулсан нь ёс суртахууны боловсролтой шууд хамааралтай биш юм. Уламжлалт өв соёлоос суралцах нь ёс зүйн боловсрол төдийгүй монгол хэл, монгол бичиг, уран зохиол, монголын түүх, нийгэм судлал зэрэг бусад хичээлтэй холбоотой бөгөөд ёс зүйн боловсролыг зөвхөн уламжлалт өв соёлоор төлөөлүүлэх боломжгүй юм.  "Иргэний ёс зүйн боловсролыг бүхэлд нь монгол өв соёл, уламжлал, заншил, буддын мэдлэг ухаанаар тодорхойлон гаргасан нь агуулга болон арга зүйн хувьд алдаатай болжээ.

**Ёс зүй ба шашин**

Ёс зүйн боловсролыг шашны боловсролтой хэрхэн холбох ба зааглах тухай асуудал бол аливаа улс орны ёс зүйн боловсролын бодлого дахь тулгамдсан асуудлын нэг байдаг. Гадаадын улс орнуудын ижил төстэй хичээлийн агуулга, хөтөлбөрийг авч үзэхэд шашны болон шашны бус гэсэн ялгаатай хөтөлбөртэй байна.

Энэ бол "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийн хөтөлбөр учраас энд шашны ёс зүйн асуудал орох эсэх, хэрэв орвол ямар түвшинд, ямар агуулгаар орохыг сайтар судалж, боловсруулсны үндсэн дээр шийдвэрлэх ёстой. ИЁЗБ хичээлийн хөтөлбөрийн 10-р ангид арга билгийг дадуулъя: аргыг дадуулах учир шалтгааныг танин мэдэх; аргыг дадуулах; билгийг дадуулах учир шалтгааныг танин мэдэх; билгийг дадуулах; 11-р ангид зөв сэтгэлийн ач тусыг танин мэдэх; зөв сэтгэлийг дадуулах; буруу сэтгэлийг тэвчье: буруу сэтгэлийн хор уршгийг танин мэдэх; буруу сэтгэлийг хорих, тэвчих; 12-р ангид дөрвөн үнэн, түүний цээрлэн хорих хэсэг: дөрвөн үнэний зовлон болон зовлонгийн шалтгааны үнэнийг танин мэдэж, хорих; дөрвөн үнэний хорихуйн үнэн, мөрийн үнэнийг танин мэдэж, дадуулах гэсэн буддист сэдвүүдийн ёс суртахууны утга агуулгыг

[1] *"Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөр, удирдамж. БСШУСЯ. УБ., 2019 он, 160 дахь тал.*

тодруулан мэдэхэд хичээлийг заах багш төдийгүй сурагчдын мэдлэг, туршлага хүрэлцээтэй биш юм.

Европын холбооны улсуудын шашны бус ёс зүйн /Non-denominational Ethics/ хичээлийн зөвхөн бага боловсролын агуулгыг авч үзвэл хэвшүүлэн дадуулах ёстой эерэг үнэлэмж, зан төлөв, зайлсхийх ёстой сөрөг үнэлэмж, зан төлөв гэсэн хоёр бүлэг бүхий байна. Бага боловсролын 1-5 дугаар ангийн сурагчдад эзэмшүүлэх ёс суртхууны үнэлэмжүүдийг бүлэглэн авч үзвэл:

| **Эерэг үнэлэмжүүд** | |
|---|---|
| Би Өөрөө | Бусад/Нийгэм |
| • Өөрийгөө хянах<br>• Өөрийгөө хүндлэх<br>• Өөрийгөө эргэцүүлэх<br>• Хувийн орон зайг эрхэмлэх<br>• Зоригтой байх<br>• Нөхөрсөг байх<br>• Соёлтой байх<br>• Нэр төрөө эрхэмлэх<br>• Үнэнч байх<br>• Шударга байх<br>• Даруу байх<br>• Хүчирхийлэл үйлдэхгүй байх<br>• Чөлөөт хүсэл эрмэлзэлтэй байх<br>• Хайрын догдлон мэдрэхүй, мэдрэмжтэй байх | • Бусдыг хүндлэх<br>• Бусдад тустай байх<br>• Хуваалцах<br>• Бусдыг хамгаалах<br>• Ондоон байдлыг хүндлэх<br>• Амьдралыг хүндлэх<br>• Хүрээлэн буй орчныг хүндлэх<br>• Оролцоотой байх<br>• Ардчилсан байх<br>• Аюулгүй байх<br>• Эв нэгдэлтэй байх<br>• Тэгш байдлыг эрхэмлэх<br>• Нээлттэй байх |

Харин хэт хувиа хичээх, идэвхигүй байх, үнэнч биш байх, шударга бус байх, залхуурах, хүндлэлгүй байх, бусдад хайхрамжгүй байх, бусдыг үл тоомсорлох, доог тохуу хийх, хамааралтай байх, бусдаас тусгаар байх, хараат байх, хүчирхийлэл үйлдэх, түрэмгийлэх, үл хүлцэх, хэт нэг талыг барих, нураан сүйтгэгч байх, бэлгийн дарангуйлагч, фанатизм, расизм, сексизм, тоталитаризм зэрэг үйлийг зайлсхийх ёстой сөрөг үнэлэмж хэмээн анги ахих байдлаар заах, ойлгуулахаар тусгасан нь ёс зүйн боловсролын хүрээнд зайлшгүй мэдүүлж, эзэмшүүлвэл зохих хэм хэмжээнүүд юм. Үүнийг манай

хөтөлбөрийн агуулгатай харьцуулж үзвэл агуулгын ялгаа нь илэрхий байна.

**ИЁЗБ хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал**

Бид МУИС-ийн 2020, 2021, 2022 онуудад элсэн орсон оюутнуудаас ярилцлагын аргаар судалгаа авсан. ИЁЗБ хичээлээр сурсан гол зүйлээ хэлнэ үү гэсэн асуултад:

1. ИЁЗБ хичээлээр яг юу үзсэнээ сайн санахгүй байна.
2. Монгол өв уламжлал, зан заншил л заасан.
3. Хөдөөний хүүхдэд малын нас зүс заагаад яахав дээ.
4. Ангийн багшийн цаг, ангийн хурал, ангийн багшийн яриа болоод л дууссан гэсэн хариулт өгсөн.

Оюутнууд хувь хүний болон хамт олны, нийгмийн үүрэг, хариуцлага, сайн муу, шударга, шударга бус гэх мэт ёс зүйн агуулгатай зүйл огт дурьдсангүй.

ИЁЗБ хичээлийн тухай сошиал орчинд 3500 хүн үзсэн, 898 шейрлэсэн нэгэн бичлэгийн доор хичээлийн агуулга дахь шашны үзэл санааг эрс шүүмжилсэн коммент цөөнгүй байна.

**Дүгнэлт**

Бид “XXI зууны дэлхийн монгол иргэн”-ийг бэлтгэх хариуцлагатай үүрэг хүлээсэн гэдгээ ухамсарлан “Айсуй хүнд хэрэгцээтэй” дэлхий нийтийн, хүн төрөлхтний нийтлэг үнэлэмж, ёс суртахууны хэм хэмжээг эзэмшүүлэх, ойлгуулах, тэдгээр мэдлэг, чадвар, дадлыг хэрхэн олгох талаарх бодлого, хөтөлбөрөө сайжруулах хэрэгцээ тулгамдаж байна. Үүний хамтаар Монгол хүний Өөрийн чанар /Identity/-ыг хадгалах, уламжлалт өв соёлоосоо таслахгүйгээр залгамжлан авч үлдэх ёстой агуулга, үнэлэмжүүдийг онцлон заах шаардлагатай байна.

Үүний тулд дараах судалгаа /desk review/ хийх шаардлагатай. Үүнд:

1. Иргэний ёс зүйн боловсрол хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх
2. Гадаад орнуудын ижил төстэй хөтөлбөр, баримт бичгүүдэд дахин судалгаа хийх
3. Монгол өв соёл, зан заншлаас ёс зүйн болон үнэлэмжийн боловсролд зайлшгүй чухал тэр агуулгыг ялгах, уламжлалт

өв соёлоос чухам ямар агуулгыг иргэний боловсролд тусгаж өгөх нь зүйтэй болох талаар хэт нэг талыг барихгүйгээр судлан тогтоох

4. Хөтөлбөрт шашны боловсрол, шашны ёс зүйн асуудлыг оруулах эсэхийг судлан оночтой шийдвэрлэх
5. Философи, ёс зүй, эрх зүйн онолын хийсвэр категориудыг амьдралд ойр, практик үйлтэй холбон ойлгуулах асуудлыг сургалтын арга зүйтэй холбон оновчтой шийдвэрлэх
6. Бага, дунд, суурь боловсролын түвшинд сурагч бүрийн зайлшгүй эзэмшсэн байх ёс зүйн, үнэлэмжийн мэдлэг, чадвар, дадлын жагсаалт гаргах зэрэг болно.

## Ном зүй


1. *"Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөр, удирдамж. БСШУСЯ. УБ., 2019 он.*
2. *Монгол ёс хүмүүжил I. БСШУСЯам. УБ.: 2019 он.*
3. *Монгол ёс хүмүүжил II. БСШУСЯам. УБ.: 2019 он.*
4. *Монгол ёс хүмүүжил III. БСШУСЯам. УБ.: 2020 он.*
5. *Монгол ёс хүмүүжил IY. БСШУСЯам. УБ.: 2021 он.*
6. *Монгол ёс хүмүүжил Y. БСШУСЯам. УБ.: 2019 он.*
7. *Монгол ёс хүмүүжил I. БСШУСЯам. УБ.: 2019 он.*
8. *Иргэний ёс зүйн боловсрол YIII. БШУЯам. УБ.: 2020 он.*
9. *Иргэний ёс зүйн боловсрол IX. БШУЯам. УБ.: 2020 он.*
10. *Иргэний ёс зүйн боловсрол X. БШУЯам. УБ.: 2020 он.*
11. *Иргэний ёс зүйн боловсрол XI. БШУЯам. УБ.: 2020 он.*
12. *Иргэний ёс зүйн боловсрол XII. БШУЯам. УБ.: 2020 он.*
13. *Program for the Non-Confessional Ethics Course Approved by the Board of Governors on 27 and 28 January 1998 in Brussels.*
14. *Ethical Curriculum Policy Monkstown Educate Together N.S. June 2015*
15. *Ethics and values education in schools and kindergartens policy paper*
16. *Whole School Plan for ethical education. newtownmountkennedy educate together national school (ntmk e.t.n.s.)*

# ЭРҮҮ ШҮҮЛТ БА ТҮҮНИЙ ЁС ЗҮЙН АСУУДАЛ

*Б.Мөнхжавхлан, доктор (Ph.D)*
*Б.Дагзмаа, доктор (Ph.D)*
*МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим*

***Хураангуй:*** *Энэ илтгэлд эрүүдэн шүүх туршлага орчин үед ч нийгмийн таагүй асуудлын нэг хэвээр буйг онцолж ёс зүйн агуулгын хүрээнд шинжилсэн. Хүний бие, сэтгэлд арилашгүй сэвт ул мөр үлдээдэг тамлан зовоох энэ үйлдэл нь утиларист ёс зүйн үүднээс зөвтгөл хүлээдэг ч зарим философи үзэл баримтлалын хувьд үгүйсгэсэн байр суурь бий. Дээрх үзэл санаануудын үүднээс уг асуудлыг хэрхэн тайлбарласныг авч үзэж угаас хүний эрхэм чанарт халдсан энэ үйлдэл бол ёс суртахууны хувьд зөвтгөх шалтгаан нь хүч багатай хэмээн эргэцүүлснээ тусгасан болно.*

***Түлхүүр үг: эрүүдэн шүүх, эрүү шүүлт, хүний эрх, хүний эрхэм чанар, тамлан зовоолт***

Хүн төрөлхтний түүхийн бүхий л цаг хугацаанд хүний эрхэм чанарт таагүй нөлөөлж, хэрэгжүүлж ирсэн нэгэн асуудал бол эрүүдэн шүүх тухай юм. Таагүй гэж өгүүлж буйн шалтгаан бол эл үйлдэл “Torture has no limit”, “Хязгааргүй өвдөлт зовлон”-г[61] авчирч байдаг. Эрүүдэн шүүх бол ёс зүйгүй хэрэг бөгөөд сөрөг үр дагавартай байдаг (Chiara Lepora, 2011). Хэдий хүний эрхэм чанарыг хүндэтгэн харьцах нь хууль, ёс суртахууны хувьд лавтай боловч аливаа нэг хүчнээс тодорхой зорилготойгоор энэ үйлдлийг хийх явдал гарч байдаг тул ёс суртахууны нээлттэй асуудал гэж нэрлэдэг. Энэ үйл ажиллагаанд хохирогч ба эрүүдэн шүүгчийн хоорондын тэгш бус харилцаа нь эрүүдэн шүүхийг шударга биш гэдгийг харуулж байдаг. Эрүүдэн шүүхийн хохирогчид маш эмзэг нөхцөлд байдаг бол эрүүдэн шүүгч нь ажлаа өөрөө төгс хянаж ажилладаг. Хохирогчид эрүүдэн шүүж буй хүнийхээ бүрэн эрхэнд байна. Мөн тэдний халдлагаас зугтаж, хариу арга хэмжээ авч бас өөрийгөө хамгаалж чадахгүй (Evans, 2012). Ийм ярвигтай нөхцөл болон тодорхой эрх ашгийн үүднээс эрүүдэн шүүх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг тул ёс зүйн тодорхой үндэслэгээ дэвшүүлэх бололцоо бий. Энэ илтгэлд эрүүдэн шүүх, хүний эрхэм чанар

[61] *Садизм ярьж байгаа бол өөр хэрэг. Энд таашаал, зугаа гэх мэт ойлголтуудын тухай мөн сэтгэл зүйн эрүүл, эрүүл биш хэв шинжийн тухай тайлбар хэрэгтэй болно. Бидний контекстэд гэмт хэрэг, үйлдлийн тухай бичиж байгаа билээ.*

зэрэг ойлголтуудыг онцлохын зэрэгцээ эрүүдэн шүүхийн тухай асуудлыг хүний эрх, ёс зүйн онолын үүднээс харьцуулж, орчин үеийн нийгмийн бас нэг чухал сэдэв гэдгийг тодотгон харуулахыг зорьсон болно. Ингэхдээ консеквенциализмын нэг хувилбар болох утилитаризм, үүнийг эсрэг байдаг деонтологи гэх мэт ёс зүйн сонгодог онолууд болон энэ асуудлыг тайлбарлахад түгээмэл ашигладаг зарим жишээг ашиглан шинжилж байгаа юм. Философичид, судлаачид эрүүдэн шүүх асуудлыг судалж, эрүү шүүлт нь хүний эрхийг зөрчсөн хэрцгий зүйл гэдэг байр сууринаас бүх тохиолдолд хориглох эсвэл тодорхой нөхцөлд зөвшөөрч, хуульчлах талаар авч үзэж маргасаар иржээ.

Монгол улсын түүхэнд ч мөн эрүүдэн шүүхийн тодорхой туршлага бий. 1921 оноос өмнө Монгол төрийн зарга маргаан шийдэх, шийтгэх гол арга хэрэгсэл нь эрүүдэн шүүх, хэрэг хүлээлгэх, залхаан цээрлүүлэх явдал зонхилох арга нь байсан байна (Интернэшнл, 2004). XVII зууны эцсээс манжийн колоничлогчид Монголыг эзэлснээр эрүүдэн шүүх, залхаан цээрлүүлэх, хэрэг хүлээлгэх үйл ажиллагаа улам бүр харгис хэрцгий шинжийг олж эрүүдэн шүүх, хэрэг тулган хүлээлгэх нь цогц чанартай болж хуульчлагдсан байна. Энэ нь түүхэнд “есөн эрүү тулгах” хэмээн нэрлэгдэж, биеийн болон сэтгэл санааны асар их хүчирхийллийг агуулсан 13 төрлийн эрүү шүүлтийг мөрдөн байцаалтын арга болгон хэрэглэж байсан байна (Интернэшнл, 2004). Эндээс харахад эрүүдэн шүүхийн сүүдэртэй түүх монголчуудын амьдрал, оюун санаанд мөн ул мөрөө үлдээсэн байна. Цаг үе улирах тусам эрүүдэн шүүлт хэлбэрээ өөрчилж бүрмөсөн арилалгүй өнөөг хүрсэн гэж үзэж болно.

1961 онд БНМАУ НҮБ-д гишүүнээр элссэнээр хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан олон улсын гэрээ конвенцид нэгдэж олон улстай хүний эрх, эрх чөлөөний талбарт мөр зэрэгцэх болсон байдаг. Монгол улс 2000 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид нэгдэн орж, улмаар 2014 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт, протоколыг соёрхон баталсан юм.

Эрх зүйн баримт бичгүүдэд уг асуудлыг хэрхэн томъёолсныг авч үзье. “Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенц” -ийн 1-р зүйлд тодорхойлсоноор “эрүүдэн шүүх” гэж төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж буй этгээд[62], өөрөө эсхүл түүний өдөөн хатгаснаар буюу ил далд зөвшөөрлөөр хэн нэгэн этгээдийг өөрөөс нь буюу гурав дахь этгээдээс мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, үйлдсэн буюу үйлдсэн гэж

[62] *Төрийн албан хаагч гэдэг нь өргөн ойлголт бөгөөд цагдаа, эмч, багш гэх мэт олон субьектыг оруулна.*

сэжиглэгдэж буй хэрэгт нь шийтгэх, айлган сүрдүүлэх аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаанаар бие махбод, сэтгэл санааны хувьд санаатайгаар хүчтэй өвтгөх, шаналгах аливаа үйлдлийг ойлгоно. Энэхүү тодорхойлолтод хуулийн дагуу цээрлэл буюу тохиолдлоор үйлдсэн өвдөлт шаналгаа хамаарахгүй (Интернэшнл, 2004) хэмээсэн байна. Харин НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд "Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй" (legalinfo.mn) гэсэн байдаг. Бүтэн нэрээр буюу НҮБ-ын "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц"-ийн агуулгыг анхааралтай харахад эрүүдэн шүүх гэдэг ойлголт нь нэлээд өргөн хүрээг хамарч буй нь тодорхой байна.[63]

Эрүүдэн шүүхийн асуудлыг харуулах түгээмэл танигдсан зарим жишээг энд дурдвал: "2001 оны 9 дүгээр сарын 11-нд Дэлхийн Худалдааны Төв болон Пентагоны байрыг гадныханд барьцаалагдсан онгоцоор дайрсан нь Нэгдсэн улсыг хүчирхийллээр хариу барихад хүргэв. Афганистан руу халдаж, Гуантанамо дахь бааз болон өөр бусад газарт хэдэн зуун хүнийг шоронд хорилоо. Цаашид дахин довтлох эсэх тухай болон бусад мэдээлэл авах зорилгоор маш олон хүн дээр Америкийн мөрдөгчид тамлан зовоох аргыг хэрэглэв. Тамлан зовоох эдгээр үйлдэл Америкийн ардчиллын үндэс болж байсан ёс зүйн зарчмыг зөрчсөн юм. Тамлан зовоох арга (өөрсдөө энэ үгнээс булздаг ч) хэрэглэхийг Жорж В.Бушийн засаг, захиргаанд ажиллаж байсан хуульчдын боловсруулсан эрх зүйн актуудаар зөвтгөн зөвшөөрөв" (Вольф, 2021). Үүнтэй адил нэг жишээ бол Америкийн ерөнхийлөгч Жорж Бушын захиргааны үед Кубын Гуантано Бэй дэх Америкийн нууц шоронд хоригдлуудыг эрүүдэн шүүх явдал үлэмж ихээр гарч байсан хэрэг юм. Монголын тухайд ч бас эрүүдэн шүүхтэй холбоотой нийтэд танигдсан жишээгээр 2008 оны 7 дугаар сарын 1-ний эсэргүүцлийн жагсаалт оролцсон иргэдийг олноор баривчилж, зүй бусаар хандан мэдүүлэг авсан байдал болон олноор нь саатуулан хорьж байсан явдал, мөн улс төрч С.Зориг агсны хэрэгт холбогдуулан баривчлагдсан түүний эхнэр болон бусад сэжигтэнтэй хэрхэн харилцаж байсан талаар нэрлэж болно.[64] Тодруулж хэлбэл дээр

[63] *Энэ илтгэлийг бичих явцад зайлшгүй танин мэдэх ёстой эрх зүйн зохицуулалт, ойлголтуудыг оруулах нь зохимжтой санагдаж байсан. Тухайлбал, сэтгэцийн эмгэгтэй болон сул дорой хөгжилтэй хүмүүс, сургууль, өнчин хүүхдүүд, ижил хүйстэн болгох, хүйсийн ялгааг өөрчлөх албадан эмчилгээ, зэвсэгт хүчин дэх дэглэлт зэрэг олон төрөлд эрүүдэн шүүх үйл ажиллагаа хэрэгждэг бөгөөд түүнд өртөж буй хүмүүсийг эрүүдэн шүүх, зүй бус байдлаар харьцахаас урьдчилан сэргийлэх талаарх төр засгийн онцгой зохицуулалт байна.*

[64] *2008 оны 7 дугаар сарын 1-ний үеэр жагсаалд оролцсон иргэдийг олноор баривчилж жижиг өрөөнд олноор нь саатуулан хорьж байсан, зүй бус харьцаж*

дурдсан эрүүдэн шүүхийн жишээ нь тус Конвенцийн “хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах” гэдэг агуулгад тохирч байгаа юм. Эдгээрээс харвал аливаа улс орнуудад янз бүрийн шалтгаанаар эрүүдэн шүүх явдал өдгөө хүртэл хэрэгжиж олон нийтийн анхаарал, эргэцүүллийн дунд байдаг нь тодорхой байна. Үүнийг ч судлаачид, хүний эрхийн шинжээчид нэгэн дуугаар зөвшөөрдөг.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын талаас авч үзвэл “эрүүдэн шүүх” бол хаана ч, ямар ч тохиолдолд зөрчигдөх ёсгүй хүний эрхэнд халдаж буй, аймшигтай зүйл байна. Нөгөөтэйгүүр энэ хэрцгий зүйлийг адилхан эрх эдлэгч (right holder) хэрнээ нэг нь нөгөөдөө санаатайгаар учруулж байгаад философийн асуудал үүсч байна. Хувь хүний тамлан зовоолтоос эхлээд мафи, улс төрийн хэрэг явдал болохын сацуу цаашилбал институцчилэгдэх асуудал дагуулдаг учир эрүүдэн шүүх нь философийн мэдлэгийн салбар болох улс төр, ёс зүйн нээлттэй сэдэв болдог. Энэ тухайд зарим онцлох санааг жишээгээр харуулья. Эрүүдэн шүүх гэдэг эрх зүйн нэр томъёог “тамлан зовоолт” гэсэн үгтэй хамтатган хэрэглэхэд буруудахгүй гэж үзэж байна. Ёс зүйн агуулгын хүрээнд “маш аюултай тэсрэх бөмбөг”-ний жишээ түгээмэл хэрэглэгддэг. “Баригдчихаад байгаа алан хядагч тун удахгүй болох асар хөнөөлтэй тэсрэх бөмбөгний тухай мэдээлэл өгөхөөс татгалзаж буй тохиолдолд эрүүдэн шүүх эсэх нь энэ асуудлыг шинжлэх гол шалтгаан болдог. Нэг гэм буруутай алан хядагчид ийм тамлал хэрэглэснээр мянга мянган гэмгүй хүнийг үхлээс аврах нь ёс суртахуунтай хүмүүсийг цочролд оруулах уу?” (Вольф, 2021) Энэ жишээ эрүүдэн шүүхийн тухай эргэцүүлэхэд анхны хөтөч болох юм. Учир нь террорист халдлагатай холбоотой бодит үйл явдал болсныг хүмүүс санадаг. 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн дараахнаас эхлэн “терроризмын эсрэг дайн[65]” үйл ажиллагааг АНУ-ын захиргаа эхлүүлж, философичид, барууны улс орнуудын бодлого боловсруулагчид эл асуудалд улам нухацтай хандаж эрүүдэн шүүхийг ёс суртахууны хувьд зөвшөөрч болох онцгой нөхцөл байдал байгаа эсэх, эсвэл бүр шаардлагатай тухайд хэлэлцэх болжээ (Al-Rodhan, 2022). Харин Хонконгийн Их сургуулийн Улс төр Нийтийн удирдлагын тэнхмийн профессор Юви Стейнхофф “Эрүүдэн шүүхийн ёс зүйн тухай” номондоо энэ “аюултай тэсрэх бөмбөг”-ийн жишээг хэрэглэхээс татгалзсан тухайгаа бичсэн байдаг. Тэрээр эрүүдэн шүүхийн тухай Америкийн хэлэлцүүлэг

*байсан тухай мэдээлэл хүний эрхийн тайланд тусгагдсан мөн улс төрч С.Зоригийн хэрэгт холбогдон шалгагдсан эхнэр Булганыг хорьж байх үеийн шоронгийн нөхцөл, зүй бусаар хандсан байдал, Чимгээ, Содномдаржаа нарыг эрүүдэн шүүсэн гэх зэрэг мэдээллүүд баримтаар нотлогдсон байна. Энэ нь эрүүдэн шүүхийн хуулинд өгүүлсэн бүх нөхцлийг хэрэгжүүлсэн гашуун туршлага юм.*

[65] *АНУ-ын ерөнхийлөгч Жорж.В.Буш Терроризмын эсрэг дайн хэмээх ойлголтыг хэрэглэж, алан хядагчдын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байна.*

бүрт байдаг "террорист халдлага" биш харин өөр жишээг сонгож буй учраа ёжтой нь аргагүй илэрхийлсэн. "Би энэ номоороо терроризмын эсрэг дайныг дэмжихийг зорьсонгүй". Энэ дайн бол утгагүй, тэгээд ч бас "бид ба тэд" гэсэн идеологи завсар нь дандаа хавчуулаастай явдаг гэжээ (Steinhoff, 2013). Гэхдээ энд нэгэнт түгээмэл хэрэглэдэг жишээний талаар дурдсан тул эрүүдэн шүүхтэй холбоотой ёс зүйн асуудалд ялгаатай байр суурь гарч буйг "аюултай тэсрэх бөмбөг"-ний тухайд авч үзье.

**Дэмжиж буй үндэслэл:**

Эл асуудалд Харвардын их сургуулийн профессор Алан Дершовицын байр суурь ихээхэн онцлогтой. Тэрээр эрүүдэн шүүхийг дэмждэг юм. "Миний хувьд, үнэхээр асар хүчтэй бөмбөгний тухай мэдээлэл авах шаардлага гарвал, тамлан зовоох эрхийг хуулийн үүднээс өгөх ёстой гэж үзэж байна. Үнэндээ гол маргаан бол тамлах явдал хуулийн хүрээнд үү, хуулиас гадуур байх уу гэдэг тухайд явагдаж байна. Хариулт тодорхой: хэрэв бид үүнийг зөвшөөрөх юм бол хуулийн хүрээнд л хийх хэрэгтэй" гэсэн байна (Вольф, 2021).

Утилитарист үзэл баримтлалын үүднээс эрүүдэн шүүх ажиллагааны үр дүнд олон хүний амь аврагдаж үр дүн эерэг байвал тус үйлдлийг зөвтгөж болно. "Нэг хүний ямар нэгэн үйлдлийн хэлбэр нь бусдын ашиг сонирхлыг хөндмөгц нийгэм түүнд хууль ёсны дарангуйлал хэрэглэх эрхтэй байна. Ингэх нь харин нийтийн сайн сайхныг арвижуулах эсэх асуудал бол маргаантай зүйл" гэж  Жон Стюарт Милль хэлж байв. (Милль, 2021)

Ер нь консеквенциалист үзлийн үүднээс үйлдлийн үр дүн нь түүний ач тус, ёс суртахууныг тодорхойлох үндсэн хүчин зүйл гэж үзэх учир эл үйлдлийг эерэгээр авч үзэж байна. Консеквенциалистуудын үзсэнээр "хамгийн сайн сайхныг авчрах нь зөв байдаг" (Luper, 2002). Энэ үзэл ёсоор олон хүний амь насанд аюул тулгарсан үед сэжигтэнд "бүх хэлбэрийн хор хөнөөл" тэр байтугай "устгахад" хүргэж болзошгүй байсан ч тус үйлдэл зөв болохыг батлахыг эрмэлзэнэ. Эрүүдэн шүүхийг хуульчлах саналын цаад сэдэл ийм байдаг. Тэсрэх бөмбөгний жишээ бол угтаа утилитарист үзэл баримтлалыг дэмжигчдийн хувьд зөвтгөх үндэслэл болно.

**Эсэргүүцэж буй үндэслэл:**

Жак Раббит тамлан зовоолт үр дүн өгдөггүй гэж үзсэн (Вольф, 2021). Энд гипотетик нөхцөл тавьж буй үед буюу баригдсан алан хядагчаас бөмбөг хаана байгааг хэлүүлэх тухайд хэдий тамлан зовоосон ч хангалттай найдвартай мэдээлэл авч чадахгүй байж магадгүй нь дэмий

цаг үрсэн хэрэг болж болох юм.

Нейропсихологийн зарим судлаачид ч бас үзэхдээ эрүүдэн шүүх нь хүний үнэнийг хэлэх чадварыг доройтуулдаг (newsweek, 2009) гэж үзсэн байдаг. Ялангуяа мөрдөн байцаах явцад эрүү шүүлт хэрэглэснээр үнэн зөв мэдээлэл авч чадна хэмээн үздэг утилитари үзэлтнүүдийн санааг тэд эсэргүүцэж мэдрэлийн болон сэтгэл зүйн туршилтын ихэнх тохиолдолд энэ таамаг худлаа болохыг баталсан байдаг (Al-Rodhan, 2022).

Мөн эрүүдэн шүүгдэж буй хүн тухайн авах гэж хүсээд, зориод байгаа мэдээллийн талаар мэдэхгүй ч байж болзошгүй юм. Зарим тохиолдолд хэн нэгэн гэмгүй хүн эрүүдэн шүүх үйлдлийн золиос болж, хэлмэгдэх эрсдлийг ч дагуулдаг. Тийм баримтууд олон бий.[66]

Деонтологи ёс зүйн үүднээс авч үзвэл ямарваа үр дүнгээс үл хамааран хүнийг хүндэтгэх ёстой ёс суртахууны ерөнхий хууль, үнэлэмж хамгийн чухал байна. Энд эрүүдэн шүүх нь бие даасан байдал, хүний эрхэм чанарыг үгүйсгэж байна гэсэн байр суурийг илэрхийлдэг. И.Кантын тодорхойлсон категорийн императив дахь “өөртөө ч бай, бусдад ч бай хүн төрөлхтнийг зорилгодоо хүрэх хэрэгсэл гэж хэзээ ч бүү ханд” (Elaine E.Englehart, 1992) гэсэн үзэл санаа эрүүдэн шүүхийн эсрэг үндсэн байр суурийг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл “аливаа нэгэн хэм хэмжээний нийтэд хамаарах шинжийг тогтоохын тулд юуны өмнө түүнийг өөртөө нийцэх эсэхийг шалган үзэх хэрэгтэй”. Хэн ч өөрөө хэрэгсэл болохыг хүсэхгүй шүү дээ. Эрүүдэн шүүхийн хувьд хохирогчийг зүгээр л арга хэрэгсэл гэж үздэг үүний цаана автономит эрхтэй хүн байгааг анхааралдаа авдаггүй авахыг ч хүсдэггүй. Энд хохирогч хүний статусыг эс хайхран эрүүдэн шүүгчийн зорилгод хүрэх, тухайлбал мэдээлэл олж авах зорилго хэрэгжиж байдаг. Тэгэхээр хүнийг хэрэгсэл болгож буй энэ үйлдэл шударга ёсыг хангах байтугай нийтээр

[66] *“Миний бие ... гадаад улсын иргэн нас барсан байхтай таарч холбогдох эрх бүхий этгээдэд мэдэгдсэн. .... аймгийн Цагдаагийн газраас гэрчээр мэдүүлэг авахаар дуудуулан очиход цагдаа нар ... сумын цагдаагийн хэсгийн байранд, мөн аймгийн Цагдаагийн газарт тус тус 2 өдөр, 2 шөнө унтуулалгүй мэдүүлэг авсан. Байцаалтын үеэр цагдаагийн албан хаагч нар “Гадаадын иргэнийг чи алсан, өөр хэн алдаг юм, худал мэдүүлэг өгч байна” гэх зэргээр хэрэг тулгаж, хувцас тайлуулж нүцгэлээд цахилгаан бороохой, цэвэр усны саваар олон удаа цохиж, шөнө унтуулалгүй байцаасан ба тухайн үед миний ухаан санаа орж гарч, маш хүнд байдалтай байсан. Дараа нь намайг Улаанбаатар хот руу шилжүүлж, цагдан хорих 0461 дүгээр ангид 5 хоног хорьж байгаад хэргийн холбогдогч олдсон гээд сулласан. Удаа дараа дуудагдаж байцаалт өгснөөр эд хөрөнгө, сэтгэл санааны хувьд хохирч, эхнэр маань гэнэтийн цочролд орохдоо улаан хоолойн хорт хавдар нь хүндэрч нас барсанд гомдолтой байна” гэжээ. Хүний амины үнэтэй эрүүдэн шүүлтийн хэргүүд Эмнести Интернэшнлийн материалаас авав.*

даган мөрдөх хууль дүрмийн ямар ч агуулгад нийцэхгүй билээ. Кантын ёс зүйн үзэл баримтлал дахь "нийтийн хэм хэмжээнд захирагдаж байхыг бүх хүмүүсээс шаардаж, бүгдэд хамаарах тэрхүү хэм хэмжээг илэрхийлэх механизм буюу ёс суртахууны Алтан дүрэм"-ийг харгалзан үзвэл эрүүдэн шүүх бол хүлээн зөвшөөрөх боломжгүй зүйл мөн. Кант ёс суртахууны үүрэг түгээмэл байгаад зогсохгүй хэлбэрэлтгүй (A.Boss, 1998) гэж байв.

Эрүүдэн шүүх явдлыг шүүмжилж судлаач Нейф эл-Родхэн бичихдээ "бид ёс суртахууны хэм хэмжээний дагуу амьдрах чадвартай, эмпати бүхий амьтад... Хүнлэг бус харгис байх, албадлагын бүтэц нь хүмүүсийн ёс суртахууны луужинг аажмаар гажуудуулж, эрүүдэн шүүх соёлыг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг хэмээсэн байна (Al-Rodhan, 2022). Эрүүдэн шүүх гэдэг нь тухайн эрүүдэн шүүгдэж буй хүнийг бүрэн үгүйсгэх гэсэн хэрэгсэл юм (Steinhoff, 2013).

Тодорхой нөхцөл байдалд ёс суртахууны хувьд хамгийн мэдрэмжтэй хүмүүс ч байцаагчдад хоригдлууд руу хашгирах, амин чухал мэдээлэл олж авахын тулд сэтгэл зүйн айдас бий болгох, унтуулахгүй байх, байнгын гэрэлтэй нөхцөлд байлгах зэрэг арга хэрэглэхийг зөвшөөрч болзошгүй юм. Зарим тохиолдолд эмийн бэлдмэл, сэтгэл зүйн айдас төрүүлэх аргуудыг ашиглахыг зөвшөөрдөг. Энэ нь улмаар эрүүдэн шүүхийн хуульчлах буюу интитуцчилэх гэдэг ойлголтод хүргэнэ. Үүний цаана эрүүдэн шүүх аргад бэлтгэх тусгай сургалт, кампус, тусгай тасаг байгуулах асуудал ч яригдаж болох юм. Алан Дершовицын санаа бол үүнтэй адил гэж энэ илтгэлдээ бид үзэж байна. Кантын үзсэнчлэн "тухайн зарчим хийгээд дүрмийг хүн бүр нэгэн мөр дагах юм бол буруу зүйл хийчих вий гэсэн айдсаас чөлөөлөгдөнө" (Лоувэр, 2016). Энэ бол илүү их уршиг дагуулах нь зайлшгүй билээ. Гэхдээ тэрээр "тухайн үед түгээмэл хууль болох ёстой гэж өөрийн хүсч буй тэр зарчимд л тохируулан үйлдэх ёстой" гэсэн нь жинхэнэ ёс суртахууны утгаар илэрхийлсэн юм. Харин Юви Стейнхофф хоёрдмол байдлаар үзэл бодлоо илэрхийлсэн. Тэрээр "эрүүдэн шүүх арга техникийг хууль ёсны дагуу ашиглаж болох онцгой нөхцөл байдлын жагсаалтыг бий болгож эрүүдэн шүүхийг зөвшөөрч болохгүй гэж би марган эсэргүүцэх болно. Үүний зэрэгцээ эрүүдэн шүүлтийн ийм хэрэглээ зайлшгүй байх нөхцөл байдгийг бид үгүйсгэх аргагүй гэж бас маргана" (Steinhoff, 2013) гэсэн юм. Гэхдээ тэрээр мөн тодорхой, хязгаарлагдмал нөхцөлд эрүүдэн шүүж болох үндэслэлийг гаргасан байдаг. Юви Стейнхофф эрүүдэн шүүхийн талаарх хэд хэдэн үндэслэлгээ гаргасан нь түүний "Эрүүдэн шүүхийн тухай ёс зүй" бүтээлд бий. Гэхдээ энд онцлох зарим санааг тусгасан болно. М.Фуко 1975 онд бичсэн "Цагдах ба шийтгэх: Шоронгийн үүсэл" гэдэг номдоо эрүүдэн шүүхийн тухай санааг улс төрийн мэдэлд уялдуулан бичсэн байдаг. Энэ

номонд “XVIII зууны дунд үе гэхэд эрх мэдэл нь хэт харгис хэрцгий байсан ба харин XIX зууны гучаад оны үед эрх мэдэл нь илүү зөөлөн ба хүмүүнлэг болсон гэхэд болно. Хэрэв урьд нь гэмт хэрэгтнүүдийг нийтийн өмнө цаазалж, эрүү шүүлт тохдог байсан бол харин хожим нь биед нь ямар нэг хохирол учруулахгүйгээр хорьж цагддаг болсон байна. Гэмт хэрэгтний тухай шинэ төсөөлөл бүрэлдэн тогтсон бөгөөд хүний биед харьцангуй ухамсартай, тооцоот байдлаар хандах болсон. Гэмт хэрэгтэн бол гэмт хэрэгтний бие бус, харин түүний зүрх сэтгэл гэдгийг ойлгосон” (Шинжлэх Ухааны Академи, 2011). Мөн тэрээр “Цагдах ба шийтгэх: Шоронгийн үүсэл” бүтээлдээ “энэ бол ямар ч тохиолдолд, аюултай хэрэг бөгөөд хаан эзний явуулж буй хүчирхийлэл, бас ард олны хүчирхийллийн хоорондох сөргөлдөөн юм. Бүрэн эрхт засаг энэ хэрцгий мөчөөрхлийг нь хараагүй мэт гэвч дахин нэг өдөр “цус урсахыг харж” дассан энэ байдал сэргэх сорилд өөрийгөө түлхэнэ. Хүмүүс улмаар удалгүй “зөвхөн цусаар л өшөө авах боломжтой” гэж үздэг болно (Foucault, 1995) хэмээсэн байна.

**Дүгнэлт:**

Дээрх байдлаар эрүүдэн шүүхийн талаар судлаачид ёс зүйн санаануудыг илэрхийлсэн байдаг. Эрүүдэн шүүх нь хуулийн хэллэг, хэрэглээ болохоос биш ердийн утгаар ч бас ( тамлан зовоох) өргөн хэрэглэгддэгийг дээрх судлаачид дурддаг. Алин боловч энэ бол гэмт хэргийн шинжтэй нь тодорхой билээ. Хүний эрхэм чанарт халтай эрүүдэн шүүх үйл ажиллагаа бол хүний эрхийг зөрчсөн, ёс суртахууны хувьд хариуцлага хүлээх субьектийн хувьд ял завших эрсдэлтэй, залруулж боломгүй үйл гэдэг нь харагдаж байгаа юм. Нөгөө талаас олон улсын гэрээ конвенцийг зөрчсөн шударга бус үйлдэл гэдэг нь тодорхой байна. Эрүүдэн шүүх гэдэг нь зөвхөн нэг хүний асуудал биш энэ харамсалтай зүйлд хохирч буй аливаа хүний амьдрал ахуй, ажил алба, эрүүл мэнд, сэтгэл санаа, амьд байх эрхтэй нь шууд хамааралтай байдаг ноцтой асуудал мөн. Иймд тус илтгэлийн байр суурь нь хүний ёс суртахуун, эрхэм чанарт харш хэмээн үзэж эрүүдэн шүүх явдал нь нийгэмд институцчилэгдэх, эсвэл тодорхой нөхцөлд уг явдлыг зөвшөөрөх нь зохисгүй хэмээн үзэж байна.

## Ном зүй

1. *Интернэшнл, Эмнести. (2004). Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь. Улаанбаатар.*
2. *Вольф, Р. Д. (2021). Философийн тухай. Улаанбаатар: Мөнхийн үсэг.*
3. *Chiara Lepora, J. M. (2011). The Tortured Patient. A Medical Dilemma.*
4. *Evans, R. (2012). The Ethics of torture; Definitions, History and Institutions.*
5. *Steinhoff, U. (2013). On the Ethics of Torture. SUNY Press.*
6. *Al-Rodhan, N. (2022). The wrongs, harms, and ineffectiveness of torture: A moral evaluation from empirical neuroscience. Journal of Social Philosophy, 1-18.*
7. *Хүний амины үнэтэй эрүүдэн шүүлтийн хэргүүд, 1.*
8. *Лоувэр, Б. (2016). Философи 30 секундэд. Nepko publishing.*
9. *Eline E.Englehart, D. D. (1992). Ethics and Life An Interdisciplinary Approach to Moral Problems. Wm.C.Brown Publishers.*
10. *Милль, Ж. С. (2021). Эрх чөлөөний тухай. Монсудар.*
11. *Luper, S. (2002). A Guide to Ethics. McGraw Hill.*
12. *A.Boss, J. (1998). Ethics for Life An Interdisciplinary and Multicultural Introduction. Mayfield Publishing Company.*
13. *Шинжлэх Ухааны Академи, Ф. (2011). Постмодернист санаа.*
14. *Foucault, M. (1995). Discipline and Punish The birth of the Prison. Vintage books.*

## Цахим эх сурвалж

15. *legalinfo.mn. (n.d.).*
16. *newsweek. (2009, 9 20).*